

# **МОНГОЛЫН УЛААН НОМ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ**  
**MINISTRY OF ENVIRONMENT AND GREEN DEVELOPMENT**

# САЙДЫН ҮГ

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны зохисгүй нөлөөллийн улмаас амьтан, ургамлын аймгийн амьдрах орчин доройтож, тархацын хүрээ улам бүр хумигдаж, тэдгээрийн нөөц хомсдон амьтан, ургамлын олон мянган зүйл устаж үгүй болсны зэрэгцээ устах аюулд ороод байгаа зүйлийн тоо хэдэн зуугаар нэмэгдэх боллоо. Олон улсын байгууллагуудаас гаргасан дүгнэлтээр амьтан, ургамлын аймгийг хомсдолоос аврах тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол 2030 он гэхэд биологийн нөөцийн 20 хувь бүрмөсөн устаж болзошгүй байгааг онцлон сэрэмжүүлсэн байна.

Монгол орон байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалтай, экологийн хувьд нэн эмзэг бүс нутагт хамаардаг тул хүн ам, мал сүргийн өсөлт, хот суурин, үйлдвэржилт болон байгальтай харьцах хүний үйл ажиллагаа эрчимжиж байгаа өнөөгийн нөхцөлд биологийн баялагийн нөөцөө хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар төр засгийн зүгээс дэс дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлж ирлээ.

Монгол улсын Үндсэн хуулийн “... газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал ... гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд урт хугацааны төрийн бодлогын баримт бичгүүдэд амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, устах аюулд орсон болон орж болзошгүй зүйлийн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамруулах, ашиглалтыг хязгаарлан зогсоож, зориудаар өсгөн арвижуулах зэрэг зорилтыг тусган хэрэгжүүлж байна. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Амьтны тухай”, “Ургамлын тухай”, “Ойн тухай” болон “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” зэрэг хуулийг Улсын Их Хурал 2012 оноос шинэчлэн батлан гаргалаа. Түүнчлэн Монгол улс “Биологийн төрөл зүйлийн конвенц” /1993/, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц” /1996/, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц” /1999/, “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц” /1999/ зэрэг олон улсын гэрээ конвенцид нэгдэн орж, олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна. Дээрх хуулиуд шинээр батлагдан гарснаар, устах аюулд орсон 31 зүйлийн амьтан, 133 зүйлийн ургамлыг дархлан хамгаалж, хөнөөгдөж байгаа 35 зүйлийн амьтан, 353 зүйлийн ургамлын ашиглалтыг хязгаарлаад байна.

Үүний зэрэгцээ “Биологийн олон янз байдлын 2011-2020 оны стратеги төлөвлөгөө”, Биологийн олон янз байдлын “Айчигийн зорилтууд” болон үндэсний бодлогод нийцүүлэн “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр” /2011/, “Байгалийн ургамлыг хамгаалах үндэсний хөтөлбөр” /2013/ шинэчлэн баталж, өнгөрсөн оноос эхлэн тусгай зориулалтаар гадаадын анчдад агнуулах, ховор амьтны тоог өмнөх жилүүдээс 7 дахин багасгаж, нэн ховор амьтан болох Мазаалай баавгай хамгаалах ажлыг онцгойлон анхаарч хэд хэдэн цогц арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Тус яамнаас 2013 оныг “Байгаль орчны боловсролын жил” болгон зарлаж энэ хүрээнд Дэлхийн байгаль хамгаалах холбооноос гаргасан “Олон улсын Улаан ном”, “Амьтан, ургамлын Улаан дансны үнэлгээний шалгуур үзүүлэлт”, “Амьтан, ургамлын хуулийн амьтан, ургамлын ангилал болон “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 19.1, Амьтны тухай

хуулийн 6.1 дэх хэсэгт” нэн ховор, ховор амьтныг олон улсын болон Монгол улсын Улаан ном, бусад холбогдох гэрээ, конвенцийн хавсралтад бүртгэж хамгаалах тухай заалтуудыг үндэслэн, Монгол улсын улаан номыг 3 дахь удаагаа шинэчлэн хэвлүүлж, уншигч Та бүхэндээ толилуулж байна.

Энэхүү номыг шинэчлэн бичих ажилд Монголын амьтан, ургамлын аймгийн нэртэй эрдэмтэд, судлаачид ихээхэн хүчин чармайлт гарган оролцсон болно.

Манай яамнаас боловсруулсан “Ногоон хөгжлийн үзэл баримтлал”, “Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр” болон “Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан” устах аюулд орж байгаа амьтан, ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь нөхөн, сэргээх, тарималжуулах, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхой ажлыг цаашид хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Энэ ажилд тус яамны зүгээс сайн санаат иргэн, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагын үүсгэл санаачлагыг дэмжин хамтарч ажиллах болно.

Байгаль хамгаалах арвин үйлс улам дэлгэрэх болтугай.

Монгол улсын Улсын Их Хурлын гишүүн,

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд

**САНЖААСҮРЭНГИЙН ОЮУН**

# ӨМНӨХ ҮГ

Хүн бол байгалийн хөгжлийн үр дүн төдийгүй үүссэн цагаасаа эхлэн хүрээлэн буй байгаль орчноосоо өөрийн хэрэгцээт зүйлийг олзворлон хэрэглэж иржээ. Урт удаан түүхэн хугацаа өнгөрөхөд дэлхийн хүн аажим олшрон урьд хүнгүй байсан газар орон хүний идээшил нутаг болон хувирах процесс эрчимжиж, байгалийн биетүүдийг олзворлон ашиглах арга ажиллагаа, хөдөлмөрийн багаж, зэвсэг улам бүр боловсронгуй болон хөгжсөөр ирлээ. Ялангуяа, дулаан, уур, цахилгаан, атомын ба цөмийн эрчим хүчийг үйлдвэрийн багаж зэвсгийн хөдөлгөх хүчин болгон өргөн хэрэглэх болсноор хүн төрөлхтний байгаль орчноос олзворлон авах хэрэгцээт зүйлийн хэмжээ түүхийн эрт үетэй харьцуулахад хязгааргүй ихээр өсөв.

Хүн нийгмийн хэрэгцээ бага байх үест байгаль дэлхийн баялаг гэгч барагдашгүй мэт байсан тул түүний ихсэж багасаж байгааг анзааран тооцолдоггүй байсан бол XIX зуун, XX зууны эхэн үед зарим улс орны байгалийн хэрэгцээт зүйлсийн нөөц шавхагдах, олон тооны амьтан, ургамал огт үгүй болох үзэгдэл газар аван мэдрэгдэх боллоо. Энэ байдлыг анх түрүүн эрдэмтэн хүмүүс ажигласан ба байгалийн баялагийн нөөц, хүрээлэн буй орчныг хамгаалах, ариг гамтай ашиглах тухай санал, онол газар сайгүй улс орон бүрт шахам дэвшүүлэгдэж, эрдэмтэд, үйлдвэрийн эзэд, газрын эздийн хооронд энэ асуудлаар олон жилийн турш тэмцэл явагдсаны дунд байгалийн баялаг, хүрээлэн буй орчны нөөц, унаган төрх байдлыг хүний хэрэгцээнд зориулан ашиглахад шинжлэх ухааны үндэстэй нарийн тооцоо хэрэгтэй нь өнөөгийн дэлхийн олон улс орны анхаарлын төвд байгаа гол асуудал болон хувирлаа. Ийм болно гэдгийн К.Маркс, Т.Энгелс нар урьдаас харан анхааруулж “Хүн хэдийгээр байгалийн түүхийн бүтээгдэхүүн мөн боловч байгальд байгалийн хүчин мэт үйлчлэнэ” гэж заагаад “Хүн нийгмийн соёлыг жолоодлогогүй хөгжүүлбэл ардаа зөвхөн элсэн цөлийг бүтээнэ” гэж сургасан билээ.

Байгалийн баялагийн дундаас хүний чиглэсэн зориулалтын ба дамын үйл ажиллагаагаар ихээхэн хөнөөгдсөн хэсгүүд гэвэл дэлхийн амьтан, ургамал аймаг юм. Тийм байгаль хамгаалах олон улсын холбоо бүр 1948 оноос эхлэн устаж, ховордож байгаа ургамал амьтны зүйлийг бүртгэх комиссыг байгуулж түүгээр дамжуулан дэлхий дахиныг хамарсан мэдээ баримтыг цуглуулан бүртгэж эхэлсэн ба уул комисс 1944-1954 онуудад ховор ургамал, амьтныг бүртгэх “Улаан ном” гэгчийг буй болгох бэлтгэл ажлыг хангажээ. Тэр үеийн мэдээгээр 1600 оноос нааш 36 зүйлийн хөхтөн амьтан, 94 зүйлийн шувуу дэлхий дээрээс бүрмөсөн устсан байлаа.

Одоогийн байдлаар дэлхийн “Улаан ном”-д 660 гаруй зүйлийн ховор буюу ховордож буй амьтад, олон тооны ургамал бүртгэгджээ. Зарим мэдээ баримтаас үзвэл дэлхийн ургамлын аймгаас даруй 25000 зүйлийн ургамал хүчтэй хөнөөгдөж, тэдгээрийн олонхийг хамгаалалтад авах шаардлагатай болсон ба 72 зүйлийн ургамлыг олон улсын тусгай хяналтаар улсууд хоорондоо өгөлцөж авалцаж байхаар ховорджээ.

Дэлхийн “Улаан ном” буй болсны дараа олон тооны улс орон өөрсдийн тус тусын нутаг орны хэмжээнд оршдог ургамал, амьтны устаж байгаа буюу ховордсон ургамал, амьтны зүйлийг бүртгэх “Улаан ном”-ыг буй болгож эхэлжээ. Энэ нь аливаа улсын хэмжээнд ургамал, амьтны зүйлүүд ховордож буй эсэхийг бүх нийтээрээ хянан анхаарч байх баримт бичиг юм. Уул номыг улаан өнгөтэй хэвлэдэг болсон нь “Анхаар! устана” хэмээсэн санааг илэрхийлсэн утгатай болно.



Дэлхийн улаан номын анхны [1969 оны] эхэнд манай орны шувуудаас япон тогоруу [хааяа үзэгддэг] тахь, хулан, хавтгай зэрэг 4 зүйлийн амьтан бүртгэгдсэн юм.

Монголчууд эртнээс нааш байгалийн зүйл тогтлыг ажиглан мэдэж, өөрийн нутаг орны үзэсгэлэнт газар, ан амьтанг хайрлан хамгаалж ирсэн сайхан уламжлалтай. Тухайлбал, Монгол оронд 25 жил суугаад 1297 онд нутаг буцсан алдарт жуулчин Марко Поло тэр үед монголчуудын баримталж байсан ангийн хууль дүрмийн тухай тэмдэглэхдээ: “Жил бүр 3 дугаар сараас 10 дугаар сар хүртэл туулай, буга, бор гөрөөс, цагаан зээр, хар сүүлт зээр зэрэг ан гөрөөсний төрөх үржих цагт нь хаан, ван, эрхтэн, дархтан, ямарч хүн агнах эрхгүй гэсэн хууль дүрэм монголд байх юм” гэжээ.

Үнэт үслэг анг монголчууд XII зууны үеэс нарийн чанд хамгаалсан бөгөөд 1640 онд халиу, булга зэрэг үслэг анг хулгайгаар агнахыг, 1720 онд их хүрээний ойр хавь газраар ан гөрөө хийхийг хуулиар хориглон дархалж байсан байна.

Ардын хувьсгалын жилүүдэд дархан цаазтай газар, ан амьтныг хамгаалах ажлыг улам хүчтэй болгох, ан амьтныг агнах, ховор ан амьтныг хамгаалах талаар дэс дараатай арга хэмжээ авч, тогтоол шийдвэр, дүрэм, заавар, хууль гаргаж мөрдүүлсэн юм. 1922 онд загас агнуурын хуулийг гаргаж, 1925 онд “Монгол улсын хязгаарын дотор загас ба ан амьтныг агнах” хуулийг бичиж мөрдүүлсний сацуу 300 шахам жил дархан байсан Богд-хан уулын дархлааг хувьсгалт хуулиар баталжээ. Үүнээс хойш 1933 онд тус улсын нутгийн бүх анг журамтай агнах тогтоол шийдвэр гаргаж, 20 гаруй зүйл амьтанг дархалсан байна.

БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор тус улсын нутагт ан агнах, загас барих тухай хуулийг 1944 онд баталж, анг журамтай агнах цаг хугацааг улам нарийсган тогтоосон байна. АИХ-ын Тэргүүлэгчдийн 52-р зарлигаар булга, халиу, суусар, минж, илбэнх, хүдэр, тахь, зэрэг 21 зүйл ховор амьтныг дархалж, ан агнахдаа сааль тавих, буу сойх, дэлбэлэх тэслэх аргаар загас барих, усанд хор хаях, шувууны үүр эвдэх, өндөг түүх, ичээ эвдэх, ухах, нүхэнд ус цуглах, утах зэргийг хориглосны дээр агнах хугацааг 1953 онд шинэчлэн тогтоож өгсөн билээ. 1962 онд эдгээрийг БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлигаар “Монголын ангийн хууль” болгон нэг мөр болгон баталсан юм. Энэ хуулийг 1972, 1974, 1978 онуудад нэмэн засварласан бөгөөд түүний дагуу минж, халиу, булга [хадны суусар, ирвэс, мазаалай, хавтгай бөхөн, тахь, хулан хар сүүлт зээр, халиун буга, хүдэр, хандгай, аргаль, янгир, цаа буга зэрэг 17 зүйл хөхтөн амьтан, хун [4 зүйл], бэгбаатар [2 зүйл], сар [4 зүйл], шар шувуу [5 зүйл], тоншуул [7 зүйл] зэрэг шувууд хилэм загасыг дархан цаазтай болгосон билээ.

Монгол орны оршин байгаа дэвсгэр нутаг уудам их, Төв Азийн өндөр уулс, цөл говь ихтэй, ус чийг ховор, хахир хатуу өвөл хаврын улиралтай тул энд орших ан амьтдын амьдрал ихээхэн өвөрмөцөөс гадна, ялангуяа сүүлийн жилүүдэд урьд нь эзгүй байсан их хэмжээний нутгийг аж ахуйн идээшил нутаг болгон ашиглах болсонтой холбогдон манай орны олон тооны ургамал, амьтны зүйл тоо толгойн хувьд эрс цөөрөх, зарим нь үгүй болох хандлага үүслээ. Ийм нөхцөл байдалд өөрийн орны ховордсон ба ойрын үед хамгаалах арга хэмжээ эс авбал устаж болзошгүй ургамал, амьтны зүйлүүдийг бүртгэн багтааж нийтийн анхааралд толилуулах “Улаан ном” буй болгох асуудал ихээхэн чухал болж байна. Энэ зорилгыг хангахын тулд БНМАУ-ын СнЗ-ийн 1985 оны 12-р сарын 23-ны 340 дүгээр тогтоолоор 23 зүйлийн хөхтөн, 19 зүйлийн шувуу, 6 зүйлийн хоёр нутагтан ба хэвлээр явагчид, 2 зүйлийн загас, 86 зүйлийн ургамлыг багтаасан “БНМАУ-ын улаан ном”-ыг буй болгохоор шийдвэрлэсэн юм.

Улаан номыг бичихдээ МБОХН-ийн Төв Зөвлөлөөс гаргаж өгсөн загварын дагуу бүх материалыг боловсруулсан ба ховор ургамал, амьтны тодорхойлолтыг өгөхдөө манай эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудаас нийтлүүлсэн ба цуглуулсан судалгааны материал, гадаадын эрдэмтдийн урьд өмнө судлан нийтэлсэн зохиол, бүтээлийг аль болох дүүрнээр ашигласан болно. Энэхүү Улаан номонд орсон 50 зүйл амьтан, 86 зүйл ургамал нь цөмөөрөө устаж сөнөхийн босгон дээр очсон ховор зүйлүүд биш бөгөөд тэдний дунд амьтнаас мазаалай, цөөвөр чоно, халиу, жороо тоодог, тахь цаа буга, ургамлаас далиу сонгино, вансэмбэрүү, жигд, монгол алтан хундага, ягаан цээнэ мэт ховордож үгүй болж буй зүйлүүдээс гадна голын минж, зэгсний гахай, уссурийн хандгай, алтан гагнуур, хөмүүл, тоорой, зэргийн ашиглагдах нөөцгүй болж буй амьтан, ургамал хамрагдаж байгаа юм. Тэгэхдээ ховор, нөөцгүй гэдэг ойлголтыг өөрийн орны хэмжээнд, аж ахуйн ба хүмүүсийн хэрэгцээнд ашиглагдах эрэлт хэрэгцээ, байгаа нөөцийг нь харьцуулан тооцоолж ариглан хамгаалах шаардлагатай болохыг анхааруулах үүднээс хэрэглэж байгааг уншигчид зөв ойлгох биз.

# ХОЁРДУГААР ХЭВЛЭЛД ЗОРИУЛСАН ӨМНӨХ ҮГ

Хүн байгаль эхийнхээ ачаар бий болж, өсч, торниод, өндөр ухамсартай болтлоо хөгжсөн атлаа олон үеийн туршид байгалиа шавхагдашгүй мэтээр төсөөлж, түүнийгээ хамгаалах, нөхөн сэргээх ажлыг орхигдуулан хайр гамгүй, алсын хараагүйгээр харьцаж, байгалиа танигдах аргагүй болтол хувирган өөрчилснөөр дэлхий нийтийг хамарсан экологийн хямрал бий болж, түүнд олон зуун сая хүн нэрвэгдэж, дэлхийд амьсгалах агааргүй, уух усгүй, гишгэх газаргүй, үзэгдэж харагдах амьтан, ургамалгүй газар, гуйланчлал нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, байгаль эх шиг өглөгч баян атлаа өгсний хариуг ухаарахгүй бол өшөөгөө авдаг хатуу гартан хаана ч байдаггүй юм байна гэдгийг дэлхий нийтээрээ ухаарч улс орнууд байгалиа доройтол, сөнөлөөс хамгаалах нийтлэг нэгэн зорилгод нэгдэн нийлж байгаа эрин үед бид амьдарч байна.

Монгол улс үйлдвэржсэн орны түүхий эдийн хавсарга болж, нэн удахгүй хоосон авдартайгаа үлдэх, зөвхөн ашиг орлого олох хэрэгсэл болдог, хүн байгальд халтай хоцрогдсон техник технологи хуримтлуулж, харь орны хог хаягдал булшлахад газар нутгаа золиосолж, өнөө болон хойч үеийнхний амьдрах орчныг доройтуулж, хөгжиж дэвшихийг мөрөөдөхөөс цаашгүй ядуу зүдүүгийн гашуун сургамжийг дахин давтахгүй байхыг зорилгоо хэмээн үзэж, экологийн хувьд нэн эмзэг, нөхөн сэргээгдэх чадвараар туйлын хязгаарлагдмал байгалийнхаа даацад нийцүүлэн нийгэм, эдийн засаг тогтвортой хөгжүүлэх шаталсан арга хэмжээг хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд биологийн баялагийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээгдэх хэмжээнд зохистой ашиглах, устах аюулд орсон амьтан, ургамлыг өсгөн үржүүлэх асуудал тодорхой байр суурь эзэлдэг билээ.

Монголын биологийн баялагийн нөөц тус орны байгаль орчны тэнцлийг хадгалах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, хүн амын ядуурлыг бууруулах, нийгэм эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд шим ертөнцийг бүрдүүлэгч анхдагч эх үүсвэрийн хувьд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Дэлхийн байгаль цаг уурын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хамгийн түрүүнд ихээр хөнөөгдөж байгаа байгалийн баялаг бол биологийн төрөл зүйл мөн. Тухайлбал, сүүлийн 40 орчим жилийн хугацаанд Монгол орны нийт нутгийн агаарын жилийн дундаж температур ойролцоогоор 0.7 хэмээр ихсэж, хур тунадасны хуваарилалт өөрчлөгдөн, хуурайших хандлага эрчимжсэнээс амьтан, ургамлын өсөлт хөгжилт удааширч байна. Манай улсын 128 сая га талбай бүхий бэлчээрийн тэн хагас нь ямар нэгэн хэмжээгээр талхлагдаж, гандуу нутгийн ургамлын ургац, 5 хүртэл дахин буурч, ургамлын зүйлийн тоо 4 дахин цөөрчээ. 1995 оны байдлаар үлийн цагаан оготно, царцаа зэрэг ургамлын хөнөөлт мэрэгч, шавж 40 орчим сая га талбайд тархсанаас ургамлын баялаг хомсдон, амьтны байршил нутаг хумигдах боллоо. Түүнчлэн олон арван зүйлийн амьтан, мод, ургамал, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар эрчимтэй ашигласнаас тэдгээрийн тархац хумигдан, нөөц хомсдож, 200 гаруй зүйл устах аюулд ороод байна. 1915 оноос хойших хугацаанд ойн сангийн талбай 2.5 сая га-аар багасч, 5 сая га талбайн ойд ихээхэн өөрчлөлт орж, зарим нутагт ойн экосистемийн тэнцэл алдагдах боллоо.

Энэхүү түгшүүрийн дохиог монголын биологич эрдэмтэд, дэлхийн эрдэмтдийн нэгэн адил гүнзгий ухамсарлаж, Монгол улсын нэгдэн орсон “Биологийн төрөл зүйл”, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай”, “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай”, “Ган цөлжилтөд нэрвэгдэж байгаа орнууд болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай” зэрэг олон улсын конвенци, амьтан, ургамал, ойн хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор улаан номыг монгол, англи хэлнээ шинэчлэн бичиж, уншигч ТАНАА толилуулж байна.

Монголын “Улаан ном”-ын анхын хэвлэл гарснаас хойших арван жилийн хугацаанд уур амьсгалын хуурайшилт, байгалийн баялагийн ашиглалт эрчимжсэнээс устах аюулд орж болзошгүй ховор амьтан, ургамлын зүйлийн тоо эрс нэмэгдэх хандлагатай байгааг сүүлийн үеийн судалгааны ажлын үр дүн нотолж байна.

Манай улс зах зээлийн эдийн засагт шилжих болсноор биологийн баялагийн ашиглалт ихээхэн нэмэгдэж, амьтан, ургамлын амьдрах орчин хумигдан доройтож байгааг харгалзан, байгаль цаг уурын эрс хатуу ширүүн нөхцөлд амьдардаг, ховордсон амьтан, ургамлын удмын санг хамгаалах зорилгын үүднээс энэхүү номыг шинэчлэх болсон юм.

Улаан номыг шинэчлэхэд дараах чиглэлийг баримталлаа.

Үүнд:

1. “Байгалийн ургамлын тухай”, “Ан агнуурын тухай” Монгол улсын хуулиудад байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн ховор хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтан, ургамлыг “нэн ховор”, байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай устаж болзошгүй амьтан, ургамлыг “ховор” гэж ангилан нэн ховор амьтан, ургамлыг зөвхөн судалгаа шинжилгээний, ховор амьтан, ургамлыг ахуйн болон түүхий эдийн зориулалтаар хуульд заасан онцгой болзол, шаардлагыг хангасан тохиолдолд ашиглахыг зөвшөөрсөн байдаг. Улаан номонд нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай нэн ховор, ховор 100 зүйл амьтан, 128 зүйл ургамлыг оруулав. Нэн ховор, амьтан, ургамал нь дэлхийн ховор зүйлийн ангиллын статуст заасан “устсан” /Extinct/, “устаж болзошгүй” /Endangered/, “эмзэг” /Vulnerable/, “ховор” /Rare/ гэсэн ангилалттай тус тус тохирно.

Түүнчлэн тухайн зүйлийн онцлогт тохируулан унаган, үлдвэр гэсэн тодотголыг хийлээ.

2. “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” Монгол улсын хуульд тус улсын тусгай хамгаалалттай газар нутгийг Дархан цаазат, Байгалийн цогцолборт, Байгалийн нөөц болон Байгалийн дурсгалт газар гэсэн ангилалд хуваадаг.

Олон улсын байгаль хамгаалах холбооноос гаргасан ангиллаар бол Дархан цаазат газар нь “Үндэсний дархан газар”, “Шим мандлын дархан газар”, Байгалийн цогцолборт газар нь “Үндэсний цогцолборт газар”, Байгалийн нөөц газар нь “Зохицуулалт бүхий байгалийн нөөц газар”, “Байгалийн баялагийн нөөц газар”, “Угсаатны нөөц газар”, “Төрөл бүрийн

зохицуулалтын нөөц газар”, Байгалийн дурсгалт газар нь “Үндэсний дурсгалт газар”, “Хамгаалалт бүхий ландшафт”, “Дэлхийн өвийн газар” гэсэнтэй тус тус дүйнэ.

3. Амьтдын тархацыг байгалийн үндсэн бүс бүслүүрээр бичсэн болно [Зураг 1].

4. Ургамлын тархацыг ургамал-газар зүйн мужлалаар үйлдэв [Зураг 2].

5. Уг номонд орсон амьтан, ургамлын зургийг өнгөтөөр зурж, зүйл бүрт тархацын зургийг оруулав.

6. Зарим зүйлийн хамгаалах арга хэмжээний үндэслэл тодорхойгүй, эсвэл бусад зүйлтэй ижил төстэй байгаа нь тэдгээрийн тархац, нөөц, хомсдох шалтгаан, үржлийн талаархи тоймтой мэдээ баримт хомс байсантай холбоотой юм. Гэхдээ тухайн зүйлийн статус нилээд оновчтой гэж үзэх үндэслэлтэй.

7. Амьтан, ургамлын зүйлийн нэрийг оноохдоо одоогоор Монгол улсын хэмжээнд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр баталгаажуулсан нэр томъёоны баримт бичгийг үндэс болгов. Олон улсын хэмжээнд цөөн зүйл, овог, багийн нэр өөрчлөлт орсныг тухайн зүйлийн нэрийн ард хаалтанд бичив.

8. Монгол улс 1975 онд хүчин төгөлдөр болсон Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцид 1996 оны 4 дүгээр сард 133 дахь гишүүн орноор нэгдэн орсон юм. Конвенци гурван хавсралттай байдаг. Үүнд:

Нэгдүгээр хавсралтанд бүрмөсөн устах аюулд орсон зүйлийг бүртгэдэг бөгөөд тэдгээрийн худалдааг онцгой тохиолдолд зөвшөөрнө.

Хоёрдугаар хавсралтанд Тухайн зүйлийн олон улсын хэмжээнд худалдааг зохицуулахгүй тохиолдолд устах аюулд орох зүйлүүдийг оруулна. Энэхүү хавсралтанд орсон зүйлийг худалдах зөвшөөрлийн бичгийг шинжлэх ухааны үндэслэл дээр тулгуурлан олгоно.

Гуравдугаар хавсралтад нэг болон олон улсын хооронд худалдаалах ажлыг зохицуулах шаардлагатай зүйлүүдийг бүртгэнэ.

Номыг бичихдээ эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудын судалгааны мэдээ баримт, гадаадын эрдэмтдийн судлан нийтэлсэн зохиол бүтээлийг аль болохоор бүрэн дүүрэн ашиглахыг эрмэлзлээ. Иймд ховордсон амьтан, ургамлыг хамгаалах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулахад энэхүү ном багагүй үүрэг гүйцэтгэх нь эргэлзээгүй.

Номыг шинэчлэх ажилд Ботаникийн хүрээлэн, Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэн, Монгол улсын их сургууль, Улсын багшийн их сургуулийн нэрт эрдэмтэд, мэргэжилт-нүүд, ялангуяа шинжлэх ухааны тухайн чиглэлээр хамгийн бодитой мэдээлэл гаргаж чадах хүмүүс оролцож, ихээхэн цаг, хүч хөдөлмөрөө зарцуулсан болно.

Хамрагдсан асуудал өргөн хүрээтэй, нэн ээдрээтэй учир алдаж ташаарсан зүйл байхыг үгүйсгэхгүй бөгөөд номын агуулга хэлбэрийг сайжруулах талаар үнэтэй санал зөвлөлгөө ирүүлвээс редакцийн зөвлөл талархалтайгаар хүлээн авах болно.

Ерөнхий редактор, доктор Ц. Шийрэвдамба

# ГУРАВДУГААР ХЭВЛЭЛД ЗОРИУЛСАН ӨМНӨХ ҮГ

Монгол улсын улаан ном хоёр дахь удаагаа шинэчлэгдэн хэвлэгдэж гарснаас хойших 17 жилийн хугацаанд байгаль орчны бодлого, түүний дотроос амьтан, ургамлын аймгийн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах зориудаар өсгөн үржүүлэх, тэдгээрийн амьдрах орчны байгалийн унаган төрхийг хадгалах урт, дунд хугацааны зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг холбогдох олон улсын байгууллагуудаас гаргаж, дэлхийн улс орнууд мөрдлөгө болгон ажиллахыг зөвлөсөн байна. Тухайлбал, Биологийн олон янз байдлын конвенцийн талуудын 2010 оны 10 дугаар бага хурлаас “Биологийн олон янз байдлын 2011-2020 оны стратеги төлөвлөгөө”, “Биологийн олон янз байдлын Айчигийн зорилтууд”, НҮБ-аас гаргасан Рио +20 бага хурлын үр дүнгийн баримт бичигт амьтан, ургамлыг хамгаалах бодлого, зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, биологийн олон янз байдалтай холбогдол бүхий конвенцийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг дэлхийн улс орнуудад үүрэг болгосон байна.

Улсын Их Хурлаас 2008, 2010 онд баталсан “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” зэрэг урт хугацааны төрийн бодлогын баримт бичигт “Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамруулах, зориудаар өсгөн үржүүлэх” зорилтыг дэвшүүлсэн болно.

Үүний зэрэгцээ УИХ-ын 2012 оны хаврын чуулганаар Амьтны тухай хуулийг /шинэчилсэн найруулга/, 2010 онд “Ургамлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” баталж, нэн ховор, ховор амьтан, ургамлын хэсэгт зохих өөрчлөлт оруулж, зөвхөн тэдгээрийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, зориудаар өсгөн үржүүлэхтэй холбогдсон 30 гаруй заалтууд үйлчилж байна.

Түүнчлэн Монгол улсын амьтан, ургамлын Улаан дансыг олон улсын жишигт нийцүүлэн бичиж, монгол, англи хэлнээ хэвлүүлэн гаргалаа.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн эрчимжилтээс байгаль орчин бохирдон доройтох, байгалийн нөөц хомсдох үйл явц улам бүр нэмэгдэж байна. Үүний улмаас манай орны устах аюулд орсон болон устаж болзошгүй амьтан, ургамлын зүйлийн тоо ихсэж байна.

Тухайлбал, манай орны нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь нь ямар нэгэн хэмжээгээр цөлжилтөнд өртөж, нийт бэлчээрийн 70 орчим хувь талхлагдаж, 5000 гаруй гол, горхи, булаг, шанд нуур цөөрөм ширгэж, нэн ховор, ховор хөхтөн амьтдын зүйлийн 16 хувь нь бүс нутгийн хэмжээнд устах аюултай, 2 хувь нь устаж байгаа, 11 хувь нь устаж болзошгүй, ургамлын 11 хувь нь устаж байгаа, 26 хувь нь устаж болзошгүй, 37 хувь нь эмзэг буюу байгаль устах эрсдэлд өндөртэй гэсэн ангилалд хамрагдаад байна.

Эдгээрийг үндэслэн, нэн ховор, ховор амьтан, ургамлын талаарх төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах зорилгоор Монгол улсын улаан номыг шинэчлэн бичиж, хэвлүүлэн уншигч Та бүхэндээ толилуулж байна. Энэхүү номонд хөхтөн – 6, шувуу – 18, мөлхөгч – 1, дээд ургамал – 95, мөөг – 6, хаг – 5, хөвд – 11, замаг – 13 зүйл тус тус шинээр нэмэгдэж, уг номноос хөхтөн – 3, шувуу – 13, дээд ургамал – 60, хаг – 2, хөвд – 3, замаг – 1 тус тус хасагдаж, нийт амьтан – 110 зүйл, ургамал – 192 зүйл тус тус орсон болно.

Дэлхийн байгаль хамгаалах холбооноос гарган мөрдүүлж буй “Олон улсын улаан ном”, “Амьтан, ургамлын Улаан данс”, олон улсын конвенциудын хавсралт, жагсаалт, түүний ангилал, “Амьтны тухай хууль”, “Байгалийн ургамлын тухай хууль”, Монгол улсын Засгийн газрын тогтоолоор баталсан “Ховор амьтан болон ургамлын жагсаалт”-уудыг үндэслэн, уг номонд орсон дээрх нэмэлт, өөрчлөлтийг тусгасан болно. Үүний зэрэгцээ амьтан, ургамлын талаарх судалгаа шинжилгээний шинэ соргог мэдээ баримт, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн нөөцийн хомсдолд нөлөөлж буй хүчин зүйл, хамгаалахаар авсан арга хэмжээ, холбогдох төрийн бодлого, хууль тогтоомж, холбогдох хөтөлбөрүүдтэй уялдуулан хамгаалах арга хэмжээг зүйл тус бүрийн онцлогт тохируулан шинээр тодорхойлсон болно. Энэ номыг монгол хэлнээ бичиж, амьтан, ургамлыг хамгаалахад чухал ач холбогдол бүхий тэдгээрийн ховордлын зэрэглэл, тархац, нөөц, хомсдох шалтгаан, хамгаалахаар авсан болон цаашид авах арга хэмжээг англи хэлнээ орчуулж, бүх амьтан, ургамлыг өнгөтөөр зурж, холбогдох мэдээллийн эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргав.

Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац, нөөц, хомсдолын шалтгааныг судлан тогтоох, мэдээллийн сан бүрдүүлэх, байгалийн жамаар болон зориудаар өсгөн үржүүлэх аргыг боловсруулж хэрэгжүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах ажил өнөөгийн эрэлт хэрэгцээ, шаардлагаас ихээхэн доогуур байгааг энэхүү номыг бичих явцад илэрснийг онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Монгол улсын улаан номны нэг, хоёрдугаар хэвлэлийн эхийг бичсэн болон уг ажлыг зохион байгуулахад оролцсон академич, доктор, профессор О.Шагдарсүрэн, академич, доктор, профессор Н.Өлзийхутаг, доктор А.Болд, доктор Ө.Цогт, доктор Г.Уранчимэг, доктор Г.Зориг, доктор Ц.Цэнджав нарынхаа гэгээн дурсгалыг мөнхлөн хүндэтгэж байна.

Энэхүү номыг шинэчлэн бичиж, хэвлүүлэх ажилд бодитой хувь нэмрээ оруулсан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, доктор С.Оюун, Байгаль хамгаалах сангийн тэргүүн, доктор Ш.Пүрэвсүрэн, Биологийн хүрээлэнгийн захирал, академич, доктор, профессор Ц.Жанчив, Ботаникийн хүрээлэнгийн захирал, академич, доктор Ч.Дугаржав, амьтан, ургамлын аймгийг хариуцсан доктор Ц.Адьяа, доктор Э.Ганболд, ургамлын аймгийг хариуцсан нарийн бичгийн дарга, доктор Г.Цэрэнханд болон нийт зохиогч эрдэмтэн, судлаачид, оролцогч нартаа гүн талархалаа илэрхийлье.

Уг номыг англи хэлнээ орчуулсан доктор З.Батжаргал, амьтан, ургамлын зургийг зурсан, мэргэжлийн зураач Н.Лхагвасүрэн, Д.Батжаргал нартаа баярласнаа илэрхийлж байна.


Монгол улсын улаан ном нь эх орныхоо амьтан, ургамлын аймгийн устах аюулд орсон болон устаж болзошгүй зүйлүүдийг онцгойлон анхаарч хамгаалах, тэдгээрийг байгалийн жамаар нөхөн төлжих нөхцлийг бүрдүүлэх, улмаар зориудаар өсгөн үржүүлэх мэдлэгийг бүх нийтэд олгох, бодлого боловсруулагчид, түүнийг хэрэгжүүлэхэд оролцогч иргэд, иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын идэвхтэй хамтын оролцоог хангахад чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Ерөнхий редактор, Доктор /Sc.D/ Ц.Шийрэвдамба






# ХӨХТӨН АМЬТАН



# 1. АЛТАЙН ЧАЦУУЛИН



*Talpa altaica* Nicolsky, 1883

Баг. Амаахай төрхтөн - *Soricomorpha*

Овог. Чацуулиныхан - *Talpidae*

Статус: Нэн ховор зүйл. Дэлхийн байгаль хамгаалах холбоо /цаашид “ДБХХ” гэх/-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлэгдсэн.

Таних шинж: Бие 190 мм, сүүл 34 мм хүртэл урт. Бие бөмбөгөрдүү гонзгойвгор. Хүзүү богино, хоншоор урт, шонтгор. Газар малтахад зохицон хөл богиноссон, урд хөл илүү бахим, алга нь гадагш эргэсэн. Нүд анивчдаг зовхитой, үсэн дотроо бараг далдарсан. Чихний дэлбээ байхгүй. Зүс тод бүдэг, хүрэн бор толбо бүхий торгомсог гялтганасан бараавтар хүрэвтэр, тугалган хөх саарал [1,3,4].

Тархац, байршил нутаг: Иртыш мөрнөөс зүүн тийш Баруун, Дунд Сибирь, Байгал нуурын баруун өмнөд нутаг хүртэл тархжээ [3,5,6]. Зүйлийн тархацын өмнө зах Монгол улсын баруун хойд хязгаарт Монгол алтайн Цагаан шувуут уулнаас зүүнээ Тана нурууны өвөр бэлийн уулс, Тэс голын эх, Улаан тайга, Дархадын хотгор, Хөвсгөл нуурын хойт уулс, Үүр голын эх хүртэлх зурвас нутагт хэсэгхэн газарт тохиолдоно [1-4]. Ялзмаг ихтэй чийглэг хөвсгөр зөөлөн хөрстэй ой шугуйд голын татам, хөндийгөөс д.т. 3500 м хүртэл [3] нутагладаг.

Амьдралын онцлог: Соён, Алтайд VI-VII сард ороо нийллэгт орж, 9 сар хээлээ тээгээд, дараа оны IV-V сард 6 хүртэл зулзага гаргадаг [3]. Олон салаалан сүлжилдсэн хэдэн км урт үлийлсэн нүхэнд орогнодог. Голдуу чийгийн улаан хорхой, элдэв шавж, тэдгээрийн өндөг өтөөр идэшлэнэ [1,3].

Тоо толгой, хомсдох шалтгаан: Монголд тоо толгойг огт судлаагүй. Голын татам, хөндий

хаврын шар усны үерт автах, цасгүй буюу бага цастай өвөл хөрс гүн хөлдөх зэрэг байгалийн сөрөг нөлөөллөөс бөөнөөр хорогддог [3].

Хамгаалсан байдал: Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн. Монгол улсын улаан ном, Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд тус тус бүртгэн, тархац нутгийн тодорхой хувийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

Хамгаалах арга хэмжээ: Тархац, тоо толгой экологи, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулах, хэвийн өсч, үржих нөхцлийг бүрдүүлэх, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Банников, 1954, 2. Дуламцэрэн, 1970, 3. Юдин, 1971, 4. Соколов нар, 1980, 5. Батсайхан нар, 2010. 6. Павлинов нар, 2002.

## 2. ДОРНЫН САРМААХАЙ



*Vespertilio sinensis* Peters, 1880

Баг. Сарьсандалавчтан - *Chiroptera* Blumenbach, 1779

Овог. Багваахайхан - *Vespertilionidae* Gray, 1821

Статус: Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлэгдсэн.

Таних шинж: Дорнын сармаахай том биетэй, жин 14-25 гр, биеийн урт 67-75 мм, сүүл 40-50 мм, шууны урт 47-54 мм, урт нарийн далавчтай, дэлхэц 30-35 см хүрдэг, унжир [эпиблем] сайн хөгжсөн хөндлөн тэвхтэй, чихний омог доод хэсгээрээ өргөссөн бөгөөд гадагш нугаларсан, чихний цэцэг суурь хэсгээрээ их өргөн, бие богино өтгөн үстэй, нурууны үс хар хүрэн, хэвэл цайвар хүрэн, хоолойн хэсэг цайвар шаргал зүстэй. Нэг популяцид хүртэл

нурууны зүс бараан хүрнээс хар хүрэн, улаан өнгөтэй цайвар сортой буурал байх зэргээр өөрчлөгддөг. Тагнайн атираа 8-9, эмэгчин нэг хос хөхтэй.

Тархац, байршил нутаг: Оросын өмнөд Сибирь ба Алс Дорнод, Хятадын төв болон дорно хэсэг, Тайван, Япон, Солонгосын хойгт тархжээ. Дэлхийн тархацын хамгийн баруун зах нь Монголд байдаг зүүн Азийн уугуул сарьсан далавчтаны ховор төлөөлөгч. Чойбалсан хотын орчим Хэрлэн голын татам [1,2], Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан орчмын нутаг, Халтарын говь [3,4,5], Буйр нуур, Халх голын сав [3,6,7], Сүхбаатар аймгийн Молцог элсний орчим, Дорноговь аймгийн Их Нарт [5], Төв аймгийн Эрдэнэсант уул [8], Дорнод аймаг Матад сум, Хэнтий аймаг Дэлгэрхаан сум, Өмнөдэлгэр сум, Дорноговь аймгийн Сулинхээр, Дорнод аймгийн Чулуунхороот сумын Тарган ухаагийн хилийн застав, Дашбалбар сумын Чух нуур зэрэгт тэмдэглэгдсэн бөгөөд Монгол орны зүүн, төв хэсгээр өргөн тархсан боловч, ховор тохиолдоно. Манай орны амьтны газарзүйн баруун Хянганы тойрог, Монгол дагуурын хээрийн тойрог, Хэнтийн тойрог, хойд говийн тойргуудын далайн түвшнээс дээш 594-1379 метр өндөртэй тал хээр, цөлөрхөг хээрийн бүсүүдэд тархан амьдарна [9].

Амьдралын онцлог: Тал хээрийн бүсэд нуур, цөөрөм, булаг, шандны ойролцоох байшин барилгын дээврийн хөндий, гүүр, өвөлжөө, саравч, хад асга, чулууны завсар хөндийд голдуу үүрлэж амьдардаг. Зүүн зүгийн хүн амын суурьшил багатай өргөн уудам задгай тал нутагт цэргийн орон сууцны байшин зэрэгт олноороо үүрлэнэ. Дорнын сармаахайн эмэгчин хавар V сарын дундуур хаврын нүүдэл хийн зуны байрандаа ирж 50-100 орчим тоотой заримдаа 1000 гаруй тоогоор төрмөл үүсгэн VI сарын сүүлээр VII сарын эхэн хүртэл хугацаанд эмэгчин сармаахай 2 зулзага төрүүлж нэг сар орчим хөхүүлдэг. Дорнын сармаахай буурал сармаахай [*Vespertilio murinus* Linnaeus, 1758]-тай хамтаар төрмөл үүсгэх тохиолдол ч байна. Энэ хугацаанд эр сармаахайнууд ганц нэгээр буюу цөөн тоогоор нийлж тусдаа амьдарна. Эр сармаахай зуны байрандаа эмэгчинээс хожуу ирэх бөгөөд VIII сарын эхээр нийлж сүрэглэнэ. Шинэ төрсөн зулзага VII сарын сүүл, VII сарын эхээр нисэж эхэлдэг. Өвөлжих байрандаа IX сарын сүүлээр ирнэ. Дорнын сармаахайд *Ischnopsyllus needhami* /HSU, 1935/ бүүрэг шимэгчилдэг [10]. Дорнын сармаахай харуй бүрий болмогц нисэж эхлэх бөгөөд задгай уудам орон зайд өндөрт нисэн ангуучилж эрвээхий, цох, шумуул зэрэг шавжаар хооллодог.

Тоо толгой хомстох шалтгаан: Тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлт хандлагын талаарх мэдээлэл хангалтгүй байгаа боловч хүний буруутай үйл ажилгааны улмаас олноор нь алж устгах тохиолдол цөөнгүй байна. Байгаль, цаг уурын хүнд ширүүн нөхцөлөөс болж, өвлийн улиралд олноороо хорогдож, тоо толгой буурдаг. Дорнын сармаахай хүний суурьшил даган байшин, барилга, өвөлжөө саравчинд орогнож үүрлэдгээс гэрийн мууранд бариулах, дуу чимээ, паразит, ялгадас зэргээс төвөгшөөх, малын өтөг бууцаар утах явдал байсаар байна. Үүрлэн амьдрах орчин хомс, нэг дор олноороо цуглан амьдардаг учраас бөөнөөрөө эрсдэлд орох магадлал өндөр байна. Уул уурхайн үйл ажиллагаа, хуучны барилга байгууламжийг эвдэх, зам гүүрийг сэргээн засах, гал түймэр, химийн хорт бодис зэрэг санаатай болон санамсаргүй үйл ажиллагаанаас өртөн амьдрах орчин хомсон, устаж болзошгүй зүйл.


Хамгаалсан байдал: Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэгдсэн. Монгол улсын улаан номонд хязгаарлагдмал тархацтай ховор зүйл хэмээн

бүртгэсэн. Тархац нутгийн зарим хэсгийг улсын тусгай хамгаалалттай газарт авсан.

Хамгаалах арга хэмжээ: Хуурай хээрийн бүсийн булаг, шандыг хүний шууд болон дам сөрөг нөлөөллөөс хамгаалах, байнга болон түр зуур олноороо бөөгнөрөн амьдрах орчныг илрүүлэн хамгаалах, алж, устгахгүй байх, экологи, биологийн судалгааг нарийвчлан хийж, хүнд үзүүлэх нөлөө, улирлын нүүдэл, өвөлжилт, тархац, нөөцийг судалж тогтоон, хамгаалах арга боловсруулан хэрэгжүүлэх. Үүрлэх орчин ховор тал хээрийн бүсэд айлын байшин, өвөлжөө, хашаа, саравчинд үүрлэх амьдрах нь элбэг байх тул нутгийн иргэдэд ашиг тусыг ойлгуулан хиймэл үүр барьж өгөх зэрэг арга хэмжээ авах.

Эх зохиол: 1. Банников, 1954, 2. Дорждэрэм, 2004, 3. Соколов нар, 1980, 4. Малыгин нар, 1986, 5. Ариунболд, 2005, 6. Horacek, 1997, 7. Мөнхбаатар, Ариунболд, 2009, 8. Nyambayar et al, 2010, 9. Ариунболд нар, 2011, 10. Scheffler et al, 2010.

### 3. ШАРНАД ЦӨӨВӨР



*Cuon alpinus Pallas, 1811*

Баг. Мах идэштэн - *Carnivora*

Овог. Чонынхон - *Canidae*

Статус: Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “устсан” хэмээн үнэлэгдсэн.

Таних шинж: Бие 110 см, сүүл 50 см орчим урт. Саарал чононоос жижиг, үнэгнээс том. Зүс тод улаан зээрд. Хэвэл, суга, цавь, чихний дотор тал цайвар. Сүүл саарал чононыхоос урт сагсгар, үнэгнийхээс арай богино, жигд улаан буурал. Завж, багалзуурын үс урт.

Тархац, байршил нутаг: Монгол дахь тархац дэлхийн тархацын хойд захад хамаарна [3]. Өнгөрсөн зуунд Хэнтий, Хөвсгөл орчмын уулс, Хангай, Монгол Алтай, Алтайн өвөр говь, Өмнөговийн уулсаар ховор биш тохиолддог байжээ [1,2,3]. 1930 онд Өмнөговийн Ноён, Сэврээ, Нэмэгт ууланд агнасан, дөчөөд онд Цагаан богд, Эдрэнгийн нуруу, Суман хаданд үзсэн мэдээтэй [1,6]. 1950 онд Монгол Алтайд устаж, Хөвсгөл орчимд алга болж, Өмнөговь, Алтайн өвөр говь, Говь-Алтайн зарим уулсаар ховорхон үзэгдэх болов [1,4]. Сэгс цагаан богдод 1967 онд хэд хэдэн удаа үзэгдсэн, 1968 онд Өмнөговийн Алтан ууланд хавханд орсныг тухайн үед нутгийнхан мэдээлж байв [2]. Өмнөговийн Зөөлөн ууланд 1969 онд хавханд орсон тохиолдол Монголд байгаагийн хамгийн сүүлчийн бодит баримт нотолгоо болно [2,6]. 1991 оны өвөл Тува Монголын хил орчимд улаан чоныг харсан хоёр тохиолдол бий. 1988 онд монголын хил залгаа Тес-Хемийн районд 4 улаан чоно хоёр хонь барьсан, Цагаан толгойн заставын офицер Гаврилов улаан чоно харсан хэмээх баримтууд бүртгэгджээ [10]. Мөн 1995-1996 онд Байгалийн чанадын өмнөд бүс нутгаас 4 улаан чонын арьс бэлтгэсэн мэдээ бий [11]. Харин түүнээс хойш цөөвөр чоныг үзсэн, олдсон үнэмшилтэй мэдээ алга [6]. Одоо зөвхөн Алтайн өвөр говьд Аж Богдын нуруунаас Тост уул хүртэл, ялангуяа, Цагаан Богд орчим, Өмнөговь, Хөвсгөлийн уулсаар тохиолдож магадгүй хэмээн судлаачид тэмдэглэдэг [2,12].

Амьдралын онцлог: Аргаль, янгир, туулай элбэгтэй говийн хад, цохиот уулс, бор гөрөөс, хүдэр, буга нутагладаг Хөвсгөлийн тайгын ян сарьдагт байршдаг байжээ. Бөөн, сүргээр явж, иддэг амьтнаа хоморголож барьдаг [3]. Гөрөөсний сэг зэмд ирнэ. Өнгөрсөн зуунд малд байнга довтолдог байсныг нутгийнхан ярьдаг [6]. Өмнөговийн Ноён ууланд агуйд үүрлэж, хоёр бэлтрэг гаргасныг нутгийн анчин олсон мэдээ бий [1]. I, II сард отолж, IV сард бэлтрэглэсэн мэдээтэй [3].

Тоо толгой, хомсдох шалтгаан: Тоо толгойн тухай мэдээ байхгүй. Малд халдахад агнадаг, хоол болдог амьтан ховордож цөөрсөн, чоно, ирвэс элбэгшиж, тэжээлийг булаасан зэргээс устаад байгаа дэлхийн хэмжээнд ховордсон зүйл.


Хамгаалсан байдал: 1973 оноос хуулиар агнахыг хориглож, улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралт, Олон улсын болон Монгол улсын улаан номд тус тус оруулжээ [7,8,9]. Тархаж байсан нилээд нутаг улсын тусгай хамгаалалттай нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ: Монголд байршиж, түр шилжин ирж болзошгүй нутагт судалгаа хийж, устсан эсэхийг үнэлэн тогтоох, сэргээн нутагшуулах эсэх асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт саналыг боловсруулах, удмын санг хадгалах арга хэмжээ авах.

Эх зохиол, мэдээ: 1. Банников, 1954, 2. Дуламцэрэн, 1972, 3. Гептнер нар, 1967, 4. Цэвэгмид, 1963, 5. ОСТСО-ийн улаан ном, 1983, 6. Дуламцэрэн, 1992, 7. Шагдарсүрэн нар, 1987, 8. Олон улсын улаан ном, 1988, 9. CITES, 1991, 10. Савельев, Шурыгин, 1997, 11. Пузанский, 1997, 12. Соколов, 1996, 13. Шийрэвдамба, нар, 1997.



## 4. ЦООХОНДОЙ МИЙ



*Felis libica* Forster, 1870 [*Felis silvestris* Schreber, 1977]

Баг. Мах идэштэн - *Carnivora*

Овог. Мийнхэн - *Felidae*

Статус: ДБХХ-ны улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй” бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” зүйл гэж үнэлэгдсэн [1].

Таних шинж: Биеийн хэмжээ, галбир гэрийн мууртай төстэй. Бие 59 см, сүүл 34 см урт [2]. Зоо нурууны дагуу өргөн бараан хүрэгтэр, боровтор судалтай. Биеийн хажуугийн цайвар бор, хөхөвтөр саарал дэвсгэр өнгөн дээр хөндлөн эгнэсэн бараан, бор, хүрэгтэр толбонуудтай. Хэвэл, мөчдийн дотор тал цайвар. Сүүлний үзүүр байраан, түүнээс дээш 4-5 тод бөгжилсэн бараан бүслүүртэй. Чихний үзүүрт 3 см шахам урт, бийр шиг цацаг үс бий [2-5].

Тархац, байршил нутаг: Африк, Энэтхэг, Төв Азийн цөл хээрийг хамарсан өргөн уудам нутагт тархана [2]. Монголын цөл, цөлөрхөг хээрийн бүсэд тархацын зүүн хойд зах хамаарна. Шаргын говь, Захуйн баян бүрдээс олдож, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Өмнөговьд алаг цоог тархсан [3-5]. Хармаг, заг, сухай бүхий элсэн довцог, баянбүрд, булаг шанд, шал тойрмын захын заг, сухай, харгана, дэрс бүхий газар довцог элс, манхан, хадархаг дов толгод, уулын бэлийн сайрт амьдардаг [4]. Хаяагүй ховор тохиолдоно.

Амьдралын онцлог: Ш сарын дундуур бие гүйцсэн эмэгчиний хээлэнд 5 мий байжээ. Элсэн дов сондуул, заг, сухайн бут доогуур нүх малтаж үүрээ засна. Жижиг мэрэгч, шувуугаар хооллоно. Захуйн говьд цоохондой мий өвлийн идэш тэжээлийн 92 хүртэл хувийг ногтруу

[*Syrrhaptes paradoxus*], тагтаа [*Columbia livia*], согсоот болжмор [*Galerida cristata*], Шоорон алаг болжмор [*Eremophilla alpestris*], оронгийн болон хээрийн боршувуу [*Passer domesticus* and *P. Montanus*] зэрэг шувууд шар чичүүлээр хооллодог байна [4-6]. Голдуу харуй бүрийгээр идэшлэнэ. Их нуугдамхай.


Тоо толгой, хомсдох шалтгаан: Монголд бага судлагдсан. Шар үнэг, хярс үнэг, шилүүс мий зэрэг амьтдад тавьсан хавханд орж агнуулна [5]. Зөвхөн Захуйн говьд 1995-1997 онд 4-5 цоохондой анчдын хавханд орж үхсэн байна [7]. Захуй, Зарман, Эхийн гол зэрэг хүн ам суурьшсан баян бүрдүүдийн орчмоор гэрийн мууртай эрлийзжих болсон нь удмын санг алдагдуулж болзошгүй [8]. Цөл, хээрт идэш тэжээл ховор үед саарал чоно, бүргэд, хаяа нохойд бариулна. Нутгийн хүмүүс тохиолдлоор агнана.

Хамгаалсан байдал: 1996 оноос агнахыг хуулиар хориглосон. Монгол улсын улаан ном [1987,1997], Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай [9] конвенцийн II хавсралтад тус тус бүртгэж, тархац нутгийн нэлээд хэсгийг Говийн их дархан цаазат газарт хамруулав [10,11].

Хамгаалах арга хэмжээ: Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулж, тоо толгойг өсгөх, амьдрах орчныг хамгаалах арга хэмжээ авах. Монгол орны ховор амьтны жагсаалт батлах тухай Засгийн газрын тогтоолын хавсралтад нэмж бүртгэх, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Монгол орны хөхтөн амьтны улаан данс, 2006, 2. Гептнер нар, 1972, 3. Банников, 1954, 4. Дуламцэрэн, 1970, 5. Дуламцэрэн нар, 1994, 6. Мөнхцог нар, 2002, 7. Б. Мижиддорж, 1997, 8. Довчиндорж, 2002, 9. CITES, 1991, 10. Шийрэвдамба нар, 1997, 11. Энэбиш нар, 2007.

## 5. ГОВИЙН ЕВРАЗИ ШҮЛҮҮС



*Lynx lynx isabellina* Blyth, 1842

Баг. Мах идэштэн - *Carnivora*

Овог. Мийнхэн - *Felidae*

Статус: Ховор зүйл.

Таних шинж: Биеийн урт 106 см, сүүлний урт 24 см, чихний урт 9.9 см, жин 21.6 кг хүрнэ [3,5]. Наймдугаар сарын сүүлээр эр ногуул 7.5 кг орчим жинтэй болно [6]. Эмэгчин биеэр арай бага. Бусад зүйл шүлүүснээс харьцангуй том биетэй, мөч урт, зэгзгэрдүү, тавхай том. Бор саарлаас шаргалдуу зүстэй. Чихний үзүүрт урт шовх хар өнгийн цацаг үстэй. Сүүл богино, үзүүр нь хар.

Тархац, байршил нутаг. Норвеги, Швейцариас Төвдийн өндөрлөг хүртэл өргөн уудам нутаг тархсан. Евразийн шүлүүсний зүйлд хамаарах боловч [1-3] хязгаарлагдмал тархацтай. XIX зууны сүүлээр Алтайн өмнөх говьд шүлүүс байгаа тухай болон Атас ууланд харсан гэсэн мэдээлэл байна [7]. Өмнөговь, Алтайн өвөр говийн хад чулуутай нүцгэн, намхан уулс, толгодоор байршиж, тэдгээрийн хоорондох хөндий гатлан гөрөөлнө [3,6,8]. 1950-иад онд А.Г.Банников Тостоос Атас хүртэлх бүх уулсаар шүлүүс ердийн тархацтай гэж тэмдэглэсэн [8]. Говийн их дархан цаазат газрын А хэсэг, түүний хил залгаа нутагт 1981-1987 онд говийн шүлүүсний бие, мөр үзсэн, агнасан, амьтан барьж идсэн сэг зэм олдсон 44 цэг тэмдэглэж, Алтайн өмнөх говьд шүлүүс ихэнх уулс, аараг толгод, бэлийн сайр садарга, бут сөөгт тал, уулсын хоорондох хотгор хоолой говьд тааралдана [6].

Амьдралын онцлог. Баянбүрд, задгай ус, булаг шандын хавьд бараг байнга нутаглаж зулзагалж, бүл 2-3 толгойгоор үзэгддэг. Ихэвчлэн шөнийн идэвхтэй ч эзгүй говь, цөлд өдөр ангуучлан явах нь тохиолдоно. Говийн шүлүүс голдуу 2-3-аар нийлж ан хийнэ. Туршлагатай хашир нь эхэлж довтолно. Хар сүүлт зээр, бөхөн, аргаль хонь, янгир ямаа, туулай, хахилаг, ногтруугаар хооллож, тэдгээрийн байршлыг дагаж нутаглана. Хар сүүлт зээрийн усанд ирэх жим дээр отож, эсвэл идээшилж байхад нь сайр, бут, бартаа даган мярааж ойртоод гэнэт үсрэн дайрч барина [6]. Жижиг мэрэгчид иднэ. Гэрийн ямаа олонтаа барих, нялх ботго, муур, тугал идсэн тохиолдол бүртгэгдсэн [6]. Ороо хөөцөө 2-3 сард болж, дунджаар 69 хоног хээлээ тээж, ихэвчлэн 2 ногуул төрүүлнэ. Говийн шүлүүс 7-р сарын хорьд орчмоос үүрнээс холдож ногуулаа дагуулан бүл сүргээр явж, ан авд сургаж эхэлнэ [3,6].

Тоо толгой, хомсдох шалтгаан. Нутгийн иргэд хавх, буугаар олонтаа агнана, ялангуяа гэрийн мал, ямаа идсэн бол мөр хөөж заавал агнахыг хичээнэ [6]. Монгол Алтайн нурууны өвөр бэл Баянбулаг хавийн 600 км<sup>2</sup> талбайд 10 сар хүртэл 9 шүлүүс агнаж байжээ. Гантай жил зээр, гөрөөс, ногтруу алс нүүдэллэж, туулай ховордоход идэш эрж, арзгар хад чулуу, хайргат говиор тэнэсэн шүлүүсний тавхайн ул хагарч урагдан, цус алдаж, үхэж хорогддог тохиолдол бий [6]. Устаж болзошгүй зүйл.


Хамгаалсан байдал: Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар [4], Ховор, ховордсон амьтан, ургамлын зүйлийг олон улсын хэмжээнд

худалдаалах тухай ковенцийн II хавсралтад тус тус бүртгэсэн [9].

Хамгаалах арга хэмжээ: Говийн шүлүүсний тархац, тоо толгой, экологи, биологийн онцлогийг судлан тогтоох, тархац нутгийг тусгай хамгаалалттай нутгийн сүлжээнд нэмж хамруулах, хамгаалалтыг сайжруулах, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй амьдрах орчин доройтохоос сэргийлэх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авах, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ. 1. Blyth, 1842, 2. Евроазийн шүлүүс, 2003. 3. Дуламцэрэн, 1970, 4. Монгол улсын Засгийн газрын тогтоол, 2012, 5. Kristin Nowell and Peter Jackson, 1996, 6. Дуламцэрэн, 1995, 7. Ладыгин, 1900, 8. Банников, 1954, 9. CITES, 1991.

## 6. ЦООХОР ИРВЭС



*Panthera uncia Schreber, 1775*  
Баг. Мах идэштэн - *Carnivora*  
Овог. Мийнхэн - *Felidae*

Статус: Нэн ховор зүйл [1]. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “устаж болзошгүй” [2], бүс нутгийн хэмжээнд “ховор” зүйл хэмээн үнэлэгдсэн [3].

Таних шинж: Хүчирхэг том мий. Биеийн урт 135 см, сэрвээний өндөр 60 см, сүүлний урт 92 см, жин 45 кг хүрнэ. Бие сунагар урт, гинс [эмэгчин] гэндээс биеэр бага. Мөч богино, сарвууны алга тавхай өргөн, том, нуумал хумстай. Толгой жижиг, чих богино. Нүд том, хүүхэн хараа дугуй. Цайвар, шаргал дэвсгэр дээр 6-8 см дугуйвтар хар толбонуудтай эрээн цоохор зүстэй. Хэвэл толбогүй, цагаан цайвар өнгөтэй. Толгой, духны хэсэгт жижиг, шигүү хар толбонууд бий [4-6].

Тархац, байршил нутаг: Цоохор ирвэс Төв Азийн Алтай, Соён, Памир, Тэнгэр, Түвдийн

өндөрлөг, Гималай, Хар хорум зэрэг уулс, 12 улсын нутагт тархсан. Монголд Монгол Алтай, Говь Алтай, Алтайн өвөр говь, Хөвсгөлийн уулс, Хангайн нуруунд тохиолдоно.

Амьдралын онцлог: Хаврын тэргүүн сард ороо нийллэгт орж, хагас сар орчим үргэлжилнэ. V-VI сард хадны хөндий, агуйд 2-5, ихэвчлэн 3 гүем төрүүлж 3 сар орчим хөхүүлнэ. Үржилд 3-4 настайгаасаа орно. Гүем бараг 2 нас хүртэл эхтэйгээ байна. Гинс жил өнжиж төллөнө. Идэш тэжээлийн 40 гаруй хувийг янгир ямаа эзлэх бөгөөд аргаль хонь, тарвага, туулай, огдой, хойлог, хахилаг зэрэг амьтад барьж иднэ. Голдуу бүрэнхий, харанхуйд хоолоо олно. Сэм явдалтай, нуугдмал амьдралтай [6-10].


Тоо толгой, хомсдох шалтгаан: 1970-аад оны дундуур Монголд 700 гаруй, 1980-аад оны дундуур 2000 орчим бүртгэгджээ [9,11,12]. 1990-ээд оны дундуур 10 аймгийн 107 сумын 160.000 км<sup>2</sup> нутагт 1700 орчим буюу 100 км<sup>2</sup> нутагт 0.8 [10], зарим судлаачдын мэдээгээр, 1000 орчим буюу 100 км<sup>2</sup> нутагт 1.1 [13] ноогдож байсан бол, 2000 онд 103.000 км<sup>2</sup> нутагт 800-1500 цоохор ирвэс 100 км<sup>2</sup> нутагт 1-1.5 бодгаль ноогдох нягтшилтай байна гэж үзжээ [14]. Хөх Сэрх, Модонт, Охонт, Баатархайрхан ууланд цоохор ирвэс хамуурч үхсэн тохиолдол бий. Нялх гүем үерт урсах, махчин амьтан амьтдад бариулах зэргээр үрэгдэнэ. Эзэнгүй бэлчих гэрийн малд халдана. Идэш тэжээл болдог уулын туруутан цөөрч, гэрийн малын тоо толгой өсөж байршил нутагт нь түрж орсноос цоохор ирвэс малаар хооллох нь ихэслээ [10, 14, 15].

Хамгаалсан байдал: 1993 оноос ан олзворын зориулалтаар агнахыг хориглож, амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан. Монгол Алтай, Говийн Алтай, Хангайн нуруу, Алтайн өвөр говь, Хөвсгөлийн уулсын 20 орчим улсын тусгай хамгаалалттай газарт цоохор ирвэсний тархац нутгийн цөм хэсэг хамгаалагдсан [9,16]. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай [17] болон Нүүдэллэдэг зүйлийг хамгаалах тухай олон улсын конвенцийн I хавсралт болон Монгол улсын улаан номонд тус тус оруулсан. Монгол Алтай, Говь Алтайн нурууны цоохор ирвэсний тархац нутаг, биологи-экологийн судалгааг хийж, Монгол орны цоохор ирвэс хамгаалах менежментийн төлөвлөгөө [1999], Увс аймгийн цоохор ирвэс хамгаалах менежментийн төлөвлөгөө [2000], Монгол орны цоохор ирвэс хамгаалах хөтөлбөр [2005], Увс аймгийн цоохор ирвэс хамгаалах хөтөлбөрийг [2011] боловсруулан хэрэгжүүлсэн [14,15].

Хамгаалах арга хэмжээ: Ховд аймгийн ихэнх нутаг, Хөвсгөлийн уулсын ирвэсний тархацыг нарийвчлан тогтоож, хамгаалах, устсан юмуу цөөрсөн нутагт сэргээн нутагшуулах, тархац хумигдах, амьдрах орчин доройтохоос сэргийлэх, хамуу өвчнийг устгах, биологийн, мониторингийн судалгааг хийж, экосистемийн хэмжээнд хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Амьтны тухай хууль, 2012, 2. Jackson, R. et.all, 2008, 3. Монгол орны хөхтөн амьтны улаан данс, 2006, 4. Банников, 1954, 5. Дуламцэрэн, 1970, 6. Гептнер нар, 1972, 7. Болд нар, 1976, 8. Маллон, 1984, 9. БНМАУ-ын улаан ном, 1987, 10. Амарсанаа, 1994, 11. Даш, 1979, 12. Амарсанаа, 1985, 13. Шаллер нар, 1994, 14. Маккарти, 2000, 15. Мөнхцог,

## 7. ГОЛЫН ХАЛИУ



*Lutra lutra* Linnaeus, 1758

**Баг.** *Мах идэштэн - Carnivora*

**Овог.** *Суусрынхан - Mustelidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “Ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Бие 95 см, сүүл 55 см хүртэл урт, жин 10 кг хүрнэ [5,11]. Шишгэд голд байршдаг зулзаган эвүүний бие 55 см, сүүл 36 см урт, жин 4.5 кг байв [4]. Бие гонзгой сунагар, цээж рүүгээ шувтан. Толгой жижиг, тавшгар. Мөчид богинохон, хуруунууд сэлэхэд зохиолдсон арьсан холбоостой. Сүүл үсэрхэг урт, угаараа бүдүүн, үзүүр тийшээ шувтан. Зоо нуруу, хавирга, сүвээ орчмоороо бараан хүрэн, гэдсээрээ мөнгөлөг цайвар зүстэй. Махилзаж суналзсан өвөрмөц хөдөлгөөнтэй.

**Тархац, байршил нутаг:** Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтий, Хянганы хаяа уулсын гол мөрөн зарим цэнгэг нуурт тархмал байгаад сөнөсөн [1,2]. 1920-1930-аад онд Онон, Минж, Завхан, Тэс, Тамир, Чулуут, Шишгэд, Дэлгэр мөрөн, Эг, Халх голын савд ховорхон үзэгддэг байжээ [1,2,7]. 1995 оны байдлаар Шишгэд голын Тэнгис Шишгэдийн бэлчирээс улсын хил хүртэлх, Халх голд Амгалантаас улсын хил хүртэлх зах хязгаарт маш цөөн үлдэж, Бэлтэс, Эг, Тэс, Хуримт голын зарим хэсэгт хааяа гүйдлээр үзэгддэг [2,3-5,10]. Халх, Нөмрөг голын шигүү бургас, монос, зэгсэн, шугуйт зэлүүд ширэнгэ, тохойд байрладаг. Шишгэдэд уулсын тайгын гүн хавцал, өтгөн шигүү ой дундуур урссан өвөл харзалдаг, ширүүн урсгалтай, боргиотой хэсэгт тааралдана. Орогнодог нүхний амсар голын эрэгт, усны түвшнээс доод талд, харин хэвтэр ноохой нүхнийхээ мухарт эргээс 4 м хүртэл зайд газар доор 2 м хүртэл гүнд байна. Ноохойноосоо дээш цооног малтаж хүн үл нэвтрэх, үзэхүйяа бэрх, өтгөн ширэнгэ дотор, эсвэл бутан доогуур салхивч, өрх гаргана [5]. Дархадын хотгор, Халх гол орчмын нутагт тархсан [13], Дархан уул аймгийн Хонгор сумын нутаг Хүйтний голд тархсан [14],

Монгол Алтайд Даян нуурын сав газарт тархсан [15], Онон голд тархсан [16] тухай судлаачдын сүүлийн үеийн мэдээ бий.

**Амьдралын онцлог:** Шишгэдэд Ш сарын дундаас отолж эхэлдэг [3,5]. Халх голд нутгийнхан 5 боортой эвүү үзсэн тохиолдол бий [4]. Ихэвчлэн загасаар хооллохоос гадна жижиг мэрэгч, шувуу, усны амьтдыг иднэ. Усан доторх болон эргийн хад чулуу, унанги модон дээр нарлаж, салхилж хэвтдэг. Өвөл заримдаа татмын шугуй, тохойг хэсэж, уул давж ой туулан хэдэн арван км хол голоос голд гүйдэг [1, 2, 3-5].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** 1970-аад оны сүүлчээр Монголд 20 гаруйхан байв [4,9]. Халх гол, Дархадын хотгорт 1995 онд хийсэн судалгаагаар, эдгээр нутагт нийтдээ 100 орчим толгой халиу байгааг тогтоожээ [13]. Дээр үеэс хайр гамгүй агнаснаас хүн байнга нутагладаг том голуудын татамд устаж, зэлүүд нутагт нэн цөөн үлдсэн [1,2]. Өвөл хоол тэжээл хайх, нар салхинд гарах, үржлийн хосоо олж, хөөцөлдөх зэргээр уснаас гарч цас мөсөн дээгүүр хэсэх үед хүн, золбин нохой, чоно, нохой зээх, бүргэд мөрдөн отож хороодог. Нүхний амсрыг мөс таглан хөлдөх, өрхөөр үер орж, эрэг нурж, үүр байр усанд автах зэргээс бүлээрээ сөнөдөг. Устах аюулд орсон зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улс 1930 оноос агнахыг хориглож, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэгдсэн. Монгол улсын улаан ном болон Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралтад тус тус оруулан, Халх гол дахь тархац нутгийг Нөмрөгийн дархан газарт хамруулсан [6,8,10,12].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц биологийг судалж, хамгаалах арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, гадагш урсгалгүй голд зориудаар өсгөн үржүүлэх, Доод Шишгэд, Халх голын эхийн тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Намнандорж, 1976, 3. Цагаан, 1970, 4. Цагаан, 1977, 5. Цагаан, 1975, 6. БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975, 7. Скалон, 1949, 8. Закон об охоте МНО, 1930, 9. Мягмарсүрэн, 1994, 10. Шийрэвдамба нар, 1997, 11. Гептнер нар, 1967, 12. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 13. Самьяа нар, 1998, 14. Цэнджав, 2005, 15. Шар, Самьяа, 2007, 16. Батсайхан нар, 2008.

## 8. СУУСАР БУЛГА



*Martes foina intermedia*, Erxleben, 1777

**Баг.** Мах идэштэн - *Carnivora*

**Овог.** Суусрынхан - *Mustelidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Биеийн урт 430-540 мм, сүүлний урт 230-325 мм. Гавлын ясны кондилобазаль урт эрэгчнийх 71-86 мм, эмэгчнийх 74-80.2 мм, сонсголын ясны өргөн эрэгчнийх 47.9-56.4 мм, эмэгчнийх 46.2-50.6 мм, гавлын ясны өндөр эрэгчинд 30.1-33.1 мм, эмэгчинд 29-31 мм, жин 11-2.3 кг [2]. Биеийн өнгө ерөнхийдөө сааралдуу хүрэн. Саарал өнгийн ноолуур сор үсний дундуур нэвт харагдах учир сааралдуу суурьтай хүрэн зүс зонхилно. Өөхий цагаан, хааяа шаргалдуу туяатай байх бөгөөд төгсгөлдөө салаалж өмнөд мөчиндөө хүртэл үргэлжилнэ. Сүүлний урт их биеийн уртын хагастай тэнцүү. Чих орой хэсгээрээ дугуйрсан. Сүүл болон хөл их биеийн өнгөнөөс илүү бараан. Чихний дэлбэ харьцангуй том [2,3].

**Тархац, байршил нутаг:** Монгол Алтай, Говь Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулс, Хангайн өвөр хэсэг, Нууруудын хөндий, Умард говь, Дорнод говийн умард хэсгийн уулын хээр, говийн хад чулуутай нүцгэн уулс толгодоор өргөн тархдаг [2-5]. Монгол Алтайд суусар бут сөөг ургасан хадны ан цаваар, Хөвсгөл орчимд уулын дунд хэсгийн хад асгаар, ойт хээрийн бүсийн уулын задгай энгэрээр тус тус байршина [2,3].

**Амьдралын онцлог:** Ихэвчлэн шөнийн идэвхтэй хааяа өдрийн цагаар гөрөөлнө. Жижиг мэрэгчид, шувууд, тэдгээрийн дэгдээхий, ургамлын үр, жимсээр хооллоно. Орхигдсон нүх, хадны хонгил, завсарт орогноно. Ороо хөөцөө зун орно. Хээлээ тээх хугацаа ойролцоогоор 8 сар үргэлжилж, хавар 4-р сарын сүүлчээр ихэвчлэн 3-4, хааяа 8 хүртэл хойв гаргана. Байгальд 12-14 насална [2,3].

**Тоо толгой, хомсдох шалтгаан.** Тархац, популяцийн өөрчлөлтийн хандлага, учирч буй



аюулын талаарх мэдээлэл хангалтгүй. Арьсыг дотоодод хэрэглэхээс гадна олон улсын хэмжээнд худалдаалдагаас үүдэн хууль бусаар агнадаг. Өвөлжөөнд нөөцөлсөн идэшний махыг идэх тул хавх, занганд орж эндэх нь элбэг [4]. Ховд, Улиастайн хязгаараас жилд 200 хүртэл тооны арьсыг бэлтгэж байсан мэдээ бий. Арьс бэлтгэлийн мэдээнээс үзэхэд, өнгөрсөн зууны 30-40-өөд оны үед Хатгал, Ховд, Улиастай, Говь-Алтай орчмын нутгаас жилд цөөн тооны арьс худалдаалагддаг байсан бөгөөд улсын хэмжээнд 20-30-аас хэтрэхгүй байжээ [2]. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолоор ховор амьтнаар бүртгэж, суусрын тархац нутгийн 21 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагджээ [1,4].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой, экологи, биологийн онцлогийг нарийвчлан судлах, хууль бусаар нийлүүлж байгаа арьс үс, агналтын хэмжээг тодруулж үндсэн тархац нутгийг ялангуяа, байнга байршин амьдардаг цөм нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай нутгийн сүлжээнд хамруулах, хамгаалалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1.Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, 1996, 2.Банников, 1954, 3.Батсайхан нар 2010, 4. Clark нар, 2006, 5. Дуламцэрэн, 1970.

## 9. ОЙН БУЛГА



***Martes zibellina* (Linnaeus, 1758)**

**Баг.** Мах идэштэн - *Carnivora*

**Овог.** Суусрынхан - *Mustelidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд

“анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Эрэгчний биеийн урт 390-450 мм, сүүлний урт 118-159 мм, харин эмэгчний биеийн урт 375-420, сүүлний урт 115-145 мм байдаг. Гавлын ясны кондилобазаль урт эрэгчнийх 75.2-82.1 мм, эмэгчнийх 72.1-79.6 мм, сонголын ясны өргөн эрэгчнийх 33.0-37.1 мм, эмэгчнийх 31.7-34.7 мм, гавлын ясны өндөр эрэгчинд 28.4-30.9 мм, эмэгчинд 26.7-30.0 мм, жин 1100-1700 гр [7] хүрнэ. Биеийн өнгө газарзүйн бүс бүслүүрээс шалтгаалан харилцан адилгүй бөгөөд Хэнтийн булга хар хүрэн, хар, мөнгөлөг сортой халтар хүрэн, Хөвсгөлийнх хүрэн шаргал, шар хүрэн халтар зүстэй байдаг [1,4,7]. Булга сахлаг зөөлөн торгомсог үстэй. Толгойн хэсэг их биеэсээ нилээд цайвар, зоо нурууныхтайгаа ерөнхийдөө ижил боловч арай цайвар хүрэн байдаг. Мөч богино, бахим. Өехийдөө шаргалдуу толботой байх боловч, хааяа толбо илрэхгүй [2].

**Тархац, байршил нутаг.** Хэнтий, Хөвсгөл, Соён, Алтай, Булган голын эх, ой тайгад хад, асга бүхий нутагт тархсан жинхэнэ ой тайгын амьтан [1,2,4,7]. Хэд хэдэн салбар зүйл (*M.z.sajanensis*-Хөвсгөлийн уулсын зүүн хэсгээр, *M.z.princeps*-Хэнтийн нуруу, Монгол дагуурын хээр, *M.z.averini*-Монгол Алтайн нуруугаар) тархан байх боломжтой талаар тодорхой таамаглал байгаа ч уг зүйлийн ангилалзүйн судалгаа бага хийгдсэн [3,7]. Тархац нутгийн бартаа ихтэй хуш, хуш шинэсэн ой, шинэсэн ойд орогнон байрших бөгөөд [4,7] хушин ой нь булга зэрэг ойн жижиг махчидын тэжээлийн зонхилох хувийг эзэлдэг, төрөл бүрийн жигүүртэн орогнон байрших нөхцлийг бүрдүүлдэг байна [7]. Голын хөндийн шинэс, улиас, гацууран төгөл, болон торлогон ширэнгэ бүхий газарт булганы мөр хааяа тааралдах боловч энэ нь түүний гөрөөлөх нутаг болно. Хэнтийд булга тархсан нутгийн 1000 га дугамд 9-15 толгой тохиолдож, эзэмшил нутаг 0.3-3.2 км<sup>2</sup> байх ажээ [7].

**Амьдралын онцлог.** Хоногийн турш идэвхтэй, өдөр шөнийн амьдралтай [4,7]. Хааяа өдрийн цагаар ч гөрөөлнө. Ойн булга идшиндээ сээр нуруутан /ойн төрөл бүрийн жижиг мэрэгчид, туруутан амьтад/, шувуу, сээр нуруугүй амьтад төдийгүй самар, жимс зэрэг ургамлын гаралтай тэжээлийг иддэг элдэв идэштэн амьтан. Идэш тэжээлийн 60-70%-ийг ойн жижиг амьтад, 30-40%-ийг самар эзэлдэг [4]. Ихэвчлэн бартаа ихтэй, наранд ээвэр, идэш тэжээл элбэгтэй хуш, хуш шинэсэн ойд хад асганы ан цав, модны хөндийд [1,2,4], заримдаа жирх, хэрэм, тоншуул зэрэг амьтан, шувуудын орхигдсон нүхэнд орогноно [7]. Ороо хөөцөө 6-7-р сард орно. Гуужилт 3-р сарын дундаас эхлэж, XI сард үс хөрс бүрэн гүйцнэ. Хээлээ 260-280 хоног тээгээд модны хонгилд 3-4, хааяа 7 хүртэл тооны хойв төрүүлнэ [2,4].

**Тоо толгой, хомсдох шалтгаан.** Энэ зүйлийн популяцийн талаар мэдээлэл маш бага. 1966-1968 онд Төв Хэнтийд 1000 га-д 11.7 бодгалийн нягтшилтай байсан бөгөөд 1970-аад онд энэ бүс нутагт 10000 бодгаль байна гэж үнэлсэн [7]. Тархац нутгийг нийтэд нь хамруулан тоо толгой нөөцийг үнэлэн тогтоогоогүй. 2000-2003 онд ХХДЦГ-ын орчны бүсэд хийсэн судалгаагаар, 12754 км<sup>2</sup> нутагт нийт 795 толгой [5] тус бүс нутагт 2008 онд Биологийн хүрээлэнгээс хийсэн судалгаагаар, 4406 км<sup>2</sup> нутагт 1000 гаруй толгой ойн булга бий [6] хэмээн үнэлэн тогтоожээ. Тархац, популяцийн өөрчлөлтөнд нөлөөлж буй гол хүчин зүйл нь хууль бус агналт юм. Арьс өндөр үнэтэй бөгөөд монголын популяци агналтаас үүдэн

буурсаны баримт нь 1910-1920 оны хооронд улсын хэмжээгээр жил бүр 4000-5000 ширхэгийг бэлтгэн нийлүүлж байснаа, XX-р зууны эхэн үеэс аажмаар багасч, 1927-1929 он гэхэд 300-500 болтлоо буурсан байна [7]. Мод бэлтгэл, самар жимс түүх зэрэг байгалийн нөөцийн ашиглалтаас үүдэлтэй болон ойн түймэр ойн булганы амьдрах орчныг доройтолд оруулж байна [3]. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэгдсэн. Энэ зүйлийн тоо толгой буурсаны улмаас 1953 оноос өнөөг хүртэл агнахыг хориглосон. Тархац нутгийн 20 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагддаг [3].

**Хамгаалах арга хэмжээ:** Агналт илүүтэй хийгдэж буй бүс нутагт нарийвчилсан судалгааг хийх, тархац, нөөц, экологийн онцлогийг нарийвчлан судалж, хууль бусаар бэлтгэж байгаа арьс үс, агналтыг таслан зогсоох амьтны менежментийн төлөвлөгөөнд тусгаж, мэдээллийн сан бүрдүүлэх, байнга байршин амьдардаг цөм нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, хамгаалалтыг сайжруулж, байгалийн нөхөн төлжих нөхцлийг бүрдүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Батсайхан нар, 2010, 3. Монгол орны хөхтөн амьтны улаан данс, 2006, 4. Дуламцэрэн, 1970, 5. Хан Хэнтийн ДЦГ-ын баруун хэсгийн хөхтөн амьтдын судалгаа, судалгааны тайлан, 2008, 6. Хан Хэнтийн орчны бүс нутгийн агнуур зохион байгуулалтын үндэслэл, бичмэл тайлан, 2003 7. Хотолхүү 1982.

## 10. ЭРЭЭН ХҮРНЭ



*Vormela peregusna* Guldenstadt, 1770

**Баг.** Мах идэштэн - *Carnivora*

**Овог.** Суусарынхан - *Mustelidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг”, олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Бие 35 см, сүүл 20 см урт, жин 0.5 кг хүрнэ. Толгой жижиг, хоншоор богиновгор, мохоодуу. Чих том, угаараа өргөн, дэлбэгэрдүү дугуй. Мөчид богинохон. Сүүл урт сагсгар. Зоо нуруу, биеийн хажуу халиун бор дэвсгэр дээр элдэв хэлбэрийн цайвар толбуудтай. Хүзүү халтар бараан. Хэвэл бараан. Хоолойноос завж, нүдийг дайрсан өргөн бараан зурвастай. Чахалзуураас нүд, чихний завсраар шургасан тууш, тод цагаан зурвас бий. Уруул, эрүү чихний урд тал цагаан. Ерөнхий зүс эрээн.

**Тархац, байршил нутаг:** Зүүн өмнөд Кавказ, Казахстан, Дундад дорнод Ази, Баруун өмнө говь, баруун өмнө Монгол, хойд Хятадын хээрийг хамарсан өргөн тархацтай [2]. Монголд Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Алтайн өвөр говиуд, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Дундговийн өмнөд хэсгээр тархжээ [3-5,9]. Заг, хармаг, сухай бүхий дов сондуулт хотгор, харгана, хялганат элсэрхэг хээр, заримдаа уулын бэлийн хадтай толгод, сайр, сархиа, задгай ус, баян бүрдийн ойролцоо элдэв мэрэгч, ялангуяа чичүүл, огдойн үлий элбэгтэй газар идээшин амьдарна.

**Амьдралын онцлог:** Монголд судлаагүй. Голдуу өглөө үдэш, заримдаа өдөр гүйж, элдэв мэрэгч, чичүүл, огдойгоор идэшлэнэ. Өмнөговийн Зүүн сайхан уулын өвөр бэлээс IV сард барьсан бодгаль хул чичүүл, Увсын Тэс голын адгаас XI сард барьсан бодгаль үхэр огдой идсэн байв [7]. Өмнөговийн Баяндалай сумын нутагт V сард элсэн довцогийн нүхэн үүрэнд 4 сөөдгий тохиолджээ [8].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой, тархац мэрэгчдийн олон цөөнөөс шалтгаалан тогтворгүй. Тусгайлан агнадаггүй ч анчдын зүүсэн хавханд орж баригддаг. Хулгайгаар агнаснаас хааяагүй ховордож байна. Идэш тэжээлээр өмхий хүрнэ, үнэг, хярс, цагаан үентэй адилхан [2]. Уул уурхайн ашиглалт, бэлчээрийн талхагдалт, цөлжилт, ган зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн. Монгол улсын улаан ном /1987, 1997/, Монголын хөхтөн амьтны улаан дансанд оруулж, тархац нутгийн 19% нь улсын тусгай хамгаалалтад хамрагдсан [6].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулж, хэрэгжүүлэх, удмын санг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Гептнер нар, 1967, 3. Авирмэд, 1972, 4. Дуламцэрэн, 1970, 5. Шагдарсүрэн нар, 1987, 6. Chotolchu et all, 1989, 7. Шийрэвдамба нар, 1997, 8. Дуламцэрэн нар 1999, 9. Dulamtseren et all, 2006,

## 11. ХҮРЭН БААВГАЙ



*Ursus arctos* Linnaeus, 1758

**Баг.** *Мах идэштэн* - *Carnivora*

**Овог.** *Баавгайнхан* - *Ursidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Биеийн урт 180-240 см, сэрвээ орчим өндөр 90-150 орчим см, хойд тавхайн урт 13-30 см, сүүлийн урт 6-21 см. Бие гүйцсэн эр баавгай 140-400 кг, эм 100-210 кг жинтэй байдаг. Толгойн ясны кондилобазаль урт 258-378 мм [1,2]. Хүрэн баавгайн үс урт, сахлаг, зөөлөн байдаг. Чих богино, дугуйвтар. Өнгө хувирамтгай боловч ихэвчлэн хүрэн байдаг. Хөл, нуруу, хажуу тал хар хүрэн өнгөтэй. Хүрэн баавгай хүчирхэг хумстай бөгөөд урд хөлний дунд хурууны хумс 80 мм хүрдэг, сүүл жижигхэн, бараг биеийн үснээс цухуйдаггүй [2].

**Тархац, байршил нутаг:** Монгол оронд газар зүйн хувьд салангид хүрэн баавгайн 4 популяци байдаг бөгөөд Хөвсгөл, Хэнтийн нурууны зүүн бие, Монгол Дагуурын хээрийн Улз, Онон гол, Монгол Алтайн баруун хойд хэсэг, Их Хянганы салбар уулс зэрэг тайга, ойт уулсаар тархжээ [1,4]. Хүрэн баавгай өөрсдийн үндсэн тархац нутгаас 130-200 км хол зайтай Дорнод Монголын уулын хээр, голын хөндийд хааяа нэг тохиолддог байна [1]. Хүрэн баавгайн үндсэн амьдрах орчин нь салхинд унасан мод, намаг балчиг, ойн цоорхой бүхий бөглүү, шигүү ой юм. Хавар, зуны улиралд өндөр өвс, буттай амрах газар, ойролцоо усан сан, ойн цоорхой бүхий голын хөндий, уулархаг газарт байршдаг. Монгол Алтайд жижиг бут сөөгөн шугуйтай хадархаг газарт тохиолдоно. Ичээ засах газраа бүдүүн унанги мод, эсвэл хадны хуурай хүнгэд сонгож, хуурай хагд өвс, хөвд, мөчир зулж дэвсдэг [1,2].

**Амьдралын онцлог:** Байгаль цаг уурын онцлогоос шалтгаалан 10-11 сараас 3 заримдаа 5 сар хүртэл, 5-6 сар ичнэ. Идэш тэжээл элбэгтэй жил 11 сарын сүүлээр ичдэг. Ичээ гол төлөв унанги мод ихтэй газарт, хадны завсар байна. Ороо нийллэг 6-р сараас 7-р сард болно. Эвш хээлээ 180-220 орчим хоног тээж, ичээндээ байх үедээ 1, 2 сарын хооронд 1, голдуу ихэр, хааяа 4 хүртэл тооны бамбарууш гаргана. Бамбарууш төрөх үедээ 350-500 гр жинтэй, нүдээ

нээгээгүй, нүцгэн байдаг. Нэг эсвэл 2-3 жил өнжиж төллөнө. Хүрэн баавгай 5 нас хүрч үржилд орно. Байгалийн нөхцөлд 20-30 жил, тэжээвэр нөхцөлд 40 хүртэл насална [2]. Идэш тэжээл нь газрын гадарга, ургамлан бүрхэвч, тэдгээрийн чанараас шалтгаалах бөгөөд олон төрлийн хоол хүнс хэрэглэдэг. Идэш тэжээл хомс хаврын эхэн үед улиангарын үр, модны нахиа, ургамлын үндэс, хуучин самар, шоргоолж зэргээр харин зуны эхэн үеэр тэд голчлон жимс жимсгэнэ, үр, самар, ногоон ургамал, шавж, загас, заримдаа сэг зэмээр хооллоно. Идэш тэжээл дутагдалтай үед хандгай, зэрлэг гахай, бор гөрөөс, халиун буга, хүдэр барина. Зуны сүүл, намрын эхэн үед гол төлөв ургамлаар хооллох бөгөөд янз бүрийн үр жимс, самар, ургамлын үндэс иднэ. Монгол Алтайд хүрэн баавгай огдой, тарвага бусад мэрэгчдээр хооллоно [1,2,3].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** ШУА-ийн Биологийн хүрээлэн /1986/ 50.000 км<sup>2</sup> нутагт ойролцоогоор, 500 орчим бодгаль хүрэн баавгай бий гэж тооцоолжээ. Тоо толгойд нөлөөлж байгаа байгалийн хүчин зүйлийн нөлөөлөл бага. Монголын ихэнх ойт бүс нутгийг хамарсан их хуурайшилт, гантай байсан 1988 оны үед Төв, Хэнтий, Сэлэнгэ аймгийн нутагт өлсгөлөн хорхойтсон баавгайтай учирсан 103 тохиолдол бүртгэгдэж, хот сууринд орж ирсэн хоёр тохиолдлын нэг нь нийслэл Улаанбаатар хот байв. Хорхойтсон 47 бодгаль баавгайг орон нутгийн хүмүүс агнасан бөгөөд бүгд маш туранхай, зарим нь дотор өөхгүй байсан ажээ [6]. Сүүлийн жилүүдэд худалдаалах зорилгоор доньд, саврууг авахын тулд хууль бусаар агнах явдал ихэссэн. Цаатан хүмүүс тэднийг мах болон арьсыг ашиглах зорилгоор агнан ашигладаг [4,9]. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан ховор амьтны жагсаалтад бүртгэсэн, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцийн II-р хавсралтад бүртгэгдсэн [8]. Тархац нутгийн 21 орчим хувь улсын тусгай хамгаалалттай нутагт хамрагдсан [4].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологи экологи онцлогийг тусгайлан судалж, хамгаалах арга боловсруулах, байршил нутаг дахь хүний дам нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах, амьдрах орчны доройтлоос сэргийлэх, тархац нутгийг хамгаалалтад авах, зах зээл дээрх баавгайн бүтээгдэхүүний хууль бус худалдааг таслан зогсоох, ган, зудын гамшигт нэрвэгдсэн үед нэмэлт тэжээл тавьж өгөх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Батсайхан, 2010, 3. Болд, 1967, 4. Clark нар, 2006, 5. Дуламцэрэн, 1970, 6. Дуламцэрэн, Ганбат, 2000, 7. Намнандорж 1976, 8. CITES-ын лавлах, 1991, 9. Zahler, 2004.

## 12. МАЗААЛАЙ БААВГАЙ



*Ursus arctos gobiensis* Socolov et Orlov, 1992

**Баг.** *Мах идэштэн - Carnivora*

**Овог.** *Баавгайнхан - Ursidae*

**Статус:** Нэн ховор, үлдвэр зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “устаж байгаа”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн [6].

**Таних шинж:** Ерөнхий төрх ойн хүрэн баавгайтай адил боловч биеэр бага. Цагаан богд уулын шармаахайн биеийн урт 168 см, сэрвээний өндөр 92 см, жин 90 кг байжээ [2]. Шар хулсны нурууны Хөшөөтийн булагт хавар амьдаар барьсан шармаахайн биеийн урт 167 см, сэрвээний өндөр 79 см, биеийн жин 138 кг [24]. Зуны зүс жигд хүрэн бор, өвөл, хавар хар хүрэн сор үстэй, цайвар шаргал ноолууртай. Хөлний өвдөгөөс доош хэсэг болон хүзүү их биеэсээ бараавгар. Хүзүү, далны шонтон хэсэгт цагаан цайвар толботой, зарим бодгальд ялангуяа эвш, залуу амьтдад ажиглагддаггүй. Зүс нас хүйснээс хамааран өөрчлөгдөж байдаг. Хумс цайвар өнгөтэй, шулуундуу, мохоо, бүдүүн богинохон. Хөнгөн шалмаг хөдөлгөөнтэй [2,4,12,19,24].

**Тархац, байршил нутаг:** 1930-аад онд Алтайн өвөр говийн баруунаа Аж богдын зүүн үзүүр, зүүнээ Тост, Нэмэгт уул, хойшоо Ээж хайрхан, Захуй, Зармангийн баянбүрд, Эдрэнгийн нуруу, өмнөө улсын хил хүртэлх нутагт тархаж байв [1,2,3,4,12]. Зүүнээ Цагаан богд, баруунаа Баруун Тооройн нуруу, хойш Зараа, Буурын хар уулын хооронд буюу тархацынхаа тэн хагасаас бага нутагт Сэгс цагаан богд, Шар хулсны нуруу, Төмөртэйн хөх нуруу, Атас Ингэс уулын хавиар байршина [1-2,4,10,12-14]. Шар хулс, Цагаан тохой, Цагаан бургас, Өлзий бэлгих, Хөшөөт зэрэг булаг шандын ойролцоох хад бартаат намхан уулсаар гүйдэлтэй. Зүүнээ Тост уул, баруунаа Майхан булаг, Хар хайрхан, хойшоо Эдрэнгийн нуруу хүртэл тохиолдлоор үзэгдэнэ [1-2,4,8,14]. Тархац нутаг 1960-аад оныхоос 5 дахин хумигдаж, 18 000 ам км нутагт байршиж байна. [26]

**Амьдралын онцлог:** XI-III сард хадны агуй, хонгил, хулсан ширэнгэ, сухайн төгөл доогуур,

нүх, хэвтэр засан ичээлнэ. Зун задгай усны ойролцоо нутаглана. Эвш жил өнжиж төллөнө [20]. Зун отолно. Эвш хавар эрт II-III сард ичээндээ ихэвчлэн нэг, заримдаа ихэр аламцаг төрүүлнэ [2,4,10,12,13]. Ургамал голлон иднэ. Зун зээргэнэ, хармагийн жимс, хавар, намар бажууны үндэс, зэгс, зээргэнэ, махирс, сухай, хялгана, хөмүүл зэрэг ургамлаар хооллоно. Амьтны зүйлээс тураг амьтдын сэг, туулай, шишүүхэй, чичүүл зэрэг мэрэгчид, шувуу, гүрвэл, шавж зэргээр идэшлэнэ [2,4,10,12-13,22]. Голдуу шөнө хоол тэжээлээ олно. Тэжээл ховортойд нэгнийгээ барьж иддэг [21]. Мазаалайн идэш тэжээлд 33 зүйл ургамал, 18 зүйл амьтны гаралтай хоол тэжээл улирлын онцлогоос хамаарч харилцан адилгүй оролцож байна [26].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** 1960-аад онд 15-20 толгой, далаад оны дундуур 20 гаруй, 1980 оны эхээр 25-30, наяд оны сүүлчээр 50-60, 1990 оны эхээр 30 гаруй толгой байжээ [2,9,15,17,24]. Автомат камер болон генотипийн судалгаагаар, 22-31 толгой байгааг тогтоосон [25,29]. Жил жилийн их хэлбэлзэлтэй, хэт хуурай, эрс тэс уур амьсгал, ус, тэжээлийн байнгын гачаалтай байдал үхэж хорогдох, тоо толгой, үржил төлжлийг нь хязгаарлах хүчин зүйл болдог [2-3,5,8,13,21]. Аялагчид тохиолдлоор хөнөөх, нялх аламцаг барих зэргээр хороодог [2-3,5,7,21]. Түүнчлэн хоргодож үүрлэх, ичээлэх орчны хулс, бутан шугуй ширэнгийг хадах, хүн, мал суурьших зэргээр хэвийн амьдралыг өөрчлөх, үргээж дайжуулна [8,13]. Ус, тэжээл хүрэлцээгүйгээс нутаг, тэжээлээ булаалдах, нэгнийгээ барих явдал байдаг [21]. Алт зэрэг ашигт малтмалыг мазаалай баавгайн тархац нутгийн хүрээнд хууль бусаар хайх, олборлох зөрчил нэмэгдэх хандлагатай байна [25]. Устах аюулд орсон амьтан.

**Хамгаалсан байдал:** Мазаалайг баавгай агнахыг 1953 оноос хуулиар хориглож, улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэж, үндсэн байршил нутгийг Говийн их дархан цаазат газарт хамруулав [20,23,30]. Монгол улсын улаан номд оруулсан [15]. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралтад бүртгэгдсэн [16]. 2013 оноос БОНХЯ-наас санаачлан тусгай ажлын хэсэг байгуулж, экологи, биологийн, судалгааны ажлыг өргөжүүлэх, амьдрах орчныг хамгаалж, нөхөн сэргээх, биотехнологийн арга хэмжээг тогтмолжуулах зэрэг цогцолбор арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Баянбүрд, булаг шандын бут сөөг, зэгс хулсан ширэнгийг цөлжилт, хуурайшилт, хүний зохисгүй нөлөөллөөс хамгаалж, нөхөн сэргээх, ус хүрэлцээгүй нутагт задгай ус гаргах, нэмэлт тэжээлийн цэгийг олшруулах, тэжээлийн байнгын нөөцийг бий болгох, хавар хээлтэй үед чанартай тэжээл өгөх, урьд байсан зарим нутагт сэргээн нутагшуулах. Мазаалайн биологи, экологи, генетик онцлогийг судалж, хамгаалах оновчтой арга, төсөл боловсруулж хэрэгжүүлэх, мазаалайн сангийн үйл ажиллагааг идэвхжүүлж, төр, мэргэжлийн төрөлжсөн хүрээлэн, төрийн бус байгууллагын түншлэлийг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Болд, 1967, 3. Хотолхүү, 1969, 4. Дуламцэрэн, 1970, 5. Базардорж, 1972, 6. БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975, 7. Болд нар, 1975, 8. Намнандорж, 1976, 9. Даш, 1979, 10. Соколов нар, 1980, 11. Ооговин, 1980, 12. Бугаев нар, 1982, 13.



Жирнов, 1983, 14. Жирнов нар, 1985, 15. Шийрэвдамба нар, 1997, 16. CITES, 1991, 17. Чулуун, 1988, 18. Бадамханд, 1988, 19. Соколов нар, 1992, 20. Тулгат нар, 1993, 21. Тулгат, 1993, 22. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 23. Тулгат нар, 1992. 24. Batsaikhan et all, 2004, 25. Амгалан нар, 2006, 26. Мижиддорж, 2006, 27. Amgalan et all, 2006, 28. Tserenbataa нар, 2006, 29. Одбаяр нар, 2011, 30. Мижиддорж, Доржготов, 2013.

### 13. ТАХЬ АДУУ



*Equus przewalskii* Poliakov, 1881

**Баг.** Туурайман - *Perissodactyla*

**Овог.** Адууныхан - *Equidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын болон шалгуураар олон улсын болон бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлжээ.

**Таних шинж:** Зэрлэг адууны цор ганц үлдвэр. Биеийн урт 250 см, мундааны өндөр 146 см, биеийн жин 325 кг хүрнэ [15]. Бие лагс, толгой том, хүзүү бахим, цээж өргөн, сэрвээ, хондлой тэнцүүвтэр. Дэл богино, босоо ихэвчлэн хар өнгөтэй. Сүүл шингэн, сүүлний хялгас гэрийн адуутай ижил. Зүс хул хонгор. Хэвэл, цавь, суга, гуяны зураа орчим цайвар, мундаанаас зоо нуруу дагуу сүүлний цацаг хялгас хүртэл бор тууш хүрэн судалтай. Мөчдийн өвдөг боривноос доош бараавтар, олонх бодгаль нь өвдөгний ар тал, борвиндоо хар хөндлөн судлуудтай.

**Тархац, байршил нутаг:** XIX зууны сүүлийн хагаст Зүүнгарын говьд Тэнгэр уулын ар хормой, бэлээс хойш Монгол Алтайн нурууны өвөр бэл, зүүнээ Аж богд, баруунаа Манас, Өрөнгө гол хүртэлх нутагт тархаж байжээ [1,2,25]. Энэ зууны хорь гучаад онд Зүүн гарын Тахийн шар нуруу, Хөх өндөр, Хавтаг, Байтаг уулс, Гүн тамга, Хонин ус, Тахийн усны говь, Биж, Бодонч, Үенч, Булган голуудын адгаар сүрэг сүргээрээ бэлчиж байв [1,4,6-13]. Гучаас тавиад онд үндсэн байршил нутаг улсын хилийн хориотой бүсэд орсноор нутгийн мал, хүний нөлөөлөл багассан юм. Тавиад оноос Байтаг богд уул, Тахийн шар нурууны хоорондох улсын

хил хавийн 20-30 км өргөн зурваст жинхэнэ байршил нутагт өвөл, хавар малчид нүүдэллэн нутаглах болсон үед тахь ховордож цөөн үзэгдэх болсон [5-8,13]. Тавь, жараад онд хилийн цэргийн анги, нутгийн малчид задгай ус, бэлчээрийг эзэгнэж, үлдсэн тахийг шахан зайлуулжээ. Жараад онд ганц нэгээр үзэгдэж байгаад, далаад оноос хойш монгол улсад устсан [8-13]. Хээр талд сүрэглэн амьдарна. Монгол улсын Засгийн газар тахийг сэргээн нутагшуулах ажлыг 1992 оноос эхлэн холбогдох байгууллага, гадаадын иргэнтэй хамтран зохион байгуулсны үр дүнд Хустайн байгалийн цогцолборт газар, Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн Бижийн гол, Хонин усны говь, Тахийн ус, Гүн тамга, Завхан Аймгийн Дөрвөлжин сумын нутаг зэрэг газарт нутагшин үржиж байна.

**Амьдралын онцлог:** Сүргээр амьдарна. Хавар, зун, намар задгай устай газар бараадна. Усанд өдөр бүр, хааяа өнжөөд өглөө, үдэш, шөнө ирнэ. Элс, хайрган хөрстэй хялгана, тэсэг, баглуур бүхий намхан уулс, толгод, тэдгээрийн хоорон дахь хотос, хоолойд байршина. Цастай өвөл говийн заг, бударганат хонхорт, зун өндөр уулсын ар, бэл, хажуу, нам уулсын хярд гарна. Ороо нийлэгт V-VII сард орж, дараа оны IV, VII сард унагална. Байдас 3-4, үрээ 5 настайгаас үржилд орно.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** 1898-1904 онд Монголын говиос тахийн 88 унага барьж, тэдгээрээс 53 нь Украин, Герман улсын амьтан үржүүлгийн газар, амьтны хүрээлэнгүүдэд эсэн мэнд хүрч, өсч үржсээр өдгөө 30 шахам орны 130 гаруй амьтны хүрээлэн, нөөц газруудад 2000 орчим толгойд хүрчээ. Монголын гурван газарт нийтдээ 400 гаруй бодгаль тахь байгаагаас Хустайн нуруу, Бижийн голын тахь жилийн турш байгальд сул чөлөөтэй идээшин дасаж байна. 1940-1950-иад онд БНМАУ-ын хилийн ойролцоо байсан хасгийн босуул зэвсэгт хүмүүс тахийг хайр гамгүй хядан хүнсэнд хэрэглэсэн, 1944-1945 оны их зуданд тоо толгой ихээхэн хорогдсон, 1898-1903 онд Европод гаргахаар нялх унагыг олон тоогоор барьсан зэрэг нь тахийн сүргийн бүтэц, тоо толгойд сөргөөр устахад нөлөөлжээ. Ус, бэлчээрээр хулан, хар сүүлт, хааяа аргаль, янгиртай давхцана. Чононд унага, даага ихэвчлэн идүүлнэ. Их цастай хүйтэн өвөл бөөнөөрөө өлдөж турж үхдэг [3,6,7,19,21]. Зүүн гарын говиос 1947 онд унага барьж, монголд бойжуулаад, 1957 онд Аскания-Новад шилжүүлээд, 1973 онд байгалийн жамаар үхсэн “Алтай” буюу Орлица III гүү бол жинхэнэ уугуул байгальдаа төрсөн тахийн хамгийн сүүлчийн бодгаль байсан [17,20].

**Хамгаалсан байдал:** Монгол улс 1930 оноос эхлэн агнахыг хуулиар хориглож, улмаар Амьтны аймгийн тухай хуульд нэн ховор амьтнаар оруулж, Монгол улсын улаан ном, Олон улсын улаан ном, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралтад тус тус оруулав [14,16,18,23,24,25]. Монгол улс 1992 оноос эхлэн Голланд, Герман, ОХУ, Швейцар, Австрали зэрэг улсын амьтны хүрээлэнгээс тахийг уугуул нутагт сэргээн нутагшуулах ажлыг улс орнууд, хувь хүн, байгууллагатай хамтран зохион байгуулж байна. 1992 онд Хустайн нуруунд 15 тахь, Говь-Алтай аймгийн Бижийн голд 5 тахь гадаадаас зөөвөрлөж тавьснаар, тахийг сэргээн нутагшуулах ажил эхэлсэн. 2004 онд Завхан аймгийн Хомын талд 12 тахь авчирснаар тахь сэргээн нутагшуулах 3 дахь төсөл эхэлсэн. 1992 онд Голланд, Украин улсаас 20, 1993 онд Украинаас 6, 1994 онд Голландаас 10, 1995 онд Швейцар, Австрали улсаас 13, 1996 онд

Швейцар, Голландаас 21 тахийг монголд сэргээн амжилттай нутагшуулж байна. Сэргээн нутагшуулсан тахийн тархац нутаг улсын тусгай хамгаалалтай газарт бүрэн хамрагджээ.

**Хамгаалах арга хэмжээ:** Сэргээн нутагшуулж байгаа тахийн биологи, экологийн нарийвчилсан судалгааг хийж, уугуул байгальд зэрлэгшүүлэх, ус тэжээлээр хангах, өвчин эмгэгээс сэргийлэх, байршил нутгийн чонын тоо толгойг зохицуулах, байгаль цаг уурын бэрхшээлтэй үед хамгаалах арга замыг бүрэн шийдвэрлэх, гэрийн адуутай эвцэлдэж, цус холилдохоос сэргийлэн, удмын санг найдвартай хадгалах арга хэмжээ авах, тухайн нутагт үржүүлж буй тахийн генетик олон янз байдлыг нэмэгдүүлэх үүднээс хооронд нь солих, тахь сэргээн нутагшуулах газруудыг өргөжүүлэх зэрэг арга хэмжээ авах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Соколов, 1959, 3. Цэвэгмэд, 1959, 4. Эрэгдэндагва, 1959, 5. Банников, 1959, 6. Шагдарсүрэн, 1962, 7. Болд нар, 1963, 8. Довчин, 1969, 9. Довчин, 1970, 10. Хотолхүү нар, 1972, 11. Цэвэгмид, 1970, 12. Намнандорж, 1964, 13. Намнандорж, 1976, 14. БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975, 15. Гептнер нар, 1961, 16. Закон об охоте МН, 1930, 17. Дуламцэрэн, 1993, 18. Шийрэвдамба, 1997, 19. Соколов нар, 1978, 20. Лобанов, 1978, 21. Соколов нар, 1980, 22. CITES, 1991, 23. Тишер нар, 1976, 24. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 25. Жирнов нар, 2005.

#### 14. МОНГОЛ ХУЛАН АДУУ



*Equus hemionus hemionus* Pallas, 1775

**Баг.** Туурайтан - *Perissodactyla*

**Овог.** Адууныхан - *Equidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “эмзэг”, бүс нутагт “ховордсон” зүйл хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Биеийн урт 220 см, мундаагаараа 137 см өндөр, сүүл 49 см, жин 200 кг хүрнэ

[16]. Гэрийн адуутай харьцуулахад, толгой том, чих урт, сүүл зөвхөн үзүүрийн хэсэгтээ шингэхэн богино хялгастай. Ерөнхий зүс хул. Зун улаавтар, өвөл цайвар хул. Мундаанаас сүүлний уг хүртэл зоо нуруу дагуу нарийхан хүрэн бор судалтай. Дэл, сүүлний хялгас бараан.

**Тархац, байршил нутаг:** Өнгөрсөн зууны дунд үе хүртэл Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, одоогийн Дундговь, Сүхбаатар аймгийн ихэнх цөлөрхөг хээр, зүүн тийшээ Буйр нуур хүртэл тархаж байв [1,2]. Дорнод тал, Дорноговийн зүүн хэсэгт 1900-аад оноос өмнө, Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд 1930-аад он хүртэлх хугацаанд устжээ [1,2,3,12]. Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговийн баруун хэсэг, Дундговийн өмнөд хэсэгт үлдсэн байв [1-3,9-12]. Одоо Зүүнгарын говь, Өмнөговь аймгийн зүүн өмнө, Дорноговь аймгийн баруун өмнө болон Говь-Алтай, Баянхонгор аймгийн өмнө хэсэг буюу манай орны баруун өмнө, өмнө болон өмнөд хэсэгт 3 голомт нутагт идээшин байршиж байна [18]. Цөл, цөлөрхөг хээрийн нам уулс, аараг толгод, тэдгээрийн завсрын уудам хөндий, хоолой, хотос, толгодын шил, бэлийн үетэн, шарилж, баглуур, бударгана, заг, харганат элсэрхэг, хайрган болон дагжуур чулуурхаг газар нутаглана [1,3,9]. Өвөл өвс сайтай, бартаа нөмөртэй, ундлах цастай, зун, хавар, намар задгай ус бүхий бэлчээрт байршина. Сүүлийн 200 жилд хуурай хээрээс цөл рүү шилжин байршжээ [8].

**Амьдралын онцлог:** Зүүнгарын говьд ороо VIII, IX сард орж гүү хээлээ 11 сар гаруй тээж, V-VII сард унагална [1,2,5]. Гүү 2-3 насандаа, азарга 3 насандаа бэлгэ боловсорч, 4-5 наснаас үржилд оролцоно [9]. Хэдэн арав, заримдаа хэдэн арваараа сүрэглэнэ [1,3,9]. Усанд өглөө, орой, шөнө ирнэ. Говь-Алтай аймагт тэжээвэр 3 гүү үржилд орж, төллөсөн унага нь хэвийн бойжсон [12].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Далаад оны дундуур монголд хулангийн нөөц 15000 орчим хулан байснаас, Алтайн өвөр говиудад 8000 байв [5]. Зүүнгарын говь буюу Говийн дархан газрын “Б” хэсэгт 1500 толгой, Алтайн өвөр говийн баруун өмнөд буюу дээрх газрын “А” хэсэгт 500 толгой хулан байв [8,10]. Дорнод тал, Дорноговь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд ундны задгай усыг хүн мал эзэгнэсэн, зохицуулалтгүй агнасан, үргээж дүрвээснээс устжээ [1,4,8,21]. Монгол орны хулан адууны тоо толгой 2000 оны эхээр 19000 орчим байгаагаас, 70 орчим хувь нь Дорноговь аймагт, 20 хувь нь Өмнөговь аймагт, 12 хувь нь Зүүнгарын говьд, үлдсэн 1 хувь нь Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутагт байрлаж байв. Тоо толгой 2003 оны байдлаар, 1997 оныхоос 60 хувь, 2009 байдлаар, 2003 оныхоос 29 хувиар тус тус буурчээ [17,18]. Одоогоор Дорноговь, Өмнөговь, Алтайн өвөр говийн хулан адууны багахан байршил нутагт нь малын тоо толгой, нэгж талбай дахь нягтшил жилээс жилд өсч, бэлчээрийн даацаас хэтрүүлэн мал бэлчээрлэснээс идэш тэжээл, нутаг усаар хавчигдах боллоо [17,18,21]. Хууль бусаар агнаж байна [1,4,8,20,21]. Байгальдаа унага, даагыг чоно барьж хороодог. Цас ихтэй бэлчээрийн хомсдолтой үед тоо толгой хорогддог.


**Хамгаалсан байдал:** Монгол улс агнахыг 1953 оноос хуулиар хориглож [6], Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын ховор амьтны хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номд оруулав [6,12]. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг

олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралт болон Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах конвенцийн II хавсралтад тус тус бүртгэгдсэн [14,19]. Тархац нутгийг Говийн их дархан цаазат газар Говийн бага дархан цаазат газар хамруулан хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, биологийн судалгааг хийх, үндсэн байршил нутгийг малын бэлчээрээс чөлөөлж, уул уурхайн ашиглалтыг байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологиор явуулж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг туршин хэрэгжүүлэх, орчны доройтлыг хязгаарлах, зудын гамшгийн үед нэмэлт тэжээл тавьж өгөх, байршил нутгийн гол, горхи, булаг, шандыг хамгаалж, нөхөн сэргээх, уст цэгийг бий болгож, тохиромжтой газарт сэргээн нутагшуулах, тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг сайжруулах, хууль бус агнуурыг таслан зогсоож, хяналтыг тогтмолжуулан чангатгах, нутгийн иргэдэд түшиглэсэн хамгааллын арга хэмжээг авах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Намнандорж, 1964, 3. Дуламцэрэн, 1970, 4. Цэвэгмэд, 1970, 5. Банников, 1975, 6. БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975, 7. Эрэгдэндагва, 1976, 8. Соколов нар, 1978, 9. Соколов нар, 1980, 10. Мөнхсайхан нар, 1986, 11. Дуламцэрэн нар, 1989, 12. Шагдарсүрэн, 1987, 13. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 14. CITES, 1991, 15. Казахстаны улаан ном, 1985, 16. Соколов нар, 1980. 17. Биологийн хүрээлэн, 2003, 18. Биологийн хүрээлэн, 2009, 19. CMS, 2011, 20. Room to roam. Discussion paper, World bank, 2006, 21. Жирнов нар, 2005, 22. Шийрэвдамба нар, 1997.

## 15. ЗЭГСНИЙ ЗЭРЛЭГ ГАХАЙ



*Sus scrofa nigripes* Blanford, 1875

**Баг.** Туруутан - *Artiodactyla*

**Овог.** Гахайнхан - *Suidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Биеийн урт 170 см, сэрвээний өндөр 80 см, сүүл 24 см, жин 200 кг хүрнэ. Толгой урт, хоншоор шонтгор, хүзүү богино. Мөчид богино. Чих дэлдгэр, үзүүртээ урт үстэй. Мөчдийн хөхөн туруу урт. Дээд, доод соёо уруулаас гадагш дорсойн гарч хоорондоо зөрсөн байрлалтай. Бодонгийн соёо мэгжийнхээс урт, том. Зүс бор саарал, хүрэн, бараавтар. Нялх тоорой тууш шаравтар судал бүхий эрээн зүстэй.

**Тархац, байршил нутаг:** 1940 он хүртэл Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говийн ихэнх нуурын эрэг, голын татам, баян бүрдийн бургас, улиас, тоорой, харгана, сухай, дэрс, хулсан шугуй ширэнгэд идээшиж байсан [1,2,4,7,9]. Одоо Хар ус, Хар нуурын эргийн хулсан шугуй, Ховд, Булган, Зэрэг, Бөхмөрөн, Тэс, Нарийн голуудын татам шугуйд хэсэгхэн газарт байдаг [1,6,7,9]. Шаргын гол, Завхан, Хүнгүй голын адаг, Зүүнгарын болон Алтайн өвөр говийн зарим баян бүрд, гол горхи зэрэг урьд байсан нутагтаа очиж, түр байршина [1,4,7]. Өвөл хүн малын хөлөөс зайдуу бөглүү хулсан ширэнгэд шивээлж их хүйтнийг өнгөрөөнө. Сэрүүн дулаан IV сарын дундаас XI сарын дунд хүртэл эргийн хулс бүхий голын татмаар төллөж, төлөө бойжуулж тарга хүчээ авна [5,6]. Зөвхөн голын татам, усны эргийн шугуй ширэнгэд нутагладаг нэн өвөрмөц хязгаарлагдмал тархацтай бөгөөд айж дүрвэсэн, өлсөж сульдсан үедээ тэндээс гарч явна. Хар Ус нуур хавьд далаад оны эхээр 200 орчим толгой гахай тоологдсон бөгөөд жил бүр хэлбэлзэлтэй ч одоо тэр хэмжээндээ байна [5,6]. Бусад нутагт маш цөөн тоогоор тохиолдоно [6,8].

**Амьдралын онцлог:** Хар Ус нуурын гахай XII сарын эцэс I сарын эхээр ороо нийлэгт орж, IV сард мэгж 2-5 торой гаргана [5,6]. Өвөл зэгс, ургамлын үндэс, мэрэгч, амьтны сэг иднэ. Хар Ус нуурын гахай өвлийн тэжээл дутмаг үед осгож, турж үхсэн малын болон өөрсдийнхөө сэгийг идэж хонь, ямаа руу дайрахаас гадна ондааторыг хялбархан барьж иднэ [2,3,5,9].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Дөчөөс жараад онд гахайг олноор агнаж байснаас тоо эрс цөөрч, үзэгдэхгүй болжээ [1,2]. Хар ус, Хар, Дөргөн нууруудын зэгсэн шугуйд тархсан гахайн тоо толгой 1998 оны байдлаар, 50-+10 байжээ [11]. Эрэг, татмын мод, сөөг, хулсыг аж ахуйн зорилгоор бэлтгэх, түймэр тавих, тариа, ногоо тарих зэргээр хоргодох тохиромжтой орчныг доройтуулж, хууль бусаар агнах тохиолдол байгаагаас нүүдэллэн зайлж байна. Дээрх шалтгаанаар байршил нутгаасаа дайжсан гахай агнуулах, чоно, нохойд бариулах, турж үхэх зэргээр хорогдоно. Цастай хүйтэн өвөл турж, осгож үхнэ [9].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан [10]. Тархац нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, байршин тархсан нуурын эрэг, голын татмаас хулсыг бэлтгэхийг хориглох, тархац, байршил нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалттай газарт авах, зуд тохиолдсон үед нэмэлт тэжээл өгөх, тархац нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл болон нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Дамдин, 1965, 3. Дуламцэрэн, 1968, 4. Дуламцэрэн, 1970, 5. Лхамсүрэн, 1974, 6. Лхамсүрэн, 1976, 7. Соколов нар, 1980, 8. Дуламцэрэн, 1982, 9. Болд нар, 1984, 10. Шийрэвдамба, 1997, 11. Шар, 1998.

## 16. ХАВТГАЙ ТЭМЭЭ



*Camelus ferus Przewalski, 1883*

*Баг. Саарьман - Tylopoda (Artiodactyla)*

*Овог. Тэмээнийхэн - Camelidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “устаж байгаа”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Биеийн галбир гэрийн хоёр бөхт тэмээтэй төстэй боловч бие гоолиг, бөх жижиг, шовгор, үргэлж босоо, хөл, хүзүү урт нарийн, тавхай ялимгүй бага, гонзгойдуу, магнай ялимгүй өргөн хавтгай, хошуу шөмбөгөр, уруул нимгэн. Өрөвлөг, бөхний сагсаг, шил, өвдөгний зогдорын хялгас богино сийрэг, эм ноосны үс тачир, шингэн. Зүс гэрийн тэмээнийхээс цайвар, элсэн шаргалаас хүрэн улаан. Сүүл нарийн, цацаг үс улаавтар. Өвдөг тойг өвчүүний саарь бараг мэдэгдэхгүй зэрэг олон ялгаатай. Бие 340 см, сүүл 55 см, хүзүү 74 см урт, сэрвээ 210 см, хондлой 220 см, бөхний өндөр 35 см, жин 550 кг [1,3].

**Тархац, байршил нутаг:** Хавтгай тэмээ Төв, Дунд Азийн говь цөлд түгээмэл дэлгэр тархацтай байжээ [2]. Хятадын Лоб нуураас умард, дорно зүгт Ачикийн хөндий, Аржин шан уул, түүний умард залгаа аараг толгодын дагуу тархдаг [12]. Монгол дахь хавтгай тэмээний үндсэн тархац нутаг Алтайн өвөр говь, Говийн их дархан цаазат газрын А хэсгийн 44.000 км<sup>2</sup>

нутгийн ихэнх хэсэгт буюу 30-35 км<sup>2</sup> нутгийг бүрэн хамран байршдаг. Цөөн тохиолдлоор ихэвчлэн өвлийн улиралд цөөн тооны бодгалиуд Баянхонгор аймгийн Баянлиг, Баянговь сумын урьд говь, Өмнөговь аймгийн Гурвантэс, Нэмэгтийн хоолой, Ингэн хөөврийн хоолой, Сэрвэй сумын урьд говиор тохиолдоно.

**Амьдралын онцлог:** Буурны ороо I-II сард орж, нэг буур 10-20 ингэ хураана [1,4,14,23]. Ингэ хээлээ 410-425 хоног тээж, III сарын эхнээс IV сарын дунд хүртэл ботголно [1,3]. Орсон буур орооныхоо үед идээшлэхгүй, гэдсээ татна. Ингэ булаг, шандаас алс нөмөр нөөлөг газар ботголж, 15-20 хоногтой ботгоо байнга дагуулан 13 сар хөхүүлээд, V-VIII сард эх үрийн харьцаанаас сүргийн харьцаанд шилжинэ [12]. 3-4 настайдаа бэлгэ боловсорч үржилд орно. Жил өнжиж төллөнө. Ногооны сөл тасарсан үед баянбүрд, булаг шандны ойр бэлчээрлэж байгаад, ногоо ургахаар алслана. 5-10 өнжиж ус ууна. Зун харьцангуй сэрүүн салхитай өндөрлөг газар бараадна. V-VI сард гуужна. Гэрийн тэмээтэй үржилд орно. Нэгдүгээр үеийн эрлийз бие галбир, авир төрхөөрөө хавтгайн шинжтэй байдаг [3,12]. Ихэвчлэн заг, улаан бударгана, шармод, сухай, баглуур зэрэг сөөг, сөөгөнцөр ургамлаар хооллоно. Өвөл цас дагаж өдөр, зун өглөө оройн сэрүүнд бэлчээрлэнэ. Хаврын хүчтэй шуурганаар эрэг, ганга, мод сөөг нөмөрдөн өнжин хонон хэвтэнэ [8]. Холч хараатай, үнэрч, соргог [3,8].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Хавтгай 1943 онд хамгийн цөөн 300, 1959-1960 онд 400-500, 1974 онд 900 орчим болжээ [5,14]. 1975-1976 оны судалгаагаар, 400, 1980-1982 онд 500-800 толгой байв [6,8,9,13]. 1982-1989 онд жил бүр нөөцийн үнэлгээ тогтоосноос үзэхэд, 480-555 байв. 1993 оны байдлаар 320 болов [12,16]. 2012 онд хийсэн тархац, биологийн нөөцийн үнэлгээгээр, 800 гаруй толгой гэж үнэлэгдсэн [22]. 1975 онд Говийн их дархан цаазат газрыг байгуулснаас хойш популяцийн тархац, тоо толгойн хэмжээ тогтворжсон. Бэлчээр, задгай усыг хүн, мал эзэгнэснээс идээшсэн нутгаа орхин дайжна [4,14,15,23]. Чоно ботгыг олноор хөнөөнө [1,12]. Орсон буур бие биеэ барьдаг тохиолдол гардаг [12]. Өөх, махыг ашиглах зорилгоор хулгайгаар агнадаг [1]. Хавтгай тэмээ машинаас болж байршил нутгаасаа дүрвэн дайждаг [12].

**Хамгаалсан байдал:** Монголд 1930 оноос хавтгай агнахыг хуулиар хориглож, Амьтны тухай хуулийн нэн ховор амьтнаар хамааруулж, Монгол улсын улаан ном, Олон улсын улаан номд оруулжээ [15,16,17,18]. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн I хавсралтад бүртгэгдсэн. Тархац нутгийг 1975 оноос дархан цаазтай газар болгосон. Их говийн дархан цаазат газарт /Баянтооройд/ хавтгай тэмээний гаршуулан тэжээсэн сүргийг бий болгожээ.


**Хамгаалах арга хэмжээ:** Байршил нутагт задгай ус бий болгох, шинээр уст цэгүүд гаргах, хуучин уст цэгүүдийг сэргээх, ган, зудийн үед нэмэлт тэжээл тавьж өгөх, өвчин эмгэгээс сэргийлэх, гэрийн тэмээтэй нийлүүлэхгүй байх, чонын тоо толгойг зохицуулах, хязгаарлах, зориудаар өсгөн үржүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бадамханд нар, 1990, 2. Гептнер, 1966, 3. Шагдарсүрэн, 1962, 4. Цэвэгмид нар, 1966, 5. Банников, 1954, 6. Жирнов нар, 1985, 7. Даш нар, 1983, 8.



Эрэгдэндагва, 1954, 9. Соколов нар, 1983, 10. Соколов нар, 1978, 11. Даш нар, 1977, 12. Тулгат нар, 1992, 13. Доржраа, 1993, 14. Банников, 1975, 15. Цэвэгмид нар, 1973, 16. Тулгат нар, 1993, 17. Шийрэвдамба нар, 1997, 18. Тишер нар, 1976, 19. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 20. Жирнов нар 2011, 21. Адьяа нар, 2012, 22. Монгол орны хавтгай тэмээний биологийн нөөц, тархацын судалгааны тайлан, 2012, 23. Жирнов нар, 2005.

## 17. АЛТАЙН АРГАЛЬ



*Ovis ammon* Linnaeus, 1758

**Баг.** Туруутан - *Artiodactyla*

**Овог.** Тугалмайтныхан - *Bovidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” зэрэглэлээр үнэлэгдсэн.

**Таних шинж:** Мөчид урт. Биеийн урт 150 см, сэрвээний өндөр 125 см, жин 180 кг хүрнэ. Угалз 125 см урт, 25 кг том эвэртэй. Аргалийн эвэр угалзныхаас жижиг нарийхан, урт 30 см. Их бие зүс хүрэн бор, хүрэвтэр. Хэвэл цайвар.

**Тархац, байршил нутаг:** Монгол Алтай, Говь-Алтай, тэдгээрийн салбар уулс, Зүүнгарын болон Алтайн өвөр говийн уулс, Өмнөговь, Дорноговийн бэсрэг уулс, Төв халхын тал хээрийн зарим намхан уулс, Хан хөхийн нуруу, Хангайн хөвчийн нуруу, түүний өмнө бэлийн уулсаар хэсэгчилсэн тархацтай [1,2,4,7]. Хөвсгөлийн хорьдол нурууны Нарийн бэлтэс, Арсайн голын эхээр хэсэгхэн газар тасархай популяци бий [1,8]. Хэнтийн баруун, өмнө захын зарим уулсад түр хугацаагаар нүүдэллэн үзэгдэнэ. Монголын умар хязгаараас өмнөд хязгаар хүртэл уулын тайга, уулын ойт хээр, хээр, цөлийн бүс, бүслүүрт тархана [1,2,8,16]. Өндөр нам уулс, аараг толгод, довцог, манхан элс зэрэг бартаа сархиа, нугачаа бүхий ой модгүй газар идээшилнэ. Алтайн нуруунд 3500 м хүртэл, Өмнөговь, Алтайн өвөр говьд 1100 м-ээс дээш, Хөвсгөлд

1250-2500 м өндөрт нутаглана [1,2,8,16]. Алтай, Хангайн уулсад зун мөнх цасны зах хүртэл нүүдэллэн тагийн нуга, царам, ар хажуугаар бэлчиж, өвөл уулын дундаас доош бэл энгэр газарт байршина. Хээр цөлийн бэсрэг уулс, аараг толгодод цас, задгай ус, өвс ногоо дагаж улирлаар хол ойр нүүдэллэж бэлчээрээ сэлгэдэг.

**Амьдралын онцлог:** Ороо нийлэгт X-XI сард орж, IV-V сард хургална. Сүрэглэн амьдарч, нэг угалз 20 хүртэл аргаль хураана. Үржилд 3-4 насандаа оролцоно. Төрөл бүрийн өвслөг ургамлаар идэшлэнэ [1,2,6,8].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан тоо толгой ихээхэн хэлбэлзэнэ. Монгол Алтай, Говь Алтайн зарим нутагт элбэг, Хангайн хөвчийн нуруу, зах бэлийн уулсад ховор, Өмнөговийн уулсаар ховордуу, Дундговь, Дорноговийн намхан уулсаар ховор тохиолдоно. Монголд далаад оны сүүлчээр, 40 орчим мянган толгой аргаль байснаас, Хөвсгөлд 200 орчим тохиолдоно [8,10]. 2001 онд 13000-15 000 толгой [14], 2009 онд хийсэн уулын туруутны судалгаагаар, аргаль хонь Монгол улсын хэмжээнд 50215.4 км<sup>2</sup> талбайд тархсан бөгөөд дунджаар 18100 толгой нөөцтэй гэж үнэлжээ. Мөн сүүлийн 10 орчим жилд Хөвсгөл, Сүхбаатар аймагт аргаль хонины тоо толгой харьцангуй тогтмол, харин тархац нутгийн хэмжээ 9.7-8.9 дахин нэмэгдсэнээс Говьсүмбэр аймагт тархац нутгийн хэмжээ 3.2 дахин, Төв аймагт 2.3 дахин, Баянхонгор, Дорноговь, Баян-Өлгий, Увс аймгуудад 1.2-1.9 дахин нэмэгдсэн, Хэнтий, Ховд, Өмнөговь, Өвөрхангай, Дундговь аймагт аргаль хонины тархац нутгийн хэмжээ 1.1-2.3 дахин багассан болохыг тогтоожээ [15]. Дээр үеэс эхлэн өнөө хүртэл хууль бусаар агнаснаас ховордсон [1,5]. Цөл, хээрт задгай ус, бэлчээр бүхий байршил нутагт мал бэлчээрлэснээс дайжин зайлж байна. Байршил нутаг малын бэлчээртэй давхцаж хавчигдан шахагдах үзэгдэл түгээмэл. Гол дайсан чоно. Бүргэд нялх хургыг барина. Хааяа ирвэс, шилүүс хорооно [4,8,9,16]. Цастай хүйтэн өвөл хөгширсөн угалз, төл олноор хорогдоно. Цөл, хээрт цангаж үхэх тохиолдол байдаг [4,8]. Сүүлийн жилүүдэд аргалын тархац нутагт уул уурхайн баялагийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрс ихэссэн, тусгай зориулалтаар агнах тоо хэмжээ өссөн. Дэлхийн хэмжээнд ховордсон устаж болзошгүй зүйл.


**Хамгаалсан байдал:** 1953 оноос агнахыг хуулиар хориглож, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэж. Монгол улсын улаан ном болон Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад тус тус [3,10,13]. Монгол Алтай, Хангайн өндөр уул, Говийн Алтай, Зүүн гарын болон Алтайн өвөр говьд аргалын байршил 6146.4 мянган га талбай бүхий 5 газрыг улсын тусгай хамгаалалтад авсан [12].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, өсгөн үржүүлж, зохистой ашиглах, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Төв, Сүхбаатар, Хэнтий аймгийн аргаль шинээр дахин нутагшиж байгаа болон улирлаар түр нүүдэллэн үзэгддэг газарт тогтворшуулан нутагшуулах, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд аргаль тархсан зарим нутгийг хамруулж, хамгаалалтын менежментийн төлөвлөгөөнд оруулах, цөл, хээрт аргаль ундлах задгай ус, булаг шандыг сэргээх, үндсэн байршил нутгийг малын бэлчээрээс чөлөөлөх, тусгай зориулалтын болон хууль бус агналтанд тавих хяналтыг сайжруулах, тархац

нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл болон нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулах, зудын гамшиг тохиолдсон үед нэмэлт тавьж өгөх, уул уурхайн ашиглалтын дэд бүтцийн сөрөг нөлөөллөөс хамгаалж, дүйцүүлэн хамгаалах аргыг нэвтрүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Дуламцэрэн, 1970, 3. БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975, 4. Эрэгдэндагва, 1976, 5. Намнандорж, 1976, 6. Соколов, 1980, 7. Жирнов нар, 1983, 8. Базардорж нар, 1984, 9. Амарсанаа, 1985, 10. Шийрэвдамба нар, 1997, 11. Дуламсүрэн нар, 1989, 12. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 13. CITES., 1991, 14. Амгаланбаатар нар, 2002, 15. Монгол орны уулын туруутны тархац нөөцийн үнэлгээ, 2010 тайлан, 16. Жирнов нар, 2005.

## 18. ЯНГИР ЯМАА



*Capra sibirica* Pallas, 1776

**Баг.** Туруутан - *Artiodactyla*

**Овог.** Тугалмайтныхан - *Bovidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” хэмээн үнэлэгдсэн [6].

**Таних шинж:** Гадаад төрх гэрийн ямаатай төстэй, биеэр том, хүзүү богино, бүдүүн, чих 15 см хүртэл урт, шовх, хөл бүдүүн бахим, сүүл 10--15 см. Тэхийн биеийн урт 128--167 см, сэрвээгээрээ 105 см өндөр, амьдын жин 80--110 кг хүрнэ. Ямаа биеэр бага, 120--136 см урт, сэрвээгээрээ 75-90 см өндөр, жин 90 кг хүрнэ [3,4,6]. Тэх гэдэргээ махийсан сэлэм хэлбэртэй, олон төвөнх үе бүхий 120--140 см урт эвэртэй. Ямааны эвэр богино, нарийн [2].

Залуу бодгаль ихэвчлэн улаавтар, идэр насных хар хүрэн, хар халтар, хөгшрөх үедээ цайвар халтар зүстэй болно. Тэхийн сахал өтгөн, урт.

**Тархац, байршил нутаг:** Монгол Алтай, Говь-Алтай, Зүүн гар, Алтайн өвөр говиудын уулс, Хан-хөхий, Хорьдол Сарьдаг, Улаан тайгын нуруу, Дундговь, Дорноговь аймгийн цөл, цөлөрхөг хээрийн бүсийн зарим уулсаар алаг цоог тархана. Бэсрэг уулсын бэл энгэр, аараг толгод, өндөр уулын эгц цавчим хад цохио, нуранги асга бүхий давчхан хавцал, ой модгүй, бартаа саадгүй газарт байршин нутаглана.

**Амьдралын онцлог:** Ороо нийлэгт XI сарын эхээр орж, IV сарын сүүлчээс V сарын эцэс хүртэл ишиглэнэ. Ихэрлэт элбэг. Орооныхоо үед хэдэн арав, зуугаараа нийлж, бусад үед тэх, ямаа ялгаран сүрэглэнэ. Тэх 8--12 ямаа хураана [1-6]. Өдрийн идэшлэгтэй, зун голдуу өглөө, оройн сэрүүнд идэвхтэй идэшлэнэ. Идэш тэжээлд үетэн, сонгинын төрөл, бут сөөгний навч зонхилно [6].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Хөвсгөл орчим Хорьдол Сарьдаг, Улаан тайгын нуруунд 1980 оны эхээр 1000 гаруй, улсын хэмжээгээр, 80 орчим мянган толгой байв. 2009 онд хийсэн уулын туруутны судалгаагаар, Монгол орны янгир ямаа 55985.8 км<sup>2</sup> талбайд тархсан бөгөөд 36.0 мянга орчим толгой нөөцтэй гэж үнэлжээ. Хэнтийн нурууны баруун өмнө захын цэг Богд хан ууланд 10 гаруй янгир нутагшуулж, одоо 30 орчим толгой болтлоо өссөн. Дээр үеэс тогтмол агнаснаас тоо толгой цөөрч, тархац нутаг тасархайтан хумигдсан. Хулгайн агналт одоо ч элбэг. Байршил нутгийн ус, бэлчээр гэрийн малынхтай байнга давхцана. Ирвэс, чоно, шилүүс, ялангуяа өвөл, хавар турж эцсэн амьтдыг идэхээс гадна ишгийг чоно, бүргэд барина [3,4]. Хамуугаар өвчлөх, гуур, хачиг мэтийн цус сорогч шавж шимэгчлэх, зуданд олноор хорогдох зэрэг шалтгаанаас нөөц хомсдож байна [2].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны хавсралтад бүртгэсэн. Тархац нутгийг Говийн их дархан цаазат газар, Хорьдол Сарьдаг Богдхан уулын дархан цаазат газар, Их Богд, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, тохиромжтой газарт сэргээн нутагшуулах, зориудаар өсгөн үржүүлэх, байршил нутагт задгай ус бий болгох, булаг шандаас чөлөөтэй ундаалах нөхцлийг бүрдүүлэх, зудын үед нэмэлт тэжээл тавьж өгөх, тархац нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулж, хууль бус агналтыг таслан зогсоох, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Намнандорж, 1976, 3. Дуламцэрэн нар, 1989, 4. Соколов, Орлов, 1980, 5. Энхбилэг, Дуламцэрэн, 1999, 6. Монгол орны уулын туруутны тархац нөөцийн үнэлгээний тайлан, 2010, 7. Дуламцэрэн нар, 2006.

19. СОРГОГ БӨХӨН



*Saiga tatarica tatarica* Linnaeus, 1766

**Баг.** Туруутан - *Artiodactyla*

**Овог.** Тугалмайтныхан - *Bovidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн [16].

**Таних шинж:** Гөрөөсний төрх галбиртай, хонины хэмжээтэй, дунд зэрэг биетэй амьтан. Биеийн урт 146 см, сэрвээний өндөр 79 см, жин 51 кг хүрнэ [2]. Эр эмэгчнээсээ биерхэг. Хэржин тахираараа 33 см хүртэл урт, гялалзсан цайвар шаргал зүстэй бөгжилсөн олон товгор цагираг бүхий хос шоорон эвэртэй. Хэрэгчин эвэргүй. Банхгар, монхор хамрын үзүүр доод уруулаасаа урт гарч, шолхойн унжих бөгөөд гүйхэд савлаж байдаг. Хүзүүгээ сунган толгойгоо өвдгөө хүртэл гудайлган тонгойж, 70-80 км/цагийн хурдтай хатирдгаараа бусад зээр гөрөөснөөс содон. Зун тод улаан шаргал, өвөл элсэн шаргал цайвар сааралдуу зүстэй [1,2,11].

**Тархац, байршил нутаг:** Монголын нутаг дахь Зүүнгарын говьд Монгол Алтайн нурууны бэлээс урагш, Хөвчийн нуруу, Булган голын хооронд, өндөр уул, говиор хязгаарлагдмал хэсэгхэн нутагт ХХ зууны эх хүртэл олноор байршиж байв [1,3-5]. Тархац, тоо толгой харьцангуй түргэн хомсдож, тавиад онд зөвхөн Хавтаг, Байтаг уул хавь, Борцонжийн говьд цөөн үзэгдэж байснаа, тавиад оны дундаас үзэгдэхээ больжээ [1-5]. 1970 оны сүүлчээр, Аргалант уулын орчим 4 бөхөн байснаас хойш дахин үзэгдээгүй [13]. Говийн хялгана, ерхөг, шаваг, хөмүүлт элсэрхэг, хайрган хөрст тал, харгана, хялгана, үетэнт элсэрхэг бэл, заримдаа шаваг, тэсэг, бударгана бүхий говьд тааралддаг. Улирлаар байршлаа сольж нүүдэллэдэг. Өвөл заг, бударганат говьд байршдаг тохиолдол бий [1,3-7].

**Амьдралын онцлог:** Тархац, нөөц, биологийг судлаагүй. Хавар, намар сөл тасарсан үед хэд өнжөөд усанд ирнэ. Харин зун шүүслэг ургамал, өвөл цас усны хэрэгцээг бүрэн хангадаг

гэсэн мэдээ бий. Зун өглөө, оройн сэрүүнд өвөл өдөржин идшилж зун өдөр, өвөл шөнө хэвтэж амарна. Казахстан улсад хэржин 19 сартай, хэрэгчин 7 сартайгаасаа бэлгэ боловсорч, XII, I сард ороо хөөцөөнд орж, V сарын эхээр хэрэгчин 1-2 янзага гаргадаг [1,2,6,11]. Нялх янзага тэжээвэр нөхцөлд гаршин дасаж бойжоод, үржилд орж хэвийн төллөдөг [12].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Бэлчээр, усаар бүх улиралд хар сүүлт зээр, цагаан зээр, хулан, өвөл, хавар эрт, намар орой малын бэлчээртэй байнга давхцан. Цас ихтэй хүйтэн өвөл олноороо турж үхнэ. Чононд идүүлнэ. Бүргэд нялх янзагыг барьж хорооно. Эврийг авахаар хэржинг түүж агнадаг, зудад эр их үхдэг зэргээс сүргийн хүйсийн тэнцвэрт харьцаа алдагдаж үржил муудаж цөөрсөн. Хорь гучаад онд Дундад Азид бөхөн ховордсоноос монгол нутаг дахь тархацын хамгийн зүүн захын популяци эх сүргээсээ тасран тоо толгойгоо нөхөн сэлбэх боломжгүй болон байгаль, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс устаад байна.

**Хамгаалсан байдал:** 1930 оноос агнахыг хуулиар хориглон, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн [15]. Монгол улсын улаан ном болон Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад оруулсан [8,9,10,14]. Тархац нутгийн ихэн хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Монголд байршин амьдарсан болон түр шилжин ирж болзошгүй нутагт судалгаа хийж, устсан эсэхийг үнэлэн тогтоох, сэргээн нутагшуулах эсэх асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт саналыг боловсруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Банников нар, 1961, 3. Намнандорж, 1976, 4. Эрэгдэндагва, 1954, 5. Дуламцэрэн, 1970, 6. Жирнов, 1982, 7. Гептнер нар, 1961, 8. БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975, 9. Закон об охоте МНО, 1930, 10. Шийрэвдамба нар, 1997, 11. Тадеев нар, 1982, 12. Петришев, 1987, 13. Жирнов, 1977, 14. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 15. Байгаль орчин хуулийн эмхэтгэл, 2012, 16. Lhagvasuren et al, 2001.

## 20. МОНГОЛ БӨХӨН



***Saiga borealis* Tscherski, 1876**

**Баг. Туруутан - *Artiodactyla***

**Овог. Тугалмайтныхан - *Bovidae***

**Статус:** Нэн ховор, унаган зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн [23]. Бөхөн нутагшдаг бүх орны Засгийн газар, шинжлэх ухааны байгууллага, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөгч оролцсон олон улсын хурал Улаанбаатар хотноо 2010 онд болж, Монгол бөхөнг тусгаар бие даасан зүйл (*Saiga borealis*) болохыг хүлээн зөвшөөрч талуудын гэрээг шинэчлэн найруулсан [24].

**Таних шинж:** Биеийн урт 116 см, сэрвээний өндөр 75 см, жин 32 кг хүрнэ. Хэржин 25 см хүртэл урт, олон төвгөр үетэй, цайвар шаргал өнгөтэй, хос шорон эвэртэй. Хэрэгчин эвэргүй. Зун улаан шаргал, өвөл цайвар саарал, нялх янзага бор хүрэн зүстэй. Хүзүүгээ урагш сунган, толгойгоо гудайлган бөхийж, цагт 60-70 км хүртэл хурдан хатирдаг.

**Тархац, байршил нутаг:** Өнгөрсөн зуунд Увс нуурын хонхороос Улаан нуур хүртэлх Их нууруудын хотгор, Нууруудын хөндийн цөлөрхөг хээрт тархан амьдарч байв [1,3,5,6,25]. 1995 оны байдлаар, байршсан тархацынхаа хориод хувьтай тэнцэх хоёрхон нутагт үлдсэн. Түүний нэг Шаргын популяци Шаргын говийн өмнө, баруун, хойд хэсгээр, эргэн тойрны уулсын бэлээс говийн хонхорын захад тархжээ. Хар Ус нуураас урагш Монгол Алтайн уулсын бэлээр 400 орчим км<sup>2</sup> хэсэгхэн нутагт үлдсэн, устах аюулд орсон зүйл [5,12]. Монгол Алтайн уулсын д.т. 1100-2200 м ар бэлийн баглуур, таана, монгол өвст, шаваг бүхий дагжуур хайрган хөрст, бартаагүй, хэвгий, ээрэм дэнж талд нутаглана [1,2,5,10-12]. Өвлийн цастай хүйтэн, эсвэл гантай зун нөмөр, бэлчээр дагаж уулсын ам хөндий, толгод доор бэлчдэг. Монгол бөхөн Шаргын говьд 3325 км<sup>2</sup>, Хүйсийн говьд 6700 км<sup>2</sup>, Таван хайрхан, Чандманий талын 1173 км<sup>2</sup> нутагт байршдаг [21].

**Амьдралын онцлог:** Өвс, ус дагаж бэлчээрээ ойр зуурхан сэлгэнэ. Алс нүүдэллэхгүй. Шаргын говьд өвөл 50 хүртэл толгойгоор сүрэглэнэ. Зун сүрэг задарч жижигрэнэ. I сард ороо нийлэг болж, 5 сар орчим хээлээ тээгээд YI сарын дундуур төллөнө. Хэрэгчиний 16 хүртэл хувь ихэрлэдэг. Хэрэгчний зарим 7 сартайдаа, хэржин 19 сартайдаа үржилд орж эхэлнэ [10,13]. Говийн хялгана, таана, хөмүүл, баглуур, шарилж зэрэг 30 гаруй зүйлийн өвслөг ургамлаар идэшлэнэ. Таана, хөмүүл зэрэг шүүслэг нялх ургамалтай үед ус бараг уухгүй. Гельминт 17, хачиг 2, арьсны гуур 1 зүйл шимэгчилдэг. Тэжээвэрт малын омруу өвчин хүнд тусдаг. Нялх янзага хүнд хялбар гаршиж бойжсоор бие гүйцэж, хэвийн төлжиж үрждэг.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Байгаль, хүний хүчин зүйлийн нөлөөгөөр тоо толгой жилээс жилд ихээхэн хэлбэлзэнэ. 1993 оны байдлаар, Шаргын популяци 1400 орчим, Манханы популяци 70 гаруй толгой байв [15,16]. Шаргын говийн 1000 га-д 5.9 толгой ногдох 1980 орчим, Хүйсийн говьд 1000 га-д 1.6 толгой ногдох 1100 орчим, Чандманий талд 1000 га-д 0.8 толгой ногдох 160 орчим, нийт 3240 толгой монгол бөхөн байна [21]. 2010-2012 онд хийсэн Биологийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/-гийн монгол дахь хөтөлбөрийн газрын хамтарсан тооллого судалгаагаар, монголд дунджаар 8000 толгой монгол бөхөн байгааг тогтоожээ [26]. Эврийг Дорно дахины ардын эмнэлэгт, махыг нутгийнхан хүнсэндээ дээр үеэс хэрэглэж, хайр гамгүй агнаснаас тархац нутаг хумигдаж, тоо толгой эрс цөөрсөн [1,4,5,11,25]. 1990-ээд оноос эхлэн эврийг гадаадад гаргах болсноор хууль бус агналт ихэссэн. Идээшин дассан гол байршил нутаг, ус бэлчээрийг хүн, мал эзлэн шахаж байна. Их цастай хүйтэн өвөл, хавар бөхөн бөөнөөрөө осгож, өлбөрч үхдэг [1,5,11,12,25,27]. Ихээхэн гууртдагаас таргалах, байгалийн бэрхшээл даах чадвар доройтож хомсдоход нөлөөлдөг [8,10]. Байгаль дахь гол дайсан бүргэд [11]. Устах аюулд орсон, унаган зүйл.

**Хамгаалсан байдал:** 1930 оноос агнахыг хуулиар хориглон, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн [22]. Монгол улсын улаан ном, Олон улсын улаан ном, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад тус тус оруулав [9,14,17,20]. Шарга, Манханыг 1993 оноос улсын тусгай хамгаалалттай нөөц газар болгосон [19]. Тархац, нөөц, биологи, экологийг судалж, гаршуулан үржүүлэх, нутагшуулах ажлыг туршив.


**Хамгаалах арга хэмжээ:** Байршил нутгийг дайрдаг олон салаа замыг цөөрүүлэн журамлах, зам дагуух хяналтыг сайжруулах. Улсын тусгай хамгаалалтай нутгийн сүлжээнд тархац нутгийг нэмж хамруулах, гаршуулан үржүүлж, байршиж байсан нутагт сэргээн нутагшуулах, мал, бөхөнгийн ус, бэлчээрийн давхцалыг арилгах, биологийн нарийвчилсан судалгааг гүнзгийрүүлэн явуулах, хууль бус агнуурыг таслан зогсоох арга хэмжээ авах, тархац нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, нутгийн иргэдэд холбогдох хуулийн дагуу хариуцуулан хамгаалуулж, хамгаалалт, хяналтыг тогтмолжуулан, чангатгах, хууль бус агналтыг таслан зогсоох, ган, зуд, гамшиг тохиолдсон үед биотехникийн арга хэмжээ авах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Эрэгдэндагва, 1954, 3. Банников нар, 1961, 4.



Цэвэгмид нар, 1973, 5. Намнандорж, 1976, 6. Ширчин, 1974, 7. Сапожников нар, 1982, 8. Грунин, 1962, 9. БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975, 10. Дуламцэрэн нар, 1989, 11. Дуламцэрэн, 1992, 12. Дуламцэрэн нар, 1993, 13. Дуламцэрэн нар, 1994, 14. Закон об охоте МНО, 1930, 15. Дуламцэрэн нар, 1993, 16. Бадрах нар, 1993, 17. Шагдарсүрэн нар, 1987, 18. Болд нар, 1984, 19. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 20. CITES, 1991, 21. Амгалан нар, 2008. 22. Байгаль орчин хуулийн эмхэтгэл, УБ. 2012, 23. Улаан данс 2006, 24. Бөхөн хамгаалах олон улсын хурлын эмхэтгэл, 2010, 25. Жирнов нар, 2005. 26. ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын тайлан, 2012, 27. Шийрэмдамба нар, 1997.

## 21. ХАР СУҮЛТИЙ



*Gazella subgutturosa* Guldenstaedt, 1780

**Баг.** Турууман - *Artiodactyla*

**Овог.** Тугалмайтныхан - *Bovidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Биеийн урт 97--118 см, сэрвээгээрээ 61-70 см өндөр, жин 20-30 кг. Сүүл 16-24 см, хар, хар хүрэн өнгөтэй. Тангийн дээд зах сүүлний уг хүрнэ. Зун зоо нуруу улаан шаргал, хэвэл тод цагаан, өвөл цайвар шаргал, хэвэл цагаан [1,5,7,15].

**Тархац, байршил нутаг:** Зүүнгар, Алтайн өвөр говиуд, Өмнөговь, Дорноговь аймгийн нутгаар нэлэнхүй, Дундговийн өмнө хэсэг, Сүхбаатар аймгийн баруун өмнөд хэсэг, Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд цөөн тоогоор алаг цоог тархсан. Уулсын бэлийн хялганат, хялгана--баглуурт, сайр садарга бүхий дагжуур хөрст хэвгий газар, загт, заг--бударганат говь, сондуул бүхий бут сөөгт цөл, хээр, хотос хоолой зэрэг орчинд байршин нутаглана [1,4,7,-11,17]. Хавар, намар, гандуу зун, өвлийн улиралд бэлчээр, ус дагаж

нүүдэллэнэ. Гандуу хавар, зун, намар ногоо, сөл дагаж, бэсрэг нам уулс, толгодод гүн нэвтэрнэ. Гантай зун Монгол Алтайн нурууны 2700 м хүртэл өндөрт уулын хяр зоонд гарч, бэлчих тохиолдол бий. Хүний нөлөө эрс ихэссэн сүүлийн жилүүдэд тэгш хээр талд байршихаа бараг больж, аараг толгод, сайр садарга, элсэрхэг довон сондуул бүхий авто хөсөг явахад бэрх, бартаатай газар дагаж, нутаглах зохилдлоготой болж байна [11]. 1990-ээд оны сүүлээр, Монголд 542.7 мянган ам км буюу манай орны нутаг дэвсгэрийн 34.6%-тай тэнцэх талбайд тархсан байна [15].-БОАЖЯ, Дэлхийн Банк, Голландын засгийн газар “NEMO-II” төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Биологийн хүрээлэн Монгол орны тал хээр, говь цөлийн тууртны популяцийн нөөцийн үнэлгээг 2010 онд хийж, хар сүүлтий Монгол орны 10 аймгийн 52 сумын нийт 343982 км<sup>2</sup> нутагт тархаж, 2000 оныхтой харьцуулахад 37.6 хувиар буурсан гэж дүгнэлт гарчээ [16].

**Амьдралын онцлог:** Өвслөг, сөөг, сөөгөнцөр ургамлаар идэшлэхийн дотор хялгана, баглуур, таана, хөмүүл, зэрэг ургамал зонхилно. Говь, цөлийн бүсийн 80 гарам зүйл ургамал бүртгэгдсэн [1,2,11,15.17]. Зун өглөө, оройн сэрүүнд, өвөл өдрийн идэшлэгтэй. Ороо нийлэг XII сард болж, шаргачин VI сард голдуу нэг (64.6%) буюу хоёр ихэр (35.4%) янзага төрүүлнэ [15]. Ихэнхдээ 4-7, нүүдэллэх үедээ 100--аас дээш толгойгоор сүрэглэнэ [3,9-11,15].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Говь цөлийн задгай ус, бэлчээрийн ашиглалт эрчимжин, задгай ус, булаг, шандыг хүн мал байнга эзэгнэх болсноос байршил нутгаасаа дайжих явдал их гарч байна. Тээврийн хэрэгслээр хөөж, гэрэлтүүлэн агнах, байршин идээшсэн нутгаас хөөж дайжуулснаас тоо толгой хорогдон багасч байна. 1960-аад оноос мал аж ахуйг хөгжүүлэхэд анхаарч говь цөлийн задгай ус, баян бүрдүүдийг эзэмших, зэлүүд бэлчээрийг усжуулан эзэгнэх, хүнсний ногоо тарих, машин техник олшрох, задгай усны дэргэд суурьших явдал ихэссэн зэрэг нь хар сүүлтийг идээшин дассан бэлчээр уснаас шахан дайжуулах сөрөг нөлөө болсон. Гол дайсан нь чоно, шилүүс, бүргэд. Тас нялх янзагыг барьдаг. Зуданд турж, осгон олноор үхнэ [1,4,11]. Дээр үеэс их хэмжээгээр хууль бусаар агнаж, сүргийн бүтцийг алдуулснаас зарим нутагт устаж, тархац нутаг алаг цоог болоод байна [2,3,7]. Тавь, жараад оны үед тархац нутаг, тоо толгой эрс хомсдсон юм. Харин 1980--аад оны үеэс мэдэгдэхүйц өссөн ч тоо толгой, тархац нутаг урьдын хэмжээндээ хүрээгүй байна. 1990-ээд оны үед Монгол орны нутагт 60 орчим мянган толгой хар сүүлтийн нөөцтэй байв [14]. 2000 оны байдлаар, Монголд 542.7 мянган ам км буюу манай орны нутаг дэвсгэрийн 34.6%-тай тэнцэх талбайд 140 орчим мянган толгой хар сүүлтий байна [15]. Говь, цөлийн тууртны популяцийн нөөцийн 2010 оны үнэлгээгээр, хар сүүлтий 10 км<sup>2</sup>-т 0.3 бодгаль ноогдох нягтшилтайгаар дунджаар 12 мянган толгой нөөцтэй, 2000 оныхтой харьцуулахад тоо толгой 11.6 дахин цөөрсөнийг тогтоожээ [16].


**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтнаар бүртгэсэн. Монголд 1962 оноос хар сүүлт зээрийг үйлвэрлэлийн зориулалтаар агнахыг хуулиар хориглож, зөвхөн иргэдийн хүнсний хэрэгцээнд IX сарны 15--аас X сарын 30 хүртэл хугацаанд түр агнахаар тогтоож, 1965 оноос агнахыг бүрмөсөн хориглож, Монгол улсын улаан номд оруулан, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн хар сүүлт зээр тархсан нутгийг улсын тусгай хамгаалалттай газар болгожээ [5,12,13]. Говийн их дархан газрын Б хэсэг, Говийн бага дархан газрын А, Б хэсэг, Говь гурван сайхны байгалийн цогцолбор газар,

Загийн усны нөөц газрууд зэрэг нь хар сүүлтий хамгийн элбэг байнга байршдаг, үржих төлжихөд онцгой чухал ач холбогдолтой голомт нутаг юм. Шарга, Манхан, Хар Ус нуур орчмын хар сүүлтий нэн ховордсон нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт авсан нь энэ бүс нутагт өсч үржих нөхцлийг бүрдүүлсэн. Хар сүүлтийн тархац нутгийн 10929.272 мян. га талбай буюу 20.1% нь улсын тусгай хамгаалалттай /дархан цаазат газар 2, байгалийн цогцолборт газар 2, байгалийн нөөц газар 4/ нутгийн сүлжээнд хамрагджээ [15].

**Хамгаалах арга хэмжээ:** Цөл, цөлөрхөг хээр, хээрт зээр ундаалах задгай ус бий болгох, зудын үед нэмэлт тэжээл тавьж өгөх, байршил нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулах, хяналтыг тогтмолжуулан сайжруулах замаар хууль бус агналтыг таслан зогсоох, Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд сэргээн нутагшуулах, тархацын умард зах руу байршин нутагших нөхцлийг бүрдүүлэх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд хамгаалах зориултаар сэргээн нутагшуулах, өсгөн үржүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Сосорбарам, 1967, 3. Хайдав, 1969, 4. Дуламцэрэн, 1970, 5. БНМАУ--ын ан агнуурын хууль, 1975, .6 Намнандорж, 1976, 7. Соколов нар, 1978, 8. Жирнов нар, 1983, 9. Амгалан, 1984, 10. Бадамханд, 1984, 11. Дуламцэрэн нар, 1985, 12. Шийрэвдамба нар, 1997, 13. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 14. Амгалан, 1995, 15. Амгалан, 2000, 16.Тал хээр, говь цөлийн бүсийн тууртны популяцийн нөөцийн үнэлгээ тайлан, 2010, 17. Жирнов нар, 2005.

## 22. БАДАНГА ХҮДЭР



*Moschus moschiferus* Linnaeus, 1758

**Баг.** Туруутан - *Artiodactyla*

**Овог.** Бугынхан - *Cervidae (Moschidae)*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Гирээ, гирэгчин эвэргүй. Гирээ дээд уруул дороосоо илүү гарч эрүүнээс доош сөрдийсэн, 7 см хүртэл урт сэлэм хэлбэртэй, хурц, тод цагаан соёотой. Гирэгчний соёо жижиг. Хажуу, зоо хондлойгоороо бүдэг шаравтар толбо бүхий хүрэн бор, бараан хүрэн зүстэй. Хэвэл, мөчдийн дотор тал цайвар [2,4,6]. Хондлой сэрвээнээсээ өндөр, урьд хөл хойд хөлөөс богино харагдана. Биеийн урт 93 см, сэрвээний өндөр 69 см, жин 14 кг хүрнэ [6].

**Тархац, байршил нутаг:** Хэнтий, Хөвсгөл, Хангайн уулархаг нутаг, Монгол Алтайн умард хэсгийн зарим салбар уулсын ойгоор тархмал [1,2,5,6]. Хөвсгөлийн уулс болон Хангайн нуруу баданга хүдэр тархан байршихад тохиромжтой нөхцөл ихтэй болохыг энэ бүс нутагт Монгол орны баданга хүдрийн нийт нөөцийн 83 хувь байгаа дүн нотолно. Уулсын ар хажууд 1700-2300 м өндөрт хуш, хуш-шинэс, шинэсэн ойд амьдарна [1,2,5,6]. Сүүдэрлэг хэц хажуугийн хөвдөн дэвсгэртэй хөрс, модны хаг ихтэй, унанги модтой балар шигүү ойд байршина. Ой доторх хад цохио, асганд тааралддаг, задгай газар үзэгдэхгүй. Байршлаа улирлаар бага өөрчилдөг. Тодорхой хэсэгхэн газар байнга нутаглана [4,6].

**Амьдралын онцлог:** Ороо нийлэгт XII сарын дундаас орж, VI сарын эцэс, VII сарын эхээр голдуу ихэр шовшоорой төрүүлнэ. Сүрэглэдэггүй. YII-YIII сард гуужна. Зун голдуу ургамал, ихэвчлэн хаг хөвд иднэ. Шовшоорой 2 сар гаруй хөхүүл байна. Аюул тохиолдох, айж сандрахдаа исгэрэх, уйлах мэт дуугарна [1-6].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Их агналтаас энэ зууны хорь гучаад онд тархацынхаа ихэнх хэсэгт нэлээд цөөрчээ [4-6]. Далаад онд тус улсад 60-80 мянга байсны 44 мянга Хэнтий, Хангайд тохиолдов [6]. Элбэг газраа 1000 га-д Хэнтийд 21-35, Хангайд 6-8 толгой бүртгэгдэж байв [5,6]. Түүнээс хойш популяцийн хэмжээ багасч 1990-ээс 2000 оны байдлаар нягтшил 1 км<sup>2</sup>-д 1.2-оос 0.2 болтлоо буурсан байна [11,12]. БОАЖЯ, Дэлхийн Банк, Голландын засгийн газар “NEMO-II” төсөл зэрэг байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс гүйцэтгэсэн “Монгол орны ойн туруутан амьтдын популяцийн үнэлгээ” 2010 судалгааны ажлын тайланд 34796 км<sup>2</sup> нутагт 1000 га-д 1,9 бодгаль ноогдох нягтшилтайгаар 6525 толгой баданга хүдрийн нөөцтэй хэмээн тогтоосон. Сүүлийн жилүүдэд хүдрийн заарыг авах зорилгоор хулгайн агналт ихэссэнээс тоо толгой эрс цөөрөх болов [1,4,6]. Байгальд чоно, шилүүс, нохой зээх, баавгайд бариулдаг [6]. Дэлхийн хэмжээнд ховордсон, устах аюулд орсон зүйл.


**Хамгаалсан байдал:** 1953 оноос агнахыг хуулиар хориглосон [6,7]. Амьтны тухай хуулиар нэн ховор амьтнаар, Монгол улсын улаан номонд, зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад тус тус бшртгэсэн [8]. Хүдрийн байршил нутгийг Хангай, Тарвагантай, Хан Хэнтий, Богдхан уулын

дархан газар, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт хамруулжээ. Баданга хүдрийн тархац нутгийн 6971км<sup>2</sup> нутаг нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт, 3854 км<sup>2</sup> нутаг нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан байна [10].

**Хамгаалах арга хэмжээ:** Хүдэрийг хууль бусаар агнах, заар худалдах, худалдан авах, дамжуулах, хилээр нууж гаргах зэрэг хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авах, тархац, нөөц, биологи, экологи онцлогийг судлах, зориудаар өсгөн үржүүлэх, үндсэн тархац нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, нутгийн иргэдэд холбогдох хуулийн дагуу хариуцуулан хамгаалуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Козлова, 1933, 2. Банников, 1954, 3. Дуламцэрэн, 1971, 4. Дуламцэрэн, 1972, 5. Соколов нар, 1982, 6. Дуламцэрэн, 1989, 7. Правило охоты на территории Монголии, 1926, 8. CITES, 1994, 9. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 10. Монгол орны ойн туруутны популяцийн үнэлгээ тайлан, 2010, 11. Цэнджав, 2000, 12. Цэнджав, 2002.

## 23. БУГАН ЦАА



*Rangifer tarandus* Linnaeus, 1758

**Баг.** Туруутан - *Artiodactyla*

**Овог.** Бугынхан - *Cervidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Биеийн урт 220 см, сэрвээний өндөр 140 см, жин 300 кг хүрнэ [1,2,4]. Бие гонзгойвгор. Хөл харьцангуй богино. Хүзүү урт. Чих жижгэвтэр, үзүүр мохоодуу. Эгэр, манжиг арагш дээш чиглээд үзүүр нь урагш эргэн дугуйрсан олон салаа, хавтгайдуу эвэртэй. Манжигийн эвэр этэрийнхээс арай бага, цөөн салаатай. Зун хүрэн буурал, бүдэг эрээлж

бүхий жигд бор, өвөл бараавгар эрээлж бүхий цайвар саарал зүстэй [1-4].

**Тархац, байршил нутаг:** Дэлхийн тархацын хамгийн өмнөд зах болох Хөвсгөл нуур орчмын өндөр уулсын зоо, тагийн бүслүүрийн д.т. 2300-3000 м өндөрт алаг цоог тархацтай. Монголд: Улаан тайгын нурууны Жамс, баруун зүүн Жодог, Бяранга, Тэнгис, Шарга голын эх, Хөвсгөл нуурын Хэвэн, Залуу үүрийн сарьдаг, Хэвэн, Залуу үүр голын эх 1600-аад ам. км нутагт тархана. Зун ойн бүсээс дээш сарьдаг, тагийн хаг, хөвд, сөөг бүхий царамд, өвөл, хавар уулын ойн дээд бүслүүрт бэлчинэ. Буган цаа 10 сарын эхнээс Саяны өндөр уулсын ар бэлээс өвөр лүү нүүдэллэн ирж, дараа оны шар усны үер болохоос урьтаж буцан нүүдэллэдэг. Нутгийн сүрэг болон сүргээсээ тасарч хоцорсон цөөн сүрэг Монголын талд тогтмол байнга байршдаг [9].

**Амьдралын онцлог:** Өвөл хаг, хөвд, мод, бутны мөчир, нахиа, найлзуураар идээшлэнэ. Зун элдэв ногоо, хаг хөвд, бутны навч, найлзуур, мөөг иднэ. Зун өглөө орой, өвөл голдуу өдөр бэлчээрлэнэ. Сүрэг янз бүрийн насны манжиг, этэр, төлөөс бүрдэнэ. Ороо нийлэг X сард болж, этэр 15 хүртэл манжиг хурааж хээлтүүлнэ. Манжиг V, VI сард хугаш төрүүлж, намар орой болтол хөхүүлнэ. Этрийн эвэр орооны дараа XII, I сард, хээлтэй манжгийнх төллөсний дараа VI сард, сувай манжгийнх II сард унаад, VIII сарын сүүлчээр ургаж дуусна.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Сүүлийн гучаад жилд цаа бугын тархац нутгийн хэмжээ ойролцоогоор бараг тал хувь багасч, тоо эрс цөөрөв. Жамс, Жолог хавьд нэн ховордлоо. Энд 1994 оны зун 2, 3, 5 толгой бүхий 3 сүрэг үзжээ. 1996 оны байдлаар, Монголд 200-400 толгой цаа бугатай байсан [6]. Хөвсгөл нуурын баруун хэсэгт (Бяран, Тэнгис, Жүгнэг, Шарга, Хороо орчимд) 80-100 орчим, зүүн хэсэгт (Нарийн ханхын эх, Хэвэн, Өлгий гол, Залуу үүрийн эх орчим) 60-80 орчим нийт 140-200 орчим буган цаа улсын хил орчмын нутгаар байршиж байна [9]. Хууль бусаар агнах, чононд их хөнөөгдсөнөөс устах аюулд ороод байна.

**Хамгаалсан байдал:** Монголд 1953 оноос цаа буга агнахыг хуулиар хориглон, амьтны тухай хуулиар нэн ховор амьтнаар оруулж [8] Монгол улсын улаан номонд хоёр удаагийн хэвлэлд “нэн ховор” зэрэглэлээр тус тус бүртгэсэн [5]. Тархац нутгийн ихэнх хэсэг нь Хорьдол-Сарьдагийн дархан цаазат газар, Улаан тайга болон Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт хамрагдаад байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, байршил, тоо толгой, үржил хорогдлын шалтгааныг судалж, хамгаалах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах, цаа буга цөөрсөн газрын чонын тоо толгойг зохицуулах, зориудаар өсгөн үржүүлэх, хил дамнасан тусгай хамгаалалтай газар байгуулж, хамгаалалтын менежментийг сайжруулах, хууль бус агналтыг таслан зогсоож, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Намнандорж, 1964, 3. Дуламцэрэн, 1970, 4. Соколов нар, 1980, 5. Шагдарсүрэн нар, 1987, Шийрэвдамба нар, 1997, 6. Төмөрсүх, 1991, 7. Улаан данс, 2006, 8. Байгаль орчин хуулийн эмхэтгэл, 2012, 9. Адьяа нар, 2013.

24. ШИВЭР МОЛЦОГ ХАНДГАЙ



*Alces alces pfitzenmayeri* Zukowski, 1910

**Баг.** Туруутан - *Artiodactyla*

**Овог.** Бугынхан - *Cervidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн [1].

**Таних шинж:** Биеийн урт 300 см, сэрвээний өндөр 240 см, жин 570 кг хүрнэ [2]. Бие харьцангуй богино, том, лагс. Мөчид урт. Чих урт, сүүл богино. Дээд уруул доод уруулаа бүрхэж унжина. Хоолойдоо арьсан унжлага буюу сүүхтэй. Мэнжийн сүүх сүндэснийхээс том. Мэнж олон салаалсан том эвэртэй. Эврийн уг богино, бүдүүн, дундаа хавтгай, зөвхөн дээд захаараа олон салаатай. Зүс жигд хар халтар бараан, хөл, хоншоор цайвар [2,3,4,5].

**Тархац, байршил нутаг:** Хэнтийн уулархаг нутгийн Онон, Хэрлэн, Туул, Хараа, Ерөө, Минж голын тайга, Хөвсгөл орчимд Улаан тайга, Хордил нуруу, Үүр голын сав, Умард Хангайд Бүтээлийн нуруу, Бүрэнгийн нурууны зүүн хэсэгт тархана [1,3-6,7-13]. Гол горхийн хөндийн ам татмын чийгтэй бургас, сөөгөн хус торлогон шугуйт намгархаг нуга, уулын хажуугийн торлог ихтэй үргэлжилсэн ойд нутагладаг [3,5-14]. Гол, горхи, нуур усны ойролцоо байх дуртай [3,5]. Өвөл, зуны байршил нутаг бараг адилхан [5]. Хэнтийд өвөл уулын 2000 м--т өгсөн ойн дээд зах хүртэл бэлчиж, зун заримдаа уулын тагд үзэгддэг [3,5]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Амьдралын онцлог:** Ороо нийлэгт IX сард орж, V сарын сүүлч, VI сарын эхээр сүндэс 1-2 ходол төрүүлнэ [5]. Голдуу ганц хоёр толгойгоор тааралдана. Хааяа бүлээрээ 6 хүртэл толгойгоор сүрэглэнэ [3,5]. Бие гүйцсэн манж ганцаар явна. Зун төрөл бүрийн ургамал, өлөн, хөвд, найлзуураар идэшлэнэ. Өвөл бут сөөгийн нахиа найлзуур, мөчир, хөвд зонхилон иднэ.

Зун намар мараа долооно. Өглөө, үдэш, шөнө идэвхтэй [3,7,8-14].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Бараг судлаагүй. Дээр үеэс мах, арьсыг ашиглах зорилгоор агнаж ховордуулжээ [5,9,10]. Наяад оны эхээр 1000 га-д ноогдох толгойн тоо Хэнтийн Минж голын савд 1-2, Захар, Хэрлэнгийн эхэнд 3-5, Ерөөгийн эх Шарланд 3-4, Бүрэнгийн нурууны зүүн хэсэгт, Ононы эх Тарс орчимд 10 км-т тус бүр нэг тохиолдож, бүх тархац нутагтаа 10 гаруй мянган толгой байсны, 70 хувь Хэнтий, Хангайн уулархаг нутагт тохиолдоно [4,5,13,14]. Монгол оронд 2010 оны байдлаар, 39945 км<sup>2</sup> нутагт 1.6 бодгаль ноогдох нягтшилтайгаар 7100 орчим шивэр молцог хандгай тархан байршиж байгааг тогтоосон байна [15]. Хууль бусаар агнадаг. Чоно төлийг хялбар барьж хороодог бөгөөд Хэнтийд хандгайд халдах нь түгээмэл. Хамар залгиурын гуур ихтэй [5]. Байршил нутаг, халиун буга, бор гөрөөс, хүдэр, зэрлэг гахайтай давхцана [5]. Устах аюулд орсон зүйл.

**Хамгаалсан байдал:** Агнахыг 1953 оноос хуулиар хориглож, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн. Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийн 20 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан [1,13,14].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц биологийг судалж, хамгаалах арга боловсруулан хэрэгжүүлэх, байршил нутгийн улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад эзлэх хувийг нэмэгдүүлж, хамгаалалтыг сайжруулах, зэрэг амьдрах орчныг хамгаалах арга хэмжээ авах, хууль бус агналтыг таслан зогсоох, удмын санг хадгалах.

**Эхзохиол, мэдээ:** 1. Clark нар, 2006. 2. Гептнер нар, 1961, 3. Банников, 1954, 4. Соколовнар, 1983, 5. Дуламцэрэн, 1989, 6. Дуламцэрэн, 1970, 7. Намнандорж, 1976, 8. Хайдав нар, 1969. 9. Дамдин, 1963, 10. Намнандорж, 1964, 11. Соколов нар, 1980, 12. Базардорж нар, 1984, 13. Шагдарсүрэн нар, 1987, 14. Шийрэвдамба нар, 1997, 15. Монгол орны ойн туруутан амьтдын судалгаа, 2010.

## 25. ХАРМӨРНИЙ МОЛЦОГ ХАНДГАЙ





*Alces alces cameloides* Milne-Edwards, 1867

*Баг. Туруутан - Artiodactyla*

*Овог. Бугынхан - Cervidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн [1].

**Таних шинж:** Шивэр хандгайнаас арай бага. Биеийн урт 276 см, сэрвээний өндөр 195 см, жин 400 кг хүрнэ [2]. Ерөнхий зүс жигд бараан, мөчид арай цайвар. Эвэр жижиг, хөнгөн, бугынхтай төстэй.

**Тархац, байршил нутаг:** Хятадын зүүн хойд нутаг Их Хянганы нуруу, ОХУ-ын Амар, Уссурийн хязгаар, Тэнгис хавийн нутгаар байршина [2]. Халх гол, түүний цутгал Дэгээ, Нөмрөг голын савд тархсан Хүйтэн, сэрүүний улиралд баруун тийш Гүү азрагын манхан, Авдрантын булаг хүртэл үзэгдэнэ. Зун татмын бургас, монос, өрөл зэрэг бутан шугуй бүхий өтгөн өндөр өвс зэгстэй намаг нугад идээшилнэ. Өвөл нарсан төгөл, мод сөөгт элсэн довцог, хоолойн зэгс, шугуйд нутаглана [2,4,7].

**Амьдралын онцлог:** Ороо нийлэгт IX сарын сүүлээр орж, V сарын эцсээр 1-2 ходол төрүүлнэ. Орооны үед мэнж 1-2 сүндэс дагадаг. Орооноос бусад үед мэнж ганцаар явна. Сүндэс, ходол, залуу эр, эм 6 бодгаль хүртэл толгойгоор сүрэглэсэн байдаг. Улирлаар нутаг бэлчээрээ ойр зуур сэлгэнэ. Зун мараанд ирнэ.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Манай оронд 1970-аад онд Нөмрөг гол, Соёлз уул хавьд 1000 га талбайд 3-4 толгой байснаа, 1990-ээд оны эхээр нийт тархац нутагтаа 70-80 толгой орчим байв [4,8]. Нөмрөгийн дархан газарт 2004 онд 73 бодгаль байсан [1]. Байршил нутаг, тэжээлээр халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахайтай давхцана. Чоно төл, залуу хандгайг барьж идэхээс гадна, ялангуяа цас ихтэй өвөл бие гүйцсэн эр, эмийг хорооно. Хулгайгаар агнадаг [5-9]. Тоо толгой өсөхгүй байгаагийн шалтгаан тодорхойгүй. Устах аюулд орсон зүйл.


**Хамгаалсан байдал:** 1953 оноос агнахыг хуулиар хориглож, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн. Монгол улсын улаан ном /1987, 1997/-нд оруулсан. Тархац нутгийг Нөмрөгийн дархан цаазат газарт хамруулсан [5,7,9].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, тархац, тоо толгойд нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралтад оруулах, хууль бус агналтыг таслан зогсоох хяналтыг сайжруулж, сэргээн нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Clark нар, 2006, 2. Гептнернар 1961, 3. Шагдарсүрэн, 1969, 4.

Шагдарсүрэн нар, 1974, 5. Засгийн газрын тогтоол, 2012, 6. Намнандорж, 1976, 7. Шийрэвдамба нар, 1997, 8. Цэвээнмядаг, Мөнхсайхан, 1993, 9. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994.

## 26. ГОЗООРОЙ ЗУРАМ



*Spermophilus alaschanicus* Buchner, 1988

**Баг.** Мэрэгчтэн - *Rodentia*

**Овог.** Хэрэмийнхэн - *Sciuridae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Бие 230 мм, сүүл 76 мм урт [1,4,6]. Зоо нуруу, биеийн хажуу тал жигд цайвар, элсэн саарал, хэвэл цайвар зүстэй. Сүүлний дээд тал жигд цайвар, доод талын уг шаргал, дундаа бараавтар хүрэн, үзүүр хэсэгтээ цайвар. Хойт хөлийн тавхай үсэрхэг.

**Тархац, байршил нутаг:** Үндсэн тархац нутаг Хятадын Алашаа, Зүүн Нань Шан тархана [4,6]. Говь Алтайн Их, Бага богд, Арц богд, Гурван сайхан уулс, Нууруудын хөндийн Өшиг ууланд тархжээ [1-6]. 2007 онд Их Богд уулаас гозоорой зурам барьж, генетикийн судалгааны дээж материал цуглуулсан бөгөөд 2010 онд Гурван сайханы нуруунд тэмдэглэсэн [5]. Тархацын хамгийн хойд зах Говь Алтай болно. Уулсын хялгана, таана, ерхөг, харгана, бүйлс бүхий бэлээс 3200 м-ийн өндөр хяр зооны бушилзат нуга хүртэлх хээрт нутаглана [1].

**Амьдралын онцлог:** Ганц нэгээр голдуу нэг амсартай олон салаагүй нүхэнд орогноно. Өвөл ичээлнэ. Таана, үетэн, шаваг оролцсон шүүслэг ургамлаар идэшлэхээс гадна шавж цох иднэ. Биологи, экологийн нарийвчилсан судалгаа хийгдээгүй.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Бүргэд, сар, үнэг, хярс, өмхий хүрнэ зэрэг махан идэшт шувуу, хөхтөнд бариулна. Тархац нутгийг хамарсан хуурайшил үржил, тоо толгойд сөргөөр нөлөөлөх магадлалтай [5]. Устах аюулд орсон зүйл.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэгдсэн. Байршил нутаг болох Говь Гурван сайхныг байгалийн цогцолбор газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологи, экологи онцлогийг судалж, хамгаалах, арга боловсруулах, хэвийн өсч, үржих нөхцлийг бүрдүүлэх, тэжээврээр өсгөн үржүүлж, зарим нутагт сэргээн нутагшуулах, арга хэмжээ авах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Дуламцэрэн, 1970, 3. Nickt нар, 1972, 4. Соколов нар, 1980. 5. Брандлер нар, 2011, 6. Соколов нар, 1996.

## 27. ОЙН УНГААХАЙ



*Dryomys nitedula* Pallas, 1778

**Баг.** Мэрэгчтэн - *Rodentia*

**Овог.** Унтаахайнхан - *Gliridae* (*Myoxidae*)

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Бие 127 мм, сүүл 110 мм урт, биеийн жин 59 гр хүрнэ. Эмэгчин эрээсээ биеэр бага. Нуруу хүрэн шаргал боловч ар зоогоороо арай бараавтар. Сүвээ шаргалдуу байснаа хэвэл цайвар шаргал зүсэд аажмаар шилжинэ. Сүүл битүү үстэй, үзүүртээ цацаг үстэй. Нүдийг

дайрсан бараан судалтай.

**Тархац, байршил нутаг:** Европ, Кавказ, Дундад Азийн уулын ой, Казахстаны өмнө хэсгээр тархжээ [2]. Тархацын хамгийн зүүн сэжүүр болох Монгол Алтайн өвөр Булган голын адагт тохиолдоно. Бөхмөрөн голын шугуйд байдаг гэсэн мэдээ бий [1]. Анх 1973 оны V сард Булган голын улсын хилээс дотогш 5 км орчимд тэмдэглэжээ. Навчит ойд голлон амьдардаг боловч ойгүй, сөөгтэй газарт тохиолддог [5,9].

**Амьдралын онцлог:** Модны 4 м орчим өндөрт мал, амьтны үс, ноос, ургамлаар зассан хурилд орогнодог. V сарын эх хүртэл ичдэг мэдээ бий [6]. VI сараас үүрээ барьж, VIII сар дуустал тэндээ амьдарна. Ичээний үүр, ноохойн талаар мэдээ байхгүй. Ичээнээс гарсны дараа ороо хөөцөлдөөн эхэлнэ. Жилд нэг удаа үржилд орж, VI сарын дундуур 3-8 зулзага төрүүлнэ [6]. Шөнийн идэвхтэй боловч, орооны үед өдөр гүйлдэнэ. Идэш тэжээлд ургамлын гаралтай зүйл зонхилно. Зуны улиралд шавжны эзлэх хувь нэмэгдэх ба тэжээлийн үлдэгдлээс шувууны зэм олдож байв [4]. V сард голдуу азарган унтаахай баригддаг. Судалгаанд хамрагдсан унтаахайн 1/3 хоёр удаа өвөлжсөн, үлдсэн хэсэг нь нэг удаа өвөлжсөн байх бөгөөд хоёр өвөлжсөн 32 бодгалийн 6 нь гурван удаа өвөлжсөнийг шүдний элэгдлээр тогтоожээ [6]. Сүргийн насны бүтцээс үзэхэд, гурав хүртэл наслана.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Дэлхийд өргөн тархацтай боловч, монголд цөөн тоогоор тохиолдоно. Хавар, зуны үржлийн үетэй уулын цасны үер давхцаж, голын татам усанд автагдсанаас хорогдоно. 1973 онд цөөн байснаа, 1974, 1975 онд нэлээд элбэг болж, 1984, 1985 оны зуны үерийн дараа ихээхэн хорогдсон байв. Эндээс үзэхэд, жил жилийн тоо толгой ихээхэн хэлбэлзэлтэй. Элбэгшсэн үедээ Булган голын татмын нэг га талбайд 20 толгой тохиолдож байв [4,6]. Бага шар булаг орчмын төгөлд 1988 онд хэд хэдэн хоосон үүр байв. Устах аюулд орсон зүйл.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэгдсэн. Тархац, нутгийг улсын тусгай хамгаалалттай нутгийн сүлжээнд бүрэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Булган голын тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, голын дагуух бургасыг огтлохыг зогсоож, амьдрах орчинг нөхөн сэргээж, хэвийн өсч үржих нөхцлийг бүрдүүлэх, тархац нутаг, нөөц, биологийн онцлогийг нарийвчлан судлах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1954, 2. Громов нар, 1981, 3. Даваа нар, 1982, 4. Дорж, 1981, 5. Соколов, 1989, 6. Штуббе нар, 1986, 7. Шагдарсүрэн, 1987, 8. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 9. Соколов нар, 1996,

28. ТӨВ АЗИЙН МИНЖ



*Castor fiber birulai* Serebrennikov, 1929

**Баг.** Мэрэгчтэн - Rodentia

**Овог.** Минжийнхэн - Castoridae

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Нас гүйцсэн минжийн бие 86 см, сүүл 29 см урт, жин 22.5 кг хүрнэ [17]. Бие лагс, нүд онигор, чих хулгар. Ерөнхий зүс халиун хүрэн. Сор үс урт, өтгөн, зөөлөн ноолууртай. Хойд хөлийн сарвуунуудын хооронд усанд сэлж шумбахад зохицсон сарьсан холбоос бий. Хойд мөчдийн хоёрдугаар хуруу давхар хумстай. Урд мөчдийн хуруунууд салангид, хөдөлгөөн сайтай, түүгээрээ идэш тэжээлийн зүйл барьж мэрнэ. Хайрсаар бүрхмэл хавтгай, дээд, голоороо тод хянга бүхий сүүлтэй. Сүүлээрээ ус балбаж, чимээ гарган бусаддаа дохио өгнө. Үүдэн шүд цүүц хэлбэртэй, улбар шар өнгөтэй.

**Тархац, байршил нутаг:** Дээр үед Европ, Азийн ойн бүсийн гол мөрөнд өргөн тархаж байжээ. XX зууны эхээр Хэнтийн нурууны Минж, Онон, Ерөө, Хөвсгөл, Хангайн зарим голд минж устаж, одоо Ховдын Булган голын дагуу хэсэгхэн нутагт ховор тохиолдоно [1-6,10,11,15]. Дашванжил уулаас улсын хил хүртэлх голын дагуу өчүүхэн зурваст минжийн уугуул популяци нутаглаж байна. Энд 26 бүл, 104-130 толгой минж байна [19]. Булган голын хамгийн тохиромжтой хэсэгт 1-1.5 км тутамд нэг бүл байршдаг. Өндөр эрэгтэй, эргийн дагуу мод, сөөг бүхий өтгөн шугуйтай, намуун урсгалтай, гүн устай гол, цөөрөм, нуурт амьдрахад илүү зохилдолгоотой.

**Амьдралын онцлог:** Голын гүн устай, өндөр эрэгтэй газар нүх ухаж овоохой засна. Нүхний ам усны гүнд байна. Нүхэнд агаар оруулах салхивч өрхтэй. Нэг бүлд эр, эмэгчин тухайн

жилийн үр төл хамт амьдарна. Эзэмшил нутгийнхаа захад шороо овоолон заараараа тэмдэг тавина. Үржлийн мэдээ ховор. V сард 5 удаагийн барилтаар нялх дүдэр (зулзага), хөхүүл эмэгчин тааралдаагүй, харин хээлтэй эмэгчин баригдаж байснаас үзвэл, VI сард төллөдөг бололтой. Булган голоос барьсан 71 минжний эр эмийн хүйсний харьцаа 1.3:1 байв. Тэдгээрийн насны бүтцийг гаргахад 1 настай 3, 2 настай 10, өсвөр насны 19, бие гүйцсэн 39 бодгаль байв [19]. Зулзаган минжийн эзлэх хувь харьцангуй бага байгааг үр төлийн хорогдол ихтэйгээр тайлбарлаж болно. Усны татуурга, салааг боож, түвшинг нэмэгдүүлэхийн тулд мод шавраар далан барина. Бургасны залуу мөчрийг богинохон тайрч эргийн тэжээл нөөцлөх нүхэнд хадгалахын зэрэгцээ өвөлжих нүхний ойролцоо гүн устай хэсэгт модыг уртаар нь эргийн дагуу хурааж, мөс хөлдсөн үед ирж, түүнийгээ авна. Үүдэн шүдний араар уруулын арьснаас хаалт үүсдэг учир усан дотор байх үедээ ч мод мэрэх чадвартай. Булган голын минжний шүдийг зүсэж насыг нь тодорхойлоход хамгийн хөгшин нь 17-18 настай байв [17]. Булган голын минжнээс *Travassosius americanus* зүйлийн хорхой, *Schizocarpus latus* Dubina, 1964 хэмээх хэдгэнийн гуур олджээ [17]. Нүдний гэмтэлтэй минж цөөнгүй тохиолддог.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тархац нутгийг тэлэх, зориудаар өсгөн үржүүлэх зорилгоор Монгол-Германы хамтарсан экспедици 1973 оноос эхлэн иж бүрэн судалгаа явуулж, 1974-1975 онуудад 24, 1978 онд 10, 1988 онд 1 минжийг Ховд голд, 1985 онд 10, 1989 онд 19 минж Тэс голд нутагшуулснаар, баруун монголын дотоодын урсгалтай усны ай савд хамаарах 2 гол минжтэй болов [17,19]. Сүүлийн үеийн судалгаагаар, нутагшсан минжийн тоо толгой Ховд голд 230-250 орчим, Тэсийн голд 70-75 хүрчээ [19, 26]. Булган, Ховд, Тэс голын дагуу өвөл, хаврын улиралд айл олноор нутагладаг, голын бургасан шугуй хүн малын шууд болон дамын нөлөөнд өртөж, нөхөн төлжилт зогсонги байдалд орсноос тархац хумигдаж, тоо толгой эрс цөөрөв. Өвөл, хаврын хачир ус, хэвтрийг эзэлж, орогнох газаргүй болгосон тохиолдол Ховд голын цагаан аралд ажиглагдсан. Хавар уулын цасны үер минжийн үржлийн үетэй давхцаж төлийн хорогдолд нөлөөлдөг. Зулзагыг нохой, үнэг, шар шувуу, бүргэд барина [1,18,19]. Устах аюулд орсон зүйл.


**Хамгаалсан байдал:** 1930-аад оноос агнахыг хуулиар хориглож, амьтны тухай хуулиар нэн ховор амьтнаар оруулсан. 1965 онд Булган гол дахь үндсэн тархац нутгийг дархан цаазтай газар болгож, Монгол улсын улаан номд оруулжээ [12,20,21,24]. Минж нутагшуулах Монгол-Германы хамтарсан экспедици 1974, 1975, 1978, 1985, 1988 онд нийт 64 минжийг Ховд, Тэс голуудад нутагшуулснаар, тогтвортой популяци бий болгожээ [13,16,17,19]. Монгол оронд минж сэргээн нутагшуулах ажлыг 2010 онд эхлүүлж, ХБНГУ, ОХУ-аас 30 орчим толгой минжийг зөөвөрлөн авчирч Туул голын эхэнд нутагшуулахаар тавьжээ.

**Хамгаалах арга хэмжээ:** Булган, Ховд, Тэс голын бургасыг их хэмжээгээр огтлохыг зогсоох, хүн, малын үйл ажиллагааг хязгаарлах, тархац болон шинээр нутагшуулсан нутагт нөөцийн судалгаа хийх, зориудаар өсгөн үржүүлэх ажлыг үргэлжлүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дашдорж, 1948, 2. Скалон, 1951, 3. Банников, 1954, 4. Эрэгдэндагва, 1958, 5. Дашдорж, 1959, 6. Банзрагч, 1961, 7. Данзан, 1962, 8. Пихокки, 1967, 9. Штуббе нар, 1981, 10. Цэвэгмид нар, 1973, 11. Даваа нар, 1974, 12. БНМАУ-ын ан агнуурын хууль, 1975,

13. Лхамсүрэн, 1975, 14. Даваа нар, 1976, 15. Намнандорж, 1976, 16. Штуббе нар, 1981, 17. Штуббе нар, 1983, 18. Соколов, 1986, 19. Минж нутагшуулах ажлын тайлан, 1990, 1992, 20. Шийрэвдамба нар, 1997, 21. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, 1994, 22. Красная книга ОСТСО, 1983, 23. CITES 1991, 24. Соколов нар, 1992, 25. Дангаасүрэн, 2010, 26. Самъяа нар, 2012.

## 29. ДАВЖАА АЛАГДААГА



*Allactaga elater* Lichtenstein, 1825

**Баг.** Мэрэгчтэн – Rodentia

**Овог.** Алагдаагынхан – Dipodidae

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Алагдааганы төрөл дотроо хамгийн жижиг зүйл. Биеийн урт 108-134 мм, сүүлний урт 154-183 мм, хойд тавхайн урт 53-65 мм, чихний урт 34-39 мм, жин нь 43-74 г. Зүс нуруу болон толгойн хэсэгтээ бор шаргал, зэгэл алагдааганцар, Өмнөговийн алагдааганаас илүүтэй цайвар. Биеийн хажуу болон дээд хэсгээр хурц зосон шаргал өнгө зонхилдог. Гол нуруу бараантаж харагддаг. Үс уг хэсгээрээ үнсэн саарал, дунд хэсэгтээ бор шаргал, үзүүр бараан. Чихний ард жижиг цагаан толботой, харин гуян дээгүүрээ хөндлөн цагаан судлуудтай. Гуяны доод хэсэг цайвар шаргал. Хоолой, цээж, хэвэл дун цагаан. Сүүлний гол нурууныхаасаа илүү цайвар. Сүүлний туг дээд талаас гурван өнгөтэй: цайвар шаргал судлаар эхлэх бөгөөд дунд хэсэгтээ хар, харин төгсгөлийн хэсэг цагаан бөгөөд дунд хэсгээсээ илүү богино. Доод тал үргэлжилсэн бараан байна.

**Тархац, байршил нутаг:** Өргөн тархалттай, баруун талдаа Турк, Кавказийн уулсаас Дундад Ази, Казахстангаар дамжин Баруун хойд Хятад, Монголын баруун өмнөд хэсэгт зүүн үзүүр нь хүрнэ. Өмнөд хэсэгтээ Иран, Афганистан, Пакистан, хойд хэсэгтээ Оросын холбооны улсын нутаг зүйлийн тархалтад хамаарна. Монголд Зүүн гарын говийн Бодончийн гол, Хонин усны говьд тэмдэглэгдсэн [5].

**Амьдралын онцлог:** Цөл болон заримдаг цөлийн бүсэд заг, зээргэнэ, харгана ургасан наанги шаварлаг хөрст чулуурхаг цөлд тархана. Үргэлжилсэн их элс болон ургамалгүй шал, тойрмоос зайлсхийнэ. Нэг амсартай нүхний урт 1-1.5 м, өдрийн цагаар нүхээ бөглөдөг. Ургамлын ногоон хэсэг, үр болон сонгинолог булцуугаар хооллоно. Жилд 1-2 удаа төллөж, нэг төрөхдөө 2-8 зулзага гаргадаг [1-2,5].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Булаг шандны ширгэлт, ган гачиг, энэ зүйлийн хорогдлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүүтэй тусдагийг хараахан тогтоогоогүй байна [4]. Устах аюулд орсон зүйл.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн. Тархац нутгийн 54 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамаарна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хэвийн өсч үржих нөхцлийг бүрдүүлэх, амьдрах орчныг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дуламцэрэн, 1970, 2. Соколов нар, 1980, 3. Цэвэгмид нар, 1988, 4. Clark нар, 2006, 5. Соколов нар, 1998.

## 30. ЭЛСНИЙ ТАЖИГДААХАЙ



*Salpingotus kozlovi* Vinogradov, 1922



**Баг. Мэрэгчтэн - Rodentia**

**Овог. Алагдаагынхан - Dipodidae**

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг”, олон улсын хэмжээнд “ховордож болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Жижигхэн алагдаага. Бие 5.7 см, сүүл 12.6 см урт, жин 12.5 г хүрнэ [3,4]. Харьцангуй том толгойтой, богинохон мохоодуу хоншоортой. Чих хув, гуурс шиг дугуй, сахал урт. Хойд мөчид 3 хуруутай. Зоо нуруу, биеийн хажуу шаргал, элсэн саарал, хэвэл шаргалдуу цагаан цайвар. Сүүлний угаас үзүүр хүртэл богино үсэн дотроос тод ялгарсан сийрэгхэн урт үсүүд бий [1-4].

**Тархац, байршил нутаг:** Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн зарим нутгаар алаг цоогхон тархана [2-5]. Говь цөлийн ургамалжсан элсэн дов сондуул, манхан бөөргүүдэд нутаглана. [1,2,4].

**Амьдралын онцлог:** Судлаагүй. Ургамлын үр, шавжаар идэшлэнэ. Өвөл ичээлнэ. Шөнийн гүйдэл хөдөлгөөнтэй.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Сар, шонхор, бэгбатар, ууль зэрэг шувуу, үнэг, өмхий хүрнэ, эрээн хүрнэ, үен зэрэг амьтан идэж хорооно. Элс нурж нүхийг дарж үхүүлдэг байж болзошгүй. Шөнө машины гэрэлд орж дайруулна. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын улаан номд оруулж, тархац нутгийг Говийн их болон Бага говийн дархан газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулан хэрэгжүүлэх, хэвийн өсч үржих нөхцлийг бүрдүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Виноградов, 1937, 2. Банников, 1954, 3. Дуламцэрэн, 1970, 4. Соколов нар, 1980, 5. Шагдарсүрэн нар, 1987. 6, Адъяа нар, 2011, 7. Шийрэвдамба нар, 1997, 8. Clark нар, 2006.

31. СООТОН АЛАГДАЙ



*Euchoreutes naso* Sclater, 1890

**Баг.** Мэрэгчтэн - *Rodentia*

**Овог.** Алагдаагынхан – *Dipodidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгджээ [1].

**Таних шинж:** Урт чихтэй, жижигхэн алагдаага. Бие 9 см, сүүл 16.5 см урт. Биеийн жин 23-45 г. Чихний урт, биеийн уртын хагастай бараг тэнцүү. Уртавгар шөмбөгөрдүү хоншоортой. Хойд мөчид таван хуруутай. Сүүлний үзүүрийн цацаг үсний уг болон үзүүр цагаан, дунд хэсэг бараан өнгөтэй. Зоо нуруу сүвээгээрээ бор саарал, хондлойруугаа арай улаавтар, хэвэл цагаан [2]. Хойд мөчид 5 хуруутай. Толгойн ясны суурин хэсгийн урт (кондилобазаль) 26-28 мм, шанааны өргөн 14.5 - 17.3 мм. Шүдний томъёо: Үүдэн шүд 1/1; соёо 0/0; бага араа 0-1/0; их араа 3/3=18. [3]

**Тархац, байршил нутаг:** Алтайн өвөр говьд тааралдана. Монгол улсын өмнөд нутаг энэ зүйл алагдааганы дэлхийн тархацын умард хил болно [1]. Бударгана, харганат элсэрхэг цөл, захын ургамал бүхий сэвсгэр хөрстэй газар, сухайн бутны хавь, сул элстэй загт хотгорт тохиолдоно [2].

**Амьдралын онцлог:** Харанхуй, бүрэнхийд идшээ олно. Өвөл ичээлнэ. Нүх ухаж орогноно. Жилд нэг удаа төрж 2-6 зулзага төрүүлнэ [3], III сард хөхүүл эмэгчин тохиолдож байв. Хоёр бодгалийн ходоодыг шинжлэхэд цох, түүний авгалдайнаас өөр тэжээл гараагүйгээс үзэхэд хоол тэжээлийн бүрдэлд шавж зонхилдог [5]. Соотон алагдаага 2-14 га нутгийг эзэмшин амьдарна [6]. Борзонгийн говийн соотон алагдаага  $12.7 \pm 3.2$  га эзэмшил талбайд идээшин амьдардаг бөгөөд нас бие гүйцсэн эр соотон алагдаага эмээсээ илүү уудам орон зайд тархдаг байна [7].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Зуун модны Баянбүрдэд 200 занганд хоногт 3 баригдаж, автомашины гэрэлд Хатан суудал уулын орчимд шөнө 46 км замналд 5, Зам билгэхийн говьд 50 км замналд 6 тоологдов [5]. Байршил нутаг шар чичүүл, савгадаахай, элсний шишүүхэйтэй давхцана [8]. Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхагдлаас үүдэлтэй орчны доройтол нүүрлэж болзошгүй. Булаг шандны ширгэлт, ган энэ зүйлийн ховордлын шалтгаан болох хэдий ч байгаль орчны өөрчлөлт эсвэл хүний үйл ажиллагааны алиных нь үр дагавар илүү нөлөөтэй болохыг тогтоогоогүй [1]. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын ховор амьтны хавсралтад болон Монгол улсын улаан номонд бүртгэгдэж, байршил нутгийн зарим хэсгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан [2,9]. Тархац нутгийн 44 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагддаг [1].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой биологийг судалж, хэвийн өсч үржих нөхцлийг бүрдүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Clark нар, 2006, 2. Шагдарсүрэн нар, 1987, 3. Батсайхан, 2006, 4. Виноградов, 1937, 5. Соколов нар, 1996, 6. Stubbe et all, 2007, 7. Ууганбадрах, 2010, 8. Банников, 1954, 9. Шийрэвдамба нар, 1997.

## 32. ЗҮҮНГАР ДААХАЙ



*Stylodipus sungorus* Sokolov and Shenbrot, 1987

**Баг.** Мэрэгчтэн – Rodentia

**Овог.** Алагдаагынхан – Dipodidae

**Статус:** Нэн ховор, унаган зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын

хэмжээнд “устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Бие 90-125 мм, сүүл 130-165 мм. Хойд тавхайн урт 54-58 мм, биеийн жин 85-90 г. Хоншоор богинохон. Чих жижиг, дугуй хэлбэртэй. Зүс нуруун хэсгээрээ элсэрхэг саарал. Сүүлний үзүүрийн үс бараан. Хойд мөч 3 хуруутай, тавхайн дотор төв хэсэг нүцгэн, хуруу болон түүний хажуу тал сийрэг үстэй [2,5,6].

**Тархац, байршил нутаг:** Аж богдоос баруун тийш Алтайн өвөр говийн Зүүнгарын хэсэг буюу Баруун хуурайн хотост тархжээ. [1-4].

**Амьдралын онцлог:** Говийн элсэрхэг болон шаварлаг хөрсөнд нэлээд гүн нүхэнд амьдарна. Зун намрын улиралд үрээр хооллоно. Жилд нэг удаа төрөхдөө 3-6 зулзага гаргана. Өвөл ичээлнэ [1-3].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхигдал бий болж, амьдрах орчны доройтол нүүрлэж болзошгүй [4]. Цөлжилт, хуурайшилт, олон жилийн гангийн давтагдал зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр тоо толгой хомдсон. Устах аюулд орсон, унаган зүйл.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн. Тархац нутгийн 41 орчим хувь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах үндэслэлийг боловсруулж, хамгаалалтыг сайжруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дуламцэрэн, 1970, 2. Соколов нар, 1980, 3. Цэвэгмид нар, 1988, 4. Clark нар, 2006, 5. Соколов нар, 1998.

### 33. СУХАЙН ЧИЧҮҮЛ



*Meriones tamariscinus* Pallas, 1773

**Баг. Мэрэгчтэн - Rodentia**

**Овог. Чичүүлийнхэн - gerbillidae**

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй”, олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй” хэмээн үнэлэгдсэн,

**Таних шинж:** Бие 185 мм, сүүл 156 мм урт, жин 150 г [1,3] хүрнэ. Зоо, нуруу сүвээ бөөр сүүлний дээд тал улаавтар хул хонгор, хэвэл сүүлний доод тал тод цагаан. Сүүлний үзүүрийн хялгас багир хүрэн. Хөмсөгний дээд талд тод цагаан толботой [1].

**Тархац, байршил нутаг:** Монголын Зүүнгарын говьд Булган голын адаг, Ёлхон, Тахийн ус, зүүнээ Мянганаас олджээ [1-4]. Голын татам, баян бүрд, хужир мараат хонхор, хотосын сухайн ширэнгэ бургас, харгана, заг мод буттай элсэн довцог, жижиг манханд идээшинэ. Бутан доогуур олон амсартай салаалсан гүн нүх малтаж орогноно. Зүйлийн дэлхэцийн хамгийн зүүн зах болох манай Зүүн гарын говийн сухай бага талбайтайгаас тоо толгой цөөн юм.

**Амьдралын онцлог:** Жилд гурав хүртэл төллөх бүрдээ 5 хүртэл бөлбөөхэй гаргана. Зүүнгарын говьд V сарын эхээр ороо хөөцөөнд ордог [1]. Ургамлын үр, навч иш, сөөгний холтос, өвслөг ургамлаар идэшлэнэ [1-3]. Бусад оронд элбэг газраа үе үе олширч, таримал ургамлын “хортон” болж зарим өвчний халдвар хадгалж, дамжуулдаг [3].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нэг үлийд 10-20 бодгаль амьдардаг. Голын татам, баян бүрд хужир мараат хонхор хотосын сөөгт элсэн довцог жижиг манханд хавар, өвөл мал олноор бөөгнөрөн хоргодож бэлчихдээ заг, харгана, бургасыг шөргөөж сухайн бутыг гишгэчиж, хүн түлш бусад хэрэгцээндээ хугачих, ашиглах зулзаган мөчир найлзуурыг идэх зэргээр доройтуулж, орчныг нь доройтуулж тоо толгойг хорогдуулна. Шөнийн махчин шувууд барьж иднэ. Устах аюулд орсон зүйл.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн. Тархац нутаг нь Говийн их дархан цаазат газарт бүрэн хамаардаг.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, амьдрах орчны хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дуламцэрэн, 1969, 2. Дуламцэрэн, 1970, 3. Соколов нар, 1980, 4. Самъяа нар, 1993. 5. Wilson нар, 2005.

## АШИГЛАСАН БҮТЭЭЛ

- 1.
2. Авирмэд Д. Булган сумын зарим хөхтөн амьтны тухай тэмдэглэл. Биол. хүр. бүт. 1972. №6.

3. Авирмэд Д. Монгол орны атигдаахайн тархацын тухай шинэ мэдээ. ШУА-ийн мэдээ. 1973. №3.
4. Адъяа Я., Амгалан Л., Мөнхбаатар М., Шар С., Сүхчулуун Г., Батдорж С., Төмөрсүх Ж., Амаржаргал. 2013. Монгол орны буган цааны (*Rangifer tarandus*, linn 1758) өнөөгийн байдал, хамгааллын менежментийн асуудалд. Биологийн хүрээлэнгийн бүтээл. №29.
5. Адъяа Я., Дуламцэрэн С., Цогтжаргал Г. Говийн бага дархан цаазат газрын “А” хэсгийн хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн, хамгааллын статус. Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 128. 2011. х.105-108.
6. Амгалан Л. Охрана и био-экологические особенности джейрана (*Gazzella subgutturosa*). Автореферат канд.биол.наук. УБ. 2000. 26с.
7. Амгалан Л., Бүүвэйбаатар Б., Чимэддорж Б., 2008. Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*)-гийн тархац, тоо толгойн өнөөгийн байдал. Биол.хүр.бүт. №27. х.4-6.
8. Амгалан Л., Довчиндорж Г., Туяа Ц., Реинолдс Х., Мижиддорж Б. 2006. Мазаалай баавгайн биологи,экологийн зарим онцлог. Биол. хүр.бүт. 126.31-34.
9. Амгаланбаатар С., Рийденг Р.П., Дуламцэрэн С., Онон Ё., Түмэнцэцэг Ш., Батсүх Н. Монгол орны аргаль хонины тархцыг газар зүйн мэдээллийг ашиглан үнэлсэн дүн // ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн бүтээл 2002. № 24. х.26-32
10. Амгалан Л. Зүүнгарын говьд хар сүүлт зээр байршин сүрэглэх онцлог. Ерөн. сорил. биол хүр. бүт. 1984. №19.
11. Амгалан Л. Монгол орны хар сүүлт зээрийн тархац, тоо толгойн хэлбэлзлэл. \*Биологи-30\* эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн хураангуй. УБ., 1995.
12. Амарсанаа Г. Улаан ном, цоохор ирвэс. Үнэн сонин. 1983. №237.
13. Амарсанаа Г. Бурхан буудай уулан дахь ирвэсний (*Uncia uncia*) өвлийн идэш тэжээлийн тухай зарим мэдээ. Ерөн. сорил. биол. хүр. бүт. 1985. №20.
14. Амарсанаа Г. Алтайн нурууны ирвэсний өвчин, Үхэл хорогдлын тухай зарим мэдээ. Ерөн. сорил. биол хүр. бүт. 1986. №21.
15. Ариунболд Ж. Монгол орны сарьсан жигүүртний зүйлийн бүрэлдэхүүн, тархац, экологийн зарим асуудал. Магистрын ажил. Улаанбаатар, (2002).
16. Ариунболд Ж. Монгол орны сармаахай (*Vespertilio Linnaeus*, 1758)-н тархац, биологи, экологийн зарим асуудал. МУБИС-ийн биологийн тэнхмийн эрдэм шинжилгээний бичиг. № 4. Улаанбаатар, (2005).
17. Ариунболд Ж., Мөнхбаатар М., Нандин-Эрдэнэ Н., Мөнхнаст Д. Монгол орны дорнын сармаахай (*Vespertilio sinensis Peters*, 1880)-н тархац, биологи, экологи, хамгааллын зарим асуудал. МУБИС-ийн БУС-ийн эрдэм шинжилгээний бичиг. № 3. Улаанбаатар, (2011) х.7-13.
18. Бадамханд Ж. Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa Guld*) төллөх хугацаа, амьдрахуйн зарим онцлог. Ерөн. сорил. биол хүр. бүт. 1984. №19.
19. 18. Бадамханд Ж. Мазаалай. Үнэн сонин. 1988. №242
20. Бадамханд Ж., Тулгат Р. Говь-Алтайн агнуурын амьтад. Алтай хот. 1990.
21. Базардорж Д., Сүхбат Х. Хөвсгөл аймгийн ан амьтан, агнуурын аж ахуй. Мөрөн. 1984.
22. Байгаль орчны хуулийн эмхэтгэл, 2012, 363х.
23. Банзрагч Д. Булган голын минж. ШУА- ийн мэдээ. 1961 №1, 3.
24. Банников А.Г. Млекопитающие Монгольской Народной Республики. Тр. Монгольской

комиссии. 1954. Вып.53.

25. Банников А.Г. Дикий верблюд - хавтгай. Журн. Природа, 1975. №2.
26. Банников А.Г. Численность кулана в Заалтайской гоби. Журн.Природа. 1975. №6.
27. Банников А.Г., Жирнов Л.В., Лебедева Л.С., Фандеев А.А. Биология сайгака. М.,1961.
28. Батсайхан Н., Самъяа Р., Шар С., Кинг С.Р. Монгол орны хөхтөн амьтад. Таних гарын авлага. 2010. 306х.
29. 28. Батсайхан Н., Ариунболд Ж., Хауэр З., Наранцацралт Б., Чинбат Ч., Ганхуяг Б. Онон Балжийн БЦГ-ын голын халиу (*Lutra lutra* Linnaeus, 1758) –ны тархацын шинэ нутаг // Онон голын сав газар дахь байгаль орчин, тогтвортой хөгжил сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд// УБ., 2008. 45х.
30. БНМАУ-ын ан агнуурын хууль. УБ.,1975.
31. Бобринский Н.А., Кузнецов Б.А., Кузякин А.П. Определитель млекопитающих СССР. М., 1965.
32. Болд А. Монгол орны хүрэн баавгай ба мазаалай баавгай. Биологийн хүрээлэнгийн бүтээл. 1967. №2.
33. Болд А., Цэвэгжав Т. Тахийн тухай дахин өгүүлэх нь. Байгал. ухаан. хүр. бүт. 1963. №1.
34. Болд А., Доржзундуй С. Говийн Алтайн нурууны өмнөд хэсгийн ирвэсний (*Uncia uncia* Schreber) тухай. Ерөн. сорил. биол хүр. бүт. 1976. №11.
35. Болд А., Дуламцэрэн С. БНМАУ-ын нутагт байгаа ховор ба ховордсон хөхтөн амьтад, шувууд. Ерөн. сорил. биол хүр. бүт. 1975. №10.
36. Болд А., Даш Я., Лхамсүрэн П. Ховд аймагт цаг зуурын бэрхшээлийн улмаас ан амьтан үхэж хорогдсон байдлыг шалгасан ажлын тайлан. (хавсралт 4 хүснэгт,7 гэрэл зурагтай) гар бичмэл. УБ., 1984.
37. Бөхөн хамгаалах олон улсын хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2010 9 сар.
38. Брандлер О.В., Сухчулуун Г., Капустина С.Ю., Адъяа Я. Современное состояние популяций бледнохвостого (*spermophilus pallidicauda*) и алашанского (*s. Alaschanicus*) сусликов в Монголии // Териофауна России и сопредельных территорий. Международное совещание (IX Съезд Териологического общества при РАН). М.: Товарищество научных изданий КМК. 2011. С.77.
39. Бугаев К.Е., Төмөр Ч. Мазаалай. Ерөн. сорил. биол. хүр. бүт. 1986. №17.
40. Виноградов Б.С., Тушканчики. Фауна СССР. М., Изд-во: АН СССР. 1937. Вып 4.
41. Гептнер В.Г., Наумов Н.П., Юргенсон П.Б., Слудский А.А., Чиркова А.Ф., Банников А.Г. Млекопитающие Советского Союза. М.,1967. т.2. часть I. Морские коровы и хищные.
42. Гептнер В.Г. О диком верблюде на территории СССР. Зоол. журн. 1966. т.15. вып.1.
43. Гептнер В.Г., Насимович А.А., Банников А.Г. Млекопитающие Советского Союза. М.,1961. т.1.
44. Гептнер В.Г., Слудский А.А. Млекопитающие Советского Союза.М.,1972. т.2. часть.2. Хищные (Гиены и кошки).
45. Громов И.М., Гуреев А.А., Новиков Г.А., Соколов И.И., Стрелков П.П., Чапский К.К. Млекопитающие фауны СССР. М-Л., 1963. часть.1.
46. Громов И.М., Баранова И.Г. Каталог млекопитающих СССР.Л., 1981.
47. Грунин К.Я. Фауна СССР, Насекомые двукрылые. Подкожные овода. 1962. т. XIX. вып. 4.
48. Даваа Н., Штуббе М., Доржраа О. Ондатра (*Ondatra zibethica* L.,1758) МНР. Тезисы

докладов международной конференции посвященной исследованиям природных условий и ресурсов МНР. УБ. 1976.

49. Даваа Н., Штуббе М. Минж нутагшуулав. Үнэн сонин. 1974. №.172.
50. Даваа Н., Штуббе М., Батхуяг Ч., Дорж С. Лесная соня реки Булган гол. Природные условия и ресурсы МНР. (тезисы докладов к конференции). УБ., 1982.
51. Дамдин Ж. Буурал анчны тэмдэглэл. УБ., 1963.
52. Дамдин Ж. Минжийг хамгаалья. Үнэн сонин. 1964. №.92.
53. Дамдин Т. Ан гөрөөс, ой мод, ард нийтийн хөрөнгө. Үнэн сонин. 1965. №.10.
54. Дангаасүрэн Ч. Булган голын минж. Улаанбаатар, 24х.
55. Данзан Г. К изучению гельминтофауны некоторых видов домашних и диких животных МНР. Тезисы докладов конференции. ВОГ АН СССР, часть I.
56. Даш Я. Экологические предпосылки охраны редких хищников гобийской части Монголии. Экологические основы охраны и рационального использования хищных млекопитающих. Материалы Всесоюзного совещания. М., 1979.
57. Даш Я., Төмөр Ч. 1983. Монгол орны ховор, ховордсон зарим амьтдын тухай тэмдэглэл. ШУА сэтгүүл. 1979. №.3.
58. Дашдорж А. О находке бобра в Монголии. Докл. АН. СССР. 1948. т.IX. №.6.
59. Дашдорж А. Булган голын минж. Шинжлэх ухаан техник. 1959. №.4.
60. Довчин Н. БНМАУ-ын нутагт тахийг судалсан түүх, одоогийн байдал. Биол. хүр. бүт. 1969. №.4.
61. Довчин Н. Новейшие данные о тахи-лошадь Пржевальского (*Equus przewalskii* Poliakov, 1881). Труды IX международного конгресса биологов и охотоведов. М., 1970.
62. Дорж С. Булган голын ойн унтаахай ба сохдой оготны биологийн судалгаа, МУИС. Биологийн тэнхим. Дипломын ажил. 1981.
63. Дорждэрэм, С. Монгол орны сарьсан багваахай (*Chiroptera: Vespertilionidae*) газар зүйн мужаар тархах төлөв байдал. Бакалаврын дипломын ажил. Улаанбаатар. . (2004).
64. Доржраа О. Тэмээн гөрөөс-хавтгайн тухай. «Баруун монгол түүний хил залгаа нутгийн байгалын нөхцөл биологийн нөөц баялаг» эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн хураангуй. УБ.,1993.
65. Доржраа О. Атигдаахай (*Cardiocranius paradoxus* Satunin) тархацын шинэ цэг. Ерөн. сорил. биол. хүр. бүт. 1977. №.11.
66. Дуламцэрэн С. Зэгсний гахайг хамгаалья. Хөдөлмөр сонин. 1968. №12.
67. Дуламцэрэн С. Монгол орны хөхтөн амьтан тодорхойлох бичиг. УБ., 1970.
68. Дуламцэрэн С. Монгол орны цөөвөр чонын (*Cion alpinus* Pallas,1811) тухай тэмдэглэл. ШУА-ийн мэдээ. 1972. №.4.
69. Дуламцэрэн С. Хэнтий, Хангайн ойн туурайтан амьтны экологи, агнуурын холбогдлын зарим асуудал. УБ., 1977. Диссертацийн хураангуй.
70. Дуламцэрэн С. Зэгсний гахайн нутагшлыг анхаарья. Үнэн сонин. 1982. №101.
71. Дуламцэрэн С. Хэнтий, Хангайн ойн туруутны экологи, агнуурын холбогдол. «БНМАУ-ын амьтны аймаг. Хөхтөн амьтан». Ред. О.Шагдарсүрэн.УБ. 1983.
72. Дуламцэрэн С., Амгалан Л. Шаргын говийн хар сүүлт зээрийн (*Gazella subgutturosa* Guld.) байршил, тоо толгойн байдал. Ерөн. сорил. биол. хүр. бүт. 1985. №20.
73. Дуламцэрэн С., Цэнджав Д. Монгол орны хөхтөн амьтан. БНМАУ-ын амьтны аймаг. УБ.,



1989. II.боть.

74. Дуламцэрэн С. Тахийн унага барьсан явдал байгаль дахь тахийн сүрэгт нөлөөлсөн үү. «Тахь төсөл» эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 1991. I.
75. Дуламцэрэн С. Цөөвөр чоно. Ардын эрх сонин. 1992. №141.
76. Дуламцэрэн С. Монгол бөхөн. Ардын эрх сонин. 1992. №27.
77. Дуламцэрэн С. Тахийн ойрмогхон үеийн ареалыг газар усны нэр баримжаалж тодруулах оролдлого. «Тахь төсөл» эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 1993. II.
78. Дуламцэрэн С., Л.Амгалан. Монгол бөхөнгийн Манханы популяцийн одоогийн байдал, устахаас аврах арга зам. «Баруун монгол түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг» эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн хураангуй. Ховд. 1993.
79. Дуламцэрэн С., Тулгат Р. Монгол бөхөн, хавтгайн тархац, байршил, тоо толгойн одоогийн байдал, хамгаалах арга хэмжээний тухай. ЕСБХ-ийн эрдэм шинжилгээний тайлан. 1993.
80. Дуламцэрэн С., Амарсанаа Г., Тулгат Р. Монголын цоохондойн (*Felis lybica* Forster, 1786) тухай зарим мэдээ. «Говийн дархан газрын байгалын нөхцөл, биологийн нөөц баялаг» эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. 1995.
81. Дуламцэрэн, Алтайн өмнөд говийн шүлүүсний тухай зарим мэдээ. // Говийн их дархан цаазат газрын байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг товхимол, редактор Ж.Бадамханд. 1995, х. 29-33.
82. Дуламцэрэн С., Д. Ганбат. Хэнтийн нуруунд гарсан хүрэн баавгайн өлсгөлөн. Биологийн хүрээлэнгийн бүтээл. УБ 2000. №22.
83. Довчиндорж. Говийн их дархан цаазат газрын орчны бүсийн цоохондой мий. Бакалаврын ажил. Улаанбаатар. 2002.
84. Евроазийн шүлүүс, 2003. [http://www.felineconservation.org/feline\\_species/eurasian lynx.htm](http://www.felineconservation.org/feline_species/eurasian lynx.htm)
85. Жирнов Л.В. Сайгак. В книге «Копытные звери». М., 1977.
86. Жирнов Л.В, Гунин П.Д., Адъяа Я., Бажа С.Н. Стратегия сохранения копытных аридных зон Монголии. Москва, 2005. -323 с.: ил. (Биологич. Ресурсы и природные условия Монголии: Труды Совм. Рос.-Монг. Компл. Биол. экспедиции, Т.45)
87. Жирнов Л.В, Гунин П.Д., Адъяа Яд. Дикий двугорбый верблюд центральной Азии. Москва. 2011.
88. Жирнов Л.В., Ильинский В.О. Большой гобийский заповедник-убежище редких животных пустынь Центральной Азии. М., 1985.
89. Жирнов Л.В., Бугаев К.Е. Крупные млекопитающие Заалтайской гоби. «Комплексная характеристика пустынных экосистем Заалтайской гоби». Пушино., 1983.
90. Жизнь животных. Млекопитающие. под.ред.В.Е.Соколова. М., 1989. т.7.
91. Закон об охоте МНР. Журн. Хозяйство Монголии. 1930. №4.
92. Кожемякин В.В. О биологии карликового пятипалого тушканчика (*Cardiocranius paradoxus* Satunin) с территории юга Монголии. В кн.: «Структура и динамика степных и пустынных экосистем МНР» 1974.
93. Кучерук В.В., Тупикова Н.В. Роль тушканчиков в питании хищных птиц степи и пустынь Восточной половины МНР. Тушканчики фауны СССР. М., 1985.
94. Ладыгин В.Ф. О пересечении Гоби от Дала-туру в Су-чжоу. Известия РГО Т. XXXIV, 1900.

95. Лобанов Н.В. История разведения лошади Пржевальского в Аскании -Нова. Научно -технический бюллетень Украинского ордена трудового красного знамени научно-исследовательского Института животноводства степных районов «Аскания-Нова» Херсон., 1978. часть. II.
96. Лхагвасүрэн Б нар. Хан Хэнтийн ДЦГ-ын баруун хэсгийн хөхтөн амьтдын судалгаа, судалгааны тайлан, Улаанбаатар, 2008.
97. Лхамсүрэн П. Хар ус нуурын агнуурын амьтан. ШУА сэтгүүл. 1974. №.2.
98. Лхамсүрэн П. Минж нутагшиж байна. ШУА сэтгүүл. 1975. №.5.
99. Малыгин В.М., Дмитриев П.П., Таракановский А.А., Адьяа Я., Даваадорж Н., Дашзэвэг Г. К фауне млекопитающих Восточной Монголии. Природные условия и биологические ресурсы МНР. (тезисы докладов). М., 1986.
100. Минж нутагшуулах судлах ажлын тайлан. МУБИС, Амьтан судлалын тэнхим. 1990. 1991. 1992.
101. Мижиддорж Б., 1997. Цоохондой устах цоорхойг хаая. Байгаль сонин. № 07.08 (121,122).
102. Мижиддорж Б. 2006. Некоторые особенности биологии и экологии гобийского медведя (*Ursus gobiensis*) и проблемы его охраны. Автореферат доктора биологических наук (PhD). УБ.
103. Монгол орны уулын туруутны тархац нөөцийн үнэлгээ тайлан. Улаанбаатар, 2010.
104. Монгол орны ойн туруутны популяцийн үнэлгээ тайлан. 2010.
105. Монгол орны тал хээр говь цөлийн тууртны тархац нөөцийн үнэлгээ тайлан. 2010
106. Монгол орны хавтгай тэмээний биологийн нөөц, тархацын судалгааны тайлан, ШУА-ийн Биологийн хүрээлэн. Хөхтний экологийн лаборатори. 2012.
107. Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр. Байгаль орчны яам. УБ., 1996. 143х.
108. Монгол улсын Засгийн газрын тогтоол 7 дугаар тогтоол. 2012.
109. Мөнхбаатар М., Ариунболд.Ж. Дорнын сармаахайн овооролдоон / Байгаль орчин, амьдрал сэтгүүл. Улаанбаатар, (2009).
110. Мөнхцог Б. Монгол орны цоохор ирвэсний биологи, экологи ба хамгаалал. доктор (PhD)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, 2006.
111. Мөнхцог Б., Тэрбиш Х., Мижиддорж Б., Пүрэвжав Л., Довчиндорж Г. 2002. Говийн их дархан цаазат газрын орчны бүсийн цоохондой мий. Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. №26.
112. Мөнхсайхан М., Буян Б., Ганбат Д., Цэрэнгочоо Н. Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт тархсан хулангийн (*Equus hemionus*, Pallas, 1775) тоо нөөцийг судалсан зарим мэдээ. Ерөн. сорил. биол. хүр. бүт. 1986. №.21.
113. Мөнхтогтох О. Редкие виды млекопитающих Западной Монголии. «Баруун монгол түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг» эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн хураангуй., УБ. 1993.
114. Мөнхбаяр Х., Доржраа О. Булган голд ондатрын шинэ нутаг олдлоо. ШУА сэтгүүл. 1972. №3.
115. Мягмарсүрэн Д., Намхай А. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд. 2012. 409х.
116. Намнандорж О. БНМАУ-ын дархан газар, ан амьтад. УБ., 1964.

117. Намнандорж О. БНМАУ-ын дархан газар, цаазтай амьтан. УБ., 1976.
118. Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр. УБ., 2011.
119. Одбаяр Т., Майкаел Проктор, Туяа Ц., Харри Рейнолдс, Амгалан Л., Мижиддорж Б., Дерек Крайгхид, Нямбаяр Я., Давид Паеткау. Генетикийн аргаар мазаалай баавгайн тоо толгойг тогтоосон судалгаа. Хүрэл тогоотын семинар-2011 бүтээлийн эмхэтгэл. УБ., 2011.
120. Орлов В.Н., Кожемякин В.В. Карликовый тушканчик в Монголии. Природа. 1971. №6.
121. Орлов В.Н., Кожемякин В.В., Авирмэд Д. К биологии пятипалого карликового тушканчика (*Cardiocranius paradoxus*, Satunin) в предгорьях Гобийского Алтая. Вестн. Моск. универ. биол. почвоведения. 1972. №6.
122. Орлов В.Н., Раджабли С.И., Малыгин В.М., Хотолхүү Н., Ковальская Ю.М., Булатова Н.Ш., Баскович М.И. Кариотипы млекопитающих Монголии. География и динамика растительного и животного мира МНР. М., 1978. №10.
123. Петрищев В.И. Пустыне нужны сайгаки. М., 1987.
124. Пузанский В.Н. Редкие виды млекопитающих Забайкалья // Редкие виды млекопитающих России и сопредельных территорий (Тезисы Международного совещания 9-11 апреля 1997г. Москва), М., 1997. с.79.
125. Редкие животные Монголии (позвоночные) под ред. академик В.Е. Соколова. Москва. ИПЭЭ РАН, 1996, -184с.
126. Роговин К.А. Медведь пищухоед в МНР. Охота и охот-е хоз-во. 1980. №9.
127. Роговин К.А., Суров А.В. Питание грызунов Юго востока Заалтайской гоби МНР. Природные условия и биологические ресурсы МНР. (тезисы докладов). М., 1986.
128. Савельев А.П., Шурыгин В.В. Красный волк и американская норка в Убсунурской котловине // Редкие виды млекопитающих России и сопредельных территорий (Тезисы Международного совещания 9-11 апреля 1997г. Москва), М., 1997, 84 с.
129. Самъяа Р., Даваа Н., Штуббе М., Штуббе А., Хайдеко Д., Сумъяа Д., Мөнхтогтох О. Баруун монголын хөхтөн амьтны зарим ховор олдвор. Баруун монгол түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн хураангуй. УБ., 1993.
130. Самъяа Р., Шар С., Доржраа, О. 2012. Минж. УБ., 140х.
131. СИТЕС-ын лавлах. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлүүдийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай олон улсын конвенци. УБ., 1991.
132. Симуков А. По пустыням Западной Гоби. Журн. Современная Монголия. 1937. №6.
133. Скалон В.Н. К фауне млекопитающих Кентейского аймака МНР. Бюлл. МОИП. 1949. т. 54. вып.3.
134. Скалон В.Н. Речной бобры Северной Азии. М., 1951.
135. Clark E. L., Мөнхбат Ж., Дуламцэрэн С., Baille J.E., Батсайхан Н., Самъяа Р., Stubbe M. Монгол орны хөхтөн амьтны Улаан данс. 2006. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот, (Монгол Англи хэлээр). 164х.
136. Соколов В.Е. Редкие и исчезающие животные млекопитающие. М.,
137. Соколов В.Е., Хотолхүү Н., Орлов В.Н. Редкие виды копытных Большого гобийского заповедника (МНР): Современное состояние и перспективы. В кн.: География и динамика растительного и животного мира МНР. М., 1978. т.10.
138. Соколов В.Е., Орлов В.Н. Определитель млекопитающих Монгольской Народной

Республики. М., 1980.

- 139.Соколов В.Е., Дуламцэрэн С., Орлов В.Н., Хотолхүү Н. Современное состояние и вопросы охраны непарнокопытных млекопитающих Большого гобийского заповедника. Журн. Проблемы освоения пустынь. Ашхабад. 1980. №5.
- 140.Соколов В.Е., Данилкин А.А., Дуламцэрэн С. Современное распространение и численность лесных копытных в Монголии. Зоологические исследования МНР. М., 1982. т.18.
- 141.Соколов В.Е., Жирнов А.В., Орлов В.Н., Лобачёв В.С., Бугаев К.Г., Тимур Ч. Современное состояние популяции дикого верблюда (*Camelus ferus Przew.*) Монголии. докл. АН СССР. 1983. т.271. №.4.
- 142.Соколов В.Е., Швецов Ю.Г., Литвинов Н.И., Мелкие млекопитающие лесов Монгольской Народной Республики. М., 1985.
- 143.Соколов В.Е., Неронов В.М., Луцкеина А.А. Современное состояние и перспективы охраны млекопитающих Монголии. Экология и природа пользование в Монголии. Сбор. науч. труд. Пушино., 1992.
- 144.Соколов В.Е., Орлов В.Н. Новый вид современных медведей -*Ursus gobiensis.sp.n.* мазаалай или гобийский медведь. Internacionales syposium Erforschung biologischer Ressourcen der Mongolei in Deutschland vom 25.3-30.3.1992. Thesen.133.
- 145.100. Сосорбарам Ж . Өмнөговь аймгийн нутаг дахь хар сүүлт зээрийн тархалт, сүргийн бүрэлдэхүүн. Биол. хүр. бүт. 1969. № 2.
- 146.Соколов В.Е., Лобачев В.С., Орлов В.Н. Млекопитающие Монголии. Тушканчики: *Dipodinae, Allactaginae*.М.: Наука, 1998.-206с.
- 147.Соколов В.Е., Шенброт Г.И. 1987. Новый вид емуранчика –*Stylodipus sungorus sp.n* (*Rodentia, Dipodidae*) из Западной Монголии. Зоологический журнал 66(4):579-587
- 148.Тулгат Р. Алтайн өмнөх говийн мазаалайн идэш тэжээл. «Улсын тусгай хамгаалалттай газар» эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 1993.
- 149.Тулгат Р. Гоц ховор амьтан мазаалайн төлжилт, үхэл хорогдол, хамгаалах асуудал. «Улсын тусгай хамгаалалттай газар» эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 1993.
- 150.Ууганбадрах О., Соотон алагдаахайн (*Euchoreutes naso, Sclater, 1891*) эзэмшил нутаг. Хүрэл тогоотын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2010.
- 151.Фишер Д., Саймон Н., Винсент Д . Красная книга. ”Прогресс”.1976.
- 152.Хайдав П., Чагнаадорж Б. БНМАУ-ын ан амьтад. УБ., 1969.
- 153.Хотолхүү Н. Ховор олдвор. ШУА сэтгүүл. 1969. № 4.
- 154.Хотолхүү Н., Хэнтийн булганы экологи, аж ахуйн холбогдол /Биологийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилон бичсэн бүтээл/. Улаанбаатар, 1982.
- 155.Хотолхүү Н., Шагдарсүрэн О., Довчин Н. БНМАУ-ын нутаг дахь Зүүн гарын говийн хөхтөн амьтдын тухай тэмдэглэл. Биол. хүр. бүт. 1972. №.6.
- 156.Цагаан С. Халиу манай оронд байна уу? ШУА сэтгүүл. 1970. № 2.
- 157.Цагаан С. Монгол орны халиуны (*Lutra lutra L.*) тархац. Музей судлал. сэтгүүл. 1975. №2.
- 158.Цагаан С. Халиуны биологийн судалгаа. Музей судлал сэтгүүл. 1977. №.3.
- 159.Цэвигмэд Д. Сохранить редчайшее животное мировой фауны. журн.природа.1959. №5.
- 160.Цэвэгмид Д. Редчайшие животные Монголии и их современное состояние. Труды IX

между- народного конгресса биологов охотоведов. М., 1970.

- 161.Цэвэгмид Д. Алтайн цаадах говьд. УБ., 1963.
- 162.Цэвэгмид Д., Даваа Н. Маммологические исследования в Монгольской Народной Республике за 50 лет. Труд. инс. биол. АН МНР. 1973. №.8.
- 163.Цэвэгмид Д., Дементьев Г. П. О диком верблюде МНР. Учен. Записки Монг. Гос.Ун-та. 1966. т.9. №.2.
- 164.Цэнджав Д. Голын халиу (*Lutra lutra*) шинэ нутгаас олдов. Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. УБ., 2005. 125. хууд. 333.
- 165.Чулуун Ч. Дархалсан газар ховордсон амьтан. Үнэн сонин. 1988. №.101.
- 166.Шагдарсүрэн О. Алтайн чанад дахь говийн хөхтний тухай. ШУА-ийн мэдээ. 1962. №.1.
- 167.Шагдарсүрэн О. Монгол орноос Уссурийн хандгай (*Alces alces cameloides* Miln-Edw.) олдов. ШУА-ийн мэдээ. 1969. №.3.
- 168.Шагдарсүрэн О. К экологии *Gazella gutturosa* Pall. I международный конгресс по млекопитающим. М., 1974.
- 169.Шагдарсүрэн О. нар БНМАУ-ын улаан ном. УБ., 1987.
- 170.Шар. С Численность кабана в тростниковых зарослях системы оз.Хар ус. МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. Ховд, 1998. 8-р боть, 13-р дэвтэр, х. 54-57.
- 171.Шар С., Самъяа Р. Голын халиуны Монгол Алтай дахь тархацын судалгааны ажлын тайлан УБ., 2007.
- 172.Шенброт Г.И. Особенности питания тушканчиков в пустынях и пустынных степях МНР. В кн.: Природные условия и биологические ресурсы МНР. (тезисы докладов). М., 1986.
- 173.Шийрэвдамба, Ц. (ер. ред.), Монгол улсын улаан ном. Улаанбаатар, II хэвлэл. (1997). 338х.
- 174.Ширчин Л. Монголын бөхөн хаана байна вэ? ШУА сэтгүүл. 1974. №2.
- 175.Штуббе М., Даваа Н., Балжинням Ж. Результаты акклиматизации бобра (*Castor fiber*. Sereb.1758) в западной Монголии. Международная конференция посвященная исследованиям природных условий и ресурсов МНР. (тезисы докладов) УБ.,1981.
- 176.Энхбилэг Д., Дуламцэрэн С. Богдхан ууланд нутагшуулсан янгир ямаа (*Capra sibirica* Pallas) Биологийн хүрээлэн. Ерөнхий ба сорилын биологийн салбар э.ш. бүтээл. Улаанбаатар, 1999.
- 177.Энэбиш Д., Мягмарсүрэн Д. Монгол улсын дархалсан газар нутгууд. УБ., 2007.
- 178.Эрэгдэндагва Д. Редкие животные Западной Монголии. Журн. Природа. 1954. №2.
- 179.Эрэгдэндагва Д. Сайга в Монгольской Народной Республике. Известия Иркутского Сельхоз. Ин- та. 1954. №.6.
- 180.Эрэгдэндагва Д. Распространение и образ жизни речного бобра в бассейне р. Булган (Западная Монголия). Известия Иркутского Сельхоз. Ин- та. 1958. №.8.
- 181.Эрэгдэндагва Д. О былом распространении лошади Пржевальского в Монголии. журн. природа. 1959. №.5.
- 182.Эрэгдэндагва Д. Алтайн өмнөх говийн зэрлэг туурайтны амьдралд усны холбогдол. Ерөн. сорил. биол. хүр. бүт. 1976. №.1
- 183.Юдин Б.С. Насекомоядные млекопитающие Сибири. Новосибирск, 1971.
- 184.Adiya Yadamsuren, Enkhbileg Dulamtseren, Richard P.Reading, The Conservation Status and

Management of Wild Camels in Mongolia. Camels in Asia and North Africa. Vienna, 2012.


185. Amgalan L. The migration of goitered gazelle (*Gazella subgutturosa*). International conference "Asian ecosystems and their protection" Ulaanbaatar. 1995.
186. Amgalan L., Ganbold D., Reynolds H.V., Craighead D.J., Tserenbataa T., Mijiddorj B. Using digital remote cameras to assess minimum population size of the critically endangered Gobi bear population in Mongolia. 17th International Conference on Bear Research and Management. Nagano. Japan. 2006.
187. Bazardorzi D. An investigation of the mazaalai (*Ursus pruinus*) of Mongolia. 1972.
188. Batsaikhan N., Mijiddorj B., Boldbaatar Sh., Amgalan L. Survey of Gobi Bear (*Ursus arctos gobiensis*) in Great Gobi "A" Strictly Protected Area in 2004. Mongolian Journal of Biological Sciences 2004 Vol.2(1): 55-60.
189. Blyth, E. A monograph on the species of lynx. Journal Asiatic Soc. Bengal. 1842. 11:740-760.
190. International Trade in Endangered species of Wild Fauna and Flora. 1991.
191. Dash J., Szaniawski A., Guld G., Hunxeler P. Observations on some large mammals of the Transaltai, Djungarian and Sargin Gobi. Mongolia, Terre et Vie. 31. 1977.
192. Dulamceren S., Amgalan L. Daten zur Reproduktion der mongolischen Saiga-antilope (*Saiga tatarica mongolica* Bannikov, 1946). Beitrage zur Jagd-Wildforschung. 1994. Bd.19.
193. Kowalski K. New data on the distribution of mammals in the Mongolian Peoples Republic. Acta Zoologica Cracoviensia. 1968. T13. №1.
194. Horacek, I. Status of *Vesperus sinensis* Peters, 1880 and remarks on the genus *Vespertilio*. Praha, (1997). 2: 59-72.
195. Nicht M., Schunzel G., Dawaa N. Säugetierkundliche Notizen von einer Studienreise in die mongolische Volksrepublik im Jahre 1969. Mitt. Zool. Mus. Berlin. Bd.47. heft.2. 1971.
196. Piechocki R. Der sudostasiatische Biber *Castor fiber birulai* Serebrennikov, 1929. in der Mongolischen Volksrepublik. Arch. Naturschutz u. Landschaftsforsch. 1967. №7.
197. Tserenbataa, T., L. Waits, H. Reynolds, D.J. Craighead, L. Amgalan, B. Mijiddorj. Genetic analysis of the taxonomic status of the Gobi bear. 17th International Conference on Bear Research and Management. Nagano. Japan. 2006.
198. McCarthy T.M. Ecology and conservation of snow leopards, gobi brown bears, and wild bactrian camels in Mongolia. PhD thesis. University of Massachusetts Amherst, USA. 2000.
199. Kristin Nowell and Peter Jackson, Status survey and conservation action plan of Wild cats. 1996. 101-106.
200. Nyambayar, B., J. Ariunbold, G. Sukhchuluun A contribution to the bats inhabiting arid steppe habitats in central Mongolia. Erforschung biologischer Ressourcen der Mongolei / Im Auftrag der Martin-Luther-Universität Halle-Wittenberg, herausgegeben von Wissenschaftlern der Martin-Luther-Universität Halle-Wittenberg der International Tachi Group, und der Nationalen Universität Ulaanbaatar- Halle (Saale) –(2010). Band 11.
201. Schaller G., Tulgat R., Naranstaal B. Observations on the Gobi Brown bear in Mongolia. Biological Conservation. 1993.
202. Schaller, J., J. Tserendeleg, and G. Amarsana. 1994. Observations on snow leopards in Mongolia. Pages 33-42 in J. Fox and Du Jizeng, editors Proceedings of the Seventh International Snow Leopard Symposium, Xining, China. International Snow Leopard Trust, Seattle, Washington. 1994.
203. Samjaa R., D. Sumjaa N. Batsajchan N. Tsevenmyadag J. Tumursuch. Verbreitung und Ökologie des

Fishotters (*Lutra lutra* L.,1758) in der Nord und Ostmongolei. Beitrage zur Jagd- und Wildforschung Bd.23 (1998), 231-238

- 204.Scheffler I., D.Dolch, J.Ariunbold, N.Batsaikhan, A.Abraham and K.Thiele, Ectoparasites of bats in Mongolia (Ischnopsyllidae, Nycteribiidae, Cimicidae and Spinturnicidae). Erforschung biologischer Ressourcen der Mongolei / Im Auftrag der Martin-Luther-Universität Halle-Wittenberg, herausgegeben von Wissenschaftlern der Martin-Luther-Universität Halle-Wittenberg der International Tachi Group, und der Nationalen Universität Ulaanbaatar- Halle (Saale) – (2010). Band 11.
- 205.CITES Appendices. I, II and III to The Convention on.
- 206.Schagdarsuren O., Stubbe B. Zur Säugetierfauna der Mongolei-IV. Der Ussurische Elch-*Alces cameliodes* (Milne-Edwards,1867) in der Mongolei. Archiv für Naturschutz und Landschaftsforschung.Heft.I. Bd.14. 1974.
- 207.Stubbe M., Dawaa N., Dorz S. Der Bauschlater *Dryomys nitedula* Pallas,1778 in der Mongolei. Erforsch. Biol.Ress. BVR, Halle. 5. 1985.
- 208.Stubbe.M., Chotolchu. N. Zur Säugetierfauna der Mongolei. mitt. zool. Museum Berlin. Bd.44. H.1. 1968.
- 209.Stubbe A., Stubbe M., Batsaikhan, Samjaa R. Drieckhianz *Euchoreutes naso* Sclater, 1890 – ein Säugetier – Endemit Zentralasiens”Erforsch. biol. Ress. Mongolei (Halle/Saale), 2007. (10): 471-486.
- 210.Tulgat R., Schaller G. Status and distribution of wild Bactrian camels - *Camelus bactrianus ferus*. Biological Conservation. 1992. 62.
- 211.Zahler P., Lkhagvasuren B., Reading R.P., Wingard G.J., Amgalanbaatar S., Gombobaatar S., Barton N and Onon Yo. Illegal and unsustainable wildlife hunting and trade in Mongolia. Mongolian Journal of Biological Sciences. UB., 2004. 2[1].
- 212.Zevegmid D., Dawaa N. Die seltenen Großsäuger der Mongolischen Volksrepublik und ihr Schutz. Arch. Naturschutz und Landschaftsforsch. Berlin. Bd.13. H.2. 1978.



1



2



3



4



5



6



7

1. *Ovis montanus*

*Ovis montanus*  
Wild Mountain

2. *Capra bedfordi*

*Capra bedfordi bedfordi*  
Asiatic Wild Ass

3. *Lynx baileyi*

*Lynx baileyi baileyi*

4. *Saiga tatarica*

*Saiga tatarica tatarica*  
Mongolian Saiga Antelope

5. *Ursus arctos*

*Ursus arctos gobiensis*  
Gobi Bear

6. *Sus scrofa*

*Sus scrofa moupinensis*  
Musk Deer

7. *Ursus arctos*

*Ursus arctos*  
Bear




ШУВУУ



2. Шыбыу

# 1. БОРЦГОР ХОТОН



*Pelecanus crispus* Bruch, 1832

**Баг.** Хотонтон - *Pelecaniformes*

**Овог.** Хотонгийхон - *Pelecanidae*

**Статус:** Нэн ховор зүйл. Дэлхийн байгаль хамгаалах холбоо /цаашид “ДБХХ” гэх/-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж байгаа” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Бие том, 170 см, 13 кг хүртэл жинтэй. Ерөнхий зүс цагаан. Хүчирхэг, урт, үзүүр тийш нарийссан өргөн хошуутай. Хошуун дороо шар сарьсан ууттай. Орооны үед цул сарьс улаан болж хувирна. Хэвэл цагаан, нуруу бор сааралдуу, дагз, шилний өд буржгар, хөх саарал. Нэгдүгээр зэргийн дэвүүрүүд хар. Зулзган хотонгийн хөл, хошуу-хар, дагз, шилний өд буржгардуу, нуруундаа хүрэндүү толбуудтай. Хүзүүгээ гэдрэг нугалж, далавчаа хүчтэй цөөн дэвэн ниснэ [1,17].

**Тархац, байршил нутаг:** Шар мөрний эхээс баруун зүгт Балканы хойг, Персийн булангаас Кустанай мужийн Хар нуур хүртэлх цөөхөн нуурт өндөглөнө [1]. Ирак, Персийн булан, Египет, Энэтхэг, Хятадын зүүн өмнөт нутагт өвөлжинө. Монголд: Ховдын Хар ус нуурт өндөглөдөг. Нүүдлийнхээ үед Нууруудын хөндий, Завхан гол, Их нууруудын хотгорт тохиолдоно. Үржилд ороогүй бодгаль Увс, Хяргас, Баян, Өгий нуурт тааралдана [2-19]. Загас, ургамал ихтэй томоохон нуур, голын адгаар өндөглөнө. Зэгс, тачирдуу ургамалтай усны шаваргүй эргээр амарна.

**Амьдралын онцлог:** Өвөлжсөн газраасаа IV сарын сүүл, V сарын эхээр нүүдэллэн ирнэ. Загастай, онгон зэлүүд том нуурын гүнзгий хоолойн эргээр тураг гогойнуудын хамт зэгсний нөмөр бараадан цуглаж, хатсан зэгс, өвсний, ишээр метр шахам өндөр, 70-аад см өргөн үүр

засна. Гурван нас хүрч, үржилд орно. V сарын дундуур шаргалдуу туяатай, цагаан 89.6 x 58.7 мм хэмжээтэй 1-2, заримдаа 2-4 өндөг гаргана. Эмэгчин өндгөө дарж, дөчөөд хоносны дараа өдгүй, нүдээ нээгээгүй ангаахай гарч, арваад хоногийн дараа цагаан ноолуур өдөөр хучигдан, усанд сэлэх чадвартай болно [4]. Ангаахайг нялхад хагас боловсруулсан загас, томорсон хойно бүтэн загасаар тэжээнэ. Ангаахай дал гаруй хоног болоод нисч эхэлнэ. Энэ үеэс хотонгийн бүлүүд сүрэглэж, загас элбэгтэй нуураар X сар гартал хэсүүчилсээр, өвөлжих газрын зүгт нүүнэ.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Дэлхийд 3200-4300 хотон бий [3]. Хар ус нуурын “Шувуун цуглаа” хэмээх хошуунд 1956 оны зун 300 гаруй хотон, 1972 онд Хар ус нуурт 207, 1981 онд 13, 1976 онд Хяргас нуурт 10, Ойгон нуурт 13, Баянхонгор аймгийн Орог нуурт 1979 оны намар 50, 1985 онд Увс нуурт 1 хотон тохиолдож байжээ. Хэрлэн голын хөвөөнд 2 бодгаль 2008 онд тохиолдож байсан [19]. Судалгааны материалаас үзэхэд, 90-ээд оны сүүлчээр Монголд 200 орчим борцгор хотон бий [8]. Гэвч 2000 оноос хойш эрс ховордож байгаад, 2005 оноос үүрлэж, зусдаг нутагтаа цөөн тоогоор эргэн ирэх болсон. 2010 оны 6 сард Хар ус нуурын Цагаан голын арлууд дээр 120-150 хотон тохиолдож байсан [18]. Усны түвшин буурах, хэт ихсэх, нуурын эрэг, арлын ургамал талхлагдах зэргээс үүр, өндөг устана. Хүн ойртоход үүрээ удаан хугацаагаар орхиж явснаас цахлай, үнэг зэрэг амьтад өндөг, ангаахайг сүйтгэнэ. Хотонгийн хошуугаар хурдан морины хусуур хийдэг нутгийнхны заншил хотонгийн нөөцийг хомсдуулж, улмаар устахад хүргэх хандлагатай байна.

**Хамгаалсан байдал:** 1953 оноос агнахыг хуулиар хориглож, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэж [23], Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц /CITES/-ийн I хавсралт 19], Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенц /CMS/-ийн I, II хавсралт [21] болон Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц /RAMSAR/-ийн жагсаалтад орсон Хар ус нуур, Орог нуур, Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар [20], Монгол улсын улаан ном /1987, 1997/-онд тус тус орсон. Тархац нутгийг Увс нуурын ай савын дархан цаазат газар, Хар ус нуурын байгалийн цогцолборт газарт тус тус хэсэгчлэн хамрагдсан [23] .

**Хамгаалах арга хэмжээ:** Үндсэн байршил нутаг, үүрэлдэг газруудыг үржлийн хугацаанд тусгайлан хамгаалах, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх. Тархац нутгийг нутгийн иргэд, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулж, хамгаалалтыг сайжруулах, хууль бус агналтыг таслан зогсоох, нууруудын эргийн бэлчээрийн талхагдалтыг хязгаарлан зогсоох ажлыг зохион байгуулах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жизнь животных том VI, 1986, 2. Фомин, Болд, 1991, 3. Остапенко нар, 1978, 4. Гомбобаатар нар, 2008, 5. Козлова, 1930, 6. Фомин, Болд, 1991, 7. Даваа нар, 1994, 8. Монгол улсын улаан ном, 1997, 9. Тэрбиш, Гомбобаатар, 2003, 10. Болд, 2005, 11. Болдбаатар, 2005а, 12. Цэвээнмядаг, Болд, 2005, 13. Нямбаяр нар, 2007, 14. Болдбаатар, 2008, 15. Нямбаяр, Цэвээнмядаг, 2009, 16. Mongolian Red List of Birds, 2011, 17. Болдбаатар, 2013 б, 18. Болдбаатар, 2013 г, 19. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын

хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), 2001, 20. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (RAMSAR), 1997, 21. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенц (CMS), 1999, 22. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, 2012, 23. Амьтны тухай хууль, 2012.

## 2. ЦАГААН ТОГОРУУ



*Grus leucogeranus* Pallas, 1773

**Баг.** Тогоруутан - *Gruiformes*

**Овог.** Тогорууныхан - *Gruidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж байгаа” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Бие том, 1200-1400 мм өндөр, дун цагаан зүстэй. Далавчны үзүүр хар. Нүүр, хошуу, хөл улаан. Эр эмээсээ арай том. Залуу тогоруу улаан туяатай, цагаан өдтэй [3].

**Тархац, байршил нутаг:** Обь мөрний дунд хэсэг, Якутын зүүн хойд нутагт өндөглөж зусдаг. Якутад Яной голоос дорно зүгт Алазе голын хоорондох өргөн уудам нутагт байршдаг шувуу. Монголын нутгийг дайран өнгөрч, зусдаг. Хятадын Хөх мөрний адагт өвөлжинө [2]. Буур, Тарь нуур, Бүхэгийн голд хавар тэмдэглэсэн [8]. 1981, 1988 оны зун Улз голын сав, 1994 онд Өгий нуурт зусаж байжээ [1-18]. Сүүлийн 5 жилүүдэд Биндэрийн нуур, түүний орчим нутгаар 8-10 толгойгоор зуны улиралд байнга тохиолдох болсон [18].

**Амьдралын онцлог:** Якутын тундр дахь үүрлэх биотоп үй түмэн жижиг, том нуурууд бүхий чийглэг тундр бөгөөд эргэн тойрон шилмүүст ойгоор хүрээлэгдсэн байдаг. Ихэвчлэн 2 өндөг гаргана [3]. Монголд IV сарын сүүлч, V сарын эхээр нүүдэллэн ирж, зэлүүд нутагт зусна [8]. Их төлөв эргээрээ зэгстэй, намгархаг нуур болон голын хөндийн өтгөн өвстэй чийглэг нугад

ТОХИОЛДОНО.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Якутад 840, Обь мөрний савд 50 орчим байдаг [3]. Маш ховор тохиолдоно. Өгий нуурт 5 бүртгэгдсэний нэг нь нялх төл байжээ [8]. Монголд оронд зусдаг учраас тархац нутагт нь мал, хүний нөлөө тайван байдлыг алдагдуулна.

**Хамгаалсан байдал:** 1995 оноос агнахыг хуулиар хориглон дархалж, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэж, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцийн I хавсралт [20], Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн I, II хавсралтад [21], Монгол улсын улаан ном /1987,1997/, 2001 оны Азийн улаан номонд тус тус оруулсан. Байршил нутгийг улсын тусгай хамгаалалтад хэсэгчлэн авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Байршил нутгийн хамгаалалтыг холбогдох хууль конвенцид нийцүүлэн хамгаалалтыг сайжруулж, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Козлова, 1930, 2. Останпенко, Цэвээнмядаг, 1983, 3. Птицы СССР, Журавлеобразные, 1987, 4. Фомин, Болд, 1991, 5. Даваа нар, 1994, 6. Гомбобаатар, 1995, 7. Гомбобаатар, 1996, 8. Монгол улсын улаан ном, 1997, 9. Сумъяа нар, 2000, 10. Цэвээнмядаг нар, 2000, 11. Birdlife International, 2001, 12. Гомбобаатар, Болд, 2002, 13. Badley et al., 2005, 14. Болдбаатар, 2005а, 15. Цэвээнмядаг, Болд, 2005, 16. Цэвээнмядаг нар, 2005, 17. Нямбаяр, Цэвээнмядаг, 2009, 18. Болдбаатар, 2013г, 19. Болд, 1969, 20. CITES, 1996, 21. CMS, 1999.

### 3. ЦАГААНГОЛГОЙТ ЯМААНСҮҮЛ



*Oxyura leucosephala* (Scopoli, 1769)

**Баг.** Галуутан - *Anseriformes*

**Овог.** Нугасныхан - *Anatidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Дунд зэргийн биетэй, 0.4-0.9 кг жинтэй [4]. Хошуу өргөн, тод цэнхэр өнгөтэй. Хүзүү богино, толгой том. Сүүл урт, шаталсан, нарийхан, хатуу өдүүдтэй. Бие гүйцсэн эр нугас улаан хүрэн зүстэй, залуу бодгаль хүрэн бидэртэй. Эрийн толгой цагаан, хар “титэмтэй”, хүзүүндээ хар бүслүүртэй [3,4,10]. Сэлж явахдаа сүүлээ босоо өргөнө. Аюул тохиолдсон үед усанд живж нуруу гүвийн ил харагдана. Хааяа 30-40 м гүн шумбаж, усан доогуур сайн сэлнэ. Нисэх дургүй, хуурай газарт гардаггүй [4]. Хөл биеийн хойд хэсэгт байрласан тул газраар явж чадахгүй, сэлэхэд онцгой зохицсон [5].

**Тархац, байршил нутаг:** Их нууруудын хотгорын Увс, Хяргас нуур, Ховдын Зэргийн нуур, Айраг нуурын шигүү зэгстэй эрэг, арал, гүн устай газар идэшлэнэ [7,8].

**Амьдралын онцлог:** Нарийвчлан судлаагүй. Цөлөрхөг хээрийн бүсийн давстай, усны ургамлаар баялаг, өтгөн зэгсэнд үүрлэн өндөглөдөг. Зэгсэн дундах гүн биш усанд хөвмөл үүр барьдаг [4]. IV сарын сүүлчээр нүүж ирнэ. Барзгар гадаргуутай, харьцангуй том 4-6 өндөг гаргаж, эмэгчин цөөн хоног дарж байгаад орхидог. Өндөгний доторх хөврөл нарны элчээс дулаан авч хөгжсөөр дэгдээхий болдог. Усны ургамлын үр, навч, усны шавж, дун, хавч хэлбэртнүүдээр хооллоно.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Хаана ч ховор тохиолдоно. Одоогийн байдлаар, дэлхий дээр 15 мянга орчим толгой бий [4]. Монголд хэдэн зуугаад бүртгэгдсэн. 1981 оны зуны сүүлчээр Увс нуур, түүнд цутгадаг Тэсийн голын адгаар 15-18, Хяргас нуурын зэгстэй тохойд 8 бодгаль байв [8]. Сүүлийн үед тархацын хил зүүн тийш тэлж, Булган аймгийн Тэшиг сумын Олон нуурт өндөглөдөг болох нь тогтоогдсон [9,10]. Усны түвшин буурч, ургамал хомсдох, зэгсийг заарт харх, оготно, мал идэх, хадлан авах, түймэрт шатах, агнах зэрэг шалтгаанаас байршил нутаг доройтон хомсдож байгаагаас ихээхэн цөөрч, устах аюулд ороод байгаа.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад тус тус бүртгэсэн [11]. Монгол улсын улаан номонд орсон [12]. Үржлийн нутаг нь улсын тусгай хамгаалалттай газруудын сүлжээнд хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судлах, үржлийн нутгаас нь малын өвөлжөө, хаваржааны газруудыг чөлөөлөх, зэгстэй нууруудын зэгсийг хадахгүй байх, түймрээс хамгаалах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Красная книга СССР, 1978, 2. Красная книга РСФСР, 1983, 3. Красная книга Уз.ССР, 1983, 4. Жизнь животных, том VI. 1986, 5. Бабенко нар, 1986, 6. Иванов, 1976, 7. Болд, 1994, 8. Болдбаатар, 2005, 9. Майнжаргал, 2005, 10. Болдбаатар, 2013 б, 11. Болд, Цэвээнмядаг, 2001, 2001, 12. Монгол улсын улаан ном, 1997.

#### 4. МОГОЙЧ ЗАГАЛАЙ



*Circaetus gallicus* (Gmelin, 1788)

**Баг.** Шонхортон – *Falconiformes*

**Овог.** Харцгайнхан – *Accipitridae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Биеийн урт 62-67 см. Өнгө зүсний цайвар, бараан хэлбэр ажиглагдана. Сүүл харьцангуй урт, хөндлөн бараан судлуудтай. Толгой, цээж, нуруу бараавтар хүрэн бор, хэвлий цайвар бор хүрэн, бор саарал, бараан хүрэн толбо ихтэй. Суух үед толгойн өд сэгсийх учир зантгар толгойтой мэт харагдана. Далавчны доод бүрхүүл өд хөндлөн судал, толбо ихтэй учир цоохор. Шуумаг өд сул хөгжсөн. Залуу шувууд бие гүйцсэнтэйгээ ижил ч биеийн дээд хэсэг цайвар, доод хэсэг толбо, судал багатай, хөндлөйд цайвар зүс хөгжөөгүй, хоолой арай бараан. Тарс нүцгэн, торлог хайрстай. Хошуу, хөл хөхвөр саарал, хумс хар. Могойгоор голчлон хооллодог ч үүрлэх, зусах газар элбэг жижиг биетэй сээртэн амьтдыг ангуучилна [1,2,12].

**Тархац, байршил нутаг:** Хэнтийн баруун-өмнөд хэсгээр үржлийн үедээ тохиолдоно [3-7]. Сэлэнгэ голын хөндийд үржиж, Орхон, Сэлэнгэ, Туул голын саваар нүүдлийн үедээ тохиолдоно [9,10]. Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Зүүн Хайлаастай, Шүтэгийн Баянгол, Өөшийн говь, Өмнөговь аймгийн Ноён сумын Баг мод, Галбын говь, Батаагийн голд өндөглөн зусна [11,13].

**Амьдралын онцлог:** Нүүдлийн манай оронд өндөглөдөг зүйл. Энэ зүйлийн үржлийн, нүүдлийн бодгалиуд манай оронд IV сарын сүүлч, V сарын эхээр нүүж ирнэ. Нүүдэллэж ирсний дараа үржлийн хосууд үүрээ сонгож, V сарын сүүлч, VI сарын эхээр цөлжүү хээр, говийн тоорой, улиас, хайлаас зэрэг мод дээр модлог, бутлаг ургамлын иш, мөчир зэргээр үүр

засаж, цагаан өнгөтэй 1 өндгийг ихэвчлэн эм шувуу 40-47 хоног дарна. Голчлон эм өндөг дарж, ангаахайг хооллож, хамгаалах ба харин эр нь могой, гүрвэл, жижиг шувуу, тэдгээрийн ангаахай, шавж ангуучилж, эм болон ангаахайгаа хооллоно. Ангаахай үүрээ орхиж ниссэний дараа ч эцэг, эх шувуудын халамжинд байна. Намрын нүүдэл VIII сарын сүүлч, IX сарын эхээр үргэлжилнэ. Нүүдлийн үедээ энэ зүйлийн нэг, эсвэл 3-4 бодгаль манай орны ойт хээр, хээр, говь цөлд тохиолдоно. Тэдгээрийн нүүдэллэх хугацаа тухайн жилийн идэш тэжээл, цаг уураас ихээхэн хамаарна [13].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Үүрлэх нутаг нь мал, ялангуяа, тэмээний бэлчээр талхлагдаж, үүрлэх орчин доройтох шалтгаан болно. Уул уурхай болон аялал жуулчлалыг дагасан барилгажуулалт, үүртэй моддыг түлшинд хэрэглэх нь түүний өндөглөх орчин улам хязгаарлагдмал болоход нөлөөлж байна. Идэш тэжээл хомсдох, эгэл шаршувуу зэрэг махан идэшт амьтдын нөлөө залуу шувуудын өсөлтөнд муу нөлөөтэй [12].


**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулж, Зэрлэг ургамал, амьтны ховордсон зүйлийг олон улсад худалдах тухай конвенцийн II хавсралт [6] болон Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн II хавсралтад тус тус бүртгэгдсэн [13]. Монгол улсын улаан номонд орсон [4]. Энэ зүйлийн манай орон дахь нийт тархалтын 11.9% нь улсын тусгай хамгаалалттай газарт багтана [12].

**Хамгаалах арга хэмжээ:** Биологи, экологийг нарийвчлан судлах, тархац нутгийг улсын тусгай хамгаалалтад нэмж авч, хамгаалалтыг сайжруулах, сурталчилгаа хийх, амьдрах орчны доройтол, бэлчээрийн талхагдлыг хязгаарлан зогсоох.

**Эх зохиол, мэдээ:** 1. Козлова, 1930, 2. Фомин, Болд, 1991, 3. Даваа нар, 1994, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Болд нар, 2001, 6. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн лавлах 2001, 7. Stenzel et al., 2005, 8. Болдбаатар, 2005 а, 9.Цэвээнмядаг нар, 2005, 10. Stubbe et al., 2010, 11. Гомбобаатар нар, 2011, 12. Gombobaatar et al., 2011 б.

## 5. БОР БҮРГЭД





*Aquila clanga* Pallas, 1811

Баг. Шонхортон - *Falconiformes*

Овог. Харцгайнхан – *Accipitridae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Биеийн урт 59-69 см. Бие гүйцсэн бодгалийн дээд, доод хэсэг бүхэлдээ хар хүрэн. Далавчны доод талаас нэгдүгээр зэргийн эхний дэвүүрүүдийн уг, хондлой үл мэдэг цагаан. Дагз орчимд улбардуу бор шаргал толбогүй. Цээж, хэвлий хар хүрэн. Хээрийн бүргэдтэй төсөөтэй ч далавч доороосоо бугуй орчимдоо цагаан судалт толботой, арай бараан зүстэй зэргээрээ ялгарна. Залуу бодгалийн далавчны бүрхүүл илүү цоохор, хондлойн цагаан тод. Далавчны доод их бүрхүүлийн орой цайвар учир энэ хэсэг цоохор. Хошуу бараан саарал. Хөл, зэтэр шар, хумс хар [1,2,22].

**Тархац, байршил нутаг:** ОХУ, алс дорнодоос Сырдарья голын хөндий хүртэлх нутагт үүрлэж, зусдаг, Баруун Европын дорнод нутаг, ОХУ-ын Алтай ба БНХАУ-ыг дайран өнгөрч, Ази болон Европын өмнөд нутаг, Египетэд өвөлждөг. Монгол оронд Хэнтийн уулс болон Сэлэнгэ голын тайга, ойт хээрийн ойд үүрлэнэ. Нүүдлийн үедээ үржлийн дээр дурдсан нутаг, Нууруудын хөндий, Халх голын савд тохиолдоно [3-11]. Хангайн нурууны Тарвагатай, Завханы Их уул орчим, өмнөд хэсэгтээ Тэрхийн голын сав, хойшоогоо Идэрийн гол, Архангайн Өгий нуур, Булган аймгийн Жаргалант Хорго, Баян-Овоо, Булган аймгийн Хутаг-Өндөр, Айрхан нуурын хоорондох нутаг, Хэнтийн уулс, Мандал сумын Баянголын хөндий, Зүүнхараагийн Хараа гол, Тэрэлж орчим, Төв аймгийн Атар орчимд нүүдлийн үедээ тэмдэглэгджээ [12-20,22,23].

**Амьдралын онцлог:** Монгол оронд энэ зүйл харьцангуй ховор өндөглөдөг, нүүдлийн зүйл.

Манай оронд үржлийн болон нүүдэллэж буй бодгалиуд IV сарын сүүлч, V сарын эхээр ирнэ. Тэд V сарын сүүлч, VI сарын эхээр үржинэ. Үржлийн хосууд тайга, ойт хээр, голын хөндийн шилмүүст, навчит болон холимог ойн өндөр модонд үүрээ моддын иш, мөчрөөр засна [18,20,21]. Нэг үүрэндээ жил дараалан үүрлэнэ. Эм бүүдгэр саарал өнгөтэй, бор хүрэн, саарал сийрэг толбо, судалтай 2-3 өндгийг ихэвчлэн 42-44 хоног дарна. Эр заримдаа усны шувууд, гүрвэл, мэлхий ч иднэ. Залуу шувууд ойролцоогоор 60-65 хоногийн дараа үүрээ орхиж ниснэ. Нүүдлийн үедээ тэд ганц нэгээрээ ойт хээр, гол, нуурын хөндий, хад чулуу, цохиотой нутагт тохиолдоно. Үржлийн болон нүүдэллэж буй бодгалиуд манай оронд IX сарын сүүлч, X сарын эхээр тааралдана [20,22].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Уул уурхайн хайгуул, олборлолт, үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар мод огтлох, аялал жуулчлалын үйл ажиллагаа ой, ойт хээрийн бүсийн өндөглөх орчныг доройтуулж байна. Ой хээрийн түймэрт өндөглөдөг нутаг ихээр өртөж, заримдаа үүр бүхий мод шатдаг [20]. Идлэг шонхорыг барихын тулд нисгэсэн урхитай тагтаанд орооцолдож, бодгалиуд эндэнэ. Нүүдлийн үедээ Үлийн цагаан оготны хоронд хордсон чичүүл, үлийн цагаан оготныг олноор идэснээр энэ зүйлийн бодгалиуд хордож үхэх аюултай [20]. Мөн өндөр хүчдэлийн шугам мөргөх, өндөр хүчдэлийн шугамын хүчдэлд цохиулж эндэнэ. Дуу шуугиан үржлийн шувуудад сөргөөр нөлөөлнө [20].

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэж, Азийн ховор шувуудын Улаан ном /2001/, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралт болон Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн I, II хавсралтад бүртгэгдсэн [15,22]. Уг зүйлийн манай орон дахь тархсан газрууд улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тоо толгой, биологи, экологийн судалгааг хийж, хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, үржлийн нутгийн амгалан байдлыг алдагдуулахгүйн тулд нутгийн иргэдэд түшиглэсэн хамгаалалт, суртчилгааны ажлыг сайжруулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Болд нар, 2001, 2. Gombobaatar et al., 2011, 3. Козлова, 1930, 4. Шагдарсүрэн, 1964, 5. Шагдарсүрэн, 1983, 6. Фомин, Болд, 1991, 7. Даваа нар 1994, 8. Цэвээнмядаг нар, 2000, 9. Цэвээнмядаг нар, 2005, 10. Болдбаатар, 2005 а, 11. Болдбаатар, 2008, 12. Козлова, 1932, 13. Bankovics et al.,1980, 14. Stephan, 1988, 15. Birdlife International, 2001, 16. Wichmann, 2001, 17. Гантулга нар, 2010, 18. Stubbe et al., 2010, 19. Өсөхжаргал нар, 2010, 20. Gombobaatar et al., 2011 б, 21. Болд нар, 2005, 22. Болд нар, 2001, 23. Болдбаатар, 2013 б.

## 6. УСНЫ НӨМРӨГБҮРГЭД



*Haliaeetus leucoryphus* (Pallas, 1771)

**Баг.** Шонхортон - *Falconiiformes*

**Овог.** Харцгайнхан - *Accipitrida*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Ерөнхий зүс бараан хүрэн. Сүүлийн залуур өдүүд цагаан бөгөөд үзүүр, угтаа хар зурвастай. Толгой, хүзүү шаргал саарал. Нүд цайвар бор, хошуу хар саарал, зэтэр цэнхэрдүү, хөл цайвар шар, хумс хар. Эр шувууны далавчны урт 545-585 мм, эмийнх 593-623 мм. Хээр ба цөлийн томоохон усан сангуудыг дагаж амьдарна. Үүрээ мод хад, овоорсон зэгсэн довцог дээр засдаг. 2-4 өндөг гаргана. Нүүдлийн, зарим үед өвөлждөг, үүрлэж, өндөглөдөг шувуу [19,22].

**Тархац, байршил нутаг:** Ази, баруун тийш Приерусланы тал, Өмнөд зүгт Байгалийн урдах нутгууд хойт БНХАУ, Түвд, Умард Энэтхэг, Бирмээр тархана. Манай орны Монгол Алтайн Ачит нуур, Их нууруудын хотгорын Хар ус, Хар, Дөргөн, Хяргас, Увс нуурууд, Завхан голын хөндий, Хангайн Орхон, Тамир, Идэр, Хэнтийн уулын бүсийн Хараа, Туул голын хөндий, Хөвсгөл, Дархадын хотгороор тааралдана. Нүүдлийн үедээ Орхон, Туулын хөндий, олон нууруудын хоолойн Бөөнцагаан нуурт тохиолдоно. Хээр, цөлийн загастай, томоохон нуур, ус дагаж амьдарна [1-22].

**Амьдралын онцлог:** Үүрээ мод, хад, газарт засч 2-4 өндөг гаргана. Тэжээлийн зонхилох хэсгийг загас эзлэх боловч, сүүгээр бойжигчид, шувуу барьж иддэг. Судалгаагаар, Хар ус нуурын Цагаан голын арал дээр, өвөлжөөн дээр үүрлэсэн байв [19].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Томоохон нуур усны эрэг хавиар амьдардаг бусад шувуудын


адил амьдрах орчны доройтол нь нэг газартаа зусах, өндөглөх боломжийг алдагдуулж байна.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэж, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцийн II хавсралт, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн II хавсралт [23], Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн хавсралтад орсон нууруудад тус тус орсон [24]. Байршил нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгойг нарийвчлан судлах, гол, нуурын эргийн бэлчээрийг сэлгээтэй ашиглаж, түүний талхагдлыг хязгаарлан зогсоох, хамгаалалтыг сайжруулах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Козлова, 1930, 2. Сушкин, 1938, 3. Piechocki, 1968, 4. Fischer, 1970, 5. Mauersberger et al., 1982, 6. Сумъяа, Скрябин, 1989, 7. Фомин, Болд, 1991, 8. Даваа нар, 1994, 9. Болд нар, 1996, 10. Цэвээнмядаг нар, 2000, 2005, 11. Сумъяа, 2002, 12. Тэрбиш, Гомбобатар, 2003, 13. Болд, 2005, 14. Болдбаатар, 2003, 15. Болдбаатар, 2005 а, 2008, 16. Цэвээнмядаг, Болд, 2005, 17. Нямбаяр, Цэвээнмядаг, 2009, 18. Gantulga et al., 2010, 19. Stubbe et al., 2010, 20. Usukhjargal et al., 2010, 21. Болдбаатар, 2013, 22. Болдбаатар, 2013 б, 23. CMS, 1999, 24. RAMSAR, 1997.

## 7. РЕЛИКТ ЦАХЛАЙ



*Larus relictus* Lonnberg, 1931

**Баг.** *Хуазтан - Charadriiformes*

**Овог.** *Цахлайнхан - Laridae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж болзошгүй”

зүйлд хамаарна.

**Таних шинж:** Хэрээний хэмжээний биетэй. Ерөнхий зүс цагаан саарал. Толгой хар. Нүднийхээ дээр, доор цагаа толботой. Хошуу, хөл улаан хүрэндүү. Хүзүү, цээж, хэвэл, сүүл, далавчны дотор тал цагаан. Нуруу, далавч дээгүүр үнсэн саарал. Залуур өдний үзүүрүүд өргөн бараан судалтай. Дэвүүрүүд үзүүрээсээ дундаа хүртэл хар толбуудтай. Дэгдээхийн хошуу, хөл хар саарал. Толгой, бие цайвар бор.

**Тархац, байршил нутаг:** Казахстаны Алаколь нуур, ОХУ--ын Тарь нуурт өндөглөдөг, Хятадын Хэбэйд өвөлждөг тухай мэдээ бий [1,3,7]. Үржлийнхээ үедээ Монголын Айраг, Хяргас, Хар ус, Дөргөн, Таацын цагаан, Адгийн цагаан, Орог, Бөөн цагаан зэрэг Их нуурын хотгорын зэгстэй том нуурууд, Эрхэл, Сангийн далай, Өгий, Тэрхийн цагаан зэрэг төвийн бүсийн нуурууд, Галуут, Хөх, Тоорой, Хайчын цагаан, Сүмийн цагаан, Чух, Буйр нуур зэрэг Улз Хэрлэн голын хөндий, Халх нөмрөг голын хөндийн том жижиг нууруудаар тааралдана [1-7].

**Амьдралын онцлог:** Улз голын савд IV сарын дундаас үзэгдэж эхэлнэ [5]. Баруун Тарь нуурын арлаар V сарын 20-оос хагдарсан өвс, өдөн дэвсгэртэй юмуу зүгээр газар хонхойлж зассан үүрэндээ голдуу 3 ш, 59.7 x 42.8 мм хэмжээтэй, бараан бүдэнтэй цагаан өндөг гаргаж, хосууд ээлжлэн 24-26 хоног дарж, дэгдээхий болгоно. Дэгдээхийг үүрэнд 3-4 хоног байлгаж, бусад бүлийн дэгдээхийтэй нийлүүлэн бие гүйцсэн шувуудаар хамгаалуулна. Дэгдээхий сар хагасын дараа нисэн бусдынхаа хамт төрсөн арлаа орхин нүүнэ. Шавж, загас, хавч хэлбэртэн, аалз, жижиг шувууны ангаахай, үлийн цагаан оготно, алаг даага, буудайн үр зэргээр хооллоно [1]. Монгол нутгаар VIII сарын дундаас IX сарын 20-ны хооронд өвөлжих газраа нүүнэ.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Дэлхийд 10 мянга орчим байдаг [1]. Тарь нуурт 300-1000, Алаколь нуурт мянгаад цахлай амьдарч байна [1]. Буйр, Хөх нуур, Орог, Таац, Бүст нуур, Улз голоор 30 орчмыг бүртгэсэн [5]. Өндөг, дэгдээхийг том цахлайнууд иддэгээс гадна шуургатай үед давалгаа арлыг нөмрөн үүр, өндгийг устгана. Үргэлжилсэн хүйтэн бороонд дэгдээхий осгож үхдэг.


**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэж [8], Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралт [10], Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн I жагсаалт [9], Монгол улсын улаан номонд тус тус оруулсан. Тархац нутгийг Монгол Дагуур, Нөмрөгийн дархан цаазат газарт хэсэгчлэн хамруулсан [11].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, үржлийн нутгийг малын бэлчээрт ашиглахгүй байх, үржлийн тайван байдлыг хангах, тусгай хамгаалалттай газар нутаг дахь хамгаалалтын менежментийг сайжруулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Птицы СССР. Чайковые, 1988, 2. Штуббе, Болд, 1971, 3. Иванов, 1976, 4.

Кишинский и др, 1982, 5. Болд, Цэвээнмядаг (Аман мэдээ), 6. Красная книга РСФСР, 1983, 7. Mongolian Red List of Birds, 2011, 8. Амьтны тухай, 2012, 9. CMS, 1999, 10. CITES, 1996, 11. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, 2012.

## 8. БАХИМХОШУУ ХУРГАЧ



*Paradoxornis heudei* David, 1872

**Баг.** Бор шувуутан - *Passeriformes*

**Овог.** Хурагчийнхан - *Paradoxornithidae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж байгаа” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Жижиг биетэй. Далавч 65 мм орчим урт. Урт шаталсан сүүлтэй, хоёр талаасаа хавчгар, бахим хошуутай. Нуруу сааралдуу, сүүлийн уг орчимдоо бор шарга. Нүдэн дээгүүр үргэлжлэн дагз толгойн ар нуруун чигт нарийссан хар хүрэн судалтай. Цээж, хэвэл зээрд зүстэй [1].

**Тархац, байршил нутаг:** ОХУ, БНХАУ, Монголын нутгуудад Ханка нуур, Сунгари голын дунд хэсгээс Илистэй гол хүртэл Хөх мөрний адаг, Буйр нуур, Халхын гол, Гүү, Азрагын гол, Ташгайн таван нуурт тохиолдоно [2,3]. Нуур, голын эргийн үргэлжилсэн өндөр зэгсэнд суурин амьдардаг.

**Амьдралын онцлог:** Үүрээ хүн амьтан ойртоход хэцүү усан дундах арал дээр 5-р сарын дунд үеэс засч, 5-6 өндөг гаргаж, 12 хоног дарна. Ангаахай 4-5 хоногт өдлөөд, 12 хоногийн дараа үүрээ орхино [4].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Буйр нуур, Дашгайн таван нуур, Халх, Гүү азарга голын


өндөр зэгстэй газруудад 1 км талбайд 8 толгой тохиолдож байв [3]. Зэгсийг бэлтгэх, түймэр гарснаас байршил нутаг доройтож, хэвийн өсч үржихэд сөрөг нөлөө учруулж байна. Хүчтэй салхи үүр, өндөг, ангаахайг гэмтээж хорогдуулна.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэсэн. Монгол улсын улаан ном /1987, 1997/, 2001 оны Азийн Улаан номд тус тус орсон.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлан тогтоох, Ташгайн таван нуурын зэгсийг хадахыг зогсоох, Гүү, Азарга гол, Буйр нуурын популяциудыг хамгаалах ажлыг зориудаар зохион байгуулах, олон нийтэд сурталчлан хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жизнь животных том VI, 1986, 2. Красная книга РСФСР, 1983, 3. БНМАУ-ын улаан ном, 1987, 4. Поливанова нар, 1974, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Mongolian Red List of Birds, 2011.

## 9. ОДОЙ ГАЛУУ



*Anser erythropus*

**Баг.** Галуутан - *Anseriformes*

**Овог.** Нугасныхан - *Anatidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Манай орны галуунуудаас хамгийн жижиг биетэй шувуу. Биеийн урт 60 см. Далавчны дэлгээ урт 125-135 см. Манхин галуутай их төстэй. Биеийн зүс бараан хүрэн юмуу бор. Нуруу, хүзүүний ар, толгойн дээд хэсэг арай бараан. Хэвлий дээрээ хөндлөн зураас үүсгэсэн бараан толбуудтай. Хошуу богино, тод ягаан өнгөтэй. Духны цагаан өнгө зулай хүрсэн байдаг. Нүдийг тойрсон нарийн шар хүрээтэй. Зогсож байхдаа хуньсан далавчны үзүүр сүүлнээс илүү гарна [1,2].

**Тархац, байршил нутаг:** Европын бүр хойд хэсгээр үүрлэх бөгөөд Зүүн Өмнөд Европ, Хар тэнгис орчим нутаг, дорно зүгт Каспийн тэнгис, Бага Ази, Нил мөрний сав, Ойрх дорнод, Иран болон Хятадад өвөлжинө [2]. Манай орны Хэрлэн, Улз голын сав, Хөх, Дөрөө, Хайчийн цагаан, Хорийн цагаан ба Дэлгэр цагаан нуурууд, Халх, Нөмрөг, Азрага голын хөндий, Буйр, Ташгайн таван нууруудад тохиолддог [3-7].

**Амьдралын онцлог:** Бутлаг, ойн тундраар үүрлэнэ. Хуурай газарт хөвд овоолж, өд дэвссэн үүр барьж, 3-7 өндөг гаргана. Усны эргийн хуурай газарт бэлчих бөгөөд ургамлын зөөлөн найлзуур, үр, нахиагаар хооллоно [1,2].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой тодорхойгүй. Хавар, намрын нүүдлийн үедээ зүүн бүсийн нуур усаар тааралдана. Дэлхийн популяци 20-35 мянган толгой гэж тоологддог. Түүний 99.9 хувь нь ОХУ-ын нутагт үүрлэнэ. Сүүлийн 30 гаруй жилийн турш тоо толгой 6-7 дахин цөөрсөн [1-3]. Монгол орны хувьд энэ зүйлийн тоо толгой хомсдоход шууд нөлөөлөл байхгүй. Усны агнуурын бусад шувуудтай холилдон сүрэглэж тааралддаг тул хууль бус ан агнуурт өртөх боломжтой.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн. Азийн Улаан ном, ОХУ-ын улаан номонд орсон. Тархац нутгийг нь хэсэгчлэн хамгаалалтад авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Дайрч өнгөрөх газар нутгуудад хууль бус агнуурын хяналтыг сайжруулах, тоо толгойг судлан тогтоох, таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жизнь животных том VI, 1986, 2. Полевой определитель гусеобразных птиц России, 2011, 3. Mongolian Red List of Birds, 2011, 4. Фомин, Болд, 1991, 5. Даваа нар, 1994, 6. Болдбаатар, 2005 а, 7. Цэвээнмядаг нар, 2005, 8. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол.

## 10. БАЙГАЛИЙН НУГАС





*Anas formosa* Georgi, 1775

**Баг.** Галуутан - *Anseriformes*

**Овог.** Нугасныхан - *Anatidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Бие жижиг, 37 см. Далавчны урт 60 см, эр шувуу өвөрмөц дуу гаргадаг. Биеийн ерөнхий зүс бараан хүрэн, өд шаргал эмжээртэй, гадаад төрхөөрөө ногоохон нугастай төстэй. Хошуу харьцангуй том. Толгойн хажуугаар тал сар хэлбэрийн тод гялалзсан ногоон, цайвар шаргал толботой.

**Тархац, байршил нутаг:** Зүүн өмнөд Ази, БНХАУ, японд өвөлждөг бөгөөд сүүлийн үед Солонгост нийт популяцийн 95 хувь нь өвөлждөг болсон. Дэлхийн хэмжээгээр 800 гаруй мянган бодгаль бий [10]. Орхон, Сэлэнгийн хөндийгөөс дорно зүгт улсын хил хүртэлх нутгаар нүүдлийн үедээ дайрч өнгөрнө [6,8,9]. Буйр нуур, Халх, Нөмрөг, Онон, Улз, Хэрлэн голын савд ховор, Хөвсгөл нуурт маш ховор тохиолдоно [3,4,5,7]. Нуур, голын эрэг, өтгөн ургамалтай жижиг нууруудад байршина.

**Амьдралын онцлог:** Монголд нүүдлийн түрүүч III сарын эцэс, IV сарын эхээр ирж, V сарын эцэс, VI сарын эхээр нүүж өнгөрнө. Сүрэг, бүлэг, хосоороо нүүдэллэдэг. Нүүдэллэхдээ задгай ус, гол, горхи, нуурын зах, эрэг орчмоор байршиж, өвслөг ургамалтай намгархаг хэсгээр амарч, тарга хүчээ авна.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой, нөөцийн хомсдлыг судлаагүй. Өвөлждөг нутгууддаа 300000 ба түүнээс дээш тоогоор сүргэлдэг.


**Хамгаалсан байдал:** 1995 оноос агнахыг хуулиар хориглож, Монгол улсын Засгийн газрын

2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар оруулсан. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад бүртгэгдсэн [12]. Байршил нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн авсан [13].

**Хамгаалах арга хэмжээ:** Тоо толгой, нөөцийн хомсдол, нүүдлийг тогтоох, байршил орчны доройтлыг хязгаарлаж, хамгаалах сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Radde, 1863, 2. Пржевальский, 1876, 3. Дементьев, Наумов, 1966, 4. Болд, Эрэгдэндагва, 1970, 5. Болд, 1972, 6. Болд, 1989, 7. Сумъяа, Скрябин, 1989, 8. Фомин, Болд, 1991, 9. Piechocki, 1968, 10. Полевой определитель гусеобразных птиц России, 2011, 11. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 12. CITES, 1996, 13. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд, 2012.

## 11. УНДАР ШУМБУУР



*Aythya nyroca* (Gueldenstaedt, 1770)

**Баг.** Галуутан - *Anseriformes*

**Овог.** Нугасныхан – *Anatidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Биеийн урт 38-42 см. *Aythya* төрлийнхөн дотроо хамгийн жижиг. Бие гүйцсэн бодгалийн ерөнхий зүс бараавтар хүрэн зээрд. Далавчны тольт, сүүлний доод даруул цагаан. Толгой, хүзүү, цээж, биеийн хажуу бараавтар хүрэн зээрд, хэвлий цагаан. Хошуу цэхэр туяатай хар, хөл цайвар саарал. Залуу шувууд нь бие гүйцсэн эмтэй ижил ч нүд хар, биеийн зүс ерөнхийдөө бараан байдгаараа ялгарна [2].

**Тархац, байршил нутаг:** ОХУ-ын Европын хэсгийн өмнөд нутгуудаас Уралаас нааш Тюмень

хүртэл тохиолдоно. Баруун Европ, Баруун хойд Африк, Өмнөд Азиар тархсан. Газар дундын тэнгис, Африк, өмнөдөд Сомали, Баруун өмнөд Ази, Бирм хүрч өвөлждөг [1]. Монгол Алтайн нурууны Булган гол, Хөвсгөл аймгийн Дархадын хотгор, Бөөнцагаан, Хар ус, Өгий, Увс аймгийн Бага нууранд нүүдлийн үедээ таарна [3-12].

**Амьдралын онцлог:** Монгол оронд нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг, зусах байдлаар тохиолддог зүйл. Үржлийн тухай баримт хомс. Манай оронд зусах болон нүүдэллэн өнгөрч буй шувууд IV сарын сүүлч, V сарын эхээр цэнгэг болон давсархаг нуур, цөөрөм зэрэг усан санд ажиглагдана. Нуурын зэгс дотор газар дээр, эсвэл хөвөгч нягтарсан ургамал дээр зэгс болон ус намгийн бусад ургамлын иш, үндсээр үүр зассаны дараа эм өндөглөнө. Өндөгний тоо 7-10. Өндөгийг зөвхөн эм 25-28 хоног дарж, дэгдээхий гарсны дараа тэднийг асарч, хамгаална. Дэгдээхийг нисэх хүртэл эм нь асрах бөгөөд өндөг хагарснаас хойш 55-60 хоногийн дараа тэд бие дааж ниснэ. Үржлийн дараа, нүүдэллэхийн өмнө, эсвэл гуужих үедээ тэд томоохон сүрэг үүсгэнэ. Идэш тэжээл болох усны ургамлын үр, навч, иш, мөн усны шавж мэт сээр нуруугүйтэн, жижиг загас, мэлхийн шанаганцараар ус руу шумбаж, эсвэл толгойгоо усанд дүрж хооллоно. Манай оронд намрын нүүдэл VIII сарын сүүлч, IX сарын эхээр ажиглагдана [13,14].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг болон зусдаг нуур, цөөрмийн усны түвшин багасаж, зарим нуурууд хатаж ширгэж буй нь энэ зүйлийн амьдралд сөргөөр нөлөөлнө. Нуурууд дээр моторт завиуд олширсон нь тэдгээрийн хэвийн амьдралд сөрөг нөлөөтэй. Дөргөн болон Тайширын усан цахилгаан станцын нөлөөгөөр Завхан гол, Айраг, Зост нуурын ус татарч, эргийн зэгс багасаж буй нь энэ зүйл амьдрахад нэн таагүй болов [12]. Өгий, Бөөнцагаан, Хар, Хөвсгөл нуурт загасны тор ашиглан загас агнадаг нь идэш тэжээлээ шумбаж олдог энэ зүйлийн орооцолдон эндэх шалтгаан болно. Усны бохирдол, зэгс ашиглах, шувууны ханиад, идлэг болон эгэл шонхор, цагаансүүлт нөмрөгбүргэд зэрэг мах идэшт шувууд тэдний амьдралд нөлөөлнө [12]. Байршил нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [16]. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад байдаг [15]. 2001 оны Азийн ховор шувуудын Улаан ном [13], Монгол улсын Улаан номонд тус тус орсон.

**Хамгаалах арга хэмжээ:** Биологи, экологийг нарийвчлан судлах, тусгай хамгаалалттай нутгийн сүлжээ дэх усны ховор шувуудын хамгааллыг сайжруулах, мониторингийн судалгааг гүйцэтгэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Иванов, 1976, 2. Гомбобаатар нар, 2011, 3. Фомин, Болд, 1991, 4. Даваа нар, 1994, 5. Цэвээнмядаг нар, 2000, 6. Тэрбиш, Гомбобаатар, 2003, 7. Болд, 2005, 8. Болдбаатар, 2005 а, 9. Цэвээнмядаг, Болд, 2005, 10. Болдбаатар, 2008, 11. Арчимаева-Озерская, Забелин, 2010, 12. Гомбобаатар нар, 2011 б, 13. Harrison, 1975, 14. Birdlife International, 2001, 15. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, 2001, 16. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7

## 12. ЦЭН ТОГОРУУ



*Grus vipio* (Pallas, 1811)

**Баг.** Тогоруутан - Gruiformes

**Овог.** Тогорууныхан - Gruidae

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Бие том, 136 см, цайвар хөхсаарал зүстэй. Толгой, шил цагаан. Цээж бараандуу. Дэвүүрүүдийн үзүүр хар. Дух, шанаа улаан. Хөл улаавтар. Хошуу бор шаргал. Залуу тогорууны зулай, шилэн хүзүү улбар шар өдтэй [10].

**Тархац, байршил нутаг:** БНХАУ-ын зүүн хойт хэсэг, ОХУ-ын Чит мужийн баруун хязгаар, Амар мөрний хөндийгөөр цөөхөн хос тохиолдоно. Онон, Хэрлэн, Улз, Халх, Багтгах, Нөмрөг Хараа, Буур гол тэдгээрийн сав, Туул, Харвахын голын адаг, Булганы Айхан, Ховдын Хар ус нуур, Авдрант орчим нутгаар тааралддаг [1,2,6,10,11]. Солонгос, БНХАУ, Япон улсын нутагт өвлийг өнгөрөөнө [4]. Алаг өвст хээрийн голын нуга, зэгстэй нуур, голын дагуу өндөглөн зусна.

**Амьдралын онцлог:** Өвөлжсөн газраас III сарын сүүл, IV сарын эхээр анхны сүрэг, хосууд ирж эхэлнэ. Үржилд 3-4 нас хүрч орно. Дов сондуулын дунд 50-80 см өргөн үүрээ хагдарсан өвсөөр засч, IV сарын сүүл, V сарын эхээр 90.5 x 60.3 мм хэмжээтэй, улбардуу бүдэнтэй 2 өндөг гаргана. Орооны үедээ хосууд чанга дуугарч, тонгочиж, цовхчиж наадна. Өндгөө ихэвчлэн эм нь дарж, 30 гаруй хоногт дэгдээхий болгоно. Анхлан хагарсан өндөгний дэгдээхий үүрээ орхин холдоход хосууд дагаж, үлдсэн өндөг эзэнгүйдэнэ [6]. Дэгдээхий

шавж, хорхой, ургамлын үндэс, нахиагаар хооллон VIII сарын дундуур нисэх чадвартай болно. Үүрлэсэн, зуссан шувууд IX сараас сүрэглэж эхэлнэ. Алсын нүүдэл IX сарын сүүл, X сарын эхээр явагдана. Хятадын нутагт өвөлжинө [5].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Дэлхийд 2.5-3 мянга орчим бий [6]. Улз голын дагуу 1990 оны VII сард 189, 1991 оны IV сард Хэрлэнгийн Сүмийн цагаан нуур, Улз голын дагуу 51, 1992 оны VII сарын сүүлч, VIII сарын эхээр Улз, Ямалх голд 161, 1993 оны VIII сард Хэрлэн голын дагуу Чойбалсан хот хүртэл 20, 1994 оны IV сүүлчээр, V сарын эх хүртэл Хурхын гол Биндэр нуур, Цэгээний нуур, Онон Бархын цутгал, Шуусын гол, Улз, Дөч, Ямалхын гол дагуу 191, 1994 оны VII сүүлч, VIII сарын эхээр Улз, Онон голоор 246 бие гүйцсэн тогоруу, 29 дэгдээхий бүртгэв. 1994 оны IX сард Улзын савд 2500-3000 толгой цэн, хар тогорууны нийлмэл сүрэг тааралдсан байна. Монголд 800 орчим толгой зусч өндөглөдөг [6]. Сүүлийн жилүүдэд энэ шувууны үүрлэх нутаг манай орны баруун хойш тийш тэлж, Айхан нуурын хөндий, Тэшигийн олон нуур, Тарвагатайн, Хужирын нууранд өндөглөх болсон. 2013 оны 9-р сарын эхээр айхан нуурын хөндийд 36 тогоруу таарч байв [11]. Үржлийн хугацаанд олонтоо гардаг хээрийн түймэр, чоно, нохой, ойн солонго, бүргэд, хар ба хон хэрээ өндөг, дэгдээхийд онцгой аюул учруулна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор ховор амьтны жагсаалтад, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралтад [7], Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн II хавсралтад [12], Монгол улсын улаан ном, Азийн ховор шувуудын Улаан номонд [8] тус тус бүртгэсэн. Байршил нутгийн тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтад авсан. Онон Улзын голыг нутгийн иргэдээр амьдрах орчныг хамгаалуулах ажлыг Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/, орон нутгийн төрийн байгууллагууд хамтран зохион байгуулж байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Нэн ховор амьтны жагсаалтад бүртгүүлэх, байршил нутгийн хамгаалалтыг сайжруулах, өндөглөн зусдаг байршил нутгийн хүн, малын сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Фомин, Болд, 1991, 2. Оогачева и др, 1988, 3. Красная книга Бурятской АССР, 1988, 4. Арчибалд, 1982, 5. Птицы СССР, (Журавлеобразные) 1987, 6. Монгол улсын улаан ном, 1997, 7. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, 2001, 8. Birdlife International, 2001, 9. Монгол улсын Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолын хавсралт, 2012, 10. Болдбаатар, 2013, 11. Болдбаатар, 2013, 12. CITES, 1996.

### 13. ХАР ТОГОРУУ



*Grus monacha* Temminck, 1835

**Баг.** Тогоруутан - Gruiformes

**Овог.** Тогорууныхан - Gruidae

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Жижиг биетэй, өвөг тогоруунаас харьцангуй том. Толгой, хүзүү цагаан, бие хар, хар саарал зүстэй. Зулай улаан. Хөл хар. Залуу бодгалийн толгой, хүзүү бараан [1,5,6].

**Тархац, байршил нутаг:** Якут, Примор, Хабаровскийн хязгаарын зарим нутгаар өндөглөдөг. Солонгос, Япон, Хятадын нутагт өвөлждөг. Сибирийн шилмүүст тайгийн намагт өндөглөөд, нуур, голын хөвөө, тариалангийн талбай бараадан байршина. Монголд нүүдлийн болон зусах байдлаар тааралдана. Хэрлэн, Улз голоор хэдэн зуугаараа үзэгдэнэ. Архангайн Цагаан сүмийн аманд зусна [1-7].

**Амьдралын онцлог:** Тайгийн намгуудад IV сарын сүүлчээр үүрээ засч, 2 өндөг гаргана. Дэгдээхий YIII сард нисч эхэлнэ. Шавж, мэлхий, ургамлын үндэс, үр жимсээр хооллоно. YI сарын эхээр 10-30-аараа сүрэглэн ирнэ. Тариалангийн талбайд олноороо цугларч хаягдсан буудайн үрийг түүж иднэ. X сарын эхээр өндөглөх нутагтаа 5-10-аараа сүрэглэн ниснэ. Үржилд ороогүй бодгалиуд зусна.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Архангай, Өвөрхангай, Завханы нутагт нүүдлийн болон зуссан нийт 10 гаруй тохиолдол тэмдэглэгдсэн. 1990 оны хавар Улзын тариалангийн талбайд 700 гаруй, 1991 онд 2079, 1992 онд 107, 1994 онд 1891 тоологдсон. 1994 оны IX сарын сүүлчээр мянга гаруй тогоруу бөөгнөрөн байв [3]. Байгаль дахь нийт нөөц 7 мянга гаруй бий [4]. 2012 оны намар Айхан нуурын хөндийд 22 хар тогоруу тааралдсан [9]. Нүүдлийн үедээ


дайрч өнгөрдөг болон зусдаг нуур, цөөрмийн усны түвшин багасаж, зарим нуурууд хатаж, ширгэж буй нь энэ зүйлийн амьдралд сөргөөр нөлөөлнө.

**Хамгаалсан байдал:** 1995 оноос агнахыг хуулиар хориглосон. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралт [8], Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн II хавсралт [10], Монгол улсын улаан ном, Азийн ховор шувуудын Улаан номонд [7] тус тус орсон, байршил нутгийн зарим хэсгийг улсын тусгай хамгаалалтад авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Монгол улсын нэн ховор амьтны жагсаалтад бүртгэх, хэвийн өсч, үржих нөхцлийг бүрдүүлэх. Зэгстэй нууруудыг шувуу үржих, зусах хугацаанд зуслан, бэлчээрээс чөлөөлөх, хамгаалах сурталчилгаа зохион байгуулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Красная книга Бурятской АССР, 1988, 2. Фомин, Болд, 1991, 3. Арчибальд, 1982, 4. Красная книга РСФСР, 1983, 5. БНМАУ-ын Улаан ном, 1987, 6. Монгол улсын улаан ном, 1997, 7. Birdlife International, 2001, 8. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн лавлах, 2001, 9. Болдбаатар, 2013в, 10. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенц, 1999.

#### 14. ХАН БҮРГЭД



*Aquila heliaca* Savigny, 1809

**Баг.** Шонхортон - *Falconiformes*

**Овог.** Харцгайнхан - *Accipitridae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Биеийн урт 70-83 см. Бие гүйцсэн шувууны биеийн галбир, зүс бор бүргэдтэй

төсөөтэй. Нуруу, биеийн доод хэсэг хар хүрэн, толгой, шилэн хүзүү цайвар шаргал, дал мөр дээрээ цагаан толботой. Залуурын хөвөөлсөн хөндлөн судал бараан. Сүүлний уг хүртэл хөндлөн нарийн жижиг бараан судал олонтой, далавчны доод бүрхүүл хар хүрэн, дэвүүр өд бараан саарал, хөндлөн бараан судлуудтай. Залуу бодгаль бие гүйцсэнтэйгээ төсөөтэй ч шаргалдуу бор хүрэн толбо судал ихтэй, дал мөрний цагаан толбо хөгжөөгүй. Хошуу бараан саарал. Хөл, зэтэр шар [2,3].

**Тархац, байршил нутаг:** ОХУ, Унгар, Балкан, Пиренейн хойгууд, Кипр, Турк, Умард Иран, Мароккогээр тархсан. Африкт Эфиоп хүртэл, Өмнөд Азид Иракаас Өмнөд Хятад хүрэх нутгаар өвөлжинө [1]. Хэнтий, Хөвсгөлийн уулс, Орхон, Сэлэнгийн хөндийд үүрлэнэ. Нүүдлийн үедээ үржлийн нутаг болон Алтай орчмын ой, ойт хээрийн задгай хуурай хэсэг, уулын бэл, хөндий, Дундад Халх, Дорнод Монголын хээр, Ховд аймгийн Булган голын хөндийд тохиолдоно. Нүүдэллэж буй шувууд, Ховдын Хар ус нуур, Завхан гол, Сэлэнгэ мөрөн, Өвөрхангайн Хужирт, Орхон голын бэлчирт үзэгдэнэ. Сансрын дамжуулагчийн судалгаагаар, залуу шувууд ОХУ-ын урд хилээс Улаанбаатар хот орчим, улмаар Сүхбаатар аймгийг дамжин нүүдэллэнэ. Нүүдлийн үедээ ойт хээрээс цөлийн хээр хүртэлх уудам нутагт ганц нэгээрээ ховор тохиолдоно [4-20,24].

**Амьдралын онцлог:** Монгол оронд нүүдлийн өндөглөдөг, дайрч өнгөрдөг зүйл. Манай оронд үржлийн болон нүүдэллэж буй шувууд IV сарын сүүлч, V сарын эхээр тохиолдоно. Үржил V сарын сүүлч, VI сарын эхнээс эхэлнэ. Үржлийн хосууд тайга, ойт хээр, голын хөндийн шилмүүст, навчит холимог ойн хөгшин өндөр модонд модны мөчир, гишүүгээр том хэмжээтэй үүр барина. Эх, эцэг шувууд, ихэвчлэн эм бүүдгэр цагаанаас цайвар бор шаргалдуу дэвсгэр өнгөтэй, бор хүрэн, бор саарал толбо, судалтай 2-3 өндөг гаргаж, 43 хоног дарна. Ангаахайн тоо хос бүрт харилцан адилгүй ч, ангаахайн өсөлт, идэш тэжээлийн хангамжаас хамааран, үүрэнд ихэвчлэн 1-2 ангаахай бойждог. Ангаахай анхны нисэх оролдлогоо өндөгнөөс гарсны дараах 60 хоногт хийнэ. Голчлон эм үүрэндээ үлдэж, ангаахайгаа асарна. Ангаахай том болох үеэс эхлэн, эр, эм бодгалиуд жижгээс дунд хирийн биетэй мэрэгчид, туулай хэлбэртэн, мөн боршувуутны багийн шувуудаар тэжээнэ. Ангаахайнууд үүрнээс ниссэнээс хойш үүр орчимдоо байрших бөгөөд эр, эм нь тэжээсээр байна [21-26].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Үржлийн нутагт уул уурхай хөгжих, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх, аялал жуулчлалын бааз байгуулах нь өндөглөдөг шувуудын амьдрах орчныг сүйтгээд зогсохгүй, тэдгээрийн үр төлөө амгалан тайван бойжуулах нөхцлийг хязгаарлана. Түймэр энэ зүйлийн өндөглөх, зусах орчныг сүйтгэнэ. Намрын нүүдлийн үедээ шонхор баригчдын урхитай тагтааны урхинд орооцолдож эндэнэ. Намрын нүүдэл, үржлийн үедээ Үлийн цагаан оготно болон ойн хортны эсрэг хэрэглэсэн хорт бодист хордож эндэх аюултай [23].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралт болон Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн I, II хавсралтад бүртгэгдсэн [13, 24]. Азийн ховор




шувуудын Улаан номонд [13] орсон.

**Хамгаалах арга хэмжээ:** Биологи, экологийн нарийвчлан судлах, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ дэх ховор шувуудын хамгаалалтыг сайжруулах, мониторингийн судалгааг гүйцэтгэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Иванов, 1976, 2. Болд нар, 2001, 3. Гомбобаатар нар, 2011, 4. Козлова, 1930, 5. Mauersberger, 1979, 6. Шагдарсүрэн, 1964, 7. Piechocki et al., 1981, 8. Шагдарсүрэн, 1983, 9. Сумъяа, Скрыбин, 1989, 10. Фомин, Болд, 1991, 11. Даваа нар, 1994, 12. Цэвээнмядаг нар, 2000, 13. Birdlife International, 2001, 14. Сумъяа, 2002, 15. Тэрбиш, Гомбобаатар, 2003, 16. Болдбаатар, 2005а, 17. Цэвээнмядаг нар, 2005, 18. Гантулга нар, 2010, 19. Stubbe et al. 2010, 20. Өсөхжаргал нар, 2010, 21. Harrison, 1975, 22. Болд нар, 2005, 23. Гомбобаатар нар, 2011b, 24. CITES, 2001.

## 15. ООЧ ЁЛ



*Gyrfalconus barbatus* (Linnaeus, 1758)

**Баг.** Шонхортон - *Falconiiformes*

**Овог.** Харцгайнхан – *Accipitridae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Гадаад шинж:** Биеийн урт 130 см. Нуруу хар, өдний голын цагаан зураасууд тод харагдана. Том өдүүд мөнгөлөг туяатай. Толгой цагаан, эсвэл шаргалдуу, зулай дээрээ хар толботой. Хатуу өргөс мэт хурц өдөөс бүрдсэн, урагш чиглэсэн хар оочтой. Дэвүүр болон залуур өдүүд саарал, хэвлий цайвар шар, гүеэ хавиараа хар бидэртэй. Сүүлийн дунд өдүүд урт, захруугаа шаталсан тул зэв хэлбэртэй. Нүд шар, эсвэл цагаан бөгөөд улаан хүрээтэй. Хошуу эвэрлэг саарал, хумс хар [8].

**Тархац байршил:** Европ, Умардын дунд Азид *G.b.aureus*, Африкт *G.b.barbatus*, Зүүн ба өмнөд Африкт *G.b.meridonalis*, Өмнөд ба Төв Азийн уулархаг бүсээр *G.b.hemachalanus* хэмээх 4 зүйлхэн тархсан. Монгол оронд Монгол Алтай, Говийн Алтайн нуруу, Сайлюгем, Хархираа, Түргэн, Жаргалант Хайрхан, Алтан хөхий, Байтаг Богд, Тахийн шар нуруу, Аж Богд, Атас-Чингис, Эдрэнгийн нуруу, Алтан уул, Нэмэгт, Сэврээ, Тост, Гурван сайхан, Хүрх уул, Хангайн хүвчин нуруу зэрэг харьцангуй өндөр уулсаар, Хордил сарьдаг хүртэл *G.b.hemachalanus* дэд зүйл тархжээ. Бага газрын чулуу, Зоргол хайрхан, Хустайн нуруунд хадан цохионд нэг үржлийн хосыг дэгдээхийтэй үүрийг тэмдэглэсэн. Тэрхийн цагаан нуурын Хорго галт ууланд 2 дэгдээхийтэй үүрийг 2007 оны VII сарын 30-нд тэмдэглэсэн. Чойрын богд, Их сансар, Язаар уул, Хэрлэн тооно газарт 2013 онд, Дархан уул, Баянхутаг, Мөнххаан, Батхаан, Хөгнөхаан уул, Эрдэнэсант сумын Алтан уул түүний орчмоор 2013 онд ганц нэг бодгалийг тус тус тэмдэглэжээ [6].

**Амьдралын онцлог:** Өндөр уулс, тэдгээрийн бэл, хормой нутаг, элгэн хад цохиотой, гүн хавцалтай газруудаар амьдарна. Хаврын эхэн сар I сарын дундаас үүрээ хүн, амьтан хүрэхэд бэрх, хөмөг, тавцан дээр бут, бургасны мөчрөөр засч хагдарсан өвс, яс, бүс даавуу, эсгийний өөдөс, нэхий, ноосоор дэвсгэр хийнэ. Үүрээ олон жил ашигладагаас жил бүр засаж сэлбэснээр тэр асар том болно. Зарим судлаачид, энэ зүйлийг XII-I сард өндөглөдөг, зарим нь II сард өндөглөдөг хэмээх мэдээнээс үзэхэд, энэ зүйл өвлийн ид хүйтэнд өндөг гаргадаг байна. 4-5 хоногийн зайтай 2 өндөг гаргаж, 60 хоног орчим түүнийг дарж ангаахай болгоно. Ангаахай VII сарын эхээр үүрээ орхино. Сэг, зэмээр хооллох боловч хааяа залуу, сул дорой амьтан барина.


**Тоо толгой хомсдох шалтгаан:** Монгол улсын уулархаг хэсгийн энэ шувууны тоо толгойн тооллого хийгдээгүй боловч ердийн зүйлд тооцогдоно. 1993 оны байдлаар, дэлхийн улс орны 29 амьтны хүрээлэнд, амьтан үржүүлэх төвүүдэд 97 бодгаль байна. Манай оронд сүүлийн жилүүдэд олноор түр орж ирэх болсон хажирын үүрлэх орчны гол өрсөлдөгч болж, хуучин үүрүүдийг булаан эзэмших болсон нь Говь Алтайн зарим уулсаар ховордох шалтгаан болж байна [9].

**Хамгаалсан байдал:** 1953 оноос хуулиар агнахыг хориглож, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [7], Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралт [5] болон Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн I, II хавсралтад [4] тус тус бүртгэгдсэн. Тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Хангайн нуруу, Говь гурван сайхан, Говийн их дархан газар, Хар ус нуур (Жаргалант хайрхан) Хөх сэрх, Алтай Таван Богд, Отгонтэнгэр, Цагаан шувуут, Түргэн уул, Хан Хөхий зэрэг газарт нэн ховор, ховор зүйлийн шувуудын хамгаалалтын менежментийг бий болгох, Суман гол, Чулуутын хавцалын хамгаалалтыг сайжруулах. Ёлыг гоёл чимэглэл, уламжлалт анагаах ухааны чиглэлээр ашиглахгүй байх, таниулан сурталчлах ажлыг сайжруулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дементьев нар, 1951, 2. Шагдарсүрэн, 1983, 3. Фомин, Болд, 1991, 4. Birdlife International, 2001, 5. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, 2001, 6. Mongolian red list of birds, 2011, 7. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 8. Болдбаатар, 2013 б, 9. Болдбаатар, 2002.

## 16. АЗИЙН ЦУУЦИЛ



### *Limnodromus semipalmatus* Blyth, 1848

**Баг.** *Хуазтан - Charadriiformes*

**Овог.** *Хомноотынхон – Scolopacidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна [20].

**Таних шинж:** Бие гүйцсэн эрийн дух, зулай, дагз дундуураа тууш бараан хүрэн, өд улбар шар эмжээртэй. Хошууны угаас нүд рүү цагаавтар, түүнээс арай доогуур завжийг дайрсан харавтар судалтай. Бие зэвэн улбар зүстэй. Хэвэл хүрэн, дунд хэсгээрээ цагаавтар. Биеийн хажуу тал нарийхан цагаан судалтай. Эм, эрийн адил зүстэй боловч, арай хүрэндүү бүдэг, хэвэл хүрэвтэр туяа бүхий цайвар.

**Тархац, байршил нутаг:** Дэлхий дээр ОХУ, Кени, Имен, Казакстан, Араб, Узбекстан, Энэтхэг, Хятад болон зүүн өмнөд Азийн нутгуудаар тархсан. Нууруудын хөндий, Их нууруудын хотгор, Хөвсгөл, Хэнтий, Орхон Сэлэнгийн сав, Монгол Дагуур, Хянганы нутгаар нүүдэллэх, өндөглөн зусах байдлаар тааралдана [6,9,10]. Айраг, Орог, Цайдам, Хөвсгөл, Буйр нуур, Халх, Бороо голын савд өндөглөн зусна [1,2,4,5,7,9]. Үржлийн болон нүүдлийн үед

тойром, бүрд, нуурын зөөлөн хөрстэй, намхан эрэг хөвөө, намаг, чийглэг нуга, хаялга, гол мөрдийн ил задгай намгархаг газар идээшин нутаглана [2,6,12,13-19].

**Амьдралын онцлог:** Амьдрал, үржлийг бараг судлаагүй. Хавар V сарын дундаас VI сарын эх хүртэл нүүдэллэнэ. Хөвсгөл нуурын Хороо, Ханх голын адгаар V сарын 2-р хагасаас VI сарын эхээр нүүдэллэн өнгөрч зарим жилд өндөглөдөг. VI сарын эхээр орооны өнгө зүстэй, үрийн булчирхай томорсон эр үзэгдэнэ [7,9]. Үүрээ шигүү өвсөн дунд засч, сайн далдална. Голын адгаар буурал хараалай, бүрдний хөгчүү, морин цууцилтай хамт үүрлэдэг онцлогтой. V сарын эцэс, VI сарын эхээр хаяа 1-3, ихэнхдээ 2, хүрэн толботой ногоовтор өндөг гаргана [3]. Дэгдээхий VI сарын сүүлч, VII сарын эхээр гарч, мөн сарын сүүлчээр нисдэг. Хирономид, хануур хорхой, усч цох, түүний авгалдай, элдэв шавжийн үлдэгдэл, ургамлын үр амьтны гаралтай зүйлсээр хооллоно [7,9]. Намрын нүүдэл VIII сард болно.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой тодорхойгүй. Үүрлэж, өндөглөх тохиромжтой нутаг хомсдох, амгалан байдлыг алдагдуулснаас цөөрнө. Түүнчлэн усны төвшний өөрчлөлт, гэнэтийн хүйтрэл, үргэлжилсэн бороо, үер зэрэг цаг агаарын тааламжгүй байдал үүр, өндөг, залуу бодгалийг цөөрүүлдэг. Мөн махчин амьтад үржилд нөлөөлнө.

**Хамгаалсан байдал:** 1995 оноос агнахыг хуулиар хориглож, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [21]. Хөрш зэргэлдээх орны болон Олон улсын улаан ном, Монгол улсын улаан номонд /1997/ тус тус бүртгэгдсэн. Байршил нутгийг Дорнод Монгол, Монгол Дагуур, Нөмрөгийн дархан цаазат газруудад хамруулсан. Сүүлийн жилүүдэд Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн хавсралтад бүртгэгдсэн [22] нууруудад хэсэгчлэн хамгаалагдаж байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой судалж тогтоох, шувуу олноороо үүрлэдэг нутгийн зэгсийг хадахгүй байх, улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын шувуудын хамгаалалтын менежментийг бий болгох.

**Эх зохиол, мэдээ:** 1. Сушкин, 1925, 2. Козлова, 1930, 3.Гладков, 1964, 4. Певцов, 1951, 5. Болд, Эрэгдэндагва, 1970, 6. Болд, 1973, 7. Гүрбадам, Сумъяа, 1982, 8. Болд, 1989, 9. Сумъяа, Скрябин, 1989, 10. Фомин, Болд, 1991, 11. Kleinstauber, Succow, 1971, 12. Lonnberg, 1909, 13.Тэрбиш, Гомбобаатар, 2003, 14. Дэлгэрмаа нар, 2004, 15. Болд, 2005, 16. Болдбаатар, 2005а, 17. Цэвээнмядаг, Болд, 2005, 18. Цэвээнмядаг нар, 2005, 19. Гомбобаатар нар, 2005, 20. Mongolian Red List of Birds, 2011, 21. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 22. RAMSAR, 1997.

17. МОНГОЛ ХУЛАНЖОРОО



*Podoces hendersoni* Hume, 1871

**Баг.** Бор шувуутан - *Passeriformes*

**Овог.** Хэрээнийхэн - *Corvidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Биеийн урт 30 см. Бие гүйцсэн эр, эмийн зулай, далавчны бүрхүүл, хоёрдугаар зэргийн дэвүүр өдүүд, нэгдүгээр зэргийн дэвүүр өдний үзүүр, сүүл гялалзсан хөхөвтөр туяатай хар өнгөтөй. Хүзүү цайвар, нуруу боровтор хул, сүүлний бүрхүүл өд элсэн шаргал, хэвэл цайвар хул зүстэй. Хошуу, хөл хар. Гүйх дуртай. Алсаас сонсогдох хонх шиг жингэнэсэн дуутай [8].

**Тархац, байршил нутаг:** Зүүн гар, Кашгар, Алааш, Цайдам, Ордос, Синь-зянь, Ганьсугаар тархана. Монголын цөл, цөлөрхөг хээр, хуурай хээрийн урд хэсэг, Алтайн өвөр говиор тархжээ. Жижиг чулуурхаг, хужир мараа бүхий заг, сухай, сөөг ургамалтай элсэрхэг цөл баян бүрд, уул толгодын сайртай нутгаар суурин амьдарна [3,8].

**Амьдралын онцлог:** Модлог ургамал дээр газраас дээш 80-100 см-ийн өндөрт модны мөчир зулж, тэмээ, хонины ноос, өдөн зөөлөвч дэвсэж шавраар шавсан үүр барина. Өндөг цагаан саарал өнгөтөй, бараан толботой. Ихэвчлэн 3-4 өндөг гаргана [1]. V, VI сард ангаахай үзэгдэнэ [5]. Төрөл бүрийн шавж, ургамлын үр, гүрвэлээр хооллоно. Зуны сүүлчээр голио, царцаа, бусад хатуу, сарьсан далавчтан шавж иднэ. Заримдаа хулан жорооны ходоодонд дан хонин гүрвэл тохиолдож байв [3].


**Тоо толгой, хомсдох шалтгаан.** Махыг уламжлалт эмнэлэгт эмийн зориулалтаар хэрэглэдэг хэмээх буруу ойлголтоор агнах, мод сөөгийг их хэмжээгээр түлшинд ашиглах зэргээс амьдрах орчин доройтож, тоо толгой цөөрч байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж [8], Монгол улсын улаан номонд [6] оруулсан. Байршил нутгийг улсын тусгай хамгаалалтад хэсэгчлэн авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Нутгийн иргэдэд хамгаалахын ач холбогдлыг сурталчилан ойлгуулж, эмийн зориулалтаар хууль бусаар ашиглалтад тавих хяналтыг сайжруулах, нутгийн иргэдэд түшиглэсэн менежментийг бий болгох.

**Эх зохиол, мэдээ:** 1. Козлова, 1975, 2. Жизнь животных, 1986, 3. Болдбаатар, 1981, 4. Piechocki, 1972, 5. Тугаринов, 1929, 6. Монгол улсын улаан ном, 1997, 7. Mongolian Red List of Birds, 2011, 8. Монголын засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 8. Болдбаатар, 2013 б.

## 18. ХОНИН ТООДОГ



*Otis tarda* Linnaeus, 1758

**Баг.** Тогоруутан - Gruiformes

**Овог.** Тоодогийнхон - Otididae

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Биеийн жин, нас, хүйс, тарга хүчнээс шалтгаалж харилцан адилгүй. Биеийн урт 100 см, 16 кг жинтэй том шувуу. Далавч харьцангуй урт, мохоо. Сүүл уртавтар. Эр тоодог эмээсээ биеэр арай том. Нуруу ухаа зээрд, хөндлөн хар бараан бидэртэй, толгой, хүзүү үнсэн саарал, хүзүүний уг, хэнхдэг зээрд, хөндлөн бараан бидэртэй. Хоёр шанааны орчимд сахал маягийн урт нарийн цайвар багц өдтэй. Цээж, суга, хэвэл, далавчны доод өд цагаан. Сүүлний захын хоёр өд үзүүрээсээ хар хашлагатай цагаан, бусад өд үзүүр уруугаа цагаан зээрд оройн

хэсэгтээ хөндлөн хар судалтай. Харьцангуй өндөр хөлтэй, гурван хуруутай [2,7].

**Тархац, байршил нутаг:** Монголын тал хээрийн нутгаар өргөн тархацтай байсан энэ шувуу Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Завхан, Увс аймгийн зэлүүд талд маш цөөн тоогоор үзэгдэх болжээ [6-30]. Төв аймгийн Жаргалант, заримдаа Дорнодын Лаг нуурын хавьд цөөхөн тоодог өвөлждөг байсан [4]. Сүүлийн жилүүдэд Эг, Тарвагатай, Тариалан, Эрдэнэбулган сумдын тариан талбайд 20-100 заримдаа түүнээс олон толгой тоодог өвөлждөг болсон [6,7].

**Амьдралын онцлог:** Монголд тоодог III сарын сүүлчээр хосоороо эсвэл сүргээрээ нүүдэллэн ирнэ. Ороо өвөрмөц. Эр бодгалиуд дэвхцэж, цамнах бөгөөд 2-3 эм цугларч, хамгийн томыг сонгон хос үүсгэнэ. Эр 5-6 насандаа, эм 3-4 насандаа бэлэг боловсорч үржилд орно. Бүл үүссэний дараа эм газарт үүр засаад, 2-3 ногоовтор бор өндөг гарган, 21-28 хоног дарна [2]. Эм дэгдээхийгээ бойжуулж, эр ганцаараа эсвэл хэд хэдээрээ нийлж, тал нутгаар хэрэн бэлчээрлэнэ. Төрөл бүрийн үет ургамлын үр, үндэс, нахиа найлзуур, цох, дэвхрэг, хорхойгоор хооллоно. Заримдаа гүрвэл мэлхийг ч идэх тохиолдол бий [1].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгойг тогтоогоогүй. Байршил нутагт мал бэлчээрлүүлэх, хадлан авах, газар тариалан эрхлэх, химийн бодис хэрэглэснээс идэш, тэжээл хомсдох, зуданд нэрвэгдэх, хулгайгаар агнах зэрэг байгаль, хүний үйл ажиллагааны шууд болон дам нөлөөнөөс эрс цөөрсөн. Дэгдээхийг шилийн сар, намгийн сахиа, бие гүйцсэн эм, залуу бодгалийг бүргэд барина. Өндгийг үнэг, хярс, чоно, нохой иддэг [4]. Зарим шимэгчдээр өвчилдөг [5,6].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [9], Зэрлэг амьтан, ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад [10], ОХУ-ын улаан ном, Монгол улсын улаан ном [5,8]-д тус тус оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулах, өвөлжих байршил нутгийг тусгай хамгаалалтад авах, зориудаар өсгөн үржүүлэх замаар байгалийн нөөцийг нөхөн сэргээх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Красная книга Бурятской АССР, 1988, 2. Птицы СССР, Курообразные, Журовлеобразные, 1987, 3. Жизнь животных, том VI, 1986, 4. БНМАУ-ын Улаан ном, 1987, 5. Красная книга РСФСР, 1983, 6. Mongolian Red List of Birds, 2011, 7. Болдбаатар, 2013 б, 8. Монгол улсын улаан ном, 1997, 9. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2013, 10. CITES, 2001.

## 19. ЖОРОО ТООДГОЙ



*Chlamydotis undulata* (Jacquin, 1784)

**Баг.** Тогоруутан - *Gruiformes*

**Овог.** Тоодогийнхон - *Otididae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “эмзэг” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Тоодогнуудаас хамгийн жижиг. Эр, эм тоодогийн нуруу, далавчны дээд тал цайвар шарга зүстэй, хэвэл цагаан. Далавчны хүчлэх дэвүүр, өдний үзүүр хар бараан, сүүлний үзүүр цагаан, угаараа бордуу хөндлөн зураастай. Толгойдоо урт, зөөлөн өдөн залаатай. Чихний араас хүзүүний хоёр талыг дагасан урт хар зурвастай. Хошуу хар. Эрүүний уг цайвар, хөлдөө гурван хуруутай. Эр тоодгой эмээсээ ялимгүй том. Гүйх дуртай.

**Тархац, байршил нутаг:** Африк, Араб, Дунд, Төв Азийн цөлөрхөг нутагт тархана [1]. Монголд: Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Алтайн өвөр, Номин, Галбын говиудаар тааралдана [1-3]. Тархацын зүүн зах Дорноговь аймгийн Цагаан элс, баруунаа Алтайн өвөр говь, Монгол; Говь Алтайн уулсын ар, Хангайн нурууны өврөөс Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, баруун хойшоо Увсын Давст, Малчин сумдын нутаг хүртэл цөл, цөлөрхөг хээр, уулсын хөндий даган д.т. 2700 м өргөгдсөн нутгуудад ховор тааралдана. Заг, хармаг, харгана, зээргэнэ, баглуур, бударгана, сийрэг ургасан хялгана таанатай тэгш, жижиг гүвээ толгод, элсэн довцогтой нутгуудад байршина [2].

**Амьдралын онцлог:** Хавар нүүдэллэн ирснийхээ дараа хосоороо салж, үүрээ газарт засч, 1-3 өндөг, заримдаа 4 өндөг гарган, 21-24 хоног дарж, дэгдээхий болгоно [2,6]. Дэгдээхий сарын дараа нисэх чадвартай болно. Эр бодгаль өндөг дарах, дэгдээхий торниулахад оролцохгүй. Хоёр нас хүрч үржилд орно. IX сарын дунд үе, X сараас дулаан орны зүг бүлээрээ нүүнэ [3].




**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Монголд 200-300 толгой жороо тоодог байдаг. 1975-1981 оны VII-IX сард явуулсан судалгаагаар, 50 орчим бодгаль байв [2,9]. 1985, 1987, 1989 онуудын VII-VIII сард Дорноговь аймгаас Борзонгийн говиор дайрч, Алтайн өвөр говь, Номингийн говийг туулан 500 км аялахад, 7 тоодог тоологдсон [3]. 1989 оны VI сарын дундуур Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн нутагт тохиолдож байснаас үзэхэд, монголд нэн ховордсоныг гэрчилнэ. Хулгайгаар агнах, байршил нутгийн тайван байдлыг алдагдуулснаас тоо толгой ихээхэн хорогдож байна. Шонхор, бүргэд зэрэг махан идэшг амьтад дэгдээхий, бие гүйцсэн тоодогийг барьж иддэг [2].

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэж, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцийн I хавсралт [10], Монгол улсын улаан ном /1987, 1997/ [2], Азийн улаан ном [8]-онд тус тус оруулсан. Байршил нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, зориудаар өсгөн үржүүлэх, хамгаалах сурталчилгаа хийх, байршил нутгийн хамгаалалтыг сайжруулах, энэ зүйлийг гаршуулан үржүүлэх замаар тоо толгой, нөөцийг нэмэгдүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жизнь животных том VI, 1986, 2. БНМАУ-ын улаан ном, 1987, 3. Курочкин, Михайлов, 1992, 4. Монгол-Зөвлөлтийн хамтарсан экспедицийн тайлан, 1975-1981, 5. Болд, 1981, 6. Красная книга РСФСР, 1983, 7. Mongolian Red List of Birds, 2011, 8. Азийн улаан ном, 2001, 9. Монгол улсын улаан ном, 1997, 10. CITES, 1996.

## 20. УСНЫ БУХШУВУУ



*Botaurus stellaris* Linnaeus, 1758

**Баг.** Өрөвтасман - *Ciconiiformes*

**Овог.** Дэглийнхэн - *Ardeidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Биеийн урт 76 см, том биетэй, харьцангуй богино хөлтэй, хүчирхэг урт, шаргал хошуутай шувуу. Далавчны дэлгээ урт 117 см. Эм арай бага. Нуруун тал хар бөгөөд шаргал эмжээртэй өдүүдтэй, толгойн дээд тал мөн тийм хар. Сүүл богино, шаргал хүрэн, дээрээ хөндлөн хар судалтай. Биеийн ерөнхий зүс зэгсний сүүдэрлэгдсэн хэсгийн өнгөнд зохицсон [1,17].

**Тархац, байршил:** Энэ шувууны үүрлэх нутаг Баруун Европоос дорно зүгт Сахалин ба Японы арлууд хүрнэ. Өмнөдрүү Африкийн урд үзүүр, умардад тундрын бүсийн өмнөд хил хүртэл тархана. Газар дундын тэнгис, Дорнод ба Төв Африк, Энэтхэг, Бирм, Зүүн Өмнөд Хятадад өвөлжинө [1,18]. Манай орны эргээрээ өтгөн шигүү зэгс, хулстай Орог, Бөөнцагаан, Дөргөн, Хар, Хар ус, Айраг, Увс, Хөвсгөл, Буйр, Ташгайн таван нуур зэрэг бараг бүх том, жижиг нуурууд, Завхан, Ховд, Орхон, Сэлэнгэ, Туул, Хэрлэн, Онон, Улз, Халх, Нөмрөг, Дэгээ, Азрага гол зэрэг голын сав нутгаар амьдрах бөгөөд үүрлэж өндөглөнө [3-16].

**Амьдралын онцлог:** Өтгөн шигүү зэгс, хулстай нуурын хулсны гүнд амьдарна. Хосоороо үүрлэнэ. Заримдаа нэг эр шувууны эзэмшил нутагт 3 эм шувуу үүрлэх тохиолдол бий. Янз бүрийн ургамлын навч, ишээр харьцангуй том үүр засч 5-р сарын дунд үеэс 3-6 бор-ногоон өндөг гаргана [1,17]. Эм шувуу ганцаараа 21-26 хоног өндөг дарна. Бүх шувуу үүрлэн амьдарч байгаа газартаа бүх урамдах адил дуу гаргана. Энэ дуу 1-2 км алсад сонсогдоно. Хулсан дунд ангуучлан отоож зогсохдоо хошуугаа дээш өргөн, түүний хоёр хажуугаар харж байдаг. Зэгс хулс салхинд найгавал дагаж найгадаг тул тэр болгон бусдад ажиглагдахгүй. Жижиг загас, хоёр нутагтан, усны шавж, бусад сээр нуруугүйтнээр хооллоно [1,17].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Олон жилийн дараалсан ган, нуурын эргийн бэлчээр талхагдалт, үржлийн нутгийн тайван байдал алдагдах, ус нуурууд хатаж ширгэх зэргээс шалтгаалан тархац нутаг, үржих газар хомсдох болсон.


**Хамгаалагдсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [19]. Тархац нутгийн тодорхой хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдан хамгаалагдсан.

**Хамгаалах арга хэмжээ.** Үржлийн нутгийн тайван байдлыг алдагдуулахгүй байх. Нуур, голын эргийн хамгаалалтын бүс тогтоож, мал бэлчээрлүүлэхгүй байх, холбогдох олон улсын конвенцуудын хавсралтад бүртгүүлэх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулах, тоо толгойг нарийвчлан тогтоох.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жизнь животных том VI, 1986, 2. Козлова, 1930, 3. Сумьяа, Скрябин, 1989, 4. Фомин, Болд, 1991, 5. Даваа нар, 1994, 6. Сумьяа нар, 2000, 7. Цэвээнмядаг нар, 2000, 8. Тэрбиш, Гомбобаатар, 2003, 9. Болд, 2005-, 10. Болдбаатар, 2005а, 11. Майнжаргал, 2005, 12. Цэвээнмядаг, Болд, 2005, 13. Цэвээнмядаг нар, 2005, 14. Болдбаатар, 2008, 15.

Озерская, Забелин, 2010, 16. Болдбаатар нар, 2013, 17. Справочник определитель птицы Европы, 2003, 18. Mongolian Red List of Birds, 2011, 19. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012.

## 21. БИЧИЛ ОДОЙБУХ



*Ixobrychus minutus* (Linnaeus, 1766)

**Баг.** Өрөөтасман - *Ciconiiformes*

**Овог.** Дэглийхэн - *Ardeidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Биеийн урт 27-36 см. Бие гүйцсэн эрийн толгойн орой, дагз, нуруу хөхвөр туяатай хар, хоолой, цээж, хэвлий, далавчны дээд бүрхүүл улбар шаргалдуу өнгөртэй цайвар шаргал. Толгой, хүзүү нарийхан. Нэгдүгээр зэргийн дэвүүр өд хар. Далавч хөх саарал. Суга цагаан. Эмийн нуруу судал толбо ихтэй бараавтар хүрэн бор. Цээж, хэвлий улбардуу хүрэн, цайвар шаргал, хар нарийн тууш судлуудтай. Залуу нь бие гүйцсэн эмтэй төсөөтэй ч биеийн доод хэсэг тууш судал ихтэй, арай бүдэг зүстэйгээрээ ялгарна. Хошуу шар ногоон, саарал [1].

**Тархац, байршил нутаг:** Хар ус, Хар, Хяргас, Айраг нуур, Ховд голын бэлчирийн зэгстэй хэсэгт үүрлэнэ. Нүүдлийн үедээ Увс нуур, Тэсийн голын бэлчир, Халх, Дэгээ, Нөмрөг, Азрага, Галдастайн гол, Буйр, Хонхор, Ташгайн таван нуурын хөндийн зэгс шагшуургатай орчинд тохиолдоно. Нүүдлийн тэнэмэл бодгалиуд Төв аймгийн Батсүмбэрийн Үдлэг, Говийн зарим баян бүрдэд тэмдэглэгдсэн тухай мэдээ бий [2-8].

**Амьдралын онцлог:** Монгол орны хувьд нүүдлийн өндөглөдөг зүйл. Манай оронд үржлийн болон нүүдэллэж буй бодгалиуд IV сарын сүүлч, V сарын эхээр ирнэ. Үржлийн хосууд V

сарын сүүлч, VI сарын эхээр зэгс, бутлаг ургамал, намгийн үетэнтэй нуур, гол, цөөрөм орчимд байршиж, үүрээ битүү зэгс дунд газар дээр, эсвэл зэгс дотор хөвмөл нягтарсан ургамал дээр зэгс, усны ургамлаар засна. Бүүдгэр цагаан өнгөтэй ихэвчлэн 5-6 өндөг гаргаж 16-19 хоног дарна. Ангаахайгаа усны сээр нуруугүйтэн, жижиг загас, хоёр нутагтан зэргээр үүрэндээ 7-9 хоног хооллоно. Ангаахай өндөгнөөс гарснаас хойш нэг сарын дараа ниснэ. Манай оронд үүрлэсэн болон дайран өнгөрч буй бодгалиуд гол, нуур, цөөрмийн хөндийн зэгс, өндөр ургамалжилт, буттай хэсгээр голчлон ганцаараа VIII сарын сүүлч, IX сарын эхээр тохиолдоно [8].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Малын тоо олшрох, дэлхийн уур амьсгалын дулааралт, хуурайшилтай холбоотой ус, намаг ширгэснээр түүний амьдрах орчин ихээр доройтож, бэлчээрийн талхагдалт, Дөргөн, Тайширын усан цахилгаан станцын нөлөөлөх усны бохирдол нэмэгдэх, томоохон нууруудад загасны тор ашиглан загасчлах, шувууны ханиад зэрэг халдварт өвчин, саарал чоно, нохой, элбинх зэрэг махан идэшг амьтад тоо толгойд дам болон шууд замаар сөргөөр нөлөөлнө [8].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [9]. Үржлийн болон нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг газар нутаг нь Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцид Хар ус, Айраг, Буйр зэрэг нууруудыг хамруулсны зэрэгцээ улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд байрших шувуудын хамгаалалт менежментийг сайжруулах, бүсчилсэн мониторингийн судалгаа явуулах, үржлийн биологи, нүүдэл, шилжилт, хорогдлыг судлах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Gombobaatar et al., 2011, 2. Фомин, Болд, 1991, 3. Даваа нар, 1994, 4. Цэвээнмядаг нар, 2000, 5. Тэрбиш, Гомбобаатар, 2003, 6. Болдбаатар, 2008, 7. Арчемаева-Озерская, Забелин, 2010, 8. Гомбобаатар нар, 2011 б, 9. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 10. Mongolian Red List of Birds, 2011.

## 22. ЗЭЭРД ДЭГЛИЙ



*Ardea purpurea*

**Баг.** Өрвийтөн - *Ciconiiformes*

**Овог.** Дэглийнхэн - *Ardeidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна.

**Гадаад шинж:** Биеийн урт 70-90 см. Далавч 325-400 мм. Бие гүйцсэн шувуу урт нарийн хүзүүтэй, хөх дэглийнээс урт сунасан бие, нарийн, урт хөл хүзүүтэйгээрээ ялгарна. Шил хүзүү, нуруу бүдэг хүрэн өнгөртэй хөхвөр саарал, мөрний өд улаан бор. Хүзүү дагасан зэвэн улаан, нарийн хар судалтай. Хэвлий, цээж бараан. Хошуу шар. Хөл шаргалдуу бараан саарал. Залуу шувууны зүс бор шаргалдуу хүрэн, хоолой, цээж нарийн хар, цайвар судлуудтай [8].

**Тархац, байршил нутаг:** Өмнөд Европ, Өмнөд Ази, Африкаар тархсан. Халх, Нөмрөг голын хөндий, Буйр нуур Ташгайн Таван нуур (Буйр нуур-Халх гол-Хянганы бүс нутаг)-аар, Баян нуур, Улз голын адаг, Монгол дагуур болон Өгий нуур, Тэрхийн Цагаан нуурын ус намгархаг газарт тохиолдоно. 2003 оны VI сард Халх голын Буйр нуурын орчмоос анхны үржлийн хосыг тэмдэглэсэн. Энэ хос шувууд зэгс, шагшуурган дунд үүрээ барьсан 3 дэгдээхийтэй үүрийг олсон [1-7].

**Амьдралын онцлог:** Үржил IV-VI сард явагддаг. Үүрээ нарийн мөчир, зэгс шагшуургын ишээр эсвэл бут модыг ашиглан барина. Ихэвчлэн 2-5 өндөг гаргах буюу заримдаа 3-8 өндөг гаргана. Өндөг гялгар цонхигор ногоовтор-цэнхэр өнгөтэй. Өндгөө 24-28 хоног дардаг. Эр, эм шувууд 42 хоног тэжээнэ. III сарын дараа биеэ даан амьдарна. Залуу шувууд нэг жилийн дараа үржилд орно. Бие гүйцсэн болон залуу шувууд ихэвчлэн жижиг хөхтөн, хоёр нутагтан, гүрвэл, жижиг загас, усны сээр нуруугүйтэн, шавжаар хооллоно. Өвөлдөө зүүн өмнөд Ази руу шилжин нүүдэг. Нүүдлийн үедээ ОХУ-аас Сингапурт нүүж ирдэг. IX сараас эхлэн өвөлжих

нутгийн зүг нүүдэл шилждэг.


**Тоо толгойн хомсдох шалтгаан:** Дэлхийд тоо толгой нь 270.000-570.000, үржлийн нутаг 22.400.000 км<sup>2</sup> талбайг эзэлнэ. Монголд тоо толгой болон хомсдолыг нарийвчлан судлаагүй. Тархац нутгийн хэмжээ бага, судалсан мэдээ байхгүй.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [6]. Тархац нутгийг Нөмрөг, Монгол дагуурын дархан цаазат газарт болон Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн Буйр нуур, Тэрхийн цагаан нуур, түүний орчмын ус, намгархаг газарт хамруулсан [9].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой, биологи, экологийн нарийвчилсан судалгааг хийх, амьдрах орчин болон байршил нутгийн зэгс, ургамлан бүрхэвчийг хамгаалах, хамгаалалтын менежментийг сайжруулах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1.Фомин, Болд, 1991, 2. Даваа нар, 1994, 3.Горошко, 2003, 2004, 4. Brunlich, 2006 а, 5. Цэвээнмядаг аман мэдээ, 6. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 7. Mongolian Red List of Birds, 2011, 8. Цэвээнмядаг нар, 2005, 9. RAMSAR, 1997.

## 23. МАНХИН ГАЛУУ



*Anser albifrons* (Scopoli, 1769)

**Баг.** Галуутан - *Anseriformes*

**Овог.** Нугасныхан – *Anatidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [12].

**Таних шинж:** Биеийн урт 70 см. Нуруу бараан, өдний цайвар эмжээр нь далавч, биеийн хажуугаар хөндлөн судлууд үүсгэнэ. Духны цагаан толбо эхний хавар үүсдэг боловч зарим бие гүйцсэн шувуунд илрэхгүй байдаг. Ерөнхий зүс хүрэн саарал, хүзүү, толгой хүрэн. Сүүлийн дээд ба доод бүрхүүл өд, сүүлийн эмжээр цагаан. Хөл улбар улаан, хошуу ягаан. Саарал цээжин дээр нь хөндлөн бараан судал буюу толботой [1,2].

**Тархац, байршил нутаг:** Үүрлэлтийн үедээ Канины хойгоос Дорнод Чукотк хүртлэх газрын тундрын бүсэд тохиолдоно. Мөн Дорнод Якут, Агнуурын тэнгис ба Хойд Америкт үүрлэнэ. Европын тундраас Баруун Сибирь, Баруун Европ, Каспийн тэнгис орчим, Дорнод Азиас БНХАУ, Солонгос, Японд очиж өвөлжинө. Манай орны Орхон, Сэлэнгэ, Эг, Хараа, Ерөө, Буурын гол дагуу буюу Сэлэнгийн сав, Туул, Онон, Балж, Хэрлэн голын хөндийгөөр тааралдана [3,4,5,6,7,8,9,10].

**Амьдралын онцлог:** Тундрт хосоороо үүрлэх боловч заримдаа маш олон үүр нэг дор ойрхон тохиолдоно. Хос бүр амьдарлын турш хамт байна. Залуу шувууд 2 насаа хүртэл эр, эм шувуудтай хамт байна. Гуужих нутагтаа мянга гаруй км хол нисч их олуулаа цугларч нэг дор гуужина [1,2].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Манай орны хувьд тоо толгойг тогтоогоогүй [12]. Евразийн хувьд тоо толгой өндөртэй шувуунд тооцогддог. Харин манай нутагт бусад галуутай сүрэглэн цөөн тоогоор нүүдлийн үедээ тохиолддог. Дэлхийн популяцид нийт 2-3 сая манхин галуу байдаг гэж үздэг [11].

**Хамгаалагдсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол [13], Нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ.** Тархац тоо толгойг нарийвчлан тогтоох, тусгай хамгаалалтын менежментийг сайжруулах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жизнь животноных том VI, 1986, 2. Полевой определитель гусеобразных птиц России, 2011, 3. Козлова, 1930, 4. Фомин, Болд, 1991, 5. Даваа нар, 1994, 6. Болдбаатар, 2005 а, 7. Цэвээнмядаг, Болд, 2005, 8. Цэвээнмядаг нар, 2005, 9. Болдбаатар, 2008, 10. Birdlife International, 2011, 11. Mongolian Red List of Birds, 2011, 12. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012.

## 24. ГЭЗЭГТ НУГАС



*Anas falcata* Georgi, 1775

**Баг.** Галуутан - *Anseriformes*

**Овог.** Нугасныхан - *Anatidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [9].

**Таних шинж:** Эр шувууны 3-р зэргийн дэвүүр өд урт бөгөөд нуруун дээгүүр унжин гээг шиг харагдана. Толгойн хоёр хажуу шилэн хүзүү хар ногоон, хоолой цагаан, дух болон дагзны хэсэг хүрэн, бие саарал өнгөтэй. Эм шувуу бор өнгөтэй, хар хошуутай.

**Тархац, байршил нутаг:** ОХУ, Япон, Зүүн хойд БНХАУ-д тархсан. Зүүн өмнөд Азиар өвөлжинө [8]. Увс нуур, Тэс голын цутгал, Орхон, Сэлэнгэ, Туул, Хараа, Халх, Нөмрөг голын сав дагуух зарим нуурууд, Хангайн нурууны Өгий нуур, Тэрхийн цагаан нуур, Тарвагатай Булнайн нурууны Тэлмэн, Эрхил нуур, Буйр, Ташгайн таван нуурт цөөн тоогоор үрждэг [1,2,3,4,5,6,7].

**Амьдралын онцлог:** 4-р сараас 5-р сар хүртэл, 9-р сараас 10-р сар хүртэлх хугацаанд нүүдлийн үедээ тохиолдоно. Зуны улиралд ховор тааралдана. Газар дээр үүр засаж, 5-8 өндөг гаргана. Гол төлөв ойт хээрийн нууруудаар тархсан. Ус, намгийн ургамлаар хооллодог.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой, нөөцийн хомсдолыг судлаагүй.


**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [10], Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн жагсаалтад бүртгэгдсэн [11]. Тархац нутгийн 7.7% нь улсын тусгай хамгаалттай газар нутагт хамруулсан.



**Хамгаалах арга хэмжээ:** Нүүдлийн замыг судлан тогтоох, үржлийн нутгийн амгалан тайван байдлыг бүрдүүлэх, тусгай хамгаалалттай газар болон холбогдох конвенцийн хавсралтад орсон нуур, голын хамгаалалтыг сайжруулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Козлова, 1930, 2. Фомин, Болд, 1991, 3. Цэвээнмядаг, 2000, 2005, 4. Сумъяа, Скрябин, 1989, 5. Болд, 2005, 6. Болдбаатар, 2008, 7. Майнжаргал, 2005, 8. Иванов, 1976, 9. Mongolian Red List of Birds, 2011, 10. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 11. CMS конвенц, 2002.

## 25. ХУРУУТ ХУН



*Cygnus olor* (Gmelin, 1789)

**Баг.** Галуутан - *Anseriformes*

**Овог.** Нугасныхан - *Anatidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [7].

**Таних шинж:** Биеийн урт 150 см, том биетэй, цагаан зүстэй. Хошуун дээрээ, духныхаа доод талд том булдруутай. Хамрын нүхний дээд тал хошууныхаа хянгатай хурц өнцөг үүсгэнэ. Духны булдруу, хошууны уг, завжны зах хар. Харин хошууны үндсэн хэсэг улаан. Хумс хар. Хөл сарвуу бүдэг хар [6].

**Тархац, байршил нутаг:** Европ, Бага Ази, ОХУ-ын Уссурин хязгаар, Байгалийн чанад дахь нутагт өндөглөн зусна [1]. Увс, Бөөнцагаан, Орог, Улаан нуур, Ховд голд тааралддаг. Гүехэн устай нуурт ихэвчлэн байршдаг [6].

**Амьдралын онцлог:** Хулсны хатсан гуурс, ургамлаар үүр засна. 7-9 өндөг гаргаж, 35 орчим хоног дарна. Дэгдээхий хурдан өснө. Ургамлын усан доорх үндэс, үндсэрхэг иш, нахиагаар голлон хооллоно [5].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** 1962 онд Орог нуурт 22, Бөөнцагаан нуурт 2, 1974 онд Ховд голын Улаан уул орчимд 2, 1976 онд Улаан нуурт 8-ийг тэмдэглэжээ [2,5,10]. Увс, Орог нуурт үржинэ. Бөөнцагаан, Өгий, Өлзийт, Буйр нуур, Ховд голд тааралдана [6].


**Хамгаалсан байдал:** 1973 оноос агнахыг хуулиар хориглож, улмаар Монгол улсын Засгийн

газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [8], Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенц [9], Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад орсон [11]. Тархац нутгийг Увс нуурын дархан цаазат газарт хамруулахын зэрэгцээ Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн хавсралтад Орог, Бөөнцагаан, Буйр нууруудыг оруулсан [4, 12].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, үржлийн биологийг судлан тогтоох, үржлийн нутгийн тайван байдлыг алдагдуулахгүйн тулд зусдаг, үрждэг газруудыг малын бэлчээрээс чөлөөлөх, хамгаалалтын менежментийг бий болгох, сурталчилгаа зохион байгуулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Иванов, 1976, 2. Остапенко нар, 1978, 3. Птицы Советского Союза, том. IV, 1952, 4. Монгол улсын ан агнуурын хууль, 1975, 5. Болд, Болдбаатар, 1994, 6. Болдбаатар, 2013 б, 7. Mongolian Red List of Birds, 2011, 8. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 9. CMS, 2002, 10. Монгол улсын улаан ном, 1997, 11. CITES, 2001, 12. RAMSAR, 1997.

## 26. ХАРХИРАА ТОГОРУУ



*Grus grus* (Linnaeus, 1758)

**Баг.** Тогоруутан - *Gruiformes*

**Овог.** Тогорууныхан - *Gruidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Том шувуу. Биеийн урт 125 см. Ерөнхий зүс хөх саарал. Хүзүүний ар хажуу цагаан, зулайн ар тал, дагз өдгүй, улаан. Хоолойн урд хэсэг хар. Хошуу ногоовтор, хөл хар.

Дэвүүрүүд саарал, орой хар. Далавч 54-66 см, дэлгээ урт 245 см [1,27,29].

**Тархац, байршил нутаг:** Хархираа тогоруу Африкийн хойд нутаг, Иран, Өмнөд Азийн нутгууд, Энэтхэг, БНХАУ-уудад өвөлжинө [1,29]. Монгол Алтайн гол, нуурууд, Их нуурын хотгорын Дөргөн, Хар, Хар ус, Айраг, Хяргас, Увс нууруудын ойролцоох чийглэг нуга, Хангай, Хэнтий, Дорнод Монголын томоохон голын хөндий, намгархаг нууруудаар тохиолдоно. Нүүдлийн үедээ Их нуурын хотгор, Булган голын хөндий, Халх гол, Сэлэнгэ, Орхон, Туул, Улзын голын хөндийд тааралдана. Нүүхийн өмнө олноороо нэг дор цуглардаг [2-27]. Нүүдлийн үедээ тариан талбайд бууж идээшлэх дуртай.

**Амьдралын онцлог:** Хүрч очиход хэцүү, өргөн уудам намгархаг газар, чийглэг нуга, нуурын ойр орчмоор амьдарна. Зэгс шагшуургатай намгархаг нутагт хэсэгхэн хуурай газар олж үүр засна. Голцуу 2 өндөг гаргана. Залуу шувууд 70 хоногийн дараа бие даан нисч чадна. Цангинуулан “хархирах” дуу нь алс хол сонсогдоно. Үр жимс, ургамлын найлзуур, шавж, хорхой, зөөлөн биетэн, хоёр нутагтнаар хооллоно. Нүүдлийн, өндөглөдөг зүйл [27].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Айрхан нуурын хөндийд 2012 оны намар 200-300 толгойгоор цугларч байсан [28]. Тоо толгой, хомсдох ховор шалтгааныг судлаагүй.

**Хамгаалагдсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэгдсэн [30]. Түүнчлэн Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралт, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенц [31]-ийн жагсаалтад тус тус бүртгэгдсэн. Тогорууны зусах, нүүдлийн үедээ олноороо цуглардаг ихэнх нутаг улсын тусгай хамгаалалттай нутгийн сүлжээнд хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ.** Тусгай хамгаалалттай газар болон олон улсын бусад ковенцуудад, хавсралт, жагсаалтад орсон газар нутгийн хамгаалалтын менежментийг бүрдүүлэх, тоо толгойг нарийвчлан тогтоох.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жизнь животных том VI, 1986, 2. Козлова, 1930, 3. Сушкин, 1938, 4. Болд, 1973, 5. Сумъяа, 1973, 6. Сумъяа, Скрябин, 1989, 7. Фомин, Болд, 1991, 8. Даваа нар, 1994, 9. Болд нар, 1995, 10. Гомбобаатар, 1995, 11. Гомбобаатар, 1996, 12. Цэвээнмядаг нар, 2000, 13. Гомбобаатар, 2002, 14. Гомбобаатар, Болд, 2002, 15. Сумъяа, 2002, 16. Тэрбиш, Гомбобаатар, 2003, 17. Badley et al., 2005, 18. Болд, 2005, 19. Болдбаатар, 2005, 20. Болдбаатар, 2005 а, 21. Цэвээнмядаг, 2005, 22. Цэвээнмядаг, Болд, 2005, 23. Болдбаатар, 2008, 24. Арчимаева-Озерская, Забелин, 2010, 26. Болдбаатар, 2013 а, 27. Болдбаатар 2013 б, 28. Болдбаатар 2013 в, 29. Справочник определитель птицы Европы, 2003, 30. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 31. CMS, 2002.

27. ЦАГААНСҮҮЛ НӨМРӨГБҮРГЭД



*Haliaeetus albicilla* (Linnaeus, 1758)

**Баг.** Шонхортон - *Falconiformes*

**Овог.** Харцгайхан - *Accipitridae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Бие 70-100 см, далавч 2-2.4 м урт, 3-6.5 кг жинтэй. Эм нь эрээсээ биеэр том. Нас гүйцсэн бодгаль хүрэн, хошуу шар, сүүл цагаан. Залуу бодгалийн сүүл арай бараандуу байснаа цагаан болно [2,8].

**Тархац, байршил нутаг:** ОХУ, Баруун Европд Унгар, Румын, Исланд, Гренланд, Бага Азийн Ирак, Иранаар тархсан. Өмнөд Европ, Египет, Энэтхэгийн хойг, БНХАУ, Япон, Солонгост өвөлжинө. Монголын томоохон нуур, голын саваар байршиж, хааяа өвөлжинө. Айраг, Хар ус, Хар, Ачит, Өгий, Орог нуур, Онон, Тамир, Шишгэд, Булган гол Сэлэнгэ мөрөнд тааралдана. 1975-1994 онуудад 30 гаруй бодгаль бүртгэв [1,6]. Сүүлийн үед Үүр, Эг, Тарвагатай, тэдгээрт цутгадаг голуудыг саваар тоо толгой нь нэмэгдэж байгаа. Богд уул, Эгийн савд өвөлжинө [7].

**Амьдралын онцлог:** Монголд хагас суурин байдлаар нүүдэллэн амьдардаг [7]. Ихэвчлэн хоёр өндөг гарган, сар орчим дарж, ангаахай болгоно. Бүдүүн модны дунд хэсэгт, эсвэл хадан хясааны ирмэг тавцан дээр модны мөчир, хатсан өвсөөр нүсэр том үүр засдаг. 4-5 настайдаа бие гүйцнэ [3]. Загасаар баян усны шувуу өндөглөдөг нуур гол, өндөр мод, хадан цохиотой газар тохиолдоно.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Байршил нутгийг доройтуулж, үүр, өндгийг сүйтгэснээс тоо толгой цөөрөх хандлага гарч байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [11], Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн I хавсралт [9], Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцийн I, II жагсаалт [10], Монгол улсын улаан номонд /1987, 1997/ [1,6] тус тус оруулж, байршил нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөц, биологийг судлах, хамгаалалтын менежментийг сайжруулах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. БНМАУ-ын Улаан ном, 1987, 2. Жизнь животных, том VI, 1986, 3. Красная книга Бурятской АССР, 1988, 4. Красная книга РСФСР, 1983, 5. 1971-1985 оны Монгол Зөвлөлтийн хамтарсан экспедицийн тайлан, 6. Монгол улсын Улаан ном, 1997, 7. Болдбаатар, 2008, 8. Болдбаатар, 2013 б, 9. CITES, 2001, 10. Зэрлэг CMS, 2002, 11. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012.

## 28. АЛТАЙН ХОЙЛОГ



*Tetraogallus altaicus* (Gebler, 1836)

**Баг.** *Taxuатан* - *Galliformes*

**Овог.** *Гургуулынхан* - *Phasianidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [9].

**Гадаад шинж:** Бие том, бахим. Толгой, биеийн дээд хэсэг хүрэн саарал. Биеийн ар нуруу, залуурын бүрхүүл өдүүд жижиг, цагаан судалтай. Бүдүүн хүзүү, гүеэндээ хөндлөн хар, жижиг толботой. Хоолой, хэвэл цагаан. Биеийн хажуу, гуя хар өдтэй. Өдний үзүүр өргөн хар

эмжээртэй. Хошуу бүдэг хар. Шилбэ, савар шаргалдуу туяа бүхий хүрэн бор хайрстай. Нүдний доор, ар талд тод шар, шаргал нүцгэн арьстай. Эр, эмээсээ биеэр том.

**Тархац байршил:** ОХУ-ын Алтай, Саяны нуруу, Селюгем, Тагнын нурууны зүүн биеэр тархсан. Монгол Алтай, Говь-Алтайн уулс Цамбагарав, Хархираа, Түргэн, Асгат, Хөх сэрх, Сөнхсарьдаг, Сутай, Хүрэн хайрхан, Жинст хайрхан, Хонгор хайрхан, Алаг хайрхан, Жаргалант хайрхан, Сагил болон Хангай, Хан Хөхий, Хөвсгөлийн уулын ойт хээрийн бүслүүрийн далайн түвшнээс дээш 2700-3000 метр өндрийн ноён оргилын байц цохио, ханан хад, нураг асгатай, ой модгүй тэгш, мөлгөр хяртай энгэр, хажуу, хунх, нугачаа, судаг, хярын зоонд байршина.

**Амьдралын онцлог:** III сарын сүүл, IV сарын эхээр ороо эхлэхэд өвлийн сүрэг тарж хоёрлосон хосууд үүснэ. Орооны үед өглөө, орой чахрин исгэрэх дуу идэвхжиж, эрүүд “адуу янцгаах” адил дуугаар эмэгчнээ дуудан хос хойлог уулын задгай энгэр хажуу, хунхад элбэгшиж үүрлэхийнхээ өмнө өндөр уулнаас доошлох нүүдэл хийдэг. V сарын эхээр хад чулууны хоорондох нөмөр газар хонхойлж, хагд өвс, өд дэвсэж үүр засна. V сарын сүүлчээр 8-12 хоногт цувуулан өндөг гаргаж, эмэгчин 28 хоног дарна [5]. Дэгдээхий VI сарын эхээр гарч, хурдан өсч томроод, X сард галбир хэмжээгээрээ бие гүйцсэн бодгальтай адил болно. VII сарын дундуур орооны идэвх буурч, VIII сарын хоринд бүр мөсөн зогсоно. Үетэн, холтсон цэцэгтэн, тэргүүлэгч цэцэгтэн, буурцагтаны овгийн ургамлаар голлон хооллоно. Мөн арвай, улаан буудай, вандуй, шар будуу, овьёос, багсармал тэжээл иддэг [5].

**Тоо толгой хомсдох шалтгаан:** 1950-иад оны эхээр их цөөрсөн боловч аажмаар тоо толгой олширч, тархацын хүрээ хуучин нутгаараа дахин тэлж, ердийн элбэг шувуудын адил өсөж байна. Монгол Алтайн нуруунд 100 га талбайд 15-30, Хангайд 3-30 толгой байдаг [3]. Бүргэд, үлэг харцага, ирвэс, шилүүс, үнэг зэрэг махчин амьтад хороодог. Үүр, өндөг, дэгдээхийг хадны суусар, дорго сүйтгэнэ. Зуны цочир хүйтрэлд дэгдээхийн 40 орчим хувь хорогдоно. Дэгдээхийг өвлийн улиралд махчид хороодгоос жилийн өсөлт 5-10 хувь байна. Эмчилгээ сувилгаанд махыг хэрэглэх зорилгоор хулгайгаар агнаж, худалдаалах, үргээж байршлыг алдагдуулсаар байна.


**Хамгаалсан байдал:** 1953 оноос агнахыг хуулиар хориглож, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан [7]. Тархац нутгийн ихэнхийг улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөнд тусган, хамгаалалтыг сайжруулах, хууль бус агналт, худалдааг таслан зогсоох зорилгоор Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад оруулах, зориудаар өсгөн үржүүлэх, хамгаалах сурталчилгаа тогтмол хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Зориг, 1989, 2. Болд нар, 1976, 3. Птицы СССР. Курообразные, 1987, 4.

Сопин нар, 1980, 5. Ирисов нар, 1991, 6. Намнандорж, 1976, 7. Монгол улсын улаан ном, 1997, 8. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 9. Mongolian Red List of Birds, 2011.

## 29. ЗЭРЛЭГ ГУРГУУЛ



*Phasianus colchicus* Linnaeus, 1758

**Баг.** *Taxuaman - Galliformes*

**Овог.** *Гургуулынхан – Phasianidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна.

**Таних шинж:** Эрийн биеийн урт 75-89 см, эмийнх 53-62 см. Эрийн биеийн ерөнхий зүс улбардуу бараан хүрэн, хөндлөн жижиг хар толбо олонтой. Хошууны уг, хоолой, хүзүү, дагз, нүдний доод хэсэг хар, гялалзсан ногоон туяатай. Хацар, завж нүцгэн улаан арьстай. Хүзүүний уг цагаан бүслүүртэй. Хөндлөй цэнхэрдүү ногоон туяатай саарал, залуур өд шаргалдуу бор хүрэн, хөндлөн хар судлуудтай. Цээж арай бараан, биеийн хажуу цайвардуу шаргал. Эм нь эрээсээ жижиг, бие бүхэлдээ шаргалдуу бор хүрэн, бараан хүрэн хөндлөн судал, толбо ихтэй учир цоохор. Сүүл богино, хөндлөн хар бараан судалтай. Хошуу бор шаргал. Хөл бор саарал. Эм гургуул бор саарал зүстэй. Хөндлөн хар бараан судалтай богинохон бор саарал сүүлтэй [1,2,36].

**Тархац, байршил нутаг:** ОХУ, Иран, Афганистан, БНХАУ, Солонгос болон Энэтхэг-Хятадын хойгийн өндөр уулсаар тархан амьдардаг суурин шувуу. Их Хянганы салбар уулс, Буйр нуур, Гүү, Азрага, Халх, Шинэ, Эмнэгтийн гол, Хүйтэн, Авдрантын булаг, Бөхмөрөн, Ховд голын шугуй, Зэргийн хөндий, Ачит нуурын хөвөөгөөр өтгөн зэгс, шагшуургатай газарт тархсан [1-31].



**Амьдралын онцлог:** Манай орны суурин шувуудын нэг бөгөөд ороо хөөцөө III сарын сүүлчээр эхлэн, VI сар хүртэл үргэлжилнэ. Монгол оронд элсэрхэг хөрстэй, бургас, улиас, хус бүхий холимог модтой, чацаргана, харгана мэт өтгөн, өндөр ургасан бутлаг ургамалтай амьдрах орчинд байршигтай. Цасны зузаан дагаж өвөлдөө ойр зуур шилжинэ. Хос бүр үржлийн эзэмшил нутагтай. Эр нь олон эмэгчин хураана. Үүр газар дээр, гүехэн хонхор мэт бөгөөд үүрний хонхорыг ургамлын хатсан цөөхөн иш, навчаар доторлон өндөглөнө. Ногоовор-хүрэн, бор хүрэн, ногоовор, эсвэл хөхвөр саарал өнгө бүхий 6-12 /15/ өндөгтэй үүрүүд IV сарын сүүлч, V сарын эхээр таарна. Эм өндгөө ганцаар 21-27 хоног дарна. Дэгдээхий өндөгнөөс харьцангуй богино хугацаанд гарч, эмэгчин тэднийг ганцаар асран, хамгаална. Өндөгнөөс гарснаас хойш 12-14 хоногийн дараа нисэх чадвартай болно. Зундаа дэгдээхийнүүд шавжаар ихэвчлэн хооллох бөгөөд шүүслэг навч, цэцэг, үр жимс, ургамлын үндэс, нахиа иднэ. Намрын сүүлч, өвөлдөө нэг бүлд багтах шувууд хамтдаа хоноглон, ургамлын үр, өвөлжих нахиа, үндэс, хатсан жимс зэргээр хооллоно. Цас ихтэй хахир өвөл тэд айлын гэр, малын хашаа хороо бараадан, малын бааснаас ургамлын үр түүж иднэ [9,32,35].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Хавар, зуны эхэн, намрын сүүлч, өвөлдөө гургуулын амьдрах орчинд мал олноор бэлчиж, амьдрах орчныг сүйтгэнэ. Бөхмөрөн, Ховд, Халх, Нөмрөг голын савд амьдрах нутгийн иргэд бургас, харганыг түлшинд ихээр хэрэглэдэг нь тэдний амьдрах орчинд нэн сөргөөр нөлөөлнө. Хавар, намрын хуурай цагийн түймэр нь гургуулын үржлийн болон өвөлжих нутгийн ойг шатаана. Гургуулын махыг идэх зорилгоор хулгайгаар агнадаг. Гэнэтийн хүйтрэл, их цас, цасан шуурганд бие гүйцсэн бодгаль, мөн залуу шувууд олноор эндэнэ. Саарал чоно, шар үнэг, гэрийн нохой гургуул барьж иднэ [33-35].

**Хамгаалсан байдал:** 1975 оноос агнахыг хуулиар хориглож, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [36]. Монгол улсын улаан номонд орсон [35]. Ховд голын шугуйгаас 1976, 1977 онд 10 орчим гургуул барьж, Улаанбаатар хотын орчмын үржүүлгийн фермд тэжээх туршилт хийсэн [34,36]. Байршил нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан [36].

**Хамгаалах арга хэмжээ:** Гургуул үржиж, өвөлждөг нутгийн тодорхой хэсгийг нутгийн иргэд, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, хамгаалахыг сурталчлах, зудын үед тэжээл тавьж өгөх, гургуул үржүүлгийн төвийг Ховд, Халх, Нөмрөг голын савд байгуулах замаар нөхөн сэргээх, хамгаалах сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Болд нар, 2001, 2. Гомбобаатар нар, 2011, 3. Козлова, 1930, 4. Сушкин, 1938, 5. Лувсанхорлоо, 1961, 6. Намнандорж, 1964, 7. Шагдарсүрэн, 1969, 8. Болд, Эрэгдэндагва, 1970, 9. Болд, 1972, 10. Намнандорж, 1976, 11. Цэвээнмядаг, 1979, 12. Шагдарсүрэн, 1980, 13. Болд, 1983, 14. Болд, 1989, 15. Болд, 1997, 16. Фомин, Болд, 1991, 17. Даваа нар, 1994, 18. Буянт, 1998, 19. Цэвээнмядаг нар, 2000., 20. Тэрбиш, Гомбобаатар, 2003, 21. Болдбаатар, 2004, 22. Болдбаатар, 2005, 31. Hennache & Ottaviani, 2006, 32. Harrison, 1975, 33. Гомбобаатар ба бусад, 2011 а, 34. Гомбобаатар нар, 2011 б, 35. Монгол улсын улаан ном, 1997, 36. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012.

## 30. ЗАГИЙН БОРШУВУУ



*Passer ammodendri* Gould, 1872

**Баг.** Боршувуутан - *Passeriformes*

**Овог.** Боршувууныхан - *Passeridae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [10].

**Таних шинж:** Биеийн урт 14-15 см. Бие гүйцсэн бодгалийн дух, зулай, дагз, нүдний өмнө хэсэг, хоолой хар. Хөмсөг, чихний ар талаар улбар шар судалтай. Шанаа цайвар саарал, нурууны дээд хэсэг тууш хар толбо бүхий улбардуу бор туяатай элсэн шаргал. Хэвлий цагаан, биеийн хажуу бор шаргал өнгөртэй. Эм шувуудын толгойн орой, хацар элсэн шаргалдуу саарал, хөмсөг, хоолой цайвар саарал. Хошуу хар саарал. Хөл улбардуу бор хүрэн. Залуу шувууд нь бие гүйцсэн эмтэй төсөөтэй ч хоолойн хэсэгт саарал болон хар өнгө байхгүй [1].

**Тархац, байршил нутаг:** Дундад Ази, Казахстан, Төв Азийн умард хэсэг, дорно зүгт Ордос хүртэл тархсан. Монгол орны Шарга, Алтайн өвөр говь, Говь-Алтайн нуруу, зүүн талдаа Зүүнгарын говийн заган ойд үүрлэнэ [2-6].

**Амьдралын онцлог:** Манай орны хувьд суурин, өндөглөдөг зүйл. Говь цөлийн заган шугуй бол энэ зүйлийн үндсэн амьдрах орчин. Үржлийн хосууд VI сард хөгшин, бүдүүн загийн хонгил, мах идэшг шувуудын үүрийг сүвлэн үүрээ засна. Зарим хосууд голын эргийн нүх / Хонгорын голын эрэг/, малын хашаа, саравчны ангал нүхэнд ч үүрлэнэ [8]. Задгайрсан амсартай торх хэлбэртэй үүрийг ургамлын иш, мөчир, навчаар засаж, үүрний хонхорыг жижиг өд, үс, ноосоор доторлож, өндөглөнө. Өндөг гялалзсан цагаан, эсвэл цайвар саарал дэвсгэр өнгөтэй бөгөөд улбар, саарал, шаргалдуу бор толбо, судалтай. 4-6 өндөг гаргаж,

ихэвчлэн эм 11-14 хоног дарна. Хуурай газрын сээр нуруугүйтэн болох цох, царцаа, аалз, тэмээлзгэнэ, тэдгээрийн авгалдай иднэ. Үржлийн бус үедээ 6-60 бодгаль нэгдэж, сүрэг үүсгэх бөгөөд ихэвчлэн ургамлын үр жимсээр хооллоно. Энэ үедээ заг, улиас, сухай зэрэг мод, бутны орчимд байршижтай. Намрын цагт тэд сүрэглэн хармагийн жимс идэх дуртай. Хахир өвөл тэд малын хашаа, саравч, айл орчимд ирж, малын бааснаас ургамлын үр иднэ. Сүрэглэсэн шувууд заган ой, өвөлдөө заримдаа айлын өвөлжөөнд ирж хоноглоно [7].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тэмээ, хавтгай заг модны мөчир, гишүүг идэх, үүртэй модыг тасчиж, сэгсчиж шувуудад сөрөг нөлөөлнө [5,7]. Заг түлшинд хэрэглэснээс амьдрах орчныг өөрчилнө. Гэнэтийн цочир хүйтрэл, мах идэшт шувууд бие гүйцсэн болон ангаахайг идэх нь тоо толгойд сөргөөр нөлөөлнө [7].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн. Манай орон дахь нийт тархалтын 41.8% нь улсын тусгай хамгаалалттай газарт багтана [7]. Үрждэг болон улирлын шилжилтийн үедээ дайрч өнгөрдөг нутаг нь Монгол орны өмнөд бүсийн зарим улсын тусгай хамгаалалттай газарт хамаарна.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөцийг тогтоох, хамгаалалтыг сайжруулах, үржлийн биологи, нүүдэл шилжилт, тоо толгойн хорогдлыг судлах, заган ойг бүхэлд нь орон нутгийн болон улсын тусгай хамгаалалттай нутагт хамруулах, хиймэл үүр байрлуулах замаар энэ зүйлийн үржил өсөлтийг дэмжих, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Gombobaatar et al., 2011, 2. Козлова, 1930, 3. Фомин, Болд, 1991, 4. Даваа нар, 1994, 5. Энхнасан, Гомбобаатар, 2005, 6. Болдбаатар, 2008, 7. Gombobaatar et al., 2011 b, 8. Болд нар, 2005, 9. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 10. Mongolian Red List of Birds, 2011.

## 31. ОЙН ШИЙХНҮҮХЭЙ



*Anthus trivialis* (Linnaeus, 1758)

**Баг.** Боршуууман - *Passeriformes*

**Овог.** Цэгцгийнхэн - *Motacillidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [18].

**Таних шинж:** Нүүдлийн, өндөглөдөг шувуу. Биеийн урт 14-16 см, цайвар бор өнгөтэй. Цээжээрээ тод хар толбон судалтай, хэвлий хэсэг цагаан цайвар. Сүүлний захын 2 өд цагаан, бусад залуур өдүүд хархүрэн, зарим нь цагаан оройтой. Хөлийн сарвуу ягаан, нүдний хөмсөг орчим үл мэдэг цайвар бөгөөд нүд дайрсан нарийн бүдэг хар судалтай. Хошууны хоёр талаас доош тууш бараан судалтай. [6,7,16].

**Тархац, байршил нутаг:** Баруун Европ, ОХУ, Туркээс Гималай хүртлэх Азийн уулс, Дорнод Тяньшанаар тархсан бөгөөд Баруун Европ, Африк болон Зүүн урд Азид өвөлжинө. Хөвсгөл, Хангай, Хэнтийн ойт хээрийн бүсийн холимог ойн зах, Ховд, Булган, Орхон, Сэлэнгэ, Онон, Балж, Хэрлэн, Улз, Халх голын сав дагуух модтой газраар нүүдэллэж, үрждэг [1-16].

**Амьдралын онцлог:** Үүрээ хожуулын ёроолд нямбай засна. 4-5 өндөг гаргана. Холимог ойн цоорхой, довцог, голын хөндийн ой, өндөр уулын нугад амьдрана. Шавж аалз, ургамлын үр иднэ. 4-р сарын дундаас нүүдэллэн ирж, 9-р сарын эхээр буцна [3].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой, нөөцийн хомсдлыг судлаагүй. Түймэр, мод бэлтгэлт зэргээс шалтгаалсан ойн нөөцийн хомсдол нь амьдрах орчны нөхцөлийг доройтуулна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [17]. Тархац нутгийн ихэнх хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нутгийн ойн нөөцийг хамгаалах, нөөцийн хомсдлын шалтгаан, биологи, экологийн судалгааг хийж, хамгаалалтын менежментийг боловсруулан хэрэгжүүлэх, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Козлова, 1930, 2. Фомин, Болд 1991, 3. Сумъяа, Скрябин 1989, 4. Dawaa et al., 1994, 5. Цэвээнмядаг нар, 2000, 6. Болдбаатар, 2002, 7. Busching, 2003, 8. Болдбаатар 2003, 9. Тэрбиш, Гомбобаатар, 2003, 10. Болдбаатар, 2005 а, 11. Цэвээнмядаг, Болд, 2005, 12. Цэвээнмядаг нар, 2005, 13. Сумъяа, 2006, 14. Ларс Свэнссон, 2009, 15. Цэвээнмядаг, 2010, 16. Болдбаатар, 2013 б, 17. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 18. Mongolian Red List of Birds, 2011.

32. ШАГШУУРЫН ШАТАНСҮҮЛТ



*Locustella luscinioides* (Savi, 1824)

**Баг.** Боршувуутан - *Passeriformes*

**Овог.** Зэржигэнийхэн - *Sylviidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [7].

**Таних шинж:** Биеийн урт 13-15 см. Бусад шатансүүлтээс ялгагдах шинж нь цээж нь элдэв судал, толбогүй, цайвар хүрэн өнгөтэй. Биеийн нуруу тал бор саарал, хоолой орчим үл мэдэг цайвар, дээд хошуу бараан, доод хошуу шаравтар өнгөтэй, сүүлний доод бүрхүүл өд улаавтар хүрэн [5].

**Тархац, байршил нутаг:** ОХУ-ын өмнөд нутгууд, Барнаул, Зайсангийн хотгор, Дундад Ази, Баруун Европ, Баруун хойд Африк, Газар дундын тэнгисээр нутаглаж, Зүүн хойд Африкийн халуун бүсээр өвөлжинө [1]. Их нууруудын ай савын Хар, Хар ус нуурын өтгөн зэгс бүхий ус намгархаг газарт тархсан [2-4].

**Амьдралын онцлог:** Нуур, голын дагуух өтгөн өндөр зэгс, өвсөнд амьдарна. Газарт үүрлэж, 6-10 өндөг гаргана. Шавж иднэ.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой, хомсдолыг нарийвчлан судлаагүй. Тархац нутгийн хэмжээ бага.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [6]. Тархац нутгийг Хар ус нуурын байгалийн цогцолборт газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологи, экологийг нарийвчлан судлах, уг цогцолборт газрын менежментийн төлөвлөгөөнд уг зүйлийг хамгаалах асуудлыг тусгах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Иванов, 1976, 2. Фомин, Болд 1991, 3. Даваа нар 1994, 4. Болдбаатар, 2008, 5. Ларс Свэнссон, 2009, 6. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 7. Mongolian Red List of Birds, 2011.

### 33. ӨГӨӨЛЭЙ ШУЛГАНАА



*Saxicola insignis* Gray, 1846

**Баг.** Бор шувуу хэлбэртэн - *Passeriformes*

**Овог.** Хөөндэйхэн - *Turdidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [11].

**Таних шинж:** Биеийн урт 14 см. Эрийн биеийн дээд тал, толгойн хажуу хар. Хэвэл, хүзүүний хажуу, сүүлний дээд хэсэг цагаан, далавч хар. Түүний доод бүрхүүл өд, дэвэгч өдний уг цагаан. Омруу цайвар. Биеийн элгэн хэсгийн өд улбар хүрэн. Залуур хар. Эмийн нуруу голоороо үргэлжилсэн бүдэг хүрэн судалтай саарал. Далавч эртэйгээ адил боловч, харавтар саарал, биеийн элгэн хэсэг, цээжиндээ арай тод улбар шар. Хошуу, хөл хар хүрэн. Залуу бодгаль зүсээрээ эмтэйгээ ижил [9].

**Тархац, байршил нутаг:** Зүүн өмнөд Алтай, Селюгеийн нуруу, БНХАУ-ын баруун хойд нутгаар тархсан. Энэтхэг-Хятадын хойгт Гимилайн нуруу, Умарт Энэтхэг, Балба, Умарт Бенгал хүрч өвөлждөг [5]. Алтай, Хангайн уулсын системд тархсан өндөр уулын жигүүртний

өвөрмөц зүйл. Монгол Алтайн Сийлгэм, Цаст, Мөнх хайрхан, Хөх сэрх, Хасагт хайрхан Хужирт, Бодонч, Боригийн голын эх, Улаан даваа, Хангайн гол нуруунд Отгонтэнгэр, Чулуут, Завхан, Богд, Бумбат, Буянт, Шаргалжуут, Онгийн голын эхийн д.т.д 2100 метрээс дээших таг, тайга, уулын хээр, чийглэг нугад байршина. [1-7]. Монгол Алтайд 2500-3100, Мөнх хайрханд 2800-3100, Даян нуур орчимд 2600, Улаан даваа, Бодонч голын эхэн хэсэгт 2600, Сийлгэмд 2100, Хангайд 2400-2600 метрийн өндөрт идээшин амьдарна [1-8].

**Амьдралын онцлог:** Үржлийн биологийн тухай мэдээ нэн хомс. Таг, царам, уулын энгэр, нугын сийрэг тачир өвс ургамал, бут сөөгтэй, хясаа цохио, гуу жалгатай гүехэн устай гол горхийн эргээс холгүй үүрлэнэ. Хэд хэдэн хос бие биедээ ойрхон үүрлэнэ. Монгол Алтайд 3-5, Хангайд 2-3 хос нэг дор үүрлэдэг [4,5,7]. Ү сарын эцэс, ҮI сарын эхээр хад чулуу, бут сөөгийн орой дээр суун жиргэж байгаа эр шувууд олонтоо тохиолдоно. Үүрээ хад чулуу, хясаа цохионы ан завсар, гуу жалгын эгц эрэгт нуугдмал засна. Өндгөө ҮI сарын эхээр гаргана. Үүрийн аягыг хуурай нарийн өвс, хаг, хөвдөөр зулж сүлжин, ургамлын хөвөн, үс, ноос дэвсэж зөөллөнө. Ногоовтор цэнхэр өндөг, мохоо үзүүртээ шаравтар хүрэн бидэртэй. Хэмжээ 18.0-18.8 x 14.1-15.1 мм. Ангаахай ҮI сарын эцсээр гарна [7]. Эм өндгөө дарж, ангаахайгаа тэжээнэ. Эр үүр, бүлийн дэргэд байж эзэмшил газраа хамгаална. Амьдрах орчны онцлогоос шалтгаалан үржлийн хугацаа газар бүр харилцан адилгүй. Үүрлэж өндөглөсөн нутгаа ҮIII сарын дундаас орхиж нүүнэ [9].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тусгайлан тооллого судалгаа хийгээгүй. Өндөр уулын хөрс, агаарын температурын огцом хэлбэлзэл, гэнэтийн хүйтрэл өндөг, ангаахай, залуу бодгалийн өсөлт, хөгжилтөд ихээхэн сөрөг нөлөөтэй [6].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [10]. Үүрлэж өндөглөдөг ихэнх нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судлах, өндөр уулын ховор шувуудыг хамгаалах менежмент боловсруулан хэрэгжүүлэх, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Сушкин, 1925, 2. Тугаринов, 1929, 3. Козлова, 1930, 4. Козлова, 1932, 5. Кишинский нар, 1982. 6. Формин, Болд, 1991, 7. Heidere нар, 1992, 8. Болдбаатар, 2013 б, 9. Монгол улсын улаан ном, 1997, 10. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 11. Mongolian Red List of Birds, 2011.

## 34. НАРАН ХӨМРӨГ



*Emberiza yessoensis* (Swinhoe, 1874)

**Баг.** Боршувуутан - *Passeriformes*

**Овог.** Хөмрөгийнхөн - *Emberizidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [8].

**Таних шинж:** Биеийн урт 14.5 см. Бие гүйцсэн үржлийн эр бодгалийн толгой, эрүү дор, хоолой бүхэлдээ хар. Биеийн дээд хэсэг улбардуу шаргал-хүрэн, өргөн тууш хар бараан судлуудтай. Биеийн доод хэсэг улбардуу шаргал хүрэн нуруунаас арай цайруу. Хэвлий, сүүлний доод өд цайвар, хошуу хар. Үржлийн бус үед эрийн ерөнхий зүс бүдэг болох бөгөөд толгойн орой, чихний бүрхүүл, шанаа, эрүү дор, хоолойн хэсэг бүхэлдээ бараан. Хөмсөг өргөн улбардуу шаргал хүрэн. Хошууны уг улбар шаргал, үзүүр бараан. Хөл улбардуу шаргал бор [2].

**Тархац, байршил нутаг:** ОХУ-ын Приморын хязгаарын зарим нуур, голын эргийн шүүр өвстэй газар, БНХАУ-ын зүүн хойд бүс нутаг, Солонгос, Японд тархсан. БНХАУ-ын өмнөд нутагт өвөлжинө [1]. Халх голын хөндий, Ташгайн таван нуур орчмын зарим газар үүрлэнэ [3, 4]. Мөн Гүү, Азаргын голын савд үүрлэдэг тухай тэмдэглэжээ [5]. Нүүдлийн үедээ Халх, Нөмрөг голын хөндий, Хянганы уулсаар дайрч өнгөрдөг [6].

**Амьдралын онцлог:** Манай оронд нүүдлийн өндөглөдөг зүйл. Монголоор нүүдэллэн өнгөрч буй бодгалиуд IV сарын сүүлч, V сарын эхээр ажиглагдана. Нуур, голын хөндийн чийглэг, тачир ургамал, богино бутлаг ургамал, зэгстэй орчинд үүрлэнэ. Үүрийг ургамлын хуурай иш, мөчрөөр газар дээр, эсвэл ургамлын иш дээр газарт ойрхон засаж, өндөглөнө. Өндөг шаргалдуу цайвар дэвсгэр өнгөтэй, бор хүрэн толбо, бараан судалтай. Өндөгний тоо 3-5.



Залуу шувууд өндөгнөөс гарснаас хойш 11-12 хоногийн дараа үүрээ орхино. Ангаахайг эр, эм хамтдаа асрах ба хуурай газрын сээр нуруугүйтнээр хооллоно. Үржлийн дараа болон өвөлдөө ургамлын үр иднэ [6].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Махан идэшт амьтад үржлийн болон нүүдлийн үед нь барьж иднэ [5].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэгдсэн [7], Азийн ховор шувуудын Улаан номонд бүртгэгдсэн [6]. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан [5].

**Хамгаалах арга хэмжээ:** Усны болон ховор шувуудын хамгааллыг сайжруулах, мониторингийн судалгааг гүйцэтгэх, үржлийн биологи, нүүдэл шилжилт, үхэл хорогдлыг судлах, Ташгайн таван нуурын хэсгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад авах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Иванов, 1976, 2. Gombobaatar et al., 2011, 3. Badley et al., 2004, 4. Гомбобаатар, 2011, ам мэдээ, 5. Болдбаатар, 2005, 6. Gombobaatar et al., 2011 b, 6. Birdlife International, 2001, 7. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 8. Mongolian Red List of Birds, 2011.

## 35. ШАРЭЛЭГТ ХӨМРӨГ



*Emberiza aureola* (Pallas)

**Баг.** Боршувуутан - *Passeriformes*

**Овог.** Хөмрөгийнхөн - *Emberizidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “ховордож болзошгүй” зүйлд хамаарна [25].

**Таних шинж:** Биеийн урт 15 см. Толгой хар, толгойн дээд хэсэг, хүзүү, нуруу, сүүлний дээд тал, мөр, бугалга хүрэн бор. Далавч дээр цагаан, хөндлөн 2 зураастай. Сүүлний доод хэсэг шар. Хошууны дээд тал бор саарал, хөл бор саарал. Эмийн толгой, бие бор саарал, сүүлний дээд тал, далавч бор. Нүүдлийн, өндөглөдөг шувуу [1,26].

**Тархац, байршил:** БНХАУ, Солонгос, Беринг, Камчатка, Сахалин, Казахстан, Баруун ба Зүүн Сибирьт тархсан. Монгол Алтай, Ачит нуур, Хархираа, Түргэний уулс, Ховд гол, Увс нуур, Хар ус нуур, Хар нуур, Хангай, Хэнтийн уулархаг муж, Хан хөхий нуруу, Буйр, Халх, Нөмрөг, Азрага гол, Алтайн өвөр говь, Шар хулсны булан, Цагаан бургас, Алаг нуур, Баруун хуурай, Булган гол, Үенч, Бодончийн голд тохиолдоно [2-26].

**Амьдралын онцлог:** Голын хөндий, бут сөөгдөг нуга, ойн цоорхой, армаг тармаг ойтой газраар амьдарна. Газарт үүр засч 4-6 өндөг гаргах бөгөөд нэг зундаа 2 удаа өндөглөнө. Үндсэн тэжээл нь шавж ургамлын үр [22].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Манай орны хувьд тоо толгой тоологдоогүй. Сүүлийн жилүүдэд тархац нутгийнхаа хэмжээнд ховордож байгаа. Ихэнх нутгаар хуурайшилтаас чийглэг нуга хатаж байгаа нь үүрлэх орчин хумигдах шалтгаан болж байна. Судалгаагаар нүүдлийн үедээ өмнөд хөршийн нутагт олноороо баригдаж, гоёл чимэглэл, хүнсний зориулалтаар ашиглаж байгаа нь тоо толгойн хомсдолд нөлөөлөх нэг үндэс болж байгаа [21].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ.** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, үржлийн нутгуудын хамгаалалтыг сайжруулах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жизнь животных том VI, 1986, 2. Тугаринов, 1932, 3. Козлова, 1930, 4. Банников, Сколон, 1948, 5. Kleinstauber & Succow, 1971, 6. Mauersberger, 1980, 7. Piechocki et al., 1982, 8. Сумьяа, Скрябин, 1989, 9. Фомин, Болд, 1991, 10. Stubbe et al., 2010, 11. Даваа нар, 1994, 12. Цэвээнмядаг нар, 2000, 13. Болдбаатар, 2002, 14. Цэвээнмядаг, Болд, 2005, 15. Болдбаатар, 2005 б, 16. Майнжаргал, 2005, 17. Цэвээнмядаг нар, 2005, 18. Сумьяа, 2006, 19. Болдбаатар, 2008, 20. Нямбаяр, Цэвээнмядаг, 2009, 21. Болдбаатар, 2006, 22. Болдбаатар, 2013 б, 23. Кузнецов, 1974, 24. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 25. Mongolian Red List of Birds, 2011.

## АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. Арчибальд Г. Вести с зимовок журавлей (1980-1981г) Журавли восточной Азии.

Владивосток, 1982 б.

2. Бабенко В.Г., Кузнецов А.А. Птицы Красной книги СССР. М. 1986.
3. Банников А.Г., Сколон В.М. Орнитоло-гические заметки о Монголии., Охрана природы. М., ВООП., 1948, №5.
4. Бианка В.Л. Материалы для изучения авифауны Монголии и Восточного Тибета Тр. экспед РТО в 1989-1901г. под нач. П.К.Козловой С.Пб. 1907. т.5.
5. БНМАУ-ын Улаан ном, 1987.
6. Болд А. Хэнтийн уулархаг районы шувууд (зүйлийн бүрэлдэхүүн ба тархац). Био.хүр.бүт., 1968. №3.
7. Болд А. 1969. Хэнтийн уулархаг районы шувууд (Зүйлийн бүрэлдэхүүн ба тархац). Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 3: 4-25.
8. Болд А. Агнуурын шувуу. БНМАУ-ын агнуурын амьтад ба ан хамгаалал. УБ. 1972.
9. Болд А. Птицы Хэнтийского горного района и их практическое знаание. Автореферат канд.дисс. УБ. 1977.
10. Болд А. Эколого-географические основы охраны и рационального использования орнитофауны МНР. док. дисс., 1989.
11. Болд А., Эрэгдэндагва С. Буйр нуур, Халх, Нөмрөг голын савын шувууны бүрэлдэхүүн. Биол.хүр.бүт. 1970. №5.
12. Болд А., Дуламцэрэн С., Цэнджав Д. Хангайн уулархаг районы агнуурын амьтныг зүй зохистой ашиглах асуудал. Ерөн. сорил. биол. хүр. бүт. 1976. № 11.
13. Болд А., Кищинский А.А., Томин В.Е., Цэвээнмядаг Н. Проблемы охраны редких видов птиц МНР. Ерөн.сорил.биол.хүр.бүт. 1981. №16.
14. Болд А., Цэвээнмядаг Н. 2001. CITES. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци. ЛАВЛАХ. Шувууны хэсэг. Улаанбаатар, х.120-263.
15. Болд А., Цэвээнмядаг Н. Реликт цахлай (*Larus relictus* Lonberg, 1931) Монгол оронд. Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. Улаанбаатар. 2005. 25: .
16. Болдбаатар Ш. Хулан жороо (*Podoces hendersoni* Hume, 1871) биологийн асуудалд. Ерөн.сорил.биол.хүр.бүт. 1981. №16.
17. Болдбаатар Ш. Улаан номын шувууд. Шинжлэх ухаан амьдрал сэтгүүл. 1989. №2.
18. Болдбаатар Ш. О некоторых состояниях синантропных птиц города Ховд и его окрестностей. Природные условия и ресурсы Западной Монголии и Сопредельных регионов. 1995. с. 89-93. 0.2.
19. Болдбаатар Ш. Гурвансайханы нуруу, түүний орчмын шувууд //Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид №1 (эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэл). Улаанбаатар. 2002. 64-77.
20. Болдбаатар Ш. 2003. Богдхан уулын экосистемд хотын нөлөөлөл ба шувуудын холбогдол. Богдхан уулын хамгаалалтын менежментийн судалгаа шинжилгээний ажлын үүрэг. ЭШ эмхэтгэл. Улаанбаатар. х 12-59.
21. Болдбаатар Ш. Сэлэнгийн савын сээртэн амьтдын экологийн тулгамдсан асуудлууд. Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид. №2 (эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэл). 2005. Улаанбаатар.
22. Болдбаатар Ш. Проблемы охраны птиц Монголии и в сопредельных странах //

Современные проблемы орнитологии Сибири и Центральной Азии. Улан-Удэ. 2006. 22-27.

23. Болдбаатар Ш. Богдхан уулын экосистемийн шувуу, нөлөөлөх хүчин зүйл//Буурал түүхийн жимээр-Хан уулын энгэр бэлээр, хатан Туулын эрэг хөвөөгөөр//. 2008. УБ. 34-38.
24. Болдбаатар Ш., Букреев С.А., Звонов Б.М. Птицы котловины озера Убсу-нур и факторы, влияющие на условия их обитания. 2013. Улан-Удэ
25. Болдбаатар Ш. Монгол орны шувууны фото лавлах . 2013 б. Улаанбаатар. 450 х.
26. Болдбаатар Ш. Аман мэдээ. 2013в. г.
27. Буянт Т. 1997. Ховд голын сав дахь гургуулын судалгаа. Бакалаврын дипломын ажил. МУИС-ийн Ховд дахь салбар. 50 х.
28. Васильченко А.А. Касфийческо-Торейский Заповедник. Журн.Охота и охот. хоз-во. 1983. №4.
29. Воробьев К.А. Птицы Уссурского края. М. 1984.
30. Габузов О.С., Иванова В.С., Трошкина Н.Н. Разведение сухоноса в неволе. В кн: Исчезающие, редкие и слабо изученные растения и животные Алтайского края и проблемы их охраны. Барнаул. 1987.
31. Гладков Н.А., Дементьев Г.П. и др. Определитель птиц СССР. М.1964.
32. Гомбобаатар С. 1995. Онон, Улз голын сав нутгийн цэн тогоруу (*Grus vipio*). Монгол улсын их сургуулийн эрдэм шинжилгээний бүтээл. Улаанбаатар. N3 (121): 46-51.
33. Гомбобаатар С. Зүүн монголын тогоруу. Магистрын дипломын ажил. МУИС-ийн Байгалийн ухааны факультет. 1996. Улаанбаатар.
34. Гомбобаатар С. 2002. Онон, Улз голын сав нутгийн тогоруу. Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид №1 (эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэл). Улаанбаатар. 90-109.
35. Горошко О.А., Кирилук В.Е. 2003. Птицы заповедника “Даурский”. Наземные позвоночные Даурии. Сборник научных трудов. Государственного природного биосферного заповедника “Даурский”. Выпв 3. Чита, 20-32.
36. Гүрбадам А., Сумъяа Д. Азиатской бекасовидный веретенник в При Хубсугулье. Природные условия и ресурсы некоторых районов МНР. Тезисы докладков. УБ. 1982.
37. Данзан Г. Гельминты домашних, охотничье-промысловых и некоторых других птиц МНР. Уч. записки МОИГУ т.IX. 2(18) материалы по фауне Монголии. УБ. 1964.
38. Дементьев Г.П., Наумов Н.П. Материалы по фауне наземных позвоночных Восточного Халха. Уч. записки МОИГУ, УБ. 1966. №7
39. Дуламцэрэн С. Хар ус нуурт хун, нугас өвөлждөг. ШУА-ийн мэдээ. 1967. №3.
40. Дэлгэрмаа Б. 2004. Монгол дагуурын дархан цаазат газрын ус намгийн ховор шувуудын судалгаа ба хамгааллын менежмент. Магистрын ажил. ТУИС-ийн Магистрын алба.
41. Жизнь животных. М. 1986. т. VI.
42. Жирнов Л.В., Винокуров А.А., Бычков В.А. Редкие и исчезающие животные СССР (млекопитающие и птицы), М. 1978.
43. Зориг Г. Алтайн хойлог. УБ. 1989
44. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн лавлах, 2001.
45. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенц (CMS), 2010.
46. Иванов А.И. Католог птиц СССР. Л. 1976.

47. Иванов А.И. Краткий определитель птиц СССР. Л. 1978.
48. Ирисов Э.А., Ирисова Н.Л. Алтайский улар. Новосибирск, 1991.
49. Кищинский А.А., Томин В.Е., Болд А., Цэвээнмядаг Н. Птицы горного массива Мунх-Хайрхан (МНР). В кн.: Биологические ресурсы и природные условия МНР. М, 1982 б. т.18.
50. Козлов П.К. Из письма П.К.Козлова. Изв. ИРГО. соб.1900. т.25. вып.1.
51. Козлова Е.В. 1930. Птицы Юго-Западного Забайкалья, Северной Монголии и Центральной Гоби. Л.
52. Козлова Е.В. Птицы высоко горного Хангая по наблюдением зоологического отряда Монгольской экспедиции 1929 год. Труды Монгольской комиссии №3. Л. 1932.
53. Козлова Е.В. Птицы зональных степей и пустынь центральной Азии. Л. 1975.
54. Красная книга Бурятской АССР (животные, растения). Улан-Удэ. 1988.
55. Красная книга РСФСР (животные). М. 1983.
56. Красная книга СССР. 1978. М-Л.
57. Красная книга Уз.ССР. Душанбе. 1983.
58. Курочкин Е.Н., Михайлов.К.Е. Гнездовая авифауна гобийской территории Монголии. В кн.: Современная орнитология, 1992.
59. Лувсанхорлоо Г. 1961. Монгол орны тахианы багийн шувуу. Шинжлэх ухааны академийн мэдээ сэтгүүл. 3:26-36.
60. Майнжаргал Г. Эгийн голын сав дахь нууруудын хөндийн шувууд. Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид. №2 (эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэл). 2005. Улаанбаатар.
61. Моллесон В.С. Краткие сведения о распределении птиц в окрестностях города Троицкосовско. Протокол Троицкосовско-Кяхтинского отделения РГО Иркутск. 1896. №4.
62. Монгол улсын ан агнуурын хууль. УБ. 1975.
63. Монгол улсын амьтны аймаг. IV боть. Шувууны анги. 1989. (гар бичмэл).
64. Монгол улсын Амьтны тухай хуулийн 7-р зүйлийн нэн ховор амьтны жагсаалт, 2012.
65. Монгол улсын Засгийн газрын Ховор амьтны тухай 7-р тогтоолын 1-р хавсралт 2012.
66. Монгол улсын Улаан ном. 1997.
67. Намнандорж О. БНМАУ-ын дархан газар, цаазтай ан амьтан. УБ. 1976.
68. Ничаев В.А. Птицы курильских островов. Л. 1969.
69. Нүүдлийн амьтныг хамгаалах Олон улсын Боннын Конвенци, 2002.,
70. Нямбаяр ба Цэвээнмядаг, Монгол орны шувуудад ашигтай газар нутаг (Монгол, англи хэл дээр). Улаанбаатар. 2009. 112 х
71. Остапенко В.А., Гаврилов В.М., Болд А., Цэвээнмядаг Н. Материалы по биологии некоторых водоплавающих птиц Монголии. В сб.: География и динамика растительного и животного мира МНР. М. 1978.
72. Остапенко В.А., Цэвээнмядаг Н. 1988. О распределении журавлей в Восточной Монголии в летний период. В сб. Журавли Палеарктики. Владивосток, ДВО АН СССР. с.177-179.
73. Панов Е.Н. Новые данные по биологии и размножению большого чекона. Тр. Окского гос. заповедника. 1976. вып.3.
74. Певцов М.В. Путешествия по Китаю и Монголии. М. 1951.

75. Поливнова Н.П., Поливнов В.М., Цибкев Ы.Б. О гнездование тростникового ополовника (*Paradoxornis heudei*) на оз. Ханка. материалы VI всесоюзной орнитологической конференции. М. 1974.
76. Полевой определитель гусеобразных птиц России. Москва, 2011.
77. Пржевальский Н.М. Материалы для орнитологической фауны Монголии и страна тангутов. СПб., 1876. т.2.
78. Птицы Советского Союза. М.Л., Т. III,IV,VI, 1951-1952.
79. Птицы СССР. М. 1951.
80. Птицы СССР. Курообразные. Журавлеобразные. Л. 1987., Чайковые М. 1988.
81. Рогачева Э.В., Сыроечковский Е.Е., Александров Д.Ы., Сухбат Х., Жуков М.А., Ганбаатар Н. Материалы по фауне птиц Дархат (северная Монголия). В кн.: Материалы по фауне средней Сибири и прилежающих районов Монголии. ИЭМЭЖ АН. СССР. М. 1988.
82. Сопин Л., Медведев Д. Алтайский улар. Журн.Охота и охот. хоз-во. 1980. №4.
83. Степанян Л.С. Состав и распределение птиц фауны СССР. "Не воробьиные". М. 1975.
84. Степанян Л.С., Болд А. Материалы по гнездовой экологии птиц Тунивской АССР и Монгольской Народной Республики. Орнитология. М. 1983. Вып.18.
85. Справочник определитель птицы Европы, 2003, Москва.
86. Степанян Л.С., Болд А., Томин В.Е. Таксономический список птиц МНР. Орнитология. М. 1988. Вып.23.
87. Сумъяа Д., Самъяа Р. Хөвсгөл нуурын усны шувуудын байршил, биологийн асуудалд. МУИС-ийн эрдэм шинжилгээний бүтээл. 1983.№4.
88. Сумъяа Д., Скрябин А.Г. Птицы При Хубсугуля МНР. Иркутск. 1989.
89. Сумъяа Д., Гомбобаатар С., Наранхүү Г. 2000. Улз голын сав нутгийн ховор шувууд. Монгол улсын Их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. Биологи №10 (163). 3-9.
90. Сушкин П.П. Птицы Советского Алтая и прилежающих частей Северо-Западной Монголии. 1938. т.1,2.
91. Сушкин П.П. Список и распространение птиц Русского Алтая и ближайших частей Северо-Западной Монголии с описанием новых или малоизвестных форм. Л. 1925.
92. Тарасов М.П. Материалы по фауне птиц юго-восточной части Монгольского Алтая и прилежающей Гоби. Биологический сб. Восточно-Сибирское отделение. ГО СССР. Противочумный Инс-т Сибири и Дальнего востока. Иркутск. 1960.
93. Тарасов М.П. Некоторые экологические особенности птиц Юго-Западной Монголии. Зоол. журн. 1960.Т.XXXIX. вып.9.
94. Толчин В.А. Новые сведения о куликах юго-восточной Сибири. Материалы VI всесоюзной орнитологической конференции. М. 1974. Часть I.
95. Тугаринов А.Я. Птицы Восточной Монголии по наблюдением экспедиции 1928г. Труды Монгольской комиссии. Л. 1932.вып. I.
96. Тугаринов А.Я. Северная Монголия и птицы этой страны. В кн.: Предварительный отчет зоол. экспедиции в северную Монголию за 1926 г. АН СССР. 1929. вып. 3.
97. Фомин В.Е., Болд А. Каталог птиц Монгольской Народной Республики. М. 1991.
98. Фомин В.Е., Болд А. Новые данные об орнитофауне Монгольского Алтая. Природные условия растительных покровов и животного мира Монголии. Пушино. 1988.
99. Ховордсон зэрлэг ургамал, амьтны олон улсын худалдааны тухай Вашингтоны (1973)





- 100.Цэвээнмядаг Н., Болд А., Болдбаатар Ш., Майнжаргал Г. Хэнтийн уулархаг мужийн шувуу. Лавлах бичиг. Улаанбаатар, 2005. 130х.
- 101.Цэвээнмядаг Н. “Ази-Номхон далайн усны нүүдлийн шувуудыг 2001-2005 онд хамгаалах стратеги” олон улсын хурлын тухай товч мэдээ. Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 2000. №22. 253-254.
- 102.Цэвээнмядаг Н., Болд А. Өгий нуур, орчим нутгийн шувуу. Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид. №2 (эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэл). 2005. Улаанбаатар.
- 103.Шагдарсүрэн О. Уулын галууг гаршуулах оролдлого. Хөдөлмөр (сонин). 1964.140.
- 104.Шагдарсүрэн О. Монгол орны агнуурын ач холбогдол бүхий зарим шувууд. Биол.хүр.бүт. 1969. №3.
- 105.Шагдарсүрэн О. Монгол орны махчин шувууд. УБ. 1983.
- 106.Энхнасан Д, Гомбобаатар С. 2005. Загийн бор шувууны (*Passer ammodendri stolickzae*) морфологи, ангиллын зарим асуудал. Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид. №2. (эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэл). Улаанбаатар. 134-139.
- 107.Эрэгдэндагва Д. Ойгон нуурын хотгор дахь шувуу, хөхтөн амьтдын тухай тэмдэглэл. ШУА сэтгүүл. 1960. №2
- 108.Archimaeve-Ozerskaya, T.P. and Zabelin, V.I. 2010. Water birds of Uvs Nuur Depression. *Erforsch. Biol. Ress. Mongolei (Haale/Saale)* 11: 259-266. (in English)
- 109.Badley, J., Busuttil, S., Brookhouse, J., Gombobaatar, S., Goroshko, O., Rowland, S., Thomas, M., Uuganbayar, Ch. 2005. Important bird area survey in eastern Mongolia. A Report on Three Ornithological Surveys During May-September 2004. Ulaanbaatar. 73 p. (In English and Mongolian)
- 110.Bold, A., Tseveenmyadag, N., and Zvonov, B.V. 1995. Cranes of Mongolia. Cranes and Storks of the Amur River. The Proceedings of the International Workshop Khabarovsk-Poyarkovo-Khabarovsk July 3-12. Moscow. p. 42-47. (in English)
- 111.Braunlich, A. 2006. Bird migration in western Mongolia. Trip report. Khovd, Mongolia. 19 p.
- 112.Bugrovsky, V.V., Zalataev, V.S., Kerjentsov, A.S., and Khakimov, F.I. 1990. Biosphere cluster reservation “Uvs nuur basin”. –Information on the Problems of Research on the Biosphere. Uvs nuur basin natural model of biosphere 2:445-455. (in English)
- 113.Busching W.D. 2003. Identification of Mongolian birds, Families: Motacillidae, Bombycillidae, Troglodytidae, Cinclidae, Prunellidae and Laniidae based on feather collections. *Beitraege zur Gefiederkunde and Morphologie der Voegel*. 1. (in German).
- 114.BirdLife International 2001a. Threatened birds of Asia: BirdLife International Red Data Book. Cambridge, UK. BirdLife International. 1516 pp. (in English)
- 115.Fischer W. 1970. Ornithological observations and an attempted bird survey at the Mongolian desert lakes, Orog and Buuntsagaan. *Zool. Abh. Ber. Mus. Tierkd.* 30:201-2096 (in German)
- 116.Gantulga, B., Gombobaatar, S., Muehlenberg, M. 2010. Breeding Success and Cooperative Breeding Behavior of Azure-winged Magpie (*Cyanopica cyanus* Pallas, 1776) in Mongolia. M.Sc. thesis of the National University of Mongolia. Ulaanbaatar. Mongolia.
- 117.Gombobaatar, S., Gregor, S., Yosef, R., Ketzenberg, C., Uuganbayar, Ch. 2008. Waders in Mongolia: Present and future research and conservation. Proceedings of Wader Study Group Conference. Jastrzebia Gyra (Hawk Hill), Poland. 3 to 6 October 2008. (in English)

118. Gombobaatar, S., Leahy, Ch. and Boldbaatar, Sh. 2011a. A field Guide to the Birds of Mongolia. A & C Black UK. (in press) (in English)
119. Gombobaatar, S., Munkh-Erdene, J., Buyantsog, B. and Jelen, E. 2011b. Wintering Ring-necked Pheasants (*Phasianus colchicus*) in Western Mongolia. Report to the Focusgruppe der Edelfasanen, France. Mongolian Ornithological Society and National University of Mongolia. Ulaanbaatar-Mongolia. 20 pp. (in English)
120. Dawaa, N., Busching, W.D., Sumijaa, D., Bold, A., Samijaa, R. 1994. Checklist of Birds and Mammals. V. 1: Vögel Naumann-Museum Köthen. 207 p. (in German and Mongolian)
121. Harrison C. 1975. A field guide to the nests, eggs and nestings of British and European Passerines. Collins Grafton Street, London. 432 pp.
122. Heidoke, D., Stubbe, M., Sumjaa, D., Ansorge, H. Saxicola insignis-Verbreitung und Brutort. Internationales simposium "Biologischer Ressourcen der Mongolii" Thesen. Halle/Else 1992.
123. Hennache A and Ottaviani M. 2006. Monograph on Pheasants. V. 2. W.P.A., Cleres, France. P. 91-118 (in French).
124. Kiton A., *Larus relictus* a review Bull Brit Ornithol Club, 1980 b. Vol 100, N3.
125. Kleinstauber C., Succow M. Zur avifauna der Nordmongolia (westliche Chentey-Ausläuter und Vorland) Mitt. Zool. Mus. Berlin Bd 54 Suppl. Ann. Orn. 2 1971.
126. Kozlova E.V. Zur Biologie von *Partuncola insignis* Blyth Comptes Rendus de l'Acad des sciences de l'URSS. 1930.
127. Lonnberg E. Notes of birds, collected by Mr. Otto Barberg in Southern Transbaikalia and Northern Mongolia. Arkiv for Zool. Bd. V. 9. 1909.
128. Mauersberger, G. 1979. Okofaunistische und biologische Beiträge zur Avifauna der Mongolie. Allgemeiner Teil und Podicipediformes bis Galliformes. Mitt. Zool. Mus. Berlin 55 (Ann. Orn. 3) 99-126. (in German)
129. Mauersberger, G. 1980. Taxonomical problems of Mongolian avifauna. Mitt. Zool. Mus. Berlin 59, Suppl.: Ann. Orn. 7: 47-83. (in German)
130. Mauersberger G, Wagner S, Wallschlaeger D and Warthold R. 1982. New data for Mongolian avifauna. Mitt. Zool. of Mus. Berlin. (58) 1:11-74. (in German)
131. Mongolian Red List of Birds, 2011.
132. Nyambayar, B., Brunlich, A., Tseveenmyadag, N., Shar, S., and Gantugs, S. 2007. Conservation of the critically endangered east Asian population of Dalmatian pelican *Pelicanus crispus* in Western Mongolia. Birding Asia 7:68-75. (in English)
133. Ostapenko W.A. Zevenmjadag N. Über Verbreitung Anzadi und Biologie der Kraniche in Ostteil der mongolischen Volksrepublik Beitr. Vogelkd., Jena 29 1983/5
134. Prechok R. Beiträge zur Avifauna der Mongolei Teil II. Non-Passeriformes. Witt. Zool. Mus. Berlin. 1968. 44.
135. Prechok R. Beiträge zur Avifauna der Mongolei Teil II. Non-Passeriformes. Witt. Zool. Mus. Berlin. 1972. 48.
136. Prechok R. Stubbe M. Uhlenschultze K. und Sumjaa D. Beiträge zur Avifauna der Mongolei. Witt. Zool. Mus. Berlin 57. 1981. nur 5.
137. Radde G. Reisen in Sudan von Ost-Sibirien in den Jahren 1855-1859 S-Pb. 1863. Bd. 2.
138. Stenzel, T., Stubbe, M., Samjaa, R., Stubbe, A. and Dulamsuren, C. 2005. The set of species of the Avifauna of Mongolia during a North-South-crossing in 1997. Erforsch. biol. Ress. Mongolei



(Halle/Saale) 2005. (9): 311-391. (in German)

139. Stephan, B. 1988. Ornithological observation in the Mongolian People's Republic. Faun. Abh. Stat. Mus. Tierkd. 15:167-197. (in German)
140. Stubbe M., Bold A. Women und Seeschwalben (Laridae, Aves) der Mongolia. Mitt.Zool.Mus.Berlin, 1971. Bd.47. N I,
141. Stubbe A., Stubbe M., et all. 2010. Erforschung biologischer Ressourcen der Mongolei. Band 11. Brutareale und Brutbiologie der Greifvogelarten der Mongolei. Martin-Luther-Universität Halle Wittenberg, Halle (Saale) 137-163.
142. Usukhjargal, D., Gombobaatar, S. and Boldbaatar, Sh. 2010. Status and Conservation of raptors in Hus-tai National Park. Proceedings of the 6 th International Conference on Asian Raptors. Ulaanbaatar, Mongolia. 23-27 June 2010. Asian Raptor Research and Conservation Network and Mongolian Ornithological Society. p. 83. (in English)
143. Wichmann, F. 2001. Analyse der Vögelgemeinschaft im Habitatmosaik Einer Naturlandschaft im Norden der Mongolei, Westchentie. Diplomarbeit Univeristät Göttingen. (in German)



1. Монгол хуланхоолоо  
*Podiceps hendersoni*  
Henderson's Ground Jay

2. Цагаан тогоруу  
*Grus leucogeranus*  
Siberian White Crane

3. Ховин толгоо  
*Otus tarda*  
Great Bustard

4. Цэн тогоруу  
*Grus vipio*  
Japanese White-naped Crane

5. Усмы нэрлэгч  
*Haliaeetus leucorhynchus*  
Pallas's Fish-eagle

6. Бор буграа  
*Aquila clanga*  
Greater Spotted Eagle



1



2




3



4



5



6

1. Говийн нэхэр хуруут гүрээл  
*Cyrtopodion elongatus*  
Gobi Naked-toed Gecko

2. Байг, татрын нэлт  
*Eryx tataricus*


3. Шинэр гүлээр  
*Salamandrella keyserlingii*  
Siberian Salamander

4. Түгээн сүүд могой  
*Eryx tataricus*  
Tatary Sand Boa

5. Ногоон бах  
*Pezomachus*  
Pezomachus's toad or Central  
Asian green toad


6. Махаон дэмүүр  
*Papilio machaon*

МӨЛХӨГЧ



### 3. Мөлхөгч

1. ГОВИЙН МАХИР ХУРУУТ ГҮРВЭЛ



*Cyrtopodion elongatus* Blanford, 1875

**Баг.** Гүрвэлтэн - *Lacertilia*

**Овог.** Гекконтныхон - *Gekkonidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлсэн бөгөөд олон улсын хэмжээнд үнэлгээ хийгээгүй.

**Таних шинж:** Бие 51.3 мм, сүүл 73.1 мм урт. Их бие цайвардуу бор хүрэн зүстэй. Нуруун дээгүүрээ сүүлийн үзүүр хүртэл 5-7 хөндлөн хүрэн судалтай. Сүүлийн үзүүр ямагт цайвар цагаан. Хэвэл үл мэдэг шаргалдуу туяа бүхий цагаан зүстэй.

**Тархац, байршил нутаг:** Алтайн өвөр говийн Ногоон довонгийн ус, Шар хулсны баян бүрд, Ногоон цавын хоолой, Ингэн хөөврийн хоолой, Цуглабарын нуруу, Цувраа хар уул, Хэрмэн цав, Зулганайн баян бүрд, Бүгийн цав, Наран булаг, Хайчийн уул зэрэг д.т 700-1300 м өргөгдсөн уул толгодын бэлийн хад асга, гуу жалга, хуурай сайр, хайргат цөлд идээшин амьдарна [1,2,4,5,6,7,8,9]. Хад асганы ан цав, завсар, хонгил, хөндий, мэрэгчдийн нүх, унанги заг, хавтгай чулууны дор болон бутлаг, ургамлын үндэс орчимд орогноно [1].

**Амьдралын онцлог:** Цөлийн бүсийн элдэв шавжаар хооллоно. Популяцийн эр, эмийн харьцаа 1.8:1. VII сарын дунд үе хүртэл өндөглөдөг. Алтайн өвөр говьд VII сарын дунд үед өндөгнөөс зулзага гарна. IX сарын дундуур зулзаганы бие 25-28 см, сүүл 32-34 см урт болно. Зуны улиралд үдшийн бүрийгээс шөнө дунд хүртэл идэш тэжээлээ хайдаг бөгөөд шөнө дундаас хойш идэвх буурч, 04 цагаас хойш үзэгдэхгүй [8]. Хад чулууны ан цаваар гарч заг, харганы мөчрөөс махир хуруугаараа бэхлэгдэн зүүгдэж мөчрөөс мөчирт ойр ойрхон үсэрч явна [7].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Жигд биш нягтшилтай. Алтайн өвөр говийн Шар хулсны баян бүрд орчимд 1 км явахад уулсын хажуу бэлийн хад чулуунд нэг, Ногоон цавын хоолойн хад асганд 6 бодгаль, 2009 онд 100 м зайд 30 бодгаль тус тус тэмдэглэжээ [7,8]. Дэлдэн зараа,


сум могой уг гүрвэлээр хооллоно [3]. Тухайн нутагт олон жил дараалсан ган тохиолдох, шөнийн идэвхтэй шавжийн тоо толгой буурснаас тэжээлийн хомсдолд орж устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэжээ. Монгол улсын улаан номонд оруулсан [6,10]. Тархац нутгийн 55 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан [10,11,12]. Үндсэн тархац нутаг Говийн их дархан цаазат газар болон Говь гурван сайханы байгалийн цогцолбор газарт хамаарна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулах. Алтайн чанадахь говийн Ногоон цавын хоолой хэмээх газрыг улсын тусгай хамгаалалтад авч, мөлхөгчдийн нөөц газар байгуулах, удмын санг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ананьева нар, 1997, 2. Боркин нар, 1983, 3. Боркин нар, 1990, 4. Мөнхбаяр, 1976, 5. Мөнхбаяр, 1977, 6. Мөнхбаяр, 1987, 7. Мөнхбаяр нар, 2009, 8. Мөнхбаяр, Тэрбиш, 1988, 9. Мөнхбаяр, Тэрбиш, 1997, 10. Terbish et al., 2013, 11. Terbish et al., 2006a, 12. Terbish et al., 2006b.

## 2. ТОЙРМЫН ХОНИН ГҮРВЭЛ



*Phrynosephalus helioscopus* Pallas, 1771

**Баг.** Гүрвэлтэн - *Lacertilia*

**Овог.** Замба гүрвэлтнийхэн - *Agamidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “үнэлэх боломжгүй”, олон улсын хэмжээнд үнэлгээ хийгээгүй.

**Таних шинж:** Бие 59 мм, сүүл 70 мм урт. Хүзүүн дээрээ тод хөндлөн нугачаастай, шилэн хүзүүний орчим нарийн хөх хөвөө бүхий улаан ягаан өнийн хос толботой байдгаараа бусад гүрвэлээс ялгагдана. Нуруу, биеийн хажуу, сүүлний дээд хайрсууд арзгар өргөсөрхөг.

**Тархац, байршил нутаг:** Дэлхийн тархацын хамгийн зүүн хойд сэжүүр болох Ховдын Булган сумын Ярант, Салхитын хөтөл, Их, Бага Онгог, Давхар хөтлийн бэл зэрэг нутагт тархана [1,2,9]. Алаг өвс, хялганат, хүрэн хөрстэй хээр, шарилж, таар-монгол өвст шавранцар хөрстэй цөлөрхөг хээр, үетэн, таарт хайргат цөлд идээшилнэ. Тойрмын хонин гүрвэлийн дэлхийн популяцийн нэгээс бага хувь нь Монгол оронд тохиолддог [8,9].

**Амьдралын онцлог:** Цох, эрвээхий, шоргоолж, бясаа, царцаа, ялаа зэрэг шавжаар хооллоно. Популяцийн эр, эмийн харьцаа ойролцоогоор 1:1. IV сарын эхээр хөөцөлдөж эхэлнэ. Онгогийн хөдөөгөөс барьсан эмэгчингээс 5.3:7.1, 5.8:7.9 мм хэмжээтэй өндөг гарчээ [4,5].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Цөлөрхөг хээрийн бүсэд 1 га талбайд 76-107, таар бүхий хайргат цөлд 1 га талбайд 63 бодгаль тааралдав [5,7]. Дэлхийн тархацын захад оршдог, Монгол орны хувьд хязгаарлагдмал тархацтай амьтан бөгөөд популяци нэн эмзэг учир амьдрах орчныг доройтуулах, барих зэргээс устах хандлагатай болов. Шонхор, хэрээ, цахлай, бамбай хоншоорт могойн хоол болдог [5]. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номонд оруулж [3], Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэжээ. Тойрмын хонин гүрвэлийн Монгол дахь тархац нутгийн нэгээс бага хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагджээ [6,8,9]. Тархац, нөөц, биологийн хэсэгчилсэн тойм судалгаа хийсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулах, улсын тусгай хамгаалалттай газар нутагт удаан хугацааны мониторингийн судалгаа явуулж үнэлгээ өгөх, хэвийн өсч үржих нөхцлийг бүрдүүлэх, өсгөн үржүүлэх ажлыг дэмжих, удмын санг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ананьева нар, 1997, 2. Боркин нар, 1990, 3. Мөнхбаяр, Тэрбиш, 1997, 4. Тэрбиш, Пүрэвжав, 2000, 5. Meyer, Zinke, 1992, 6. Terbish et al., 2013, 7. Terbish, 1992, 8. Terbish, 2006a, 9. Terbish, 2006b.

### 3. ТОЛБОТ МОГОЙ ГҮРВЭЛ



*Eremias arguta potanini* Bedriaga, 1912

**Баг.** Гүрвэлтэн - *Lacertilia*

**Овог.** Жинхэнэ гүрвэлтнийхэн - *Lacertidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлсэн бөгөөд олон улсын хэмжээнд үнэлгээ хийгээгүй.

**Таних шинж:** Биеийн урт 95 мм, сүүл богино. Зүс ногоовтор туяа бүхий цайвардуу бор хүрэн. Нурууны хоёр талаар үргэлжлэн эгнэсэн цөөн хүрэн толботой. Хэвэл цайвар. Духны хайрс гүн ховилтой, шилбэний дотор талын гадна эгнээний хайрс жижгэвтэр зэрэг шинжээрээ монголын бусад гүрвэлээс ялгаатай.

**Тархац, байршил нутаг:** Хонин усны говь, Тахийн ус, Загийн толгойн худаг, Хүрэн дэлийн хотгор, Майхан хар уулын баруун хэсэг, Алтай, Үенч сумын төв орчим, Хусны ар дэн, Бамбагарын шал, Бодончийн гол, Цагаан түнгийн эх, Булганы хөдөө, Уушигийн ус, Байтаг Богдын нурууны арын хотос, Олон булаг, Хөвчийн нуруу, Гүн тамга зэрэг Зүүн гарын говийн шавранцар, элсэнцэр, хайрган хөрстэй, д.т. 800-1800 метр өргөгдсөн нутагт байршина [1,3,5,6,8,9]. Их нуурын хотгорын Хяргас нуурын урд эргээс тэмдэглэсэн мэдээг [8] нягтлан тодруулах шаардлагатай. Сайр, садаргын дагуу баглуур, зээргэнэ, заг бүхий хайргат цөл, голын эргийн дагуу хармаг, дэрс бүхий довцог элсэнд идээшин амьдардаг.

**Амьдралын онцлог:** Цох, эрвээхий, шоргоолж, бясаа, царцаа, ялаа зэрэг шавжаар хооллоно. Зүүн гарын цөлийн популяцийн эр, эмийн харьцаа 55.7:44.3 байв. V сард ороо хөөцөлдөө болж, VI сарын эхээр 6 хүртэл өндөг гаргана. IX сарын дундуур зулзаган гүрвэлийн урт 43 мм, жин 1090 мг хүрдэг [1,7].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Амьдрах орчныхоо онцлогтой уялдан нягтшил нь харилцан




адилгүй. Нэг га талбайд 3-29 бодгаль байдаг. Судалгаанаас үзэхэд, зараа, үнэг, хярс, дэглий, харцага, шонхор, сар, элээ, бүргэд, тоодог, хэрээ, сум могой, бамбай хоншоорт могой зэрэг амьтдын идэш болно [1,7]. Монгол нутаг энэ гүрвэлийн дэлхийн тархацын хамгийн зүүн зах хязгаар учир амьдрах орчныг доройтуулахад тоо толгой хорогдох талтай. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэжээ. Монгол улсын улаан номонд оруулж [2,4], тархац нутгийн 18 орчим хувийг Говийн их дархан газарт хамруулсан [10,11,12,13]. Тархац, нөөц, биологийн хэсэгчилсэн судалгаа хийсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Толбот гүрвэлийн популяцийн тоо толгой, биомассын талаар удаан хугацааны мониторингийн судалгаа явуулж, үнэлгээ өгөх, удмын санг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ананьева нар, 1997, 2. Мөнхбаяр, 1987, 3. Мөнхбаяр, Шагдарсүрэн, 1968, 4. Мөнхбаяр, Тэрбиш, 1997, 5. Орлова, Тэрбиш, 1986, 6. Тэрбиш, 1985, 7. Тэрбиш, 1989, 8. Тэрбиш, Мөнхбаяр, 1982, 9. Щербак, 1974, 10. Terbish et al., 2013, 11. Terbish et al., 2007, 12. Terbish et al., 2006a, 13. Terbish et al., 2006b.

#### 4. ТЭМЭЭН СҮҮЛ МОГОЙ



*Eryx tataricus* Lichtenstein, 1823

**Баг.** Могойтон - *Serpentes*

**Овог.** Аварга могойныхон - *Boidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” хэмээн үнэлсэн бөгөөд олон улсын хэмжээнд үнэлгээ хийгээгүй.

**Таних шинж:** Бие 91 см урт. Сүүл богино мухар, өнгөц, харахад толгой, сүүл ялгагдахгүй. Толгойн дээд талд том бамбай хайрсгүй. Бие жижиг мөхлөгөн хайрстай. Хэвэл хайрс хэвэл дунд хэсгийг бүрнэ. Их бие боровгор зүстэй. Нуруу, биеийн хажуу талаар бор хүрэн, хар хүрэн торлосон толбуудтай. Хэвэл цайвар, толбо нэлээд шигүү.

**Тархац, байршил нутаг:** Борзонгийн говь, Зээмэгийн говь, Ногоон цав, Толь булаг, Эхийн гол, Говь-Алтайн Алтай сумын төв орчим, Тахийн шар нурууны баруун хэсэг, Ногоон довонгийн ус зэрэг газарт тохиолдоно [1,3,4,6,8]. Заг, зээргэнэ, нохой шээрэн, хармаг, торлог зэрэг мод, сөөг ургамалтай довцог элс, сайр садарга, сухай, зэгс, хулстай баян бүрдэд идээшинэ. Ихэвчлэн шөнийн амьдралтай. Эхийн гол орчимд өглөө эрт, оройн сэрүүнд үзэгдэнэ [8].

**Амьдралын онцлог:** Биологийг судлаагүй. Гүрвэл, мэрэгчдээр хооллоно. IV сарын эцэс, V сарын эхээр ороо хөөцөлдөөнд орж, 3-34 хүртэл зулзагыг VII сарын эцсээс VIII сар хүртэл гаргана [2].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Говь, цөлийн заг, сухай зэрэг ургамлыг хэт ашигласнаас амьдардаг орчин доройтох, махчин шувууд, зараанд идүүлэх зэргээр хорогддог байна [1,8,10]. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан [5,7]. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад оржээ. Байршил нутгийн 33 орчим хувийг Говийн их дархан цаазат газарт хамруулав [10]. Тархац, нөөцийн хэсэгчилсэн судалгаа хийгдсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Алтайн чанадахь Говийн Ногоон цавын хоолойг улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамруулан, мөлхөгчдийн нөөц газар байгуулах, удмын санг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ананьева нар, 1997, 2. Богданов, 1960, 3. Боркин нар, 1990, 4. Мөнхбаяр, 1976, 5. Мөнхбаяр, 1987, 6. Мөнхбаяр, 1981, 7. Мөнхбаяр, Тэрбиш, 1997, 8. Тэрбиш, 1989, 9. Terbish et al., 2007, 10. Terbish et al., 2006a.

## 5. НАРИЙН МОГОЙ



*Coluber spinalis* Peters, 1865

**Баг.** Могойтон - *Serpentes*

**Овог.** Нарийн могойныхон - *Colubridae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” хэмээн үнэлсэн бөгөөд олон улсын хэмжээнд үнэлгээ хийгээгүй.

**Таних шинж:** Бие нарийхан, 570 мм урт, сүүл түүнээс 3-4 дахин богино. Хоншоор дугуйвтар, дээд талаасаа хавтгай. Цайвардуу бор зүстэй. Духнаас сүүлийн уг хүртэл, нурууны голоор тууш цагаан шаргал судалтай байдгаараа бусад могойноос ялгаатай.

**Тархац, байршил нутаг:** Говь-Алтайн Захуй, Зарман, Аж Богд, Баянхонгорын Их Богд, Орог нуур, Холбоолж нуур, Өмнөговийн Тост, Ноён, Буурын нуруу, Хоолойн гашуун, Хан Богд, Ноён сумын төв, Дундговийн Талын уул, Уулын худаг, Баяндов, Дорноговийн Сулинхээр, Хөвсгөл сумын нутаг, Сүхбаатарын Дариганга, Өвөрхангайн өмнөд хэсэгт цөөн тааралдана [1,2,3,4,6,8]. Мөн Сэлэнгэ аймгийн нутаг, Орхон голын савд хамаарах Цагаан толгой орчмоос энэ зүйлийг тэмдэглэсэн байна. Цөл, цөлөрхөг хээр, хуурай хээрийн бүсийн хад асгатай уулсын суга, бэлээр сөөг бүхий элсэрхэг хөрстэй газар идээшлэнэ. Мэрэгчдийн нүхэнд орогноно.

**Амьдралын онцлог:** Монголд судлаагүй. Ихэвчлэн гүрвэлээр хооллоно. VII сард нэг эмэгчин могой 9 өндөгтэй байв [1].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Жил дараалсан ган гачиг, говийн баян бүрдүүдийн доройтол, булаг шандын ширгэлт зэргээс зүйлийн тоо толгой буурч байна. Түлээ, түлшний зорилгоор мод бутыг түүх, ашигт малтмалын хайгуул, олборлолт зэрэг аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр амьдрах орчны хомсдол бий болж, тархац нутаг хумигдан, тоо толгой


буурах магадлал нэн өндөр.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын улаан ном /1987, 1997/-онд оруулсан [5,7]. Нарийн могойн тархац нутгийн 24 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчилсэн хамруулсан [9,10,11].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулах, хэвийн өсч, үржих нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авах, удмын санг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1958, 2. Боркин нар, 1990, 3. Боркин нар, 1983, 4. Мөнхбаяр, 1976, 5. Мөнхбаяр, 1987, 6. Мөнхбаяр, 1981, 7. Мөнхбаяр, Тэрбиш, 1997, 8. Семенов, Шенброт, 1986, 9. Terbish et al., 2013, 10. Terbish et al., 2007, 11. Terbish et al., 2006a.

## 6. ЭГЭЛ ЗАГАЛМАЙТ МОГОЙ



*Vipera berus* Linnaeus, 1758

**Баг.** Могойтон - *Serpentes*

**Овог.** Загалмайт могойнхон - *Viperidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлсэн бөгөөд олон улсын хэмжээнд үнэлгээ хийгээгүй.

**Таних шинж:** Их биеийн урт 74 см хүрдэг дунд зэргийн хэмжээтэй могой. Нурууны нэг эгнээний хайрс 19. Хэвэл хайрс эр амьгад 132-151, эм амьганд 140-156, төгсгөлийн сүвийн бамбай хайрс нэг. Хамрын сүв хамрын хайрсны төв дунд оршино. Энэ могойн их бие цайвар хүрэн зүстэй, нурууг дагаж тахиралсан хар бараан судалтай. Мөн нүднээс завж хүрсэн хар судалтай. Толгой дээрээ хэрээс хэлбэрийн хээтэй, хэвэл цайвар хүрэн юмуу хар толботой.

Заримдаа улаан хүрэн юмуу хилэн хар зүстэй могойнууд тохиолдоно. Сүүлийн үзүүр цайвар шар эсвэл улбар [3].

**Тархац, байршил нутаг:** Эгэл загалмайт могой Хэнтийн нуруу, Хөвсгөлийн уулс, Монгол Алтайн нурууны баруун хэсгээр тохиолдоно [1,3,4,5,6,]. Алтай Таван Богдын байгалийн цогцолбор газрын нутаг дэвсгэрт, элдэв өвст уулын нуга, шилмүүст ой бүхий хад чулуут уулсын энгэр хажуугаар гол төлөв уулын ойт хээр, уулын хээрт идээшин амьдарна.

**Амьдралын онцлог:** Монголд судлаагүй. Судалгааны дүнгээс үзвэл, өдрийн идэвхтэй амьдралтай. Хавар ичээнээс гарснаас хойш 2-4 долоо хоногийн дараа эвсэлд орж, хээлээ бараг 3 сар тээнэ. 6-12 хүртэл тооны амьд зулзага төрүүлнэ. Хоёрнутагтан, жижиг мэрэгчид, бор шувууны багийн жижиг шувуудын ангаахай, дэгдээхийгээр гол төлөв хооллоно. Эгэл загалмайт могойгоор зараа, өмхий хүрэн, үнэг, дорго, махчин шувууд хооллоно [2].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Монгол Алтайн нурууны баруун бие, Сонгинотын голын савын ойт хээр, элдэв өвст уулын хээрт 7 сард нийт 10 км замналд 4 бодгаль тааралдана [5]. Түлээ, түлшний зорилгоор мод бутыг түүх, ашигт малтмалын хайгуул, олборлолт зэрэг аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр амьдрах орчны хомсдол бий болж, тархац нутаг нь хумигдан, нягтшил нь буурах магадлал нэн өндөр. Аливаа зүйл могойг ямар ч зорилгогүйгээр хөнөөн устгах явдал Казах иргэдийн дунд түгээмэл. Устаж болзошгүй зүйл.


**Хамгаалсан байдал:** Тархац нутгийн 9 орчим хувь нь Алтай Таван Богд, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар, Хан Хэнтийн дархан цаазат газрын нутаг дэвсгэрт хамаарна [7,8].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулах, ховор амьтны жагсаалтад оруулж, хэвийн өсч, үржих нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авах, орон нутгийн тусгай хамгаалалтад авч, удмын санг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ананьева нар, 1997, 2. Банников нар, 1977, 3. Мөнхбаяр нар, 2010, 4. Семенов, Мөнхбаяр, 1996, 5. Тэрбиш, 1989, 6. Тэрбиш, Мөнхбаяр, 1989, 7. Terbiash et al., 2007, 8. Terbish et al., 2006b.



## 4. Хоёр нутагтан



*Salamandrella keyserlingii* Dybowskii, 1870

**Баг.** Сүүлтэй хоёр нутагтан - *Caudata*

**Овог.** Гүлмэртхэн - *Hynobiidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлжээ.

**Таних шинж:** Бие сүүлний хамтаар 8-9 см урт. Хоёр хажуугаараа 13-15 босоо төвгөртэй, мөчид 4 хумстай. Бүлтгэр нүдтэй, хоёр хажуугаасаа хавчиг сүүлтэй, нуруугаа дагасан бүдэг төвгөртэй. Боровгор хар хүрэн нуруутай, хэвэл, хоолой цайвардуу.

**Тархац, байршил:** Бага Хэнтийн нуруу, Богдын гол, Туул гол, Баянзүрхийн ар, Онон голын дагуу Биндэр, Орхон, Сэлэнгийн дагуу Хүдэр, Шаамар, Зүүнбүрэн, Эгийн голын Хонгор толгой, Аригийн гол, Мөнхсарьдаг, Дархадын хотгор, Шишхэдийн гол, Тэсийн голын савд байдаг [1,3,4,5,6,7,11,12]. Уулын тайга, ойт хээрийн бүслүүрийн гол, мөрөн, нуур, цөөрмийн намгархаг газар амьдарна. Өдөр чийглэг газар унасан дархи, гол мөрний эргийн сөөг, сөөглөг ургамал, малын аргалын дор, хад асганы өвс ногоонд нуугдана [13].

**Амьдралын онцлог:** Элдэв шавж, зөөлөн биетэн, чийгийн улаан хорхой, хавч хэлбэртэнээр хооллоно. Авгалдайн үедээ жижиг шавж, нэг эст замаг иддэг. Ичээнээс IV сард гарч, V сард түрсээ шахна. Үржлийнхээ үед өдрийн идэвхтэй. Баянзүрх орчмоос 1969 оны V сард эмэгчин гүлмэрийн түрсний хос уут бүрээс 60-298 түрс гарсны 86 бодгаль 2.5 мм голчтой байлаа [2,7]. Хөвсгөлийн Мөнхсарьдагийн нурууны өврийн нуураас 1981 оны VII сарын 10-нд олдсон гүлмэрийн түрсний голч 5 мм байв. Эрэг орчмын 1 м талбайд 3-4 түрс ноогдоно [1,5]. Хөвсгөлийн уулархаг нутагт шанаганцарлах хугацаа VI сарын 20-ноос эхлээд VII сарын 15-нд үргэлжилнэ [3,5]. Шанаганцарын хөгжил VIII сарын дундуур дуусаж, хуурай газар, усны эрэг орчимд бөөгнөрнө. Ийм зулзага 24-30 мм урт биетэй, 10-19 мм урт сүүлтэй. Түрс шахахаас эхлээд хуурай газар гарах хүртэл 3 сар орчим болно [1,2,7]. Өндөр уулын бүслүүрт гүлмэрийн авгалдайн хөгжил нам дор газрынхаас, 2-3 долоо хоногоор хоцорно.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Амьдрах орчныг өөрчлөх, ус намаг хатаж хуурайших, усан орчин бохирдох зэрэг шалтгаанаас тоо толгой цөөрөн ховордож байна. Ийм шалтгааны улмаас 1960-аад онд Баянзүрх орчимд элбэг байсан шивэр гүлмэр одоо тун ховордов [10]. Шаамарын орчимд авгалдайн нягтшил литр усанд дунжаар 0.004-0.027, дүрс хувиралтын шатанд буй авгалдай 10 хавтгай дөрвөлжин метр талбайд 18 ширхэг байв [2]. Авгалдайг усны цох ихээр иддэг [1]. Шаамар орчмоос барьсан нэг настай гүлмэрийн уушиг *Rhabdias* төрлийн нематодотой холбоотой халдварласан тохиолдол ажиглагдав [1]. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын улаан ном /1987, 1997/-нд оруулсан [8,10]. Тархац нутгийн 16 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагджээ [14,15,16]. Үүний үлэмж хэсэг нь Хан Хэнтий, Хорьдол Сарьдагийн дархан цаазат болон Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамаарна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулах. Сэлэнгэ аймгийн нутаг, Орхон голын сав дахь Шаамарын Бүүрэг толгой хэмээх газрыг тусгай хамгаалалтад авч, хоёр нутагтан, мөлхөгчдийн нөөц газар байгуулах. Уг арга хэмжээг хэрэгжүүлснээр энд идээшин амьдарч буй хоёр нутагтан, мөлхөгчдийн 8 зүйлийг цогцоор хамгаалах боломжтой болно [16]. Мөн удмын санг хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Боркин нар, 1988, 2. Кузьмин, Мөнхбаяр, Оюунчимэг, 1986, 3. Литвинов, Скуратов, 1986, 4. Мөнхбаатар нар, 2001, 5. Мөнхбаяр, 1962, 6. Мөнхбаяр, 1967, 7. Мөнхбаяр, 1976, 8. Мөнхбаяр, 1987, 9. Мөнхбаяр нар, 1991, 10. Мөнхбаяр, Тэрбиш, 1997, 11. Улыкпан, Мөнхбаяр, 1982, 12. Хотолхүү, 1969, 13. Masato Hasumi et al., 2009, 14. Terbish et al., 2013, 15. Terbish et al., 2006a. 16. Terbish et al., 2006b.

## 2. НОГООН БАХ





*Bufo pewzovi Bedriaga, 1898*

*Баг. Сүүлгүй хоёр нутагтан - Anura*

*Овог. Бахтныхан - Bufonidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлжээ.

**Таних шинж:** Биеийн урт 9 см. Урд хөлийн 4 дэх хуруу, 3 дахь хурууны 1 дүгээр үед хүрсэн байдгаараа монгол бахаас ялгаатай. Ногоовтор саарал зүстэй, эм амьтны нуруун дээгүүрээ бараавтар хул толботой, эр бүдэг сааралдуу толботой.

**Тархац, байршил нутаг:** Монгол Алтайн нурууны баруун урд тал, Булган голын дагуу, Зүүнгарын говьд тархжээ. Одоогоор энэ бахыг Ховд аймгийн Булган, Үенч, Алтай сумдын нутаг Улиастай, Дээд нарийн, Мэлхийт, Сөнхөл, Индэрт голууд, Уушигийн болон Дамжигийн ус, Өвдөг, Хүйтэн булаг, Баян мод, Ихэр толь, Шар булаг, Хөх булаг, Хавчиг булаг, Ямаан усны булаг, Үенч гол, Тахилт, Хөндлөнгийн булаг зэрэг газраас тэмдэглэжээ [1,2,3,4,5,6,8,9,10,11,12]. Уулын хээр, цөлийн баян бүрдийн хуурай уур амьсгалтай нутагт нуга, намаг, жижиг булаг, шанд, голын эргийн дагуу амьдарна. Өдөр хад чулууны доорх хөндий, мэрэгчдийн нүх, өвс ургамлын үндэсний завсар зайд орогноно [10].

**Амьдралын онцлог:** Бие гүйцсэн ногоон бах, цох, шоргоолж, хос далавчтан зэрэг шавжаар, шанаганцар нэг эст замгаар голдуу хооллоно. Хүйтэн булагт V сарын 15-нд усны хэм 6-13°C байхад, горхийн дагуу 100 метр тутамд түрсээ шахаж буй 3 хос бодгаль тохиолдож байв. V сарын дундуур Хүйтэн булагт 10-15 мм хэмжээтэй шанаганцар, нийлэгт орж, түрсээ шахаж буй хос бодгалиуд болон бахын түрс элбэг байв. Эндээс үзэхэд, ногоон бахын үр хөврөлийн болон авгалдайн хөгжил монгол орны нөхцөлд ойролцоогоор 1.5-2 сар үргэлжилнэ [9]. Эр, эмийн харьцаа Улиастайн голд 7 дугаар сард 2:1, Ямаан усны булагт VI сард 7,5:1, Үенч орчимд X сард 1:2, Хүйтэн булагт V сарын дундуур 1:2,4 тус тус байв [1,10,11]. Ийнхүү тухайн нутаг дахь популяцийн хүйсийн тоон харьцаа харьцангуй их хэлбэлзэлтэй байгаа нь эр, эм бодгалиудын хоногийн идэвхжил улирлаар хувьсан өөрчлөгддөгийг гэрчилнэ.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Улиастайн голд шөнө 1-2 цагийн турш явуулсан ажиглалтаар, 5-30 бодгаль, Хүйтэн булгийн 200:4 метр талбайд дунджаар 104 бодгаль, Улаан үзүүрийн булгийн 240:2 метр талбайд 172 бодгаль байгааг тогтоов [9,10,11,12]. Зүүн гарын говийн зарим баян бүрдэд үржлийн болон ичээний үедээ олноор цугладаг. Цөлийн булаг шанд, намаг хатаж хуурайшсанаас олноороо хорогдоно. Айл өрх, мал сүрэг сэлгээгүй, удаан хугацаагаар байнга суурьшин нутаглах нь хуурай бүс нутгийн эмзэг экосистем болох уст цэг, түүний орчмын нутгийн, амьдрах орчныг доройтуулна [16]. Устаж болзошгүй зүйл.


**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэжээ. Монгол улсын улаан номны хоёрдахь хэвлэлд ховор зэрэглэлээр орсон [7]. Говийн Их дархан цаазат гарын “Б” хэсэг, Булган голын Байгалийн нөөц газрын нутаг дэвсгэрт ногоон бах идээшин амьдрах бөгөөд нийт тархац нутгийн нэгээс бага хувь нь улсын

тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ [13,14,15,16].

**Хамгаалах арга хэмжээ:** Зүүнгарын говийн гадаргын уст цэгүүдийн судалгаа хийж, тархалтын төлөв байдлыг шинэчлэн тогтоох. Удаан хугацааны мониторингийн судалгаа хийж, популяцийн динамикийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, тусгаарлагдсан популяцийн генетикийн төлөв байдлын харьцуулсан судалгаа хийх, удмын санг хадгалах [16].

**Эх зохиол, мэдээ:** 1. Боркин, Воробьева нар, 1988, 2. Боркин, Розанов нар, 1986, 3. Боркин, Тэрбиш нар, 1986, 4. Мөнхбаяр, 1976, 5. Мөнхбаяр, 1981, 6. Мөнхбаяр нар, 2009, 7. Мөнхбаяр, Тэрбиш, 1997, 8. Орлова, Тэрбиш, 1986, 9. Тэрбиш, 1985, 10. Тэрбиш, Кузьмин, 1988, 11. Тэрбиш, Мөнхбаяр, 1982, 12. Peters, 1971, 13. Terbish et al., 2013, 14. Terbish et al., 2007, 15. Terbish et al., 2006a, 16. Terbish et al., 2006b.

### 3. МОДНЫ МЭЛХИЙ



*Hyla japonica* Gunther, 1859

**Баг.** Сүүлгүй хоёр нутагтан - Anura

**Овог.** Модны мэлхийтнийхэн - Hylidae

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлжээ.

**Таних шинж:** Бие 42.3 мм урт. Хөлийн хурууны үзүүрт хөхлөгтэй. Их бие ногоон, шар ногоон, хэвэл цайвар зүстэй.

**Тархац, байршил нутаг:** Сэлэнгэ, Шаамар, Их, Бага бүүрэг толгой, Ерөө, Хараа гол, Булган аймгийн Тулгатын даваа, Халх голын савд байршина [1,2,4,6,7]. Нуга, намгархаг газарт амьдардаг. Бургас, жимс жимсгэний таримлууд, бутлаг ургамлын навч, мөчир дээр хааяа

тохиолдоно [4]. Борооны дараа хад асган дээр авирна [1]. Авгалдай гүехэн, тогтмол усны өнгөн хэсэгт зөвхөн өдрийн цагт хооллодог [5].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Шаамар, Их бүүргийн орчимд 3000:3 метр талбайд 23-30 бодгаль байв [2,7]. Бие гүйцсэн бодгалиуд VII-VIII сард усны эргийн намагжсан газарт их элбэг тохиолдоно. Зарим газарт 100-500 бодгаль тааралдана [2]. Намар VIII сараас эхлэн усны захаар зулзаган мэлхийнүүд зонхилох бөгөөд 1,5 хавтгай дөрвөлжин метр талбайд 34 хүртэл бодгаль үзэгдэв. Усны цох, сонын авгалдай зэрэг махчин шавжууд авгалдайг хөнөөдөг. Шаамар орчимд авгалдайн 17 хувь шархтай байсны зэрэгцээ үүнээс шалтгаалан зарим нь гаж буруу хөгжсөн байна [2]. Шаамар орчимд модны мэлхийн ходоодноос *Oswaldocruzia bialata* зүйлийн дугариг хорхой гарсан бөгөөд нийт бодгалийн 3 хувь халдварлажээ [3]. Элдэв шавжаар идэшлэнэ. Шанаганцар нь замаг, усны жижиг шавжаар хооллоно. Бусад хоёр нутагтнаас харьцангуй хожуу төрцөө шахдаг. Их бүүргийн орчмоос барьсан 2 эмэгчингийн өндөгний хоолойгоос тус бүр 2 мм голчтой, шаравтар өнгийн 700-7600 өндөг гарчээ [7]. Шаамар орчимд VI сарын 25-наас VII сарын 26-ны хооронд хөөцөлдөх бөгөөд вааглах дуу ихсэнэ [2]. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын улаан ном/1987,1997/-онд оруулсан [8].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, хамгаалах арга боловсруулах. Удман санг хамгаалах. Сэлэнгэ аймгийн нутаг, Орхон голын сав дахь Шаамарын бүүрэг толгойн хэмээх газрыг тусгай хамгаалалтад авч, хоёрнутагтан, мөлхөгчдийн нөөц газар байгуулах. Уг арга хэмжээг хэрэгжүүлснээр энд идээшин амьдарч буй хоёрнутагтан, мөлхөгчдийн 8 зүйлийг цогцоор хамгаалах боломж бүрдэх болно.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников, 1958, 2. Боркин нар, 1988, 3. Данзан, Мөнхбаяр, 1970, 4. Кузьмин, 1986, 5. Кузьмин, 1987, 6. Мөнхбаатар нар, 2008, 7. Мөнхбаяр, 1976, 8. Мөнхбаяр, Тэрбиш, 1997. 9. Terbish et al., 2006a, 10. Terbish et al., 2006b.

#### 4. ДОРНОДЫН МЭЛХИЙ



*Rana chensinensis* David, 1875

**Баг.** Сүүлгүй хоёр нутагтан - Anura

**Овог.** Мэлхийнхэн - Ranidae

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлжээ.

**Таних шинж:** Бие 64 мм урт. Нуруугаараа хулсан шаргал, боровтор зүстэй. Нуруу, хажуугийн хуниасны хоорондох арьс тууш гүвдрүүтэй, түүнийг тойрсон хар толботой. Хэвэл, хоолой цайвар юмуу ягаавтар.

**Тархац, байршил нутаг:** Дорнодын тал, Хянганы уулсаар тохиолдоно. Сүхбаатарын Ганга нуур, Дагшийн гол, Дуут нуур, Молцог элс, Хонгорын гол, Ар нөмрөг Хусын гол, Ханын гол, Харгилдайн булаг, Бичигт, Азарга, Дэгээ, Халх гол түүний цутгал, Хөх нуур орчимд тэмдэглэжээ [2,4,5,6,7,8,9]. Тал хээрийн гол нуур, цөөрмийн эргийн зэгс шагшуурга, дов сондуултай газар, үетэн, уулын алаг өвст нуга, намагт амьдарна.

**Амьдралын онцлог:** Элдэв шавж, хавч хэлбэртнээр хооллоно. IV-V сард түрсээ шахна. Эм мэлхий 1200-3500 түрс гаргана [1,4,5]. Нэг цөөрөмд хөгжлийн өөр өөр шатанд байгаа шанаганцарууд тохиолдоно.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Дагшийн голын дагуух цөөрмийн эргээр 1 км явахад 60 гаруй, Ханын голд 500 м замналд 35 орчим бодгаль тохиолдоно. Амьдрах орчинг бусниулах, өвчин эмгэг нэрвэх, усыг бохирдуулснаас хорогдоно. Дагшийн гол орчимд хийсэн судалгаагаар, нарийн гэдэснээс *Dolichosaccus rostellus* хэмээх трематод, уушигнаас *Rhabdias* төрлийн нематодыг илрүүлжээ [3,4]. Энэхүү хорхойгоор 84% уушгиндаа халдвартай, тэн хагас нь арьсандаа хануур хорхой, шимэгч агуулдаг байна. Устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны жагсаалтад бүртгэж, Монгол улсын улаан ном/1987, 1997/-онд оруулсан [10]. Тархац нутгийн 15 орчим хувь улсын тусгай хамгаалалтай газар нутагт хамрагдсан [12,13]. Дорнод Монгол, Нөмрөгийн Дархан цаазат газар, Дарьгангын байгалийн цогцолборт газруудын нутаг дэвсгэрт амьдарна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судалж, хамгаалах арга боловсруулах, хомсдлын шалтгааныг тогтоож, хэвийн өсч үржих нөхцлийг хангах арга хэмжээ авах. Усны нөөцийн зохисгүй хэрэглээ, бохирдлыг бууруулах талаар нутгийн иргэд, аж ахуй эрхлэгчдэд зориулсан сургалт, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Банников нар, 1977, 2. Боркин нар, 1988, 3. Данзан, 1970, 4. Мөнхбаатар, 2003, 5. Мөнхбаяр, 2003, 6. Мөнхбаяр, 1973, 7. Мөнхбаяр, 1976, 8. Мөнхбаяр, 1987, 9. Мөнхбаяр, Эрэгдэндагва, 1970, 10. Мөнхбаяр, Тэрбиш, 1997, 11. Terbish et al., 2007, 12. Terbish et al., 2006a, 13. Terbish et al., 2006b.

## АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. Ананьева Н.Б., Мунхбаяр Х., Орлов Н.Л., Орлова В.Ф., Семенов Д.В., Тэрбиш Х. Земноводные и пресмыкающиеся монголии. Пресмыкающиеся. КМК лтд. Москва, 1997. 416с.
2. Банников А.Г. Материалы по фауне и биологии амфибий и рептилий Монголии. Бюлл. МОИП. отд. биологии. Т.63, вып. 2. 1958.
3. Банников А.Г., Даревский И.С., Ищенко В.Г., Рустамов А.К., Щербак Н.Н. Определитель земноводных и пресмыкающихся фауны СССР. М., 1977.
4. Богданов О.П. Земноводные и пресмыкающиеся. Ташкент. Фауна Узбекской ССР. 1960. Т.1.
5. Боркин Л.Я., Воробьева Э.И., Даревский И.С., Кузьмин С.Л., Мунхбаяр Х., Семенов Д.В. Земноводные и пресмыкающиеся МНР. Общие вопросы. Земноводные. М., Наука. 1988.
6. Боркин Л.Я., Мунхбаяр Х., Орлов Н.Л., Семенов Д.В., Тэрбиш Х. Распространение рептилий в Монголии. Рептилии горных и аридных территорий: систематика и распространение. Тр. Зоол. Ин-та АН СССР. 1990. Т. 207.
7. Боркин Л.Я., Мунхбаяр Х., Семенов Д.В. Амфибии и рептилии Заалтайской Гоби. Природа. 1983. <sup>1</sup> 10.
8. Боркин Л.Я., Розанов Ю.М., Тэрбиш Х., Цауне И.А. Распространение, кариология, таксономическое положение и изменчивость жаб группы *Bufo viridis* в Монголии. Герпетологическое исследования в МНР. М., ИЭМЭЖ АН СССР. 1986.
9. Боркин Л.Я., Тэрбиш Х., Цауне И.А. Кариологическое исследование популяции жаб группы *Bufo viridis* из Монголии. Докл. АН СССР. 1986. Т. 287. <sup>1</sup> 3.
10. Данзан Г. Монгол орны Дорнод хэсгийн Номхон далайн ай савын амьтны аймгийн гельминтийн бүрэлдэхүүнийг судлах асуудалд. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг.

1970. <sup>1</sup> 27.

11. Данзан Г., Мөнхбаяр Х. *Oswaldokruzia bialata* [Molin, 1860] Travassos, 1917 Монголд анх удаа шинэ эзэнд тэмдэглэгдэв. УБДС-ийн эрдэм шинжилгээ, заах аргын бичиг. 1970. <sup>1</sup> 1/8/.
12. Кузьмин С.Л. Материалы по экологии амфибий и рептилий Северной Монголии. Природные условия и биологические ресурсы МНР. Тез. докл. междунар. конф. М. Наука. 1986.
13. Кузьмин С.Л. Сравнительная экология питания земноводных Монголии. Экология. 1987. <sup>1</sup> 2.
14. Кузьмин С.Л., Мунхбаяр Х., Оюунчимэг Ж. Об экологии и распространении сибирского углозуба [*Hynobius keyserlingii* Dyb.] в Монголии. Герпетологические исследования в МНР. М., ИЭМЭЖ АН СССР. 1986.
15. Литвинов Н.И. Сибирский углозуб в Прихубсугулье. Природные условия биологические ресурсы некоторых районов МНР. Иркутск. 1981.
16. Литвинов Н.И., Скуратов Н.В. К экологии сибирского углозуба в горах Прихубсугулья. Природные условия и ресурсы Прихубсугулья. Иркутск. 1986.
17. Мөнхбаатар М. Дорнод Монголын хоёрнутагтан, мөлхөгчид. Улаанбаатар. 2003. 76 хууд.
18. Мөнхбаатар М., Ариунболд Ж.. Шивэр гүлмэр [*Salamandrella keyserlingii* Dyb.] Онон голын саваас олдов. *Centrel Asian Ecosystem*. 2001. P. 197.
19. Мөнхбаатар М., Боркин Л.Я., Литвинчук С.Н., Мөнхбаяр Х., Золжаргал П. Дорнод Монголд 2008 онд явуулсан герпетологийн судалгаа. МУБИС, БУС-ийн э.ш. бичиг <sup>1</sup>1, 27-28
20. Мөнхбаяр Х. Монгол орны хүйтэн цустан амьтны тухай тэмдэглэл. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 1962. <sup>1</sup> 1.
21. Мөнхбаяр Х. Сибирийн гүлмэр. БНМАУ-ын ШУА-ийн мэдээ. 1967. <sup>1</sup> 2.
22. Мөнхбаяр Х. Земноводные и пресмыкающиеся МНР. Автореф. дис. канд. биол. наук. Ташкент. 1973.
23. Мөнхбаяр Х. Монгол орны хоёр нутагтан, хэвлээр явагчид. АБЯ-ны хэвлэл. Улаанбаатар. 1976.
24. Мунхбаяр Х. Гобийский голопалый геккон *Gymnodactylus elongatus* Blanford - новый для Монголии вид ящериц. Тр. ЗИН АН СССР. 1977. Т. 74.
25. Мөнхбаяр Х. Хоёрнутагтан, мөлхөгчид. БНМАУ-ын улаан ном. Улаанбаатар. 1987. III хэсэг. 63-69.
26. Мунхбаяр Х. Новые данные о распространении некоторых амфибий и рептилий МНР. Тр. ЗИН АН СССР. 1981. Т.101.
27. Мөнхбаяр Х., Даваа Н., Лхамсүрэн Н. Шивэр гүлмэрийн шинэ нутаг. Шинжлэх ухаан амьдрал. 1991. <sup>1</sup> 4.
28. Мөнхбаяр Х., Мөнхбаатар М., Ариунболд Ж. Герпетологийн судалгаа - 2009 онд. МУБИС-ийн БУС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 2009. <sup>1</sup>2. 57-72
29. Мөнхбаяр Х., Тэрбиш Х. Говийн нүцгэн хуруут геккон гүрвэл [*Cyrtopodion elongatus* Blanford 1875]-ийн судалгааны материалууд. Ховдын УБДС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 1988. 4-р боть.
30. Мөнхбаяр Х., Тэрбиш Х. Мөлхөгчид ба хоёрнутагтан. Монгол улсын Улаан ном. Ерөнхий

редактор Ц.Шийрэвдамба. Монгол улсын Байгаль орчны яам. Улаанбаатар. 1997. Хууд. 133-150.

31. Мөнхбаяр Х., Тэрбиш Х, Мөнхбаатар М. Монгол орны хоёрнутагтан, мөлхөгчид. Улаанбаатар. 2010. 78 хууд.
32. Мөнхбаяр Х., Шагдарсүрэн О. Монгол орноос нэгэн зүйл гүрвэл [*Eremias arguta* Pall.] шинээр олдов. *Studia Museologica*. T.1 Fasc. 1-8. Улаанбаатар, 1968.
33. Мөнхбаяр Х., Эрэгдэндагва Д. Дорнод Монголын хоёр нутагтан, мөлхөгчдийн тухай. УИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 1970. 27-р боть.
34. Орлова В.Ф., Тэрбиш Х. Материалы по герпетофауне Джунгарской Гоби. Герпетологические исследования в МНР. М., 1986.
35. Семенов Д.В., Мунхбаяр Х. Классы земноводные и пресмыкающиеся. Редкие животные Монголии [Позвоночные]. Глава II. 40-71.
36. Семенов Д.В., Шенброт Г.И. Материалы по герпетофауне юго-восточной Монголии. Герпетологические исследования в МНР. М., 1986.
37. Тэрбиш Х. БНМАУ-ын нутаг дахь Зүүн гарын говийн хоёр нутагтан, хэвлээр явагч амьтдын тухай тэмдэглэл. Ховд дахь УБДС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 1985. 2-р боть.
38. Тэрбиш Х. Герпетофауна юго-западной части МНР и природно-хозяйственное значение. Автореф. канд. дис. Улан-Батор: Ховдск. гос. пед. Ин-т. 1989.
39. Тэрбиш Х., Кузьмин С.Л. Об экологии жаб Западной Монголии. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 1988, 1990. 1, 2.
40. Тэрбиш Х., Мөнхбаяр Х. Хүйтэн цустан амьтны тухай хоёр шинэ мэдээ. Шинжлэх ухаан амьдрал. 1982, <sup>1</sup> 2.
41. Тэрбиш Х., Мөнхбаяр Х. Могойн шинэ олдвор. Шинжлэх ухаан амьдрал. <sup>1</sup>3. Хууд. 41-44.
42. Тэрбиш Х., Пүрэвжав Л. Монгол орны тойрмын хонин гүрвэл [*Phrynoscephalus helioscopus*]-ийн амьдрахуйн зүйн судалгааны асуудалд. УБИС-ийн Эрдэм шинжилгээний бүтээл. <sup>1</sup> 1 [Биологи]. Улаанбаатар. 2000. Хууд. 100-106.
43. Улыкпан К., Мөнхбаяр Х. Сибирийн гүлмэр Шаамараас олдов. Шинжлэх ухаан амьдрал. 1982, <sup>1</sup> 2.
44. Хотолхүү Н. Сибирийн гүлмэр Хэрлэн голын эхнээс олдов. ШУА-ийн мэдээ. 1969. <sup>1</sup> 2.
45. Щербак Н.Н. Ящурки Палеарктики. Киев. Наукова думка. 1974.
46. Frank Meyer, Olaf Zinke. Zur Okologie von *Phrynoscephalus helioscopus* [Pallas, 1771] in der Dschungarischen Gobi [Reptilia; Agamidae]. *Bonn. zool. Beitr.* 1992. Bd. 43. H. 1. Bonn.
47. Masato Hasumi, Tsagaan Khongorzul, and Khayanhirvaa Terbish. Burrow Use by *Salamandrella keyserlingii* [Caudata: Hynobiidae]. *American Society of Ichthyologists and Herpetologists*. Volume 2009. Issue 1 [February 2009]. 46-49.
48. Obst F. J. Eine herpetologische Sammelreise nach der Mongolei. *Aquarian-Terrarien*. 1962. Bd. 9. H. 11.
49. Peters G. Materialien zur Okologie und Verbreitung der Amphibien in der Mongolei. *Mitt. Zool. Mus. Berlin*. 1971. Bd. 47. H.2.
50. Terbish Kh., Munkhbayar Kh. and Munkhbayar M. A guide to the amphibians and reptiles of Mongolia. "Admon Print" Publishers. Ulaanbaatar. 2013. 80 pp.
51. Terbish Kh., E. L. Clark, J. E. M. Baillie, and J.Munkhbat. *Proceedings of the Second*

International Mongolian Biodiversity Databank Workshop: Assessing the Conservation Status of Mongolian Reptiles and Amphibians. Mongolian Journal of Biological sciences. 2007. Vol.5 [1-2]: 19-28.

52. Terbish Kh. Ecology of *Phrynocephalus helioscopus* Pallas [Reptilia; Agamidae] in Mongolia. Erforschung biologischer Ressourcen der Mongolei. 2. Internationalis Symposium. Thesen. Haale/Saale. 1992.
53. Terbish Kh., Munkhbayar Kh. New records of amphibians and reptiles in Mongolia. Erforschung biologischer Ressourcen der Mongolei. 2. Internationalis Symposium. Thesen. Haale/Saale. 1992.
54. Terbish Kh., Munkhbayar Kh., Clark E.L., Munkhbat J. And Monks E.M. Mongolian red List of Reptiles and Amphibians. Regional red List Series Vol. 5. Zoological Society of London, London. 2006a.
55. Terbish Kh., Munkhbayar Kh., Clark E.L., Munkhbat J. And Monks E.M. Summary Conservation Action Plans for Mongolian Reptiles and Amphibians. Regional red List Series Vol. 6. Zoological Society of London, London. 2006b.




# 5. Загас



5. ЗАГАС

1. ШИВЭР

# ХИЛЭМ



*Acipenser*

*baerii* Brandt, 1869

**Баг.** Хилэмтэн - *Acipenseriformes*

**Овог.** Хилэмийнхэн -

*Acipenseridae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “устаж байгаа”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн [9,10].

**Таних шинж:** Нуруун тал бор саарал, хэвэл цайвар шаргал өнгөтэй. Хошууныхаа доод талд байрласан амтай. Хоёр хос сахалтай. Арьс, ялангуяа толгойн хэсэгтээ товхон хайрстай. Нурууны сэлүүр 38-53, хэвэл сэлүүр 22-32, төгсгөлийн сүвийн сэлүүр 20-32, цээжний сэлүүр 36-51 гуурстай. Нурууны сэрвэн 11-17, хажуугийн сэрвэн 47-53, хэвэл нь сэрвэн 10-12, залмагайн өргөс 36-45. Залмагайн эхний нумд 31-44 өргөстэй [7,8].

**Тархац, байршил нутаг:** Обь мөрнөөс Колым хүртлэх голуу, Иртыш гол, Енисей мөрөн, Байгаль нуурт тархсан [10]. Олон голын бэлчир, Сэлэнгэ мөрөн түүний цутгалан голуудаар тархана [1-3]. Тавиад оноос Сэлэнгэ, Орхон, Туул гол өгсөн ганц нэгээр нүүдэллэн ирж, нутагшиж эхэлсэн. 1988 онд Булган аймгийн Хантай багийн нутаг Эгийн голоос баригдаж байв. Жараад оноос хууль бусаар хайр гамгүй агналтаас эрс ховордлоо [7]. Өнөөгийн байдлаар, манай оронд 3 газар түрсээ шахдаг гэж үздэг [10].

**Амьдралын онцлог:** Хөдөлгөөн багатай. Голын гүн, эргүүлэгтэй усны ёроолд элс, лаг шавартай газар хошуугаа газар шүргүүлэн хэвтэж, ус сорон, ёроолын элдэв шавж, зөөлөн биетэн, ургамлаар хооллодог. Үржих үедээ Байгалнуурын савын голоос Сэлэнгэ мөрнийг өгсөн нүүдэллэн манай улсын нутагт ирж түрсээ шахдаг [5,6]. Зарим бодгаль монголын гол, мөрөнд нутагшин идээшиж байна. Биеэр нэлээд том, Байгаль нуурын хилэм 100-115 кг хүнд [1]. Судлаачдын ажиглалтаар, Дэлгэр мөрний 10 гаруй настай хилим 1,1-1,3 м урт, 5-7 кг жинтэй байв [2]. Атуу 12-14 насандаа 108-120 см урт, 5-7 кг жинтэй, атуух 10-12 настайдаа 95-108 см урт, 4-6 кг жинтэй үедээ үржих чадвартай болно. V сарын дундаас VI сарын 15 хүртэл ус, 10-15 хэм дулаан байхад, усан доорх хайрга чулуун дээр, чулууны завсар түрсээ

шахна. Нэг агуух 3,08-11,0 кг хар түрс гаргана. 138 см урт биетэй, 16 кг жинтэй загас дунджаар, 211 мянган түрстэй байдаг [4].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нөөцийг нарийвчлан тогтоогоогүй. Түрсээ жил өнжиж шахдаг, удаан үржилтэй загас. Гучаад оноос Байгал нуур, Сэлэнгийн савын гол мөрнөөс хууль бусаар агнаж, Сэлэнгэ мөрний цутгал голуудын усыг бохирдуулснаас нөөц багасч байна.


**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын улаан номонд *Acipenser baeri baikalensis* Nikolski, 1896 салбар зүйл нь орсон [5,7]. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн II хавсралт [11], Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа, усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн I хавсралтад тус тус бүртгэгдсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлах, байршил нутгийг тусгай хамгаалалтад авах, гадагш урсгалгүй голд нутагшуулах, зориудаар өсгөн үржүүлэх, замаар тоо толгойн өсөлтийг дэмжих үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн болон төрийн бус байгууллагыг бүх талаар дэмжиж, хууль бус агналтад тавих хяналтыг сайжруулах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Егоров, 1961, 2 . Дулмаа, 1970, 1985, 3. Дашдорж, 1976, 4. БНМАУ-ын загас, I-II боть, 1983, 1985, 5. БНМАУ-ын Улаан ном, 1967, 6. Красная книга Бурятской АССР, 1988, 7. Монгол улсын улаан ном, 1997, 8. Баасанжав нар, 2001, 9. The IUCN Categories and Criteria [Version 3.1] IUCN SSC, Gland and Cambridge. 2001, 10. Mongolian Red List of Fish, 2011, 11. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн лавлах, 2001, 12. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа, усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц, 1998.

## 2. ХАР

### МӨРНИЙ ХИЛЭМ



*Acipenser schrenckii* Brandt,  
1869

**Баг.** Хилэмтэн - *Acipenseriformes*

**Овог.** Хилэмийнхэн -

*Acipenseridae*

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж байгаа” зүйлд хамаарна [5].

**Таних шинж:** Шивэр хилэмтэй маш төстэй боловч, хажуугийн сэрвэнгийн тоо 32-37, өргөс 26-44 цөөн. Биеийн урт дунджаар 173 см, жин 37 кг хүрнэ. Өргөс дэвүүр бус хэлбэртэй.

**Тархац, байршил нутаг:** Орос, Хятад дахь Амар мөрний сав тархсан. Онон гол, түүний цутгал голуудад тохиолдоно [1-4].

**Амьдралын онцлог:** Судалгаа хийгээгүй. 8-14 насандаа бие гүйцэж үржих чадвартай болоод, V сарын эцсээс IX сарын эхэн хүртэл үржинэ. Нэг бодгаль 27,640-433,940 түрс гаргана.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Мэдээ баримт байхгүй. Тоо толгойн хомсдох шалтгаан тодорхойгүй, 1976 оноос хойш Монголд тэмдэглэгдээгүй [9].

**Хамгаалсан байдал:** 1995 оноос агнахыг хуулиар хориглож, Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулж хамгаалсан. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн II хавсралт, Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа, усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийн II хавсралтад тус тус бүртгэгдсэн. Онон голын адгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг тусгайлан судалж, хамгаалах арга боловсруулах, нүүдэллэн ирж, түрсээ шахдаг газрын хамгаалалтыг сайжруулах, гадагш ургсгалгүй голд нутагшуулах, зориудаар өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулах, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Никольский, 1956, 2. Дашдорж, 1976, 3. БНМАУ-ын загас, I-II боть, 1983, 1985, 4. Красная книга РСФСР, 1983, 5. The IUCN Categories and Criteria [Version 3.1] IUCN SSC, Gland and Cambridge. 2001, 6. Монгол улсын Амьтны тухай хууль 2012, 7. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн лавлах 2001, 8. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа, усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци, 1998, 9. Mongolian Red List of Fish, 2011.

3. ТУЛ



*Hucho taimen* [Pallas,  
1773]

**Баг.** Яргайтан -  
*Salmoniformes*

**Овог.** Хулдынхан -  
*Salmonidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “устаж болзошгүй” зүйлд хамаарна [6].

**Таних шинж:** Бүдүүн, уртавтар биетэй. Ам тэгш, том. Эрүү тагнай бөх шүдтэй, толгой дээрээ жижиг дугуй бараан толботой, биеийн гадаргуудаа хагас сар хэлбэрт хар толбуудтай. Нуруу боровтор бараан, хажуу тал зэсэн улаан хүрэн, өөхий мөнгөлөг цагаан өнгөтэй. Нурууны өөхөн сэлүүртэй. Үржлийн үед хэвэл, сүүлний сэлүүрүүд улаан ягаан өнгөтэй. Дээд эрүү уртавтар, нүднээс хойш давсан. Залуу бодгалийн биеийн хажуу 7-10 хар өнгийн хөндлөн судалтай [4].

**Тархац, байршил нутаг:** Обь, Лена, Кама мөрөн, Агнуурын тэнгисээс Амар мөрний сав хүртэл тархсан [7]. Сэлэнгэ мөрний томхон цутгал голууд, Дархадын хотгорын зарим нуур, Шишгэд, Хөг, Дэлгэрмөрөн, Эг, Онон, Хэрлэн, Халх гол, Буйр нуур тархжээ [1-4].

**Амьдралын онцлог:** Өндөр газрын хүйтэн устай нуур, ширүүн урсгалтай голын усанд амьдрах зохилдолгоотой. Голын гүнзгий булан тохойн усанд өвөлжиж, хаваржина. Залуу тул бага усны элдэв сээр нуруугүй амьтнаар хооллож байгаад, 4 наснаас махан идшинд шилжин жижиг загас, хөхтөн амьтад, шувууны ангаахай, дэгдээхий барьж иднэ. Дархадын хотгор, Олон голын бэлчирээс 22-34 настай, 1,2-1,5 м урт, 22-45 кг жинтэй тул байснаа, 1979-1991 онд, 3,36-79,2 см урт, 430-4200 грамм жинтэй болжээ [4]. Урт настай, дунджаар 40 гаруй жил насалдаг. 7 наснаас бэлэг боловсорч, үржилд орно. Хавар 5-р сарын эхээр голын цөн түрэх үед үржих газраа хуран цугларч, түрсээ шахна. Голын эхний хайрган ёроолтой, түргэн урсгалтай хэсэгт үржинэ. Нэг атуу 8375-25380 түрс гаргана [8].


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Өвөлжих, хаваржих цүнхээл гүн газрыг хөндөн сүйтгэх, алт олбдворлолт болон бусад тохиолдлоор ус бохирдох, хууль бусаар агнаснаас тархац нутагтаа хааяагүй эрс ховордож байна.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэсэн [5], Монгол улсын улаан номонд [4] орсон. Онон, Хэрлэн голын хэсэгчилсэн нутгийг улсын тусгай хамгаалалтад авсан. Уг загасыг зориудаар өсгөн үржүүлэх туршилт судалгааны ажлыг гүйцэтгэж, түүнийг хамгаалах чиглэлээр холбогдох олон улсын байгууллагатай хамтран “Тул төсөл”-ийг хэрэгжүүлсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, үржлийн нутгуудыг тодорхой хугацаатайгаар тусгайлан хамгаалах, гадагш ургсгалгүй гол, нуурт нутагшуулах, тул үржүүлгийн газрыг байгуулах, тархац нутгийг мэргэжлийн болон төрийн бус байгууллага, нутгийн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулж, хууль бус агнуурыг хууль тогтоомжийн дагуу таслан зогсоож, сурталчилгааг тогтмолжуулж, хяналтыг чангатгах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дулмаа, 1977, 2. БНМАУ-ын загас I-II боть, 1983, 1985, 3. Красная книга Бурятской АССР, 1986, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 6. The IUCN Categories and Criteria [Version 3.1] IUCN SSC, Gland and Cambridge. 2001, 7. Mongolian Red List of Fish, 2011, 8. Баасанжав нар, 2001.

#### 4. МОНГОЛ ОМУЛЬ



*Coregonus*

*migratorius* [Georgi, 1775]

**Баг.** Яргайтан - *Salmoniformes*

**Овог.** Хулдынхан - *Salmonidae*

**Статус:** Ховор зүйл. Монголын загасны улаан дансанд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Бие урт гоолиг, толгойн хойт хэсэгт овгор байхгүй. Мөнгөлөг цагаан өнгөтэй,

хар толбо үгүй. Загалмайн өргөс 35-54. Төгсгөлийн сүвийн сэлүүрийн салаалсан гуурсны тоо 10-12. Гэдэсний дагавар салбан 128-291.

**Тархац, байршил нутаг:** Байгаль нуурын савд тархсан. Монголд Хөвсгөл, Дархадын хотгорын Шарга, Хөгийн гол, Доод цагаан, Хармай нуур, Говийн Улаагчны Хар, Бага нууруудад нутагшин үржиж байна. Тавиад оны дундаас Хөвсгөл нуурт, наяд оны эхээр говийн Улаагчны Хар, Бага нуурт, наяд оны дундаас Дархадын хотгорын Доод цагаан, Хармай нуур, Шаргын гол, Хөгийн голд нутагшин идээшиж, 5-10 дахь үеийн 7-10 гаруй насны оморь тархан үржиж байна. Одоогоор агнуурын нөөцгүй [1,2, 4]. Монголд шинээр нутагшин үржиж байгаа

**Амьдралын онцлог:** Монголд нутагшиж байгаа оморь зуны улиралд нуурын гүн хэсэг, булан тохойгоор тархан амьдарна. Намар орой бие гүйцсэн бодгалиуд үржлийнгүйдэлд орж, нуурын цутгал голуудад цугларна. Үржлийн бус цагаар Хөвсгөл, Улаагчны Хар, Бага, Хармай, Доод Цагаан нуурын гүнд амьдарна. Хамгийн томын жин 4200 г, урт 60 гаруй см хүрнэ. Ихэнх бодгаль 30-40 г жинтэй [3,4]. 5-7 насандаа бие гүйцэж, үржилд ордог. Үржлийн хугацаа газар бүр харилцан адилгүй. Хөвсгөл нуурт IX сарын эхээс X сарыг дуустал цутгал голуудыг сүрэг сүргээрээ өгсөж, усны дулаан 2,0-1,4 хэм хүртэл буурахад, түрсээ шахдаг. Наснаас хамаарч гаргах түрс 15-120 мянган ширхэг буюу дунджаар 49,8 мянга хүрнэ. Үр тогтсон түрснээс 6-7 сарын дараа авгалдай төрнө. Залуу бодгаль ихэвчлэн хөвөгч амьтнаар, 5-аас дээш насных хөвөгч, ёроолын элдэв зүйлээр хооллоно.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Хөвсгөл, Хангайн өндөрлөг газрын нуур, голын эрс тэрс шинэ нөхцөлд дасан нутагшиж байгаа загасыг хууль бусаар агнаснаас нөөц хомсдож байна. Хөвсгөл нуурт нутагшуулсан бодгалийн үржих тааламжтай орчин хязгаарлагдмал учир ихээр хорогддог [2,4].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Монгол омуль – *Coregonus autumnalis migratorius* нэртэй 1997 оны Монгол улсын улаан номонд орсон [4], байршил нутаг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, хамгаалалтыг сайжруулах, зориудаар өсгөн үржүүлэх, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Тугарина, Дашдорж, 1972, 2. Дулмаа, 1991, 1992, 1995, 3. БНМАУ-ын Улаан ном, 1987, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Mongolian Red List of Fish, 2011.

## 5. ҮХЭРДЭЙ



***Tinca tinca*** [Linnaeus, 1758]

**Баг.** Мөрөгтөн - Cypriniformes

**Овог.** Мөрөгийнхөн - Cyprinidae

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар бүс нутгийн хэмжээнд “үнэлэх боломжгүй” хэмээн үнэлэгдсэн [6].

**Таних шинж:** Бүдүүн, бахим биетэй. Өлтсөн жижиг амтай. Хоёр завжиндаа хос богино сахалтай. Нуруу хар ногоон, хажуу шар туяа бүхий бараавгар ногоон зүстэй. Сэлүүрүүдийн үзүүр дугуй мохоо. Сүүлний сэлүүр богинохон бөгөөд өндөр, өргөн. Эр хажуугийн шугамандаа 90-110, эм 87-115 жижиг хайрстай, нүд улаавгар өнгөтэй [7].

**Тархац, байршил нутаг:** Английн вант улс, Франц, Орос, Хятадад тархсан. Хойд Америк, Чили, Энэтхэг, Индонез, Япон, Австрали, Шинэ Зеланд, Зимбабед нутагшуулсан. Монголын Булган голд ховор тохиолдоно.

**Амьдралын онцлог:** Жижиг цөөрөм, нуурт, эх голтойгоо холбоо бүхий ургамлаар баялаг гол, горхины булан тохойд идэшлэнэ. Сүрэглэдэггүй, ганц нэгээрээ амьдарна. Голын гүнзгий хэсгийн ёроолын шаварлаг хурдсанд шигдэн өвөлждөг. 3-4 насандаа бэлэг боловсорч, үржих чадвартай болно. V-VI сард усны температур 19-24 хэм дулаан болоход үрждэг, дулаан усны загас. Түрсээ ургамал дээр хэсэг хэсгээр гаргана. Үржлийн хугацаа 45-60 хоног үргэлжилнэ. Биеийн урт 30 см, жин 900 г хүрнэ.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Далаад онд Булган голын савын цөөрмөөс цөөн тоогоор баригдаж байснаа, одоо нэн ховор тохиолдох болов. Амьдрах орчныг доройтуулах, нуурын ус багассанаас цөөрнө.

**Хамгаалсан байдал:** Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар бүртгэж [5]. Монгол улсын улаан номонд оруулсан [7]. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.


**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, дулаан устай гол, нуурт нутагшуулах,



зориудаар өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулах, тархац нутгийг орон нутгийн хамгаалалтад авч, хамгаалалтыг сайжруулан, хууль бус агналтыг зогсоох, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дашдорж, 1976, 2. БНМАУ-ын загас, I-II боть, 1983, 1985, 3. Монгол улсын дархан цаазтай газар, 1994, 4. Красная книга Бурятской АССР, 1988, 5. Амьтны тухай хууль, 2012, 6. Mongolian Red List of Fish, 2011, 7. Монгол улсын улаан ном, 1997.

## 6. ЗАНТАХАЙ ЗАГАС



*Mesocottus*

*haitej* [Dybowski,  
1869]

**Баг.**

*Живертэн - Scorpaeniformes*

**Овог.** *Живэртийнхэн - Cottidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар “мэдээлэл дутмаг” зүйлд хамаарна [6].

**Таних шинж:** Биеийн 40-өөд хувийг эзэлсэн том, зантгар толгойтой. Нуруу, хажуу жижиг өргөслөг товгоруудтай, бараан саарал, хүрэгтэр өнгөтэй, хэвэл цайвар. Нурууны нэгдүгээр сэлүүрээс хойш сүүлний уг хүртэл бараан өнгийн гурван судалтай. Сэлүүрүүд жижиг хар толботой. Нурууны сэлүүрийн шулуун гуурсны тоо 10, салаалсан гуурс 12, Сүүлний өмнөх сэлүүрийн гуурс 10-12, цээжний сэлүүрийн гуурс 16, Хэвлийн сэлүүрийн шулуун гуурс 1, салаалсан 3 байна. Биеийн урт дунджаар 17 см, 18-50 гр жинтэй.

**Тархац, байршил нутаг:** Амар мөрний сав, Сахалинд тархсан. Онон голд байдаг [1-3]. Гучаад онд Хэнтий аймгийн Биндэр сум орчим Онон голоос ганц бодгаль баригдсан [1-2].

**Амьдралын онцлог:** Хөдөлгөөн багатай, ёроолын амьдралтай. Хүчилтөрөгчөөр баялаг, цэвэр тунгалаг урсгал усанд амьдардаг. Голын хайргатай хэсэгт чулуун доогуур шургаж хоргодно. Ёроолын жижиг амьтнаар хооллоно.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нөхөн төлжих нөөцгүй болсон [4]. Зүйлийн тархалт, популяцийн хэмжээ, хорогдлын шалтгааны холбогдолт мэдээлэл хомс [6].

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номонд бүртгэсэн [4].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судлан тогтоох, ховор амьтнаар оруулж хамгаалах, зориудаар өсгөн үржүүлэх, байгальд нь сэргээн нутагшулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дулмаа, 1969, 2. Дашдорж, 1976, 3. БНМАУ-ын загас, I - II боть, 1983, 1985, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. The IUCN Categories and Criteria [Version 3.1] IUCN SSC, Gland and Cambridge. 2001, 6. Mongolian Red List of Fish, 2011.

# ДУГУЙ АМТАН

## 1. НОМХОН ДАЛАЙН МОГОР



*Lampetra japonica* Martens, 1868

**Баг.** *Дугариг амтан - Petromyzoniformes*

**Овог.** *Хорхой загасныхан - Petromyzonidae*

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны улаан дансны ангилалын шалгуураар “Хязгаарлагдмал тархацтай” зүйлд хамаана.

**Таних шинж:** Эрүүгүй. Могой шиг урт нарийхан биетэй. Толгой, их бие, сүүлээс бүрдэнэ. Нимгэн зөөлөн салслаг арьстай. Толгойн өмнөд хэсгийн доод талд уруугаа чиглэсэн дугуй соруул хэлбэртэй жижиг ам байрлана. Аман дахь эвэрлэг, өргөст болцуу шүдийг орлоно. Толгойн хоёр хажуугаар залмагай долоон хос ил сүвтэй. Хөдлөх эрхтний үүргийг нуруу болон сүүлний сэлүүрүүд гүйцэтгэнэ [3].

**Тархац, байршил нутаг:** Сибирийн зүүн захын тэнгистэй хил залгаа нутгийн гол, Агнуурын тэнгис, Амар мөрний сав, Солонгос, Японы голуудад тархсан [5]. Зөвхөн Хэрлэн, Онон, түүний цутгал Хурх голд байдаг. Хязгаарламал тархацтай.

**Амьдралын онцлог:** Авгалдай голын наанги шавартай, зөөлөн урсгалтай хэсэгт, бие гүйцсэн бодгаль хайрга чулуу, том ширхэгт элс, ургамалтай урсгал хэсэгт амьдарна. Хөдөлгөөн багатай, өдөр усны ямар нэг зүйлийг амаараа хөхөж тогтсон байдаг. Авгалдай 4-5 жилд бие гүйцнэ. Амьдралынхаа эхний хэдэн жилд хурдан 6,6 см хүртэл өснө. Урт 14,7-20 см хүрнэ. Түргэн урсгалтай, хайрга элсэнцэр хурдастай хэсэгт түрсээ шахаж 5-6 сард үржинэ. Үржлийн үедээ 10-40 бодгаль нийлж сүрэглэнэ. Түрсээ 6-9 см гүн, 20-30 см урт нүхэнд байлгана. Нэг бодгаль дунджаар 9 мянган түрс гаргадаг. Хурдасны үйрмэг шим бодис, замгаар голлон хооллоно [1-2].

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тархац нөөцийг судлаагүй. Тархац нутагтаа хааяагүй ховор, цөөн тохиолддог [1-2]. Хурх зэрэг жижиг голын усны түвшин багасах нь хэвийн өсөлт,

амьдралд орчинд муугаар нөлөөлнө.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтанд ховор амьтнаар бүртгэсэн [5]. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг нарийвчлан судалж, хамгаалах аргыг боловсруулж, хэрэгжүүлэх, зориудаар өсгөн үржүүлэх, сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дулмаа, 19696, 2. БНМАУ-ын Загас, I-II боть, 1983, 1985, 3. Монгол улсын Улаан ном 1997, 4. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 2012, 5. Mongolian Red List of Fish, 2011.

## АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. БНМАУ-ын загас. I-II боть. 1983, 1985. /орос хэл дээр/
2. БНМАУ-ын Улаан ном. 1987.
3. Баасанжав Г., Цэнд-Аюуш Я. Монгол орны загас. 2001.
4. Берг Л.С. Рыбы пресных вод СССР и сопредельных стран. М. Л. Изд-во АН СССР 1948, 1949.
5. Дашдорж А. Таунистические комплексы рыб Монголии. В сб.: “Природные условия и ресурсы Прихубсугуля”. Иркутск-Улаанбаатар, 1976. вып. 3.
6. Дулмаа А. Шинээр олдсон загас. Шинжлэх ухаан амьдрал. 1969. №3.
7. Дулмаа А. Монгол орны томхон нуурын биологийн зарим асуудал. Улаанбаатар, 1977.
8. Дулмаа А. Монгол оронд цэнгэг усны загас нутагшуулах онолын зарим асуудал. ШУА-ийн мэдээ. 1991. №2.
9. Дулмаа А. Интродукция байкальского омуля в водоемы Западной Монголии. В сб.: “Природные условия и ресурсы некоторых районов Центральной Азии”. Иркутск. 1992.
10. Дулмаа А. Acclimatization of Whitefishes in reservoirs of the Mongolia. Proceedings of the Mongolian Academy of Sciences. 1995. №1
11. Егоров А.Г. Байкальский осетр. Улан-Үдэ. 1961.
12. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн лавлах. 2001.
13. Красная книга РСФСР. М. Россельхозиздат. 1983.
14. Красная книга Бурятской АССР. Улан-үдэ. Бурят.книж.изд-во.1988.
15. Никольский Г.В. Рыбы бассейна Амура. М. Изд-во АН СССР. 1956.
16. Монгол улсын Дархан цаазтай газар. 1994.
17. Монгол улсын Тусгай хамгаалалттай Газар нутаг. 1994.
18. Монгол улсын улаан ном. 1997.
19. Монгол улсын Амьтны тухай хуулийн 7-р зүйлийн нэн ховор амьтны жагсаалт. 2012.
20. Никольский Г.В. Рыбы бассейна Амура.1956.
21. Тугарина П.Я., Дашдорж А. Об инструкции байкальского омуля в оз. Хубсугул. В сб.:

“Природные условия и ресурсы Прихубсугулья”. 1972. вып. I. Иркутск-Уланбатор,


22. Mongolian Red List of Fish, 2011.

23. The IUCN Categories and Criteria [Version 3.1] IUCN SSC, Gland and Cambridge. 2001.

24. Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа, усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц, 1998.

# ХАВЧ ХЭЛБЭРТЭН

## 1. ХАР МӨРНИЙ ХАВЧ



*Leander modestus* Heller, 1778

**Баг.** Арван хөлтөн - Decapoda

**Овог.** Голын хавчийнхан - Astacidae

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Цагираглан сунасан, нарийвтар биетэй, жижиг хавч. Хитин бүрхүүлийн өмнөд хэсэг хурц үзүүртэй хошуу болж хувирна. Толгойдоо хөдөлгөөн ихтэй хос нийлмэл нүдтэй. Усны гүнд хөвөн сэлж амьдарна. Биеийн урт 2.5-4.0 см, 0.3-1.0 гр жинтэй [1,2].

**Тархац, байршил нутаг:** Буйр нуурт цөөн тохиолдоно.

**Амьдралын онцлог:** Нуурын нектон, планктоны гүн хэсэгт нутагладаг боловч, ургамлан ширэнгэд байрлаж, усан хөрш, үелээ зэрэг ургамал, планктоны жижиг хавч, хүрд хорхойгоор хооллоно.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Нуур, голын усны түвшин буурах, зарим хэсгээрээ хатаж ширгэх, загас агнуурын тороор олноор шүүгдэн гарч тоо толгой хорогдож байгаа устаж байгаа зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж [3], Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцид Буйр нуур түүний орчмын газарт /2004/ [5] тус тус орсон. Монгол улсын улаан номонд оруулсан [4].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийн онцлогийг судлах, загасны торонд орсон хавчийг усанд буцааж тавих, нуур, голын усны түвшин буурах, зарим хэсгээрээ хатаж ширгэхээс сэргийлэх, байршин амьдрах ургамлан ширэнгийг хамгаалах зэрэг арга хэмжээ авах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бирштэйн, 1940, 2. Дулмаа, 1965, 3. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Рамсарын конвенцийн тайлан, 2011.

## 2. ГОЛЫН ХАВЧ



*Cambaroides dauricus* Pallas, 1778

**Баг.** Арван хөлтөн - *Decapoda*

**Овог.** Голын хавчийнхан - *Astacidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Цагираглан тогтсон. Толгой, цээжний цагирагууд хоорондоо нийлж, битүү хуяган бүрхүүл үүсгэнэ. Цээж, хэвлийн сайн хөгжилтэй мөчүүд хөдөлгөөний үүргийг гүйцэтгэнэ. Цээжний нэг хос хөл хүчирхэг хавчуур хэлбэртэй, идэш тэжээлээ барина. Хэвлийн хамгийн сүүлийн цагираг өргөн сэлүүр болж хувирсан. Бие гүйцсэн эр хавчийн урт 7.5-9.0 см, эм 5.5-6.5 см. Өсөлт удаан, нэг настай хавч 2.8-3.0 см урт, 1.5-2.5 гр жинтэй. Бие гүйцсэн хавч 12-30 гр хүрнэ.

**Тархац, байршил нутаг:** Тархацын хамгийн захын хэсэгхэн нутаг болох Онон, Балж, Эгийн голын зарим хэсгээр ховор тохиолдоно. Хязгаарлагдмал тархацтай.

**Амьдралын онцлог:** Цэвэр тунгалаг, хүчилтөрөгчөөр баялаг, уулын хүйтэн устай голд амьдарна. Элсэрхэг, чулуун хурдастай газрын хад чулуун доогуур хорогдоно. Өдөр хөдөлгөөн багатай, нуугдмал байдалтай. Бүрэнхий, харанхуйд идэш хоол тэжээлээ олно. Жижиг амьтан, том амьтны сэгээр хооллоно. Арав гаруй жил наслана. Дэлхийн олон оронд зориудаар өсгөн үржүүлж, хүнсэнд хэрэглэдэг [1-4]. Усны ёроолоор мөлхөж амьдарна.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нөөцийг нарийвчлан тогтоогоогүй. Өсөлт, хөгжилт удаан, усыг бохирдуулах, үрждэг газрыг хөндөх, хууль бусаар барих зэргээс тоо толгой цөөрч байгаа.  
**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 7 дугаар тогтоол [5], Монгол улсын улаан


номонд оруулсан [6]. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц биологийн онцлогийг судлах, байршин амьдрах усан орчны цэвэр тунгалаг, хүчилтөрөгчөөр баялаг байх нөхцлийг ханган элдэв бохирдлоос сэргийлэх, хамгаалах сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бирштэйн, 1940, 2. Труды Амурской Ихтиологической экспедиции, 1945-1949 г., 3. Дулмаа, 1965, 4. Дулмаа, 1985, 5. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 6. Монгол улсын улаан ном, 1997.



## 1. ДАМНУУРГА ЦЭНХЭР СОНО



*Aeshna juncea mongolica* Bartenef, 1911

**Баг.** *Сономон - Odonata*

**Овог.** *Дамнуурчныхан – Aeshnidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Нүд хүрэн, бор эсвэл хөх өнгөтэй, нүд дээд хэсэгтээ нилээд өргөн хэсгээр хоорондоо нийлсэн. Хөл хар, зарим тохиолдолд урд хөлний доод тал шар өнгөтэй. Цээжний өмнөд хэсгээс далавчны суурь хүртэл үргэлжлэх хоёр шар судал эрэгчинд тод ялгарах бөгөөд эмэгчинд сул илэрнэ. Далавч их биед суумал байрлалтай, гадаргуу хээгүй, тунгалаг. Далавчны дээд хүрээ хэсэгт байрлах толбо эрэгчинд хар хүрэн өнгөтэй, эмэгчинд улаавтар бор. Хэвэл суурь хэсэгтээ өргөн, цаашид нарийсч шулуун үргэлжлэх бөгөөд улаан хүрэн, элгэн хүрэн өнгөтэй байх нь түгээмэл. Хэвэл судалжилт эрэгчинд шар болон хөх өнгөтэй, эмэгчинд шар, бор өнгөөр хосолсон. Хэвэл хоёрдахь үе дээр шар гурвалжин байхгүй, хэвэл үед нуруун талдаа төвийн хэсгээрээ судалтай. Хэвэл нь ес болон арав дахь үе судалгүй, харин хоёул хойд хэсгээрээ хос бүслүүр үүсгэсэн толботой. Хэвэл 50-53 мм, хойт далавч 41-45 мм урт. Биеийн урт дунджаар 74 мм хүрнэ [1].

**Тархац, байршил нутаг:** Монголд: Хар ус, Төвийн Сөгнөгөр, Баянгол сумдын зарим нутаг [2], Үүрэг нуур, Хөвсгөлийн Ханх сум, Далбаа гол, Сэлэнгийн Зэлтэр, Улаанбаатар хотын Туул, Сэлбэ голын хөндийд [3], Хэнтийн Норовлин, Дадал сумын Онон, Балж голын хөндийд [4] тус тус тохиолдоно. Цөөрөм, тогтоол ус, булаг орчмын намгархаг газарт тохиолдоно.

**Амьдралын онцлог:** Авгалдай VI сарын дунд үеэс эхлэн улалж, зэгс зэрэг усны ургамал дамжин хуурай газарт ил гарч бие гүйцэнэ. Бие гүйцсэн соно үржилд орж VII сарын сүүлчийн арав хоногийн эхээр уснаас цухайх ургамал дээр сууж бэхлэгдэн усны ургамлын иш, навчин дээр өндөгөө шахна [2,4,5]. Авгалдай тогтмол усанд, голын хөндийн татмын усан санд тохиолдоно. Тухайн тархац нутгийн цаг агаарын байдал, идэш тэжээлийн хүрэлцээ сонын хөгжилд ихээхэн нөлөөтэй. VI-IX сард идэвхтэй ниснэ. Соно идээшиж буй экосистемдээ идэш тэжээлийн хэлхээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Сонын авгалдай голчлон усны хөвөгч амьтдаар, мөн хоёр нутагтны авгалдай, жараахайг барьж иддэг ба бие гүйцсэн үедээ ялаа, шумуул, дэлэнч, хөх түрүү, өдөрч, хаварч, хоовгон зэрэг шавжаар хооллоно. Харин тэд өөрсдөө аалз, эрлэг ялаа, сарьсан далавчтан, шувуудын идэш тэжээл болдог.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Гол, горхи ширгэх, намаг хатах зэргээс шалтгаалан тоо толгой цөөрсөн.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 07 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийн зарим хэсэг тусгай хамгаалалттай газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нутгийн доройтлыг хязгаарлан зогсоох, тоо толгойн бууралтын шалтгааныг нарийвчлан тогтоох, гол, горхи ширгэх, намаг хатахаас сэргийлэн хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бельшев, 1973, 2. Бельшев, Дашдорж, 1958, 3. Гантигмаа нар, 2012, 4. Benedek, 1968, 5. Крылова, 1974.

## 2. ШҮТЭЭН ЦОХ



*Scarabaeus typhon* Fischer-Waldheim, 1823

Баг. Хатуу далавчтан - Coleoptera

# **Овог. Илтэс сахалтныхан – Scarabaeidae**

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Бие зуувандуу, хэмжээ ойролцоогоор 16-30 мм. Өргөн, хар өнгөтэй. Биеийн хэвэл тал болон хөл хүрэн үслэгтэй. Нүүрэвч хүрз хэлбэрийн 4 шүдтэй. Духны төвгөр нам, тасалданги, бага зэрэг өнцөг үүсгэж өргөгдсөн. Эр бодгалийн хойд шилбэний дотор талын хүрээ маш өтгөн, хүрэн эсвэл хүрэн улаан үстэй [1].

**Тархац, байршил нутаг:** Сайншанд хот, Зүүнбаян, Эрдэнэ сумын хоорондох элсэрхэг хөрстэй нутаг, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрт орших Сэлэнгэ мөрний Гуртын гүүрнээс баруун тийш тархсан элсэрхэг хөрс бүхий газар, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Номгон багын орчим тохиолдоно [2].

**Амьдралын онцлог:** Шөнийн идэвхтэй [3,4,5]. V сарын дунд үеэс нилээд элбэг тохиолдож VII сарын дунд үеэс ховордож эхлэх бөгөөд IX сар дуустал цөөн тоогоор үзэгдэнэ. Малын ялгадсыг жижиг бөмбөлөг хэлбэртэй болгон өнхрүүлж хөрсөнд зассан үүрэндээ авчирч эгнүүлэн хураана. Бөмбөлөг хэлбэрт оруулсан ялгадасны оройн хэсэг бага зэрэг шовгор байх бөгөөд энэ хэсэгт өндөгөө шахдаг. Авгалдай үедээ тэд энэхүү үүрэндээ орогнож, хүүхэлдэйлнэ.


Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлах, тоо толгойн хувьд буурахад нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох замаар хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Balthasar, 1963, 2. Гантигмаа нар, 2012, 3. Пузанова-Мальшева, 1956, 4. Кабаков, 1980, 5. Николаев, Пунцагдулам, 1984.

## **3. ДОРНЫН ЗААРТ ЭВЭРТ ЦОХ**



*Aromia moschata orientalis* Plavilstshikov, 1932

**Баг.** Хамуу далавчтан - *Coleoptera*

**Овог.** Эвэрт цохтныхон – *Cerambycidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Бие том, сунасан хэлбэртэй, 23-34 мм урт. Дээд далавч болон биеийн гадаргуу бүхэлдээ гоёмсог гялгар, хөх ногоон өнгөтэй. Антенн эрэгчин бодгалийн хувьд биеийн уртаас илүү гарна. Цээж суурийн хэсгээрээ улаавар шар, оройн хэсэгтээ хар хөндлөн үрчлээтсэн эмжээртэй [1].

**Тархац, байршил нутаг:** Зүүнхараа, Халх голын хөндийн бургасан шугуй, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрт орших Сэлэнгэ мөрний Гуртын гүүр орчимд тэмдэглэгдсэн [2].

**Амьдралын онцлог:** VII сарын эхнээс VIII сарын эцэс хүртэл ниснэ. Бие гүйцсэн цох тодорхой хугацааны туршид цэцэгт ургамлын балаар хооллож байгаад нисэлтийн сүүл үедээ бугасан шугуй руу нүүдэллэж үржилд орно. Эмэгчин бодгаль өндөгөө бургасны гол ишний уг орчмын ан цав, холтосны завсарт шахна. Өндөгний хөгжил 20-26 хоног үргэлжилж, гарсан авгалдай модлог эдэд нэвтрэн орж бургасны гол ишний дагуу зам гарган мэргж хооллоно [3-6]. Авгалдай гурав дахь өвөлжилтийн дараа уг газартаа хэвтэш бэлдэж хүүхэлдэйлэх ба VII сард бие гүйцэж ниснэ.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Ойн түймэр болон модлог ургамлаар хооллох хөнөөлт шавжийн нөлөөгөөр амьдрах орчин чанарын хувьд доройтох шалтгаанаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлан тогтоож, цөм популяцийн биологи, экологийн судалгааг нарийвчлан тодорхойлох замаар хамгаалах, шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Черепанов, 1981, 2. Гантигмаа нар, 2012, 3. Черепанов, Черепанова, 1975, 4. Черепанов, 1981, 5. Плавильников, 1940, 6. Намхайдорж, 1976.

#### 4. АПОЛЛОН



*Parnassius apollo* Linnaeus, 1758

**Баг.** Эрвээхийтэн - *Lepidoptera*

**Овог.** Дэвүүрлэгтнийхэн – *Papilionidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 70-94 мм. Далавч цагаан, зарим тохиолдолд цайвар шаргал, өмнөд далавчны орой хэсэг өнгөгүй, тунгалаг. Урд далавч тус бүр таван хар толботой, хойд далавч бүр дээд талдаа хар хүрээ бүхий хоёр том улаан толботой. Антенн хар булцуутай. Бие нилээд үсэрхэг [1].

**Тархац, байршил нутаг:** Хөвсгөл нуурын урд хэсэг, Тосонцэнгэл, Туул, Баянголын хөндий, Хэнтийн Норовлин сум, Сэлэнгийн Мандал сумын нутаг Ерөө голын эх, Төвийн Мөнгөн морьт орчмын өндөр уулын намгархаг нугад тохиолдоно [2-5]. Уулархаг нутагт ойн зах, цоорхойн наранд ээвэр газар идээшилнэ.

**Амьдралын онцлог:** VI сарын сүүлчээс VIII сарын эхний арав хоног дуустал ниснэ. Цаг агаар тааламжтай үед хамгийн идэвхтэй ниснэ. Монгол орны томоохон голуудын хөндий, уулын нуга, өндөр уулын нугад *Sedum telephium* их ургасан, намгархаг газарт хамгийн их тоотой тохиолдоно [5]. Хүрэнцэр гэрэлтэй, дулаан үед могойн идээ зэрэг ургамлын навчаар

хооллож, бусад тохиромжгүй үед хагд өвс, бут, чулуу зэрэг элдэв зүйлийн дор хоргодно. Бүрхэг өдөр залуу хүрэнцэрүүд бөөгнөрнө. Хүүхэлдэйн бойжилт гол төлөв хоёр долоо хоногийн хугацаанд явагддаг. Жилд нэг удаа үржилд орно.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Байршил нутагт мал сэлгээгүйгээр бэлчих, хадлан хадах, хараа булаасан гоёмсог том эрвээхий тул олноор цуглуулах зэргээс тоо цөөрч байгаа устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Зэрлэг амьтан, ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад болон Монгол улсын улаан номонд тус тус оруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлах, популяцийн тоо толгойг үнэлэх, томоохон популяциуд нутагшиж буй орчинг илрүүлэн амьдрах орчныг хамгаалах арга боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Коршунов, 2002, 2. Forster, 1967, 1968, 1971, 3. Коршунов, Соляников, 1976, 4. Коршунов, 1977, 5. Гантигмаа нар, 2012.

## 5. ЭВЕРСМАНЫ ДЭВҮҮР



*Parnassius evermanni* Menetries, 1849

**Баг.** Эрвээхийтэн -Lepidoptera

**Овог.** Дэвүүрлэгтнийхэн – Papilionidae

**Статус.** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт ойролцоогоор 65 мм. Эмийн далавч шаргалаас цайвар, эрийнх шар өнгөтэй. Эр, эмийн урд далавч маш тод ялгарахуйц хөндлөн, саарал судалтай. Хойд далавч хар хүрээ бүхий хоёр улаан толботой. Энэ нь эрэгчинд илүү тод, түгээмэл байна. Зарим тохиолдолд хойд далавчны төгсгөл орчимд хос толбо байдаг [1].

**Тархац, байршил нутаг:** Алтай Таван Богдын Потанины мөсөн гол орчимд цөөн тоотой популяци [2], Хөвсгөл нуурын баруун эрэг дагуу байрлах өндөр уулын ойн зах, цоорхой, Ренчинлхүмбэ, Арсай голын хөндийд тус тус тэмдэглэгдсэн [3-6].

**Амьдралын онцлог:** Жилд нэг удаа үржилд орно. VI сарын сүүлчээс VII сар дуустал ниснэ. Бие гүйцсэн эрвээхий цаг агаарын тааламжтай нөхцөлд идэвхтэй нисэлт хийнэ. Авгалдай ургамлын нахиа, навч, цэцгээр хооллоно. Хүүхэлдэйлэх үедээ чулуун дор орогноно.

Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, Монгол улсын улаан номонд орсон.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нутгийг нарийвчлан тогтоох, авгалдайн идэш тэжээлийн болон бие гүйцсэн үед ашиглах балт ургамлын судалгааг хийж нөөцийг тогтоох, хомсдолын шалтгааныг тодорхойлж хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Коршунов, 2002, 2. Roman V. Yakovlev, 2012, 3. Коршунов, 1970, 1974, 4. Куренцов, 1970, 5. Коршунов, Солянжов, 1976, 6. Гантигмаа нар, 2012.

## 6. ШТУББЕНДОРФЫН ДЭВҮҮР



**Баг.** Эрвээхийтэн - *Lepidoptera*

**Овог.** Дэвүүрлэгтнийхэн – *Papilionidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 50-70 мм. Далавчны өнгө цагаан, цайвар шаргал, урд далавчны үзүүр хэсэг болон гадаад хүрээ сааралдуу, тунгалаг. Далавчны судас тод, толбожилт бараг байхгүй, зарим тохиолдолд эрэгчиний урд далавч толбо маягийн хар сүүдэртсэн хэсэгтэй. Хойд далавчны доод ирмэг хар, дотогш дугуйрсан. Бие хар үстэй [1].

**Тархац, байршил нутаг:** Хөвсгөлийн Дархадын хотгор, Хөвсгөл нуурын баруун эрэгт байрлах өндөр уулсын тагын нугад байршина [1-3].

**Амьдралын онцлог:** Жилд нэг удаа үржилд орно. VI сарын сүүлийн хагасаас VII сар дуустал ниснэ. Нарлаг, дулаан байх үед маш идэвхтэй нисч цэцгийн тоос балаар хооллоно. Хүрэнцэрийн шатандаа өвөлжинө.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тодорхойгүй. Тархац нутаг бэлчээрийн талхагдалт амьдрах орчин хомсдох шалтгааны улмаас устаж болзошгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж, тархац нутгийг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийн судалгаа явуулж, хамгаалах арга боловсруулах, тархац нутгийн бэлчээрийг сэлгээтэй ашиглах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Коршунов, 2002, 2. Коршунов, Соляников, 1976, 3. Гантигмаа нар, 2012.

## 7. ФЭБ ДЭВҮҮР





*Parnassius phoebus* Fabricius, 1793

**Баг.** Эрвээхийтэн - *Lepidoptera*

**Овог.** Дэвүүрлэгтнийхэн – *Papilionidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 50-60 мм. Аполлонтой маш төстэй, харин биеийн хэмжээний хувьд багавтар, далавчны суурь өнгө цагаан, таруу байрласан хар хайрстай. Өмнөд далавчны гадаад [эрэгчний хувьд мөн хойд далавчны] хүрээ тунгалаг. Ялгарах онцлог шинж нь хар-цагаан антеннтай. Урд далавч олон тооны хар толботойгоос гадна хар хүрээ бүхий хоёр улаан толботой. Урд далавчны төв сархиагт дугуйвтар хар, түүнээс урагш наймын тоо хэлбэрийн хоёр толботой. Хойд далавч хар эмжээр бүхий том хоёр улаан толботой. Хойд далавчны зах, урд далавчны уг хар, урт цагаан саарал үстэй, түүн дээр хар хүрээтэй хоёр том улаан толботой. Хойт, урд далавчны гадаад ирмэгт тулсан судлуудын үзүүр болон түүнээс нилээд дотогш 2 эгнээ гурвалжин, сар хэлбэрт жижиг толботой [1].

**Тархац, байршил нутаг:** Дархадын хотгор, Хангайн нурууны салбар уулсын нугад амьдарна [2,3]. Хөвсгөлийн баруун эргийн өндөр уулын нуга, Өвөрхангай аймгийн Уянга сумын Ширээт нуур орчмын өндөр уулын нугад тохиолдоно [4].

**Амьдралын онцлог:** Жилд нэг удаа үржидд орно. VI сарын дунд үеэс VIII сарын дунд арав хоног хүртэл ниснэ. Үржилд орсон эмэгчин өндөгөө хүрэнцэрийн идэш тэжээл болох ургамлын ойролцоох газрын хөвд, хагд өвс, чулуун дор шахна. Өндөг шатандаа өвөлжих боловч зарим тохиолдолд хөврөлийн үеийн гадаад мембран дотор хүрэнцэрийн эхний үедээ шилжин диафаузад орж хавар V сарын сүүлч VI сарын эхээр ил гарч хооллож эхэлдэг. Хүрэнцэр сэрдэг [Saxifraga], могойн идээ [Sedum] зэрэг ургамал дээр хооллож, өвөлжөөд хавар хүүхэлдэйлнэ [3]. Нугажуу хээрийн бүлгэмдэл зонхилох ургамалжилттай орчинд түгээмэл байх бөгөөд нарлаг, дулаан байх үед нилээд идэвхтэй ниснэ.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тодорхойгүй. Хадлан хадах, сэлгээгүйгээр мал бэлчээх зэргээс амьдрах орчин доройтох шалтгаанаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийн зарим хэсэг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийн онцлогийг судалж, ховордох шалтгааныг тогтоож, хамгаалах арга боловсруулах, хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Куренцов, 1970, 2. Коршунов, 1972, 1977, 3. Forster, 1968, 4. Гантигмаа нар, 2012.

## 8. ЗҮҮН СИБИРИЙН ДЭВҮҮР



*Parnassius tenedius* Eversmann, 1851

**Баг.** Хайрстан - *Lepidoptera*

**Овог.** Дэвүүрлэгтнийхэн – *Papilionidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 50-53 мм. Далавчны суурь өнгө цагаан, цайвар шаргал, дэвсгэр дээр бараан хээтэй. Урд далавчны хажуугийн ирмэг дагуу саарал тунгалаг хүрээтэй, хойд далавч хажуу ирмэгээрээ судал үүсгэсэн хар толбуудтайгаас гадна гурвалжин дүрс бүхий тод хар таван [зарим тохиолдолд зургаан] толботой. Хойд далавч дээрх тод хар хүрээ бүхий улаан хоёр толбоны хэлбэр тархалтын цэгээсээ хамааран зууван, дугуй эсвэл гурвалжин байх нь түгээмэл. Бие цайвар үслэгээр хучигдсан. Хойд далавчны доод ирмэгийн хар судлын төгсгөл орчимд байрлах жижиг хар толбо зарим тохиолдолд дундаа улаан

толботой байна. Харин хойд далавчны хүрээ орчмын гурвалжин тод хар толбуудаас дотогш орших жижиг хар толбууд далавчныхаа доод талд тод улаан өнгөтэй харагдана.

**Тархац, байршил нутаг:** Тархацын хамгийн өмнөд сэжүүр болох Хөвсгөлийн Баянзүрх, Сүмбэр, Сэлэнгийн хилийн дагуух нутгаар тохиолдоно. Уул тайгын гол горхины хөндий, нуга, уулсын бэл, сийрэг ойд идээшлэнэ [1-4]. Сүүлийн жилүүдийн судалгаа Хэнтийн нуруунд Тэрэлж орчмын уулын хад асга, нуранга хад бүхий энгэр газар, Өдлөг, Баянголд уулын хуурай энгэр, уулын нугад, Баруун Хэнтийд Ерөө голын эх орчмын голын хөндийн алаг өвст нугад байгааг тогтоосон [5].

**Амьдралын онцлог:** Жилд нэг удаа үржилд орно. VI сарын эхнээс VII сарын сүүлч хүртэл нисдэг. Энэ зүйлийн биологийн онцлогийг нарийвчлан судлаагүй.

Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийн зарим хэсэг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судлан, тоо толгой багасах шалтгааныг тогтоож, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Коршунов, 1970; 1972, 2. Коршунов, Соляников, 1976; 3. Куренцов, 1970; 4. Баранчиков, 1979; 5. Гантигмаа нар, 2012.

## 9. МАХАОН ДЭВҮҮР



**Баг.** Эрвээхийтэн - *Lepidoptera*

**Овог.** Дэвүүрлэгтнийхэн - *Papilionidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 64-86 мм. Урд далавчны суурь өнгө тод шар, уг хар, урд ирмэгийн дотор талд 3 бор толботой. Хойт далавчны дотоод зах хар, сар хэлбэрийн олон шар толботой, захаараа хөх толбуудтайгаас гадна хойт буландаа хөх хүрээ бүхий дугуй улаан толботой, гадаад өнцөгт урт сэртэнтэй.

**Тархац, байршил нутаг:** Ойт хээрийн бүслүүр, тал хээрийн бүсийн голын хөндий, наранд ээвэр энгэр, бэл, уулархаг газарт байдаг [1-5]. Улаанбаатар, Богд уул; Архангай аймаг, Их тамир сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Хөвсгөл аймаг, Ханх, Хатгал, Алаг-Эрдэнэ; Өмнөговь аймаг, Гурван тэс, Ханбогд, Галбын говь, Зүүнгарын говь; Хэнтий, Биндэр, Дадал сумдын нутагт ой зах, ойн цоорхой, наранд ээвэр энгэр, бэл, голын хөндий, газарт амьдарна [6].

**Амьдралын онцлог:** Тааламжтай нөхцөлд зун хоёр удаа үржилд орно. Тархац нутгийн онцлогоос хамааран өнгөний хувирал ихтэй, V сарын сүүлч, VI сарын эхэн үеэс VIII сарын эх хүртэл нисэх боловч тухайн жилийн хавар, намрын улирлын цаг уурын нөхцөл байдлаас хамааран нисэх хугацаа жил бүр харилцан адилгүй. Шүхэр цэцэгтэн, уруул цэцэгтэн, нийлмэл цэцэгтэний бал, тоосоор голлон хооллоно. Өндгөө янз бүрийн ургамал дээр шахна. Хүүхэлдэйн шатандаа өвөлжинө.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгойг судалж тогтоогоогүй. Мал бэлчээх, хадлан хадах явцад хүрэнцэр олноороо хорогддог.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийн зарим хэсэг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар, Хан Хэнтийн дархан цаазат газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархацыг тогтоох, тоо толгойг буурч байгаа шалтгааныг судлан, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Seyer, 1974, 1976, 1977, 2. Forster, 1965, 3. Alberti, 1967, 4. Намхайдорж, 1968, 5. Коршунов, Соляников 1976, 6. Гантигмаа нар, 2012.

10. БАГА ТОГОСОН ОДОТ



*Eudia pavonia* Linnaeus, 1761

Баг. Эрвээхийтэн - *Lepidoptera*

Овог. Тогос одотынхон – *Saturniidae*

Статус: Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 60-75 мм. Эрэгчингийн урд далавч бор шаргалдуу, хойт далавч тод улаавгар шаргал, эмэгчиннийх бүхэлдээ цайвар саарал, тархац нутгийнхаа хүрээнд газар зүйн онцлогоосоо хамаарч илүү тод өнгөлөг байх тохиолдол бий. Далавчин дээрээ хос хөндлөн зурвастай. Далавч бүр төвийн хэсэгтээ нүд маягийн том толботой бөгөөд гадна талаараа тод хар хүрээтэй, төвийн цагаан хар толбо шар цагирагаар хүрээлэгдсэн. Далавчны ирмэг цагаан саарал. Бие их үсэрхэг [1].

**Тархац, байршил нутаг:** Сэлэнгийн Шаамарт тохиолдоно. Холимог болон навчит ойн зах, нуга, сөөг бүхий толгодын хээр, намагжсан орчинд амьдарна. Сүүлийн үеийн судалгаагаар, Сэлэнгийн Мандалд Ерөө голын эх орчмоос [2] Сэлэнгийн Шаамар, Бугант, Булган аймгийн Хялганатад тэмдэглэгдсэн [4].

**Амьдралын онцлог:** Суурин амьдралтай. Жилд нэг удаа үржилд орно. V сарын сүүлч VI сарын эхээр нисч эхэлнэ. Бие гүйцээд нэмэлт хоолонд орохгүйгээр эвцэлдэнэ. Хүрэнцэр тавилгана, хус, үхэр нүд, далан хальс зэрэг ургамлаар хооллоно. Хүүхэлдэй шатандаа бортогонд өвөлждөг [1,3].


Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын улаан номонд оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархацыг тогтоох, ховор амьтны хамгаалалтад бүртгэх, хамгаалах аргыг боловсруулж хэрэгжүүлэх.

Эх зохиол, мэдээ: 1. Ефетов, Будашкин, 1990, 2. Гантигмаа нар, 2012, 3. Ламперт, 1913, 4. Пунцагдулам нар, 2005.

## 11. ЭГЭЛ ХОШУУЛАГ ШУМБУУР



*Macroglossum stellatarum* Linnaeus, 1758

**Баг.** Эрвээхийтэн - *Lepidoptera*

**Овог.** Шумбуурынхан - *Sphingidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 40-50 мм. Урд далавч бордуу саарал, хөндлөн бараан хээтэй. Хойт далавч тод улбар шар өнгөтэй, Далавчны уг болон гадаад хөвөө хар саарал. Бие саарал, зоондоо хар, хажуугаараа цагаан толботой. Хэвэлийн төгсгөлд сунаж тогтсон хайрстай байх бөгөөд энэ нь сүүл мэт харагдана [1].

**Тархац, байршил нутаг:** Увсын Айраг, Хяргас нуурын орчмын нутгаар байдаг.

**Амьдралын онцлог:** Тархац нутгийнхаа хүрээнд нүүдэл хийдэг. Олигофаг. Хүрэнцэр луулийн овгийн ягаандай, өрөмтүүл болон далантүрүү дээр хооллоно. Жилд хэд хэдэн удам өгдөг. Эрвээхий VII сарын эхнээс IX сар хүртэл ниснэ. Гол төлөв бие гүйцсэн, хааяа хүрэнцэрийн шатандаа өвөлжинө [2].

Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.


**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж,

Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийг хэсэгчлэн улсын хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархацыг тогтоож, хомсдох шалтгааныг судлан, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Pittaway, 1997, 2. Державец, 1977.

## 12. ИНЖИРИЙН ШУМБУУР



*Deilephila elpenor* Linnaeus, 1758

**Баг.** Эрвээхийтэн - *Lepidoptera*

**Овог.** Шумбуурынхан - *Sphingidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 60-70 мм. Урд далавч их бие, далавч бүдэг ногоон. Хойд далавчны уг хэсэг хар бараандуу. Антенн, урд далавчны урд болон гадна ирмэг цайвар ягаан. Нуруувчин дээр гурван тууш, хэвэл зоон талд хоёр хажуугаар нь цайвар ягаан зураастай [1].

**Тархац, байршил нутаг:** Улаанбаатар Туул голын шугуй, Сонгино орчимд, Дорнод аймгийн Халх гол сум, Нөмрөг голын шугуйгаар тохиолдоно.

**Амьдралын онцлог:** Элдэв идэштэй. Жилд 1-2 удаа үржилд орно. Хүрэнцэр хөвөн оройт, өрөмтүүл, хөвөнцөр зэрэг ургамлаар хооллоно. V-VI сард бүрэнхийгээр нисдэг. Хүүхэлдэйн шатандаа өвөлжинө [2]. V-VII сард тархалтын урд цэгтээ намар болтол ниснэ. Хүрэнцэр

ногоон юмуу хүрэн өнгөтэй, нарийн хар зураасуудтай. Антенн богино, хар хүрэн өнгөтэй. Хүрэнцэр элдэв идэштэй, өрөмтүүл, хөвөнцөр, ягаандай, ихэр өвс зэрэг өвслөг ургамал, түүнчлэн далан хальсны навчаар хооллоно [1].


Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийн зарим хэсэг Нөмрөгийн дархан цаазат газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой түүний хомсдох хүчин зүйлийг судлан тогтоож, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Пунцагдулам нар, 2005, 2. Державец, 1977.

### 13. БЭР ЦЭЦЭГЧ ШУМБУУР



*Hemaris tityus* Linnaeus, 1758

**Баг.** Эрвээхийтэн - *Lepidoptera*

**Овог.** Шумбуурынхан - *Sphingidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 38-42 мм. Бүдүүн, махлаг биетэй, өтгөн саарал үстэй, гадна төрхөөрөө үхэр хэдгэнэтэй төстэй. Далавч бүр тунгалаг, далавчны ирмэг болон суурийн хэсэг бор, бараан. Хэвлийн дээд хэсэг үсэрхэг. Бие шаравтар ногоон, хэвэл дунд хэсэгтээ хар судалтай. Төвийн энэ судлаас хойш хэвэл улбар шар өнгөтэй болно. Хэвлий төгсгөлдөө



богино, үс хэлбэрийн хар хайрсан цацагтай. Антенн эрүүл хэлбэртэй [1].

**Тархац, байршил нутаг:** Улаанбаатар хот орчим, Богдхан ууланд ховор тохиолдоно. Ойн зах, цоорхой, нугад амьдарна [1-2]. Түүнчлэн Хэнтийн Норовлин, Сэлэнгэ аймаг, Мандал сумын нутагт Ерөө голын эх орчимд тэмдэглэгдсэн [3].

**Амьдралын онцлог:** Хүрэнцэр бэр цэцэг [Scabiosa], өрөмтүүл [Galium], сиймхийлэг [Lychnis] зэрэг ургамлаар хооллоно. Жилд 1-2 удаа үржилд орно. Тархалт нутгийнхаа хүрээнд V-VIII сард цөөн тоогоор тохиолдоно. Хүүхэлдэйн шатандаа өвөлжинө.

Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийн зарим хэсэг Богдхан уул болон Хан Хэнтийн дархан цаазат газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой, түүний хомсдох хүчин зүйлийг судлан тогтоож, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Державец, 1977, 2. Daniel, 1969, 3. Гантигмаа нар, 2012.

## 14. ГОЛТ БОРЫН ШУМБУУР



*Sphinx ligustri* Linnaeus, 1758

**Баг.** Эрвээхийтэн - *Lepidoptera*

**Овог.** Шумбуурынхан - *Sphingidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Далавчны дэлгэмэл урт 76-86 мм. Хэвлий бор саарал, цагираг бүр дээр хар, улаан өнгийн хөндлөн судалтай, зоогоороо бордуу судалтай, голоороо хар зураастай. Урд далавч нарийн урт, үзүүр хэсэгтээ цайвар. Урд далавчны ар тал тод хүрэн өнгөтэй, өмнөх нь цайвар бор. Антенн цайвар, ээрүүл хэлбэртэй [1].

**Тархац, байршил нутаг:** Хэнтийн Жаргалантын нутгаас олдсон. Сөөг бүхий талархаг хээрт амьдарна [1-2]. Төвийн Мөнгөн морьт сум, Хэрлэн голын шугуй, Хэнтий аймаг Өндөрхаан хотын Хэрлэн голын хөвөө, Дорнод Халх гол сум, Халх гол, Нөмрөг голын шугуй, Сүхбаатар аймаг Сүхбаатар сумын Дархан Хан уул [3], Сэлэнгэ аймаг, Мандал сумын нутагт Ерөө голын эх орчимд тэмдэглэсэн [4].

**Амьдралын онцлог:** V сарын сүүлч, VI сарын эхнээс VIII сар хүртэл ниснэ. Хүрэнцэр бишгүүр өвс [Ligustrum], буриад бүрэлзгэнэ [Viburnum], тавилгана [Spiraea] зэрэг ургамал дээр X сар хүртэл хооллож бойжно. Жилд нэг удаа үржилд орно. Хүүхэлдэйн шатандаа хөрсөнд өвөлжинө.

Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийн зарим хэсэг Хан Хэнтийн болон Нөмрөгийн дархан цаазат газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой, түүний хомсдоход нөлөөлж буй хүчин зүйлийг судлан тогтоож, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Daniel, 1969, 2. Державец, 1977, 3. Пунцагдулам нар, 2005, 4. Гантигмаа нар, 2012.

## 15. ХӨВДНИЙ ҮХЭР ХЭДГЭНЭ



***Bombus muscorum* Fabricius, 1775**

**Баг. Хальстан - Hymenoptera**

**Овог. Зөгийнхөн – Apidae**

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Бие бор шаргал өнгөтэй эсвэл улаан хүрэн үсээр хучигдсан. Эмэгчин 18-22 мм, ажилчин хэдгэнэ 10-15 мм, эрэгчин 12-15 мм урттай. Эмэгчний хэвэл 6 цагирагтай, хатгууртай. Антенн 12 үетэй. Эрийн хэвлий 7 цагирагтай, хатгуургүй, бахь маягийн эвслийн эрхтэнтэй. Сахал 13 үетэй. Цээжний зоон тал, хэвлий ижил шар өнгөтэй байдгаараа бусад хэдгэнээс ялгаатай. Хөл цайвар шараас хар хүрэн, хар үстэй [1].

**Тархац, байршил нутаг:** Сэлэнгэ мөрний сав газар нутгаар цөөн тоотой тохиолдоно. Ойн зах, нуга, сөөгтэй орчинд амьдарна.

**Амьдралын онцлог:** Нэг бүл нь ажилчин, эрэгчин, эмэгчин гэсэн 3 бүлгээс бүрдэнэ. Нэг бүлд 50-100 бодгаль байдаг. Намар эвцэлд орсон эмэгчин үлдэж өвөлжин, бусад нь үхдэг. Зуны эхнээс эмэгчин үүрээ засаж, өндөглөнө. Өндөгний хөгжил 4 хоног үргэлжилж 22-23 хоногийн дараа бие гүйцнэ. Хавар, зуны улиралд зөвхөн ажилчин хэдгэнэ бий болж, үүрэнд нэг эмэгчин байдаг. Зуны сүүлчээр эмэгчин, эр бий болно. Эмэгчин болон ажилчин хэдгэнэ цэцгийн бал, тоос цуглуулдаг. Эр сайн хөгжсөн хошуутай, хооллохдоо ургамалд тоос хүртээдэг. Эвцэлд орсоны дараа эрэгчин үхнэ. Үр тогтсон эмэгчин үүрээ орхин ганц ганцаараа ичнэ. Хэвийн өсч үржих тааламжтай нөхцөл 25-26° С. Хоногийн идэвх үүр цайхаас эхэлж, өдрийн 11 цаг хүртэл үргэлжлэн 12-14 цагт үүрэндээ амраад, дахин хоол тэжээлийн эрэлд гарч, 18 цаг хүртэл идэвхтэй нисдэг. Эрэгчин үүрээ хөрсний гадарга дээр хөвд болон өвсөөр барина. Гол төлөв буурцагтан, нийлмэл цэцэгтэн, уруул цэцэгтний овгийн ургамлаар хооллоно [1-6].


Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой, түүний хомсдоход нөлөөлж буй хүчин зүйлийг судлан тогтоож, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Панфилов, 1956, 1978, 2. Гринфильд, 1954, 3. Скориков, 1922, 4. Сысолетина, 1970, 1976, 1977, 5. Малышев, 1928, 6. Панфилов, Зимица, 1962.

## 16. МОДЕСТУС ҮХЭР ХЭДГЭНЭ



***Bombus modestus** Eversmann, 1852*

***Баг. Хальстан - Hymenoptera***

***Овог. Зөгийнхөн – Apidae***

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Толгойдоо хүрэн, саарал үстэй, цээжний зоо шаргалдуу, хажуу цагаан шаргал үстэй. Хэвлийн II цагирагийн зоо бараан шаргал, III цагираг хэсэгчилсэн юмуу бүхэлдээ хар. V цагираг тод шар өнгө бүхий үсээр хучигдсан.

**Тархац, байршил нутаг:** Богдхан ууланд тэмдэглэгдсэн. Ойн зах, чөлөөнд тохиолдоно [1-2].

**Амьдралын онцлог:** Олон зүйлийн ургамалд тоос хүртээнэ. Амьдралын онцлог хөвдний үхэр хэдгэнэтэй ижил. Иршимбийн овгийн ургамал дээр суух дуртай [3].


Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийг Богдхан уулын дархан цаазат газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгой, түүний хомсдох болсон шалтгааныг судлан тогтоож, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Сысолетина, 1970, 1976, 2. Скориков, 1922, 3. Peters, 1968, 4. Panfilov, 1968.

## 17. СПОРАДИКУС ҮХЭР ХЭДГЭНЭ



*Bombus sporadicus* Nylander, 1848

**Баг.** Хальстан - *Hymenoptera*

**Овог.** Зөгийнхэн – *Apidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Ажилчин болон эмэгчин бодгалийн хэвлий тод үзэгдэхүйц 6 тергитээс тогтоно. Хатгууртай. Антенн 12 үеэс тогтоно. Эрэгчний антенн 13 үетэй, хэвэл 7 тергитээс тогтоно. Далавчны угны хоорондох зоон талдаа бараан үсэн тод бүслүүртэй. Шанааны хүрээ хар хүрэн үстэй. Хэвлийн II цагирагийн нуруун тал шар, V-VI цагираг цагаан үстэй [1-3].

**Тархац, байршил нутаг:** Архангайн Урд-Тамир, Булганы Дашинчилэн, Хэнтийн

Жавхлантаас урагш, Дорнотын Хөөвөр зэрэг газарт ганц нэгээр тохиолдоно.

Амьдралын онцлог: Тодорхойгүй.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой, түүний хомсдлыг тогтоогоогүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийг Богдхан уулын дархан цаазат газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгойн судалгааг нарийвчлан гүйцэтгэж, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Панфилов, 1984, 2. Peters, 1968, 3. Panfilov, 1968.

## 18. БАЙГАЛИЙН ҮХЭР ХЭДГЭНЭ



*Bombus subbaicalensis* Vogt, 1909

**Баг.** Хальстан - Hymenoptera

**Овог.** Зөгийнхэн – Apidae

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Цээжний урд хэсэг, бамбайнцар битүү үстэй. Далавчны угийн хооронд бараан үсэн бүслүүртэй. Цээжний хажуу, дух, антенны угаас дээш хэсэгтээ саарал юмуу шар саарал үстэй. Хэвлийн IV, V цагираг зоондоо шаргал үсгүй, II цагирагийн зоо цайвар хүрэн, харин III-V цагирагийн зоонд хар болон шаргалдуу үс холилдсон байдаг [1].

**Тархац, байршил нутаг:** Сэлэнгийн умард нутгийн ойн сөөгөнд тохиолдоно. Сүүлийн жилийн судалгаагаар, Хөвсгөлийн баруун эргийн ойн цоорхойд цөөн тоогоор тохиолдож буйг тэмдэглэсэн [2].

**Амьдралын онцлог:** Нэг бүл нь эмэгчин, эр, ажилчин гэсэн гурван янзын цөөн бодгалиас бүрдэнэ. Үүрээ хөвд, өвсөөр хөрсний гадарга дээр барина. Буурцагтан, нийлмэл цэцэгтэн, уруул цэцэгтний овгийн ургамлын бал, тоосоор хооллоно. Эвцэлдэж үр тогтсон эмэгчин өвөлжинө.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан. Тархац нутгийг Богдхан уулын дархан цаазат газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгойн үнэлгээг хийж, хамгаалах үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. *Определитель насекомых европейской части СССР, 1978,*  
2. *Гантигмаа нар, 2012.*

## 19. ИХ ЭРЛЭГ ЯЛАА



*Satanias gigas* Eversmann, 1854

**Баг. Ялаатан - Diptera**

**Овог. Эрлэгийнхтэн - Asilidae**

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Бие нарийн. Урт 28-35 мм. Саарал өнгөтэй. Далавч тунгалаг. Хөл хар өргөс болон шивээтэй. Хошуу богино, орой хэсгээрээ зууван эсвэл дугуй байна [1].

**Тархац, байршил нутаг:** Ховдын Булган голын татам, баянбүрдэд бий [2]. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Зүүн хөвийн булаг орчмын нугад тэмдэглэсэн [3].

**Амьдралын онцлог:** Төрөл бүрийн шавжаар хооллодог. Авгалдай ихэвчлэн хөрсөнд, хааяа өмхөрсөн мод сөөгт бойждог. Жилд нэг удаа үржилд орно. Биеийн хөгжил жил гаруй үргэлжилнэ [4].

Тоо толгой, хомсдох шалтгаан: Тодорхойгүй.

**Хамгаалсан байдал:** Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, тоо толгойн хэмжээг нарийвчлан тогтоож, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Определитель насекомых Дальнего Востока России, 1999, 2. Hull, 1962, 3. Гантормаа нар, 2012, 4. Лер, 1996.



# ЗӨӨЛӨН БИЕТЭН

## 1. ДАГУУРЫН СУВДАН ХЯСАА



*Dahurinaia dahurica* Middendorff, 1850

**Баг.** Сувдман - *Unioniformes*

**Овог.** Сувдтныхан - *Margaritiferidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Нэлээд том, зузаан хавгастай. Лавайн гадарга хар хүрэн, зарим хэсгээр бараан хар өнгөтэй. Танан давхар цагаан ягаавтар өнгөтэй, хясааны урт 105-218 мм, өндөр 32-69 мм, цүндгий 25-40 мм, жин 840-1000 гр хүрнэ [1-3].

**Тархац, байршил нутаг:** Онон, Халх голын савын гол, горхи, жижиг нуурт амьдардаг. Хязгаарлагдмал тархацтай.

**Амьдралын онцлог:** Уулархаг нутгийн цэвэр тунгалаг устай, нуур голын элсэнцэр, жижиг хайрган хурдастай хэсгээр тохиолдоно. VII-VIII сард үржинэ. Өчүүхэн жижиг авгалдай загасны заламгайд хөгжинө.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тоо толгой, нөөцийг тогтоогоогүй. Өсөлт, хөгжилт удаан. Голын ус бохирдох, үерээр булингартах, зарим үед нуур, цөөрөм хатаж, ширгэх зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр үхэж хорогдоно.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж [4], Монгол улсын улаан номонд оруулсан [5]. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Биологи экологийн онцлогийг судлах, тогтмол байршин амьдрах нуур голын элсэнцэр, жижиг хайрган хурдастай хэсгийг элдэв бохирдлоос хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дулмаа, 1969, 2. Жадин, 1952, 3. Красная книга РСФСР, 1983. 4. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 5. Монгол улсын улаан ном, 1997.

## 2. ДЭЛТ ТАНАН ХЯСАА



*Cristaria plicata* Leach, 1815

**Баг.** Танатан - *Unioniformes*

**Овог.** Танатынхан - *Unionidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Монголын том хясааны нэг. Хавтасны дээд захаас овойсон гурвалжин “дэлтэй”. Лавай, хавтас зузаан, ногоовтор дэвсгэр дээр бараан судал бүхий хүрэгтэр өнгөтэй. Урт 200-240 мм, өндөр дэлийг оролцуулаад 140-180 мм, дэлгүйгээр 150 мм, цүндгий 60 мм, 300 гр хүрнэ [1,2].

**Тархац, байршил нутаг:** Буйр нуурт тохиолдоно. Жараад оноос өнөө хүртэл Буйр нуураас загас агнуурын тороор шүүгдэн гарч нэлээд хэмжээгээр хорогддог. Загас байнга барьдаг газар эрс цөөрсөн. Хязгаарлагдмал тархацтай.

**Амьдралын онцлог:** Лаг, элсэнцэр хурдастай, зөөлөн урсгалтай гол, нуурын булан, тохойн 1.5-2 м гүн газраар нутаглана. Гол мөрөн, нуурын захын ус дааварласан торгон элсэн дээр анжисны мөр шиг ховилтож зурагсан содон мөр гаргаж, гулсан хөдлөнө.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Нуурын усны горимын эрс өөрчлөлт хясааны авгалдайн амьдрах чадварыг бууруулж, бие гүйцсэн бодгаль загасны тороор шүүгдэн гарч хорогдоно.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралт [3], Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцид Буйр нуур түүний орчмын газарт /2004/ [5], Монгол улсын улаан номонд бүртгэж, оруулсан [4].

**Хамгаалах арга хэмжээ:** Биологийн онцлогийг судлах, байршил нутгийг улсын эсвэл орон нутгийн тусгай хамгаалалтад авах, загасны тороор гарсан хясааг буцааж тавих, үржлийн бөөгнөрөл газраас тороор загас барихыг хориглох, хамгаалах сурталчилгаа хийх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Дулмаа, 1985, 2. Жадин, 1952, 3. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Рамсарын конвенцийн тайлан, 2011.

### 3. СЭЛЭНГИЙН ТАНАН ХЯСАА



*Anodonta sedakovi* Siemaschko, 1848

**Баг.** Танатан - *Unioniformes*

**Овог.** Танатынхан - *Unionidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хавгас өргөн, гонзгойвгор, нимгэн, хэврэг харьцангуй цүндгэр. Баринтагийн гадна тал ногоовгор, шаравгар бор өнгөтэй, бараандуу ховил судлуудтай. Дотор талын тана бүдэг шаргал толботой цагаан. Урт 92 мм, өндөр 51 мм, цүндгий 33 мм [1].

**Тархац, байршил нутаг:** Сэлэнгэ, Орхон, Туул голын адгаар тархана.

**Амьдралын онцлог:** Голын намуун урсгалтай булан тохойн ёроолын лаг шавар элсэнд шигдэн амьдардаг. Татмын жижиг нуур, усанд амьдарна.


**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Усны бохирдолтоос Туул голын Улаанбаатараас Улхын булан хүртэлх усанд нэн ховор тохиолдох боллоо.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын хавсралтад ховор амьтнаар бүртгэж [2], Монгол улсын улаан номонд бүртгэн оруулсан [3].

**Хамгаалах арга хэмжээ:** Биологи, экологийн онцлогийг нарийвчлан судлах, тогтмол байршин амьдрах голын усны бохирдлыг бууруулан цэвэршүүлэх, ялангуяа, Туул голын сав нуггийн усны бохирдолд онцгой анхаарал хандуулах, Хойд мөсөн далайн ай савын зарим голд устаж, цөөрсөн хэсэгт зориудаар өсгөн үржүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жадин, 1952, 2. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоол, 3. Монгол улсын улаан ном, 1997.

#### 4. МОНГОЛ ТАНАН ХЯСАА



*Miodendorffinaia mongolica* Middendorff, 1851

**Баг.** Танатан - *Unioniformes*

**Овог.** Танатынхан - *Unionidae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хясааны хавтас хатуу, уртавгар, бага зэрэг хавчгар. Хавтасны гадна тал хар хүрэн өнгөтэй. Дотор талын тана цэнхэр туяа бүхий шаравтар цагаан. Урт 30-80 мм хүрнэ.

**Тархац, байршил нутаг:** ОХУ-ын Чита мужын нутгаас олджээ [1]. Онон, Балж, Халх, Нөмрөг голын сав газрын гол, горхиор тааралдана.

**Амьдралын онцлог:** Түргэн урсгалтай, элсэнцэр хурдастай, уулархаг болон тал хээрийн голын гольдролд 1.5 м хүртэл гүнд амьдарна. Өндгөн эс, авгалдайн хөгжил VI сарын эхээс VIII сар хүртэл үргэлжилнэ. Авгалдай 20-40 хоногийн дараа эхийн биенээс салж, усанд чөлөөтэй хөвж, ооролдсон загасны заламгайд шилжин бие гүйцсэн хясаа болтлоо амьдардаг.

**Тоо толгой, хомсдох шалтгаан:** Тархац, нөөцийг судлаагүй. Нэн хязгаарлагдмал нутагт маш цөөн тохиолдоно. Өсөлт, хөгжилт удаан. Голын ус бохирдох, үерээр булингартаж хүчилтөрөгчийн хангамж буурснаас авгалдай, заримдаа бие гүйцсэн бодгаль үхэж үрэгдэнэ.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын ховор амьтны жагсаалт [2], Монгол улсын улаан номонд оруулсан [3]. Тархац нутгийг Монгол дагуур, Нөмрөгийн дархан газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Биологи, экологийн онцлогийг нарийвчлан судлах, байршин амьдрах Онон, Балж, Халх, Нөмрөг голын сав газрын гол, горхины усны бохирдлоос сэргийлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Жадин, 1952, 2. Монгол улсын Засгийн газрын 2012 оны “Ховор амьтны жагсаалт батлах тухай” 7-р тогтоол, 3. Монгол улсын улаан ном, 1997.

## АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. Бельшев [1973]: Стрекозы Сибири [Odonata]. Часть 2. Издательство “Наука”. Сибирское отделение: Новосибирск.
2. Бельшев & Дащдорж [1958]:
3. Гантигмаа Ч., Баяртогтох Б., Айбек У., Энхнасан Д., Алтанчимэг Д. [2012]: “Монгол орны шавж, сээр нуруугүйтны тархацын судалгааг зохион байгуулах” сэдэвт ажлын тайлан.
4. Benedek P. [1968]: Odonata. Ergebnisse der zoologischen Forschungen von Dr. Z. Kaszab in der Mongolei. Reichenbachia. 11, 17:183-188.
5. Крылова В.Н. [1974]: Стрекозы [Odonata] Монгольской Народной Республики. Насекомые Монголии. Т. IV. Ч. 2. Л: Наука. С. 14-22.
6. Пузанова-Малышева Е.В. [1956]: Поведение жука скарабея - *Scarabaeus sacer* L. [Coleoptera, Scarabaeidae]. Труды Всесоюз. энтомол. общ-ва, т. 45. М.-Л. С. 51-71
7. Balthasar V. [1963]: Monographie der Scarabaeidae und Aphodiidae der palearktischen und orientalischen Region. I. 391 p.
8. Кабаков О.Н. [1980]: Ревизия жуков рода *Scarabaeus* L. [Coleoptera, Scarabaeidae] фауны СССР // Энтомол. обозр., т. 59, вып. 4, с. 819-829.

9. Николаев Г.В., Пунцагдулам Ж. [1984]: Пластинчатоусые [Coleoptera, Scarabaeoidea] Монгольской Народной Республики. Насекомые Монголии.- Л., 1984.- Выпуск 9, с. 90-294.
10. Черепанов А. И.[ 1981]: Усачи Северной Азии [Cerambycinae]. Новосибирск: «Наука», — Т. II. — С. 89—93. — 215 с.
11. Черепанов А.И., Черепанова Н.Е. [1975]: Жуки-дровосеки ивовых лесов Сибири. М., Наука, 208 с.
12. Черепанов А. И. [1981]: Усачи Северной Азии [Cerambycinae]. — Новосибирск: Наука. — 216 с.
13. Плавильщиков Н.Н. [1940]: Жуки-дровосеки. Ч. 2 // Фауна СССР. Насекомые жесткокрылые. — М.—Л.: Издательство АН СССР. — Т. 22. — 784 с. — [Новая серия №22].
14. Намхайдорж Б. [1976]: К фауне жуков-дровосеков [Col.,Ceram.] Монгольской Народной Республики. -Насекомые монголии 4:202-216
15. Коршунов Ю. П. [2002]: Определители по флоре и фауне России // Булавоусые чешуекрылые Северной Азии. Выпуск 4. — М.: Товарищество научных изданий КМК. — 424 с. — ISBN 5-87317-115-7
16. Forster, W. [1967]: Ergebnisse der zoologischen Forschungen von Dr. Z. Kaszab in der Mongolei. 102. Rhopalocera et Hesperidae II. Reichenbachia, 9: 121-134.
17. Forster, W. 1968. 147. Rhopalocera et Hesperidae II. Ergebnisse der zoologischen Forschungen von Dr. Z. Kaszab in der Mongolei [Lepidoptera]. – Reichenbachia 11 [18]: 189 – 205.
18. Forster, W. [1971]: Ergebnisse der zoologischen Forschungen von Dr. Z. Kaszab in der Mongolei. 224. Rhopalocera et Hesperidae IV. Faunistische Abhandlungen Staatliches Museum für Tierkunde in Dresden, 3: 187-217.
19. Korshunov, Yu. P. & Soljanikov, V. P. [1976]: Diurnal butterflies [Lepidoptera, Rhopalocera] of the Mongolian People's Republic. In [Kerzhner, I.M. & Kozlov, M. A. eds.]: Insects of Mongolia, Vol. 4: pp. 403-458. [In Russian]
20. Korshunov, Yu. P. [1977]: Diurnal butterflies [Lepidoptera, Rhopalocera] of the Mongolian People's Republic, II. In [Kerzhner, I. M. ed.]: Insects of Mongolia, Vol. 5: pp. 649-681. [In Russian]
21. Roman V. Yakovlev [2012]: Checklist of Butterflies [Papilionoidea] of the Mongolian Altai Mountains, including descriptions of new taxa. Nota lepi. 35 [1]: 51 – 96.
22. Куренцов А. И. [1970]: Булавоусые чешуекрылые Дальнего Востока СССР. [Определитель]. — Л.: Наука. С. 26. — 163 с.
23. Коршунов Ю.П. [1970]: Булавоусые чешуекрылые Якутии, Предбайкалья и Забайкалья. // Фауна Сибири. Новосибирск. С. 152-201.
24. Korshunov Yu.P. 1974. Rhopalocera [Lepidoptera] of Polar circle in Western Siberia. In: Kerzhner I.M., ed. Materials of 7th congress of VEO. P. 1. Leningrad: VEO, ZIN, p. 57- 58 [in Russian].
25. Korshunov, J. P. [1977]: Diurnal butterflies [Lepidoptera, Rhopalocera] of the Mongolian People's Republic,II. – In: The joint Soviet-Mongolian complex biological Expedition. – Insects of Mongolia 5: 649 – 681,fig. 1 – 2 [In Russian]
26. Коршунов Ю.П. [1972]: Каталог булавоусых чешуекрылых [Lepidoptera, Rhopalocera]

фауны СССР. - Энтомологическое обозрение 51 [1]: 136-154; 51 [2]: 352-368.

27. Баранчиков Ю.Н. [1979]: Обзор фауны булавоусых чешуекрылых Южного Прибайкалья. // Фауна лесов бассейна оз. Байкал. Новосибирск. С. 109-123.
28. Seyer, H. [1974]: Versuch einer Revision der *Papilio machaon*-Subspezies in der westlichen Palaedarktis. — Mitt. ent. Ges. Basel [N. F.] 24 [2]: 64—90, [3]: 93—117.
29. Seyer, H. [1976]: Versuch einer Revision der *Papilio madao*«-Subspezies in der ostlichen Palaarktis. Mitt. Ent. Ges. Basel 26: 65-87. [German].
30. Ackery P. R. [1975]: A guide to the genera and species of Parnassiinae [Lepidoptera: Papilionidae] / P. R. Ackery// Bull. Brit. Mus.[Natur. Hist.] Entomol.- 1975.- 31.- P. 71-105, 15 pls., frontispiece.
31. Verity [1905-1911]: *Rhopalocera palaeartica* : Iconographie et description des papilions diurnes de la region palearctique. Papilionidae et Pieridae / R. Verity.- Florence : Verity; Landi, 1905-1911.- 368 p., 72 pls. - [о датах публикации отдельных частей этой работы см. Verity, 1914; Kudrna, 1983].
32. Seyer, [1977]: 2. Nachtrag zum Versuch einer Revision der *Papilio machaon*-Subspezies in der Palaearktis und 1. Beitrag zur Nearktis / H. Seyer // Ibid.- 1977.- N. F., 27.- S. 105-115.
33. Alberti B. [1967]: Begegnung mit der Wirklichkeit von Traumfaltern [kaukasische Sammelerinnerungen] / B. Alberti // Entomol. ber.- 1967.-S. 112-118.
34. Forster, W. [1965]: 58. *Rhopalocera* et *Hesperiidae*. Ergebnisse der zoologischen Forschungen von Dr. Z.Kaszab in der Mongolei [Lepidoptera]. – Reichenbachia 7 [ 19]: 165 – 178.
35. Намхайдорж Б.[1968]: Монгол орны хайрсан далавчтаны [Lepidoptera] зүйлийн бүрэлдэхүүн, тархалтын тоймв Биологийн хүрээлэнгийн бүтээл №3.
36. Ефетов, К. А. Будашкин Ю. И. [1990]: Высшие разноусые чешуекрылые Крыма. — Симферополь: Таврия. — 112 с. — ISBN 5-7780-0171-1].
37. Ламперт К. [1913]: Атлас бабочек и гусениц Европы и отчасти Русско-Азиатских владений. С-Петербург. 488 с., 100 цветных таблиц.
38. Pittaway A.R. [1997]: *Sphingidae* of the Western Palaearctic [including Europe, North Africa, the Middle East, western Siberia and western Central Asia.]. Pittaway A.R. *Sphingidae* of the Western Palaearctic [including Europe, North Africa, the Middle East, western Siberia and western Central Asia.]. <http://tpittaway.tripod.com/sphinx/>. [115]
39. Державец Ю.А.[ 1977]: Бражники [Lepidoptera, Sphingidae] Монголии // Насекомые Монголии. Вып. 5. С. 642–648.
40. Намхайдорж Б. [2000]: Монгол оронд тархсан ба байж болох шумбуур [Sphingidae] эрвээхий. Биологийн хүрээлэн эрдэм шинжилгээний бүтээл. № 22. С. 115–128.
41. Пунцагдулам Ж., Горбунов О.Г., Тузов В.К., Алтанчимэг Д., Тогс-Эрдэнэ С. [2005]: Монгол орны зарим овгийн эрвээхийн [Lepidoptera: Saturniidae, Sphingidae] холбогдолтой шинэ мэдээ. Биологийн хүрээлэн эрдэм шинжилгээний бүтээл. № 25. С. 221–226.
42. Daniel F. [1969]: 165. *Bombyces* et *Sphinges* III. Ergebnisse der zoologischen Forschungen von Dr. Z. Kaszab in der Mongolei [Lepidoptera] // Ibid. Bd. 11, N 25. S. 265–277.
43. Панфилов Д.В. [1956]: К экологической характеристике шмелей в условиях Московской области// Уч.зап.Моск.Гос.пед.инст., т.61, с.467-484.
44. Скориков А.С. 1922. Шмели Палеарктики. Часть 1. Общая биология [с включением зоогеографии] // Известия Северной областной станции защиты растений от вредителей.




Петроград. Т.IV. Вып.1. С.1–160.

45. Гринфельд Э.К. [1954]: Насекомые опылители красного клевера. М—Л.: Изд-во АН СССР.-56 с.
46. Панфилов Д.В., Зимина Л.В. [1962]: Некоторые данные о гнездовании шмелей [Hymenoptera, Bombus] II Бюл. МОИП. Отд. биол. Т. 67, вып. 3. -С. 38-44.
47. Панфилов Д.В. [1978]: Сем. Apidae Пчелиные // Определитель насекомых европейской части СССР. - Л., Т. 3. Ч. 1. - С. 508-519.
48. Сысолетина Л. Г. [1970]: Фауна шмелей лесостепной провинции Приволжской возвышенности. // Уч. зап. ЧГПИ сер. биол. -Вып. 31. Чебоксары. С. 22-35.
49. Сысолетина Л.Г. [1976]: Об изменении фауны и населения шмелей в Чувашской АССР за последние 15 лет // Современные проблемы зоологии и современные методики ее преподавания в ВУЗе и школе: тезисы Всесоюзной научной конференции зоологов педвузов. - Пермь: ПГПИ. - С. 142-143.
50. Сысолетина Л.Г. [1977]: Редкие и исчезающие виды шмелей [Hymenoptera, Apoidea, Bombus] в Среднем Поволжье // VII Международный симпозиум по энтомофауне Средней Европы [Ленинград, 19-24 сентября 1977 г.]: тезисы докладов. - Л.: Наука. - С. 98.
51. Малышев, С.И. [1928]: Биологические особенности шмелей /С.И.Малышев // Пчеловодное дело [Москва]. № 5. - Вып. 70. - С. 237-238.
52. Pierre Rasmont & Stйphanie Iserbyt [2010]: Atlas of the European Bees: genus Bombus. <http://www.zoologie.umh.ac.be/hymenoptera/page.asp?id=169>
53. Peters, G. [1968]: Hummeln {Bombus} und Schmarotzerhummeln {Psithyrus} Ergebnisse der zoologischen Forschungen von Dr. Z. Kaszab in der Mongolei./ G. Peters, D. V. Panfilov // Reichenbachia, Mus. Tierk. Dresden. - V. 11, N. 16.-P. 177-182.
54. Панфилов, Д.В. [1968]: Общий обзор населения пчелиных Евразии /Д.В.Панфилов //Сб. науч. тр. /Зоол. музей МГУ. Т. XI. 1. С. 18-35.
55. Панфилов Д.В., Кочетова Н.И., Акимушкина М.И. [1984]: Шмель моховой *Bombus muscorum* [Fabricius, 1775]. Шмель Шренка *Bombus schrencki* Morawitz, 1881. Шмель modestus *Bombus modestus* Eversmann, 1852. Шмель спорадикус *Bombus sporadicus* Nylander, 1848. Шмель байкальский *Bombus subbaicalensis* Vogt, 1911 // Красная книга СССР. Редкие и находящиеся под угрозой исчезновения виды животных и растений. Т.1. М.: Лесная промышленность. С.260–263.
56. Определитель насекомых европейской части СССР. 1978 Т. III. Ч.1
57. Определитель насекомых Дальнего Востока России.[ 1999]: Т. VI. Двукрылые и блохи. Ч.1 / под общ.ред. П. А. Лера. — Владивосток: «Дальнаука». — С. 591—640. — 655 с. — 500 экз. — ISBN 5-7442-0921-2
58. Лер П. А. [1996]: Ктыри подсемейства Asilinae [Diptera, Asilidae] Палеарктики. Эколого-морфологический анализ, систематика и эволюция. — Владивосток: Дальнаука. — 184 с.
59. Hull F.M. [1962]: Robber flies of the world. Bulletin of the United States National museum 224:1-907.
- 60.
- 61.
62. Бирштейн Я.А. 1940. Высшие раки. Жизнь пресных вод. Т I. АН СССР.
63. Дулмаа А. 1965. Монгол орны хавч хэлбэртэн. ШУА-ийн мэдээ. Улаанбаатар. ШУА-ийн




хэвлэл. № 4. х 18.30.

64. Дулмаа А. 1985. Нуурын амьдрал. УБ.
65. Жадин В.И. 1952. Моллюски пресных вод СССР. Изд-во АН СССР.
66. Красная книга РСФСР. 1983. Москва, Россельхозиздат.
67. Монгол улсын Засгийн газрын 2012 оны “Ховор амьтны жагсаалт батлах тухай” 7-р тогтоол.
68. Монгол улсын Улаан ном, 1997. Адмон хэвлэлийн газар.
69. Труды Амурской Ихтиологической экспедиции /1945-1949/. Т III.



10. Дээд ургамал



*Dryopteris dilatata* [Hoffm.] A.Gray

*Pteridophyta*

**Овог.** *Согсортон* – *Aspidiaceae* Mett. ex Frank.

**Статус:** Нэн ховор ургамал. Дэлхийн байгаль хамгаалах холбоо /цаашид “ДБХХ” гэх/-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Богиноссон үндэслэг иштэй, олон наст өвс. Навч том, 30-100 см урт, гурвалжин юмуу зуувандуу-гурвалжин, урт бариултай, 3–4 дахин өдөлсөн, нүцгэн юмуу сийрэг булчирхайт үстэй, хар ногоон өнгөтэй. Сегментүүд сорлог шүдлэг. Сорус 1 мм голчтой, навчны дунд судлыг даган хошоодоор байрлана [2,4].

**Тархац, ургах орчин:** Сибирыг тархана. Монголд: Хянганы Нөмөргийн гол. Хус улиагаран ойн төгөлд ургана [1,3]. Нэн хязгаарлагмал тархацтай.

**Үржил:** Үндэслэг иш, спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, нарийвчлан тогтоогоогүй. Түймрийн улмаас хөнөөгдөж байгаа нөхөн сэргэх чадавх нэн хязгаарлагдмал устах аюулд орсон зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр оруулж, тархац нутгийг бүхэлд нь Нөмрөгийн дархан цаазат газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судлах, тархац нутгийг тэлэх, зориудаар үржүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008. 5. Мон. ур. улаан данс..., 2012.

## 2. ЮЛДЭН ШҮҮДРИЙН ОЙМ



***Botrychium lanceolatum* [S.G.Gmel.] Angstr.**

*Pteridophyta*

**Овог. Шүүдрийн оймтон – Botrychiaceae**

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “үнэлэх боломжгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Шүүслэг зөөлөн, 7-20 см өндөр, олон наст өвслөг ургамал. Үндэслэг ишнээс олон махлаг үндэс гардаг. Навч залаархуу салаалсан, спор төрүүлэх дээд, спор төрүүлэхгүй доод гэсэн 2 өөр хэсэгтэй. Спор өгдөггүй, доод навч өдлөг, цуулбар. Навчны ерөнхий хэлбэр зууван юмуу гурвалжиндуу зууван, юлдэрхүү хурц салбантай. Бөөрөнхий хэлбэрийн үрэнцэрүүд салбангуудын оройд бөөнөөрөө байрладаг [2,4,7].

**Тархац, ургах орчин:** Европ, Сибирь, Алс Дорнод, Умард Америкт тархана. Монголд: Хангай нурууны Халзангийн даваанд тохиолдоно. Ойт хээрийн бүсэд уулын нугад ургана [1,3,5].

**Үржил:** Үндэслэг иш, спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Ган, хуурайшилтаас шалтгаалан хөрс хатаж, ургах орчин доройтох, түймрийн улмаас үрэнцэр, нөхөн сэргэлтийн нахиа шатах, аадар бороо, мөндөрт цохиулан гэмтэх, усны үерт урсах зэргээс шалтгаалан устах аюулд орж байгаа зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулиар нэн ховор ургамлын жагсаалтад, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэж, ашиглалтыг хориглосон.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржил, биологийг судалж, зориудаар тарьж ургуулах, байгалийн нөхөн ургалтыг дэмжих арга хэмжээ авч, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар , 2008, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012, 7. Флора СССР, 1934. Т.1.

### 3. БАЛУУН ШИВЭРСЭН



*Lycopodium clavatum* L.

*Pteridophyta*

**Овог.** Шивэрстэн – *Lycopodiaceae* Rich.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Олонтаа салаалсан, мөлхөө, үндэслэг иштэй, 1 м хүртэл өндөр, олон наст өвслөг ургамал. Харин салаа мөчрүүд нь 10-15 см өндөр цэх юмуу нумраа, шигүү олон навчтай. Навч 5-10 мм урт, 0.5-0.7 мм өргөн, шугаман-юлдэрхүү юмуу шугамархуу, ишнээсээ нилээд дэрвийж байрласан, бүтэн захтай, үзүүртээ урт цагаан сортой. Спорт түрүүхэй 2-4-өөрөө юмуу хааяа ганц нэгээр байрладаг. Найлзуур бөөрөнхий, навчисын хамт 6-10 мм бүдүүн. Спорын навчинцар дугуй өндгөрхүү юмуу өргөн гурвалжин, захаараа сарьслаг шүдлэг, хялбар хугардаг үсэрхүү сортой [2,4,5].

**Тархац, ургах орчин:** Европ, Ази, Австрали, Умард Америкт тархана. Монголд: Хэнтийн

Минж голын цутгал Байвантын эхэнд тохиолдоно. Хөвдөжсөн шилмүүст ойд ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай [1,3].

**Үржил:** Үндэслэг иш, спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Ойн түймэрт, хөнөөлт шавжинд нэрвэгдэж, ойгүй болох, өндөр уулын хүчтэй үерт хөрсний өнгөн давхарга хуурах, хөрсний хуурайшилтаас байгалийн нөхөн сэргэлт буурах, эмийн зориулалтаар бэлтгэж, ашиглах зэрэг байгалийн болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс шалтгаалан устах аюулд орсон зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэж, байгалиас түүж ашиглахыг хориглосон. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, зориудаар өсгөн үржүүлэх аргыг туршин нэвтрүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008, 5. Монгол Улсын улаан ном, 1997. 6. Мон. ур. улаан данс..., 2012.

#### 4. СИБИРЬ ЖОДОО



*Abies sibirica* Ledeb.

*Pinophytina*

**Овог.** Нарстан – *Pinaceae* Lindl.

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** 25 метр хүртэл өндөр, 60 см хүртэл бүдүүн, 200 хүртэл жил насладаг. Шилмүүст мод. Титэм нилээд өтгөн, шовх оройтой. Гялгар, бараан холтостой, нэг нэгээрээ байрласан зөөлөн, 2-3 см урт, мохоо, хавтгай, шүүсэнцэр, хар ногоон, анхилуун шилмүүстэй, түүний доод хэсэг арай цайвар ногоон өнгөтэй. Боргоцой эгц босоо, боловсрохдоо хайрс нь бутарч, зөвхөн гол тэнхлэг нь мөчир дээр үлддэг. Боргоцой 5-9 см урт, 2-4 см өргөн зуувиндуу бортгон хэлбэртэй. Үр нь 5-7 мм, далавч 8-12 мм урт, урвуу өндгөн хэлбэртэй. Цайвар хүрэн, шаргал өнгөтэй. Үр тогтсон жилийн сүүлчээр үр боловсорч гүйцдэг [2,8].

**Тархац, ургах орчин:** Обь мөрний адагт, Орос Алтай, Сангилен, Хамар даваанд тархана [1,2]. Монголд: Хэнтийн нурууны баруун хойт хэсэг Бугант голын эхнээс Минжийн даваа хүртэл, Хөвсгөлийн Шишхэд голын адаг, Жолго, Жамц, Бусийн голуудын савд тохиолдоно [4,5,6]. Хуурайшилтаас Монгол дахь тархац хумигдах хандлагатай боллоо. Богдхан ууланд жодоо ургаж байсан мэдээ бий. Монголд д.т. 1100-1500 метрийн өндөрт уулын ар, оройн хэсгээр тайгын цэвдэгт, сул, чандруулаг шавранцар, чийгтэй хөрсөнд гацуур, хуштай эсвэл дангаараа ой үүсгэнэ. Агаарын чийг ихтэй, сүүдэрсэг, цас их унадаг газарт ургана.

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** 2010 оны судалгаагаар, Монголын жодоон ой Сэлэнгэ аймагт 1334 га талбайд 236.3 мянган шоо метр нөөцтэй, Хөвсгөл аймагт 36 га талбайд 2.5 мянган шоо метр нөөцтэйг тогтоожээ[9]. Ойн модыг хавтгайруулан огтлосноос зулзган модын өсөлт зогсох, түймэрт өртөгдөх зэрэг шалтгаанаас болж ховордож байна. Мөн сүүлийн жилүүдэд жодооны тархалтын орчимд алтны уурхай үйл ажиллагаа явуулж, газрыг ухаж, ургах орчинг алдагдуулах аюул нүүрлээд байна.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн нэн ховор ургамлын жагсаалтад, Монгол улсын улаан ном/1987, 1997/, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн авсан. 1980-аад онд Ботаникийн цэцэрлэгт зулзган жодоог нутагшуулах туршилт хийсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Жодоон ойг нарийвчилан судалж, ургуулах аргачлал боловсруулах. Хамгаалалтыг сайжруулах, алт олборлох ажлыг жодооны тархалтын орчинд бүрэн хориглох, хяналтыг сайжруулах. Үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад хамруулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бобров, 1978, 2. Богданов, 1974, 3. Коротков, Цэдэндаш, 1983, 4. Леса МНР, 1978, 5. Малышев, 1957, 6. Монгол улсын улаан ном, 1997, 7. Мон. ур. улаан данс., 2012, 8. Хлонов, 1979. 9. Энхсайхан, 2010.

5. ДАГУУР ШИНЭС



*Larix dahurica* Turcz. ex Trautv. [*Larix gmelinii* [Rupr.] Rupr]

Pinophytina

**Овог.** Нарстан – Pinaceae Lindl.

**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** 30 метр хүртэл өндөр, 1 метр хүртэл бүдүүн, 400 хүртэл жил насалдаг шилмүүст мод. Залуу найлзуур шаргал хүрэн, сийрэг үстэй, боргоцой 15-30 мм урт, өргөн өндөгөрхүү хэлбэртэй, залуу боргоцой бараг бортого хэлбэртэй, хайрс нүцгэн, түүний орой тайрмал эсвэл ухагдмал, том боргоцойд 40-50 ширхэг үртэй. Үр 3.5-4 мм урт, далавч түүнээс 1.5-2 дахин урт [1,2].

**Тархац, ургах орчин:** БНХАУ, ОХУ, Солонгосын хойгт тархана. Монголд: Монгол Дагуурын тойргийн Эрээний нурууны төгсгөл, улсын хил орчимд дагуур шинэсэн ой дангаар тохиолдоно. Харин Эрээний нуруунаас баруун зүгт Цэнхэрмандал, Батширээт, Балж голын эх хүртэл дагуур шинэс, сибирь шинэсний эрлийз болох Чекановскийн шинэс тархана [3,4]. Бүх зүйлийн шинэснээс, хүйтэн уур амьсгалд илүү зохицсон, ган, цэвдэг хөрсөнд тэсвэртэй. Өндөр уул, тундрт сөөг хэлбэрээр ургана [2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг нарийвчлан тогтоогоогүй. Ахуйн хэрэгцээнд зориулан огтлох, түймэрт шатсанаас тархац хомсдож байгаагаас эгэл бийрэн сүүлт, өрөөсгөл хүр эрвээхий зэрэг хөнөөлт шавж шилмүүсээр хооллож, өсөлт, хөгжилтийг зогсоож байна. Мөн сүүлийн жилүүдийн хуурайшилтаас болж тархац хумигдаж устаж болзошгүй зүйл.



**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монголын улсын улаан ном /1987, 1997/, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулах, түймрээс хамгаалах, хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, ойг нөхөн сэргээх, зориудаар тарьж ургуулах ажлыг яаралтай хийх, ховор ургамлын жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бобров, 1978, 2. Богданов, 1974, 1987, 3. Коротков, Цэдэндаш, 1983, 4. Леса МНР, 1988, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012.

## 6. ОДОЙ НАРС



*Pinus pumila* [Pallas] Regel

Pinophytina

**Овог.** Нарстан – Pinaceae Lindl.

**Статус:** Нэн ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** 5 метр орчим өндөр, 200 хүртэл жил насалдаг шилмүүст мод. Залуу найлзуур өтгөн бор шаргал үсэнцэртэй. Боргоцой 3.5-5 см урт, 2.5-3 см өргөн, эхний жилдээ улбар ягаан, бүрэн боловсрох 2 дахь жилдээ хүрэн бор өнгөтэй. Хайрс зууван, дугараг, үзүүр мэдэгдэхүйц гадагш эргэсэн, самар 0.5-0.8 см урт, 0.4-0.6 см өргөн [1].

**Тархац, ургах орчин:** Чукот, Камчатка, Лена мөрний адаг, Япон, Солонгос, Байгаль нуурт тархана [2]. Монголд: Хэнтийн өндөр уулын орой, ойн дээд захаар ганц нэгээр тохиолдоно [3]. Өндөр уулын д.т. 2300 метр өндөр уулын орой, зооны чулуурхаг цэвдэгт хөрсөнд ургадаг, хүйтэнд өлчир мод.

**Үржил:** Үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Залуу модны хальсыг буга идэж гэмтээхээс гадна, түймэрт амархан шатаж устах аюулд орсон зүйл. Монгол оронд байгалийн аясаар нөхөн сэргэх чадавх нэн хязгаарлагдмал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Ойн тухай хуулиар 1995 оноос цармын ойд ургадаг энэхүү модны ашиглалтыг хориглосон. Монголын улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, биологийг судалж, хамгаалах арга боловсруулан хэрэгжүүлэх, тохиромжтой нутагт шилжүүлэн суулгах, зориудаар ургуулах, түймэрт нэрвэгдэхээс урьдчилан сэргийлж, нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, хамгаалалтыг сайжруулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бобров, 1978, 2. Богданов, 1974, 3. Грубов, 1982, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс., 2012.

## 7. ӨРГӨННАВЧИТ ТУТАРГАНА



*Zizania latifolia* [Griseb.] Stapf.

*Magnoliophyta*

**Овог.** Биелэгтэн - *Poaceae Barnhart*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Үенүүдээсээ үндэслэдэг, урт, бүдүүн /голчоороо 1 см орчим/ иштэй, 80-150 см өндөр олон наст өвс. Навч хавтгай, өргөн шугамархуу, 1.5-3.5 см өргөн, түүний дээд гадаргуу нь ширүүвтэр арзгардуу. Хэлхэн гонзгойвгор-гурвалжиндуу, захаараа иржгэр. Залаа баг цэцэг, түүний доод хэсэг дэрэвгэр, дээд хэсэг хумигар. Залааны мөчир жижиг өргөсөнцөрүүдээр хучигдсан, ширүүвтэр. Түрүү дан бэлэгт нэг цэцэгтэй. Доод хэсэгт эр цэцэгт түрүүхэй, дээд хэсэгт эм цэцэгт түрүүхэй байрлана. Эм цэцгийн доод хайрс сормууслас сортой. Харин дээд хайрс 3 судалтай [2, 4].

**Тархац, ургах орчин:** Евразид тархана. Монголд: Дорнод Монгол, Халх голын дагуу хээрийн тойрогт нуурын мараалаг эрэг, усны захаар юмуу усан дотор ургадаг [1,3].

**Үржил:** Үр, үндэслэг ишээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Бэлчээрийн талхагдалт, хуурайшилтаас гол, нуур, цөөрмийн ус татрах, голын татруугаа ширгэх зэрэг шалтгаанаас устах аюулд орж байгаа зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монголын ургамлын улаан дансанд бүртгэж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, тархац нутгийн урсгал устай голын зах, хаялага, тогтмол устай нуур, цөөрмийн зах дагуу үрээр тарьж, үндэслэг ишээр суулган ургуулж, нутагшуулж, тархацын хүрээг өргөжүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Дариймаа, 1997, 3. Мон. ур. улаан данс., 2012, 4. Цвелев, 1976.

## 8. ХЭНТИЙН БИЕЛИГӨВС



*Poa kenteica* Ivanova

*Magnoliophytina*

**Овог.** Биелэгтэн – *Poaceae* Gaertn.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Газрын дор богино мөлхөө найлзууртай, сийрэг дэгнүүлт, олон наст өвслөг ургамал. Иш 40-110 см өндөр, 3-4 үетэй. Навч 3-9 см урт, 2-4 мм өргөн нарийн шугаман, хавтгай, гялгар, навчны хэлхэн мохоо, тэгш оройтой. Залаа өндгөрхүү зууван юмуу пирамид хэлбэртэй, сийрэг саглагар баг цэцэгтэй, цайвар ногоон юмуу ягаан туяатай, залааны мөчир 0.5-4 см урт, ширүүн. Түрүүхэй юлдэрхүү хэлбэртэй цайвар ногоон өнгөтэй, түрүүхэйн хайрс нэг судалтай, дээд хайрс гурван судалтай, юлдэрхүү хоорондоо адилгүй, 2-3 цэцэгтэй. Цэцгийн доод хайрс юлдэрхүү хэлбэртэй, цайвар ногоон, 5 бүдэг судалтай [3,4].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хэнтийн тойргийн ойт хээрийн бүслүүрийн уулын хээрийн нуга, уулын арын горхины дагуух нуга, голын эрэг, дэнжийн нугаар ургана [1,2].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, нэн хязгаарлагдмал тархацтай учир малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлсэн тохиолдолд устаж болзошгүй унаган зүйл.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг тусгай хамгаалалтад авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж, зориудаар өсгөн үржүүлэх

аргыг туршин боловсруулж нэвтрүүлэх, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 1997, 4. Малышев, Пешкова, 1979.

## 9. ЛИТВИНОВЫН БОТУУЛЬ



*Festuca litvinovii* [Tzvel.] E.Alexeev

*Magnoliophytina*

**Овог.** Биелэгтэн – *Poaceae Gaertn.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Олон настай, өтгөн дэгнүүл үүсгэдэг, нэг гэрт өвс. Иш 25–60 см өндөр, эгц босоо, гөлгөр, хагдарсан навчны угларгаар хучигдмал. Навч сэлмэрхүү юмуу ширүүн хялгасархуу, ногоон юмуу хөхөмдөг өнгөтэй, дээд гадаргуу 3-5 тод судалтай, ширүүн угларга ишний өндрийн  $\frac{1}{3}$  - хүртэл битүү. Залаа уртавтар, шигүү, залааны мөчир ширүүн үсэрхэг. Түрүүхэй юлдэрхүү хэлбэртэй, 4-6 цэцэгтэй, бага зэрэг гялгар ногоон өнгөтэй, боловсрох үедээ цайвар хүрэн. Түрүүхэйн хайрс өргөн юлдэрхүү, үзүүрээдээ ширүүвгэр, ногоон. Цэцгийн доод хайрс юлдэрхүү, сортой [3,4].

**Тархац, ургах орчин:** Сибирь, Алс Дорнодод тархана. Монголд: Дорнод Монголын хээрийн тойрогт чулуурхаг хажуу, заримдаа элсэрхэг хөрсөнд ургана [1,2].

**Үржил:** Үр болон үндэслэг ишээр ургана.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Тархац, нөөц хязгаарлагдмал учир уур амьсгалын хуурайшилтад нэрвэгдэж, цэцэглэх, үрлэх нөхцөл хязгаарлагдаж, мал ихээр идэж байгаагаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, Дорнод Монголын дархан цаазат газарт тархац нутгийн тодорхой хэсгийг хамруулжээ.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судалж, тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, зориудаар өсгөн үржүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Дариймаа, 1997, 3. Малышев, Пешкова, 1979, 4. Лигаа нар, 2009.

## 10. ФЕДЧЕНКОГИЙН ЦАГААНСУЛЬ



*Elymus fedtschenkoii* Tzvel.

*Magnoliophytina*

**Овог.** Биелэгтэн - *Poaceae Gaertn.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Мөлхөө найлзуургүй, дэгнүүл үүсгэдэг. 50-100 см өндөр ургамал. Навч хавтгай юмуу хумираа, навчны дээд гадаргуу хааяа 2 тал нь өтгөн, тачир, заримдаа урт үсэрхэг. Навчны угларга гөлгөр. Түрүү тод хүрэн, ягаан өнгөтэй, нэг талтай, шулуун, эгц босоодуу, хааяа бага зэрэг нугархай, бүхэлдээ зөвхөн нэг нэгээрээ байрласан, бараг суумал

түрүүхэйтэй. Түрүүхэй өргөн юлдэрхүү, 4-6 цэцэгтэй. Түрүүхэйн хайрс юлдэн өндгөнөөс нарийн юлдэрхүү, 5-7 тод судалтай. Цэцгийн доод хайрс зууван–юлдэрхүү, нуруугаараа богиновгор өргөсөнцөр юмуу үсэрхэг, тахир сортой. Цэцгийн дээд хайрс доод хайрстайгаа тэнцүү юмуу бага зэрэг богино, хянга дагуу болон хянга хоорондоо тачир үслэгтэй [2,4].

**Тархац, ургах орчин:** Дундад Ази, Зүүнгар, Тэнгэр уулын өндөр уулаар ховор тархана. Монголд: Монгол Алтайн уулын хээрийн тойрогт, уулын дээд бүслүүрийн нугажуу хажуу, эрэг орчмын нуга, хайрганд ургана [1,3].

**Үржил:** Үр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй, олон жил үргэлжилсэн ган, хуурайшилт, ширүүн аадар бороо, мөндрөөс улбаалсан усны үер, хүчтэй шуурга зэрэг байнга тохиолддог байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр тархцын хүрээ хумигдаж, нөөц хомсдон устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, зүйлийн тархац нутгийг Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газарт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Зүйлийн тархац, нөөц, экологи, биологийн онцлогийг нарийвчлан судалж, хамгаалалтыг сайжруулж, зориудаар тарьж ургуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Мальшев, Пешкова, 1979, 3. Лигаа нар, 2009, 4. Цвелев, 1976.

## 11. ИХ БУШИЛЗ



*Kobresia robusta* Maxim.

*Magnoliophytina*

**Овог.** Улалжтан - *Cyperaceae* Juss.

**Статус:** Ховор, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Үндэс орооцолдсон цагаан үслэгтэй, бага зэрэг дэгнүүл үүсгэсэн олон наст өвс. Иш бүдүүвтэр 2 мм орчим голчтой, 60 см хүртэл өндөр, гөлгөр. Ишний уг шаргал өнгөтэй, илтэсгүй угларгатай. Навчны илтэс шулуун, хумираа, ишнээсээ богино. Түрүү баг цэцэг түрүүнцэрээс бүрддэг ба 3 см хүртэл урт, шадар хайрс 7-8 мм урт. Түрүүнцэр 1 эм, 2-3 эр цэцэгтэй. Самранцар 3 талтай. Үр боловсрох орны амсар 2-3 [2,6].

**Тархац, ургах орчин:** Умард, Дорнод, Төвдөд тархана. Монголд: Хангайн нурууны Халзан бүргэдтэй ууланд ховор тохиолдоно. Ойн бүслүүрийн шинэсэн ойн элсэнцэр хөрстэй газраар нэн ховор ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай [1,3,4].

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй, өнө эртний ургамал тул өсөлт, хөгжил удааширсны зэрэгцээ хуурайшилт болон малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлснээс устаж болзошгүй, үлдвэр ургамал.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэж хамгаалсан.



**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, экологи, биологийг нарийвчлан судалж, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулах, зориудаар тарьж ургуулах, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лиганар, 2008, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс., 2012, 7. Раст. Цент. Азий, 1967, Вып.Ш.

## 12. БАГА УЛАЛЖ



*Carex parva* Nees

*Magnoliophytina*

**Овог.** Улалжтан - *Cyperaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Мөлхөө үндэслэг ишгэй, 10-40 см өндөр, олон наст. Ишний уг хүрэн нилээд урт, хэд хэдэн хайрсархуу угларгатай. Хуйларсан, ишнээсээ харьцангуй богино шовх навчтай. Түрүүнцэр эр, эм олон цэцгээс бүрддэг. Ууганцар шугаман-юлдэрхүү, олон тод хүрэн судалтай. Шадар хайрс юлдэрхүү, гялалзсан хүрэн өнгөтэй, ууганцараасаа богино. Үр боловсрох орон 3 амсартай [2,4,6].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Хангайн төв хэсэгт тохиолдоно. Ойт хээрийн бүсэд намгархаг нугад ургана. Тархац нутаг хязгаарлагдмал [1,3,5].

**Үржил:** Үндэслэг иш, үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Бэлчээрийн талхагдалтаас устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулан хамгаалж, тархац нутгийг хэсэгчлэн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөц, биологийн онцлогийг судалж, зориудаар тарьж ургуулах аргыг боловсруулж турших, хамгаалалтыг сайжруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигая нар, 2009, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012, 7. Раст. Цент. Азий, 1967, Вып.Ш.

### 13. ЦАГААН УЛАЛЖ



*Carex alba* Scop.

*Magnoliophytina*

**Овог.** Улалжтан - *Cyperaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 10-25 см өндөр, гөлгөр туяхан иштэй. Урт нарийхан мөлхөө үндэслэг ишнээс найлзуурууд багцлан гардаг, тэдгээрийн угийн угларга бүтэн, зэгэл хүрэн. Навч хялгасархуу

нарийн, ишнээсээ богино. Эр түрүүнцэр нарийхан, хамгийн дээд талын эм түрүүнцэрээс доор, хааяа нэг түвшинд байрлана. Эм түрүүнцрүүд 1-2 урт шилбэтэй, сийрэг суусан цөөн цэцэгтэй. Түрүүнцэрийн дагавар навч хоолойрхуу, урт угларгатай, илтэсгүй, гагцхүү хальслаг оройтой. Уутанцарууд юлдэрхүү, ногоон, оройдоо хальслаг оньтой. Шадар хайрс шовх үзүүртэй, цайвар хүрэн, хальслаг [2,4,5].

**Тархац, ургах орчин:** Европ, Кавказ, баруун, зүүн Сибирьт тархана. Монголд: Хөвсгөлийн шинэсэн ба холимог ой, хад асгатай хажуугаар ургана [1,3].

**Үржил:** Үр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Ойн түймрийн нөлөөгөөр хөрсний өнгөн давхарга шатах, ойн ургамалжилт хээрийн ургамалжилтаар солигдох зэргээр ургах орчны нөхцөл тохиромжгүй болох, ширүүн бороо, мөндрийн үерийн улмаас үндэслэг ишийг ил гаргах, эсвэл асга, чулуу овоорч цаашид ургах нөхцөлгүй болтол нь гүн дарах шалтгаанаас тархацын хүрээ хумигдах, нөөц хомсдох хандлагатай бөгөөд устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Тархац нутгийг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц хумигдан хомсдож байгааг харгалзан, зүйлийг үр болон үндэслэг ишээр үржүүлэх аргыг боловсруулж, үржүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лиган нар, 2009, 5. Раст. Цент. Азий, 1967. Вып. III.

## 14. ЭГЭЛ ГОДИЛ-ӨВС



*Acorus calamus* L.

*Magnoliophytina*

**Овог.** Годил өвстөн - *Araceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Бүдүүн мөлхөө үндэслэг иштэй, 50-100 см өндөр, олон наст өвс. Иш нэг талдаа ховилтой, нөгөө талдаа хянгатай, хөндлөн огтлол нь гурвалжин. Навч өргөн сэлмэрхүү хэлбэртэй. Цэцэг маш жижигхэн. Тэдгээр нь ишний үзүүрт боргоцой хэлбэрийн баг үүсгэн байрладаг. Боргоцой махлаг голтой, хажуугийнх, түүнээс илүү гарсан шугамархуу ногоон навчирхаг хучаастай [2,4,5].

**Тархац, ургах орчин:** Европ, Сибирь, Умард Америкт тархана. Монголд: Хэнтийн Бархын гол, Хангайн Зэлтэрт ховор тохиолдоно. Нуур, голын эрэг, усанд ургана [1,3].

**Үржил:** Үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Уур амьсгалын дулааралт, цөлжилтөөс гол, горхи, нуур, цөөрмийн ус татрах, тархац нутагт мал бэлчээрлүүлэх, эмийн зориулалтаар түүж ашигласнаас устах аюулд орсон зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном /1987, 1997/, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэсэн. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрлах туршилтын талбайд үндэслэг ишээр ургуулж байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судлах, ургамал тарималжуулдаг, ширгэдэггүй нуур, цөөрөм, зөөлөн урсгалттай голд үндэслэг ишээр тарьж ургуулах ажлыг өргөжүүлж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1 **Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008, 5. Монгол Улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс., 2012, 7. Санчир, 1987.

## 15. ЧАС-УЛААН АЛТАНДУСАЛ



*Tofieldia coccinea* Rich.

*Magnoliophytina*

**Овог.** Балцэцэгтэн – *Melanthiaceae* Batsch.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Газар дор мөлхөө найлзуургүй, 5-10 /15/ см өндөр, эгц босоо шулуун иштэй, дэгнүүлт олон наст өвс. Ишиндээ 2, үндэс орчимд олон навчистай, шугамархуу-юлдэн, жижиг шүдлэгтэй, ишний дээд хэсгийнх ногоон, доод хэсгийнх цагаан. Баг цэцэг толгойрхуу хэлбэртэй. Шадар эрхтэний навчинцар урт, улаавтар ягаан юмуу хааяа цайвардуу ногоон өнгөтэй. Цэцгүүд гудайж байрладаг. Хонхорцог урт, өргөн-өндгөрхүү хэлбэртэй [2,3,4].

**Тархац, ургах орчин:** Дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын өндөр ууланд ховор тархалттай. Монголд: Хөвсгөлийн уулын тайгын тойргийн дорнод хэсэг, Дархадын хотгорт тагийн хадтай

хажуу, сөөгөрхөг, хөвдөрхөг тайга, өндөр уулын чийглэг ойн цоорхой, хайргархаг хажууд цөөн цэгт алаг цоог тохиолдоно [1,6].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр ургана.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Хуурайшилт, ойн түймэрт өртөх, мод огтлох зэрэг шалтгаанаас устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэгдсэн. Тархац нутгийг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, зориудаар тарьж ургуулах, тархац нутагт мод бэлтгэхийг зогсоож, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Малышев, Пешкова, 1984, 4. Монгол улсын Улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс., 2012, 6. Өлзийхутаг, 1985.

## 16. СИБИРЬ АГДАРГАНА



*Zigadenus sibiricus* [L.] A.Gray

*Magnoliophytina*

**Овог.** Балцэцэгтэн – *Melanthiaceae* Batsch.

**Статус:** Нэн ховор, үлдвэр ургамал.

**Таних шинж:** 20-60 см өндөр, нарийн туяхан, эгц босоо, энгийн иштэй, олон наст өвслөг ургамал. Хар хүрэн хальстай, гонзгой өндгөрхүү сонгинолог булцуутай. Ишний доод хэсэгт нарийн навчнууд байрлана. Цайвар ногоон өнгийн одорхуу хэлбэрийн цэцгүүд нийлж цацаг баг цэцгийг үүсгэнэ. Цэцгийн шилбэний угт хүрэн ягаан дагавар навчтай. Үр жимс хонхорцог хэлбэртэй, гонзгой гурван талтай [2,3,4].

**Тархац:** Дорнод Европ, Сибирь, Алс Дорнодод тархана. Монголд: Хөвсгөлийн тойргийн дорнод хэсэг, Дархадын хотгорт ховор тохиолдоно. Шинэсэн ой, түүний төгөл, ойн цоорхой, сөөгөн ширэнгэд цөөн тоогоор ургана [1,5].

**Үржил:** Үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Өнө эртний гаралтай зүйл тул өсөлт, хөгжилт удаан явагддаг. Сибирийн тархацын өмнөд сэжүүрийн нэн хязгаарлагдмал нутагт ургадаг учир уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, түймэр, хүний зохисгүй үйл ажиллагааны улмаас устах аюулд орсон үлдвэр ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулиар нэн ховор ургамлын жагсаалтад, Монгол улсын улаан ном /1987, 1997/-онд тус тус бүртгэж, байгалийн нөхцөлд түүж, ашиглахыг хориглосон. Тархац нутаг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хэсэгчлэн хамрагдсан. ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн цэцэрлэгийн талбайд 2000 оноос тарималжих боломжтойг тогтоосон.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, үрээр тарьж ургуулах аргыг боловсруулж нэвтрүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Малышев, Пешкова, 1984, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Өлзийхутаг, 1985.

## 17. ГИЕНИЙ ХАВРЫНШАР



*Gagea hiensis* Pasch.

*Magnoliophytina*

**Овог.** *Сараанатан* - *Liliaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Сонгинолог булцуу хажуудаа хэд хэдэн нэмэлт бяцхан булцуутай, хүрэн сааралдуу хальсан бүрхүүлтэй. Иш 8-15 см өндөр, туюхан. Үндэс орчмын ганц навч хавтгай, 0.8-2 мм өргөн, нарийн шугаман хэлбэртэй. Баг цэцэг жигд биш шилбэ бүхий 2-8 цэцэгтэй. Цэцгийн шадар эрхтний навчинцар 6-10 мм урт, нарийн юлдэн хэлбэртэй, хурц үзүүртэй, дотор тал нь цайвар шаргал, гадна тал ногоон. Багана нилээд уртассан амсартай, үрэвч зуувандуу бөөрөнхий [1,4].

**Тархац, ургах орчин:** Дорнод Сибирьт тархана. Монголд: Хэнтийн уулын тайгын тойргийн ойн чийглэг эргийн нуга, татамд ургана. Монгол Дагуурын уулын хээрийн тойрогт Хайрхан, Хустайд тэмдэглэгдсэн [2,3].

**Үржил:** Үрээр болон сонгинолог булцуугаар үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ойн түймэр, бэлчээрийн талхагдалтын нөлөөнөөс шалтгаалан устах аюулд ороод байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн нэн ховор ургамлын хавсралтад бүртгэгдсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, зориудаар тарьж ургуулах аргыг



боловсруулж турших, ургаж буй орчны доройтлыг хязгаарлан зогсоох, хамгаалалтыг сайжруулах, үрийн удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996; 3. Лигаа нар, 2009, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс., 2012, 6. Өлзийхутаг, 1985.

## 18. САРМИСАН СОНГИНО



*Allium obliquum* L.

*Magnoliophytina*

**Овог.** Сонгинотон – *Alliaceae* Batsch. ex Borkh.

**Статус:** Нэн ховор, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Сонгинолог булцуутай, 60-140 см өндөр иштэй, олон наст өвс. Сонгинолог булцуу 2-3 см голчтой, илгэлэг улаан хүрэн хальстай, нижгээдээр байрлана. Үзүүр нь аажмаар нарийссан 6-9 мм хавтгай шугаман навчтай. Ногоовтор шар олон цэцгээс бүрдсэн бөмбөлгөн баг цэцэг ишний үзүүрт байрлана [1,4,7,8].

**Тархац, ургах орчин:** Зүүнгарын тарвагатай, Тэнгэр уул, Дунд, Зүүн өмнөд Европ, Дунд Азийн Алтай, Соёны уулсад тархана. Монголд: Баян-Өлгий аймгийн Сагсай, Алтай суманд бага хэмжээний талбайд цөөн тохиолдоно. Уулын дунд, доод хэсгийн ойн цоорхой, нугад ховор тохиолдоно. Тархац нутаг нэн хязгаарлагдмал [2,6].

**Үржил:** Үрээр үржинэ. Сонгинолог ишээр сэргэн ургана.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага бөгөөд нарийвчлан тогтоогоогүй, бага хэмжээний талбайд цөөн тоогоор ургадаг, ургамлын булцууг хүнсний зориулалтаар ашигладаг, тархац нутагт мал бэлчээрлүүлж байгаа зэрэг шалтгаанаас устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэгдсэн. Дархан хотын УГТЭШХ, Ботаникийн хүрээлэнгийн Ботаникийн цэцэрлэгт эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар үр, булцуугаар үржүүлэх ажлыг хийж байна. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрлах туршилтын талбайд 2008 оноос үрээр тарьж байна [3].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч хашиж хамгаалах, ургах газрыг нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалах замаар ашиглалтыг таслан зогсоож, үр болон сонгинолог булцуугаар зориудаар тарьж ургуулах ажлыг өргөжүүлж, тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, үрийн удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Жамъяндорж, Лигаа нар, 2011, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс., 2012, 6. Өлзийхутаг, 1985, 7. Дикорастущие полезные растения флоры Монгольской Народной Республики, 1985, 8. Флора Сибири, 1986, 9. Растения Центральной Азии, 1977, Т.7.

## 19. ПОТАНИНЫ САРААНА



*Lilium potaninii* Vrihcz

*Magnoliophytina*

**Овог.** *Сараанатан - Liliaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Сонгинолог булцуу өндгөрхүү, шаргалдуу хүрэн, хайрслалт бүрхүүлтэй, Иш сааралдуу ногоон, шулуун, цагаан тачирхан нягт үслэгтэй, 20-50 см өндөр. Навчис ишний дунд хэсэгт шигүү байрлалттай, шугаман хэлбэртэй, 1-3 судалтай. Цэцгийн дагавар навч шөвгөрхүү, хосоороо байдаг. Цэцгийн шилбэ урт. Цэцэг улаандуу, иш мөчрийн оройд 1-3 –аар байрладаг. Дохиур толгойрхуу, тоосовч шар. Цэцгийн шадар эрхтэн гадагш эргэсэн [1,4,5,6].

**Тархац, ургах орчин:** Хятадын төв болон хойт хэсэг, Өвөр Монголд тархана. Монголд: Монгол Дагуурын уулын ойт хээрийн, Хянганы уулын нугат хээрийн, Дорнод Монголын хээрийн /Дарьганга/ тойргуудад сийрэг шинэсэн ой, төгөл мод, сөөгөн ширэнгэ, чулуурхаг бэл, хажуу, хадны хормой, сүүдэр, чулуутай энгэрт ургана [2,3].

**Үржил:** Үр болон булцуугаар үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Олон жил дараалсан ган гачиг, ой хээрийн түймэр, бэлчээрийн талхагдалт зэрэг хүчин зүйлээс шалтгаалж цэцэглэлт, үрлэлт явагдахгүй байх, сонгинолог булцуу хатах зэрэг шалтгаанаас устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг хэсэгчлэн тусгай хамгаалалттай газар нутагт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Ургамлын тархац, нөөцийг нарийвчлан судлах, үр болон үржлийн эрхтэнээр нь зориудаар тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Өлзийхутаг, 1985, 4. Растения Центральной Азии, 1977, Т.7, 5. Флора Сибири, 1986, 6. Флора СССР, 1934, Т.1.

## 20. ЦӨӨНМӨЧИРТ ХЭРЭЭНҮД



*Asparagus oligoclonos* Maxim.

Magnoliophytina

**Овог.** Хэрээнүдтэн – *Asparagaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Иш голдуу ганц, эгц босоо, 25-70 см өндөр, тод ногоон өнгөтэй олон наст өвс. Мөчир салаархаг, хурц өнцөг үүсгэн байрладаг. Мөчир шулуун юмуу нумархаг, гадаргуу нь ширүүн, овгор, товгор тууш зурдастай. Кладоди 5-15-аараа нийлж ишин дээрээ суусан багц үүсгэнэ. Цэцгийн шилбэ 10-15 /20/ урт, дунд хэсгээрээ салж унана. Тоосовч уртавтар хэлбэртэй бөгөөд шилбэнээсээ нэлээд богино. Жимсгэнэ бөөрөнхий, эхлээд улаан байснаа бараан хүрэн өнгөтэй болдог [1,3,4].

**Тархац, ургах орчин:** ОХУ, Алс Дорнод, Хятад, Солонгосын хойг, Японд тархана. Монголд: Хянганы уулын нугат хээрийн тойргийн Хавирга ууланд уулын хээрийн сөөгөн ширэнгэнд элс, чулуутай хуурай хажуу, бэлээр ургана [2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Хээрийн түймэр, байгаль, цаг уурын өөрчлөлт, олон жилийн давтамжтай ган гачгийн улмаас цэцэглэхгүй, үрлэхгүй тохиолдолд хумигдмал байдалтай тархац нутаг бүхий


энэхүү зүйл устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэж, тархац нутгийг хэсэгчлэн улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, үрээр үржүүлэх аргыг боловсруулж, зориудаар тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Флора Сибири, 1986, 4. Флора СССР., 1935, Т.2.

## 21. КЕЙСКИЙН ХОНХОНЦОР



*Convallaria keiskei* Miq.

Magnoliophytina

**Овог.** Хонхонцортон – *Convallariaceae* Horan.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** 15-25 см өндөр, олон наст өвс. Мөлхөө үндэслэг иштэй, сахлаг үндэстэй. Навч зууван юмуу юлдэрхүү зууван, урт бариултай, 2, хааяа 3, ишээ нягт ороосон, урт нарийн

угларгатай. Цэцэг цагаан, өргөн хундгархуу, унжиж байрласан, 6 шүдэт нийлэнгэ шадар эрхтэнтэй. Цэцгийн шилбэ нугархай, цэцгүүд ишний оройд цацаг баг цэцгийг бүрдүүлдэг. Шилбэтэйгээ тэнцүү юмуу арай урт цэцгийн дагавартай. Улаан өнгөтэй, бөөрөнхийдүү шүүслэг жимстэй [2,4,8].

**Тархац, ургах орчин:** Эрхүү, Чита муж, Алс Дорнод, Хятад, Солонгосын хойг, Япон, Умард Америкт тархана. Монголд: Хэнтийн Хүдэр, Хянганы Халх, Нөмрөгийн голын хөндийн шугуйд ургадаг. Хус, шинэсэн ой, сөөгөн ширэнгэ, ойн цоорхой, ойн нугатай газар голдуу уулын баруун энгээр дагаж ургана.

**Үржил:** Үндэслэг иш, үрээр үржинэ

**Нөөц, хомсдох шалтгаан:** Ургамлын цэцэглэлтийн үед нь гоёмсог цэцгийг түүх, ой, хээрийн түймэрт шатах, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлснээс тархац хумигдаж, нөөцгүй болон устах аюулд орж буй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулиар нэн ховор ургамлын жагсаалтад, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэгдсэн. ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн цэцэрлэгийн үржүүлгийн талбайд 2005 оноос нарийн үндэслэг ишээр үржүүлэх туршилт судалгааны ажлыг хийж байна. Тархац нутгийн ихэнх хэсгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөцийг нарийвчлан тогтоож, зориудаар тарих ажлыг эрчимжүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс..., 2012, 6. Өлзийхутаг, 1985, 7. Растения Центральной Азии, 8. Флора Сибири, 1986, 9. Флора СССР, 1935, Т.4.

**22. ХУРЦДЭЛБЭЭТ ЦАХИЛДАГ**



*Iris oxypetala* Bunge

*Magnoliophytina*

**Овог.** Цахилдагтан - *Iridaceae* Lindl.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Утсархуу нарийн үндэстэй, сийрэг дэгнүүлт бугаар ургадаг. Суурь хагдарсан навчны зэвэн хүрэн, ширхэгтэж салмарсан угларгын үлдэгдлээр хучигдсан олон наст өвс. Навчис шугамархуу, хатуу. Цэцгийн бүрхэвч тууш судлуудтай, цвндгэр, сарьслаг хатуу, цэцгийнхээ хоолойноосоо урт. Шадар эрхтний хоолой дэлбэнгээсээ урт, эсвэл түүнтэй тэнцүү. Цэцэг цайвар хөх, нил ягаан дэлбээтэй, цэцгийн өнгө ургах хугацаандаа хувирдаг. Хонхорцог үр жимстэй [1].

**Тархац, ургах орчин:** Хятад, Өвөр Монголын нутагт тархана. Монголд: Дорноговь, Алашааны говьд ургадаг. Хайргат чулуурхаг хажуу, бэл хормой, элсэрхэг, элс, хайрган хөрс бүхий садрага даган ургана [2].

**Үржил:** Үр, үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Олон жилийн дараалсан ган, цэцэглэх үед нь хүйтэн бороо орох, цочир хүйтрэлт зэргээс ургамлын үр жимсний гарц буурч, үрлэлт хязгаарлагдаж байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгийн талбайд 2000 оноос үндэслэг ишээр шилжүүлэн суулгаж, үрээр ургах боломжтойг тогтоосон.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийн онцлогийг нарийвчлан судалж, зориудаар тарьж ургуулах, тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996.

## 23. ТОМЦЭЦЭГТ СААДГАНЦЭЦЭГ



*Cypripedium macranthum* Sw.

*Magnoliophytina*

**Овог.** Цэгэрэмтэн - *Orchidaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Нилээд бүдүүн, үндэслэг ишгэй, 20-40 см өндөр олон наст өвслөг ургамал. Зууван хэлбэрийн 8-15 см урт, цувраа байрлалтай, 3-5 навчтай. Ишний үзүүрийн дагавар навчны өвөрт 1-2 улбар ягаан том цэцэгтэй. Цэцгийн шадар эрхтний дөрвөн навчинцар нарийн, юлдэрхүү, үзүүрээдээ шовх, уруул уутархуу, улбар ягаан өнгөтэй [1,3,6].

**Тархац, ургах орчин:** Баруун, Зүүн Сибирь, Алс Дорнод, Европ, Япон, Хятадад тархана. Монголд: Хөвсгөл орчим, Монгол Дагуурын тойргийн баруун хэсэг, Хэнтийн тойрогт тохиолдоно. Сийрэг шинэсэн ой, хус шинэсэн ой, улиангар хусан ой, нарс, хусан ойн төгөл, ой зах нугад ургана [2,4].

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр үржинэ.




**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Цэцгийг гоёл чимэглэлд зориулж түүх, ой хээрийн түймэрт нэврэгдэх, ой модыг бэлтгэх, ургамлыг эмийн зориулалтаар ашиглаж байгаа зэрэг шалтгаанаас устах аюулд ороод байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар бүртгэгдсэн. Монгол улсын улаан номд /1987, 1997/, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнл худалдаалах тухай конвенцийн II хавсралтад, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэсэн [5]. Тархац нутгийг хэсэгчлэн тусгай хамгаалалттай газарт хамруулсан. ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгийн туршилтын талбайд Сэлэнгэ аймгийн Хүдэр орчмоос 2012 онд цуглуулсан 10 бодгалийг шилжүүлэн суулгаж, нутагших боломжтойг тогтоогоод байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржил, биологийг нарийвчлан судалж, тарьж ургуулах аргыг боловсруулж турших, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Вахрамеева и др, 1991, 2. Ганболд, 2010, 3. Грубов, 1982, 4. Губанов, 1996, 5. Мон. ур. улаан данс..., 2012, 6. Невский, 1937.

## 24. ШАР СААДГАНЦЭЦЭГ



*Cypripedium calceolus* L.

*Magnoliophytina*

**Овог.** Цэгэрэмтэн - *Orchidaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Хөндлөн, бараан үндэслэг иштэй, 20-40 см өндөр олон наст. Ишний дунд хэсэгт 6-10 см урт, 2-4 см өргөн, зууван, суумал 3-5 долгионтсон навчтай, үзүүртээ 1 юмуу 2-3 том цэцэгтэй. Цэцгийн шадар эрхтний 4 навчинцар 3-5 см урт, нарийн юлдэрхүү, мушгирсан улбар хүрэн өнгөтэй, цайвар шар уруултай [1,2,5].

**Тархац, ургах орчин:** Европ, Газрын дундад тэнгис, Бага Ази, Кавказ, Сибирь, Алс Дорнодод тархана. Монголд: Монгол дагуурын Ноён уулын хусан ой, ойн цоорхой, зах, ойн бүсийн гол горхийн эргийн нугад ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай [2,3].

**Үржил:** Цэцэглэлт ховор, тоос хүртэлт төвөгтэй, үр ургахдаа эмзэг, үрээр үржихдээ маш удаан, үндэслэг ишээр сайн үржиж, нөхөн ургана.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Мод огтлох, түймэр гарах, нуга, голын эргээр мал бэлчээрлүүлэх, ургамлыг түүж бэлтгэх зэргээс ховордож байна.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар бүртгэгдсэн. Монгол улсын улаан номд /1987, 1997/, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай конвенцийн II хавсралтад, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэсэн [4]. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалтай газарт хамруулсан. ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгийн туршилтын талбайд Сэлэнгэ аймгийн Хүдэр орчмоос 2012 онд цуглуулсан 10 бодгалийг шилжүүлэн суулгаж, нутагших боломжтойг тогтоогоод байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судлах, зориудаар тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, байгалийн нөхөн ургалтыг дэмжих, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Вахрамеева и др, 1991, 2. Ганболд, 2010, 3. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Мон. ур. улаан данс..., 2012, 5. Невский, 1937.

25. БУЛЦУУТ ТҮДЭНХАВХ



*Calypso bulbosa* [L.] Oakes.

*Magnoliophytina*

**Овог.** Цэгрэмтэн - *Orchidaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Сарьслаг угларгаар хучигдсан, уртавгар-өндгөрхүү хэлбэрийн бяцхан булцуутай. Энэ булцуунаас утаслаг нарийхан үндэс гарсан. 8-15 см өндөр олон наст, өвслөг ургамал. Үндэс орчимдоо урт бариултай, 3-5 см урт, 2-3 см өргөн-өндгөрхүү, ганц навчтай. Цэцэг том, 2.5-3 см голчтой, улбар ягаан өнгөтэй, ишний оройд ганц нэгээр байрладаг. Дэлбийн уруул шаахайрхуу хэлбэртэй, 1.5-2 см урт [1,5].

**Тархац, ургах орчин:** Европ, Сибирь, Алс Дорнод, Япон, Хойд Америк, Хятадад тархана. Монголд: Монгол Дагуурын Ноён ууланд тохиолдоно. Шилмүүст ойн сүүдэрсэг, хөвдөрхөг хөрсөнд ургана. Тархалт нэн хязгаарлагдмал [2,3].

**Үржил:** Булцууны нахиагаар үржинэ. Үрээр үржихдээ удаан, үрийн ургах чадвар дорой.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй, түймэрт нэрвэгдэснээс устах аюулд ороод байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар, Монгол улсын улаан ном /1987, 1997/, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтанд, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэж, хамгаалсан [4].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийн биологийг нарийвчлан судлах, зориудаар тарьж байгалийн нөхөн ургалтыг дэмжих, тохиромжтой газарт нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Вахрамеева и др, 1991, 2. Ганболд, 2010, 3. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Мон. ур. улаан данс..., 2012, 5. Невский, 1937.

## 26. ЦӨӨНЦЭЦЭГТ ГАНЦААХАЙ



*Lysiella oligantha* [Turcz.] Nevski

*Magnoliophytina*

**Овог.** Цэгэрэмтэн - *Orchidaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 7-20 см өндөр, олон наст өвслөг ургамал. Ишний угт ганц уртавгар-юлдэрхүү хэлбэрийн 5-7 см урт, 12-20 мм өргөн, навчтай. Навчны суурь нарийсч, бариултай төсөөтэй, ишээ зуусан далбанлаг болсон. Цацаг баг цэцэг жижиг, ногоовтор 4-9 цэцэг, ишний үзүүрт 2-4 см урт баг цэцэг үүсгэн байрладаг. Шадар эрхтний гадаад навчинцар дугуй, дундахаасаа нилээд өргөн, дотор талын навчинцар юлдэн, дээш чиглэсэн. Доод уруул дөрвөлжин юлдэрхүү юмуу шугаман. Богинохон годо йтой. 6-7 дугаар сард цэцэглэнэ [1,3,5].

**Тархац, ургах орчин:** Дорнод Сибирь, Алс Дорнодод тархана. Монголд: Хөвсгөл, Хангайн тойргийн төв хэсэгт тохиолдоно. Шинэс, гацууран ойн хөвдөрхөг хөрсөнд ургана [2,4].

**Үржил:** Үр, үндэсний шижмээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Ойгоос мод бэлтгэх, түймэр гарах, хөвдөн бүрхэвч шатах, хуурайших зэрэг шалтгаанаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг хэсэгчлэн улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийг нарийвчлан судлах, зориудаар тарьж ургуулах аргыг боловсруулж турших, ховор ургамлын жагсаалтад оруулж, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Вахрамеева и др, 1991, 2. Ганболд, 2010, 3. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Невский, 1937.

## 27. УЛААН САРВУУ-ҮНДЭС



*Dactylorhiza cruenta* [O.F.Muell.] Soo

*Magnoliophytina*

**Овог.** Цэгэрэмтэн - *Orchidaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Салбанлаг булцуутай, ягаан өнгөтэй, хөндий, 10-30 см өндөр иштэй. Ишний суурийн болон дунд хэсгийн навчис өндгөрхүү юмуу уртавтар юлдэн хэлбэртэй, 6-10 см урт, 1.5-3 см өргөн, гадаргуу жижигхэн толботой. Цэцгийн дагавар навчинцар ягаан юмуу толборхог. Шадар эрхтний навчинцар 5-7 мм урт, уртавтар өндгөрхүү, бараан толботой. Ягаан олон цэцэгтэй. Уруул 5 мм орчим урт, дөрвөлжиндүү-өргөн зууван хэлбэртэй. Годой 4-6 мм

урт, мохоовгор бөгөөд бага зэрэг махир. Цэцгүүд ишний оройд 3-8 см урт, бортгорхуу хэлбэрийн баг цэцэг бүрдүүлдэг. 6-7 дугаар сард цэцэглэнэ [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Газар Дундын Тэнгис, Баруун, Зүүн Сибирыг тархана. Монголд: Хангайн тойрогт тэмдэглэгдсэн. Чийглэг нуга, сөөгөн шугуй, шаварлаг хүлэрлэг, гэрэлсэг хөрсөнд ургана. Тархац нэн хязгаарлагдмал [2,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, нарийвчлан судлаагүй. Ургах орчин хуурайших, бэлчээрийн талхагдлаас шалтгаалан устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж, ховор ургамлын жагсаалтад бүртгэх, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, зориудаар тарьж ургуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Вахрамеева и др, 1991, 2. Ганболд, 2010, 3. Губанов, 1996.

## 28. ФУКСИЙН ЦАХИРАМ



*Dactylorhiza fuchsii* [Druce] Soo

*Magnoliophytina*

**Овог.** Цэгэрэмтэн - *Orchidaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Сарвуулаг, салбанлаг булцуутай. Хүрэн цоохор толболог 4-8 навчтай, 25-50 см өндөр иштэй, 2-10 см урт сийрэг баг цэцэгтэй, олон наст өвс. Ишний доод хэсэгт 3-10 см урт, 1-3 см өргөн, хүрээрхүү зууван, мохоо хэлбэртэй хоёр навчтай, ишний дунд хэсгийн навч нарийсч жижгэрсэн, зууван-юлдэрхүү, шовх оройтой. Цэцгийн дагавар навч ногоон, нилээд урт. Цэцгийн шадар эрхтэний навчинцар цайвар ягаан, 5 мм орчим урт, зууван, хажуугийн хоёр навчинцар дэлгэмэл. Цэцгийн уруул дэвүүрэрхүү, гурван салбанлаг, тачир шүдлэг, дундах нь нарийн, урт, хөх ягаан өнгөтэй, хүрэн толболог, зурдастай [1,3,5].

**Тархац, ургах орчин:** Европ, Сибирьт тархана. Монголд: Монгол Дагуур [Ноён уул], Хэнтий [Хүдэр гол]-д тохиолдоно. Хус, шинэсэн ой, гацууран ойн хаяа, ойн цоорхой, сөөгөн ширэнгэ, намгийн захаар ургана [2,3].

**Үржил:** Үрээр болон ургал эрхнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Цэцгийг түүх, булцууг эмийн зориулалтаар бэлтгэх, мал бэлчээрлүүлэх, ой хээрийн түймрийн нөлөөгөөр устах аюулд орж байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар, Монгол улсын улаан номд /1987, 1997/, Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн II хавсралтад, Монголын ургамлын улаан дансанд тус тус оруулж бүртгэгдсэн [4]. Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархалт, нөөц, биологийг нарийвчлан судлах, зориудаар тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Вахрамеева и др, 1991, 2. Ганболд, 2010, 3. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Мон. ур. улаан данс..., 2012, 5. Невский, 1937.

29. ЧАС-УЛААН САРВУУ-ҮНДЭС



*Dactylorhiza incarnata* [L.] Soo  
*Magnoliophytina*  
**Овог.** Цэгэрэмтэн - *Orchidaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Гүн сарвуулаг булцуулаг үндэстэй, 40 см хүртэл өндөр иштэй, 25 см хүртэл урт, олон ногоон навчтай. Баг цэцэг өндгөрхүү, өтгөн. Цэцгийн дагавар навчинцарын зах, гол судал ягаандуу. Цэцэг улбар юмуу өтгөн улаан, уруул 5-8 мм урт, хар толбон зурдастай. Годой шовгор, бага зэрэг махир бөгөөд үрэвчийн  $\frac{3}{4}$  -тай тэнцүү. 6 дугаар сард цэцэглэнэ [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Баруун Сибирь, Кавказ, Иранд тархана. Монголд: Хангай, Хянганы тойрогт тохиолдоно. Ойн цоорхой, чийглэг нуга, хөвдөт намаг, намгархаг сөөг дунд ургана [2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Нуга хуурайших, намаг хатах, түймэрт өртөгдөх, мал бэлчээрлүүлэх шалтгаанаас устах аюулд орж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийг нарийвчлан судалж, ховор ургамлын жагсаалтад оруулах, зориудаар тарьж ургуулах, удмын санг хадгалах.



Эх зохиол, мэдээ: 1. Вахрамеева и др, 1991, 2. Ганболд, 2010, 3. Губанов, 1996.

### 30. ЭЛДЭВНАВЧИГ УЛИАС [ТООРОЙ]



*Populus diversifolia* Schrenk

*Magnoliophytina*

**Овог.** *Бургасман – Salicaceae Mirb.*

**Статус:** Нэн ховор, үлдвэр зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Өтгөн саглагар титэмтэй, 8-10 м өндөр мод. Хагарч цуурсан цайвар саарал холтос бүхий бүдүүн иштэй. Нэгэн жигд бүдэг ногоовтор цэгээн сарьслагдуу навчистай. Өргөн дугуй, эсвэл тайрмал юмуу зүрхэн хэлбэрийн суурьтай, хотон шүдлэг, хоёр талдаа 4-5 шүдэнцэртэй, залуу найлзуурын навч нарийн юлдэрхүүгээс өндгөрхүү-юлдэн, бараг бүтэн захтай. Баг цэцэг уртавтар, унжмал. Үр жимс хонхорцог хэлбэртэй, шилбэнээсээ 2 дахин урт, нүцгэн үрчгэрдүү гадаргуутай, үр жижиг [1,3,6,7].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Говь-Алтай, Зүүнгар, Алашаа, Алтайн өвөр говиудын тойргийн бага хэмжээний талбайд тохиолдоно. Тархац нутгийн баруун зах Аж богдын нурууны өмнөт хормойн Элст мянганд тэмдэглэгдсэн бөгөөд, зүүн зах Тост, Ноён богд, Нэмэгт уулсаар хязгаарлагдаж, Монгол Алтайн нуруунаас урагш Эзний голын сав нутгийн адаг хүртэлх газрыг хамардаг. Цөлийн Захуй, Бага нуур, Эхийн гол, Тооройн булаг, Шар хулс, Цагаан бургас, Чонын боом, Эхэн зулганай, Зуун модны баянбүрдэд шугуйлан ургана. Говийн баян бүрдүүдэд сайрын үйрмэг чулуу, хайргат хурдас, хужирлаг газруудын захаар цуварч урган бага хэмжээний тармаг, төгөл ой үүсгэдэг. Мөн элсэн манханы захаар

ургана [2,5].

**Үржил:** Үр болон үндэсний салмайгаар маш удаан үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Цөл, цөлөрхөг хээрийн нөхцөлд олон жил дараалан ган болж, хөрсний чийг багасаж хуурайшилт эрчимжиж байгаагаас үрээр үржих явц удаарширч байгаа. Ус чийглэг цөөн тооны газруудаар хааяа үрээс нялх тоорой цухуйхад болон үндэсний салмайнаас залуу найлзуур гарахад түүнийг мал, зэрлэг амьтан идэж гэмтээснээс ургалтанд муугаар нөлөөлж байна. Тооройг түлшинд хэрэглэх, малын хашаа барихад болон гэр ахуйн модон хэрэглэл хийхэд ашиглаж байгаагаас тооройг талбай дахь модны тоо цөөрч, тархац нутаг хумигдан устах аюулд орсон. Өнө эртний үлдвэр зүйл учир нөхөн төлжих чадавх зогсонги байдалд орсон.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном /1987,1997/, Монголын ургамлын улаан данс тус тус бүртгэж, байгаль дээрээс түүж бэлтгэхийг хориглон, тархац нутгийг улсын тусгай хамгаалалтай газарт хэсэгчлэн авч хамгаалсан. Тарималжуулж, нутагшуулах зорилгоор ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн Ботаник цэцэрлэгт хийсэн боловч бодитой үр дүн гараагүй. 1987 оноос Говийн их дархан газрын харъяа мод үржүүлгийн газар байгуулахаас эхлээд тооройг үр, мөчрийн тайрдсаар ургуулах судалгааг анх удаа хийж гүйцэтгэж, тарьц, суулгац ургуулсан байна. Ойн хүрээлэнгээс 1994-1995 онуудад тооройн тархалтыг тоймчлон судалж, Монгол оронд 25000 орчим тоорой ургаж байна гэж тогтоожээ. 2006 оноос говь, цөл бүс нутгийг хамруулсан судалгаа явуулж, шинээр тархалтын цэгүүдийг илрүүлсэний зэрэгцээ зүүн талын цэг нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Задгайт, Сайхандулаан сумын Завсар, Тооройн хоолой, Хөвсгөл сумын тооройн төгөл, Мандах сумын Өлгий хийд зэрэг газруудад байгааг илрүүлэв. Харин баруун талын цэг нь Ховд аймгийн Булган сумын нутаг хүртэл тархан ургаж байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Ургах тохиромжтой орчныг тогтоож, үрээр ургах, үндэсний салмайгаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлэх, байгаль дээр сэргэн ургаж буй нялх болон зулзаган тооройг услах, хашиж хамгаалах, цөлийн баян бүрдүүд, устай цэгүүд, цөл, хээрийн бүсийн туршлагын станц, төвүүдэд усалгаатай, хамгаалагдсан нөхцөлд тооройг тарьж ургуулах ажлыг улсын төсвийн ойжуулалт болон орон нутгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос санхүүжүүлж, хэрэгжүүлэх, зарим тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулж, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1.Грубов, 1955, 2. Лигаа нар, 2008, 3. Монгол улсын улаан ном, 1997, 4. Мон. ур. улаан данс..., 2012, 5. Рачковская, 1986, 6. Флора СССР., 1936, Т.5, 7. Юнатов, 1968, 8. Юнатов 1977.

31. НООСОНШИЛБЭТ БАГЛУУР



*Anabasis eriopoda* [Schrenk] Benth. ex Volkens

*Magnoliophytina*

**Овог.** Луульман – *Chenopodiaceae* Vent.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Хөхөвтөр өнгөтэй, ихэд салаалж мөчирлөсөн, тал бөмбөлөг хэлбэрийн бут үүсгэдэг сөөг. 10-30 см өндөр ургамал. Үндэс голлосон бортгорхуу хэлбэртэй, хар бараан өнгөтэй. Ишний уг орчимдоо эсгийрхэг үслэгтэй. Ишний доод хэсгийн навч хайрсархуу, уртавтар-өндгөрхүү, 6-10 мм урт. Цэцэг навчны өвөрт ганц нэгээрээ байрладаг. Цэцгийн дагавар навч өвслөг, цэцгээсээ богино. Шадар эрхтэн хальслаг, зуувандуу юмуу уртавтар хэлбэрийн навчинцартай. Үр өргөн-өндгөрхүү юмуу бөмбөлөг хэлбэртэй, 3-6 мм урт [1,2,4].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Зүүнгарын говийн толгодын чулуурхаг хотгордуу хажуугаар тархдаг [1].

**Үржил:** Үрээр болон ургал эрхтнээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Олон тооны малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэх, олон жилийн гангийн давтагдал, хөрсний чийгийн хомсдол, цөлжилтөөс тархац нутаг улам бүр хумигдан, нөөц багасч байгаа устах аюулд орсон зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр бүртгэж, Монгол улсын улаан ном болон Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэлдсэн. Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Бэлчээрийг сэлгээтэй ашиглах, цөлжилттэй тэмцэх, тархац, нөөцийг тогтоож, зориудаар тарьж ургуулах замаар байгалийн нөхөн ургалтыг дэмжих, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Лигаа нар, 2008, 3. Мон. ур. улаан данс..., 2012, 4. Флора СССР., 1936, Т.6.

## 32. ӨНДӨР БАГЛУУР



*Anabasis elatior* [C.A.Mey] Schischk.

Magnoliophytina

**Овог.** Луультан – *Chenopodiaceae* Vent.

**Статус:** Ховор ургамал.

**Шинж таних:** 15-35 см өндөр, нүцгэн, тод ногоон өнгөтэй заримдаг сөөгөнцөр. Ишний уг нилээд модожсон олон салаатай, саарал өнгийн холтостой, залуу зөөлөн олон мөчиртэй, бут үүсгэн ургадаг. Навч гурвалжин шөвгөрхүү, ихэнхдээ ишрүүгээ ханарч байрладаг, завирхуу хэлбэрийн хальслаг нилээд богино цэцгийн дагавартай. Навчны өвөрт цэцэг ганц нэгээрээ байрлан, иш мөчрийн оройд нягт түрүүрэхүү хэлбэрийн баг цэцэг үүсгэдэг. Шадар эрхтэний салбан мохоо, гадна хүрээнийх нь өргөн-өндгөрхүү. Дотор хүрээний салбан нь нилээд нарийн, далавчгүй. Үр 2-3 мм голчтой, шүүслэг, дугуй [1,3].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Зүүнгарын говийн баруун хэсгээр чулуурхаг болон хужир мараатай газраар ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай [2].

**Үржил:** Үрээр болон ургал эрхтэнээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй, олон жилийн гангийн давтагдал, цөлжилт, хуурайшилтаас нөөц хомсдон тархац нутаг хумигдаж байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор зүйлээр бүртгэсэн. Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судлах, байгаль дээрээ нөхөн төлжих нөхцлийг хангах, зориуд тарих аргыг боловсруулж, үржүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Лигаа нар, 2008, 3. Флора СССР., 1936, Т.6.

### 33. ГӨЛГӨР ИВЭРГЭНЭ



*Herniaria glabra* L.

*Magnoliophytina*

**Овог.** *Баширман* - *Caryophyllaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Шар ногоон өнгөтэй, жижигхэн олон наст өвслөг ургамал. Иш 3-10 см өндөр, дэлгэмэл юмуу өндиймэл. 2-5 мм урт, зууван, нүцгэн навчистай. Цэцэг олон /6-10/, жижиг, 1 мм голчтой, таван гишүүнтэй. Дэлбэ цайвар. Үр жимс өндгөрхүү, үр жижиг, бөөрөнхий, хүрэн өнгөтэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Европ, Дундад Ази, Кавказ, Төв Ази, Баруун Сибирыг тархана. Монголд: Монгол Алтайн тойрогт Булган голын эхээр буюу Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Булган сумын нутагт тохиолдоно. Чулуурхаг, хуурай энгэр хажуу, усны ойролцоох элсэрхэг газарт ургана [2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Хэт халуун, цөлжилт, хуурайшилтад нэрвэгдэх, бэлчээрийн талхагдалтаас цэцэг, үр жимс гэмтэж, үр боловсрохгүй нөхцөл бүрдээд байгаа устаж болзошгүй зүйл.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэж хамгаалсан. Тархац нутгийг улсын тусгай

хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг тогтоох, биологийн онцлогийг илрүүлэх, байгалийн нөхөн ургалтыг дэмжих зорилгоор үндсэн тархац нутгийг малын бэлчээрээс чөлөөлөх, үрээр үржүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996. 3. Ковтонюк, 1993.

## 34. ЗҮҮНГАРЫН БАШИР



*Dianthus soongoricus* Schischk.

*Magnoliophytina*

**Овог.** *Баширман - Caryophyllaceae Juss.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Үндэслэг иш богинохон зузаавтар, салаархаг, дэгнүүл үүсгэдэг, олон наст өвс. Иш 10-30 /35/ см өндөр, энгийн, олноороо гардаг. Навчис нарийн шугамархуу, 1-3 см урт, 1 мм орчим өргөн, судал хянгархуу, үсгүй. Цоморлиг 25-30 мм урт, 3-4 мм өргөн, юлдэрхүү шүдлэгтэй. Дэлбийн хэлтэс баргар улаан юмуу тод улаавтар өнгөтэй. Үр жимс зууван [1].

**Тархац, ургах орчин:** Төв Ази /зөвхөн Зүүнгарт/-д тархана. Монголд: Зүүнгарын тойрогт Бодонч голын адгаар буюу Ховд аймгийн Алтай сумын нутагт тохиолдоно. Элсэрхэг болон бутармаг чулуут болон чулуурхаг газарт ургана [2].

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэх, хуурайшилтаас байгалийн жамаар нөхөн үржих явц удаарширч, устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, биологийн онцлогийг судлах, байгалийн нөхөн ургалтыг дэмжих зорилгоор үрээр үржүүлэх, нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996.

### 35. ГЕЛЫЦЕРИЙН БАШИР



*Dianthus hoeltzeri* C.Winkl.

*Magnoliophytina*

**Овог.** *Баширман - Caryophyllaceae Juss.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Урт үндэслэг ишгэй, олон наст өвслөг ургамал. Иш олон, 15-60 см өндөр. Навчис шугаман юмуу шугаман-юлдэрхүү, хавтгай, 4-8 см урт, /2/ 4-10 мм өргөн. Цэцэг цөөн, 1-4. Цоморлиг 23-25 мм урт, 4-5 мм өргөн. Дэлбийн хэлтэс бараан ягаан юмуу бүдэг улаан өнгөтэй. Үр жимс жижиг, зуувандуу [1].

**Тархац, ургах орчин:** Төв Азид тархана. Монголд: Монгол Алтайн тойрогт Бүс Хайрхан уул,



Булган голын эхээр буюу Баян-Өлгий аймгийн Булган сумын нутагт тохиолдоно. Шинэсэн ой, элдэв өвст уулын болон дэд тагийн нуга, хааяа уулын хээрийн хотос хонхор газарт ургана [2].

**Үржил:** Үндэслэг иш, үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Цаг уурын дулаарал, хэт халуун, хуурайшилт, ган, хөрсний чийгийн хомсдол, бэлчээрийн талхагдалтаас шалтгаалан ургамлын нөөц хомсдож, тархац нутаг хумигдаж байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэж, ашиглалтыг хязгаарласан. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг тогтоох, үрээр ургуулах аргыг туршиж, нэвтрүүлэх, хамгаалалтыг сайжруулах, үндсэн тархац нутагт мал бэлчээрлүүлэхийг хязгаарлах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996.

## 36. ДӨРВӨЛСӨН БӨЛБӨӨ



*Nymphaea tetragona* Georgi

*Magnoliophytina*

**Овог.** *Бөлбөөтөн* – *Nymphaeaceae* Salisb.

**Статус:** Нэн ховор, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн

ҮНЭЛЭГДСЭН.

**Таних шинж:** Үндэслэг иш шулуун, олон наст өвслөг, усны ургамал. Навч зүрхэн хэлбэрийн суурьтай зууван юмуу өргөн-өндгөрхүү хэлбэртэй. Цэцэг том, 4-5 см хааяа 9 см хүртэл голчтой, 10-12 дэлбийн хэлтэстэй, дохиураас эрс тусгаарлагдсан, 4 талт суурьтай. Үр боловсрох орны амсар 4-10 цацрагтай [2,6,7].

**Тархац, ургах орчин:** Умард Европ ба Баруун, Зүүн Сибирь, Алс Дорнод, Хятад, Энэтхэг, Япон, Умард Америкт тархана. Монголд: Хөвсгөлийн Дархадын хотгорын Цэцэгт нуур, Хангайн Идэр гол, Их нууруудын хотгор /Хар нуур, Хар ус нуур/-ын тойрогт тохиолдоно. Нуур, голын татуургат ургана [2].

**Үржил:** Үр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Гол, горхи, нуурын урсац багасгах, ширгэх, намаг хатаж хуурайших, мал бэлчээрлүүлэх зэрэг шалтгаанаас устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар, Монгол улсын улаан ном /1997/ болон Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэсэн [4,5]. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судлан тогтоох, байгаль дээр нөхөн төлжих нөхцлийг бүрдүүлэх, тохиромжтой газарт зориудаар үржүүлэх, хамгаалалтыг онцгойлон анхаарч, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1955, 2. Грубов, 1982, 3. Лигаа У нар, 2009, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс..., 2012, 6. Пешкова, 1979, 7. Санчир, 1980.

37. БЯЦХАН СААХУУ ЦЭЦЭГ



*Nuphar pumila* [Timm] DC.

*Magnoliophytina*

**Овог.** *Бөлбөөтөн* – *Nymphaeaceae* Salisb.

**Статус:** Нэн ховор, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Үндэслэг иш нарийхан, 1 см орчим голчтой, олон наст өвслөг, усны ургамал. Хөвөгч навч дугуй-зууван хэлбэртэй, зүрхэн суурьтай, доод гадаргуу нь үсэрхэг, 5-15 см урт, 3,5-11 өргөн. Цэцэг шар, улбар шар дэлбэтэй, ногоон цоморлигтой [1,3,5].

**Тархац, ургах орчин:** Баруун, Зүүн Сибирь, Алс Дорнод, Скандинав, Хятад, Японд тархана. Монголд: Хөвсгөлийн Дархадын хотгор Цэцэг нуур, Хангай [Идэрийн гол], Их нуурын хотгор [Хар нуур, Хар ус нуур]-ийн тойрогт ургана. Нуур, цөөрөм, усны хаялга, гол, горхийн салаагаар усанд ургадаг [1,2].

**Үржил:** Үр, үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, уур амьсгалын хуурайшилтын нөлөөгөөр усны түвшин доошлох, усны хаялга, горхийн салаа хатах, нуур, цөөрмийн хүрээ хумигдан, ус бохирдож хомсдохоос шалтгаалан устах аюулд орсон үлдвэр ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулиар нэн ховор ургамлын жагсаалтад, Монгол улсын улаан ном /1987, 1997/-нд тус тус оруулж, тархац нутгийг хэсгийг улсын тусгай хамгаалалтай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, экологийн ижил төстэй нуур, цөөрөм, усны хаялга, гол, горхийн салаалсан хэсэгт зориудаар тарьж, үржүүлэх аргыг боловсруулж турших, хамгаалалтыг сайжруулж, удмын санг хадгалах ажлыг цаг алдалгүй зохион байгуулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Лигаа нар, 2008, 3. Монгол улсын улаан ном, 1997, 4. Мон. ур. улаан данс..., 2012, 5. Санчир, Цогт, 1968.

### 38. ЦАГААН ЦЭЭНЭ



*Paeonia albiflora* Pall. [*Paeonia lactiflora* Pall.]

Magnoliophytina

**Овог.** Цээнэтэн – *Paeoniaceae*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Зузаан үндэслэг иштэй, 40-80 см өндөр, олон наст өвс. Иш бүдэг, ногоон, заримдаа улаавтар. Навч 7-12 см урт, цувраа байрлалтай, хошоод гурвалсан, 6-10 см урт бариултай. Навчинцар зууван-юлдэрхүү хэлбэртэй, нарийн мөгөөрслөг шүдлэг бүхий ширүүн захтай. Цэцэг ганцаар эсвэл хэд хэдээр байрласан, цагаан, том, 3-5 см голчтой. Дэлбийн хэлтэс тонгоруу өндгөрхүү, юмуу өндгөрхүү-дугуй хэлбэртэй, хурц, тахир үзүүртэй. Үр боловсорсны дараа хэтэвч ханзарч үрээ гүвдэг. Гурван хэтэвчит цана маягийн жимстэй [1,6].

**Тархац, ургах орчин:** Дорнод Сибирь, Алс Дорнод, Хятад, Японд тархана. Монголд: Хянган, Дорнод Монголын тойргийн Халхын гол, Онон Улзын сав газраар, Монгол Дагуурын тойрогт,

нугатай энгэр, хээрийн болон алаг өвст нуга, толгодын энгэрийн болон голын хөндийн хийгээд уулын өвөр хормой, сийрэг сөөгөнд дунд ургадаг [2,3,6].

Үржил: Үр, үндэс, үндэслэг ишээр үржинэ.

Нөөц, хомсдох шалтгаан: Нөөц бага, нарийвчлан судлаагүй. Ган, хуурайшилтаас хөрсний чийг буурч хатах, ургах орчин элсний нүүдэлд дарагдах, бэлчээрийн талхагдалтад орох, эм, гоёл чимэглэлийн зориулалтаар ногоо, цэцэг, үндэс, үндэслэг ишийг хавтгайруулан түүж бэлтгэх зэрэг шалтгаанаас тархац нутаг хумигдан, нөөц хомсдож байгаа устах аюулд орсон ургамал.

Хамгаалахаар авсан арга хэмжээ: Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр оруулж, Монгол улсын улаан ном /1997/, Монголын ургамлын улаанд дансанд [7] тус тус бүртгэсэн. Тархац нутгийн ихэнх хэсгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан. ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн Ботаникийн цэцэрлэгийн үржүүлгийн талбайд Хэнтий, Дорнод аймгаас авсан ургамлыг шилжүүлэн суулгаж, үрээр тарималжих бүрэн боломжтойг тогтоосон. Хэнтийн аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрлах туршилтын талбайд, ургуулж үр авч байна.

Хамгаалах арга хэмжээ: Тархац, нөөц, үржлийн биологийг нарийвчлан судалж, байгаль дээр нөхөн сэргээх, эм, гоёл чимэглэлийн зориулалтаар тарьж ургуулах ажлыг өргөжүүлэх, хууль бус ашиглалтыг таслан зогсоож, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Жамъяндорж, Лигаа нар, 2011, 4. Лигаа, 1996, 5. Лигаа нар, 2008, 6. Монгол улсын улаан ном, 1997, 7. Мон. ур. улаан данс., 2012.

### 39. НАНГИАД ЖАМЪЯНМЯДАГ



*Trollius chinensis* Bunge

*Magnoliophytina*

**Овог.** Холтсонцэцэгтэн - *Ranunculaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Ихэвчлэн салаалж мөчирлөсөн эгц босоо иштэй, 40-80 см өндөр, олон наст өвслөг ургамал. Үндэс орчмын навч урт бариултай, 3-5 салбан бүхий сарвуулаг цуулбар хэлбэртэй. Ишний навч дээшлэх дутмаа жижгэрдэг. Суумал байрлалтай. Цэцэг том 3-5 см голчтой, ухаа шар өнгөтэй. Цоморлигийн навчинцар өргөн зууван хэлбэртэй 5 юмуу хааяа 7-10. Дэлбэн балавч 3 см хүртэл урт. Үр жимс хэтэвч хэлбэртэй, олноороо толгой хэлбэрийг үүсгэн байрладаг [1,2].

**Тархац, ургах орчин:** Алс Дорнод, Япон, Хятадын нутгаар тархана. Монголд: Хянганы нуга, сөөг, ойн чөлөөгөөр ургана.

**Үржил:** Үр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Цэцгийг гоёл чимэглэлийн зориулалтаар түүдэг. Хуурайшилт, ой хээрийн түймрийн улмаас цэцэглэлт, үрлэлт удаарширч байгаагаас устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийн биологийг нарийвчлан судалж, тарьж ургуулах арга боловсруулж турших, гоёл чимэглэлийн зориулалтаар тарих, хамгаалалтыг сайжруулах, ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Флора СССР, 1937, Т.7, 2. Fl. China, 2001. Т.8.

40. ГАНБОЛДЫН УДВАЛ



*Aquilegia ganboldii* R.Kam. et Gubanov

*Magnoliophytina*

**Овог.** Холтсонцэцэгтэн - *Ranunculaceae* Juss.

**Статус:** Нэн ховор, унаган ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “мэдээлэл дутмаг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Богиноссон үндэслэг иштэй, олон наст өвслөг ургамал. Иш эгц босоо, 60 см орчим өндөр, бага зэрэг салаалсан. Навч энгийн юмуу хошоод гурвалсан. Үзүүрийн навчинцар нарийн өндгөрхүү хэлбэртэй. Цэцэг шар өнгөтэй, богинохон годойтой. Цэцгүүд хэд хэдээрээ иш мөчрийн үзүүрт байрладаг [3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хянганы тойрогт, ойн нугад ургадаг. Тархац нэн хязгаарлагдмал [1,2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, нарийвчлан судлаагүй. Ой хээрийн түймэр, хуурайшилт зэрэг хүчин зүйлээс устах аюулд орсон унаган ургамал.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр бүртгэж, тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулж хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж тогтоох, үрээр үржүүлэх арга

боловсруулж, тарьж ургуулах, тохиромжтой газар нутагт шилжүүлэн үржүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2008, 4. Мон. ур. улаан данс..., 2012.

#### 41. КОМАРОВЫН ХОРС



*Aconitum komarovii* Steinb. [*Aconitum coreanum* [Levl.] Rapaics]

*Magnoliophytina*

**Овог.** Холтсонцэцэгтэн - *Ranunculaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Тонгоруу-өндгөрхүү, ээрүүлэрхүү, төмслөг хоёр булцуулаг үндэстэй. Буржгар тармаг үстэй, 60-120 см өндөр, цэх, шулуун иштэй, олон наст өвслөг ургамал. Сарвуулсан цуулбар навчтай түүний салбан шугаман хэлбэртэй. Зөв буюу тэгш хэмт шар өнгийн цэцэгтэй. Цөөвгөр, 2-7 цэцэг ишний оройд цацаг баг цэцэг бүрдүүлдэг. Цомирлог 5 навчинцараас тогтох бөгөөд түүний дээд талын нэг хэлтэс дуулга хэлбэртэй болсон. Дохиурууд сийрэг үстэй [2].

**Тархац, ургах орчин:** Алс Дорнод, Зүүн Хойт Хятад, Японд тархана. Монголд: Хянганы тойрогт, сөөгөн ширэнгэ, нугатай энгэрт ургадаг [1].

**Үржил:** Үндсээр болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Ургах орчин хуурайших, ой хээрийн түймэрт



шатах зэргээс нөөц улам бүр хомсдон, тархац нутаг хумигдаж, устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, тохиромжтой газарт нутагшуулах, үр болон үндсээр үржих аргыг боловсруулж, турших, байгалийн нөхөн ургалтыг дэмжих, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Лигаа нар, 2009, 2. Флора СССР, 1937, Т.7.

## 42. КУЗНЕЦОВЫН ХОРС



*Aconitum kusnezoffii* Reichenb

*Magnoliophytina*

*Овог. Холтсонцэцэгтэн - Ranunculaceae Juss.*

**Статус:** Нэн ховор, унаган ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** 80-150 см өндөр, гялгар бөөрөнхий иштэй, олон наст өвслөг ургамал. Булцуулаг үндэс 2-4 см урт, 5-12 мм бүдүүн. Навч арьсархуу, хоёр тал нь нүцгэн, сууриа хүртэл цуурч, салбан үүсгэх бөгөөд харин ишний үзүүр хэсгийн навч өдлөн хэрчигдэж, гонзгойвтор-юлдэн салбантай болсон. Гадна тал бараг нүцгэн нил-ягаан цэцгүүд олноор нийлж, нягт цацаг юмуу нягт залаа үүсгэдэг. Оройн залаа маш шигүү байрласан олон цэцэгтэй. Цэцгийн шилбэ цэцгээс богино бус, баг цэцгийн тэнхлэгт бараг налж байрлана. Балавч цүндгэр, үзүүртээ нарийн матигар нарийн годойтой [3].

**Тархац, ургах орчин:** БНХАУ, ОХУ-д тархана. Монголд: Хянган, Дорнод Монголын тойрогт. Элдэв өвс-үетэнт нугаар ургадаг [1].

**Үржил:** Үрээр үржиж, булцуут үндсээр нөхөн сэргэнэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Булцуут үндсийг их хэмжээгэр түүж, бэлтгэх, ой хээрийн түймэрт шатах, бэлчээрийн талхагдалт зэргээс шалтгаалан устах аюулд ороод байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэгдсэн [2]. Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулсан. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрлах туршилт үйлдвэрлэлийн талбайд тарьж ургуулж байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Дээрх тарьсан туршлагыг тохиромжтой газарт нэвтрүүлж, зориудаар тарьж ургуулах ажлын цар хүрээг өргөжүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Лигаа нар, 2008, 2. Мон. ур. улаан данс., 2012, 3. Флора СССР, 1941, Т.7.

### 43. МОХООДУУ ЯРГУЙЖИН



*Anemone obtusiloba D. Don.*

*Magnoliophytina*

*Овог. Холтсонцэцэгтэн - Ranunculaceae Juss.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Голлосон үндэстэй, олон наст өвс. Иш 12-35 см өндөр. Үндэс орчмын дэвсээ навчис олон, үсэрхэг. Ишний навчис 5-10 см урт, гурвалсан, 3-4-өөрөө цэцэглэх ишийг тойрч байрласан. Цэцэг жижгэвтэр, баг цэцэг үүсгэн байрладаг. Цэцэг цагаан, заримдаа нил хөх өнгөтэй. Дохиур цайвар шар. Үр жижиг, бөөрөнхий [3].

**Тархац, ургах орчин:** Европ, Сибирьт тархана. Монголд: Хангайн шинэсэн ой түүний захаар ургана. Тархац нэн хязгаарлагдмал [1,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, нарийвчлан судлаагүй. Ой хээрийн түймэрт өртөгдөх, бэлчээрийн сэлгээгүй ашиглалт, хадлан бэлтгэх, хуурайшилтаас байгалийн жамаар нөхөн сэргэлт буурч, устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, тарьж ургуулах аргыг боловсруулж, турших, удмын санг хадгалах, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Флора СССР, 1941, Т.7.

#### 44. ЦУУЛБАРНАВЧИСТ ЗОГДОР-ӨВС



*Clematis aethusifolia Turcz.*

*Magnoliophytina*

*Овог. Холтсонцэцэгтэн - Ranunculaceae Juss.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Олон наст ороонго ургамал. Навчис хошоод болон гурвантаа өдлөг цуулбар, жижиг шовх, дөрвөлжиндүү юмуу шугаман. Цэцэг нарийн хонхорхуу, жижиг, 10-15 мм хүртэл голчтой, цагаан өнгөтэй, ганц нэгээрээ бөхөгөр байрлалтай. Цоморлиг 4 навчинцартай. Дохиурын шилбэ нарийн. Үр жимс үсэрхэг, бөөрөнхийдүү хэлбэртэй [1].

**Тархац, ургах орчин:** Сибирь, Зүүн хойд Хятад, Алс Дорнодод тархана. Монголд: Дорнод Монголын тойрогт Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг болох Молцог элсэнд тохиолдоно. Хээрийн сөөгөн шугуй, хад асга нурагт ургана [2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Зөвхөн хилийн дагуу зурвас нутгаар бага хэмжээгээр ургадаг устаж болзошгүй зүйл.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар

тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, үрээр үржүүлэх ажлыг цаг алдалгүй хийж, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996.

#### 45. МОНГОЛ АЛТАНХУНДАГА



*Adonis mongolica* Simonovicz

*Magnoliophytina*

*Овог. Холтсон цэцэгтэн - Ranunculaceae Juss.*

**Статус:** Нэн ховор, унаган, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Богиноссон үндэслэг иштэй, сахлаг үндэстэй. Иш эгц босоо юмуу өндиймөл, олноор байрлана. Нүцгэн юмуу сийрэг үслэгтэй, 10-20 см өндөр, олон наст өвслөг ургамал. Навч өргөн өндгөрхүү эсвэл ромборхуу, хааяа өргөн зуувгар хэлбэртэй, хошоод юмуу гурвантаа өдлөг, цуулбар, шугамархуу хэлбэрийн хурц салбанцаруудтай. Цэцэг олон, том, цагаан дэлбэтэй. Ягаавтар цоморлигтой [2,5,6,7].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Дундад Халхын тойргуудад тохиолдоно. Уулын хормой, бэлийн элдэв өвст хээр, жалгын ам, голын хөндийгөөр ургана [1,2,3].

**Үржил:** Үр, үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Ой хээрийн түймэр, хуурайшилт, хөнөөлт шавж, малын бэлчээрийн нөлөөллөөс үрээр үржих, үндэсний салмайгаар нөхөн сэргэлт эрс удааширч, ургах талбай багасгах хандлагатай. Эмийн зориулалтаар их хэмжээгээр хууль бусаар түүж, бэлтгэснээс устах аюулд орсон унаган, үлдвэр ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр бүртгэн оруулж, ашиглалтыг хориглосон. Монгол улсын улаан ном /1987, 1997/, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан. ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн харъяа Ботаникийн цэцэрлэгт үр, суулгацаар ургуулах туршилт хийж үрийн соёололт 0.13-4.42% байсныг 33.0-40.0% болгон нэмэгдүүлж, үндэсний салмайн хуваагдлаар олшруулан ургуулах аргыг нэвтрүүлсэн. Налайх орчмоос шилжүүлэн суулгасан ургамал Ботаникийн цэцэрлэгийн өвслөг ургамлын цуглуулгын талбайд ургаж байна. Ургамлын эд, эсийн өсгөврийн аргаар ургуулах туршилтыг амжилттай хийсэн боловч ажил зогсонги байдалд орсон.

**Хамгаалах арга хэмжээ:** Үндсэн тархац нутгийг холбогдох хуулийн дагуу нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, хаших, зориудаар тарьж ургуулах замаар байгалийн нөхөн ургалтыг дэмжих, хууль бус ашиглалтыг таслан зогсоох, цэцэрлэгт хүрээлэн болон тохиромжтой газарт үржүүлэх ажлыг өргөжүүлэн зохион байгуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов 1996, 4. Магсар, 1995, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012, 7. Цагаанмаам, 1983.

#### 46. ХАНГАЙН НАМУУ



*Papaver changaicum* R.Kam.

Magnoliophytina

Овог. Намуутан - Papaveraceae Juss.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Цэцэглэх иш /цэцгийн сум/ 20-40 см өндөр, бат бэх, налуу үстэй. Навч бариултай, түүний илтэс энгийн цуулбар, мөн налуу үслэг, сааралдуу салбангууд ихэвчлэн бүтэн захтай, нарийн, юлдэрхүү шугаман хэлбэртэй. Доод хэсгийн навчисын илтэс шүдлэг. Бундуу шигүү торгомсог үслэгийн улмаас цагаан өнгөтэй болсон. Дэлбэ шаргал улаан, хааяа

цагаан [3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хангайн тойрогт ургадаг. Уулын чулуурхаг энгэр, хад чулууны ёроол, хээржүү хажуу, ойн захаар ургадаг [1,2].

**Үржил:** Үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Ой хээрийн түймэр, бэлчээрийн талхагдалт, хөрсний чийгийн хомсдол зэргээс шалтгаалан устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэгдэж, ашиглалтыг хязгаарласан.

**Хамгаалах арга хэмжээ:** Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, мал сүргийг тухайн ургамлын үндсэн тархац нутагт сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг зогсоож, нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, тархац, нөөцийг тогтоож, үрээр үржүүлэх аргыг нэвтрүүлж, зориудаар тарьж ургуулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008.

#### 47. ЖИНХЭНЭ ТОМ-ҮРТ



*Megacarpaea megalocarpa* [Fish. ex DC.] B.Fedtsch.

*Magnoliophytina*

*Овог. Тонолжин цэцэгтэн – Brassicaceae Burnett*

Статус: Ховор ургамал.

Таних шинж: Үндэс бүдүүн, ээрүүлэрхүү хэлбэртэй. Үндэсний хүзүү өнгөрсөн оны навчны бариулын үлдэгдлээр шигүү бүрхэгдсэн. Иш ганц нэгээрээ, 20-35 см өндөр, үзүүр хэсгээрээ мөчирлөг, цэцэглэх найлзуур навчгүй. Навчны ерөнхий хэлбэр гонзгойдуу бөгөөд өдлөг-цуулбар, хажуугийн салбан 4-6, үндэс орчмынх бариултай, ишнийх суумал, үсэрхэг. Сийрэг цацаг баг цэцэгтэй. Дэлбийн хэлтэс цайвар ягаан. Жимс хавтгай, том, өргөн далбанлаг дүгэрэг, хоёр ижил хавтастай, задардаггүй [2].

Тархац, ургах орчин: Хятад, Өвөр Монголын нутагт тархана. Монголд: Зүүнгарын говь [Алаг толгой уул], уулын хажуу хайрга чулуутай шавартай цөлийн бэл, толгодын энгэрт ургадаг тархац хумигдмал [1].

Үржил: Үндэслэг ишээр үржинэ.

Нөөц, хомсдох шалтгаан: Нөөцийг тогтоогоогүй. Олон жилийн гангийн давтагдлаас хөрсний ус доошилж, чийгийн хангамж буурснаас шавартай цөл хатах зэрэг шалтгаанаас устах аюулд орж болзошгүй ургамал.

Хамгаалахаар авсан арга хэмжээ: Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

Хамгаалах арга хэмжээ: Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, үр, үндэслэг ишээр үржүүлэх аргыг боловсруулж турших, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Губанов, 1996, 2. Флора СССР, 1937, Т.7.

## 48. ЦАГААНЦЭЦЭГТ ЗУУЧ



*Cardamine leucantha* [Tausch] O.E.Schulz.

*Magnoliophytina*

**Овог.** Тонолжин цэцэгтэн – *Brassicaceae* Burnett

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Үндэслэг иштэй, 35-60 см өндөр, өтгөн юмуу сийрэг үслэгтэй, олон наст өвслөг ургамал. Иш энгийн, тахиралдсан. Навчис өдлөг нийлмэл, үсэрхэг, 2 юмуу 3 хос навчинцартай. Навчинцар жигд бус юмуу хөрөөн давхар шүдлэг захтай, сууриадаа шаантгархуу, шовх оройтой. Цацаг баг цэцэг 12-24 цэцэгтэй. Цоморлиг гонзгой, хальсархаг захтай. Дэлбэ цагаан, халбагархуугаас гонзгой юлдэрхүү, шилбэгүй сууриадаа шаантгархуу,

дугариг оройтой. Гэрцэг шугаман. 6-7 дугаар сард цэцэглэж, 7-8 дугаар сард үрлэнэ [1,3].

**Тархац, ургах орчин:** Хятад, Япон, Өмнөд Солонгос, ОХУ-д тархана. Монголд: Хянганы тойрогт тэмдэглэгдсэн. Хус, хайласан төгөл, ой, гол, горхийн эргээр ургадаг, нэн хязгаарлагдмал тархацтай [2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийн хэмжээг тогтоогоогүй. Ой хээрийн түймэрт шатаж, устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийн нарийвчилсан судалгаа хийх, тухайн зүйлийн биологи, экологийг судалж, тарималжуулах, нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Fl. China 8: 2001.

## 49. БҮНГИЙН САЛААГАНА



*Chorispora bungeana* Fisch. et Mey.

*Magnoliophytina*

**Овог.** Тонолжин цэцэгтэн – *Brassicaceae* Burnett

**Статус:** Ховор ургамал.



**Таних шинж:** Олон толгойт үндэстэй, дэгнүүл үүсгэдэг 2-8 см өндөр, олон наст өвслөг ургамал. Булчирхайт болон энгийн үслэгтэй. Навчис дэвсээ, илтэс юлдэрхүү юмуу гонзгой, навчны зах гонзгой юмуу өндгөрхүү салбанд хуваагдсан, мохоо оройтой. Ишэндээ навчгүй. Ишний үзүүрт ганц нэг цэцэгтэй. Цоморлиг улаавтар ягаан, шугаман-гонзгойдуу. Дэлбийн хэлтэс шунхан улаан, өргөн тонгоруу өндгөрхүү, шилбэ 1.2 см хүртэл урт. Гэрцэг шугаман бортгорхуу, 8-12 тасархайтсан үетэй. 6-7 дугаар сард цэцэглэж, 7-8 дугаар сард үрлэнэ [1,3].

**Тархац, ургах орчин:** Афганистан, Кашмир, Казахстан, Киргизстан, ОХУ, Пакистан, Тажикстан, Хятад, Узбекистан, Энэтхэгт тархана. Монголд: Монгол Алтайн /баруун-хойт: Кызыл-Гайны даваа/ тойрогт тэмдэглэгдсэн. Өндөр уулын бүслүүр дэх чулуулгийн хурдас, чулуурхаг асгараг, нураг, хад асганд ургана [3].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийн хэмжээ тодорхойгүй. Хуурайшилтаас байгалийн нөхөн ургах чадавх буурч, ширүүн бороо, мөндрийн улмаас гэмтэх, үржил, саарах зэрэг байгалийн хүчин зүйлээс хамаарч устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолын хавсралтад ховор зүйлээр бүртгэж, тархац нутгийг Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газарт хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөцийн хэмжээг тогтоох, биологийн нөхөн сэргэлтийн судалгаа хийж, тарималжуулах, нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Fl. China 8: 2001.

50. ГРУБОВЫН СУВДЛИГЦЭЦЭГ



***Torularia grubovii* Botsch. [*Netorularia grubovii* [Botsch.] Botsch.**

***Magnoliophytina***

**Овог. Тоонолжин цэцэгтэн - *Brassicaceae* Burnett**

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Олон наст өвслөг ургамал, дэгнүүл үүсгэдэггүй, сийрэг үсжилттэй. Үндэс орчмын навчис олон, шигүү дэвсгэр навч үүсгэдэг. Ишний навчис бүтэн. Гэрцэг шулуун, дээшээ ташуу, урт нарийнхан шилбэтэй [3,4].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хөвсгөл [баруун: Хотон гол], голын элсэрхэг, хайргархаг харгианд ургадаг, нэн хязгаарлагдмал тархацтай [1,2].

**Үржил:** Зөвхөн үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Хуурайшилт, ой хээрийн түймрээс шалтгаалан устаж болзошгүй унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, зориудаар тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Бот. журн. 60, 4. Флора СССР, 1941, Т.8.

## 51. ТӨГРӨГНАВЧИГ ҮСТХИГ



*Drosera rotundifolia* L.

*Magnoliophytina*

**Овог.** *Үстхигтэн - Droseraceae Salisb.*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Цэцэглэх сум иш 7-15 см өндөр, нижгээдээр юмуу нэг дор хэд, хэдээр байрлан ургадаг. Навч 0.4-1 см өргөн, дугуй юмуу дугуйдуу-зууван, огцом нарийсч 1-7 см урт бариул болдог урт олон эст таруу үстэй. Цагаан цөөн цэцгүүд нийлж сийрэг цацаг үүсгэдэг. Дэлбэ цомирлогоосоо ялимгүй урт. Хонхорцог уртавтар зууван, нүцгэн. Үр ээрүүл хэлбэртэй, цайвар хүрэн [2, 5].

**Тархац, ургах орчин:** Баруун Европ, Кавказ, Баруун, Зүүн, Дорнод Сибирь, Алс Дорнод, Япон, Умард Америкт тархана. Монголд: Умард Хэнтийд ховор тохиолдоно. Хүлэрлэг, хөвдөт намагт ургана [1,3,4].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Тархац нутаг ойн түймэрт өртөгдөх, мод бэлтгэх зэрэг шалтгаанаар ургах орчин хуурайших, гол, горхи ширгэх, намаг хатах, эмийн зориулалтаар их хэмжээгээр түүж бэлтгэн ашиглах зэргээс шалтгаалан устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд [5,6] тус тус бүртгэж, ашиглалтыг хязгаарласан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг тогтоож, зориудаар үржүүлэх аргыг боловсруулж турших, эмийн зориулалтаар ашиглахад тавих хяналтыг нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, нутагшуулах, зориудаар тарьж ургуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008, 5. Монгол улсын улаан ном, 1997. 6. Мон. ур. улаан данс..., 2012.

## 52. АНГЛИ ҮСТХИГ



*Drosera anglica* Huds.

*Magnoliophytina*

**Овог.** *Үстхигтэн - Droseraceae Salisb.*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Цэцэгт иш 10-25 см өндөр, хэд хэдээр нэг дор байрладаг. Навчис шугамархуу юмуу шугамархуу-гонзгойвгор, орой нь дугуй, угруугаа аажмаар нарийссан, бариул нь нүцгэн. Цэцэг цагаан өнгөтэй, цөөн цэцгүүд нийлж, сийрэг цацаг үүсгэдэг. Дэлбэ хоолойрхуу хонх хэлбэрийн цомирлогтойгоо бараг тэнцүү юмуу түүнээс арай урт. Үр гонзгойвгор, ээрүүл хэлбэртэй, бараан өнгөтэй [2,4,5].

**Тархац, ургах орчин:** Баруун Европ., Кавказ, Баруун, Зүүн, Дорнод Сибирь, Алс Дорнод, Алжир, Умард Америкт тархана. Монголд: Хэнтийн Хүдэр голын хөндийн намгархаг газарт хүлэрлэг, хөвдөт намагт ургана [1,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Үндсэн тархац нутаг ой түймэрт нэрвэгдэх, намаг хуурайших, хатах, эмийн зориулалтаар их хэмжээгээр түүж бэлтгэх зэрэг байгалийн болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөнөөс шалтгаалан устах аюулд ороод байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд [6] тус тус бүртгэсэн хамгаалсан. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, үржлийн болон нөхөн сэргэлтийн биологи, экологийг судалж, зориудаар тарьж ургуулах, нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд үндсэн тархац нутгийг хариуцуулан хамгаалуулах ажлыг яаралтай зохион байгуулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012.

### 53. ЦАГААН МҮГЭЗ



*Rhodiola algida* [Ledeb.] Fisch. et Mey.  
*Magnoliophytina*

## ***Овог. Зузаалайтан - Crassulaceae DC.***

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Бүдүүн, урт, олон толгой бүхий голлосон үндэстэй. Үндэслэг иш махлаг, хүрэн хайрстай. 10-30 см өндөр олон иштэй, олон наст өвслөг ургамал. Навчис хавтгай, бүтэн захтай шугаман, гонзгой. Навчис цувраа байрлалтай суумал. Баг цэцэг голчоороо 2-6 см. Цэцэг таван гишүүнтэй, цагаан юмуу ягаавгар. Боловсорсон хэтэвч баргар улаан, юлдэн хэлбэртэй [1,4].

**Тархац, ургах орчин:** Дундад Ази, Казакстан, Үзбекстан, Баруун Сибирьт тархана. Монголд: Ховд, Монгол Алтайн өндөр уулын бүслүүрт хад, асга, чулуурхаг хажуу, асгарга, мөстлөгийн үлдэгдэл мөлгөр чулуун дунд ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай [2,3].

**Үржил:** Үрээр маш удаан үрждэг, үндэслэг ишээр нөхөн сэргэх нь хязгаарлагдмал.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Олон жил дараалан болж буй хуурайшилт, бэлчээрийн талхагдалт, ширүүн мөндөрт цохигдож цэцэг юмуу дутуу боловсорсон үр унаж, сарних зэрэг шалтгаанаар устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж, байгаль дээрх нөхөн сэргэх үржлийг тогтоож, зориудаар үржүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2008, 3. Флора СССР, 1939, Т.5.

54. НҮЦГЭН ТОВЬЦЭЦЭГ



*Mitella nuda* L.

*Magnoliophytina*

**Овог.** Сэрдэгтэн - *Saxifragaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** 8-20 см өндөр, нарийн, шулуун, булчирхайт үсэнцэр бүхий иштэй, олон наст өвс. 1.5-3.5 см голчтой, дугуйвгар зүрхэн хэлбэрийн навч ишнийхээ угт урт нарийн бариулаар бэхлэгдэнэ. Цэцгийн дагавар навчгүй, улаан хүрэн өнгийн цэцэгтэй. Утас шиг нарийн өдлөг дэлбэтэй, цоморлиг 5 мм голчтой. Нэг үүртэй, олон үрт хонхорцогтой [2,4,5].

**Тархац, ургах орчин:** Баруун, Дорнод Сибирь, Алс Дорнод, Умард Америкт тархана. Монголд: Хэнтийн уулын тайгын тойрог [Хүдэр голын хөндий], Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт ойн чийглэг нугаар ховор тохиолдоно. Тархац нэн хязгаарлагдмал [1,3].

**Үржил:** Үр, үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Ой хээрийн түймэрт нэрвэгдэх, хуурайшилтаас шалтгаалж гол, нуур, цөөрмийн ус татрах, голын намаг хуурайших зэргээс устах аюулд орсон.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар бүртгэж, байгалийн нөхцөлд түүж ашиглахыг хориглосон. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг шинэчлэн тогтоох, хамгаалалтыг сайжруулах, үрээр тарьж, үндэслэг ишээр суулган ургуулж, нутагшуулах, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигая нар, 2008, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012.

## 55. ЭЛДЭВ-ҮСТ УЛААГАНА



*Ribes heterotrichum* C. A. Mey.

*Magnoliophytina*

**Овог.** Сэрдэгтэн - *Saxifragaceae* Juss. [*Grossulariaceae* D.C.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 50–100 см өндөр, өргөсгүй, сөөглөг хоёр гэрт ургамал. Навч 3 салбантай, харьцангуй жижиг, 3 см хүртэл өргөн, бага зэрэг үслэгтэй бөгөөд доод гадаргуу болон бариулдаа шар өнгийн цэгэн суумал булчирхайтай. Нахианы хайрс хальслаг. Үр боловсрох оронт цэцгийн дохиурууд дутмаг хөгжилтэй байдаг бөгөөд цацаг хэлбэрийн баг цэцэг үүсгэдэг. Цомирлог үсэрхэг, боровгор өнгийн цэцэгтэй, цэцгийн дагавар том бөгөөд үрлэх үедээ унадаг. Ухаа шар өнгийн шүүслэг жимстэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид ховор тархана. Монголд: Зүүнгарын говийн тойргийн Байтаг Богдын нуруу, Их Хавгага уулын хад, чулуун дунд ургадаг [2,4].

**Үржил:** Үр болон ургал эрхтэнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Хуурайшилт, гангийн давгагдал, бэлчээрийн талхагдлаас шалтгаалан устаж болзошгүй ургамал.



**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж, тарималжуулах, нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Иллюстрированный определитель растений Казакстана, 1969, 4. Лигаа, 1981.

## 56. ЦАГААН БОРОЛЗГОНО



*Dasiphora lactiflora* [L.] Rydb.

*Magnoliophytina*

**Овог.** Сарнайман - *Rosaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал.

**Таних шинж:** Хүчтэй салаалж мөчирлөсөн сөөг. Навчис гурвалсан юмуу, сарвуулаг нийлмэл, эсвэл навчинцартай. Цэцгийн суудал тавгархуу, цагаан өнгийн цэцэгтэй. Навчны хэмжээ болон цэцгийн дэлбэ сөөгөн боролзгоныхоос арай том [3,4].

**Тархац, ургах орчин:** Япон, Зүүн хойд Хятадад тархана. Монголд: Хянган. Зараа уулын дээд хэсэгт хад чулуутай хярд ургана [1,2].

**Үржил:** Ургал эрхтэн болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ой хээрийн түймэр, хуурайшилтаас устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулиар нэн ховор ургамлаар бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулж хамгаалсан. Байгаль дээрээс түүж ашиглахыг хориглон, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөц тархацыг нарийвчлан судлах, зориудаар үрээр үржүүлэх, тарималжуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа нар, 2008, 3. Монгол улсын улаан ном, 1997, 4. Флора СССР., 1934, Т.10.

## 57. ИКОННИКОВЫН ГИЧГЭНЭ



*Potentilla ikonnikovii* Juz.

*Magnoliophytina*

**Овог.** *Сарнайман - Rosaceae* Juss.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Бага зэрэг дэгнүүл үүсгэдэг, олон наст өвслөг ургамал. Бүдүүн голлосон үндэстэй. Иш эгц босоо, нарийхан, олон найлзууртай, 2-10 см өндөр, үндэс орчмын навчнаас бага зэрэг урт. Угаараа навчны хүрэн үлдэгдлээр хучигдсан бөгөөд хатсан навчны бариул гадагш тахийсан байдаг. Үндэс орчмын навч, ишний угийн навчис 2 хос хажуугийн навчинцартай, утсархуу бариултай. Ишний навч гурвалсан, нийлмэл навчинцар тонгоруу-

өндгөрхүү, тал тус бүртээ 1-2 том шүдлэгтэй, тод ногоон, тархай цэгэн булчирхайлаг, налархай үслэгтэй. Цэцэг урт утсан шилбэн дээр 1-2-оороо суусан [2,4,5].

**Тархац, ургах орчин:** Монголд: Говь-Алтай. Уулын дунд, дээд хэсэгт хадны ан цав, чулуун дунд ургадаг. Тархац маш хязгаарлагдмал [1,3].

**Үржил:** Үрээр болон ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Цөлжилт, хөрсний чийгийн хангамжийн дутагдал, бороо, усны үер, хүчтэй салхи зэрэг байгалийн хатуу ширүүн нөхцөлд ургадагтай холбоотойгоор ховордож, устаж болзошгүй унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэж, хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, өсөлт, хөгжлийн биологи, ургах тохиромжтой нөхцлийг нарийвчлан судалж, зориудаар тарьж ургуулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008, 5. Флора СССР., 1934, Т.10.

## 58. АЛАГЦЭЦЭГТ ГИЧГЭНЭ



*Potentilla chrysantha* Trev.

*Magnoliophytina*

**Овог.** Сарнайтан – *Rosaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Голлосон хүчирхэг үндэстэй, үзүүр хэсэгтээ ацлан салаалсан турь муутай, тахиралдсан өндиймөл 15-30 см өндөр иштэй, өвслөг ургамал. Иш, навчны бариул болон цэцэглэгч суман иш босоо үстэйн дээр аржгар үснээс бүрдсэн үслэгтэй. Навч сарвуулаг хэлбэртэй. Үндэс орчмын навч тавчилсан, урт бариултай, ишний дунд ба дээд хэсгийн навчис гурвалсан. Цэцэг олон, урт нарийн шилбэ бүхий том цэцэгтэй. Дэлбийн хэлтэс цомирлогийн илтэснээсээ 1.5-2 дахин урт. Үр өндгөн хэлбэртэй, гадаргуу үрчгэр, бага зэргийн хянгатай [2,3].

**Тархац, ургах орчин:** Дундад Европ, Венгри, Балк.- Малайз /Югослав/ тархана. Монголд: Монгол Алтай /Хар Азрага/. Шинэсэн ой, ойн захад ургана [1]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Ургал эрхтэн болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Ган, хуурайшилтын улмаас гол, горхи ширгэх, хээрших, ойд бүртгэгдсэн талбай хумигдах зэрэг шалтгаанаас устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, өсөлт, хөгжлийн биологи, ургах тохиромжтой нөхцлийг нарийвчлан судалж, үржүүлэх аргыг боловсруулж, нутагшуулах, тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа нар, 2008, 3. Флора СССР., 1934, Т.10.

59. ПАВЛОВЫН ХУМИЛЖ



*Alchemilla pavlovii* Juz.

*Magnoliophytina*

**Овог.** *Сарнайман* – *Rosaceae* Juss.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Навчис бага зэрэг долгионтсон, бөөрөрхүү юмуу дүгэрэг-бөөрөрхүү, 9 тал дугуй салбантай, хэлтгий шүдтэй, дээд талдаа бараг нүцгэн юмуу зөвхөн нугалаас, салбангийн захаар болон судал дагуу тархай үслэгтэй. Дагавар навчинцар голдуу улайдаг. Цоморлиг юүлүүрэрхүү, нүцгэн. Цэцгийн шилбэ нүцгэн [1,4].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хангай /Төв хэсэг/. Өндөр уулын бүслүүр болон ойн дээд захаар намгархаг нуга, ойн нуга, ойн захаар ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай [2,3].

**Үржил:** Үр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ой хээрийн түймэрт өртөгдөж, бэлчээрийн талхагдалт улмаас устах аюулд ороод байгаа унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, үр, үндэслэг ишээр тарьж, ургуулах туршилтийг хийж, тохиромжтой газрыг тогтоож, нутагшуулах, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулж, нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Бюл. Моск. общ. испыт. прир., отд. биол. 1929, 38; 1-2: 85, 2. Ганболд, 2010, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008.

## 60. ХАНГАЙН ХУМИЛЖ



*Alchemilla changaica* V.Tichomirov

*Magnoliophytina*

**Овог.** Сарнайтан – *Rosaceae* Juss.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Иш эгц босоо, 20 см орчим өндөр, мөлхөө үндэслэг иштэй, олон наст өвслөг ургамал. Иш уг хэсгээрээ сийрэг үслэгтэй. Үндэс орчмын навч урт бариултай, бөөрөрхүү хэлбэртэй, 7-9 салбантай, салбан хоорондоо хуниастай. Навч нүцгэн юмуу тачир үслэгтэй, доод талын гол судлаараа үслэгтэй. Ишний навч өргөн-өндгөрхүү юмуу өндгөрхүү хэлбэрийн салбантай. Шар ногоон өнгийн 3 мм орчим урт жижгэвтэр цэцэгтэй. Цөөвтөр цэцгүүд ишний үзүүрт нягтаар бөөгнөрөн байрлаж, баг цэцэг үүсгэдэг [3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хангайн тойрогт ховор тохиолдоно. Ойн бүслүүрт ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай [1,2].

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр маш удаан үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Олон жил дараалан үргэлжилж буй хуурайшилтаас ой түймрийн улмаас уулын жижиг гол, горхи татарч, ширгэх, нуга хуурайших зэрэг байгалийн хүчин зүйлийн сөрөг нөлөөгөөр өсөлт, хөгжилт, цэцэглэх, үрлэх явц саатаж, нөхөн сэргэлт

тасалддаг. Мөн ойн түймэрт өртөж нөхөн сэргэлтийн нахиа гэмтэх, ойг хавтгайруулан огтолсноос ургах орчин өөрчлөгдөж, нөхөн ургах боломжгүй болох зэрэг шалтгаанаар бүрмөсөн устах аюулд орсон унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор эл зүйлийг ховор ургамлын жагсаалтад оруулж, хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологи, ургах тохиромжтой нөхцлийг нарийвчлан судалж, зориудаар тарьж ургуулах, нутагшуулах, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2008.

## 61. АЛЬБЕРТИЙН САРНАЙ



*Rosa alberti* Regel

*Magnoliophytina*

**Овог.** *Сарнайман* – *Rosaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Зүүрхүү хэлбэрийн шулуун жижиг өргөс ихтэй, 1 м шахам өндөр, сөөг ургамал. Өдлөг нийлмэл навчтай. Нарийхан /5/ 7-9 /11/ тонгоруу-өндгөрхүү, зузаан навчинцраас тогтсон. Навчинцарын дээд гадаргуу нүцгэн, ирмэгээрээ хөрөөрхүү давхар шүдлэгтэй. Цэцэг цагаан, 3-4 см голчтой, ганц нэгээрээ байрладаг. Гонзгой жамартай, жимс болоход цоморлиг унана[2, 3].

**Тархац, ургах орчин:** Баруун Сибирь, Дундад Азид тархана. Монголд: Монгол Алтай /

Харгайтын гол, Булган голын зүүн салаа/. Шинэсэн ой, түүний захаар ургадаг, нэн хязгаарлагдмал тархацтай [1].

**Үржил:** Үр, ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Ой, хээрийн түймэр, мод огтлох, хуурайшилт, ургах орчны доройтол, мал бэлчээрлүүлэлт зэрэг шалтгаанаас тархац нутаг хумигдан, нөөц хомсдож байгаа устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологи, ургах хамгийн тохиромжтой нөхцлийг нарийвчлан судалж, зориудаар тарьж, ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авч хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа нар, 2008, 3. Флора, СССР, 1941, Т.10.



## 62. БЕГГЕРИЙН САРНАЙ



*Rosa beggeriana* Schrenk

*Magnoliophytina*

**Овог.** Сарнайман – *Rosaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 1-1.5 м өндөр босоо найлзууртай сөөг. Найлзуурын өнгө саарал, сууриараа өргөссөн, махир хадуурархуу хэлбэрийн шаргал өргөстэй. Эдгээр өргөс навчны угт хосоор байрладаг. Навч уртавтар гонзгойдуу, зуван хэлбэртэй. Навчинцар жижиг, шүдлэг захтай. Олон цэцгүүд бамбайрхуу юмуу залаархуу хэлбэрийн баг цэцэг бүрдүүлдэг. Үр жимс улаан өнгөтэй, жижиг бөмбөлөг хэлбэртэй [2,3].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Зүүнгарын говь. Хадны ангал завсраар ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай [1].

**Үржил:** Ургал эрхтэн болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Олон жил дараалсан ган, хуурайшлын улмаас, хөрсний чийг хомсдох, өсөлт, хөгжилт, үржил саатах зэргээс тархацын хүрээ хумигдаж, тоо ширхэг цөөрч устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор уг зүйлийг ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг Говийн их дархан

цаазат газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг онцлогийг шинээр судалж, үрээр тохиромжтой газарт үржүүлэх, нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа нар, 2008, 3. Флора СССР, 1941, Т.10.

### 63. ХАВТГАЙХАТГУУРТ САРНАЙ



*Rosa platyacantha* Schrenk

*Magnoliophytina*

**Овог.** Сарнайман - *Rosaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Улаан холтос бүхий намхан юмуу дунд зэргийн өндөртэй сөөг. Өргөс, сундуу ихтэй үзүүр олигор, өргөн хавтгай сундуу бүхий 1-2 м өндөр найлзууртай. Навч өдлөг нийлмэл, 5-9 навчинцартай. Навчинцар зууван хэлбэртэй, жигд биш шүдлэг ирмэгтэй. Навчинцарын доод гадаргуу цайвардуу өнгөтэй, судлаа дагасан үслэгтэй. Цэцэг шар, бараан нил өнгийн бөндгөр, 1-2 см голчтой жамартай [2,3].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид /Тянь-Шан., Пам-Ал./ тархана. Монголд: Зүүнгарын говь [Их Хавгага уул]. Хавцлын ёроол, шанд орчим ургадаг, нэн хязгаарлагдмал тархацтай [1].

**Үржил:** Үр болон ургал эрхтэнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Олон жил үргэлжилсэн ган, хуурайшилтаас булаг


шанд ширгэх, ургах орчин доройтох, өсөлт, хөгжилт саарах зэрэг шалтгаанаас устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, үрээр үржүүлэх, тохиромжтой газарт нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа нар, 2008, 3. Флора СССР, 1941, Т.10.

## 64. КОКАНД САРНАЙ



*Rosa kokanica* [Regel] Juz.

*Magnoliophytina*

**Овог.** *Сарнайман* – *Rosaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Том бус дунд хэмжээний сөөг, урт шулуун мөчирүүд улаан хүрэн ягаан өнгийн холтостой. Ишиндээ олон тооны өргөстэй хааяа ганцаар байх ба өргөс шулуун, унамтгай, үзүүрлүүгээ нарийхан, сууриараа огцом өргөссөн, хүрэн ягаан өнгөтэй. Харин найлзуур дээрхи өргөс нэлээд жижиг. Навч 7-9 навчинцартай том бус, хоёр давхар хөрөөн шүдлэг захтай. Навчинцар зууван юмуу тонгоруу-өндгөрхүү, дугуй эсвэл сууриараа сэлмэрхүү. Цэцэг хэд хэдээрээ юмуу хааяа хосоор байрлана. Түүний шилбэ заримдаа шигүү үслэгтэй. Цэцэг 2-

4 см голчтой, цайвар шар өнгийн дэлбэтэй [2,4].

**Тархац, ургах орчин:** Кит-Япон, Дундад Азид тархана. Монголд: Монгол Алтай. Уулын хад чулуутай хажуугаар ургана [1,2].

**Үржил:** Үр, ургал эрхтнээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй, хуурайшилтаас тархац хязгаарлагдмал улам бүр хумигдаж сэргэн ургалт, саатах хад чулуу нурж дарах, хүчтэй үерийн нөлөөгөөр үндсээрээ булгарах, бэлчээр талхагдах зэрэг шалтгаанаар устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар бүртгэж, Монголын ургамлын улаан дансанд [3] тус тус оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, нөхөн сэргээх, тарималжуулах, нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа нар, 2008, 3. Мон. ур. улаан данс., 2012, 4. Флора СССР., 1941, Т.10.

## 65. МОНГОЛ БҮЙЛЭЭС



*Amygdalus mongolica* Maxim.

*Magnoliophytina*

**Овог.** *Сарнайман* – *Rosaceae* Juss.

**Статус:** Ховор, унаган зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Өргөстэй, дэрвэгэр олон салаа мөчиртэй, 25-80 см өндөр, сөөг. 0.5-1.5 см урт, тонгоруу өндөг юмуу дугариг эсвэл зуван хэлбэртэй, жижигхэн, мэдэгдэхүйц шүдлэг захтай, нүцгэн навчтай. Цэцэг суумал, цайвар ягаан. Цэцэглэлтийн дараа навч гарна [1].

**Тархац, ургах орчин:** Монголд: Борзон, Галбын говь, Алтайн нурууны Баянцагаан, Их Богд, Ноён Богд, Нэмэгт, Тостын уулс, түүний хормой бэл, уулын хөндийгөөр тохиолдоно. Уулын чулуурхаг хад, асгатай энгэр, дов толгод, хад цохио, сайрын чулуурхаг эрэг хөвөө, элсэрхэг хөрсөнд ургана [1,2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ургах орчны цөлжилт, хуурайшилтаас өсөлт хөгжилт саатах, их хэмжээгээр түлшинд хэрэглэх, сэлгээгүйгээр мал бэлчээх зэрэг шалтгаанаас сүүлийн жилүүдэд нөөц мэдэгдэхүйц хомсдож байгаа устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын улаан номонд оруулж, Ботаникийн цэцэрлэгт тарималжуулан нутагшуулах туршилтын ажлыг 1974 оноос хийж, нутагших боломжтойг тогтоосон.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөцийг тогтоох, бүйлсэн төгөл бүхий тархац нутгийг улсын хамгаалалтад авах, зориудаар тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах, ажлыг цаг алдалгүй зохион байгуулах, бүйлсэн төгөлийг нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, ховор ургамлын жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1955, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Юнатов, 1977.

66. ШАРГАЛДУУ ЛИДЭР



*Sophora flavescens* Soland.

*Magnoliophytina*

Овог. Буурцагтан - *Fabaceae* Lindl.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Цагаан шаргал, бүдүүн, бортгон үндэстэй. 50-100 см өндөр, олон наст өвслөг ургамал. Иш эгц босоо. Сондгой өдлөг навчтай. Навчинцар 5-9 хос, доод гадаргуу саарал үсэнцэртэй, дээд гадаргуу ногоон, бүтэн захтай, зууван эсвэл гонзгой-өндгөрхүү. Иш мөчрийн оройд цайвар шаргал өнгийн цацагархуу баг цэцэгтэй, Дэлбэ 5 хэлтэснээс тогтдог. Завь шонтонгүй. Үр жимс эрхирхүү хэлбэртэй, дөрвөн талтай, 5-7 см урт [1,9,13].

**Тархац, ургах орчин:** Алс Дорнод, Сибирь, Хятадын Манжуур, Япон, Солонгост тархана [1,9,12,13]. Монголд: Монгол Дагуурын дорнод хэсэг, Дорнод Монголын хойт хэсгээр тохиолдоно [1,10,11]. Харгана-алаг өвс үетэнт хээр бүхий энгэр, гол нуурын хөндий, улиангарын төгөлд ургана [2,10,11].

**Үржил:** Үр, үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Ган, хуурайшилт, бэлчээрийн талхагдалт болон эм гоёл чимэглэлийн зориулалтаар ногоо, цэцэг, үндэс, үндэслэг ишийг их хэмжээгээр хууль бусаар түүж ашигласнаас устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор

ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэж, тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан. ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн харьяа Ботаникийн цэцэрлэгийн туршилтийн талбайд Халх гол орчмоос авчирч ургуулж байгаа. Хэнтийн аймгийн Дэлгэрхаан сумын нутагт байрлах туршилтын талбайд тарьж ургуулж үр авч байгаа.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, тарьж ургуулах ажлыг үргэлжлүүлэн, цар хүрээг өргөжүүлж, хамгаалах ажилд бүх талын оролцоог хангах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Борисова, 1968, 2. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Лигаа, 1996, 4. Лигаа, 2008, 5. Лигаа, 1969, 6. Монгол улсын улаан ном, 1997, 7. Мон. ур. улаан данс., 2012, 8. Өвөр монголын өвсөн эм, 1974, 9. Үндэс, 1987, 10. Санчир, 1967, 11. Тумбаа, Лигаа, 1969, 12. Юмжав нар, 1974, 13. Яковлев, 1988.

## 67. ГРУБОВЫН ТАРВАГАНШИЙР



*Thermopsis grubovii* Czefr.

*Magnoliophytina*

**Овог.** Буурцагтан - *Fabaceae* Lindl.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Эгц босоо, салаалсан ишгэй, 50-70 см өндөр, олон наст өвслөг ургамал. Навч гурамсан, түүний илтэс гонзгойвгор зууван, хоёр дагавар навчтай, иш, навчис сийрэг, налуу үслэг. Цэцэг шар, ишний оройд тус бүр гурваар багцлан байрласан. Буурцаг эгц дээш байрлах бөгөөд хааяа хажуу тийш бага зэрэг хазайсан харагддаг, 40-50 мм урт, 7-8 мм өргөн. Үр бөөр

хэлбэртэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Зүүнгарын говийн тойрог, Борцонжид ховор тохиолдоно. Голын эрэг, өвслөг энгэр, хужирлаг нуга, дэрсний хооронд ургадаг [2].

**Үржил:** Үр, үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Олон жил дараалсан ган, хуурайшилтаас шалтгаалан цөлийн нуга, голын ус татарч ширгэх, цөлийн хээр хуурайшиж хатах зэрэг шалтгаанаар устах аюулд орсон унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг судлан тогтоож, зориудаар тарьж ургуулах аргыг боловсруулж нэвтрүүлэх, тохиромжтой нутагт нутагшуулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 2. Лигаа, 1987.

## 68. МОНГОЛ БУУРЦГАНА



*Chesneya mongolica* Maxim.

*Magnoliophytina*

**Овог.** Буурцагтан - *Fabaceae* Lindl.



**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Модожсон үндэслэг иштэй, олон наст өвслөг ургамал. Сэрэвгэр цагаан үсээр бүтэн хучигдсан, иш газраар дэвсэж ургадаг. Навчис сондгой өдлөг, 1-2 см урт, богинохон бариултай, навчис 3-4 хос, тонгоруу-өндгөрхүү хэлбэртэй. Цэцэг 10-12 мм урт, дэлбэ шарлангуй нилдүү ягаан. Буурцаг цүндгэр, хатуу, цагаан үстэй, 7, 8 дугаар сард цэцэглэдэг [3].

**Тархац, ургах орчин:** Төв Азид /Өвөр Монголд/ тархана. Монголд: Их нуурын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алашааны говьд тархсан. Хужирлаг элс, элсэрхэг, хайргархаг цөл, эргийн хайрга, сайр садрагын элс хайргатай ёроолоор ургана [1].

**Үржил:** Үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг нарийвчлан тогтоогоогүй. Ган, хуурайшилт, элсний нүүдэл, малын бэлчээрийн талхлагдалт зэргээс тархац нутаг хумигдаж, зарим газарт устаж үгүй болсон, устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар бүртгэж, тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг шинээр тогтоож, үрээр зориудаар тарьж үржүүлэх аргыг боловсруулж туршин, байгалийн нөхөн ургалтыг дэмжих, тохиромжтой газарт нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Мон. ур. улаан данс..., 2012, 3. Новости сист. высш. раст. 1964, вып 1.

69. ГРУБОВЫН ХӨӨНДИЙ



*Spongiocarpella grubovii* [Ulzij.] Yakovlev

*Magnoliophytina*

**Овог.** Буурцагтан – *Fabaceae* Lindl.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Өдлөг нийлмэл навчтай, 1.5 м голчтой, нягт том дэрэрхүү бут үүсгэдэг сөөг. Хос уруултай, хатуу сарьслаг, зэвгэр бор хүрэн өнгийн цоморлигтой, үсэрхэг. Ганц, эсвэл цөөхөн цэцгүүд навчны суганд баг цэцэг үүсгэн байрладаг. Буурцаг суумал, богино шилбэтэй, гонзгойдуу, хатуу арьслаг юмуу, илгэлэг, ихэвчлэн ганц үртэй, хэвлийн заадлаараа ханзардаг хоёр хавгастай [1,2].

**Тархац, ургах орчин:** Өвөр Монгол, Алашаа говь, Ордост тархана. Монголд: Алашаа говийн цөлийн тойрогт, Борзонгийн говь, Галбын говь, Сулинхээрийн зүүн хэсгээр, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойргийн Хөвсгөл сумын цөл, цөлөрхөг хээрийн бүсэд тохиолдоно. Цөлийн бүсийн нам толгодын элс, хайргатай хажуу бэл, хормой, сайрын эрэг дагаж ургана. Цөөн газарт ховор тохиолдоно [3,4].

**Үржил:** Ургал эрхтэн болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Цөлжилт, бэлчээрийн хэт талхагдалт, уул уурхайн ашиглалтын нөлөөлөлд орж, устах аюулд орсон.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн нэн ховор ургамлын

жагсаалтад, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэж, тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг судлан тогтоож, тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, мал бэлчээрлэлтийг хязгаарлан зогсоох, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Мон. ур. улаан данс., 2012, 4. Өлзийхутаг, 1983, 1985, 5. Улзийхутаг, 2003.

## 70. ХЭВРЭГНАВЧИГ ОРТУУЗ



*Oxytropis fragilifolia* Ulzj.

*Magnoliophytina*

**Овог.** Буурцагтан – *Fabaceae* Lindl.

**Статус:** Нэн ховор, унаган, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Нягт чигжүү, том дэр хэлбэртэй, биедээ цавуулаг булчирхайт үсэнцэртэй, олон наст өвс. Навч өдлөг нийлмэл, шүүслэг, зөөлөн, шугамандуу, гонзгой эсвэл гонзгой-зуувгардуу, хар ногоон навчинцраас бүрдэнэ. Цэцэг цайвардуу өнгөтэй, 3-4-өөрөө цацаг үүсгэнэ. Далбаа 17-22 мм урт. Буурцаг нимгэн, сарьслаг, цүрдгэр, өргөн өндгөрхүү [1,2,4].

**Тархац, ургах орчин:** Монголд: Монгол Алтай, Говь-Алтай [Алтайн нурууны Хасагт Хайрхан, Аж Богдын нуруу, Бурхан Буудай, Зүүн Жаргалант] ууланд уулын жижиг хайргархаг

нураг, асга, эгц хажуугийн асга, хад чулуутай газар ургана [2,4].

**Үржил:** Үр болон ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Эртний гаралтай, алаг цоог тархацтай энэхүү ургамлын өсөлт, хөгжилт, байгаль орчны доройтолд орж зогсонги байдалд орох, уул уурхайн олборлолтоос үүдэлтэй эдэлбэрт орох, бэлчээрийг сэлгээгүйгээр ашигласнаас хумигдаж, нөөц хомсдож, улмаар устах аюулд ороод байгаа унаган, үлдвэр ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулиар нэн ховор ургамлын жагсаалтад, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус оруулж бүртгэгдсэн. Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт бүрэн хамруулж, нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, зориудаар тарьж ургуулах ажлыг шуурхай зохион байгуулах, тохиромжтой газрыг сонгон нутагшуулах, тархац нутгийг малын бэлчээрээс чөлөөлөх, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Мон. ур. улаан данс., 2012, 4. Өлзийхутаг, 1983, 1985, 5. Улзийхутаг, 2003.

## 71. СУТАЙН ОРТУУЗ



*Oxytropis sutaiica* Ulzj.

*Magnoliophytina*

**Овог.** Буурцагтан – *Fabaceae* Lindl.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Бага зэргийн нягт дэгнүүл үүсгэдэг, бүдүүн модожсон үндэстэй, ишгүй, олон наст. Навч 4-6-аараа ишэн дээрээ тойрч байрладаг. Навчинцар өндгөрхүү юмуу зуувиндуу, маш жижигхэн, торгомсог үслэгээр бүрхэгдсэн, булчирхайлаг үслэггүй. Цэцэг хөх ягаан өнгөтэй, 1,2,3-аараа байрлан богинохон цацаг баг цэцэг үүсгэдэг. Цоморлиг гуурсархуу хэлбэртэй. Цэцгийн дагавар 2-4 мм урт. Буурцаг цоморлигоосоо гарч ханзардаг, хальсархаг, уртавтар юмуу өндгөрхүү-бөмбөлөг хэлбэртэй, хэвлий талдаа өргөн таславчтай, 2 үүр үүсгэдэг [1,3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Монгол Алтай, Хангайн уулын ойт хээрийн [төв], Монгол Алтайн уулын хээрийн [төв, өмнөд хэсэг] тойргуудын өндөр уулын бүслүүрийн мөнх цасны заагт нураг, асгатай газар улалж, бушилз бүхий газраар ургадаг [2]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үр болон ургал эрхтэний оролцоотойгоор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, нарийвчлан тогтоогоогүй. Хуурайшилт, бэлчээрийн талхагдалтаас устах аюулд орсон унаган ургамал.

**Хамгаалаахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн. Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн авч хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийн биологийг нарийвчлан судалж, зориудаар өсгөн үржүүлэх аргыг боловсруулж турших, тохиромжтой газарт нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, үндсэн тархац нутгийг малын бэлчээрлэлтээс чөлөөллөх, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Бот. журн. 1979. 64.3.

72. ШОВГОР ХОТИР



*Zygochloa mucronata* Maxim.  
*Magnoliophytina*  
**Овог.** Хотиртон – *Zygochloaceae* R.Br.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Модожсон олон салаат бүдүүн үндэстэй, олон наст өвслөг ургамал. Иш олон 5-6 см өндөр, нарийн хугарамтгай. Өнгөрсөн оны мөчрүүд ишний доод хэсэгт модождог. Навч 1.5-2 см урт, махлаг 2-3 навчинцартай. Навчинцар уртавтар юмуу уртавтар юлдэрхүү хэлбэртэй. Цэцэг, навчны өвөрт байрлах бөгөөд үрлэх үедээ гудайдаг, гадаргуу тод ногоон өнгөтэй, үр жимс уртавтар 10-17 мм урт, 5 мм орчим өргөн [1,3].

**Тархац, ургах орчин:** Дж-Хятад, Ганьсу, Өвөр Монголд тархана. Монголд: Алтайн өвөр говийн тойрогт, уул толгодын чулуурхаг, үйрмэг чулуут хормойд ургадаг [2]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үр болон ургал эрхтэнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Цөлжилт, ургах орчны доройтол, хөрсний чийгийн хангамж буурах, хүчтэй шороон шуурга зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Байгалийн нөхөн ургалт, тархац, нөөцийг судлан тогтоож,

тохиромжтой газарт нутагшуулах, тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2009.

### 73. ОРХИГДМОЛ ХОТИР



*Zygothymus neglectum* Grub.

*Magnoliophytina*

**Овог.** Хотиртон – *Zygothymaceae* R. Br.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Нүцгэн, гөлгөр, олон наст өвслөг ургамал. 2-3 хос навчинцар бүхий өдлөг навчтай. Дагавар навчис цагаан хальслаг. Хонхорцог өргөн далбанлаг, бараг бөөрөнхий, урт өргөнөөрөө 18-20мм [1,3]

**Тархац, ургах орчин:** Хятад /Ганьсу/-д тархана. Монголд: Зүүнгарын говь/Аргалантын толгод/-ийн тойрогт тохиолдоно. Уул толгодын хадтай, чулуурхаг цөлжүү хажууд ховор тохиолдоно [2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Олон жил үргэлжилсэн ган, хуурайшил, цөлжилт, хүчтэй шороон шуурга зэрэг байнга тохиолддог байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр тархцын хүрээ хумигдаж, нөөц хомсдож байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Байгалийн нөхөн ургах нөхцөл, явц, тархац, нөөцийг судлан тогтоож, тохиромжтой газарт тарьж ургуулах, нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2009.

## 74. ТАГИЙН СҮҮТ-ӨВС



*Euphorbia alpina* С.А.Мей.

*Magnoliophytina*

**Овог.** Сүүт өвстөн - *Euphorbiaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Голчоороо 1-2 см орчим болдог нилээд бүдүүн, олон толгойт үндэстэй, олон наст өвслөг ургамал. Зөөлөн босоо үслэг бүхий 20-50 см өндөр, энгийн иштэй. Навчис гонзгойвгор, орой дугуй юм уу мохоо, богино бариултай, харин ишний навчис суумал, зууван, суурь зүрхэрхүү, дугуй, танамал юмуу ялимгүй ухмал оройтой. Оройн шүхэр 2-5 шилбэтэй, ишний дээд хэсгийн навчны өврөөс цэцэг олноороо гарч бараг залаархуу баг цэцэг үүсгэсэн. Цэцгийн дагавар навч дугуйдуу- зууван, зууван. Жүнз нүцгэн, мохоо салбантай. Балавч хөндлөн, гонзгойвгор зууван, эвэргүй [1,3].

**Тархац, ургах орчин:** Баруун Сибирьт тархана. Монголд: Монгол Алтай/баруун хойт хэсэг/-н тойрогт тохиолдоно. Өндөр уулын болон уулын хээрийн бүслүүрт хад, чулуу, өвслөг энгэр



даган ургадаг [2].

**Үржил:** Ургал эрхтэн болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Бэлчээрийн малын хөлд гишгэгдэж гэмтэх, ширүүн мөндөрт цохигдон цэцэг, үр унаж тарах зэрэг шалтгаанаар устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг судлан тогтоож, тохиромжтой газарт тарих эсвэл нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2009.

## 75. ГЕБЛЕРИЙН АЛТАНЦЭГЦҮҮХЭЙ



*Hypericum gebleri* Ledeb.

*Magnoliophytina*

**Овог.** Алтанцэгцүүхэйтэн - *Hypericaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Үндэслэг ишгэй, олон наст өвслөг ургамал. Иш цөөн, 50-60 см өндөр. Навчис суумал, ишээ зуусан, 3-6 см урт, 5-15 мм өргөн, нарийн зуувгар. Цэцэг тод шар, 3.5-4 см голчтой. Цоморлигийн навчинцар өндгөрхүү юмуу дүгрэг-өндгөрхүү, 10-15 мм урт, 6-10 мм

өргөн, мохоодуу. Үр боловсрох орны багана суурьтаа нийлэнгэ, боловсорсон хонгорцогоос 2-3 дахин богино. Хонгорцог өндгөрхүү. Үр зууван [2,4].

**Тархац, ургах орчин:** Дорнод Казахстан, Сибирь, Алс Дорнодод тархана. Монголд: Хэнтийн тойрогт буюу Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Ар Минжийн гол дагуу тохиолдоно. Голын эргийн хайрга, бургасан шугуй, чийглэг нугад ургана [1,3].

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Тархац нутагт мал бэлчээрлүүлэх, голын ус багасч, нуга хуурайших зэргээс устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийн ихэнх хэсгийг тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийн биологийг нарийвчлан судалж, үрээр тарьж ургуулах аргыг боловсруулж, туршин, байгалийн нөхөн сэргээлтийг дэмжих, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Флор Сибири, 1996.

## 76. АРЗГАР СУХАЙ



*Tamarix hispida* Willd.

*Magnoliophytina*

**Овог.** *Сухайтан* - *Tamaricaceae* Link.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 5 метр хүрэхүйц өндөр сөөг. Навч хайрсархуу маш жижиг, 1-7 мм урт. Найлзуур болон навчис тачир шулуун үсээр хучигдсан. Таван гишүүнт жижиг ягаан цэцгүүд оройн залаа баг цэцгийг бүрдүүлдэг. Харин хажуугийн залуу найлзуур дээр хааяа дөрвөн гишүүнт буюу дөрөвчилсэн бүтэцтэй цэцгүүд байрладаг. Дохиур 4-5, түүний шилбэ саланги. Үр боловсрох орон 3-4 баганатай [1].

**Тархац, ургах орчин:** Дундад Ази, Дорнод Казакстан, Хятад тархана. Монголд: Говь-Алтай [Хөрх уул, Алтан амны хавцал]-д ургадаг. Хужирлаг элс, мараа, өргөн их сайрын мараалаг ёроол бараадан ургана [2]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Цөлжилт, хуурайшилт болон бэлчээрийн талхлагдалт зэргээс нөхөн сэргэлт саатаж, тархац нутаг хумигдаж байгаа, устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлаар бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологи, экологийн нарийвчлан судалж, нутагшуулах, зориудаар тарьж ургуулах замаар байгалийн нөхөн ургалтыг дэмжих, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996.

77. ТОЛГОДЫН НИЛ



*Viola collina* Bess.

*Magnoliophytina*

**Овог.** Нилтэн - *Violaceae* Batsch.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Үндэслэг иш үдээсэрхүү, олон тооны саглагар үндэстэй, зөвхөн үндэс орчмын дэвсээ навчтай, навчны өврийн ганц цэцэгт иш бүхий 4-25 см өндөр, олон наст өвслөг ургамал. Навч өргөн өндгөрхүүгээс дугуйдуу, зүрхэрхүү суурьтай, бариултайгаа адил сэрэвгэр үслэгээр хучигдсан, маш зөөлөн, цайвар ногоон өнгөтэй. Цоморлигийн навчинцар зууван, дэлбийн хэлтэс нарийн, тонгоруу- өндгөрхүү. Навчны дагавар нарийн юлдэрхүү, захаараа цацгархуу сормослог, голын хөндлөн судал сормослог. Цэцэг анхилуун, цайвар ягаан, шулуун годойтой, цэцэглэх иш жимслэх үедээ цацаг хэлбэртэй. Үр боловсрох орны багана ээрүүлэрхүү хэлбэртэй. Хонхорцог үсэрхэг, бөөрөнхий. Үр цайвар шаргал, лийрэрхүү [3,4].

**Тархац, ургах орчин:** Дорнод Сибирьт ховор тархана. Монголд: Хянганы уулын нугат хээрийн тойрогт хусан төгөл, сөөгөн шугуйд ургана [1,2].

**Үржил:** Үр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, тархац хязгаарлагдмал учир хуурайшилт болон ой хээрийн түймэрт өртөгдөснөөс устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Тархац нутгийг улсын тусгай

хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Үржлийн биологи, тархац, нөөцийг нарийвчлан судалж, зориудаар тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Дариймаа, 1997, 3. Лигаа нар, 2009, 4. Малышев, Пешкова, 1979,

## 78. АХАР-ЭВЭРТ НИЛ



*Viola brachyceras* Turcz.

*Magnoliophytina*

**Овог.** Нилтэн - *Violaceae* Batsch.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Мөхсөн навчны үлдэгдлээр хучигдсан, бүдүүн үндэслэг иштэй. Ишгүй 6-10 см өндөр, намхан, олон наст өвслөг ургамал. Навч ихэнхдээ 2-3, дугуй юмуу өргөн өндгөн, зүрхэрхүү суурьтай, гүдэн шүдлэг ирмэгтэй. Нарийн юлдэрхүү цацаглаг, жижиг хүрэн дагавар навчтай. Урт бариултай, навчны хоёр тал адилхан ногоон өнгөтэй, нүцгэн. Цэцэг жижиг 8 мм урт, цагаан өнгөтэй, 1 мм орчим богино годойтой. Цэцэглэх үед цэцгийн шилбэ навчнаасаа бага зэрэг урт. Цоморлогийн навчинцар өргөн юлдэрхүү, нүцгэн, жижиг мохоо дагалттай. Дэлбийн хэлтэс зууван тонгоруу өндгөрхүү. Хонхорцог хар хүрэн [4,5].

**Тархац, ургах орчин:** Дорнод Сибирьт тархана. Монголд: Хэнтийн уулын тайгын тойргийн

шилмүүст ой, чийгтэй хад, хавцлын сүүдэрт ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай [1,2,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Ойн түймэрт нэрвэгдэснээс устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монголын ургамлын улаан дансанд [6] тус тус бүртгэсэн. Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг нарийвчлан судалж, үрээр үржүүлэх аргыг боловсруулан туршиж, нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 1997, 4. Лигаа нар, 2009, 5. Малышев, Пешкова, 1979, 6. Мон. ур. улаан данс..., 2012.

## 79. МУРКРОФТЫН ЖИГД



*Elaeagnus moorcroftii* Wall. ex Schlecht.

*Magnoliophytina*

**Овог.** Жигдтэн - *Elaeagnaceae*

**Статус:** Нэн ховор, үлдвэр зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Улбар хүрэн холтостой. 4 метр өндөр мод. Залуу найлзуур навчис гадуураа мөнгөлөг хайрсархуу юмуу одорхог үсэнцэрээр хучигдсан, цагаан саарал өнгөтэй. Навчны илтэс өргөн юлдэрхүү, гонзгой 3-5 см урт. Навчны өвөрт нарийн шилбэтэй, хоолойрхуу, 7мм урт, 1-3 -аараа байрласан шадар эрхгэнтэй, дөрвөн гишүүнт хос бэлэгт цэцэгтэй. Жимс 1 см орчим урт, шаравтар, зөөлөн ясан бүрхүүлийн гадуур 8 тууш бараан ховилтсон судалтай.

**Тархац, ургах орчин:** Төв Ази, Алтайн өвөр болон Алашаа говийн заагт орших Хөвдийн булагт цөөн бий[1-3]. Жигд байгальд Өмнөговь аймгийн Хөвдийн баянбүрд, Эхэн-Зулганай баянбүрд зэрэг газруудад 60 орчим ширхэг ургана [4]. Элсэрхэг баянбүрдийн булаг, сайрын захаар марзтай хөрсөнд ургана.

**Үржил:** Үрээр болон үндэсний цухуйцаар үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш хомс. Цөлжилт, олон жил дараалсан ган, хуурайшилтаас нас гүйцсэн модод хатаж өгөршин, нөхөн сэргэлт удааширч байна. Баянбүрдэд мал бэлчээх, хашаа барих, модыг түлшинд ашигласнаас ургах орчин доройтож, нөөц хомсдож устах аюулд орсон, үлдвэр зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэсэн. 1960-аад оноос Өмнөговь аймгийн Эхийн гол, Даланзадгад, Мандалговь хот зарим сумдын мод үржүүлэх газар, цэцэрлэг, гудамж талбайн услагаатай нөхцөлд тарьж ургуулах туршилтыг хийсэн. 2000 онд “Алтай өвөр говийн цөлийн нөхцөлд муркрофтын жигдийг тарималжуулах агротехнологийг боловсруулжээ [4]. Одоогоор тарималаар Алтайн өвөр говийн Баянтоорой, Өмнөговь аймгийн төв, Баянхонгор аймгийн Богд, Булган аймгийн Дашинчилэн, Рашаант, Дорноговь аймгийн Замын-Үүд, Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Говьсүмбэр аймгийн төвөөс хойш 10 км-т байдаг үржүүлгийн газарт ургуулж байна [5].

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, нөхөн сэргэх ургалтын дэмжих, зориудаар тарьж ургуулах, тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, баянбүрдийн элсний нүүдлийг зогсоох, ургах орчны доройтлыг бууруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1.Горшков, 1949, 2. Грубов, 1982, 3. Козловская, 1953, 4. Хауленбек, 2000, 5. Хауленбек, 2006,

80. ЗҮҮНГАРЫН ГОЁО [УЛААН ГОЁО]



*Synotarium songaricum* Rupr.

*Magnoliophytina*

**Овог.** *Гоёотон - Synotoriaceae Lindl.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Элсэн товцог, хармагийн үндэс дээр нэг буюу хэд хэдээрээ бэхлэгдэж ургана. Бие улбар хүрэн юмуу хар бараан өнгөтэй, 5-30 см урт, 1-3 см голчтой, ээрүүлэрхүү монголор баг цэцэгтэй, хүрэн ягаан өнгөтэй, 10-20 см урт, 1-2 см голч бүхий махлаг, зөөлөн иштэй, шимэгч ургамал. Ишний дагуу цуваа байрласан үлдэгдэл төдий хайрсархуу навчтай. Маш жижиг, олон тоотой, дан юмуу хос бэлэгт цэцэгтэй. Цэцгийн шадар эрхтэн энгийн, улаавгар юмуу хүрэн ягаан өнгөтэй, суурь нарийн шаантгархуу, 1-4 /хааяа 8/ навчинцартай. Эр цэцэг дундаа бүдүүн утаслаг шилбэ бүхий нэг дохиуртай. Эм цэцэг доор үрэвчтэй. Тавархуу бяцхан амсар бүхий нэг үр боловсрох оронтой. Самранцар хэлбэрийн үр жимс бөмбөлөгөрхүү, жижигхэн, улбар хүрэн өнгөтэй, нэг үртэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Иран, Дундад Ази, Баруун Хятадад тархана. Монголд: Их нуурын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашааны говьд тархсан. Элсэн, элсэнцэр хөрсөнд ургасан хармагийн үндэснээс шимэгчлэн олноороо нэг дор эгнэн амьдардаг. Гантай жил ургахгүй [2,3].

**Үржил:** Ургал эрхтэн болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц шинэчлэн тогтоогоогүй, цөөн газар тархсан. Ишийг хүнсний зориулалтаар, хармагийг түлшинд их хэмжээгээр түүж бэлтгэх, говийн баян бүрдүүдийн мөхөл доройтол, цөлжилт, булаг шанд ширгэж, хөрсний ус доошлох, бэлчээрийн хүчтэй



талхагдалт зэргээс шалтгаалан, хармагийг манхан, төгөл улам бүр байхгүй болж байгаа бөгөөд гоёо олон газар нутагт ургахгүй болсон.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлаар бүртгэж, Монгол улсын улаан номонд оруулж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийн судалгааг шинэчлэн явуулж, нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай газрыг тогтоож, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад хамруулж, малын бэлчээрээс чөлөөлж, хармагийн манхан, төгөлийг нөхөн сэргээх, зориудаар үржүүлэх, хүнс, эмийн зориулалтаар ашиглахыг хязгаарлах, нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хуулийн дагуу харицуулан хамгаалах, тохиромжтой газар тарьж ургуулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 2010, 2. Губанов, 1996, 3. Монгол улсын улаан ном, 1997.

## 81. ХАВТАГНАВЧИТ ХӨХТОЛГОЙ



*Eryngium planum* L.

*Magnoliophytina*

**Овог.** Майлцман [Шүхэртэн] - *Apiaceae* Lindl. [*Umbelliferae* Juss.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Үндэс түүдэгэрхүү. Олон наст өвслөг ургамал. Иш нүцгэн, үл мэдэгдэм хавиргалаг, 30-80 /100/ см өндөр, нил ягаавгар өнгөтэй. Үндэс орчмын навчис энгийн бөгөөд бүтэн, өндгөрхүү юмуу урвуу өндгөрхүү, захаараа мохоо шүдэрхэг. Ишний навчис жижиг,

захаараа хурц шүдэрхэг, эсвэл өргөсөрхүү бөгөөд заримдаа цуулбар өдлөг. Шүхэр нягт толгойрхуу. Ороолтын навчинцар 5-7, үзүүрээдээ нарийн өргөсөрхүү. Дэлбэ нил хөх, хааяа цайвар. Дэлбийн хэлтэс ухагдмал. Үр жимс өндгөрхүү хэлбэртэй [1,2,3].

**Тархац, ургах орчин:** Европ, Кавказ, Дундад Ази, Төв Ази, Сибирь, Алс Дорнодод тархана. Монголд: Монгол Дагуурын тойрогт Өмнөд Дархан орчимд тохиолдоно. Хээрийн бүсэд хуурай нуга, голын эрэгт ургана [2].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Харь орны нутгаас зөөгдөж ургасан тул өдгөө цөөн цэгт тархсан, нөөц бага. Хуурайшилт, элсний нүүдэл, гол, горхи ширгэх, намаг хуурайшиж хагах, бэлчээрийн талхагдалт өртөгдөн устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, зориудаар үржүүлэх аргыг боловсруулж турших, байгалийн нөхөн ургалтыг дэмжих, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Ургамал, 2009, 4. Флора Сибири, 1996.

## 82. ДЭРЭВГЭР ЖИРГЭРҮҮ



*Saposhnikovia divaricata* [Turcz.] Schischk.

*Magnoliophytina*

**Овог.** Майлцтан [Шүхэртэн] - *Ariaceae* Lindl. [*Umbelliferae* Juss.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Үндэс голлосон, голчоороо 1.5-2 см. Сууриасаа ихэд салаархаг 30-80 см өндөр нүцгэн иштэй, олон наст өвс. Үндэс орчмын навчис олон. Навчис хошоод юмуу гурвантаа хагалбар өдлөг. Навчны төгсгөлийн эрэмбийн сегмент юлдэрхүү юмуу урвуу-өндгөрхүү, 8-20 /25/ мм урт, 1.5-8 мм өргөн. Шүхэр 2-8 см голчтой, адил урттай 5-8 /10/ шилбэтэй. Шүхрэнцэр 4-10 цэцэгтэй. Нуухны навчинцаргүй. Нууханцрын навчинцар цөөн, цэцэг цагаан, дэлбэ нүцгэн, хэлтэс бүтэн. Үржимс нүцгэн, 5-7 мм урт, 3-3.5 мм өргөн [2,4,5]

**Тархац, ургах орчин:** Сибирь /Зүүн/, Алс Дорнод, Дорнод Азид тархана. Монголд: Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монголын тойргуудад тохиолдоно. Ойт хээрийн бүслүүр болон хээрийн бүсэд хайргат ба чулуурхаг хээржүү хажуу, хялганат хээр, хуурай сайр, атаржсан тариан талбайд ургана [1,3]

**Үржил:** Үрээр, ургал эрхтэнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Эмийн зориулалтаар ургамлын үндсийг их хэмжээгээр түүж, гадаад улсад удаан хугацаагаар гаргаж байгаа болон бэлчээрийн талхагдалт, хээрийн түймэрт шатаж байгаагаас тархац эрчимтэй хумигдаж, нөөц улам бүр багасч, устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Монос группын Эм судлалын хүрээлэнгийн эмийн ургамлын туршилтын талбайд зориудаар тарьж ургуулах судалгааг явуулж байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, зориудаар тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Ургамал, 2009, 5. Flora China, 2005.

83. ЗАЛААРХАГ ХАВРАГ



*Ferula ferulaeoides* [Steud.] Korov.

*Magnoliophytina*

**Овог.** *Майлцман [Шүхэртэн] - Apiaceae Lindl. [Umbelliferae Juss.]*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Нэг удаа цэцэглэдэг, олон наст өвс. Цэцэглээгүй үедээ 10-60 см урт, зузаан, ээрүүлэрхүү, 5-25 см бүдүүн үндэстэй, үндэсний хүзүүг тойрсон нягт, утаслаг ширхэгтэй. Үндэс орчим дэвсээ байрласан гурвантаа юмуу дөрвөнтөө өдлөг, цуулбарласан 10-40 см урт, гурвалжиндуу өндөгөрхүү, 3-9 навчтай. Навч угтаа өргөн, үзүүрээдээ бөөрөнхий урт бариултай, илтсийн салбан шүдэрхэг, зөөлөн, сааралдуу үсэрхэг. Цэцэглэх үедээ 1 метр өндөр, 2-4 см бүдүүн, олон салаатай иштэй. Ишний навч бяцхан илтэстэй, эсвэл дан углагархуу. Ишний үзүүр, мөчирт угласан мэт олон давхар тойруулган шүхэр баг цэцэгтэй. Шүхэр дунджаар 10 цэцэгтэй, 3-12 цацрагтай. Цэцэг доор үрэвчтэй, шүүдэрэрхүү цомирлогтой, шаравгар дэлбээтэй. Үр жимс дотогшоо хонхордуу хавтгай, зууван, нуруу талдаа 3-5 хавиргархуу, ирмэгээрээ нимгэн, хос үрэнцэртэй. Үрэнцэрийн хана 4 сувагтай [2,3,5,7].

**Тархац, ургах орчин:** Дундад Ази, Баруун Сибирь, Хятадад тархана. Монголд: Монгол Алтай болон Зүүнгарын тойргийн зааг болох Ховд аймгийн Булган сумын нутагт орших Рашаантын нуруу, Билүүт уул, Их, Бага Онгогт тохиолддог. Уулс хоорондын гүвээ, дэнж, толгодын бэл, судаг, жалга, хуурай сайрт ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай [1].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Цас, борооны үерт үндэс урсах, цэцэг, үр жимс гэмтэж, үр боловсрохгүй болох, давирхайт үндсийг эмийн зориулалтаар их хэмжээгээр хууль бусаар түүж бэлтгэх зэрэг шалтгаанаас нөөц эрс хомсдож, тархац нутаг хумигдаж устах аюулд ороод байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулиар нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансад тус тус бүртгэж хамгаалсан. 1990 оноос Ховдын их сургуулийн багш, мэргэжилтнүүд уг зүйлийн тархац, нөөц, хөгжил, үрийн ургах чадварыг судалж, тархац нутгийг орон нутгийн хамгаалалтад авсан. Мөн 1990 оноос Буянт голын хөндийд шилжүүлэн суулгаж, нутагшуулах туршилт хийснээр тарималжуулах ажлыг эхлүүлсэн. ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгийн өвслөг ургамлын цуглуулгын талбайд Ховд аймгийн Булган сумаас цуглуулсан дээжийг 2012 оноос үндэслэг ишээр тарималжуулах судалгааг хийж байна.

**Хамгаалах арга хэмжээ:** Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенийн жагсаалтад оруулах, урьд ургаж байсан болон ижил төстэй нутагт зориудаар тарьж ургуулах, нутагшуулах, зориудын үржүүлгийн газар бий болгох, хамгаалалтыг сайжруулах, үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалттай газарт хамруулах, тархац бүхий газрыг нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд холбогдох хуулийн дагуу хариуцуулан хамгаалуулж, хууль бус ашиглалтыг таслан зогсоох, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Камелин, Губанов, Дариймаа 1985, 3. Монгол улсын улаан ном 1997, 4. Мөн. ур. улаан данс., 2012, 5. Род ферула, 1963, 6. Сафина, 1984, 7. Суран, Жамсран 1993, 8. Суран, 1996, 9. Ургамал, 2009.

## 84. ГАЗ СОЁЛЖ



*Sajanelia monstrosa* [Willd. ex Spreng.] Sojak

Magnoliophytina

**Овог.** Майлцман [Шүхэртэн] - *Apiaceae* Lindl. [*Umbelliferae* Juss.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Үндэс голлосон, олон наст өвсөг ургамал. Иш салаагүй, үсгүй, 20-50 см өндөр, хөндий. Навчис нүцгэн, нэжгээд ба хошоод өдлөг цуулбар, төгсгөлийн эрэмбийн сегмент дугариг юмуу өндгөрхүү, 13-30 мм урт, 8-20 мм өргөн. Шүхэр ганц, 4-6 см голчтой, үсэрхэг. Дэлбэ бүдэгдүү нил хөх, хөх ягаан. Дэлбийн хэлтэс бүтэн. Үржимс бөөрөнхийдүү [2,4,5].

**Тархац, ургах орчин:** Дорнод Казахстан, Сибирьт тархана. Монголд: Хэнтийн /Онон гол/ тойрогт буюу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутгийн хойд захаар тархана. Зөвхөн хил дагуу зурвас нутгийн өндөр уулын бүслүүрт уулын нуга, шинэсэн ой, ойн зах, чийглэг энгэр, голын эрэг дагуу ургана [1,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Ойн түймрээс шалтгаалан устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац, нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, зориудаар тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, ховор ургамлын жагсаалтад оруулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Ургамал, 2009, 5. Флора Сибири, 1996, Т.10.

85. АЛТАН ТЭРЭЛЖ



*Rhododendron aureum* Georgi

*Magnoliophytina*

**Овог.** Дальман – *Ericaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** 10-15 см өндөр, мөнх ногоон сөөг. 8 см хүртэл урт, бүтэн захтай, ирмэгээрээ гэдрэг эргэсэн арьслаг навчистай. Навч ишин дэрээ шигүү сууж байрлана. Шар өнгийн том цэцэгтэй. Дэлбийн хэлтэс нийлж урган хонхорхуу хэлбэртэй болсон. Цэцгүүд хоёр, гурваараа иш мөчрийн үзүүрт бамбайрхуу хэлбэрийн баг цэцэг үүсгэнэ. Үл мэдэг шүдлэг жижигхэн цомирлогтой. Өтгөн эсгийрхэг үслэгээр бүрхэгдсэн уртавгар хонхорцгон үр жимстэй [2,5].

**Тархац, ургах орчин:** Баруун, Зүүн Сибирь., Алс Дорнод, Японд тархана. Монголд: Хөвсгөл, Хэнтийн тойргийн зарим нутагт нэн ховор тохиолдоно. Өндөр уулын бүслүүрийн таг, чулуу, асга, хад, хааяа ойн дээд захаар, хушин ойд ургана [1,3].

**Үржил:** Үр, ургал эрхтэнээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Байгальд нөхөн сэргэх боломж дутмаг, мод бэлтгэх, түймэрт нэрвэгдэх зэрэг шалтгаанаас устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном, [5] Монголын ургамлын улаан дансанд [6] тус тус бүртгэж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, зориудаар тарьж ургуулах аргыг боловсруулж турших замаар байгалийн нөхөн ургалтыг дэмжих, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигая нар, 2008, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012.

## 86. БЯЦХАНЖИМСТ ЦАНГИС



*Oxycoccus microcarpus* Turcz. ex Rupr.

*Magnoliophytina*

**Овог.** *Нэрстэн – Vacciniaceae S.F.Gray.*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Мөлхөө үндэслэг иштэй, мөнх ногоон, 75 см хүртэл өндөр иштэй, заримдаг сөөгөнцөр. Навч сарьслаг, уртавтар-өндгөрхүү юмуу гонзгойвгор-өндгөн хэлбэртэй, хуулирсан захтай, дээд гадарга хар ногоон, доод гадарга саарал өнгөтэй. Цомирлог дөрөвчилсэн бүтэцтэй, дугуйдуу салбантай, ирмэгээрээ нүцгэн юмуу богинохон сормислиг үстэй. Цэцэг ягаавтар улаан, шилбэ нүцгэн, шилбэний дундаас доош шугаман хэлбэрийн дагавар навчтай. Жимс хүрэн улаан [4,6].

**Тархац, ургах орчин:** Арктик., Скандинов, Солонгост тархана. Монголд: Хэнтийн тойрогт хөвдөт намаг, хүлэр бүхий намаг, чулуурхаг царманд ургадаг нэн хязгаарлагдмал тархацтай [1,2,3].



**Үржил:** Үр, ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг нарийвчлан тогтоогоогүй. Түймэрт шатах, эм, хүнсний хэрэгцээнд их хэмжээгээр хууль бусаар ашиглаж байгаагаас устах аюулд ороод байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном /1987, 1997/ болон Монголын ургамлын улаан дансанд [5] тус тус бүртгэж хамгаалсан. Тархац нутгийг Хан Хэнтийн дархан цаазат газарт хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөц, тархацыг нарийвчлан тогтоож, нутгийн иргэд, нөхөрлөлд тархац нутгийг хариуцуулан хамгаалуулах замаар хамгаалалтыг сайжруулж, хууль бус ашиглалтыг таслан зогсоох, тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1.Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2008, 4. Монгол Улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс..., 2012, 6. Флора, СССР., 1952, Т.18.

## 87. БРОТЕРУСЫН УЛБУУДАЙ



*Cortusa brotheri* Pax ex Lipsky

*Magnoliophytina*

**Овог.** *Хаварсалтан – Primulaceae Vent.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 20-25 /35/ см өндөр, олон наст өвслөг ургамал. Навчны илтэс дугуйдуу, бөөр хэлбэртэй, голчоороо 4-5 см, жижиг шүдлэг, дугуйвтар далбантай, дээд гадаргуу нүцгэн, хар ногоон, харин доод гадаргуу нь сааралдуу бөгөөд бариул үслэг. Дэлбэ юүлүүр хэлбэртэй, урт, ягаавтар нил, гонзгойвтор мохоо салбантай. Цоморлиг бараг гурвалжин, өргөн салбантай. Цэцэг 5-8 /10/-аараа бөөгнөрч өрөөсгөл шүхэр үүсгэдэг. Хонхорцог гонзгойвтор өндгөрхүү, цомирлогоосоо ялимгүй урт [1,4].

**Тархац, ургах орчин:** Кашгар, Төвд, Гимилай [баруун]-д тархана. Монголд: Монгол Алтайн ойн дээд хэсэг өндөр уулын бүслүүрийн доод хэсгийн шинэсэн төгөл, тэдгээрийн зах, горхийн эрэг, сөөгөн ширэнгэн дунд ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай ургамал [2,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Тархац нутагт мал бэлчээрлүүлэх, мод бэлтгэх, хадлан бэлтгэх, хуурайшилтын улмаас устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, Тархац нутгийг Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийн биологийг нарийвчлан судалж, үрээр зориудаар тарьж ургуулах аргыг боловсруулж турших, байгальд ургах нөхцлийг хангахад малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэхийг хязгаарлаж, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. БНМАУ-ын улаан ном, 1987, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2008, 4. Флора, СССР., 1952, Т.18.

88. ГАНГАН ЮЛТ



*Goniolimon callicotum* [C.A.Mey.] Boiss.

*Magnoliophytina*

**Овог.** Хорголжинтон - *Plumbaginaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Суман иштэй, олон наст өвс. Богиноссон найлзуур дээр олон навчис сууж байрлан, тэвгэн хэлбэрийг үүсгэдэг. Навч нарийн зуувгараас юлдэрхүү хэлбэртэй болсон. Навч захаараа хавтгай жижиг шохойлог цэгүүдтэй. Суман иш буюу цэцэгт иш 2-6, заримдаа 10 гаруй. Цэцгүүд бамбайрхуу залаархаг баг цэцгийг бүрдүүлнэ [1].

**Тархац, ургах орчин:** Казахстанд тархана. Монголд: Монгол Алтай /Алтан–Хөхүй/-д ургадаг. Үйрмэг чулуутай хужирлаг энгэр газар ургадаг [2].

**Үржил:** Үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Уур амьсгалын өөрчлөлтөөс өсөлт удааширч, нөөц хомсдон, тархац нутаг хумигдаж, устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг судалж, үрээр үржүүлэх аргыг боловсруулж турших, тохиромжтой нутагт нутагшуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996.

## 89. ГРУБОВЫН БЭРМЭГ



*Limonium grubovii* Lincz.

*Magnoliophytina*

**Овог.** Хорголжинтон - *Plumbaginaceae* Juss.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Иш навчгүй, зөвхөн үеүд дээрээ сарьслаг хайрстай, олон наст өвс. Иш ганцаараа юмуу хоёр гурваараа, эгц босоо, дээд хэсгээрээ салаалсан, 15-30 см өндөр. Навчис гонзгой тонгоргуу-өндгөн, 2-5 см урт, 1-2 см өргөн. Толгой баг цэцэгтэй, цоморлиг алтан шар, өргөн юүлүүрэрхүү хэлбэртэй. Дэлбэ улбар шар өнгөтэй. 7, 8 дугаар сард цэцэглэнэ [1,2].

**Тархац, ургах орчин:** Монголд: Дорнод Монгол [Лагийн гол]-д ургадаг. Давслаг хөрстэй хээр, эрэг орчмын мараалаг нугад бага хэмжээгээр ургана. Тархац нэн хязгаарлагдмал [3].

**Үржил:** Үрээр болон ургал эрхтэнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Хуурайшилт, мал бэлчээрлүүлэлт зэрэг шалтгаанаас устах аюулд орсон унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 тогтоолоор

ховор ургамлын жагсаалтад оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийн биологийг судалж, үрээр үржүүлэх аргыг боловсруулж, зориудаар тарьж ургуулах замаар байгалийн нөхөн ургалтыг дэмжих, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, малын бэлчээрээс чөлөөлөх, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бот. журн. 1971, 56, 11:1635, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996.

## 90. БАНЗРАГЧИЙН ЗҮЛЭГЛИГ



*Swertia banzragczii* Sancz.

*Magnoliophytina*

**Овог.** Дэгдтэн – *Gentianaceae* Juss.

**Статус:** Нэн ховор, унаган ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Богиноссон үндэслэг иштэй, махлаг үндэстэй олон наст өвслөг ургамал. Иш эгц босоо, 15-40 см өндөр, дээд хэсгээрээ бага зэрэг салаалсан. Навч уртавтар юмуу юлдэн хэлбэртэй, үндэс орчмын навч урт бариултай, харин ишнийх богинохон юмуу бараг суумал бөгөөд навч дээшлэх дутмаа жижгэрдэг. Цэцэг шар ногоон өнгөтэй, дэлбэ 10-12 см урт, хүрдэрхүү хэлбэртэй, цацаг баг цэцэгт нэгддэг [2].

**Тархац, ургах орчин:** Алжир, Армени, Афгинастан, Египет, Ирак, Иран, Казахстан зэрэг оронд тархана. Монголд: Ховд, Говь-Алтай тойрогт өндөр уул, ойн нугад ургана [1].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Уур амьсгалын өөрчлөлтөөс хур тунадас багасгах, хэт халах, хуурайших, үйл явц эрчимжиж, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлснээс шалтгаалан устах аюулд орсон унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор

ургамлын жагсаалтад оруулж, Монголын ургамлын улаан дансанд бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судалж, үржүүлэх аргыг боловсруулж турших, улмаар зориудаар тарих, тархац нутгийг тусгай хамгаалалтад авч нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, үндсэн тархац нутгийг малын бэлчээрээс чөлөөлөх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа нар, 2008. 3. Мон. ур. улаан данс..., 2012.

## 91. ЧӨДӨР ЗЭЛЛЭГЦЭЦЭГ



*Calystegia hederacea* Wall.

*Magnoliophytina*

**Овог.** Сэдэргэнэтэн – *Convolvulaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 10-60 /100/ см өндөр, олон наст өвслөг ургамал. Иш нүцгэн, туяхан, дэлхээ юмуу эгц босоо, эсвэл бусдыг ороож ургадаг. Үндэс голлосон, зузаавтар юмуу ээрүүлэрхүү хэлбэртэй. Навч урт бариултай, мохоо оройтой, доод хэсгийнх өндгөрхүү юмуу уртассан өндгөрхүү, дээд хэсгийнх жадархуу хэлбэртэй. Цэцэгт найлзуур навчнаасаа урт юмуу тэнцүү. Цэцгийн дагавар өндгөрхүү юмуу уртавтар өндгөрхүү, цомирлогоосоо урт. Дэлбэ цайвар ягаан өнгөтэй. Дохиур дэлбэнээсээ богино, шилбэ нь доод хэсгээрээ өргөссөн. Хонхорцог 0,1 см орчим урт [2,4].

**Тархац, ургах орчин:** Баруун Сибирийн Алтай, Алс Дорнодын Уссур, Дундад Ази, Манжуур,

Солонгос, Япон, Гималайн хойд хэсэг, Афганистан, Малайзад тархана. Монголд: Говь-Алтайн уулын цөлөрхөг хээрийн тойргийн Хөх уулын хярд хавцлын хадтай энгэрт тэмдэглэгдсэн. Элсэрхэг хөрс, голын эрэг, эрэг орчмын дэгнүүлгүй газраар ургадаг, нэн хязгаарлагдмал тархацтай [1,3].

**Үржил:** Үндэслэг ишээр болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг маш бага. Олон жил дараалсан ган, хүчтэй шороон шуурга зэрэг байгалийн гамшигт өртөх, эмийн зориулалтаар хууль бусаар түүж бэлтгэснээс устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж, зориудаар үржүүлэх, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, хууль бус ашиглалтыг таслан зогсоох хяналтыг нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа нар, 2008, 3. Өлзийхутаг, 1985, 4. Флора СССР, 1945, Т.11.

## 92. МАРТАГДСАН ЗЭЛЛЭГЦЭЦЭГ



*Calystegia subvolubilis* [Ledeb.] G. Don.

*Magnoliophytina*

**Овог.** Сэдэргэнэтэн – *Convolvulaceae* Juss.



**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Мөлхөө, олсорхог үндэслэг иштэй, олон наст өвслөг ургамал. Иш доод хэсгээрээ шулуун, нүцгэн, дээгүүрээ ороож ургадаг, бага зэргийн үсэрхэг, 1 м хүртэл өндөр, Навч богинохон бариултай, нарийвтар гурвалжиндуу-сумархуу хэлбэртэй, ишний дунд хэсгийн навч уртассан-юлдэрхүү, орой шовх. Цэцгийн дагавар том, өндгөрхүү хэлбэртэй, орой хурц, үсэрхэг, цомирлогоо далдалдаг. Гэхдээ навчнаасаа эрс ялгагдана. Цэцэг урт шилбэн дээр байрлан, навчны өврөөс олноороо гардаг. Дэлбэ тод ягаан өнгөтэй. Үр боловсрох орны багана зуувгар амсартай[3].

**Тархац, ургах орчин:** Алс Дорнод, Зүүн болон Баруун Сибирьт тархана. Монголд: Хангайн тойргийн Бүтээлийн нуруунд голын эргийн дагуух сөөгөн ширэнгэн дунд, ойн цоорхой, татмын нуга, хээрийн нугад ургана [1,2].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогдоогүй. Ой хээрийн түймрийн улмаас устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тархац, нөөцийг нарийвчлан судалж, тохиромжтой газарт нутагшуулах, үрээр зориудаар тарьж ургуулах замаар байгалийн нөхөн ургалтыг дэмжих, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Ганболд, 2010, 2.Губанов, 1996, 3. Лигаа нар, 2008.

93. НААЛДАМХАЙ ГҮҮНХӨХ



*Scutellaria viscidula* Bunge

*Magnoliophytina*

**Овог.** Мажтан [Уруулцэцэгтэн] - *Lamiaceae* [*Labiatae* Juss.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Модожсон үндэслэг иштэй, заримдаг сөөгөнцөр. Иш 12 -20 см өндөр, сууриасаа олон салаалсан, буталж ургадаг, өтгөн үсэрхэг, булчирхайлагтай. Навч юлдэрхүү, бүтэн захтай, захаараа сормослиг үсэрхэг, шовх оройтой, суумал, дээд гадаргуу булчирхайлаг, сийрэг үслэгтэй, доод гадаргуу судлаа дагасан сэрэвгэр үсэрхэг, булчирхайлаг. Цэцгүүд ишний дээд хэсгийн навчны өвөрт байрлаж үзүүрийн цацаг баг цэцэг бүрдүүлдэг. Цэцэг цайвар шар юмуу цайвар өнгөтэй, гадна талаараа булчирхайт үслэгтэй. Дэлбийн дээд уруул 3 илтэстэй ба дунд илтэс хажуугийн илтсээс 2 дахин том, доод уруул дээд уруулаас 2 дахин богино. Дохиурын шилбэнүүд дунд хэсгээрээ наалдамхай үслэгтэй. Тоосовч сормослиг үслэгтэй. Самранцар хар өнгөтэй, өндгөрхүү хэлбэртэй, товруурхаг гадаргатай [1,3,5].

**Тархац, ургах орчин:** Хятад, Японд тархана. Монголд: Дорнод Монголын тойрогт элс, хайргархаг голын эргээр ургадаг [2,4]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Хээрийн түймэр, бэлчээрийн талхагдалт болон эмийн зориулалтаар ашиглаж байгаагаас устаж болзошгүй ургамал.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэж, ашиглалтыг хязгаарласан. Зэрлэг амьтан ба

ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад бүртгэгдсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж, нутагшуулах, тарьж ургуулах аргыг боловсруулж, тарималжуулах, түймрээс хамгаалах, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, малын бэлчээрээс чөлөөлөх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Дариймаа нар, 2009, 3. Чернева, 1970, 4. CITES-ийн хавсралт, 5. Flora of China volume 17.

## 94. ПАУЛСЫН ГҮҮНХӨХ



*Scutellaria Paulsenii* Briq.

*Magnoliophytina*

**Овог.** *Мажтан [Уруулцэцэгтэн] - Lamiaceae [Labiatae Juss.]*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Модожсон нарийхан үндэслэг иштэй, заримдаг сөөгөнцөр. Иш дэлхэж ургасан, нэлээд мөчирлөг, иш мөчрүүд урт ба богино налчгар юмуу сэрэвгэр үсэрхэг. Навч өндгөрхүү, нэг талдаа 3-4 мохоо шүдлэгтэй, мохоо оройтой, бариул болон навчны суурь орчимд урт үсэрхэг. Навчны дээд гадаргуу сийрэг буржгар үслэгтэй, доод гадаргуу тод судалтай. Цэцгүүд иш, мөчрийн үзүүрт байрлан богино түрүүрхүү баг цэцэг үүсгэнэ. Цэцгийн дагавар навч өндгөрхүү хэлбэртэй, цайвар шаргал өнгөтэй, төв хэсэгтээ ягаавтар туяатай, бүтэн захтай, ирмэгээрээ урт сормослиг, бусад хэсгээрээ урт богино холилдсон үсэрхэг. Дэлбэ цайвар шар өнгөтэй, 3.5 см хүртэл урт, дээд уруулдаа ягаан толботой, гадна талдаа үсэрхэг [1,3,4].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Монгол Алтайн тойрогт Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутаг Булган голын эхээр тохиолдоно. Өндөр уулын бүслүүрт голын эрэг, хуурай гольдрол, хайрга чулуутай нугархаг хажуу дагаж ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай [2,5].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Уур амьсгалын өөрчлөлт болон бэлчээрийн талхагдалтаас байгалийн нөхөн сэргэлт удааширч байгаа устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад бүртгэгдсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, тарьж ургуулах аргыг боловсруулж, турших, тохиромжтой нутагт нутагшуулах, тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Лигаа нар, 2009, 3. Чернева, 1970, 4. Флора СССР., 1954, Т.20, 5. CITES-ийн хавсралт.

## 95. НҮЦГЭН МИЙНХУМС



*Nepeta nuda* L.

*Magnoliophytina*

**Овог.** Мажтан [Уруулцэцэгтэн] - *Lamiaceae* [*Labiatae* Juss.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Модожсон мөчирлөг үндэслэг иштэй, олон наст өвс. Иш 50-120 см өндөр, эгц босоо, бадриун, энгийн юмуу салаалж мөчирлөсөн. Навч 3-7 см урт, өндгөрхүү юмуу уртавтар өндгөрхүү хэлбэртэй, зүрхэрхүү суурьтай, мохоо шүдлэг захтай. Цэцгүүд иш мөчрийн үзүүрт байрлан залаа баг цэцэг бүрдүүлдэг. Дагавар навч, шугаман юмуу шугамархуу-юлдэн хэлбэртэй, цайвар ногоон юмуу хөхөвтөр өнгөтэй. Дэлбэ цайвар ягаан өнгөтэй. Дэлбийн дээд уруул эгц, оньтой, доод уруул дээдхээс урт ба дундах салбан хажуугийнхаас 3-4 дахин өргөн. Самранцар бор өнгөтэй, гөлгөр гадаргуутай [1,3,4,6].

**Тархац, ургах орчин:** Казакстан, Киргизстан, Орос, Тажикстан, Европт тархана. Монголд: Ховдын тойрогт тохиолдоно. Нугат хээр, задгай хажуу газраар ургадаг. Тархац маш хязгаарлагдмал [5].

**Үржил:** Үрээр болон ургал эрхтэний оролцоотойгоор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч нарийвчлан тогтоогоогүй. Нугат хээр хуурайшиж хатах, мал бэлчээрлэлтээс шалтгаалан устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад тус тус бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологи, экологийн онцлогийг нарийвчлан судалж, зориудаар өсгөн үржүүлэх, хамгаалалтыг сайжруулж, зориудаар суулгаж, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Лигаа нар, 2009, 3. Чернева 1970, 4. Флора СССР, 1954, Т.20, 5. CITES-ийн хавсралт, 6. Flora of China volume 17.

**96. НУГЫН ТУЙПЛАНЦАР**



***Phlomoides pratensis*** [Kar. et Kir.] Adyl., R.Kam. et Machm.

*Magnoliophytina*

**Овог.** Мажстан [Уруулцэцэгтэн] - *Lamiaceae* [*Labiatae* Juss.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Богиноссон үндэслэг иштэй, олон наст өвс. Иш 40-60 см өндөр, эгц босоо, дээд хэсгээрээ мөчирлөсөн. Навч зүрхэрхүү, өндгөрхүү хэлбэртэй, мохоо шүдлэг захтай, бариултай. Цэцгүүд тойруулган байрлаж, дээд хэсэгтээ ойртсон доод хэсэгтээ хоорондоо алслагдсан түрүүрхүү баг цэцэг үүсгэдэг. Дагавар навч цоморлигтой тэнцүү юмуу богино. Цоморлиг хоолойрхуу тод судалтай, судлаа дагасан, шүдлэгүүд оньтой, ониноос гарсан хурц өргөслөг. Дэлбэ ягаан, цоморлигоос 1.5-2 дахин урт. Дохиурууд дэлбээс цухуйгаагүй, түүний шилбэ төгсгөлдөө урт годой хэлбэрийн унжлагатай. Үр боловсрох орны амсар тэнцүү биш 2 салбантай. Самранцар оройдоо нүцгэн [1,3,4,6].

**Тархац, ургах орчин:** Казахстан, Киргизстанд тархана. Монголд: Ховдын тойрогт Баян-Өлгий аймгийн Бугат сумын нутаг Хатуу голын эх орчмоор тохиолдоно. Өндөр уулын хээрт, уулын мод, сөөгөрхөг бүслүүрт, ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай [2,5].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Уур амьсгалын өөрчлөлт болон бэлчээрийн талхагдалтын хүчин зүйлийн улмаас устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг

олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад бүртгэгдсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судлан тогтоож, зориудаар ургуулах аргыг боловсруулж турших, ургах орчны нөхөн сэргэлтийг дэмжих, тохиромжтой газарт нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Лигаа нар, 2009, 3. Чернева, 1970, 4. Флора СССР, 1954, Т.21, 5. CITES-ийн хавсралт. 6. Flora of China volume 17.

## 97. МОНГОЛ ТУЙПЛАНЦАР



*Phlomooides mongolica* [Turcz.] R.Kam. et A.Budantz.

Magnoliophytina

**Овог.** Мажтан [Уруулцэцэгтэн] - Lamiaceae [Labiatae Juss.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Модожсон үндэслэг ишгэй, олон наст өвс. Иш 15-70 см өндөр. Үндэс орчмын навчны илтэс гурвалжин, зүрхэрхүү суурьтай, гүдэн шүдлэг захтай, мохоо оройтой. Цэцгүүд тойруулган байрлаж, хоорондоо зайтай түрүүрхүү баг цэцэг үүсгэдэг. Дагавар навч матигар, шугамархуу, цоморлигтой тэнцүү, хатуу, сормослиг ба өргөслөг оройтой. Цоморлиг хоолойрхуу. Цоморлигийн шүдлэг дугариг оройтой, захаараа үсэрхэг. Дэлбэ ягаан. Хойд дохиурын шилбэний төгсгөлд годой хэлбэрийн 2 богино унжлагатай [1,3,4].

**Тархац, ургах орчин:** Хятад, Өвөр Монголд тархана. Монголд: Хянган, Дорнод Монголын тойрогт тохиолдоно. Хээр, уулын хээржүү хажуу, сайрын ёроол, хад цохионд ургана [4].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ой хээрийн түймэр, бэлчээрийн талхагдалт, эмийн зориулалтаар ашиглах, хуурайшилт зэргээс шалтгаалан ургах орчны доройтолд орсноос устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, зориудаар тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулж, эмийн зориулалтаар ашиглахыг хязгаарлан зогсоож, үндсэн тархац нутгийг малын бэлчээрээс чөлөөлөх, ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Лигаа нар, 2009, 3. Чернева, 1970, 4. Flora of China volume 17.

## 98. ЦӨЛИЙН МҮГВАА



*Salvia deserta* Schangin

*Magnoliophytina*

**Овог.** *Мажтан* [Уруулцэцэгтэн] - *Lamiaceae* [*Labiatae* Juss.]

**Статус:** Нэн ховор ургамал.

**Таних шинж:** 45-80 см өндөр, олон наст өвс. Үзүүр хэсэгтээ мөчирлөсөн, эгц босоо, хэд хэдэн иштэй. Навч 5-9 см урт, уртавтар өндгөрхүүгээс уртавтар хүртэл хэлбэртэй, зүрхэрхүү суурьтай, шовх оройтой. Баг цэцгийн доор 6-8 хосоороо байрладаг. Цэцгийн тойруулгууд 6-10



цэцэгтэй. Цэцгийн дагавар навч өндгөрхүү, ягаавгар өнгөтэй, сормослог захтай. Дэлбэ хөх ягаан өнгөтэй, дээд уруул оньтой. Доод уруулын дундах салбан өргөн, тонгоруу өндгөрхүү хэлбэртэй, хажуугийнхаас том. Дохиур 2. Самранцар гурвалжин бөмбөлөгөрхүү юмуу гурвалжин-өндгөрхүү хэлбэртэй, хар хүрэн өнгөтэй [1,3,4,6].

**Тархац, ургах орчин:** Казахстан, Киргизстан, ОХУ-д тархана. Монголд: Ховдын тойрогт тархана. Хээрийн бүсэд нуга, уулын хажуу, ойн зах, голын эргээр ургана [1,2,5].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Бэлчээрийн талхагдалт, цөлжилт, хуурайшилт болон эмийн зориулалтаар бэлтгэж байгаагаас устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж хамгаалсан. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад бүртгэгдсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, зориудаар тарьж ургуулах аргыг боловсруулж туршин, байгалийн нөхөн ургалтыг дэмжих, тохиромжтой газарт нутагшуулах, холбогдох хуулийн дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг зогсоох, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Лигаа нар, 2008, 3. Чернева, 1970, 4. Флора СССР, 1954, Т.21, 5. CITES-ийн хавсралт, 6. Flora of China volume 17.

## 99. ЦӨЛИЙН ГАНГА



*Thymus mongolicus* [Ronn.] Ronn.

*Magnoliophytina*

**Овог.** *Мажтан* [Уруулцэцэгтэн] - *Lamiaceae* [*Labiatae* Juss.]

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Иш мөлхөө юмуу өндиймэл, үрлэх мөчир /1,5/ 2-10 см өндөр, 2-4 навчтай. Навчны илтгэс өндгөрхүү, шаантган суурьтай, бүтэн захтай юмуу 1-2 шүдлэгтэй, мохоо юмуу бага зэргийн шовх оройтой. Толгойрхуу хэлбэрийн баг цэцэгтэй. Дагавар навч 1/3 хүртлээ сормослиг захтай. Цоморлиг хоолойрхуу-хонхорхуугаас нарийхан хонхорхуу болсон. Дэлбэ ягаавтар улаан. Самранцар зууван бөмбөлөгөрхүү юмуу зууван өндгөрхүү хэлбэртэй [1,3,4,6].

**Тархац, ургах орчин:** Хятад, Өвөр Монголд тархана. Монголд: Говь-Алтайн тойрогт Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Богд сумын нутаг Бага Богд ууланд тохиолдоно. Чулуурхаг хажуу, байц цохио, хад, сайрт ургадаг хязгаарлагдмал тархацтай [2,5].

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Үндсэн тархац нутагт мал сэлгээгүйгээр бэлчээрлүүлэх, хөрсний хуурайшилтаас ховордож байгаа устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад бүртгэгдсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөцийг тогтоож, тохиромжтой газар, зориудын орчинд тарьж ургуулах, шилжүүлэн суулгах, тархац нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, мал бэлчээрлэлтийг хязгаарлан зогсоож, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Даариймаа нар, 2009, 3. Чернева, 1970, 4. Флора СССР, 1954, Т.21, 5. CITES-ийн хавсралт, 6. Flora of China volume 17.

100. ГОВЬ-АЛТАЙН ГАНГА



*Thymus gobi-altaicus* [Ulzij.] R.Kam. et A.Budantz.

Magnoliophytina

**Овог.** Мажстан [Уруулцэцэгтэн] - Lamiaceae [Labiatae Juss.]

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Дэлхэж ургадаг заримдаг сөөгөнцөр. Цэцэглэх мөчир үсээр хучигдмал. Ишний навч ба дагавар навч уртассан юлдэн хэлбэртэй. Навчны бариул захаараа өтгөн сормослигтой. Цэцгүүд толгойрхуу өтгөн баг цэцэг үүсгэдэг. Цоморлиг өтгөн үслэгээр бүрхэгдсэн. Дэлбэ ягаан өнгөтэй, 7 мм орчим урт. Дохиур 4, дэлбээс цухуйсан. Самранцар бор шаргал өнгөтэй, бөмбөлөгөрхүү хэлбэртэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Говь-Алтайн тойрогт тэмдэглэгдсэн. Өмнөговь аймгийн нутаг Говь-Алтайн нуруу, Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Арц Богд ууланд ургадаг, нэн хязгаарлагдмал тархацтай [2]. Хад, нуранга хажуу хээржүү ургана.

**Үржил:** Үрээр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Хуурайшилт, бэлчээрийн талхагдалт зэрэг шалтгаанаас устах аюулд орсон унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Уг ургамлыг хамгаалах тодорхой арга хэмжээ аваагүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөц, тархацыг тогтоож, үндсэн тархац нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалах, байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлж, мал бэлчээрлүүлэхийг зогсоож,

бэлчээрийг тодорхой хугацаагаар өнжөөх, зориудаар тарьж ургуулах аргыг ургах орчинд нь боловсруулж турших, нэн ховор ургамлын жагсаалтад яаралтай оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бюл. Моск. общ. испыт. прип., отд. биол. 1990.95. 3:97, 2. Губанов, 1996. 3. Камелин, Буданцев, 1990.

## 101. ТАНАМАЛ МАХИРС



*Lycium truncatum* Y.C.Wang.

*Magnoliophytina*

**Овог.** Чэсэнцэртэн - *Solanaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 1-1.5 метр өндөр, цөөн тооны урт өргөстэй, мөчир шулуун сөөг. Эгц дээш ургадаг, зэгэл саарал юмуу зэгэл шарга өнгөтэй. Навч юлдэрхүү, тод гүвгэр судалтай, шовх оройтой. Цэцэг бүдэг ягаан. Дэлбэ хадаасархуу, цоморлигоосоо урт, нарийхан хоолойтой дохиур дэлбээсээ урт. Жимс тод улаан, дугуй өндгөрхүү хэлбэртэй. Жимсний үзүүр тайранхай мэт тэгш юмуу хонхортой. 8 болон 9-р сард цэцэглэдэг [1].

**Тархац, ургах орчин:** Хятад, Өвөр Монголд тархана. Монголд: Дорноговь /Галбын говь Алашааны говь [Борзонгийн говь]-д тархсан. Хужирлаг элс, элсэрхэг–хайргархаг цөл, эргийн хайрга, сайрын элс хайргатай ёроолоор дэрс хармагтай холилдон ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай [2].

**Үржил:** Үрээр, богино үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Цөлжилт, гангийн олон жилийн давтагдал, бэлчээр ашиглалтаас шалтгаалан устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, зориудаар тарьж үржүүлэх, тохиромжтой газарт нутагшуулах, үндсэн тархац нутагт мал бэлчээрлүүлэхийг тодорхой хугацаагаар өнжөөх, ховор ургамлын жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996.

## 102. ТӨВД ЛАНЦАЙ



*Lancea tibetica* Hook.fil . et Thoms.

Magnoliophytina

**Овог.** Иршумбэтэн - *Scrophulariaceae* Juss.

**Статус:** Нэн ховор, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Нарийн шидмэсэрхүү үндэслэг иштэй, олон наст өвслөг ургамал. Иш энгийн, эгц босоо, 2-7 см өндөр. Навч зузаавтар, тонгоруу өндгөрхүү юмуу зууван хэлбэртэй. Ишэн дээрээ 2-5 хосоор сууж байрладаг. Цэцэг 1.5 см голчтой, богино шилбэтэй. Ишний оройд 1-5-аараа байрлана. Дэлбэ өтгөн ягаан юмуу улаавтар хөх өнгөтэй [2,5,7].

**Тархац, ургах орчин:** Төвд, Цинхай, Гималай, Баруун хойд, өмнөд Хятадад тархана. Монголд: Хангайн урд Тамирын голын хөндий, Хөвсгөлийн Түнэл сумын Зуны голд маш ховор тохиолдоно. Гол горхины эрэг, цахилдагт хужирлаг нугад ургана [1,4].

**Үржил:** Үр, үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Бэлчээрийн хэт талхагдалт, эмийн зориулалтаар хууль бусаар бэлтгэж ашиглах болон ургах орчны доройтлоос шалтгаалан устах аюулд орсон үлдвэр ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, Монгол улсын улаан ном /1987,1997/, Монголын ургамлын улаан дансанд [6] тус тус бүртгэж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судлан тогтоож, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад цаг алдалгүй хамруулж, нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, тохиромжтой газарт нутагшуулах, тарьж ургуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа нар, 2008, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012, 7. Санчир, Ганболд, 1972, 8. Санчир, 1978.

### 103. ШӨМБӨГӨР ХУВИЛАНГА



*Pedicularis proboscidea* Stev.  
*Magnoliophytina*

**Овог.** *Иршимбэтэн - Scrophulariaceae Juss.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Богиноссон үндэслэг иштэй, нарийхан сахлаг үндэстэй, олон наст өвслөг ургамал. Иш эгц босоо бадриун гялалзсан өнгөтэй. Үндэс орчмын навч бариултай, илтэс юлдэрхүү, өдлөг цуулбар, далавч бүхий гол тэнхлэгтэй. Ишний навч цувраа байрлалтай, улмаар жижгэрч бүтэн болдог. Баг цэцэг бортгорхуу, цэцгийн дагавар торлог сэгсгэр үслэгтэй, шугамархуу. Дэлбэ шар, богино шулуун хоолойтой, хадуурархуу хэлбэртэй, нуруун тал дугуйдуу дуулгатай. Ирмэгээрээ сэгсгэр, үслэгтэй, нарийссаар урагш чиглэсэн шонтон болно. 2 дохиурын шилбэ сэгсгэр үслэгтэй. Хонхорцог өндгөрхүү, богино сортой [3].

**Тархац, ургах орчин:** Алтай болон Зүүнгарын Тарвагатайгаар тархана. Монголд: Монгол Алтайн тойргийн Бурхан буудайн өвөр талаар өндөр уулын нуга, нугархаг хажуугаар ургадаг [1,2].

**Үржил:** Үр болон ургал эрхтний оролцоотойгоор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй, бэлчээрийн хэт талхагдалт, хуурайшилт, ширүүн аадар бороо, мөндрөөс улбаалсан усны үер, хүчтэй шуурга зэрэг байнга тохиолддог байгаль цаг уурын нөлөөгөөр тархацын хүрээ хумигдаж, нөөц хомсдож байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг судлан тогтоож, тарьж ургуулах, туршилт судалгаа явуулж, зориудаар үржүүлэх, тохиромжтой газарт нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Флора СССР, 1955, Т.22.

104. БАВГАРТҮРҮҮТ ХУВИЛАНГА



*Pedicularis dasystachys* Schrenk

*Magnoliophytina*

**Овог.** *Иршимбэтэн* - *Scrophulariaceae* Juss.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Богиноссон бүдүүн үндэслэг иштэй, олон наст өвслөг ургамал. Иш 10–30 см өндөр ганц нэгээрээ юмуу хэд хэдээрээ, эгц босоо, салаалж мөчирлөөгүй, баг цэцэг дороо сэгсгэр үслэгтэй. Үндэс орчмын навчис өдлөг хагалбар, богинохон бариултай, илтэс уртавтар, өндгөрхүү хэлбэртэй, нүцгэн, зөвхөн судлаараа үслэгтэй. Харин ишний навчис өндгөрхүү уртавтар, богино бариултай, тойруулган байрлалтай бөгөөд үзүүр хэсгийнх бүтэн. Баг цэцэг нягт, бараг толгойрхуу хэлбэртэй, үрлэх үедээ 15 см хүртэл уртасч сийрэг болдог. Цэцгийн дагавар шугамархуу, цомирлогоосоо урт. Цомирлог өргөн хонхорхуу, үл мэдэг цүндгэр, шүдлэг хоолойноосоо 2 дахин богино. Дэлбээ тод ягаан юмуу цагаан өнгөтэй, дуулга гохорхуу матигар, дуулгынхаа тэнхлэгтэй зэрэгцээ чиглэл бүхий 2 шүдтэй. Доод уруул дуулганаасаа үл мэдэг урт. Хонхорцог өндгөрхүү, сортой [3].

**Тархац, ургах орчин:** Евразид тархана. Монголд: Монгол Алтайн тойргийн хээржүү болон голын эргээр ургана [1,2].

**Үржил:** Үр болон ургал эрхтгнээрээ ургах боломжтой.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй, цаг уурын хуурайшилт, малын бэлчээрийн талхагдалтаас устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар



тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, болон нөхөн сэргэлтийн биологийг судалж, үр, ургал эрхтэнээр үржүүлэх аргыг боловсруулж, тарьж ургуулах, нутагшуулах, үндсэн тархац нутгийг орон нутгийн хамгаалалтад авч хамгаалах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Флора СССР., 1955, Т.22.

## 105. ФЕДДИЙН АРГАМЖИНЦЭЦЭГ



*Cistanche ningxidensis* Ma et Zhan.

*Magnoliophytina*

**Овог.** *Гувшаахайтан - Orobanchaceae Vent.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** 15-30 см өндөр иштэй, 10-20 см урттай баг цэцэг бүхий олон наст, шимэгч ургамал. Ишний голч 1-2 орчим см бүдүүн, ихэнх хэсэг газрын доор ургана. Ишний ёзоор бага зэрэг бүдүүн, ишин дээрх хайрс нарийн гонзгойвгор, хүрэн, ишиндээ нягт наалдсан байна. Цэцэг хоолойрхуу хонхон хэлбэртэй, цайвар шаргал, цоморлиг шугамархуу юлдэн, жигд бус шүдлэг дөрвөн салбантай. Цацаг баг цэцэгтэй. Хонхорцог дээд талдаа нээгдэгч хоёр хавгастай. Үр бөөрөнхий, жижиг, барзгар гадаргатай [1].

**Тархац, ургах орчин:** Өвөр Монголд тархана. Монголд: Дорноговь, Алашааны говьд тархсан. Элсэн хөрсөнд ургасан хармаг, загийн үндэснээс шимэгчлэнэ. Нэн хязгаарлагдмал тархацтай [2].

**Үржил:** Үндэслэг ишээр түргэн ургадаг, үрээр удаан үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Цөлжилт, хуурайшилт, ишийг эмийн зориулалтаар хууль бусаар бэлтгэх, заг, хармагийг их хэмжээгээр түлшинд хэрэглэснээс тэдгээрийн ургах орчин доройтож, тархац нутаг хумигдах зэрэг шалтгаанаар устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, ургах орчныг олж, тохиромжтой газарт нутагшуулах, зориудаар тарьж ургуулах, тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулж, хамгаалалтыг сайжруулж, хууль бус ашиглалтыг зогсоох, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996.

## 106. ЦӨЛИЙН АРГАМЖИНЦЭЦЭГ



*Cistanche deserticola* Ma

*Magnoliophytina*

**Овог.** *Гувшаахайтан - Orobanchaceae Vent.*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Ургамлын нийт урт 50-150 см, баг цэцгийн өнгө цайвар ягаан, дэлбэний гадагш эргэсэн ирмэгийн өнгө мэдэгдэхүйц тод, газар дээрх хэсгийн хайрс урт, харьцангуй

чөлөөтэй байрласан учир хатсаны дараа өргөс хэлбэртэй болдог. Цэцгийн тоо хэдэн зуу хүрнэ. Ишний хайрс өргөн, суурьтаа нягт. Цэцгийн цоморлиг дэлбэнээсээ 2-3 дахин богино. Дэлбийн хоолой болон доод уруулын гадна тал үсэрхэг [1,3].

**Тархац, ургах орчин:** БНХАУ-д тархана. Монголд: Дорноговь, Галбын говь, Алтайн өвөр говийн Хар загийн хоолой, Зүүн гарын говийн Баруун хуурайн хотгор, Олон нуурын хөндийн Улаан нуурын хотгор, Баян заг, Эргийн загт тохиолдоно. Элсэн хөрсөнд ургасан загийн үндэснээс шимэгчлэн 4-5-аараа эгнэн амьдардаг [2].

**Үржил:** Үндэслэг ишээр түгэн ургадаг ч үрээр удаан үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Ишийг эмийн зориулалтаар хууль бусаар бэлтгэх, загийг түлшинд хэрэглэх, цөлжилт, бэлчээрийн талхагдалт, ургах орчны доройтол зэрэг шалтгаанаар устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд [4] тус тус бүртгэж ашиглалтыг хориглосон. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, нөхөн сэргэх биологийг нарийвчлан судалж, тохирсон нөхцөл, хөрс, загтай газарт зориуд тарьж ургуулах, цөлийн аргамжин цэцэг бүхий заг, хармагийн төгөл бүхий газрыг тусгай хамгаалалтад авах, үндсэн газрыг нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Монгол улсын улаан ном, 1997, 4. Монголын ургамлын улаан данс..., 2012.

107. ЭГЭЛ ТОСОНДОЙ



*Pinguicula vulgaris* L.

*Magnoliophytina*

**Овог.** Бөмбөөхэйтэн - *Lentibulariaceae* Rich.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Богинохон үндэслэг иштэй. 5- 15 см өндөр, шавжаар хооллодог олон наст. Навч суумал, уртавтар зууван, мохоо оройтой, нарийссан суурьтай. Навчны дээд гадаргуу тод ногоон, булчирхайтай, үндэс орчимдоо олноороо дэвсэж байрладаг. Цэцэглэх иш ганц нэгээрээ юмуу хэд хэдээрээ 5-17 см өндөр, эхний үедээ битүү жижиг булчирхайт үслэгээр бүрхэгдсэн байдаг. Дэлбэ хөх ягаан, годойн хамтдаа өргөн хоолойрхуу, годой зүүрхүү бөгөөд мохоо. Цомирлог 3-4 мм урт, сийрэг богино булчирхайтай. Цомирлогийн салбан өндгөрхүү юмуу уртавтар зууван. Цэцгүүд гудайж байрладаг. Хонхорцог бараг бөмбөлөг хэлбэртэй, 4 мм голчтой [4].

**Тархац, ургах орчин:** Өмнөд Сибирыг тархана. Монголд: Хөвсгөлийн уулын тайгын тойргийн баруун хэсгээр, уулын голын нугаар ургадаг [1,2].

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ойн түймэрт өртөгдөж, тархац хумигдаж байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, үрээр үржүүлэх, ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 1997, 4. Малышев, Пешкова, 1979.

## 108. САРЖЕНТЫН БҮРЭЛГЭНЭ



*Viburnum sargentii* Koehne

*Magnoliophytina*

**Овог.** Даланхальстан – *Caprifoliaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Салаалж мөчирлөсөн 2-3 метр өндөр, сөөг. Мөчир хүрэн, саарал, залуудаа бор шарга, улаан өнгийн холтостой. Ихэвчлэн өндгөрхүү, өргөн өндгөрхүү хэлбэртэй, сарвуулаг хагалбар, судлаараа үсэрхэг. Цэцэглэдэг мөчрийн навч бүтэн, зууван, дээд гадаргуу хар ногоон, доод гадаргуу үсэрхэг цайвар ногоон. Цайвардуу өнгийн 5-7 мм голчийн дэлбэтэй цэцгүүд хэд хэдээрээ нэгдэн нийлмэл шүхэр баг цэцэг үүсгэнэ. Улаан шар өнгийн жимс 7-9 мм өргөн, бөмбөлөг хэлбэртэй [1,2,6,7].

**Тархац, ургах орчин:** Дорнод Сибирь, Алс Дорнод, Хятадын зүүн хойт хэсэг, Солонгос, Япон, Төвдөд тархана. Монголд: Хянганы тойрогт ургана. Навчит холимог ой, түүний цоорхой, сөөгөн ширэнгэ бүхий уулын хажуу, голын хөндийн ой, ширэнгэд ховор тохиолдоно [2,7]. Нэн хязгаарлагдмал тархацтай [3].

**Үржил:** Үр, ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Ойн түймрээс шалтгаалан устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном /1987,1997/, Монголын ургамлын улаан дансанд [5] тус тус бүртгэж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг нарийвчлан судалж, зориудаар тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. БНМАУ-ын улаан ном, 1987, 2. Грубов, 1982 3. Губанов, 1996, 4. Лигая.У нар, 2008, 5. Монголын ургамлын улаан данс., 2012, 6. Пояркова, 1958.

## 109. МОНГОЛ БҮРЭЛГЭНЭ



*Viburnum mongolicum* [Pall.] Rehd.

*Magnoliophytina*

**Овог.** Даланхальстан – *Caprifoliaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Салаалж мөчирлөсөн, 1-1,5 см өндөр, сөөг. Мөчрүүд цайвар холтостой, залуу мөчир, навч одорхуу хэлбэрийн үсэнцэртэй, хүрэн холтостой. Навч богино бариултай, өндгөрхүү юмуу зууван хэлбэртэй, илтэс шүдлэг ирмэгтэй. Нарийн хоолой хэлбэрийн цайвар

шар өнгийн дэлбэтэй цэцгүүд нийлж шүхэр хэлбэрийн баг цэцэг үүсгэнэ. Үр жимс эхэн үедээ улаан, бүрэн боловсрохдоо хар өнгөтэй болдог [2,5].

**Тархац, ургах орчин:** Дагуур, Умард Хятадад тархана. Монголд: Монгол Дагуурын Угтам, Түмэн Цогт уул, Хянганы тойрогт ховор тохиолдоно. Уул толгодын чулуурхаг хажуу, байц, цохио хадны ангалд ургана [2,7].

**Үржил:** Ургал эрхтэн болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Ой хээрийн түймэр, хуурайшилтаас ургах орчин өөрчлөгдөж, тархац нутаг хумигдан, устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монгол улсын улаан ном /1987,1997/, Монголын ургамлын улаан дансанд [6] тус тус бүртгэж, тархац нутгийг хэсэгчлэн улсын тусгай хамгаалалтад авч хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, үрээр тарьж ургуулах аргыг боловсруулж турших, нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. БНМАУ-ын улаан ном, 1987, 2. Грубов, 1955, 3. Губанов, 1996, 4. Лигаа.У нар, 2008, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Монголын ургамлын улаан данс., 2012, 7. Пояркова, 1958, 8. Санчир, 1987.

## 110. ЗЭНТГЭР БАМБАЙ



*Valeriana capitata* Pall. ex Link

*Magnoliophytina*

**Овог.** Бамбайн овог - *Valerianaceae* Batsch.

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Урт мөлхөө үндэслэг иштэй. Эгц дээшээ босоо иштэй, ишний үе дээрээ богино ширүүн үслэгтэй. Навч нүцгэн, үндэс орчмын болон ишний доод хэсгийн навч бүтэн, өндгөрхүү юмуу зууван хэлбэртэй, бүтэн ирмэгтэй юмуу бага зэрэг шүдлэгтэй. Урт бариултай. Харин ишний дунд, үзүүр хэсгийн навч суумал бөгөөд гурвалсан хагалбар юмуу цуулбар, дунд хэсгийн салбан хоёр хажуугийн салбангаасаа хэд дахин урт байдаг. Цэцгүүд нийлж толгойрхуу баг үүсгэн байрладаг. Дэлбэ цагаан юмуу цайвар саарал өнгөтэй. Үр жимс нүцгэн [3,4].

**Тархац, ургах орчин:** Баруун, Дунд Сибирыг тархана. Монголд: Хөвсгөлийн тойрогт тохиолдоно. Өндөр уулын бүслүүрт чулуурхаг тундр, хүлрийн хөвдөг намаг, сийрэг шинэсэн ой, сөөгөн дунд, горхийн эрэг, чулуурхаг хажуугаар ургадаг [1,2].

**Үржил:** Үндэс болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Ойн түймэрт нэрвэгдэх, бэлчээрийн малын хөлд гишгэгдэж гэмтэх, ширүүн мөндөрт цохигдон цэцэг юмуу дутуу боловсорсон үр унаж сарних зэрэг шалтгаанаар устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг шинэчлэн тогтоож, зориудаар үржүүлэх аргыг боловсруулж, турших, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Раст. Цент. Сибири, 1979.

111. САЙХАНЫ БАМБАЙ





*Valeriana saichanensis* Kom.

*Magnoliophytina*

**Овог.** Бамбайтан – *Valerianaceae* Batsch.

**Статус:** Нэн ховор, унаган ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Иш 10-25 см, хааяа 45 см өндөр. Нимгэн зөөлөн навчтай. Үндэс орчмын ба ишний уг хэсгийн навч урт бариултай, өндгөрхүү хэлбэрийн илтэстэй, бүтэн юмуу хос маш жижиг хажуугийн салбанцартай. Баг цэцэг нягт бамбайрхуу, Үрлэх үедээ залаархуу болдог [1].

**Тархац, ургах орчин:** Монголд: Говь-Алтайн тойрогт тэмдэглэгдсэн байна. Тагийн нуга, дэнж, хад асгатай газраар ургадаг [2].

**Үржил:** Үрээр ба үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Уур амьсгалын өөрчлөлт, нөлөөлөл бэлчээрийн ашиглалтаас шалтгаалан устах аюулд орсон унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, зориудаар тарьж ургуулах, туршилт, судалгааг хийж, үр дүнг тохиромжтой газарт нэвтрүүлэх, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Грубов, 1982, 2. Губанов, 1996, 3. Лигаа нар, 2008, 4. Монголын ургамлын улаан данс..., 2012.

## 112. ХАНГАЙН ХОНХЛОЙ



*Adenophora changaica* Gubanov et. R.Kam.

*Magnoliophytina*

**Овог.** Хонхонцэцэгтэн – *Campanulaceae* Juss.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Хөндлөн үрчлээстэй саарал хүрэн бүдүүн үндэстэй. Энгийн, цэх, нилээд навчлаг, 50 см орчим өндөр иштэй, олон наст өвс. Бүх навчис цувраа байрлалтай, ишний доод хэсгийн навчис өндгөрхүү-юлдэн, хөрөөлөг том шүдтэй, мэдэгдэхүйц бариултай, дунд хэсгийн навчис юлдэрхүү, хоорондоо зайтай байрласан шүдлэг юмуу бараг бүтэн захтай, ишний үзүүр хэсгийн навчис шугамархуу юлдэн, суумал. Ялимгүй унжсан 7-8 цэцгээс тогтсон сийрэг баг цэцэгтэй. Цоморлиг нарийн гурвалжин шүдтэй. Цэцгийн дэлбэ 20 мм хүрэхүйц урт, хонхорхуу, тод хөх, нил, багана дэлбээнээсээ нилээд урт [3,4].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хангай /Урд Тамирын хөндий/. Голын эрэг дагуух хуурай хажуугаар ургадаг [1,2].

**Үржил:** Үр болон үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, нарийвчлан тогтоогоогүй. Бэлчээрийн талхагдлаас шалтгаалан устах аюулд орж байгаа унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолын хавсралтад ховор зүйлээр бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг нарийвчлан тогтоож, зориудаар тарьж ургуулах ажлыг цаг алдалгүй зохион байгуулах, тохиромжтой газарт нутагшуулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, үндсэн тархац нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд холбогдох хуулийн дагуу хариуцуулан хамгаалуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Губанов, Камелин, 1988, 4. Лиганар, 2009.

### 113. ЗОГДОРГОНОРХУУ СҮҮН ОРХООДОЙ



*Codonopsis clematidea* [Schrenk] Clarke.

*Magnoliophytina*

**Овог.** Хонхон цэцэгтэн - *Campanulaceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Дунд хэсэгтээ бүдүүрсэн урт, голлосон үндэстэй. Мохоо өнцөглөг иштэй, 1 м өндөр, олон наст өвслөг ургамал. Навч өндгөрхүү юмуу гонзгойвгор-өндгөрхүү, бүтэн ирмэгтэй, богино үсэнцэрээр хучигдсан байна. Цэцэг цайвар юмуу хөвхөр, өргөн хонхорхуу,

цоморлигоосоо 2 дахин урт, үр жимс дээд талаасаа гурван хавтасаар нээгддэг гэрцэг [2,3].

**Тархац, ургах орчин:** Афганистан, Иран, Казахстан, Киргизстан, ОХУ, Пакистан, Тажикстан, Энэтхэгт тархана [3]. Монголд: Монгол Алтай тойрогт. Уулын жижиг гол, горхийн эрэг, булаг шандын хажуугаар ургадаг [1].

**Үржил:** Үрээр үржинэ. Үндэсний хүзүүний нахианаас нөхөн сэргэнэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Үндсийг эмийн зориулалтаар түүж ашиглах, удаан хугацаагаар мал бэлчээрлүүлж, бэлчээрийг талхагдалт оруулах, олон жилийн гангаас гол, горхи, булаг шанд ширгэж хатах зэрэг байгаль цаг уур, хүний үйл ажиллагаанаас шалтгаалан устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр бүртгэж, Монголын ургамлын улаан дансанд [3] тус тус оруулж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтын биологийг нарийвчлан судалж, зориудаар тарьж ургуулах, нутагшуулах, хууль бус ашиглалтыг зогсоож, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Губанов, 1996, 2. Лигаа, 1996, 3. Лигаа нар, 2008, 3. Монголын ургамлын улаан данс..., 2012.

## 114. ЗӨӨЛӨН ЛАВАЙ



*Asterothamnus mollusculus* Novopokr.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн – Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Заримдаг сөөгөн амьдралын хэлбэртэй. Угаасаа хүчтэй салаалж мөчирлөсөн, модожсон, 25-50 см өндөр иштэй. Залуу найлзуур ба навч ороолцолдсон ноосорхог үслэгтэй. Навч гонзгой-юлдэрхүү юмуу гонзгой, мохоо мөгөөрслөг үзүүртэй, зөөлөн, тачир буржгардуу үслэгтэй, цайвар саарал өнгөтэй. Ногоон, хэд хэдэн эгнээ ороолт навчинцараас тогтдог. Гадна талын ороолт навчинцар өндгөрхүү, дотор талынхаасаа богино, тачир үслэгтэй. Дотор талын ороолт навчинцар уртавтар захаараа хальслаг эмжээртэй. Сагс цөөн хэл ба хоолой цэцэгтэй, 6 хэл, 12 хүртэл хоолой цэцэгтэй, иш ба мөчрийн үзүүрт 1-3-аараа байрладаг. Гадна хүрээгээр байрлаж байгаа хуурамч хэл цэцэг цайвар ягаан. Үзүүртээ 3 шүдлэгтэй. Голын хос бэлэгтэй хоолой хэлбэрийн цэцэг шар. Цомцог цайвар шаргалдуу өнгийн энгийн үслэгтэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Дорноговийн тойрогт говийн улаан хурдас дээр ургадаг [2]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үндэс болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Цөлжилт, ургах орчны доройтол, хөрсний чийгийн хангамжийн хомсдлоос шалтгаалан устах аюулд бүрмөсөн орсон унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолын ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, биологи, экологийг судалж, зориудаар тарьж ургуулах туршилт судалгааг явуулж, тохиромжтой нутагт үржүүлэх, нутагшуулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, үндсэн тархац нутгийг орон нутгийн хамгаалалттай газар болгож хамгаалах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

115. ЭЛСНИЙ МӨНХЦЭЦЭГ



*Helichrysum arenarium* [L.] Moench

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн - Asteraceae Dumort.*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “үнэлэх боломжгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Модожсон үндэслэг иштэй, нягт дэгнүүл үүсгэдэг, эсгийрхэг цагаан үслэгтэй, олон наст өвс. Хэд хэдэн энгийн эгц босоо иштэй, 15-50 см өндөр, уг орчим нь үхсэн навчны үлдэгдлээр хучигддаг. Навч энгийн бүтэн. Ишний үзүүр, дунд хэсгийн навч юлдэрхүү шугаман юмуу шугаман, суумал бөгөөд дээшлэх тусмаа навч жижгэрдэг. Сагс олон цэцэгтэй, бөмбөлөг юмуу тонгоруу өндгөн хэлбэртэй, 4-8 мм голчтой шар өнгөтэй, ихэвчлэн олноороо нийлж, нягт юмуу сийрэг бамбай баг цэцэг бүрдүүлдэг. Ороолт гадна талаараа сэгсгэр үслэгтэй. Ороолт навчинцар олон эгнээ, цэцэглэлтийн сүүлчээр шар, ягаан, цайвар шар зэрэг өнгөтэй болдог. Гадна талын ороолт навчинцар тонгоруу өндгөрхүү юмуу зууван хэлбэртэй, дотор талынх нь өргөн юмуу уртавтар хүрээрхүү хэлбэртэй. Цомцог зөөлөн шаргалдуу юмуу цайвар шар өнгөтэй, дэлбэтэйгээ бараг тэнцүүхэн [1,5].

**Тархац, ургах орчин:** Евразид тархана. Монголд: Монгол Алтайн тойрогт уулын хээрийн бүслүүрийн хуурай үйрмэг чулуут болон хайргархаг хажуугаар ургана [2,3].

**Үржил:** Үрээр ба үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ургах орчны доройтол, бэлчээрийн талхагдалт болон эмийн зориулалтаар ашиглалт зэрэг шалтгаалан устах аюулд орсон.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор ургамлаар оруулж, Монголын ургамлын улаан дансанд тус тус бүртгэж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг нарийвчлан тогтоож, зориудаар тарьж ургуулах, эмийн зориулалтаар хууль бус ашиглалтыг таслан зогсоож, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003. 4. Мон. ур. улаан данс..., 2012, 5. Флора СССР, 1959, Т.25.

## 116. ХАЛХЫН-ГОЛЫН ТУНХУУ



*Chrysanthemum chalingolicum* Grub. [*Dendratherma chalingolicum* [Grub.]  
Gubanov et R.Kam.]

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн* – *Asteraceae Dumort.*

**Статус:** Нэн ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Салаалсан, нарийвтар үндэслэг иштэй олон наст өвс. Иш ихэвчлэн ганц нэгээрээ юмуу хэд хэдээрээ, эгц босоо юмуу өндиймөл, 15-25 см өндөр, үзүүр хэсгээрээ бага зэрэг салаалсан, сийрэг энгийн үслэгтэй. Навч цайвар ногоон, бага зэрэг богинохон налчгар үслэгтэй юмуу бараг нүцгэн, 1 см өргөн, богинохон бариултай. Навч энгийн өдлөг-цуулбар юмуу хагалбар, түүний салбанцар нарийн шугаман. Ишний уг хэсгийн навч энгийн өдлөг-хагалбар юмуу цуулбар, үзүүр хэсгийн навч бараг бүтэн. Төгсгөлийн салбан юлдэрхүү хэлбэртэй, хурц оройтой. Сагс 2-3 см голчтой, 1-3-аараа иш, мөчрийн үзүүрт байрладаг. Гадна талын ороолт навчинцар богино, өндгөрхүү хэлбэртэй, дотор талынх уртавгар,

гаднахаасаа урт, цайвар бор өнгийн хальслаг эмжээртэй. Үрэнцэр цомцоггүй [1,3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хянган, Дорнод Монголын тойрогт нуга, нугажуу хажуугаар ургана [2]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үндэслэг иш, үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Ой хээрийн түймэрт шатах, мал бэлчээрлүүлэх зэрэг шалтгаанаар устах аюулд орж байгаа зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 153 дугаар тогтоолын ховор ургамлын жагсаалтад бүртгэж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, биологи, экологийн судалгаа хийж, үрээр зориудаар үржүүлэх, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэж, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.



## 117. ДЭГЖИН ШИВААНТИГ



*Pyrethrum pulchrum* Ledeb.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн - Asteraceae Dumort.*

Статус: Ховор ургамал.

**Таних шинж:** Салаалсан мөлхөө үндэслэг иштэй, олон наст өвс. Иш эгц босоо, 10-30 см өндөр, ганц, нэгээрээ гарсан, салаалж мөчирлөөгүй, энгийн, нүцгэн юмуу сийрэг орооцолдсон үслэгтэй. Ишний навч энгийн өдлөг цуулбар, богино бариултай. Ишний уг болон дунд хэсгийн навч илтэснээсээ урт, угруугаа өргөссөн далавчирхуу бариултай. Сагс ишний үзүүрт ганц нэгээрээ байрладаг. Ороолт шилбийнхээ хамт сийрэг эсгийрхэг цагаан үслэгтэй. Түүний навчинцар өвслөг, хар хүрэн өнгийн хальслаг эмжээртэй. Үр жимс 5-7 тууш хавиргатай, богино үслэгтэй [2,4].

**Тархац, ургах орчин:** Өмнөд Сибирьт тархана. Монголд: Хөвсгөлийн уулын тайгын тойрогт өндөр уулын бүслүүрт хад чулуутай хажуугаар ургана [1,3]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Түймэрт өртөгдөж байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** . Монгол улсын засгийн газрын 1995 оны 153 дугаар

тогтоолын ховор ургамлын жагсаалтад оруулсан. Хил залгаа нутагт ховор ургадаг. Монгол орны ургамлын аймагт шинээр нэмж бүртгэсэн. Тархац нутгийг Хөвсгөлийн байгалийн цогцолборт газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, биологи, экологийг судлан, үрээр үржүүлэх аргыг боловсруулж, тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов 1982, 3. Дариймаа, 2003, 4. Мальшев, Пешкова, 1979.

## 118. ХАНГАЙН ШИВААНТИГ



*Pyrethrum changaicum* Krasch. ex Grub.

*Magnoliophytina*

**Овог.** Голгэсэртэн - *Asteraceae* Dumort.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Урт үндэслэг иштэй, олон наст өвс. Иш эгц босоо, ганц нэгээрээ юмуу хэд хэдээрээ, 50–70 см өндөр, навчирхаг үндэс орчмын цөөвтөр навчтай. Навч тод ногоон, хошоод юмуу гурвантаа өдлөг-цуулбар. Ишний навч хошоод өдлөг-цуулбар, харин үндэс орчмын навч гурвантаа өдлөг цуулбар. Навчны илтэс 4-5 см урт гонзгой-зууван хэлбэртэй. Ишний уг хэсгийн болон үндэс орчмын навч урт бариултай. Ишний үзүүр хэсгийн навч бараг суумал. Навчны салбангууд шугаман-юлдэрхүү, богинохон, хурц үзүүртэй. Ороолт навчинцар уртавтар, өвслөг, хэд хэдэн эгнээгээр байрладаг ба гадна талын навчинцар доторхоосоо

богинохон. Хуурамч хэл цэцэг эм бөгөөд цагаан, захаараа байрлалтай. Голын цэцэг шар, хоолой хэлбэртэй, хос бэлэгтэй. Сагс, ишний үзүүрт ганцаараа юмуу хааяа хоёроороо байрладаг. Үрэнцэр 5-8 тууш хавиргатай, дээд ирмэгээрээ богино үслэгтэй [2,4].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хангай, Монгол Алтайн тойрогт тархана. Өндөр уулын бүслүүрийн сайрга чулуутай хажуугаар ургана [1]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Бэлчээрийн талхагдалтаас устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолын ховор ургамлын жагсаалтад бүртгэж, тархац нутгийг хэсэгчлэн Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, биологи, экологийн судалгаа хийж, тарьж ургуулах аргыг боловсруулж үржүүлэх, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов 1982, 3. Губанов, 1996, 4. Дариймаа, 2003.

## 119. МОНГОЛЧУУДЫН ТОСТ



*Brachanthemum mongolorum* Grub.

*Magnoliophytina*

**Овог.** Голгэсэртэн – *Asteraceae* Dumort.

**Статус:** Нэн ховор, унаган, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Модожсон, бүдүүн голлосон үндэстэй, 5-20 см өндөр, цайвар өнгийн заримдаг сөөгөнцөр. Ишний уг орчимдоо салаалж мөчирлөсөн. Ургал мөчир цэцэглэх ишнээсээ бараг 2 дахин богинохон. Иш, навч өтгөн үслэгтэй. Навч ихэвчлэн хошоод-гурвантаа цуулбар, шугаман салбангуудтай. Цэцэглэх иш цөөвтөр, түүний навч жижигхэн, юлдэрхүү юмуу шугамархуу бараг бүтэн, хоорондоо зайдуу байрлалтай. Сагс 1 см орчим голчтой, дан хоолой хэлбэрийн цэцэгтэй, шар өнгөтэй. Ороолт навчинцар цөөвтөр эгнээ. Цагаан өнгийн үслэгтэй. Сагс ишний оройд ганцаар байрладаг. Цомцоггүй. Үрэнцэр 3 мм орчим урт, 2 мм орчим зузаантай. Бор хүрэн өнгөтэй [1,3,4].

**Тархац, ургах орчин:** Дорнод Монгол Матад сумаас зүүн хойш, Ар Жаргалант хийдийн туурь орчим, Цог өндөр уулын баруун хэсгээр ховор тохиолдоно. Хээрийн бүсэд дов толгодын чулуурхаг орой, алаг өвст чулуурхаг хээрт ургана [4]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үр болон ургал эрхтэнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Ой хээрийн түймэрт өртөх, тархац нутагт мал бэлчээрлүүлэх зэрэг шалтгаанаас эртний гаралтай унаган ургамлын өсөлт хөгжил удаашран, бодгалийн тоо цөөрч сийрэгжих, тархацын хүрээ хумигдах зэргээр устах аюулд орж байгаа ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр, Монгол улсын улаан ном, Монголын улаан дансанд [5] тус тус бүртгэж, хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийг нарийвчлан судалж, зориудаар тарьж ургуулах аргыг туршин нэвтрүүлэх, тохиромжтой газарт нутагшуулах, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, хамгаалалтыг сайжруулан малын бэлчээрээс чөлөөлөх, удмын санг хадгалах ажлыг цаг алдалгүй зохион байгуулах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов, 1982, 2. Дариймаа 2003, 3. Лигаа нар, 2008, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс..., 2012.

120. МОНГОЛ ТОСТ



*Brachanthemum mongolicum* Krasch.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн* – *Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Сөөгөнцөр юмуу заримдаг сөөгөн амьдралын хэлбэртэй, зөөлөн нарийхан эсгийрхэг үслэгээр бүрхэгдсэн, цайвар өнгөтэй, олон наст ургамал. Бүдүүн модожсон үндэстэй. Иш олон, ихэд салаалж мөчирлөсөн, модожсон, эгц босоо 15-40 см өндөр. Навч дагаваргүй, гурвалсан сарвуулаг, хурц үзүүр бүхий нарийн шугаман салбанцартай, махлагдуу. Сагс аягархуу хэлбэртэй, 8-10 мм голчтой, захын богинохон цагаан хэл цэцэгтэй. Хэл цэцгийн дэлбэ уртавтар-зууван юмуу бараг дугуйдуу 2-3 мм урт дэлбэтэй. Голынх хоолой хэлбэртэй, шар өнгөтэй. Цомцог байхгүй. Ороолт 6 мм орчим голчтой, навчинцар, бор өнгийн хальслаг эмжээртэй. Гадна талын ороолт навчинцар уртавтар-өндгөрхүү, дотор талынх уртавтар хэлбэртэй. Үрэнцэр цайвар бор, 3 мм орчим урт [1].

**Тархац, ургах орчин:** Төв Азийн нутаг дэвгэрт тархана. Монголд: Зүүнгарын говьд үйрмэг чулуут цөлд ургадаг [2,3]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үндсээр болон үрээр үрждэг.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Цөлжилт, хөрсний чийгийн хангамж буурч, хуурайшиж хатах, хүчтэй шороон шуурганд өртөгдөх зэрэг шалтгаанаас устаж болзошгүй зүйл.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын засгийн газрын 1995 оны 153 тогтоолын

ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг Говийн их дархан цаазат газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, биологи, экологийн судалгаа хийж, зориудаар үржүүлэх аргыг боловсруулж нэвтрүүлэх, тохиромжтой газарт нутагшуулах, үндсэн тархац нутгийг хамгаалж, ургах орчинг нөхөн сэргээх, нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

## 121. ЧУЛУУРХАГ ШАРИЛЖ



*Artemisia lithophila* Turcz.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн* – *Asteraceae* Juss.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Модожсон, бүдүүн, голлосон үндэстэй, доод хэсгээрээ ихээхэн салаалсан, 40-60 см өндөр, бут үүсгэн ургадаг, заримдаг сөөг. Гадуураа бор саарал холтсоор бүрхэгдсэн, модожсон олон тооны богинохон ургал мөчиртэй. Мөчрийнхээ үзүүрт багцалсан навчтай. Навч бүтэн, үзүүртээ 3-5 шүдлэгтэй, нарийн юлдэрхүү юмуу тонгоруу шаантгархуу хэлбэртэй. Навчны хоёр тал эсгийрхэг, торгомсог үслэгээр хучигдсан цайвар саарал өнгөтэй. Сагс тал бөмбөлөг хэлбэртэй, харьцангуй урт шилбэтэй, ташуу юмуу гудгар байрлалтай, нарийн цацаг баг цэцэг бүрдүүлдэг. Ороолт навчинцар уртавгар юлдэрхүү, өргөн хальслаг эмжээртэй, өтгөн үслэгтэй [2,4,7].

**Тархац, ургах орчин:** Арктик, Дорнод Сибирь, Алс Дорнодод тархана. Монголд: Хөвсгөлийн Сул хэмээх ууланд цөөн тохиолдоно. Ойн бүслүүрийн хад, асга, хайрганд ургана [1,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, нарийвчлан тогтоогоогүй. Ойн түймэрт нэрвэгдэж, устах аюулд орсон ургамал. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр оруулж, Монгол улсын улаан данс, Монголын ургамлын улаан дансанд [6] тус тус бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, үрээр тарьж ургуулах, тохиромжтой газарт нутагшуулах, тархац нутгийг орон нутгийн хамгаалалтад авч, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Дариймаа, 2003, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012, 7. Поляков, 1961.

## 122. ЖАНЗ ШАРИЛЖ



*Artemisia tomentella* Trautv.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн – Asteraceae Juss.*

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “эмзэг” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Голлосон, хааяа салаалсан 3 см хүртэл голч бүхий үндэстэй. Хэд хэдээрээ юмуу олноороо гарсан 35-60 см өндөр иштэй. Уг орчим нь модожсон, өтгөн цагаан үслэгээр бүрхэгдсэн олон наст өвс. Навч торгомсог үслэгтэй, энгийн юмуу хошоод өдлөг-цуулбар, уртавтар-өндгөрхүү хэлбэртэй, салбангууд нь өргөн шугамархуу юмуу шугаман-юлдэрхүү. Ишний уг хэсгийнх богино бариултай, дунд ба үзүүр хэсгийнх суумал. Сагс уртавтар өндгөн хэлбэртэй. Ороолт навчинцар зууван, захаараа хальслаг эмжээртэй. Сагсны захын цэцгүүд хос бэлэгтэй бөгөөд үрэвчийн хөгжил сайтай учир үрлэдэг. Харин голын цэцгүүдийн үрэвчийн хөгжил сул учир үрлэдэггүй. Сагс богинохон, шилбэтэй, нарийн залаархуу хэлбэрийн баг цэцэг үүсгэн, иш мөчрийн оройд байрладаг [3,4].

**Тархац, ургах орчин:** Сибирыг тархана. Монголд: Хөвсгөл, Хангай, Ховд, Их нууруудын хотгор, Зүүнгарын говь цөлөрхөг хээрийн бүсэд элсэнд ургана [1,2].

**Үржил:** Үрээр, ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Цөлжилт, усан хангамжийн дутагдал ургах орчны доройтол, бэлчээрийн талхагдалтаас устах аюулд орсон ургамал.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн нэн ховор ургамлын хавсралтад оруулж, Монголын ургамлын улаан дансанд [5] бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалтад авч хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, үрээр тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003, 4. Крылов, 1949, 5. Мон. ур. улаан данс..., 2012.

123. ИЛЫИНИЙ ААРНИГ





*Arnica iljinii* [Maguire] Iljin

*Magnoliophytina*

**Овог.** Гол гэсэртэн - *Asteraceae* Dumort.

**Статус:** Нэн ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Хайрс бүхий нарийн мөлхөө, бор өнгийн үндэслэг иштэй ургамал. Иш эгц босоо юмуу үл мэдэг өндиймөл, энгийн, ганц нэгээрээ болон хэд хэдээрээ, 10-30 см өндөр. Доод хэсгээрээ энгийн ба булчирхайт үслэгээр бүрхэгдсэн. Үндэс орчмын навч уртавтгар-зуувангаас өргөн юмуу нарийн юлдэрхүү хэлбэртэй болсон. Ишний навч дээшлэх тусмаа жижгэрдэг. Үндэс орчмын ба ишний угийн навч далавч бүхий бариултай, харин үзүүр хэсгийн навч суумал. Сагс 2-6 см голчтой, хурц шар өнгийн хэл цэцэгтэй. Хуурамч хэл цэцэг тод шар өнгөтэй, үзүүртээ 3 шүдлэгтэй. Хоолойрхуу цэцэг цомцогтой бараг тэнцүүхэн, шар. Сагс ганц нэгээрээ юмуу хэд хэдээрээ иш мөчрийн оройд байрладаг. Ороолт хонхорхуу, түүний навчинцар хурц үзүүр бүхий юлдэрхүү хэлбэртэй, улаан ягаан туяатай. Үрэнцэр шугамархуу, бараан сааралдуу өнгөтэй, цав цагаан өнгийн цомцогтой [1,5].

**Тархац, ургах орчин:** Евразид тархана. Монголд: Монгол Алтайн тойргийн өндөр уулын бүслүүрт чулуурхаг хажуугаар ургадаг [2,3]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үрээр ба үндэслэг ишээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй, мал бэлчээрлэлтээс устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр оруулж, Монголын ургамлын улаан дансанд [4] тус тус бүртгэсэн. Тархац нутгийг хэсэгчлэн улсын тусгай хамгаалалтад авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг тогтоож, хамгаалах, зориуд ургуулан тордох асуудал боловсруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003. 4. Мон. ур. улаан данс..., 2012, 5. Флора СССР., 1961, Т.26.

## 124. ДӨЛ ЗОХИМОН



*Senecio flammeus* Turcz.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн – Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Үндэслэг иштэй, олон наст өвслөг ургамал. Иш эгц босоо, 25-80 см өндөр, бөөгнөрсөн ороолдсон үслэгтэй, дээд хэсгээрээ салаалсан. Үндэс орчмын навч эрт унадаг. Ишний уг орчмын навчны бариул өргөссөн, бараг илтэстэйгээ тэнцүү, дунд хэсгийн навч суумал, ишээ зуусан. Навчны илтэс өндгөн-юлдэрхүү юмуу юлдэрхүү, орой мохоо юмуу хурцавтар, ирмэгээрээ жижиг шүдлэгтэй юмуу том сунасан шүдлэгтэй. Сагс 3-20-оороо оройн бамбайн баг цэцэг үүсгэн байрладаг. Ороолт 5-6 мм урт, нэг эгнээ, ягаан өнгөтэй, нүцгэн юмуу бага зэрэг ороолдсон үслэгээр бүрхэгдсэн. Захын хэл цэцэг, шугамархуу, хүрэн юмуу хүрэн ухаа өнгөтэй. Цомцог бор өнгөтэй, хоолой цэцэг түүнээс богинохон. Үрэнцэр

ойролцоогоор 2 мм урт, үсэрхэг [1,4].

**Тархац, ургах орчин:** Алс Дорнодод тархана. Монголд: Хянганы уулын нугат хээрийн тойрогт чийглэг алаг өвст нуга, сөөгөн дунд ургадаг [2,3].

**Үржил:** Үндэслэг ишээр болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Хуурайшилтаас нугат хээр хатаж, ургах орчин доройтсоноос устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулж хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, зориудаар үржүүлэх туршилт судалгаа хийж, үр дүнг нэвтрүүлэх, хамгаалалтыг сайжруулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003, 4. Малышев, Пешкова, 1979.

## 125. ЗҮҮНГАРЫН ЗАЯАХАЙ



*Ligularia songarica* [Fisch.] Ling.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн* – *Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Богиноссон үндэслэг иштэй, олон наст өвс. Махлагдуу сахлаг үндэстэй. Иш эгц босоо, бадриун, 50-70 /100/ см өндөр. Үндэс орчмын навч урт бариултай, угийн хэсэг нь угларга болон өргөссөн, илтэснээсээ 2 дахин урт, илтэс гонзгой-өндгөрхүү юмуу хааяа сумархуу суурьтай гурвалжиндуу хэлбэртэй. Ишний үзүүр хэсгийнх ихэвчлэн гонзгой-өндгөрхүү, жижгэвтэр бөгөөд суумал, ишээ бага зэрэг зуусан байдаг. Сагс олноороо /30-100/ иш, мөчрийн үзүүрт урт, цацгархуу бамбай хэлбэрийн баг цэцэг бүрдүүлдэг. Ороолт нарийн бортгорхуу, ороолт навчинцар ногоон, нуруун талаараа богинохон үслэгтэй, ирмэгээрээ богино сормуулаг. Дэлбэ шар. Үрэнцэр 7 мм орчим урт, цомцог бор шарга өнгөтэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Дундад Ази, Зүүнгарын Кашгарид тархана. Монголд: Зүүнгарын говийн цөлийн бүсийн хужирлаг нугаар ургана [2].

**Үржил:** Үндэслэг ишээр болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Тархац маш бага, цөлжилт, хуурайшилт, хэт халалт, хүчтэй шороон шуурганаас хөрсний чийгийн хангамж багасч, нуга хатах зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, экологи, биологийн судалгаа явуулж, байгалийн нөхөн ургалт, зориудаар үржүүлэх аргыг боловсруулж турших, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

126. УДМЫН АРЗГАНА



*Cousinia affinis* Schrenk

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн – Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Модожсон бүдүүн үндэстэй, олон наст өвс. Иш 20-40 см өндөр, үзүүр хэсгээрээ салаалсан, эсгийрхэг цагаан үслэгтэй бөгөөд үрлэх үедээ нүцгэрч ороолдсон, бөөгнөрсөн үслэг үлддэг. Навч уртавгар юмуу гонзгой-өндгөрхүү, том онин шүдлэгтэй юмуу бараг өдлөг хагалбар, ирмэгээрээ зүүрхүү өргөстэй. Ишний доод хэсгийн навч богино бариултай, харин үзүүр хэсгийн навч суумал, ишээ зуусан. Сагс 1.5-2 см голчтой, иш мөчрийнхөө үзүүрт 1-3-аараа байрладаг. Ороолт навчинцар ногоон, өндгөрхүү юмуу гонзгой-өндгөрхүү хэлбэртэй, үзүүртэй махир өргөстэй. Цэцэг олон, хүрэн ягаан. Үрэнцэр нүцгэн, 3 мм урт, хавчгар, нарийхан хальслаг эмжээр бүхий тэнцүү биш ирмэгтэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Зүүнгарын говийн тойрогт элсэн довцог, дэрсэн дунд ургадаг [2].

**Үржил:** Үндсээр болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Цөлжилт, хуурайшилт, хөрсний чийгийн хангамжийн бууралт, хүчтэй шуурга зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс ургах орчин доройтон, байгалийн жамаар нөхөн сэргэх чадавх буурч байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар

тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж, байгалийн нөхөн ургалтыг дэмжих зорилгоор зориудаар тарьж ургуулах аргыг тогтоох, ургах орчны доройтлыг хязгаарлах, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

## 127. НӨМРӨГТ БАНЗДОО



*Saussurea involucrata* [Kar. et Kir.] Sch.Bip.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн - Asteraceae Dumort.*

**Статус:** Нэн ховор, үлдвэр ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Үндэс, иш бүдүүн, 2-3 см голчтой шүүслэг, нүцгэн. Суурь хэсэгт нь хагдарсан навч цөөнгүй тохиолдох ба ишиндээ олон навчтай. Навч өндгөрхүү, гонзгойвгор, суумал, тод шар судалтай, захаараа шүдлэг. Баг цэцэг /үрлэх хүртэл/ нягт байрлах сагнаас тогтдог, 2 эгнээ аягархуу юмуу завирхуу, нимгэн сарьслаг, цагаан, оройн навчаар хүрээлэгддэг [1,4].

**Тархац, ургах орчин:** Дундад Ази, Дорнод Сибирь, Зүүнгарын Кашгар, Тянь-Шаньд тархана [1,4]. Монголд: Монгол Алтай, Говь-Алтай, Зүүн гарын говийн тойрогт тохиолдоно. Өндөр

уулын тагийн бүслүүрийн хад, асга, асгаргын чийгтэй хөрсөнд ургана [2,3].

**Үржил:** Үрээр удаан үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тодорхойгүй. Ойн түймэрт нэрвэгдэж, Эмийн зориулалтаар их хэмжээгээр түүж, бэлтгэх, тархац нутаг улам бүр хумигдаж, үр ургах нөхцөл хязгаарлагдаж байгаагаас устах аюулд орсон ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтад нэн ховор зүйлээр оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд [6] тус тус бүртгэсэн. Тархац нутгийг хэсэгчлэн авч хамгаалсан. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг нарийвчлан тогтоох, үрээр тарьж ургуулах аргыг нэвтрүүлэх, хамгаалалтыг сайжруулж, эмийн зориулалтаар ашиглахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу яаралтай таслан зогсоож, үндсэн тархац нутгийг нутгийн иргэд, иргэдийн нөхөрлөлд хариуцуулан хамгаалуулах, хашиж хамгаалах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Грубов, 1982, 3. Губанов, 1996, 4. Лигаа, 1997, 5. Монгол улсын улаан ном, 1997, 6. Мон. ур. улаан данс..., 2012.

## 128. ЕКАТЕРИНЫ БАНЗДОО



*Saussurea catharinae* Lipsch.

*Magnoliophytina*

**Овог.** Голгэсэртэн – *Asteraceae* Dumort.

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Өтгөн дэгнүүл үүсгэн ургадаг, олон наст. Иш олноороо багцалж ургадаг бөгөөд баг цэцгийнхээ орчимд бага зэрэг салаалсан, 30 см хүртэл өндөр. Ишний уг модожсон, үхсэн навчны үлдэгдлээр нягт хучигдсан. Навч шугамархуу, бүтэн ирмэгтэй, ирмэгээрээ эргэсэн, шаантгархуу суурьтай, дээд гадаргуу ногоон, доод гадаргуу бага зэрэг үслэгтэй, цайвар саарал өнгөтэй. Сагс уртавтар-өндгөрхүү хэлбэртэй, ягаан өнгийн дэлбэтэй, ороолт навчинцар гонзгой-өндгөрхүү, шовх оройтой, сийрэг сааралдуу үслэгээр хучигдсан. Сагс иш мөчрийн үзүүрт залаа хэлбэрийн баг цэцэг үүсгэдэг [1,3].

**Тархац, ургах орчин:** Алтайн Өвөр говьд тархана. Хадны ан цав, ирмэг хөвөөнд ургадаг [2]. Тархац нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үндэслэг ишээр болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Тархац маш бага, хуурайшилт, хөрсний чийгийн хангамжийн бууралт, хүчтэй шуурга болон малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэх зэрэг хүчин зүйлээс шалтгаалан байгалийн жамаар нөхөн сэргэлт улам бүр хязгаарлагдаж, устах аюулд орж байгаа унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологи, экологийг нарийвчлан судалж, зориудаар тарьж ургуулах аргыг боловсруулж турших, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

129. ДОРОГОСТАЙСКИЙН БАНЗДОО





*Saussurea dorogostaiskii* Palib.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн – Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Иш хөндий, 1,5-2 см голчтой, өтгөн цагаан үсээр хучигдмал, 1 метр хүртэл өндөр, олон наст өвслөг ургамал. Навч барзгар, дугуй эсвэл мохоо оройтой, захаараа шүдлэг, гонзгойвгор-өндгөрхүү, өргөн далавчлаг бариултай, ишээ ялимгүй ороосон байрлалтай. Бүрзгэр хүрэн цэцэгтэй. Сагс баг цэцэг олноороо нийлж, өтгөн цацаг баг цэцэг үүсгэнэ [3,4].  
**Тархац, ургах орчин:** Өмнөд Сибирьт тархалттай. Монголд: Хөвсгөл, Хангай, Хэнтийн уулын тайгын тойргийн өндөр уулын бүслүүрийн хад чулуу асганд ургадаг [1,3].

**Үржил:** Үндэслэг иш болон үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Тархац маш бага, хуурайшилт, хөрсний чийгийн хангамжийн бууралт, хүчтэй шуурга болон малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэх зэрэг хүчин зүйлээс шалтгаалан байгалийн жамаар нөхөн сэргэлт улам бүр хязгаарлагдаж байгаа устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, Монгол улсын улаан ном, Монголын ургамлын улаан дансанд тус тус оруулан бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийн онцлогийг судлан тогтоож, зориудаар ургуулах аргыг боловсруулж турших, үндсэн тархац нутагт мал сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлан өнжүүлэх, нэн ховор ургамлын жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ганболд, 2010, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 1997, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс..., 2012.

### 130. КЛЕМЕНЦИЙН БАНЗДОО



*Saussurea klementzii* Lipsch.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн – Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор, унаган ургамал.

**Таних шинж:** Богиносон үндэслэг иштэй, саарал ногоон, олон наст өвс. Иш 3-12 см өндөр, ганц, нэгээрээ юмуу хэд хэдээрээ, өтгөн навчирхаг. Навч бүтэн, шаантгархуу суурьтай, ихэвчлэн эргэсэн захтай, богино бариултай. Ишний үзүүр хэсгийн навч суумал. Сагс хонхорхуу, 1.5 см хүртэл өндөр, иш мөчрийн үзүүрт шигүү бамбай хэлбэрийн баг цэцэг үүсгэн байрладаг. Ороолт нүцгэн, ногоон юмуу улаавтар өнгөтэй. Гадна талын навчинцар доторхоосоо богинохон, юлдэрхүү, харин дотор талынх нь уртавтар хэлбэртэй, бие биенээ дэрлэн байрладаг. Цэцгийн дэлбэ ягаан өнгөтэй, дэлбэ 1 см-ээс урт, нарийн хоолойтой, дэлбэн богинохон. Тоосовч ягаавтар өнгөтэй. Өдлөг үслэг бүхий цомцогтой [1,3].

**Тархац, ургах орчин:** Монголд: Монгол Алтайд тархана. Уулын сайргархаг хажуу, нуранга, асга, хаданд ургадаг [2]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үндэслэг ишээр болон үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Тархац маш бага боловч нөөцийг нарийвчлан тогтоогоогүй. Хуурайшилт, чийгийн хангамжийн бууралт, ойн түймэр болон малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэх зэрэг шалтгаанаас устах аюулд орсон унаган ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, нөхөн төлжих биологийн онцлогийг судалж тогтоох, ургах орчинд зориудаар тарьж ургуулах туршилт, судалгаа явуулж, байгалийн нөхөн ургалтыг сэргээх, үндсэн тархац нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, нэн ховор ургамлын жагсаалтад оруулах удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

## 131. АРЗГАРЖИМСТ ЧОНОГОНО



*Jurinea chaetocarpa* [Ledeb.] Ledeb.

*Magnoliophytina*

**Овог.** Голгэсэртэн - *Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Голлосон бүдүүн үндэстэй, цайвар өнгийн олон наст ургамал. Иш ороолцолдсон үслэгтэй, салаалж, мөчирлөсөн, хааяа энгийн, 10-40 см өндөр. Навчны дээд

гадаргуу орооцолдсон юмуу бөөгнөрсөн буржгар үслэгтэй, доод гадаргуу орооцолдсон эсгийрхэг үслэгтэй. Үндэс орчмын навч олон, өдлөг-хагалбар, уртавгар-шугаман, эргэсэн зах бүхий салбантай. Ишиндээ цөөвтөр, жижгэвтэр, богино бариултай юмуу суумал навчтай. Сагс том, урт мөчир дээр ганц нэгээрээ юмуу 2-5-аараа байрладаг. Ороолт 13-18 мм голчтой, түүний навчинцар юлдэрхүү, хурц, гадуураа ороолцолдсон үслэгтэй юмуу нүцгэн гадагшаа үл мэдэг эргэсэн өргөн оройтой. Үрэнцэр 5-6 мм урт, уг орчимдоо өргөссөн, өтгөн, дээшээ чиглэсэн юмуу налчгар өргөсөрхүү үслэгтэй [1].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Монгол Алтай, Зүүнгарын говийн тойргуудад цөлийн элсэрхэг хөндий, элсэрхэг, хайргархаг хормой, хажуугаар ургана [2,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг нарийвчлан тогтоогоогүй. Цөлжилт, олон жил дараалсан гангийн давтагдал, гадаргын усны түвшин доошлох зэрэг байгалийн хүчин зүйлээс хамааран устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, нөхөн төлжих биологийн онцлогийг судалж, үрээр үржүүлэх туршилт судалгаа хийх, ургах орчныг хамгаалах, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

## 132. ЛОМОНОСОВЫН ХАСЗУЛ



*Olgaea Lomonosowii* [Trautv.] Iljin

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн - Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд “үнэлгээ хийгдээгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” хэмээн үнэлэгдсэн.

**Таних шинж:** Голлосон бүдүүн үндэстэй, 30 см орчим өндөр, олон наст өвс. Навчны бариул нарийссан, ишээ дагаж далавч үүсгэдэггүй. Бариулын илтэс ирмэгээрээ жижгэвтэр өргөсөнцөртэй, дээд гадаргуу үсэнцэргүй, хар ногоон өнгөтэй, доод гадаргуу эсгийрхэг үслэгтэй. Хоолой хэлбэрийн ягаан өнгийн цэцэгтэй, 3-5 см голчтой, сагсууд ишэнд ганц нэгээрээ байрлана [1,4].

**Тархац, ургах орчин:** Өвөр Монголын зүүн хойд хэсгээр тархана. Монголд: Дорнод Монголын хээржүү хажуу, элсэрхэг хээрээр ургадаг [2,3].

**Үржил:** Үрээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалгаан:** Нөөц бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Хуурайшилт, хээрийн түймэр, мал, амьтны нөлөөгөөр тархац нутаг хумигдах, нөөцгүй болох магадлалтай, устаж болзошгүй ургамал.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, Монголын ургамлын улаан дансанд [5] тус тус бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, биологийн онцлогийг нарийвчлан судалж, үрээр үржүүлэх туршилт судалгаа хийж турших, нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Мон. ур. улаан данс..., 2012.

133. ГРУБОВЫН ХАВИСГАНА



*Scorzonera grubovii* Lipsch.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгээсэртэн - Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Голлосон бүдүүн урт үндэстэй, олон наст өвслөг ургамал. Иш эгц босоо юмуу нумраадуу, бага зэрэг салаалж мөчирлөсөн, нарийвтар, хурц хавиргалаг, 12-20 см өндөр, олон. Иш навчирхаг. Ишний навч ногоон, нимгэн, шугаман-юлдэн, 5 см хүртэл урт, нарийхан шөвгөр үзүүртээ гох дэгээрхүү нугархайтай. Сагс цайвар шар өнгийн хэл цэцэгтэй. Хэл цэцэг үзүүртээ 5 шүдлэгтэй, хос бэлэгтэй. Үрэвч доор байрлалтай. Цомцог цайвар шар өнгөтэй, өдлөг үслэгтэй. Ороолт хэд хэдэн эгнээ навчинцараас тогтдог. Гадна талын ороолт навчинцар өргөн өндгөрхүү хэлбэртэй, дотор талынхаас богинохон. Үрэнцэр 3-4 мм урт, нүцгэн [1,3].

**Тархац, ургах орчин:** Төв Азийн хойт хэсгээр тархана. Монголд: Зүүнгарын говьд уул, толгодын чулуурхаг хажуугаар ургана [2]. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Үрээр, ургал эрхтэнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Цөлжилт, олон жил дараалсан гангийн давтагдал зэрэг байгалийн хүчин зүйлийн сөрөг нөлөөллөөс устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг шинэчлэн тогтоох, биологийн онцлогийг илрүүлэх судалгаа явуулж, байгальд үрээр тарьж ургуулах туршилт хийж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

## 134. БЯЦХАНЦЭЦЭГТ ХАВИСГАНА



*Scorzonera parviflora* Jacq.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн - Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Салаалсан үндэстэй бөгөөд дээд хэсгээрээ навчны угларгын үлдэгдлээр хучигдсан. Иш 15-50 см өндөр, эгц босоо юмуу өндиймөл, энгийн юмуу бага зэрэг салаалсан, цөөвтөр [1-3] хайрсархуу навчтай. Үндэс орчмын навч юлдэрхүү, хааяа зууван юлдэрхүү, хурц махирдуу оройтой, сунаж нарийссан суурьтай, угтаа өргөссөн угларгатай. Ишний навч юлдэн шугамархуу, жижигхэн. Сагс том биш, 13-20 см өндөр, 3-7 мм өргөн, ганц нэгээрээ хааяа 2-3-аараа ишний оройд байрладаг. Гаднах ороолт навчинцар өндгөрхүү, хурц, доторх талын өндгөн юлдэрхүү, мохоо оротой, нарийн хальслаг эмжээртэй. Цэцэг шар, ороолтоосоо нилээд урт. Үрэнцэр гөлгөр, цагаан цомцогтой [1,4].

**Тархац, ургах орчин:** Евразид тархана. Монголд: Зүүнгарын говийн хужир мараатай газраар, мараалаг нугад ургана [2,3].

**Үржил:** Үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Цөлжилт, ган, ургах орчны доройтлоос устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, ургах орчинд үрээр үржүүлэх аргыг боловсруулж турших, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003, 4. Малышев, Пешкова, 1979.

### 135. ЧҮЙН БАНГА



*Crepis czuensis* Serg.

*Magnoliophytina*

**Овог.** *Голгэсэртэн* – *Asteraceae Dumort.*

**Статус:** Ховор ургамал.

**Таних шинж:** Салаалсан нарийхан үндэслэг иштэй. Иш энгийн, цагаан буржгар үслэгтэй, 3-7 см өндөр, олон наст ургамал. Ишин дээрээ 1-2 шугамархуу хурц жижигхэн навч байрладаг. Үндэс орчимдоо олон навчтай бөгөөд навчны доод гадаргуу буржгар цагаан үслэгтэй, хааяа хэрчигдсэн байдаг. Тэдгээрийн салбан юлдэрхүү юмуу шугамархуу хэлбэртэй. Сагс ганц нэгээрээ байрладаг. Ороолт навчинцар өргөн юүлүүрэрхүү, 1-1.5 см өргөн. Түүний гаднах ороолт навчинцар шугаман, доторх юлдэн шугамархуу, мохоо. Дэлбэ шар, хэлэрхүү, үзүүртээ



5 шүдлэгтэй. Бүрэн боловсорсон үрэнцэр 4-4.5 мм урт, хар хүрэн өнгөтэй, олон хавиргатай [1,3].

**Тархац, ургах орчин:** Баруун Сибирьт тархана. Монголд: Ховдын уулын цөлөрхөг хээрийн тойрогт уулын хад чулуурхаг болон сайргархаг хажуугаар ургадаг. Уулын хайрга чулуутай хажуугаар ургана [2].

**Үржил:** Үндэслэг иш ба үрээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Хуурайшилт, бэлчээрийн талхагдалтаас устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад бүртгэсэн. Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг шинэчлэн тогтоох, зориудаар үржүүлэх туршилт судалгаа явуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Грубов 1982, 2. Губанов, 1996, 3. Дариймаа, 2003.

## 1. УГЛАРГАТ СИМЛЕФАРИС



*Symblypharis vaginata* [Hook.] Wijk. et Marg.

*Овог. Дикранумтан – Dicranaceae Schimp.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Шигүү нягт дэгнүүлтэй шар эсвэл бор ногоон өнгийн хөвд. Навч хуурай үедээ мушгирсан, өргөн угларгатай, нарийн урт шовх орой бүхий уртавтар юлдэн хэлбэртэй. Судал нарийн, навчны оройгоос бага зэрэг илүү гарна. Навчны эс дээд хэсэгтээ дөрвөлжин, суурьлуугаа уртавтар тэгш өнцөгт эсвэл шугаман хэлбэртэй. Хонгорцог нарийн бортгон хэлбэрийн шулуун [2].

**Тархац, ургах орчин:** Ойрх Дорнод, Хятад, Хойд болон Төв Америкт тархана. Монголд: Хангайн районы Бүтээлийн нуруу, Хэнтийн Зүүн Бүрхийн гол орчимд ховор тохиолдоно [1]. Ойд өмхөрсөн мод, модны ишин дээр ургана [2].

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Байгалийн хуурайшилт, мод бэлтгэлт, ойн түймрийн улмаас устаж болзошгүй.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, ховор хөвдийн жагсаалтад бүртгэж,

хамгаалалтыг сайжруулах, мод бэлтгэлтийг хязгаарлах, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Абрамова, Цэгмэд, 1994, 2. Цэгмэд, 2010.

## 2. БУРЖГАРНАВЧИТ РАБДОВЕЙЗИ



*Rhabdoweissia crispata* [Dicks. ex With.] Lindb.

*Овог. Дикранумтан – Dicranaceae Schimp.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Сэвсгэр дэгнүүлтэй тод ногоон эсвэл ногоон өнгийн жижиг хөвд. Навч хуурай үедээ атирсан, шугаман хэлбэрийн, богино шовх оройтой, орой хэсэгтээ шүдлэг ирмэгтэй. Судал бүдүүн, навчны орой орчимд төгсөнө. Навчны эс дөрвөлжин эсвэл дугуйдуу дөрвөлжин хэлбэртэй. Хонгорцог жижиг, шулуун, дугуйдуу-өндгөн хэлбэртэй [1].

**Тархац, ургах орчин:** Урал, Дорнод Сибирь, Алс Дорнод болон Хятад, Японд тархана. Монголд: Хангайн Хөгнө Хан уул, Хэнтийн Богд Хан ууланд тохиолдоно [1]. Ойд хад чулуун дээр ургана.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Байгалийн хуурайшилт, ойн түймрийн улмаас устаж болзошгүй.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт

ихэнхийг хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан судалж тогтоох, ховор хөвдийн жагсаалтад оруулж, хамгаалалтыг сайжруулах, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Цэгмэд, 2010.

### 3. МОЛЦГОН ОНГСТРЕМИ



*Aongstroemia julacea* [Hook.] Mitt.

**Овог.** Дикранумтан – *Dicranaceae Schimp.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Шаравтар ногоон эсвэл боровтор өнгийн шигүү дэгнүүлтэй хөвд. Иш 2 см өндөр шулуун. Навч бие биенээ нягт налж молцоглосон, халбагархуу хомбогор, өргөн өндгөрхүү эсвэл хэлэрхүү хэлбэртэй, дугуйдуу-мохоо оройтой. Навчны зах дундаа хүртэл шүдтэй. Судал тод бүдүүн, навчны оройд төгсөнө. Навчны доод хэсгийн эс дөрвөлжин, дээшээгээ тэгш өнцөгт, үзүүр хэсэгтээ тэгш бус өнцөгт хэлбэртэй. Хонгорцог цэх, 6-7 эс бүхий том том үүсгэгч биетэй [3].

**Тархац, ургах орчин:** Азид: Балба, Хятад, Дорнод Сибирь, Япон, Гималай; Өмнөд Африк, Мадагаскар, Мексик, Өмнөд Америкт тархана. Монголд: Түргэний нуруу, Их Богд ууланд ховор тохиолдоно [1, 3]. Өндөр уулын бүслүүрт, хад чулуу, хадны ангал, завсарт ургана [2, 3].

**Үржил:** Спороор болон ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Байгалийн хуурайшилтаас өсөлт, хөгжилт


удаашран устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хөвдийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [2], тархац нутгийг Их Богдын байгалийн цогцолборт газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, хамгаалалтыг хуулийн дагуу сайжруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Абрамова, Абрамов, 1983, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Цэгмэд, 2010.

#### 4. ӨМНӨДАЗИЙН ДИДУМОДОН



*Didymodon australasiae* [Hook. et Grev.] Zander

**Овог.** *Поттиатан* – *Pottiaceae* Schimp.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Сэвсгэр дэгнүүлтэй, боровгор эсвэл ногоон саарал, жижиг хөвд. Навч хуурай үедээ ишээ ороож мушгирсан, уртавтар-юлдэн эсвэл богино хэлэрхүү хэлбэртэй, мохоодуу, зузаан хомбогор оройтой. Судал бүдүүн, бараг навчны орой хүрнэ. Навчны дээд хэсэг болон захаараа 2 давхар эстэй. Навчны эс дугуйдуу дөрвөлжин, суурь хэсэгтээ судлынхаа орчим амархан ховхордог, том цагаан эсүүдтэй. Үрт бие тодорхойгүй [1].

**Тархац, ургах орчин:** Газрын дундад тэнгисийн эрэг орчмын орнууд, Дундад Ази, Өмнөд Америк, Шинэ Зеландад тархана. Монголд: Алтайн нуруу, Тонхил сум орчимд ховор

тохиолдоно [1]. Хадтай хажуу, хавцалд хад чулууны завсар, хадны дэргэд хуримтлагдсан хөрсөн дээр ургана [1].

**Үржил:** Судлын уг орчим байрлах үүсгэгч биеийн тусламжтай үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Байгалийн хуурайшилт, бэлчээрийн сэлгээгүй ашиглалтаас шалтгаалан устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, ховор хөвдийн жагсаалтад оруулж, хамгаалалтыг хуулийн дагуу сайжруулах, байгалийн нөхөн ургалтыг дэмжиж, зориудаар үржүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Цэгмэд, 2010.

## 5. ВЕЛЕНОВСКИЙН ГИЛБЕРТИ



*Hilpertia velenovskyi* [Schiffn.] Zander.

**Овог.** *Поттиатан* – *Pottiaceae Schimp.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Жижиг, шаравтар эсвэл бор ногоон өнгийн, сийрэгдүү дэгнүүлтэй, заримдаа хэсэг бүлгээрээ ургадаг хөвд. Навч хуурай үедээ мушгирсан, чийгтэй үедээ дэрвийсэн, өргөвтөр-зууван эсвэл дугирагдуу, хомбогор, орой хэсэгтээ лав эргэсэн, бүтэн захтай. Судал

нь навчны оройгоос урт, өнгөгүй гөлгөр хялгасан үзүүр болж илүү гарна. Навчны эс дугуйдуу тэгш өнцөгтөөс тэгш бус өнцөгт хэлбэртэй. Хонгорцог шулуун, бортгон хэлбэртэй [2].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Дархадын хотгорт Цагааннуур, Бор Хоёг уул, Монгол Алтайн Шаазгайтын нуруу, Гичгэний нуруу, Говь Алтайн Их Богд ууланд тохиолдоно [1]. Уулын хажуу, гуу жалга орчмоор хад чулуун дээр ургана [2].

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Байгалийн хуурайшилт, орчны доройтлоос шалтгаалан устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, байгалийн нөхөн ургалтыг дэмжиж, хамгаалалтыг сайжруулах, ховор хөвдийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Абрамова, Цэгмэд. 1994, 2. Цэгмэд, 2010.

## 6. КАСПИОРЧМЫН ТОРТУЛА



*Tortula transcaspica* Broth.

**Овог.** *Pottiaceae* Schimp.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Шаравтар ногоон өнгийн дэгнүүлтэй, жижиг хөвд. Навч өргөн юлдэн эсвэл

дугуйдуу хэлбэртэй, богино шовх оройтой, хүрээгүй захтай. Судал тод, улаавгар өнгөтэй, навчны оройгоос гөлгөр, өнгөгүй, урт хялгасан үзүүр болж гарна. Навчны дээд хэсгийн эс гөлгөр, дөрвөлжин, богино тэгш өнцөгт хэлбэртэй. Хонгорцог шулуун, бортгон хэлбэртэй, бор хүрэн өнгөтэй [2].

**Тархац, ургах орчин:** Дундад Азид тархана. Монголд: Монгол Алтайн Аж Богд, Гичгэний нуруу, Говь Алтайн Зүүн Сайхан уул, Хүрэн Ханын нуруу, Тост уул, Зүүн гарын говын Сэртэнгийн хөвч ууланд тохиолдоно [1]. Уулын хуурай хажуугаар хад чулууны дэргэд, хадны завсарт ургана [1].

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Байгалийн хуурайшилт, цөлжилт, бэлчээрийн талхагдалтын улмаас устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, байгалийн нөхөн ургалтыг дэмжиж, хамгаалалтыг сайжруулах, ховор хөвдийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ignatov et all., 2002, 2. Цэгмэд, 2010.

## 7. ХОСШҮДЭТ СИНТРИХИ



*Syntrichia bidentata* [X.-L. Bai] X.-L. Bai  
**Овог.** Поттиатан – Pottiaceae Schimp.



**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Сэвсгэр дэгнүүлтэй, сааралдуу эсвэл ногоон саарал өнгийн хөвд. Навч шулуун, дэрвийж эргээгүй, зуувандуу хэлэрхүү хэлбэртэй, мохоодуу оройтой. Судал навчны оройгоос шүдлэг, урт хялгасан үзүүр болж гарна. Навчны орой орчмын шүдлэгүүд салаалсан. Навчны эс дан, дөрвөлжиндүү эсвэл олон өнцөгт хэлбэртэй, папиллатай. Үрт бие тодорхойгүй [2].

**Тархац, ургах орчин:** Өвөр Монголын Хелан ууланд тархана [1]. Монголд: Говь Алтайн районы Баян Цагааны нуруу, Их Богд, Зүүн Сайхан уулууд, Хүрэн Ханын нуруу, Тост ууланд тохиолдоно [2]. Уулын хадтай хажуу, хад чулуун дээр ургана [2].

**Үржил:** Ургал биеэр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Байгалийн хуурайшилт, цөлжилтийн нөлөөнөөс болж устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, байгалийн нөхөн сэргэлтийг дэмжиж, хамгаалалтыг сайжруулах, ховор хөвдийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Bai Xueliang, 1997, 2. Цэгмэд, 2010.

## 8. ЦАСНЫ ВОЙТИ



*Voitia nivalis* Hornsch.

**Овог:** Сплахнумтан – *Splachnaceae* Grev. et Arnott

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Цайвар ногоон өнгийн нягт дэгнүүлтэй хөвд. Навч уртавгар өндгөн хэлбэртэй, хомбогор, огцом нарийссан урт шөвгөрхүү оройтой. Судал навчны нарийссан хэсэгт төгсөнө. Хонгорцог шулуун, нарийн өндгөн хэлбэртэй [2].

**Тархац, ургах орчин:** Голарктикийн өндөр уул, Арктикт тархана [1]. Монголд: Хархираа, Түргэний нуруу, Хангайн Отгонтэнгэр ууланд тохиолдоно [2]. Өндөр уулын таг, царманд ургана [2].

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Байгалийн хуурайшилтийн улмаас тархац хумигдан, нөөц хомсдож, устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, зориудаар үржүүлэх, хамгаалалтыг сайжруулах, ховор хөвдийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бардунов Л.В. 1969, 2. Цэгмэд, 2010.

## 9. БАРДУНОВЫН ОРТОДОНДОПСИС



*Orthodontopsis bardunovii* Ignatov et B.C.Tan

**Овог.** *Ортодонцтон* – *Orthodontaceae* Ignatov

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Бүдэгдүү ногоон, сэвсгэр дэгнүүлтэй, эсвэл ганц нэг ишээрээ ургана. Навч хуурай үедээ мушгирсан, уртавтар юлдэн эсвэл шугамархуу юлдэн хэлбэрийн, богино шовх оройтой, бүтэн эсвэл оройгоосоо доош бүдэгдүү шүдтэй. Судал навчны орой хүрэхгүй төгсөнө. Навчны эс уртавтар олон талт, урт өргөний харьцаа 2:2,5-4 орчим, нимгэн ханатай. Хонгорцог бортгон хэлбэртэй, шулуун заримдаа налуу бараг хэвтээ, аажмаар нарийссан хүзүүтэй [1].

**Тархац, ургах орчин:** Орос Алтай, Дорнод Саянд тархана. Монголд: Хөвсгөлийн Жанхайн даваа, Зүүн хойд Хангайн Дулаан Хан ууланд тохиолдоно [1]. Ой доторх өмхөрсөн модон дээр ургана [1].

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ойн түймэр, мод бэлтгэлт, хуурайшилтаас болж устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалалтыг сайжруулах, ховор хөвдийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. *Цэгмэд, 2010.*

10. НОГООН ПООЛИ



*Pohlia viridis* Lindb. et Arnell

*Овог. Мулихгофертэн – Mielichhoferiaceae Schimp.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Ногоон эсвэл цайвардуу ногоон дэгнүүлтэй, жижиг хөвд. Навч юлдэн хэлбэртэй, урт шовх оройтой, хавтгай эсвэл суурь хэсэгтээ эргэсэн, оройдоо шүдлэг захтай. Судал тод, навчны оройд төгсөнө. Навчны эс шугаман хэлбэртэй. Хонгорцог нарийн бортгон хэлбэртэй, шулуун, ногоовтор өнгөтэй [2].

**Тархац, ургах орчин:** Дорнод Сибирыг тархана [1]. Монголд: Хэнтийн Зүүн Бүрхийн голд ховор тохиолдоно [2]. Ойн бүслүүрт ой бүхий газарт хад чулуун дээр ургана [2].

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ойн түймэр, хуурайшилтаас болж устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, зориудаар үржүүлэх, хамгаалалтыг сайжруулах, ховор ургамлын жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Савич-Любицкая, Смирнова. 1970; 2. Цэгмэд, 2010.

## 11. СУДАЛТ СТРУКИ



*Struckia enervis* [Broth.] Ignatov, T.J.Kop. et D.G.Long.

**Овог.** Плагиотециумтан – *Plagiotheciaceae* Fleisch.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Үл мэдэг гялалзсан шигүү дэгнүүлтэй, ногоон эсвэл цайвар ногоон өнгийн хөвд. Навч юлдэн юмуу нарийн юлдэн хэлбэртэй, орой нь аажмаар нарийсч хялгасан үзүүр болно. Судал бүдэг, богино, үзүүртээ заримдаа салаалсан, эсвэл огт судалгүй. Навчны эс шугаман эсвэл нарийн тэгш бус өнцөгт хэлбэртэй. Үрт бие тодорхойгүй. Харин амархан унадаг, навч хэлбэрийн үүсгэгч биетэй [2].

**Тархац, ургах орчин:** Алтай, Дорнод Саянд тархана [1]. Монголд: Хангайн Тэрхийн Цагаан нуур, Намнан уул, Хантайн нуруу, Хөгнө Хан уул, Хэнтийн Богд Хан уул, Монгол Дагуурын Дэлгэр Хан ууланд тохиолдоно [2]. Ойн бүслүүрт ой дотрох хад чулуун дээр ургана [2].

**Үржил:** Үүсгэгч биеийн тусламжтай үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ойн түймэр, мод огтлолт, хуурайшилтаас болж устаж болзошгүй.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, ойн түймрээс урьдчилан сэргийлэх,

тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг сайжруулах, ховор хөвдийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бардунов. 1974, 2. Цэгмэд, 2010.

## 12. ТУНГАЛАГ КЛАОРОДИУМ



*Claopodium pellucinerve* [Mitt.] Best  
**Овог.** Туидиумтан – *Thuidiaceae* Schimp.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Шигүү дэгнүүлтэй, шаравтар эсвэл боровтор ногоон, жижиг хөвд. Гурвалжиндуу юлдэн, өргөвтөр суурьтай, огцом нарийссан хялгасан үзүүр бүхий навчтай. Судал тод, тунгалаг, навчны хялгасан үзүүрийн угт төгсөнө. Навчны эс дугуйдуу олон талт эсвэл зууван хэлбэртэй. Хонгорцог дугуйдуу зууван ба унжмал [3].

**Тархац, ургах орчин:** Дорнод Сибирь , Алс Дорнод, Энэтхэг, Пакистан, Хятад, Солонгос, Япон, Хойт Америкт тархана [1]. Монголд: Хангайн Бүрэнгийн нуруунд тохиолдоно [3]. Ойн бүслүүрт хад чулуун дээр ургана [3].

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ойн түймрээс шалтгаалан устаж болзошгүй.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт

хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд шуурхай унтраах, ховор хөвдийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бардунов. 1974; 2. Иркутская красная книга, 2010, 3. Цэгмэд, 2010.

## 1. ДЖЕННЕРИЙН АРТРОСПИРА



*Arthrospira jenneri* Stizenb.

**Овог.** *Формидиумтан - Phormidiaceae Anagn. et Kom.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Дерновик чөлөөтэй хөвдөг юмуу бэхлэгддэг, тод хөх ногоон өнгөтэй, хальсархуу. Трихом хөх ногоон, 6-8 мкм өргөн, төгсгөл рүүгээ нарийсаагүй, зөв эргүүлэг үүсгэдэг. Эс дөрвөлжиндүү, төгсгөлийн эс дугуйрсан [2].

**Тархац, ургах орчин:** Европ, Ази, Америкт тархана. Монголд: Хөвсгөлийн Дүүрэн нуурт хөвмөл байдлаар тохиолдоно.

**Үржил:** Ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага боловч тогтоогдоогүй. Нуурын ус багасч, малын нөлөөгөөр бохирдох зэргээс хамаарч устаж болзошгүй. Нэн хязгаарлагдмал тархацтай.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тодорхой хамгаалалт хийгдээгүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг нарийвчлан тогтоож, байгалийн нөхөн ургалтыг ургал эрхтнээр ургуулах судалгаа явуулж, ургах орчинг хамгаалах, ховор замгийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Комаренко, Васильева, 1978.

## 2. МОНГОЛ ТОЛУФОТРИКС





*Tolypothrix mongolica* Zagorenko et Prozorov  
**Овог.** *Микрохететан* – *Microchaetaceae* Lemm.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Тод хүрэндүү өнгөтэй, 5-8 мм урт, салаалж мөчирлөсөн замаг. Утаслагын суурь, дунд хэсэг 22-44 мкм өргөн үзүүр тийшээ аажмаар нарийсч 11-20 мкм болно. Угларга өргөн, хүрэндүү, тэгш захтай, дээшээ аажмаар нарийссан. Үсэнцэр хөх ногоон, хүрэн ногоондуу, төгсгөлийн эс дугуйвтар, 2-4 /6-8/ мкм бүхий хөх ногоон замаг [1,2].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хөвсгөл нуурын эрэг хавийн хад чулуун дээр ховор тохиолдоно.

**Үржил:** Ургал эрхтнээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогдоогүй. Мал, хүний нөлөөгөөр нуурын эрэг орчмын бэлчээрийн хомсдол, хөрсний дагтаршилт, орчны доройтлоос устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор замгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэн, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, нуурын эрэг орчмыг малын бэлчээрээс чөлөөлж, сэлгээтэй ашиглах, аялал жуулчдын замыг тогтоож, хог хаягдлыг арилган, нуурын эргийн байгалийн төрх, удмын санг хадгалах.

Эх зохиол мэдээ: 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Загоренко, Прозоров, 1983.

### 3. ХАДУУРАРХУУ АНАБЕНА



*Anabaena sigmoidea* Nyg.

**Овог.** Цэлцгэртэн – *Nostocaceae* Dum.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Трихом ганц нэгээр, зөв бус эргүүлгэн юмуу тойрог маягаар мушгирсан, хагас цагираг юмуу S маягтай харагдах бөгөөд салслаг уутгүй, өргөн 3-4 мкм. Эс бортгорхуу, дугуйдуу төгсгөлтэй, уртавтар зуувандуу юмуу торхорхуу, 24-5 мкм өргөн, 5.5-7.5 мкм урт гетерцисттэй, мөн шулуун юмуу үл мэдэг тахийсан гөлгөр, өнгөгүй бүрхүүл бүхий 7.5-8.5 мкм өргөн, 16-21.5 мкм урт нэг үрэнцэртэй [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Хөвсгөлийн Доод нуурт хөвмөл байдлаар тархана. Нэн хязгаарлагмал тархацтай.

**Үржил:** Ургал эрхтнээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага боловч тогтоогдоогүй. Загас агнуурыг замбараагүй хийх, нуурын ус багасах зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Одоогоор тодорхой авсан арга хэмжээ байхгүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Шинэ тархац нутгийн судалгаа явуулж, нөөцийг тогтоох, нуурын хамгаалалтыг сайжруулах, ховор замгийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

Эх зохиол мэдээ: 1. Белякова и др., 2006.

#### 4. ШТУРМИЙН АНАБЕНОРСИС



*Anabaenopsis sturmiaae* /Woloszynska/ V.Muller

*Овог. Цэлцгэртэн - Nostocaceae Dumortier*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Үсэнцэр бараг шулуундуу боловч заримдаа цагираг маягаар мушгирсан, 3-3.5 мкм өргөнтэй. Эс бараг бөмбөлөгөрхүү юмуу голчлон зуувандуу, гетерцит оройн, зуувандуу 4 мкм өргөн, 4.7 мкм урт. Үрэнцэр бараг бөмбөлөгөрхүү 5-6 мкм голчтой [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Баянхонгорын Таацын цагаан нуурт хөвмөл байдлаар тархдаг.

**Үржил:** Бэлэг бусаар үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогдоогүй. Нуурын ус багасч ширгэх, малын нөлөөгөөр бохирдож байгаагаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тодорхой хамгаалалт хийгдээгүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Шинэ тархац нутаг илрүүлж, нөөцийг тогтоох, байгалийн нөхөн ургалтын судалгаа явуулж, үржүүлэх эсвэл тохиромжтой нуурт шилжүүлэн суулгах, орон нутгийн хамгаалалтад авах, ховор замгийн жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Комаренко, Васильева, 1978.

#### 5. ГАЗРЫН ҮС



*Nostoc flagelliforme* Berk.et Curt.

**Овог.** Цэлцгэртэн - *Nostocaceae* Dumortier

**Статус:** Нэн ховор зүйл.

**Таних шинж:** Хар ногоон, хар хүрэндүү өнгөтэй 2-3/5-8/ мм өргөн, 20-30/50/ см урттай нарийн утаслаг биетэй, хөх ногоон замаг. Цувран гинжилж, хоорондоо нягт байрласан дугуй бөмбөлөгдүү эс гадна талаараа салслаг давхраатай [1,2].

**Тархац, ургах орчин:** Европ, Америк, Африк, Төв Азид тархана. Монголд: Дорноговийн Эрдэнэ, Улаан уул, Хатан булаг, Өмнөговь аймгийн Гурван Тэс сумдын нутгаар ховор тохиолдоно.

**Үржил:** Ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** 1га талбайд 22 кг биологийн нөөцтэй. Бэлчээрийн талхагдах, хүнс, эмийн түүхий эдийн зориулалтаар ашиглах, цөлжилт, хуурайшилтаас тархац хумигдан, нөөц улам бүр хомсдож байгаа устах аюулд орсон зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор замгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд тус тус бүртгэн, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархацыг нарийвчлан тогтоож, байгалийн нөхөн ургалтын судалгаа явуулж, тохиромжтой газарт нутагшуулах, үндсэн тархац нутгийг малын бэлчээрээс чөлөөлж, нэн ховор замгийн жагсаалтад бүртгэж, хууль бус ашиглалтыг зогсоож, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Голлербах, 1953.

## 6. ЭРХЭН ВАТРАХОСПЕРМУМ



### *Batrachospermum moniliforme* Roth.

*Овог. Ватрахоспермотон - Batrachospermaceae Rabenh.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Шаравгар эсвэл хөхөвтөр саарал өнгөтэй, салаалж мөчирлөсөн улаан замаг. Нэг эгнээ өнгөгүй зууван эсүүдээс тогтохоос гадна үзүүрийн эсийн хуваагдлаар сунаж ургана. Мөчрүүд тойруулган байрлалтай, өргөнөөрөө бараг ижил. Замгийн суурийн хэсэг хатуу, эсийн урт 20-40 мкм, өргөн 5-10/12/ мкм. Карпогон 4-6 мкм өргөнтэй, үсэнцэр мунархуу хэлбэртэй [1,2].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Төв аймгийн Баруун бүрхийн голоос тэмдэглэгдсэн. Түргэн урсгалт, цэнгэг гол, усны чулуунд бэхлэгдэж ургадаг. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Бэлгийн үржлээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогдоогүй. Гол горхи хатаж ширгэх, байгалийн аясаар хуурайших, голын ус бохирдох, бэлчээрийн талхагдалтаас устаж болзошгүй зүйл.


**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор замгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэн, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархацын шинэ нутаг илрүүлж, нөөцийг тогтоох, голын эхийг

хамгаалж, малыг сэлгээтэйгээр бэлчээрлүүлэх, усны бохирдлыг хязгаарлан зогсоож, удсын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Монгол улсын улаан ном, 1997,2. Виноградова, 1980.

## 7. НОГООН ДУНЕЛЛА



*Dunaliella viridis* Teod.

**Овог.** Дунеллатан - *Dunaliellaceae* Christjuk

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Эсийн сийвэн дотор аяганцар хэлбэрийн өнгөт мөхлөг, улаан нүдэнцэр болон бөөмтэй. Нэг эст, хоёр шилбүүртэй, бүрхүүлгүй, эсийн сийвэнгийн зузаарсан давхарга бүрхүүлийн үүрэг гүйцэтгэнэ. Агших, сунах шүүсэвчгүй, ногоон замаг [1,2].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Дорнод аймгийн Сангийн далай нуурт тэмдэглэгдсэн. Давстай усны замаг.

**Үржил:** Ургал эрхтнээр болон бэлгийн үржлээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогдоогүй. Нуурын ус багасан, бохирдох, нуурын давс хужирыг их хэмжээгээр байнга замбараагүй ашигласнаас устаж болзошгүй зүйл. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Гадаадын зарим оронд өсгөвөрлөж хэрэглэдэг бөгөөд Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор замгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэн, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт оруулж хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Шинэ тархац нутаг илрүүлж, нөөц тогтоох, нуурыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, давс, хужирын тархац, нөөцийг тогтоон, ашиглалтыг хязгаарлах, тохиромжтой нуурт нутагшуулах, замгийг зориудаар өсгөвөрлөх, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Пүрэв, 1972.

## 8. ГУАЛИГ ЭВДОРИНА



*Eudorina elegans* Ehrenb.

**Овог.** Вольвокстон- *Volvocaceae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Ценобии 32 /8-16/ эстэй, зуувандуугаас бөөрөнхий. Эс бөөрөнхийдүү, 12-20 мкм голчтой, монад бүтэцтэй, хоорондоо нийлээггүй чөлөөтэй байрладаг /1/.

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Хөвсгөлийн Тарган нуурт хөвмөл байдлаар ховор тохиолдоно.

**Үржил:** Ургал эрхтнээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогдоогүй. Нуурын ус багасган бохирдохоос устаж болзошгүй зүйл.

Хамгаалахаар авсан арга хэмжээ: Тодорхойгүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, байгалийн нөхөн ургалтыг судалж, ижил төстэй нуурт нутагшуулах, ховор зхмгийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

Эх зохиол мэдээ: 1. Комаренко, Васильева, 1978.

## 9. ТОРОНГИДРОДИКЦИОН



*Hydrodictyon reticulatum* /L./ Lagerh.

**Овог.** Гидродикционтан – *Hydrodictyaceae* [Korsch.] Fott

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Ценобий нь том, торорхуу ууган хэлбэртэй, олон эст, 20 хүртэл см урт. Эс бортгорхуу юмуу өргөн зуувандуу, 15 хүртэл мм урттай, эсийн төгсгөлийн хэсгүүдээр холбогдож тор үүсгэдэг. Эсийн хана дагуух цитоплазм олон тооны бөөм, хроматофор болон пириноид агуулдаг [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Хэнтийн төвөөс зүүн тийш 5-6 км-т Хэрлэн голын эрэгт ховор ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогдоогүй. Бэлчээрийн талхагдалтаас ургах орчин доройтож, устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Хамгаалах тодорхой арга хэмжээ аваагүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Шинэ тархац нутаг илрүүлэн, нөөцийг тогтоож, тохиромжтой орчинд нутагшуулах, зориудаар үржүүлэх, ховор замгийн жагсаалтад бүртгэж, хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

Эх зохиол мэдээ: 1. Горбунов, 1981.



## 10. НУУРЫН ООЦИСТИС



*Oocystis lacustris* Chod

**Овог.** *Ооцистистон* - *Oocystidaceae* Bohlin

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Нэг эст, нарийн өргөн зуувгар, 9-12 мкм урт, 5-9 мкм өргөн. Бүрхүүл гөлгөр, нимгэн боловч заримдаа 2 туйл руугаа зузаарсан байдаг. Хлоропласт автоспор болон залуу ургал эсэд хана дагуу байрладаг, нэг пириноидтой хөвмөл ногоон замаг [1,2].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Хөвсгөл нуурын цэнгэг усанд хөвмөл байдлаар тохиолдоно.

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогдоогүй. Нуурын ус бохирдвол устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор замгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Нуурын усыг бохирдохоос урьдчилан сэргийлэх, тархац, нөөцийг нарийвчлан тогтоох, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Монгол улсын улаан ном, 1997. 2. Загоренко, 1983.

## 11. НАРИЙН СТИГЕОКЛОНИУМ



*Stigeoclonium tenue kutz.*

**Овог.** *Хетофоровтан - Chaetophoraceae [Harvey] De Toni et Levi*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Салаалалт голчлон дэс дараалсан байх бөгөөд хоёрдогч салаалалт шулуун, богино, хурц юмуу урт хялгасархуу үсээр төгсдөг. Эс бортгорхуу 3-16 мкм зузаантай, 12-18 мкм урттай [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Архангайн Өгий нуурын эрэг дагуу тархдаг.

**Үржил:** Ургал эрхтэн, спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Нуурын хүчтэй давалгаа болон нуурын усны бохирдлоос устаж болзошгүй.

Хамгаалахаар авсан арга хэмжээ: Тодорхой арга хэмжээ аваагүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Нөөц тогтоох, нуурын усыг хамгаалах, ховор замгийн жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Комаренко, Васильева , 1978.

## 12. КОЖОВСКИЙН КЛАДОФОР



*Cladophora kozhowii* Zagor. et Izbol.

**Овог.** Кладоформан - *Cladophoraceae* [Hass.] Cohn

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Цацраг хэлбэрээр тал бүр тийш салаалсан төв тэнхлэгтэй, үндсэнцэргүй, ёроолын ногоон замаг. Эсийн бүрхүүл зузаан, биеийн захын хэсгүүд бугын эвэр мэт мөчир үүсгэж салаална. Оройн шовгор эсээр ургаж биежнэ. Олон тооны нөсөө, пириноид бүхий торолсон өнгөт мөхлөгтэй. Гол утаслагын эсүүд 55-163 мкм голчтой, урт өргөний харьцаа 1.1:2.3, хажуугийн мөчрийн эс хавчгар 30-90 мкм голчтой, урт өргөний харьцаа 1.3:4.5 [1,2].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хөвсгөл нуурын усанд тэмдэглэгдсэн. Цэнгэг усны ёроолын хөрсөнд сул чөлөөтэй оршино.

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Нуурын ус бохирдсноос устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор замгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэсэн.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархацын шинэ нутаг илрүүлж, нөөцийг тогтоох, Хөвсгөл нуурын усыг нефтийн бүтээгдэхүүн, фосфор ашиглалтын болзошгүй бохирдлоос урьдчилан сэргийлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Монгол улсын улаан ном, 1997 2. Загоренко, Ижболдина, 1977.

### 13. ВЕБЕРИЙН СПИРОГИРА



*Spirogyra weberi* Kutz.

**Овог.** *Спирогиртан* – *Spirogyraceae* Palla

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Вегетатив эс /19/23-35/39/ мкм өргөн, урт нь өргөнөөсөө /2/3-16 дахин их. Хлоропласт 1/2/. Конъюгаци голчлон шаталсан, заримдаа хажуугийн. Зигоспор зуувандуу харьцангуй дугуйрсан оройтой, 21-49/54/ өргөн, /26/40-105/122.5/ мкм урт. Экзоспор нимгэн өнгөгүй, гөлгөр гадаргуутай. Мезоспор зузаан, шараас хүрэндүү өнгөтэй, хоёр давхаргатай, гадаргуу нь гөлгөр [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Завханы Идэр голд тэмдэглэгдсэн, төмрийн нэгдэлд мэдрэмтгий харин азотын нэгдэл бүхий шүлтлэг орчинд сайн ургадаг.

**Үржил.** Ургал эрхтнээр болон бэлгийн үржлээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг, тогтоогоогүй, усны нөөцийн хомсдлоос устаж болзошгүй зүйл.

**Хамгаалсан байдал:** Тодорхой арга хэмжээ аваагүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Нөөцийг тогтоох, байгалийн нөхөн ургалтыг судалж, ховор замгийн жагсаалтад оруулж, удмын санг хадгалах.

Эх зохиол мэдээ: 1. Рундина, 1998.

### 14. САРАРХУУ КЛОСТЕРИУМ



*Closterium lunula* /Mull./ Nitzsch.

**Овог.** Клостериумтан - *Closteriaceae* Pritchard

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Эс бараг шулуун 348-460 мкм урт, 48-57 мкм өргөн, хоёр төгсгөл рүүгээ аажмаар нарийсдаг. Төгсгөл өргөн дугуйрсан, үл мэдэг арагшаа нумарсан, 12-14 мкм өргөн. Нуруу тал бага зэрэг гүдгэр, хэвлий тал бараг шулуун. Хлоропласт 5-6 урт хавиргархуу. Пироноид олон, эмх замбараагүй байрласан [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Ази, Африк, Австрали, Америкт тархана. Монголд: Төв аймгийн Ест нуурын намгархаг эрэг дагуу ургадаг, нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Бэлгийн үржлээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогдоогүй. Хуурайшилт, бэлчээрийн хэт ашиглалт, нуурын эргийн намаг хатах зэрэг шалтгаанаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт авсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, нөхөн ургалт, зориудаар үржүүлэх судалгаа явуулж, тохиромжтой газарт нутагшуулах, зориудаар үржүүлэх, ховор замгийн жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Комаренко, Васильева, 1978.

## 15. ДОЛГИОНЛОГ ДОЦИДИУМ



*Docidium undulatum* Bail

**Овог.** Десмидиевтан - *Desmidiaceae* Nageli

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Эс дундач хэмжээтэй, 176-245 мкм урт, 10-16.7 мкм өргөн, хавчгар бортгорхуу, шулуун юмуу үл мэдэг нумарсан. Тал эсийн хажуу гадаргуу долгионлог, дээд хэсэгтээ бага зэрэг нарийсдаг, суурь хэсэг нь өргөн, 6-7 товгортой [1,2].

**Тархац, ургах орчин:** Европ, Ази, Хойд, Өмнөд Америкт тархана. Монголд: Төв аймгийн нутаг Ест нуурын намгархаг эрэгт ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай.


**Үржил:** Бэлгийн үржлээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогоогүй. Хуурайшилтаас нуурын намархаг эрэг хатах шалтгаанаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, зориудаар үржүүлэх, ховор замгийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Комаренко, Васильева, 1978. 2. Косинская, 1960.



*Tetmemorus granulatus* [Breb.] Ralfs  
**Овог. Десмидиевтан - Desmidiaceae**

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Эс харьцангуй том, ээрүүлэрхүү хэлбэртэй, Урт нь өргөнөөсөө 4-6 дахин их. Тал эс сууриасаа дээшлэх тусам нарийсдаг, төгсгөл дугуйрсан, голдоо гүнзгий хэрчигдсэн, олон хромагофортой, 3-8 нэг эгнээгээр байрласан пириноидтой. Эсийн урт 126-226 мкм, өргөн 27-46 мкм, төгсгөлийн өргөн 13.5-20.8 мкм [1].

**Тархац ургах орчин:** Европ, Ази, Америкт тархана. Монголд: Төв аймгийн Ест нуурын намгархаг эрэг орчим тохиолдоно.

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогоогүй. Хуурайшилтаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, ижил төстэй ургах орчинд нутагшуулах, ховор замгийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Косинская, 1960.

17. ШҮДЭРХЭГ МИКРАСТЕРИАС



*Micrasterias denticulate* Breb.

**Овог.** Десмидиевтан – *Desmidiaceae*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Нэг эст, 200-312 мкм урт, 136-240 мкм өргөн, хоёр ижил тал эсэд хуваагдах бөгөөд эдгээр нь хоорондоо ухлаадас сэтэрхийний дүнд үүссэн хоолойгоор /хүзүүвч/ холбогдоно. Тал эс бүр нэг дунд /захын/, хоёр хажуугийн хэмээх далбангаас тогтоно. Дунд далбан хажуугийн далбангаас бараг илүү гарахгүй, дээд тал нь дунд хэсэгтээ өнцөгтөрхүү дугуйрсан юмуу мохоо өргөсгүй төгсгөлтэй. Захын ба хажуугийн далбангийн ухлаадас нарийн, гүнзгий [1,2].

**Тархац, ургах орчин:** Европ, Ази, Африк, Хойд, Өмнөд Америкт тархана. Монголд: Төв аймгийн Дунд Хороотын голд тохиолдоно. Голчлон намгархаг усан сан, нуур, голын эргээр ховор тохиолдоно. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогоогүй. Усны нөөц хомсдох бэлчээрийн талхагдалтаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Хамгаалах арга хэмжээ аваагүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийн биологийг судлан тогтоож, ховор замгийн жагсаалтад бүртгэж, тохиромжтой газарт нутагшуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Комаренко, Васильева, 1978. 2. Косинская, 1960.



## 18. ЭНГИЙН ХАРА



*Chara vulgaris* L.

**Овог.** Хараман - *Characeae* L.C.Rich

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Дээд ургамалтай төстэй. Иш 15-20 см өндөр, сааралдуу юмуу ногоон хүрэндүү өнгөтэй, бат бөх, шохойгоор хучигдсан. Олон тооны үеэс тогтсон холтостой. Оогони, антерид навчны зангилаан дээр байрладаг [1].

**Тархац, ургах орчин:** Европ, Азид тархана. Монголд: Баянхонгорын Түйн голын эрэг дагуу тэмдэглэгдсэн.

**Үржил:** Ургал эрхтнээр ба бэлгийн үржлээр үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, тогтоогоогүй. Голын ус багасч, ширгэх, ус бохирдох, бэлчээрийн хэт талхагдалтаас устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тодорхой арга хэмжээ авагдаагүй.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржлийн биологийн онцлогийг нарийвчлан судалж, тохиромжтой газарт нутагшуулах, үржүүлэх, үндсэн тархац нутгийг малын бэлчээрээс чөлөөлөх, ховор замгийн жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол мэдээ:** 1. Голлербах, Красавина, 1983.

## 1. ПАМИРЫН ТЭВГЭНЭ



*Squamarina pamirica* N.S. Golubk.

**Овог.** *Бацидман* – *Bacidiaceae* W. Watson

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Олон тооны хайрсаас тогтсон хайрслал хаг. Ургах гадаргуудаа бэхлэгдсэн хэсгээрээ улаавтар хүрэн өнгөтэй, дээш өндийж дэрвийсэн зах ирмэг хэсгээрээ цайвар өнгөтэй, 2-2.5 мм орчим голчтой хайрсуудаас тогтсон эх бие олон тооны үрт биетэй [1].

**Тархац, ургах орчин:** Памир, Тянь-Шаньд тархана. Монголд: Хөвсгөлийн Дархадын хотгор, Доод нуурын орчим, Зүүнгарын говийн Бодончийн голд тохиолдоно [2,3,4,5]. Хээр, цөлөрхөг хээрийн хад, чулуун ёроолын хурдас хөрсөн дээр тааралдана. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага, шинэчлэн тогтоогоогүй. Мал бэлчээрлүүлэлт, цөлжилт, хуурайшилт зэрэг хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [3], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг шинэчлэн тогтоож, байгалийн нөхөн ургалт, ургах орчныг нарийвчлан судалж, үндсэн тархац нутгийн бэлчээрийг нөхөн сэргээх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Голубкова, 1971, 2. Голубкова, 1981, 3. Монгол улсын улаан ном, 1997, 4. Цогт, 1976, 5. Согт, 1979.

## 2. ГОВИЙН ХАРЛАГ



*Tonina gobica* Golubk.

**Овог.** *Багшихтан* – *Catillariaceae Hafellner*

**Статус:** Нэн ховор, унаган зүйл.

**Таних шинж:** Хаг бие хайрслал. Цайвар шаргал өнгийн төвгөрдүү дугираг хэлбэрт хайрсуудаас тогтоно. Гөлгөр биш жижиг товруут гадаргуутай, нимгэн цагаан цайвар өнгөрт хайрсууд хоорондоо цайвар хүрэн өнгийн эмжээр үүсгэсэн нарийн ан цаваар тусгаарлагдана [3].

**Тархац, ургах орчин:** Ази. Монголд: Өмнөговийн Зүүн Сайхан уулын Ёлын ам, Говь-Алтайн Хөрх ууланд ховор тохиолдоно [1,2]. Улирлын чанартай урсгал голын дэргэд силикат чулуун дээр ургана. Тархац нэн хязгаарлагдмал.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Уур амьсгалын хуурайшилт, малын хөлийн нөлөө, газар ашиглалт зэрэг хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устах аюулд орсон унаган зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Үндсэн тархац нутагт булаг шанд, голын эхийн хамгаалалтыг сэргээн сайжруулах, газар ашиглалтыг хязгаарлах, тархац, нөөц, ургах орчинг нарийвчлан судалж, үндсэн тархац нутгийг тогтоон, мал бэлчээрлэхийг зогсоож, хамгаалалтыг сайжруулах, нэн ховор хагийн жагсаалтад оруулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Голубкова, 1973, 2. Голубкова, 1981, 3. Урбанавичене, 2003.

### 3. КАНЕВСКИЙН БУТАНЦАР



*Cladonia kanewskii* Oksner

**Овог.** *Бутанцартан*– *Cladoniaceae* Zenker

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Бутлаг амьдралын хэлбэртэй хаг. Гөлгөр холтослог давхраатай, үл мэдэг ацалж салаалсан туузан хэлбэрт мөчрөнцөрүүд хөхөвтөр цайвар, ногоондуу саарал өнгөтэй. Хатуу хугарамтгай, 5-13 см орчим өндөр, мөчрийн оройн эвэрлэг хэлбэрийн салаалсан цайвар хүрэн өнгийн хэсэгт үрт бие байрлана [4].

**Тархац, ургах орчин:** Алс Дорнод, Хойд Америкт тархана. Монголд: Хэнтэйн тойргийн Туул голын эх болон Хангайн тойрогт ховор тохиолдоно [1,2,3]. Ойн тайгын сөөглөг ширэнгийн зах, хөвдөрхөг хэсгээр ургана.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага, шинэчлэн тогтоогоогүй. Байгаль цаг уурын хуурайшилт, мод огтлолт, хөнөөлт шавж, түймэрт нэрвэгдсэнээс устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [3], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, нөхөн сэргэлтийн биологийг судлан тогтоож, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах замаар байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцлийг хангаж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Ahti, 1976, 2. Голубкова, 1981, 3. Монгол улсын улаан ном, 1997, 4. Трасс, 1978.

#### 4. МОНГОЛ БУТУУЛЖ



*Cladonia mongolica* Ahti

**Овог.** Бутанцартан– *Cladoniaceae* Zenker.

**Статус:** Нэн, ховор, унаган зүйл.

**Таних шинж:** Бутлаг хаг. Сааралдуу ногоон өнгөтэй анхдагч биеийн доод элгэн тал цагаан өнгөтэй. Бортого хэлбэрт ургал биеийн үзүүр хэсэгт байрлах эвэрлэг эсвэл цомбого маягаар өргөссөн хэсгийн зах ирмэгээр хар хүрэн өнгийн үрт биетэй. Ургал бие суурийн хэсэг хар хүрэн, оройн хэсэг нь ногоондуу саарал юмуу цагаан өнгөтэй, олон тооны соред болон хайрсанцартай [2].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хөвсгөл аймгийн Улаан уул сум Бэлтэс гол, түүнчлэн Хэнтий, Хангайн тойрогт ховор тохиолдоно [1,2,3]. Ой, тайгын хөвдөрхөг хөрс болон өмхөрсөн модон дээр маш ховор тохиолдоно.

**Үржил:** Соред болон спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Байгалийн хуурайшилт, мод огтлолт, ойн түймэр, хөнөөлт шавжид нэрвэгдсэнээс устах аюулд орсон унаган хаг.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, ургах орчин, үржлийн байдлыг нарийвчлан судалж, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, ургах орчныг нөхөн сэргээх, нэн ховор хагийн жагсаалтад оруулж, хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бязров, 2010, 2. Ahti, 1976, 3. Huneck, 1987.

## 5. ХАНГАЙН ШИГМЭЭ



*Aspicilia changaica* [Klem.] N.S. Golubk.

*Овог. Наалдамхайтан – Нуменелиацеае Коерб.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хаг тачир бутлаг. Эх биеийн өөр хоорондоо нягт шигүү байрлах хар хүрэн өнгийн талмайнууд хөгжлийнхээ эхэн үедээ нэг хэвийн наалдамал хэлбэрээс аажимдаа 2-3 мм орчим дээш өргөгдсөн бортого маягийн тачир бутлаг хэлбэрт шилжинэ. Бутлаг биеийн цайвардуу саарал өнгөртэй үрт бие байршсан, ялимгүй өргөссөн оройн хэсэг нүхтэрсэн, суурийн хэсэг нь цайвардуу шаргал өнгөтэй [3].

**Тархац, ургах орчин:** Соёны нуруу, Байгал орчмын нутагт тархана. Монголд: Хөвсгөл,

Хэнтийн Хурх уул, Хангайн Бүтээлийн нуруу, Дундад Халхын Шилийн Богд, Говь-Алтайн Их Номгон ууланд ховор тохиолдоно [1,2,3,4]. Ойт хээрийн бүслүүрт уулын шохойн юмуу боржин чулуун дээр тааралдана.

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Уур амьсгалын хуурайшилт, ойн түймэр, малын хөлийн нөлөө, газар ашиглалт, чулууг буталж, зам, барилгын материал болгон ашиглах зэрэг хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [2], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Үндсэн тархац нутаг, нөөцийг нарийвчлан судалж, тархац нутгийг тусгай хамгаалалтад авч, хамгаалах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Голубкова, 1981, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Klement, 1965, 4. Schubert, Klement, 1971.

## 6. ХҮНСНИЙ ШИГМЭЭ



*Aspicilia esculenta* [Pall.] Flagey.

**Овог.** *Наалдамхайтан* – *Hymeneliaceae* Koerb.

**Статус:** Нэн ховор зүйл.

**Таних шинж:** Бөмбөлөг хэлбэртэй нүүдэг хаг. Цайвар, сааралдуу хүрэн өнгөтэй, 1-4 см

орчим голчтой. Долгиолсон эсвэл ялимгүй хотойж тахийсан олон тооны хайрсуудаас тогтоно. Хайрсуудын зах ирмэг нэлээд зузаавгар, голын мөөгөн давхраа нягт, цайвар өнгөтэй. Үрт бие ховор тохиолдоно [3].

**Тархац, ургах орчин:** Европ, Кавказ, Дундад Ази, Газар Дундын Тэнгис, Иран, Хойд Америкт тархана. Монголд: Увс аймгийн Давст сумын нутаг, Увс нуурын зүүн хойт эрэг дагуу зурвас газарт тохиолдоно[1,2,4,5]. Цөл, цөлөрхөг хээрийн бүсийн хөрсөнд сул чөлөөтэй нүүдэллэж тааралдана.

**Үржил:** Ургал эрхтэнээр болон спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Малын хөлд гишгэгдэх, хөрс дагтарших, ургах орчин цөлжин хуурайшиж байгаагаас устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [2], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг судалж тогтоох, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, малыг сэлгээтэй бэлчээрлүүлж, байгалийн нөхөн ургалтыг дэмжих, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Голубкова, 1981, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Окснер, 1971, 4. Cogt, 1979, 5. Klement, 1965.

## 7. ГЕДИНИЙ ШИГМЭЭ



*Aspicilia hedinii* [H. Magn.] Oxn.



## *Овог. Наалдамхайтан – Hymeneliaceae Koeber.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хаг бие наалдмал. Цайвардуу саарал өнгөтэй, 10 см хүртэл голчтой, дугуй биеийн төв хэсгээр байрлах харилцан адилгүй төвгөр хэлбэрт талмай бүр үрт биетэй, харин зах хөвөө хэсгээрээ үл мэдэг хайрслал. Хайрс бүр нэлэнхүйдээ эсвэл зөвхөн зах ирмэгээрээ цагаан өнгөртэй [2].

**Тархац, ургах орчин:** Дундад-Ази. Монголд: Хэнтэй, Хангай, Монгол-Алтайн тойрогт ховор тохиолдоно [1,3]. Уулын хээрт, шохойн чулуун дээр тааралдана.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тогтоогоогүй. Уур амьсгалын хуурайшилт, ой түймэр, малын хөлийн нөлөө, газар ашиглалт зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоох, байгалийн нөхөн ургалтыг дэмжиж, малыг сэлгээтэй бэлчээрлүүлэх, хамгаалалтыг сайжруулах, ховор хагийн жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Голубкова, 1981, 2. Окснер, 1971, 3. Цогт, 1985.

## 8. БАРАНОВЫН БӨӨНГӨНӨ



*Rhizoplaca baranowii* [Poelt] Goluk.

**Овог.** *Жижугсэгтэн* – *Lecanoraceae* Koerb.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Бөмбөлөг хэлбэртэй нүүдэг хаг. Цайвар ногоондуу шаргал өнгийн салбангууд өөр хоорондоо нягт барьцалдан бөөгнөрөн дотогшоогоо хумирч хуйлагдан улмаар олон тооны хунайс нугалаат гадаргууг үүсгэнэ. Үрт бие ховор тохиолдоно [2,3].

**Тархац, ургах орчин:** Төв Азид тархана. Монголд: Ховдын Цагаан нуур, Таван толгой голын эх, Монгол-Алтайн Холбоо нуур, Чигэртэйн голд тохиолдоно [1,3,4]. Ойт хээрийн бүслүүрт уулын хөндийн хөрсөн дээр сул чөлөөтэй нүүдэллэнэ.

**Үржил:** Ургал эрхтэн, хаяа спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Уур амьсгалын хуурайшилт, бэлчээрийн талхагдалт зэрэг хүчин зүйлийн нөлөөнөөс шалтгаалан устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийнн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [3], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Үндсэн тархац нутагт булаг шанд, голын эхийн хамгаалалтыг сэргээн сайжруулах, газар ашиглалтыг хязгаарлах, бэлчээрийн талхлалтыг зогсоож, байгалийн аясаар нөхөн төлжих нөхцлийг бүрдүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Голубкова, 1981, 2. Копачевская, 1971, 3. Монгол улсын улаан ном, 1997, 4. Согт, 1979.

## 9. ПОТАНИНИЙ ХӨВДӨЛ



*Allocetraria stracheyi* [Bab.] Kurok. et M.J.Lai [*Cetraria potaninii* Oksner.]

**Овог.** Навчраатан – *Parmeliaceae* Zenker

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хаг бие тачир бутлаг. Цайвар шаравтар өнгөтэй, үл мэдэг хөвсийж хагуурсан, өөр хоорондоо шигүү байрласан туузан хэлбэрт салбангийн дээд гөлгөр гадаргуун элгэн хэсэгт үл мэдэг судлархаг эсвэл хунирч торолсон. Салбангийн цуулбарлаж салаалсан оройн хэсгийн захаар байрлах хар бараан өнгийн төвгөр пикнидтэй [3].

**Тархац, ургах орчин:** Төвд, Байгаль орчмын нутагт тархана. Монголд: Хөвсгөл, Хэнтэй, Хангайн, Монгол-Алтайн тойрогт ховор тохиолдоно [1,2,4]. Ойн дээд хэсгийн хөвдөрхөг хэсгээр ургана.

**Үржил:** Ургал эрхтэнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц тодорхойгүй. Байгаль цаг уурын хуурайшилт, ойн түймэрт өртсөнөөс устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [2], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, байгалийн нөхөн ургалтыг дэмжих, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Голубкова, 1981, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Рассадина, 1971, 4. Cogt, 1979.

## 10. ТАГИЙН ХӨВДӨЛ



*Cetraria alvarensis* [Wahlenb.] Lyng.

*Овог. Навчраатан – Parmeliaceae Zenker*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хаг бие тачир бутлаг. Улбардуу шар өнгийн 2-4 см орчим өндөртэй, үл мэдэг торолж хотойсон гадаргуутай, суурийн хэсэг 2-3 мм хүртэл нарийсаж хунирсан туузан хэлбэртэй. Салбангийн хотойж нумиран өргөсөж салбарласан оройн хэсгийн ялимгүй хөвсийж өргөссөн ирмэгт үрт бие ховор тохиолдоно [2].

**Тархац, ургах орчин:** Монголд: Хөвсгөлийн Мөнх Сарьдаг уул, Ханхад ховор тохиолдоно [1]. Хаг, хөвдтэй тагийн нугын хөрсөнд ургана.

**Үржил:** Биеийн салбангийн хэсгээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Байгаль цаг уурын хуурайшилт, ойн түймэрт нэрвэгдсэнээс устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [1], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, үржих нөхцлийг судлан тогтоож хангах, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Рассадина, 1971.

## 11. ХЭЭРИЙН ХӨВДӨЛ



*Cetraria steppae* [Savicz] Cogt

*Овог. Навчраатан – Parmeliaceae Zenker*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Бутлаг хэлбэрт нүүдэг хаг. Хар бараан хүрэн өнгийн, 2-4 см орчим голчтой, утаслаг хэлбэрийн салбарлаж салаалсан мөчирөнцөрүүд үзүүр төгсгөл хэсгээрээ огцом нарийсаж шивүүр хэлбэр үүсгэнэ [2].

**Тархац, ургах орчин:** Европ, Дундад Азид тархана. Монголд: Хэнтэй, Хангай, Ховд, Монгол-Алтайн тойрогт ховор тохиолдоно [1,3,4]. Уулын хээрийн хөрсөнд ургана.

**Үржил:** Ургал эрхтэнээр үржинэ


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Байгаль, уур хамьсгалын хуурайшилт, бэлчээрийн талхагдалт, ойн түймэрт өртсөнөөс устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [1], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Томин, 1960, 3. Согт, 1979, 4. Huneck, 1987.

## 12. КОМАРОВЫН ХӨВДӨЛ



*Nephromopsis komarovii* [Elenkin.] J. C. Wei

**Овог.** *Навчраатан* – *Parmeliaceae* Zenker

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хаг бие өргөн илтэслэг. Зах ирмэг хэсгээрээ өргөсөж дугуйрсан 5-15см орчим голчтой, дэрэвгэр ухмал салбангийн төв хэсгээр нэлээд хуниралдаж үрчийсэн гадаргуутай. Гөлгөр, цайвар ногоондуу шар өнгийн дээд гадаргуун доод элгэн талын цайвардуу бараан хүрэн өнгөтэй гөлгөр гадаргуу олон тооны цайвар толбонуудтай. Үрт бие салбангийн зах хөвөө хэсгээр байрлана [5].

**Тархац, ургах орчин:** Байгаль орчмын нутаг, Соёны нуруу, Чит мужид тархана. Монголд: Хөвсгөлийн Эгийн голын эх, Хэнтэй, Хангайн Хөгнө Хан ууланд ховор тохиолдоно [1,2,3,4,6]. Шилмүүст ойн зах, модны иш, хожуул, чулуу, бул чулууны хөвдөрхөг хэсэгт ургана.

**Үржил:** Ургал эрхтэн, спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Байгаль цаг уурын хуурайшилт, мод бэлтгэх, ойн түймэрт нэрвэгдсэнээс устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [4], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, үндсэн тархац нутгийг ойн түймрээс хамгаалж, мод бэлтгэлтээс чөлөөлж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бязров, 1987, 2. Голубкова, 1981, 3. Еленкин, 1902, 4. Монгол улсын улаан ном, 1997, 5. Рассадина, 1971, 6. Согт, 1979.

### 13. НАМГИЙН ПЕЛТУЛА



*Peltula zabolotnoji* [Elenk.] Golubk.

**Овог.** *Пелтулатан - Peltulaceae Budel.*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хаг бие хайрсархуу салбанлаг. Сааралдуу цагаан өнгөртэй, гялалзсан цайвар тослог хүрэн өнгөтэй, 1-2 мм голчтой ганц нэгээрээ эсвэл хоорондоо нийлж барьцалдсан хайрсуудаас тогтоно. Хайрс тус бүрт ганц нэгээр эсвэл хэд хэдээрээ шигдэж байрласан үрт биеүдтэй. Доод элгэн талд холтослог давхраа сайн хөгжсөн, олон тооны хар өнгийн ризинтэй [2,3].

**Тархац, ургах орчин:** Азийн Хятадад тархана. Монголд: Монгол Дагуур, Дорнодын тойрогт ховор тохиолдоно [1,2,4, 5]. Томоохон уулсын ам, хөндийн элсэрхэг хөрсөн дээр тааралдана.

**Үржил:** Ургал бие болон спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Бэлчээрийн талхагдалт, хуурайшилт, түймрээс шалтгаалан устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлан тогтоох, үндсэн тархац нутгийн гол, горхийг хамгаалах, бэлчээрийн талхагдалтыг зогсоож, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, байгалийн аясаар нөхөн төлжих нөхцлийг бүрдүүлж, ховор хагийн жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Голубкова, 1971; 2. Еленкин, 1905; 3. Инашвили, 1975; 4. Монгол улсын улаан ном, 1997; 5. Согт, 1979.

## 14. ТОРЛОГ САРХИЛЖ



*Lobaria retigera* [Bory.] Trevis

**Овог.** Сархилжстан – *Lobariaceae* Chevall

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Том салбант илтэслэг хаг. Цайвар хүрэн өнгийн ухмал салбангийн сархинаг мэт дотогш хотойж торолсон талмайнуудын гөвгөр ирмэгээр бортого хэлбэрт изидүүдтэй. Талмай бүрийн харгалзах доод элгэн хэсэгт товойсон цайвар толбыг хүрээлж сүлжсэн хар хөх өнгийн эсгийрхэг гадаргуутай [1,3].

**Тархац, ургах орчин:** Ази, Африк, Хойд Америк, Номхон далайн арлууд, Австралид тархана. Монголд: Хөвсгөл, Хэнтий, Хангай, Дундад Халхын тойрогт ховор тохиолдоно [2,3]. Шилмүүст ойн төгөл дагаж, мод, чулууны хөвдөрхөг хэсгээр ургана.

**Үржил:** Ихэвчлэн ургал эрхтэн, хааяа спороор үржинэ.




**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц бага. Байгаль цаг уурын хуурайшил, мод бэлтгэлт, ойн түймэрт нэрвэгдсэнээс устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор хагийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [3], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөц, байгалийн нөхөн ургалтыг судлан тогтоож, хамгаалалтыг сайжруулах, ургах орчныг доройтлоос сэргийлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Блюм, 1975; 2. Голубкова, 1981; 3. Монгол улсын ном, 1997.

## 15. ЛЕНИЙН ТОЛБУУР



*Caloplaca lenae* Sochting et Figueras

**Овог.** Улбарман - *Teloschistaceae* Zahlbr.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Хаг бие 3 см хүртэл голчтой тэвгэрхүү хэлбэртэй. Төв хэсгээрээ хайрслал, зах ирмэг хэсгээрээ тачир богино салбанцартай. Шаргалдуу саарал, улбар шар юмуу ягаандуу эсвэл хүрэгэр өнгөтэй, цагаан өнгөртэй. Хаяа хэд хэдээрээ нийлж эмх замбараагүй хэлбэр төрх үүсгэнэ. Биеийн төв хэсэг нэлэнхүйдээ соредоор хучигдсан эсвэл түүний хайрс бүхий талмайн зах хөвөө хэсгийн холтослог давхрааны зөвхөн ханзарсан ирмэгээр олон тооны сорали үүсгэж хөгжинө [1].

**Тархац, ургах орчин:** Өмнөд Сибирь, Якут орчимд тархацтай. Монголд: Хөвсгөлийн Хатгалд

тохиолдоно [1]. Уулын хээрийн карбонат чулууны сүүдэрлэг ёроолд тааралдана.

**Үржил:** Спороор эсвэл ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Малын хөлийн нөлөө, газар ашиглалт, бэлчээрийн талхагдалт, түймэр зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг тогтоож, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, малыг сэлгээтэйгээр бэлчээрлүүлэх, ховор хагийн жагсаалтад бүртгэж, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Schting, Figueras, 2006, 2. Красная книга иркутской области, 2010.

## 1. АЗИЙН БӨӨНДИЙГӨНӨ



*Boletinus asiaticus* Sing.

**Овог.** Бөөндийтөн – *Boletaceae* Sing.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Малгайт мөөг. Малгай 4-12.5 см голчтой, улаавгар, цусан улаан өнгийн хилэнлэг гадаргуутай. Шар өнгийн, зузаавтар махлаг эдтэй. Гуурст давхраа шилбээ дагаж уруудаж байрласан, шараас ногоондуу шар өнгөтэй, гуурсны амсар сунасан, олон өнцөгт хэлбэртэй. Шилбэ малгайтайгаа ижил өнгөтэй, цул, шар өнгийн нарийхан цагирагтай [2].

**Тархац, ургах орчин:** Баруун Европ, Алс Дорнодод тархана. Монголд: Хөвсгөл, Хангай, Хэнтий тойргийн зарим нутагт ховор тохиолдоно [1,2]. Шинэсэн болон холимог ойд шинэсний ойролцоо ургана.

**Үржил:** Спор болон ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Ойн түймэр, хуурайшилт, мал бэлчээрлүүлэлт, хүнсний зориулалтаар түүж бэлтгэх зэрэг байгаль болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг судлан тогтоож, үндсэн тархац нутагт ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлах, хүнсний зориулалтаар ахуйн хэрэгцээнээс бусад тохиолдолд хуулийн дагуу түүж бэлтгүүлэх, мод огтлохыг зогсоох, ховор мөөгийн жагсаалтад бүртгэх, зориудаар үржүүлэх.

Эх зохиол, мэдээ: 1. Петров, 1999, 2. Уранчимэг, 2004.

## 2. УЛИАНГАРЫН ТААХАЙ



*Leccinum aurantiacum* [Bull.] S.F.Gray.

**Овог.** Бөөндийтөн – *Boletaceae* Sing.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Малгайт мөөг. Малгай 5-15 см голчтой, тал бөмбөлөг эсвэл бөмбөгөрдүү оройтой, гялгар хилэнлэг гадаргуутай, улбар улаандуу өнгөтэй. Цайвар махлаг эдийг зүсэхэд өнгө хувирч сааралтаж харлана. Цул, цагаан өнгийн бортгон хэлбэртэй шилбэ гадуураа жижиг хайрстай, цайвар байснаа хүрэн болдог [1,2].

**Тархац, ургах орчин:** Зүүн, Баруун Европ, Ази, Хойд Америкт. Монголд: Хэнтийн Бор хонины гол, Хөвсгөлийн Гачууртын даваа, Монгол Дагуурын зарим нутагт ховор тохиолдоно [2]. Навчит болон холимог ойд хус улиангарын үндсэн дээр ургана.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Ойн түймэр, хуурайшилт, мал бэлчээрлүүлэлт зэрэг байгаль болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [1], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг судлан тогтоож, үндсэн тархац нутагт ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлах, мод огтлохыг зогсоох, зориудаар үржүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Уранчимэг, 2004.

### 3. ХАЙРСАРХАГ ДАЛБИГА



*Agaricus tabularis* Pers.

**Овог.** Далбигатан – *Agaricaceae* Chevall.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Малгайт мөөг. Малгай 5-10 см голчтой, зузаан, махлаг, нягт, эхлээд гүдгэрдүү байснаа аажимдаа бараг дэлгэгддэг, хайрсархаг гадаргуутай. Малгай захаараа гүнзгий хагарч цуурсан. Махлаг эд нягт, цагаавтар өнгөтэй, гар хүрэнгүүт шарладаг. Салбан нарийхан, чөлөөтэй, эхлээд цагаан байснаа хөгшрөхдөө ягаарч эцэстээ хар хүрэндүү өнгөтэй болно. Бортогон хэлбэртэй, нягт хатуувтар цагаан өнгийн шилбэтэй [1].

**Тархац, ургах орчин:** Хойд Америк, Дундад Ази, Казахстан, Киргиз, Украинд тархана. Монголд: Баян-Өлгий, Ховд аймгийн зарим нутагт ховор тохиолдоно [2]. Цөлөрхөг хээр, хээрт өвслөг ургамал дунд хайргархаг хөрсөнд ургана.

**Үржил:** Спороор болон ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Цөлжилт, хуурайшилт, бэлчээрийн талхагдалтаас ургах орчин доройтож, тархац хумигдаж, устаж

болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Уг мөөгийг ОХУ, Казахстан, Украин улсын улаан номд оруулсан бөгөөд манай оронд тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг судлан тогтоож, ховор мөөгийн жагсаалтад бүртгэж хамгаалах, цөлжилттэй тэмцэх, зориудаар үржүүлэх, бэлчээрийн талхагдалт, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлан зогсоох, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Лебедева, 1949, 2. Хэрлэнчимэг, 2013.

#### 4. ШИЛБЭТ ЭНДОПТИХУМ



*Chlorophyllum agaricoides* [Czern.] Vellinga

**Овог.** Далбигатан - *Agaricaceae* Chevall.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Малгайт мөөг. Залуу үрт бие бөөрөнхий, шовгордуу, өндгөн хэлбэртэй. Бие гүйцсэн мөөг шилбэтэй, гурвалжиндуу зууван малгайтай, гадна талаараа жижиг хэвтээ хайрстай, эсвэл гялгар, жигд захтай. Малгай 1-7 см голчтой, малгайн дотор талд тахиралдсан тасалгаа бүхий салбанлаг хэсгүүдтэй. Цагаан, цайвар шаргал өнгөтэй байснаа хүрэн болдог [1].

**Тархац, ургах орчин:** Баруун Европ, Дундад Ази, Хойд Америк, Австрали, Шинэ Зеландад тархана. Монголд: Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр сумын зарим нутагт, Сүхбаатар аймгийн зарим сумдын нутагт ховор тохиолдоно [2]. Уулын бэл, хээрийн элсэрхэг хөрсөн

дээр ургана.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Цөлжилт, хуурайшилт, хөнөөлт мэрэгчдийн олшролт, мал бэлчээрлүүлэлт, ургах орчны доройтол зэрэг байгаль болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй зүйл.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор мөөгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [1], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлан тогтоож, үндсэн тархац нутгийн хамгаалалтыг сайжруулах, ургах орчны доройтлыг хязгаарлан зогсоох зорилгоор бэлчээрийг өнжөөж, сэлгээтэй ашиглах, цөлжилтэй тэмцэх, зориудаар үржүүлэх, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Ge, Zhu L. Yang, 2006.

## 5. ШИРЭГНИЙ ГАНДМАГ



*Lepista caespitosa* [Bres.] Sing.

**Овог.** Хүрээмэгтэн – *Tricholomaceae* Heim

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Малгайт мөөг. Малгай 6-15.5 см голчтой, голдоо хотгор хавтгай хэлбэртэй, дотогш эргэсэн нимгэн захтай, төв хэсэгтээ цайвар шаргалдуу туяатай цагаан, бүдэг саарал өнгөтэй. Махлаг эдийн өнгө хувирахгүй. Салбан шигүү байрлалтай, шилбэндээ шууд

бэхлэгдсэн, малгайтайгаа ижил, эсвэл ягаавгар өнгөтэй. Шилбэ бортогон хэлбэртэй, цайвар саарал, сууриадаа цайвар хүрэн өнгөтэй бөгөөд 3 см хүртэл бүдүүрнэ [1,2].

**Тархац, ургах орчин:** Баруун Европ, Алс Дорнодод тархана. Монголд: Хангай, Хэнтий, Монгол Дагуурын тойрогт ховор тохиолдоно [2]. Хээр тал, уулын ар, голын хөндий дагасан дэнжийн мөөгийн хүрээнд бөөнөөрөө багцалж ургана.

**Үржил:** Спороор болон ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Хуурайшилт, мал бэлчээрлүүлэлт зэрэг байгаль болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [2], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг судлан тогтоож, үндсэн тархац нутагт ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлах, хүнсний зориулалтаар ахуйн хэрэгцээнээс бусад тохиолдолд хуулийн дагуу түүж бэлтгүүлэхгүй байх, зориудаар үржүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Васильева, 1973, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Уранчимэг, 2004.

## 6. ТОМ ЦҮЛДМЭГ



*Leucopaxillus giganteus* [Sibthorp: Fr.] Sing.

**Овог.** Хүрээмэгтэн – *Tricholomaceae* Heim

**Статус:** Ховор зүйл.



**Таних шинж:** Малгайт мөөг. Малгай 10.5-20 см голчтой, бөмбөгөрдүү оройтой, хуурай гялгар гадаргуутай байснаа төв хэсэгтээ хагарч арзгардуу болдог. Малгайн зах шилбэ рүүгээ хумирсан, эхлээд цагаан өнгөтэй, хөгшрөхдөө шаргал сааралдуу өнгөтэй болно. Махлаг эдийн өнгө хувирдаггүй, зузаандуу, цагаавтар өнгөтэй. Салбан шигүү байрлалтай, нарийхан, ногоондуу туяатай шаргал өнгөтэй, шилбэндээ шууд бэхлэгддэг. Шилбэ цул, махлаг, сууриадаа бүдүүрч цүлхийсэн хэлбэртэй, гялгар эсвэл хайрсархаг гадаргуутай, цайвар сааралдуу өнгөтэй [1,2].

**Тархац, ургах орчин:** Баруун Европ, Кавказ, Хойд Америкт тархана. Монголд: Хэнтийн тойргийн Жаргалант голын дагуух уулын ар, Мухаргутаин ам, Төв аймгийн Сэргэлэн сумын зарим нутагт, хээрт мөөгийн хүрээнд ургана [3].

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Хуурайшилт, мал бэлчээрийн талхагдалт зэрэг байгаль болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор мөөгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [1], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Мөөгийн тархац нөөцийг тогтоож, тархац нутгийг орон нутгийн хамгаалтад авах, мөөгийг томоохон хүрээ бүхий газрыг хашиж хамгаалах, түүж бэлтгэхэд тавих хяналтыг сайжруулах, хөрсөн доорх ургал биеийг гэмтээлгүй хутгаар газрын дээрх хэсгийг огтлон авахыг хэвшил болгох, зориудаар үржүүлэх.

**Эх зохиол, мэдээ:** 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Сержанина, 1984, 3. Уранчимэг, 2004.

## 7. МОНГОЛ ХҮРЭЭМЭГ



## *Tricholoma mongolicum* Imai.

**Овог.** Хүрээмэгтэн – *Tricholomaceae* Heim

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Малгайт мөөг. Малгай 9-22 см голчтой, цагаан өнгийн гялгар гадаргуутай, бөмбөгөрдүү хавтгай оройтой, зах нь дотогш хумирсан. Цагаан өнгийн, махлаг эдтэй. Салбан нимгэн, шигүү, цагаан цайвар шаргал өнгөтэй, шилбэндээ бэхлэгддэг. Сууриараа бүдүүрч цүлхийсэн, цагаан өнгийн шилбэтэй [1,3].

**Тархац, ургах орчин:** Казахстан, Өвөр Монголд тархана. Монголд: Хөвсгөлийн Согоотийн хөндий, Хангайн Тарвагатайн нурууны Нарийны ам, Монгол Дагуурын зарим нутагт ховор тохиолдоно [2]. Тал хээр тал, уулын араар мөөгийн хүрээнд ургана.

**Үржил:** Спороор үржинэ.


**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага. Хүнсэнд их хэмжээгээр бэлтгэхдээ ухаж, хөрсөн доорх ургал биеийг гэмтээх, спор боловсроогүй нялх мөөгийг түүснээс нөөц багасаж, тархац хумигдаж байгаа устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор мөөгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [1], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг нарийвчлан тогтоож, Байгалийн ургамлын тухай хуулийн нэн ховор мөөгийн жагсаалтад оруулах, үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтад авах, мөөгийн хүрээ бүхий газарт мал сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлан зогсоох, хүрээг хашиж хамгаалах, хүнсний зориулалтаар ахуйн хэрэгцээнээс бусад тохиолдолд түүж бэлтгүүлэхгүй байх.

Эх зохиол, мэдээ: 1. Монгол улсын улаан ном, 1997, 2. Хэрлэнчимэг, 2011, 3. Imai, 1939.

## 8. ЭМИЙН ТУРУУДАЙ



*Fomitopsis officinalis* [Vill.] Bond. et Sing.

**Овог.** Туруудайтан – *Fomitopsidaceae* Julich

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Ур мөөг. Үрт бие 3-40 см хэмжээтэй, нягт, хатуу, цагаавгар, шардуу өнгөтэй, захаараа хүрэгтэр. Гадаргуу нь хагарч цуурсан, хуурай. Цагаан өнгийн хуурайвгар махлаг эдтэй. Гуурст давхарга тод ялгарч харагдахгүй. Шинэсний иш, хожуул дээр шимэгчлэн амьдардаг [1].

**Тархац, ургах орчин:** Баруун Европ, Алс Дорнодод тархана. Монголд: Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуурын тойргийн зарим нутагт ховор тохиолдоно [2]. Шинэсэн болон холимог ойд шинэсний ёроол хэсгийн ишэнд ургана.

**Үржил:** Спороор болон ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч шинэчлэн тогтоогоогүй. Ойн түймэр, хуурайшилт, мал бэлчээрлүүлэлт эм, хүнсний зориулалтаар ашиглах зэрэг байгаль болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай, авах хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг судлан тогтоож, мөөгийн түүж бэлтгэх газар, нөөцийн хэмжээг тодорхойлох, үндсэн тархац нутагт ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлах, хүнсний, эмийн зориулалтаар ахуйн хэрэгцээнээс бусад тохиолдолд хуулийн дагуу түүж бэлтгүүлэх, мод огтлохыг зогсоох, зориудаар үржүүлэх, ховор мөөгийн жагсаалтад бүртгэж хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Аííääðöåå, 1998, 2. Петров, 1981.

## 9. ГАНДЕРМА ЛУЦИДУМ



***Ganoderma lucidum* [Leyss ex Fr.] Karst.**

**Овог.** Ганодерматан - *Ganodermataceae* Donk

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Ур мөөг. Олон наст үрт биетэй, холтослог буюу модлог-холтослог бүтэцтэй, хавтгай хэлбэртэй, богино хажуугийн шилбэтэй. Малгай 10-15 см голчтой, 2-3 см зузаан, дээд гадаргуу нягт, гялалзсан, нил ягаан, цусан улаанаас хар хүрэн өнгөтэй. Шилбэ 5-15 см урттай, бортогон хэлбэртэй [1].

**Тархац, ургах орчин:** Ази, Европ, Хойд Америкт тархана. Монголд: Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутагт ховор тохиолдоно [2]. Шинэсэн болон холимог ойд шинэсний иш, хожуул дээр ургана.

**Үржил:** Спор болон ургал биеэр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Ойн түймэр, хуурайшилт, мал бэлчээрлүүлэлт, эмийн зориулалтаар их хэмжээгээр түүж бэлтгэснээс устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын улаан номонд бүртгэж, тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамгаалсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац нөөцийг судлан тогтоож, мөөгийн түүж бэлтгэх газар, нөөцийн хэмжээг тодорхойлох, үндсэн тархац нутагт ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлах, хүнсний, эмийн зориулалтаар ахуйн хэрэгцээнээс бусад тохиолдолд хуулийн дагуу түүж бэлтгүүлэх, мод огтлохыг зогсоох зориудаар үржүүлэх, ховор мөөгийн жагсаалтад бүртгэх, удмын санг хадгалах.

Эх зохиол, мэдээ: 1. *Áíääðöäâá, 1998.*

## 10. ЖИНХЭНЭ ОНГОЛ



*Inonotus obliquus* [Pers.; Fr.] Pilat  
*Овог. Уртан – Polyporaceae Fr. ex Corda*

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Ур мөөг. Тодорхой хэлбэр дүрсгүй, гадуураа зузаан холтослог, арзгар гадаргуутай, хар хүрэн, нил ягаан туяатай харавтар өнгийн бүрхүүлтэй. Бие гүйцсэн үедээ хэдэн арван см-ээс метр урт, өргөн болдог, амьд хус модонд шимэгчлэн амьдарна [1,2].

**Тархац, ургах орчин:** Европ, Хойд Америк, Австралид тархана. Монголд: Хөвсгөл аймгийн Эг-Үүр, Булган аймгийн Бугант, Хялганат сумдын зарим нутагт [2], Баруун Хэнтийд Шарын голын Моностойн аманд ховор тохиолдоно [3]. Хөгширсөн хустай холимог ойд хусны ишэн дээр ургана.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөцийг тогтоогоогүй. Хязгаарлагдмал өвөрмөц орчинд ургадаг, өсөлт, хөгжилт удаан явагддаг энэхүү мөөгийг хүнс, эмийн зориулалтаар их хэмжээгээр түүж бэлтгэх, мод бэлтгэлт, ойн түймэр, ургах орчны доройтол зэргээс устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Монгол улсын Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор мөөгийн жагсаалтад оруулж, Монгол улсын улаан номонд бүртгэж [2], тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлан тогтоож, мөөгийн түүж бэлтгэх газар, нөөцийн хэмжээг тодорхойлж, үндсэн тархац нутагт ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, мод бэлтгэл болон хүнсний зориулалтаар ахуйн хэрэгцээнээс бусад тохиолдолд хуулийн дагуу түүж бэлтгэхийг зогсоох, зориудаар үржүүлэх, удмын санг хадгалах

**Эх зохиол, мэдээ:** 1. Бондарцев, 1953, 2. Монгол улсын улаан ном, 1997, 3. Хэрлэнчимэг 2008.

## 11. ТОМ КАЛЬВАТИА



*Calvatia gigantea* [Batsch] Lloyd

**Овог.** Дүлийтэн – *Lycoperdaceae* Chevall.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Дүлий мөөг. Үрт биеийн бүх хэсэг нь эвдэрч спор нь ил гардаг. Үрт бие бөөрөнхий 60 см хүртэл голчтой зарим үед үүнээс ч том байдаг бөгөөд маш бага хэсгээрээ ургах орчиндоо бэхлэгддэг. Гадар гөлгөр гадаргуутай эхэндээ цагаан боловсроод цайвар

хүрнээс бор өнгөтэй. Махлаг эд цагаан байснаа боловсрох үедээ цайвар бор өнгөтэй [2].

**Тархац, ургах орчин:** Европ, Төв Ази, Өмнөд Америкт тархана. Монголд: Хөвсгөлийн тойрогт [1], Баруун Хэнтийд Шарын голын Моностойн аманд тохиолдоно [1]. Ойт хээрт хөрсөн дээр ургана. Тархац нэн хязгаарлагдмал.

**Үржил:** Спороор болон ургал эрхтнээр үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч нарийвчлан тогтоогоогүй. Эмийн зориулалтаар их хэмжээгээр түүснээс тархац хумигдан, нөөц хомсдож устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг улсын тусгай хамгаалалтай газарт хэсэгчлэн хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлан тогтоож, үндсэн тархац нутагт малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлах, эмийн болон хүнсний зориулалтаар ахуйн хэрэгцээнээс бусад тохиолдолд түүж бэлтгэхийг зогсоох, зориудаар үржүүлэх, ховор мөөгийн жагсаалтад оруулж хамгаалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бүрэнбаатар, 2013, 2. Bates, 2004, 3. Петров, 1981.

## 12. ЗӨӨЛӨН ДҮЛИЙ



*Lycoperdon molle* Pers.

**Овог.** Дүлийтэн – *Lycoperdaceae* Chevall.

**Статус:** Ховор зүйл.

**Таних шинж:** Дүлий мөөг. Урвуу лийр хэлбэрийн үрт бие 2.5-5 см голчтой, өндөр нь 2.5-6 см. Спор нь оройн хэсгээс цацарна. Үрт бие хуурамч шилбэтэй угтаа мөөгөн утаслагаас тогтсон унжлагуудтай. Гадаргуу богино үүнүүд болон товруунуудтай махлаг эд цагаан байснаа боловсрох үед шаргалдуу хүрэн өнгөтэй болно [2].

**Тархац, ургах орчин:** Европ, Төв Азид, Өмнөд Америкт тархана. Монголд: Хөвсгөлийн тойрогт [3], Хэнтийн тойргийн Моностойн аманд тохиолдоно [1]. Шилмүүст болон навчит ойд хөрсөн дээр ургана. Нэн хязгаарлагдмал тархацтай.

**Үржил:** Спороор үржинэ.

**Нөөц, хомсдох шалтгаан:** Нөөц маш бага боловч нарийвчлан тогтоогоогүй. Бэлчээрийн талхагдалт болон эмийн зориулалтаар их хэмжээгээр түүснээс тархац хумигдан, нөөц хомсдож устаж болзошгүй.

**Хамгаалахаар авсан арга хэмжээ:** Тархац нутгийг хэсэгчлэн улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Хамгаалах арга хэмжээ:** Тархац, нөөцийг судлан тогтоож, үндсэн тархац нутагт ойн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, малыг сэлгээгүйгээр бэлчээрлүүлэхийг хязгаарлах, зориудаар үржүүлэх, ховор мөөгийн жагсаалтад бүртгэж, мөөгийг түүж бэлтгэх ажлыг холбогдох хуулийн тогтоомжийн дагуу зохион байгуулах, удмын санг хадгалах.

**Эх зохиол, мэдээ:** 1. Бүрэнбаатар, 2013, 2. Bates, 2004.

## АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. Абрамова, А.Л., Абрамов, И.И. 1983. Конспект флоры мхов МНР. Л., -221.
2. Абрамова, А.Л, Цэгмэд, Ц. 1977. Интересные виды мхов Монголии. В кн.: Нов. сист. низш. раст. Т-14: 219-223.
3. Абрамова, А.Л, Цэгмэд, Ц. 1979. Редкие и интересные виды мхов Монголии. В кн.: Нов. сист. низш. раст. Т-16:169-175.
4. Абрамова, А.Л., Цэгмэд, Ц. 1987. Дополнение ф флоре мхов МНР.–Новости сист.низш.раст., Т-24:88-91
5. Ahti, T. 1976. The lichen genus *Cladonia* in Mongolia, J. Jap.Bot., (51):365-373.
6. Абрамова, А.Л, Цэгмэд, Ц. 1994. Новые роды и виды для флоры мхов Монголии. Ботанический журнал, Т-78:138-143.
7. Амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенци /CITES/. 1998.
8. Ашигт ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ. /Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны А-415 тушаал/.
9. Афонина, О.М., Бредкина, Л.И., Макаров, И.И. 1980. Распределение лишайников и мхов в



лесостепных ландшафтах с средней течений р. Индигирки. Ботанический журнал, Т-65(7): 66-82.

10. Бадамханд, Ж. 2012. Монгол орны зонхилох ургамлын лавлагаа. УБ.
11. Байгалийн ургамлын нөөцийг эзэмших, ашиглах, хамгаалах харилцаа. 2009. УБ.
12. Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралт, 1995. Нэн ховор ургамлын жагсаалт.
13. Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралт, 1995. Ховор ургамлын жагсаалт.
14. Бардунов, Л.В. 1974. Листостебельные мхи Алтай и Саян. Новосибирск. Наука.- 168.
15. Bates, S.T. 2004. Arizona members of the Geastraceae and Lycoperdaceae. Arizona State University.:88-100.
16. Биологийн төрөл зүйлийг хамгаалах үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 1996 оны 163 дугаар тогтоол.
17. Белякова, Р.Н. и др. 2006. Водоросли вызывающие цветение водоемов северо-запада России. М.:212-214.
18. БНМАУ-ын Улаан ном. 1987. УБ: Улсын хэвлэлийн газар. -181.
19. Блюм, О. Б. 1975. Сем. Stictaceae.- в кн.: Определитель лишайников СССР, Л: Наука.: (3)210-211.
20. Бондарцева, М.А. 1998. Порядок Афиллофоровые. в кн.: Определитель грибов России, Санкт-Петербург: Наука. (2):74-79, 200-205.
21. Бондарцев, А.С. 1953. Трутовые грибы Европейской части СССР и Кавказ. Л: Наука.-1106.
22. Ботанический журнал. Т-60(7):-948
23. Бот. журнал. 1971. Т-56(11):-1635
24. Бот. журнал. 1979. Т-64(3).
25. Бюл. Моск. общ. испыт. прир., отд. биол. 1929, 38; 1-2.-85.
26. Бюл. Моск. общ. испыт. прир., отд. биол. 1990.95. 3:-97
27. Бүрэнбаатар, Г. 2013. Хэнтийн уулсын зарим нутгийн дүлийтэн (Lycoperdaceae) мөөгийн судалгаа. Биологийн ШУ-ны магистрын зэрэг горилсон бүтээл. МУИС.-57.
28. Бязров, Л.Г. 1987. Дополнения к флоре лишайников Хангая (МНР). III. Семейство Parmeliaceae Eschw. Бюлл. МОИП. Отд. биол. 92(3):111-115.
29. Бязров, Л.Г. 1989. Лишайники /Флора Хангая/ Л., Наука.
30. Бязров, Л.Г. 2010. Видовой состав лишенобиоты Монголии. Версия 7.- [http://www.sevin.ru/laboratories/biazrov\\_mong.html](http://www.sevin.ru/laboratories/biazrov_mong.html)
31. Васильков, Б.П. 1948. Съедобные и ядовитые грибы (определитель). М.-Л., Изд-во АН СССР.-135.
32. Васильева, Б.П. 1973. Агариковые шляпочные грибы Приморского края. Л: Наука.-331.
33. Вахрамеева, М.Г., Денисова, Л.В., Самсонов, С.К. 1991. Орхидей нашей страна. Москва. Наука.
34. Виноградова, К.Л., Голлербах, М.М. 1980. Определитель пресноводных водорослей. М.
35. Ганболд, Э. 2010. Флора Северной Монголии. Москва.-254.
36. Ge, Z.W., Zhu, L. Yang. 2006. The genus Chlorophyllum (Basidiomycetes) in China, Mycotaxon, Beijing.: 96:-pp 181-191.
37. Голубкова, Н.С. 1981. Конспекты флоры лишайники Монгольской Народной Республики. Л., Наука.

38. Голлербах, М.М., Косинс, Е.Е., Полянский, В.И. 1953. Синезеленые водоросли-Суанophyta.М. /Определитель пресноводных водорослей СССР. Вып.2/.
39. Голлербах, М.М., Красавина, Л.К. Харовые 1983. водоросли.-Charaphyta. Л. Определитель пресноводных водорослей СССР. Вып.14.
40. Голубкова, Н.С. 1971. К флоре лишайников Монгольской Народной Республики, Ботанический журнал, 56 (6): 777-786.
41. Голубкова, Н.С. 1981. Конспект флоры лишайников Монгольской Народной Республики. Том 16. Л: Биологические ресурсы и природные условия Монгольской Народной Республики, Наука.-200.
42. Голубкова, Н.С. 1983. Анализ флоры лишайников Монголии. Л: Наука.-248.
43. Еленкин, А. А. 1902. Краткий предварительный отчет о споровых, собранных в Саянских горах летом 1902 г., Известия Импер. СПб Ботан. Сада. 2(7):218-220.
44. Грубов, В.И. 1982. Определитель сосудистых растений Монголии/ с атласом/ Л., "Наука". -435.
45. Губанов, И.А. 1996. Конспект флора внешней Монголии (сосудистые растения) Москва, "Валанг".-136.
46. Губанов, А.И., Камелин Р.В. 1988. Материалы к флоре МНР. Новые сосудистые растения, выявление МНР, в последние годы. В кн.: Прир.условия раст. Покров и животный мир. Монголии. Сборник научных трудов. Пуштина.
47. Дариймаа, Ш. 2003. Астровые (Asteraceae Dumort.) Монголии (систематический состав, экология, география, история развития их хозяйственное значение) Дисс. на соиск. ученой степени докт. биол. наук. -644.
48. Дикорастущие полезные растения флоры Монгольской Народной Республики. 1985. – Л.: Наука. -236.
49. Дорофеюк, Н.И., Цэцэгмаа, Д. 2002. Конспект флоры водорослей Монголии. Наука.
50. Еленкин, А. А. 1902. Краткий предварительный отчет о споровых, собранных в Саянских горах летом 1902 г., Известия Импер. СПб Ботан. Сада. 2(7):218-220.
51. Еленкин, А. А. 1905. Новые виды лишайников.1. Известия Импер. СПб Ботан. Сада 5(3):77-88.
52. Жамъяндорж, Х., Лигаа У., Отгонбилэг, Х., Саарал, Н. 2011. Хэрлэний Хөдөө-Аралд тарьсан нэн ховор, ховор ашигт ургамал. УБ.
53. Жизнь растений. 1977. Водоросли, лишайники. М., Т-3.
54. Загоренко, Г.Ф. 1983. Река Селенга //Рыбы МНР. М.:45-60.
55. Загоренко, Г.Ф, Ижболдина Л.А. 1977. Новый вид рода Cladophora Kutz. //Новости систематики низших растений. Л., Т-14. :20-24.
56. Загоренко, Г.Ф, Прозоров, В.А. 1983. Новый вид рода Tolypothrix /Scytonemataceae. Суанophyta/ из озера Хувсугул /МНР/. Ботан. Журн. Т.68(8):1128-1131.
57. Игнатов, М.С., Игнатова, Е.А. 2003. Флора мхов средней части европейской России. Том 1, 2. М:-352.
58. Иллюстрированный определитель растений Казахстана. 1969.
59. Инашвили, Ц. Н. 1975. Сем. Нерриасеae.- в кн.: Определитель лишайников СССР, Л: Наука. (3):119-120.
60. Ignatov, M.S., Ignatova, E.A, Tsegmed, Ts. & Benito Tan. 2006. The genus Orthodontopsis Ignatov

& V.C.Tan (Bryaceae, Bryophyta) in Russia, Mongolia and China. - *Arctoa*. vol. 15:163-168.

61. Imai, S. 1939. On an edible Mongolian fungus "pai-mo-ku". *Proc. Imper. Acad. Tokyo*. 13:280-282.
62. Камелин, Р. В., Буданцев, А. Л. 1990. Обзор видов рода *Thymus* L. во флоре МНР. // Бюл. Москва испытателей природы отд. Биол. Т. 95. вып. 3.:91-97
63. Камелина, Р.В., Губанов, И.А., Даариймаа, Ш. 1985. Дополнение к флоре Монголии. Бюлл. Моск. общ. "Испытатель природы" Отд. биол. вып.5.
64. Kherlenchimeg, N. 2013. Morphological study Genus of *Agaricus* L. of Mongolia, "Төв Азийн ургамлын олон янз байдал, экосистемийн үйлчилгээ" Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, Улаанбаатар.: 79-80.
65. Клемент, О. 1965. Flechten aus der Mongolischen Volksrepublik. *Ergebnisse der Mongolisch-Deutschen Biologischen Expedition seit 1962, Feddes Repertorium*. 72 (7): 98-123.
66. Комаренко, Л.Е., Васильева, И.И. 1975. Пресноводные зеленые водоросли водоемов Якутии. Наука.
67. Копачевская, Е.Г. 1971. Определитель лишайников СССР. Л. Т.1.
68. Косинская, Е.Е. 1960. Флора споровых растений СССР. Т.5. Десмидиевые водоросли. М.-Л. С.270-272.
69. Крылов, П.Н. 1949. Флора Западной Сибири Вып.2.
70. Лигаа, У. 1981. Монгол орны жимс, жимсгэнэт ургамал. УБ.: 93-94.
71. Лигаа, У. 1987. Монгол орны ашигт ургамал. УБ.:171-172.
72. Лигаа, У.1996. Монгол уламжлалт эмнэлэгт эмийн ургамлыг хэрэглэх арга ба жор. Шувуун Саарал. УБ.:312-313, 194-195.
73. Лебедева, Л.А. 1949. Определитель шляпочных грибов. (*Agaricales*). Л: Печатный Двор. 63-71.
74. Лигаа, У., Дариймаа, Ш. нар. 2008. Монгол орны нэн ховор ургамлын зурагт лавлах. УБ.
75. Лигаа, У., Дариймаа Ш. нар. 2009. Монгол орны ховор ургамлын зурагт лавлах. УБ.
76. Machiel Ignatov, Tsegmed, Ts., Benito Tan., Xueliang Bai and Valerij Zolotov. 2004. Mosses of Gobi in Mongolia. *J. Hattori Bot. Lab. No.* 96:183-210.
77. Магсар, Д. 1987. Монгол алтан хундаганыг /*Adonis mongolica* Sim/ ургал эрхтнээр тариалах асуудал. Бот. хүр.бүт. № 10.
78. Малышев, Л., Пешкова, Г.А. 1979. Флора Центральной Сибири. Т.2.
79. Малышев, Л.И., Пешкова, Г.А. 1984. Особенности и генезис флоры Сибири (Предбайкалье и Забайкалье). Новосибирск. 364с.
80. Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2001 оны 105 дугаар тогтоол.
81. Монгол улсын улаан ном. 1997. Адмон хэвлэлийн газар.
82. Монголын ургамлын улаан данс. 2012. Улаанбаатар.
83. Мягмарсүрэн, Д., Намхай, А. 2012. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд. УБ.
84. Невский, С.А. 1937. Сем. *Orchidaceae*. В кн.: Флора СССР. Л., Т.4.
85. Новости сист. высш. раст. 1964, вып 1.
86. Huneck, S. et al., 1987. Zur Verbreitung und Chemie von Flechten der Mongolischen Volksrepublik. II. *Ergebnisse der Mongolisch-Deutschen Botanischen Expeditionen seit 1962, Nova Hedwigia* , 44:189-213.

87. Оксер, А. Н. 1971. Род. *Aspicilia*.- в кн.: Определитель лишайников СССР, Л: Наука.: (1)195-196.
88. Өвөр монголын өвсөн эм. 1974. Өвөр монголын Синхуа хэвлэх үйлдвэр. Хөх хот. :66-67
89. Өлзийхутаг, Н. 1983. БНМАУ-ын гуурст ургамлын Латин-Монгол-Орос нэрийн толь. УХГ. УБ. -557.
90. Өлзийхутаг, Н. 1985. БНМАУ-ын бэлчээр, хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг. УБ.
91. Петров, А.Н., Белова, Н.В. 1999. К флоре макромицетов северной Монголии.-в кн.: Микология и фитопатология, Санкт-Петербург: Наука.: 33(1): 25-29.
92. Петров А.Н. 1981. К флоре макромицетов Прихубсугулья, В книге: Природные условия и ресурсы Прихубсугулья /МНР/, Иркутск. С. 70-77.
93. Пешкова, Г.А. 1979. Семейство Ranunculaceae Лютиковые. В кн.: Флора Центральной Сибир. "Наука".
94. Поляков, П.П. 1961. *Artemisia L.* Флора СССР Т.26.
95. Пояркова, А.И. 1949. Род *Viburnum*. В кн.: Флора СССР. Л., Т.16.
96. Пүрэв, Л. 1972. Материалы по изучению водорослей в районе г. Улан-Ботара // Тр. Ин-та биологии АН МНР. №5. с.105-114.
97. Рассадина, К.А. 1971. Сем. *Parmeliaceae*.- в кн.: Определитель лишайников СССР, Л: Наука.: (1) 367.
98. Растения Центральной Азии.1967. вып.Ш.
99. Растения Центральной Азии. 1977. Т.7.
- 100.Растения Центральной Сибири. 1979. Издательство. "Наука" Новосибирск. -800.
- 101.Рачковская Е.И. 1986. Флора. В кн.: Пустынь Заалтайской гоби. М., "Наука".
- 102.Рундина, Л.А. 1998. Зигнемовые водоросли России. /Chlorophyta: Zygnemotophyceae, Zygnematales/. Наука.:281-282.
- 103.Санчир, Ч. 1967. Монгол орны ургамлын аймгийн зарим шинэ олдвор ба шинэ нутаг. Биол. хүр. бүт. № 2.
- 104.102. Савич-Любицкая, Л.И., Смирнова, З.Н. 1970. Определитель листостебельных мхов СССР, Верхоплодные мхи. Л: Изд. Наука.: -826.
- 105.Санчир, Ч. 1978. Монгол орны ургамлын аймгийн жагсаалтад нэмэгдэх зүйл. ШУА-ийн мэдээ.№ 2.
- 106.Самчина, Д. 1981. Флора споровых растений Казахстана. Алма-Ата. Т.13.
- 107.Санчир, Ч., Ганболд, Э. 1972. Монгол орны ховор ургамлын шинэ нутагшил. Биол. хүр. бүт. № 7.
- 108.Санчир, Ч., Даариймаа, Ш., Мандах Б. 1980. Монгол орны ургамлын аймагт шинээр нэмэгдэх зүйлүүд. ШУА-ийн мэдээ. № 2.
- 109.Санчир, Ч., Цогт, Ө. 1968. Монгол орны ус нуурын ургамлын тухай тэмдэглэл. Биол. хүр. бүт. № 3.
- 110.Сержанина, Г.И. 1984. Шляпочные грибы Белоруссий. Определитель и конспект флоры. Минск: Наука и техника.-406.
- 111.Cogt, U. 1979. Bogentflechten der Mongolischen Volksrepublik Fedd. Rep. Vol. 10.
- 112.Суран, Д., Жамсран, Ц. 1993. Залаархаг хаврагийн цэцэг, үр жимс, Баруун монгол, түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг /илтгэлийн хураангуй/. УБ.

- 113.Трасс, Х.Х. 1978. Сем. Cladoniaceae.- в кн.: Определитель лишайников СССР, Л: Наука.: (5) 68.
- 114.Томин, М.П. 1960. Лишайники, Бактерии и Актиномицеты, Определитель низших растений, (5):163-164
- 115.Тумбаа, Х., Лигаа У. 1969. Лидрийг мал эмнэлэгт хэрэглэх нь. Улаанбаатар.
- 116.Улзийхутаг, Н. 2003. Бобовые Монголии. Улаанбаатар.
- 117.Уранчимэг, Х. 2004. Монгол орны хүнсний мөөг. УБ: Бемби сан. -160.
- 118.Урбанавичене, И. А. 2003. Род. Toninia.- в кн.: Определитель лишайников России, СПб: Наука.: (8) -80.
- 119.Ургамал М. 2009. Монголын ургамлын аймаг. Ариасеае-Сорнасеае, УБ. 10-р дэвтэр.
- 120.Үндэс үрт ургамлын зурагт толь. 1987. Өвөр Монголын сурган хүмүүжлэгийн хэвлэлийн Хороо, Хөх хот.
- 121.Хэрлэнчимэг, Н., Г. Бүрэнбаатар. 2008. Баруун Хэнтийн макромикет мөөгийн ангилалзүйн судалгааны үр дүн, МЗЭХ-ны “Хүрэл тогоотын семинар-2008” эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл, Улаанбаатар.: 66-70.
- 122.Хэрлэнчимэг, Н. ба бусад. 2011. Монгол орны ойн дагалт баялагийн тархац, нөөцийн атлас. УБ: Бемби сан.- 18,56.
- 123.Флора Сибири. 1986.
- 124.Флора Сибири. 1993. Т.6.
- 125.Флора Сибири. 1996. (Ариасеае) Новосибирск, Наука, Т.10.
- 126.Флора СССР. Л., 1934. Изд-во АН СССР, М-Л. Т.1.
- 127.Флора СССР. 1935. Изд-во: АН СССР, М-Л. Т. IV.
- 128.Флора СССР. 1936. Изд-во: АН СССР, М-Л. Т. V.
- 129.Флора СССР. 1936. Изд-во: АН СССР, М-Л. Т. VI.
- 130.Флора СССР. 1937. Изд-во: АН СССР, М-Л. Т. VII.
- 131.Флора СССР. 1939. Изд-во: АН СССР, М-Л. Т.VIII.
- 132.Флора СССР. 1941. Изд-во: АН СССР, М-Л. Т. X.
- 133.Флора СССР. 1945. Изд-во: АН СССР, М-Л. Т. XI.
- 134.Флора СССР. 1949. Изд-во: АН СССР, М-Л. Т. Флора СССР. 1952. Изд-во: АН СССР, М-Л. Т. XVIII.
- 135.Флора СССР. 1954. Изд-во: АН СССР, М-Л. Т. XX.
- 136.Флора СССР. 1954. Изд-во: АН СССР, М-Л. Т. XXI.
- 137.Флора СССР. 1955. Изд-во: АН СССР, М-Л. Т. XXII.
- 138.Флора СССР. 1959. Изд-во: АН СССР, М-Л. Т. XXV.
- 139.138. Флора СССР. 1961. Изд-во: АН СССР, М-Л. Т. XXVI.
- 140.Хауленбек, А. 2006. Говийн их дархан газрын ховор ба ховордсон модлог ургамлууд, тэдгээрийг тарималжуулах гарын авлага. УБ.
- 141.Цагаанмаам, Д. 1983. Биолого-экологические особенности и ресурсы адониса монгольского. Автореф. на соиск. уч. степ. канд. биол. наук. УБ.
- 142.Цвелев, Н.Н. 1976. Злаки СССР. “Наука”.
- 143.Цогт, У. 1976. Напочвенные лишайники района Прихубсугулья МНР. В кн.: Структура и динамика основных экосистем МНР.
- 144.Цэцэгмаа, Д. 2008. Монгол орны замгийн ерөнхий тойм. /зүйлийн бүрэлдэхүүн, тархац/

УБ.

- 145.Цэгмэд, Ц. 2010. Флора мхов Монголии. ТСРМКБЭ РАН. М: 634с.
- 146.Чернева, О. В. 1970. Растения Центральной Азии. Ленинград
- 147.Юнатов, А.А. 1968. БНМАУ-ын хадлан бэлчээр дэхь тэжээлийн ургамлууд. Монголын комиссын бүтээл. УБ. 56х.
- 148.Юнатов, А.А. Дашням Б. 1977. Карта растительности МНР в масштабе 1:1,5 млн. Л. УБ.
- 149.Яковлев Г.П. 1988. Бобовые. В кн.: Растения Центральной Азии. Л., “Наука”.вып.8.
- 150.Flora of China. volume 17.
- 151.Flora of China. 2001. volume 8.
- 152.Flora of China. 2005.
- 153.Schubert, R., Klement, O. 1971. Beitrag zur Flechtenflora der Mongolischen Volksrepublik, Feddes Repertotium, 82:187-262.
- 154.Schting, U., Figuera, G. 2006. *Caloplaca lenae* sp. nov., and other *Caloplaca* species with caloploicin and vicanicin, The Lichenologist, 39(1): 7–14.